



ДАА 320  
ННА 66  
У - 315

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОВЧООН (2012 - 2016)

Редактор:	Б. Болдбаатар
Ажлын багийг ахалсан:	Р. Хатанбаатар
Эмхэтгэсэн:	Г. Чулуун
Техник ажилбаруудыг:	Ө. Мөнхтунгалаг, Д. Алтангэрэл, С. Дэмбэрэлням
Бүрдлийг нягталсан:	И. Жаргалзаяабямба, Д. Нандингэрэл
Гэрэл зургийг:	Л. Баярсайхан, Х. Сүх-Очир

Цаасны хэмжээ: В5, 172x245мм  
Хэвлэлийн хуудас: 77,6 хх.  
“Адмон принт” ХХК -ийн үйлдвэрт 400 ш. хэвлэв.

ISBN 978-99973-0-936-5

Copyright © УИХ -ын Тамгын газар

Утас: +976-51-267016

Факс: +976-11-327016

Цахим шуудан: [secretariat@parliament.mn](mailto:secretariat@parliament.mn)

All rights reserved

## ГАРЧИГ


	Өмнөх үг .....	7	
I БҮЛЭГ	УИХ -ын 6 дахь удаагийн сонгуулийн дүн, Анхдугаар чуулган эхэлсэн нь .....	9	
	• УИХ -ын сонгуулийн дүн, Парламентын шинэ бүрэлдэхүүн .....	11	
	• Монгол Улсын Их Хурлын сонгуулийн дүн, УИХ -ын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай Сонгуулийн ерөнхий хорооны дарга Н.Лувсанжавын илтгэл, 2012.7.06 .....	14	
	• УИХ -ын зургаа дахь удаагийн сонгуулиар УИХ -ын гишүүнд нэр дэвшигчдийн авсан саналын тоо (Хүснэгт) .....	17	
	• Улсын Их Хурлын бүрэлдэхүүн (2012 - 2016, гэрэл зургаар) .....	26	
II БҮЛЭГ	УИХ -ын чуулганы нэгдсэн хуралдааны тойм (2012 - 2016) .....	33	
	• УИХ -ын чуулганы нэгдсэн хуралдааны тойм (2012 - 2016) .....	35	
	• УИХ -ын дотоод зохион байгуулалтын ерөнхий тойм (2012-2016) .....	43	
	• УИХ -ын ээлжит ба ээлжит бус чуулганууд .....	53	
	• УИХ -ын чуулганы нэгдсэн хуралдааны тоон танилцуулга, (2012 - 2016) .....	206	
	• УИХ -ын чуулганы нэгдсэн хуралдааны ирцийн мэдээ (2012 - 2016) .....	208	
	• УИХ -ын чуулганы хуралдаанд гишүүдийн үг хэлсэн, асуусан асуултын мэдээ (Хүснэгтээр, 2012 - 2016) .....	211	
	• УИХ -ын 2012 - 2016 оны нэгдсэн болон байнгын, дэд хороодын хуралдааны мэдээ (графикаар) .....	213	
	• УИХ -ын Байнгын хороодын хуралдааны дүн (Хүснэгтээр) .....	214	
	• УИХ -ын нэгэн бүрэн эрхийн хугацаанд хууль тогтоох байгууллагаас батлан гаргасан Монгол Улсын хууль тогтоомжийн нэгтгэсэн тоон дүн .....	214	
	• УИХ -ын чуулганы хугацаанд нам, эвслийн бүлгийн завсарлага авсан байдал, түүнд холбогдох судалгаа (Хүснэгт) .....	215	
	• УИХ -ын чуулганы нэгдсэн ба хүндэтгэлийн хуралдаанд Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ -ын дарга, Ерөнхий сайд болон гадаад дотоодын Хүндэт зочдын тавьсан илтгэл, хэлсэн үг (бүрэн эхээрээ, 2012 - 2016) .....	227	
	III БҮЛЭГ	Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагааны тойм (2012 - 2016) .....	373
• УИХ -ын хянан шалгах чиг үүргийн дагуу зохион байгуулагдсан ажлын товч тоон танилцуулга .....		375	
Хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах ажлын талаар .....		375	
Улсын Их Хурлын гишүүдээс тавьсан асуулга, асуултын талаар .....		376	
Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийн хийсэн мэдээллийн талаар .....		377	
Хууль тогтоомжоор Засгийн газарт өгөгдсөн үүргийн хэрэгжилтийн талаар .....		377	
Төсвийн хяналт, шинжилгээний талаар .....		377	
- Улсын Их Хурлын 2012 - 2016 оны бүрэн эрхийн хугацаанд дүн шинжилгээ хийсэн ажлын талаарх статистик мэдээ .....		379	

IV БҮЛЭГ	- УИХ -ын даргын захирамж, УИХ -ын Байнгын хороодын тогтоолоор байгуулагдаж, хянан шалгах болон хуулийн хэрэгжилттэй танилцсан ажлын хэсгүүдийн талаарх статистик мэдээ (2012.10.01 - 2016.02 - 05) .....	379
	- УИХ -ын гишүүдээс тавьсан асуулгын талаарх статистик мэдээ (2012.10.01 - 2016.02.05) .....	380
	- УИХ -ын гишүүдээс бичгээр тавьсан асуултын талаарх статистик мэдээ (2012.10.01 - 2016.02.05) .....	381
	- УИХ -ын чуулганы нэгдсэн хуралдаанд сонссон Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний мэдээлэл, аман асуулгын талаарх статистик мэдээ .....	382
	- УИХ -ын Байнгын болон Дэд, Түр хороодод сонссон мэдээллийн талаарх статистик мэдээ (2012.10.01 - 2016.02.05) .....	385
	- УИХ -ын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн нэрийн жагсаалт (2012.10.01 - 2016.02 - 05) .....	391
	Улсын Их Хурал: (Үйл явдлын он дарааллын хэлхээс, 2012 - 2016) .....	399
V БҮЛЭГ	• УИХ -ын үйл явдлын товчоон (2012 - 2016) .....	401
	• УИХ, УИХ -ын Тамгын газрын гадаад хамтын ажиллагааны тойм .....	555
	• Улсын Их Хурлын гадаад харилцааны үйл явдлын тойм (2012.07 - 2016.4.30) .....	562
VI БҮЛЭГ	УИХ -ын Тамгын газар (2012 - 2016) .....	567
	• Улсын Их Хурлын Тамгын газар (Чиг үүрэг, бүтэц зохион байгуулалтын зарим онцлог, 2012 - 2016) .....	569
	• Улсын Их Хурлын Тамгын газрын үйл явдал (Он цагийн дараалаар) .....	586
	• УИХ -ын Хянан шалгах чиг үүргийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн Тамгын газрын зарим ажил үйлчилгээ (Хяналт үнэлгээний хэлтэсээс бэлтгэсэн товч мэдээдэл) .....	614
	• УИХ -ын үйл ажиллагааг олон нийтэд хүргэж сурталчлах талаар Тамгын газраас авч хэрэгжүүлсэн зарим ажил үйлчилгээ (он, оноор) .....	616
	• Улсын Их Хурлын Тамгын газрын тайлан (2016) -г УИХ -ын Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралд аанаар хэлэлцсэн нь (2016-04-06) .....	618
	УИХ -ын Тамгын газрын бусад нэгж, дотоод зарим ажил үйлчилгээ (2012 - 2016, танилцуулга) .....	623
VI+ ХЭСЭГ	• Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын алба .....	625
	• Улсын Их Хурлын даргын Ажлын алба .....	633
	• УИХ -ын Тамгын газрын оролцоо дэмжлэгтэйгээр хэрэгжиж байгаа төслүүд .....	634
	• Улсын Их Хурлын Тамгын газрын Ахмадын хороо .....	647
	• Парламентчдын шадар туслахуудын холбоо (ТББ) .....	652
	• Тамгын газрын Спортын зөвлөл .....	652
	Хавсралтууд (нэмэлт зарим мэдээ мэдээлэл, лавлагаа) .....	655
	• Батлагдсан хууль тогтоомжийн нэрийн жагсаалт (2012.VII. - 2016.VII.) .....	657
	- Бие даасан хууль (жагсаалтаар) .....	657

---

- Нэмэлт өөрчлөлт оруулсан хуулийн нэрийн жагсаалт .....	661
- Гэрээ, конвенц, зээлийн хэлэлцээр соёрхон баталсан тухай хууль (жагсаалтаар) .....	695
- Хууль, хуулийн зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хууль (жагсаалтаар) .....	698
- УИХ -ын тогтоолын жагсаалт (2012. VII. - 2016.VII.) .....	703
• Улсын Их Хурлын шийдвэрт Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хориг (Жагсаалт, 2012 - 2016) .....	723
Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол (Жагсаалт, 2012 - 2016) .....	723
• Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт (Жагсаалт, 2012 - 2016) .....	725
• Улсын Их Хурлын гишүүдээс санаачлан өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, (Жагсаалт, 2012 - 2016) .....	729
• Улсын Их Хурлын гишүүдээс санаачлан өргөн мэдүүлсэн УИХ -ын тогтоолын төсөл (Жагсаалт, 2012 - 2016) .....	746
• Монголын Парламентын Бүлгэм .....	751
• 2012-2016 онд УИХ -ын хууль тогтоох үйл ажиллагаанд зориулан гүйцэтгэсэн судалгааны ажлын жагсаалт .....	754
• 2012 - 2014 онд УИХ-ын Тамгын газраас эрхлэн гаргасан ном товхимлын жагсаалт .....	769
• Товчилсон нэрийн жагсаалт .....	773

\*\*\*



---

## ӨМНӨХ ҮГ

Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдаад 27 дахь жилийн нүүрийг үзэж, энэ хугацаанд парламентын сонгууль (Улсын Бага Хурлын сонгуулийг оруулаад) нийт 7 удаа болжээ.

УИХ –ын 6 дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан парламентын бүрэн эрхийн хугацаа өндөрлөж байгаатай холбогдуулан “Монгол Улсын Их Хурлын түүхэн товчоон (2012 - 2016)” эмхэтгэлийг хэвлүүлж уншигч Танаа хүргэж байна.

Эмхэтгэлд Улсын Их Хурлын ээлжит болон бусад чуулганы нэгдсэн хуралдаан, Байнгын хороо, Дэд, Түр, Тусгай хороодын хуралдааны тойм, Улсын Их Хурлын болон түүний Тамгын газрын үйл ажиллагаа, дотоод гадаад харилцааны онцлог үйл явдлын хэлхээсийг он цагийн дарааллаар бүлэглэн оруулав. Түүнчлэн Улсын Их Хурлын ээлжит болон бусад чуулганы нээлт хаалтад Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын хэлсэн үгс, байнгын ажиллагаатай парламентын бүрэн эрхийн хугацаанд батлагдаж гарсан хууль тогтоомжийн жагсаалтыг нэгтгэж хавсаргав.

Түүхчилсэн лавлагааны эмхтгэлийг хэвлүүлэхэд УИХ –ын Тамгын газрын бүх хэлтэс, албад, холбогдох ажилтнууд эрхэлсэн чиг үүргийнхээ дагуу зохих ёсоор шамдан, хүлээсэн үүргээ цагт нь биелүүлж, хамтын оролцоогоор бүтээлч шуурхай ажилласныг тэмдэглэхийн сацуу хэвлэлд бэлтгэх ажлыг хариуцсан Тамгын газрын Ажлын хэсэгт талархал илэрхийлье.

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Ерөнхий нарийн бичгийн дарга Б. Болдбаатар





1

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЗУРГАА ДАХЬ УДААГИЙН СОНГУУЛИЙН ДҮН ба АНХДУГААР ЧУУЛГАН



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЗУРГАА ДАХЬ УДААГИЙН СОНГУУЛИЙН ДҮН,  
БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ ПАРЛАМЕНТЫН ШИНЭ БҮРЭЛДЭХҮҮН**

2012.VI - VII сар;

2012.6.28 (Пүрэв гараг)

Монгол Улсын байнгын ажиллагаатай парламентын 6 дахь удаагийн сонгууль болов. Сонгуулийн санал авах хугацаа зургадугаар сарын 28 -ны өдрийн 20.00 цагт дуусав. Гадаад суугаа монголчуудын саналыг зургадугаар сарын 28 -нд олон нийтийн хэвлэл мэдээллийнхэнд нээлттэйгээр тоолжээ.

2012.6.29-30

УИХ –ын 6 дахь удаагийн сонгуулийн урьдчилсан дүнг Сонгуулийн ерөнхий хороо VI сарын 29 -ний Баасан гарагийн 15 цагт мэдээлэв.

2012.7.05

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 4, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн зарлиг (№123) гаргаж, шинээр сонгогдсон Улсын Их Хурлын анхдугаар чуулганыг товлон зарлав. Зарлигт “Монгол Улсын Их Хурлын зургаа дахь удаагийн сонгуулийн Анхдугаар чуулганыг 2012 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 10.00 цагт товлон зарласугай” гэжээ.

2012.7.05

(УИХ –ын Анхдугаар чуулганы хуралдааны тэмдэглэлээс ...)

- Монгол Улсын Их Хурлын зургаа дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулганы 2012 оны 7 дугаар сарын 6-ны өдөр (Баасан гариг) -ийн хуралдаан 10 цаг 25 минутад Төрийн ордны Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхимд эхлэв.
- Анхдугаар чуулганы хуралдааныг Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж нээж, даргалав. Чуулганы нэгдсэн хуралдаанд ирвэл зохих 69 гишүүнээс 69 гишүүн ирж, 100 хувийн ирцтэй байв.
- Хуралдаанд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Д.Баттулга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга Н.Лувсанжав, Нарийн бичгийн дарга Ч.Содномцэрэн, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн дарга Ц.Энхтүвшин, Төрийн албаны зөвлөлийн дарга Д.Зүмбэрэлхам, Авлигатай тэмцэх газрын дарга Н.Ганболд, Ерөнхий аудитор Ч.Раднаа, Ерөнхийлөгчийн зөвлөх Л.Пүрэвсүрэн, Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх Д.Даваасамбуу, зөвлөх Д.Батмөнх, Б.Золбаяр, Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Долгор, Улсын Их Хурал дахь МАН-ын Ажлын албаны дарга Ш.Бадам, АН-ын Ажлын албаны дарга Б.Болдбаатар, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Шаравдорж, Нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Эрх зүй, хууль тогтоомжийн хэлтсийн дарга Д.Насанжаргал, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга Ц.Нарантунгалаг, Захиргаа, боловсон хүчний хэлтсийн дарга Л.Пүрэвжав, Мэдээллийн технологи, техник ашиглалтын хэлтсийн дарга Г.Чиндэгсүрэн, Санхүү, аж ахуй үйлчилгээний хэлтсийн дарга Д.Жанчивдорж, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга Ш.Содномжамц, Судалгааны төвийн дарга Ц.Норовдондог, Байнгын хороодын ажлын албаны дарга Д.Одсүрэн нар байлцав.

- Анхдугаар чуулганы хуралдаанд Сонгуулийн ерөнхий хорооноос Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсэн шинээр сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд болон урилгаар оролцогсод танхимд байраа эзэлсэн байлаа.
- Танхимын баруун жигүүрт Улсын Их Хурлын сонгуульд олон суудал авсан АН-ын гишүүд, зүүн жигүүрт МАН-ын гишүүд, төв хэсэгт МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвсэл, ИЗННам, бие даагчид байраа эзэлсэн байлаа.
- Шинээр сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдийн нэрсийг ширээн дээр байрлуулан тавьсан байв.
- Хуралдааны танхимын гол хэсэгт, индрийн урд соёмбо сийлбэртэй том ширээг 2 сандлын хамт, индрийн зүүн талд Төрийн далбааг байрлуулж, өмнө нь эсгий ширмэл ширдэг дэвсжээ. Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын зүүн талд хүндэт харуул зогссон байлаа. Түүнчлэн Монгол Улсад суугаа гадаад орнуудын Элчин сайдууд болон Дипломат төлөөлөгчдийн газрын тэргүүн нар хүрэлцэн ирж оролцов.
- Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсэн 72 гишүүнээс 69 гишүүн хуралдаанд оролцлоо. Харин МАХН-МҮАН -ын “Шударга ёс” эвслээс нэр дэвшиж Улсын Их Хурлын гишүүний түр үнэмлэхээ гардан авсан Ц.Цолмон, О.Баасанхүү, Ц.Оюунбаатар нар танхимд ирээгүй болно.
- МАХН-МҮАН -ын “Шударга ёс” эвслийн хуралдаанаар тус эвслээс нэрсийн жагсаалтаар Улсын Их Хурлын сонгуульд дэвшүүлсэн Н.Энхбаяр, С.Нарангэрэл, Э.Батшугар нартай холбогдох асуудлыг Үндсэн хуулийн цэц шийдвэрлэсний дараа дээрх гишүүдийг Улсын Их Хурлын гишүүний тангараг өргүүлэхээр болсон тул хуралдаанд оролцоогүй.
- Сонгуулийн ерөнхий хорооны дарга Н.Лувсанжав сонгуулийн дүнг танилцуулж, Өвөрхангайн 2, Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн 1 мандат дээр тус тус дахин сонгууль явуулах тухайгаа мэдэгдсэн юм.
- Сонгуулийн ерөнхий хорооны даргын илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ө.Энхтүвшин, Н.Алтанхуяг, Д.Лүндээжанцан, Д.Тэрбишдагва, Ч.Сайханбилэг нарын тавьсан асуултад Сонгуулийн ерөнхий хорооны дарга Н.Лувсанжав хариулж, тайлбар хийв.
- Асуулт, хариулт дууссаны дараа Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу тангараг өргөх ёслолын ажиллагаа эхэллээ. Энэ удаагийн парламентын насаар хамгийн ахмад гишүүн Д.Дэмбэрэл индэр дээрээс тангарагийг уншихад бусад гишүүд босч, дагаж уншив.
- Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Улсын Их Хурлын гишүүдийн нэрсийг үсгийн дарааллаар, хоёр хоёроор нь дуудахад Улсын Их Хуралд шинээр сонгогдсон гишүүд төрийн сүлдэнд мэхийн ёсолж, тангарагийн хуудсанд гарын үсэг зурж, Улсын Их Хурлын гишүүний энгэрийн тэмдгээ гардан авлаа.
- Улсын Их Хурлын 69 гишүүн тангаргаа өргөж дууссаны дараа Зэвсэгт хүчний Жанжин штабын Бүх цэргийн үлгэр жишээ үлээвэр найрал хөгжимчид Монгол Улсын Төрийн дууллыг танхимд эгшиглүүлэхэд хуралдаанд оролцогсод босч хүндэтгэв.
- Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж шинээр сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрх нь хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан баяр хүргэж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу насаар хамгийн ахмад гишүүн Д.Дэмбэрэлийг хуралдаан даргалахыг урив.
- Улсын Их Хурлын гишүүн Д.Дэмбэрэл Улсын Их Хурлын даргын суудалд сууж, Улсын

Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулж, дэмжиж байгаа гишүүдийг гараа өргөхийг хүслээ.

- Санал хураалтад 69 гишүүн оролцож, 69 гишүүн зөвшөөрч, 100 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа. Саналыг Тамгын газрын Чуулган, байнгын хорооны хуралдаан зохион байгуулах албаны нэгдсэн хуралдааны шинжээчид гараар тоолсон юм.
- Хуралдаан даргалагч Д.Дэмбэрэл шинээр сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдийн цаашдын ажилд амжилт хүсч, баяр хүргэв. 11.50 цагт Улсын Их Хуралд шинээр сонгогдож, тангараг өргөсөн гишүүд дурсгалын зураг авахуулав. Хуралдаан 11 цаг 50 минутад өндөрлөв.

2012.07.06

УИХ -ын анхдугаар чуулганд Сонгуулийн ерөнхий хорооны дарга Н. Лувсанжав үг хэлж байнгын ажиллагаатай парламентын 6 дахь удаагийн сонгуулийн нэгдсэн дүнг илтгэв. (Илтгэлийг бүрэн эхээр нь ард хавсаргав)

\*\*\*

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2012 ОНЫ СОНГУУЛИЙН НЭГДСЭН ДҮН, УЛСЫН ИХ ХУРЛЫН ШИНЭЭР  
СОНГОГДСОН ГИШҮҮДИЙН БҮРЭН ЭРХИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ**

Илтгэгч: Сонгуулийн ерөнхий хорооны дарга Н.Лувсанжав

2012.7.06

Монгол Улсын Ерөнхийлөгч өө!  
УИХ-ын шинээр сонгогдсон гишүүд ээ!  
Хүндэт зочид, хатагтай, ноёд оо!

Монгол Улсын Их Хурлын 2012 оны ээлжит сонгууль болон Нийслэлийн ИТХ -ын сонгууль 6 дугаар сарын 28 -ны өдрийн Пүрэв гаригт улс орон даяар явагдаж өнгөрлөө. Монголын ард түмэн төрийн эрх барих дээд байгууллага - Улсын Их Хурлаа зургаа дахь удаагаа сонголоо.

Сонгуулийн ерөнхий хороо тойргийн хороодын шийдвэрийг үндэслэн УИХ -ын сонгуулийн нэгдсэн дүн, нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн авсан суудлын тоо, УИХ -ын гишүүнээр сонгогдогчдын нэрийн жагсаалтыг 2012 оны 7 дугаар сарын 05-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчид айлтган, нийтэд мэдээлсэн билээ.

Сонгуулийн ерөнхий хороо сонгуулийн нэгдсэн дүнг үндэслэн УИХ -д шинээр сонгогдсон гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай асуудлыг хэлэлцүүлэхээр УИХ-ын анхдугаар чуулганд оруулж байна.

Улсын Их Хурлын энэ удаагийн сонгуулийг хууль эрх зүйн шинэ орчинд сонгуулийн хосолсон тогтолцоогоор анх удаа зохион байгууллаа. Улсын Их Хурлын сонгуулийг улс орон даяар зохион байгуулж явуулах үүрэг бүхий сонгуулийн 26 тойргийн хороо, 333 салбар хороо, 1905 хэсгийн хороо байгуулагдаж, тэдгээрт төрийн жинхэнэ болон үйлчилгээний 15549 албан хаагч ажиллаж сонгуулийг зохион байгууллаа.

Сонгуулийн ерөнхий хороо хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлын сонгуулийг хуулийн дагуу зохион байгуулж явууллаа. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх, бэлтгэл ажлыг хангуулах, сонгуулийн ажлыг зөв, шуурхай зохион байгуулах зэрэг асуудлыг хуралдаанаараа авч хэлэлцэн, сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх заавар, журам, загвар маягтуудыг шинээр боловсруулан баталж хүргүүлэв.

Монгол Улсын сонгуулийн эрх бүхий 1.836.548 иргэн саналаа өгөхөөр нэрийн жагсаалтад бүртгэгдсэн байна. Сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх, нягтлан шалгах, давхардлыг арилгах ажлыг улсын хэмжээнд анх удаа Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /УБЕГ/ бие даан зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар ханган ажилласан.

Монгол Улс түүхэндээ анх удаа гадаад оронд байгаа сонгогчдынхоо саналыг авлаа. Уг ажлыг зохион байгуулах комиссыг Сонгуулийн ерөнхий хороо, Гадаад харилцааны яам хамтран байгуулсан бөгөөд гадаад оронд байгаа Дипломат төлөөлөгчийн газарт сонгуулийн 39 салбар комисст 188 хүн ажиллаж, гадаад улсад амьдарч буй саналаа өгөхөөр бүртгүүлсэн 4276 иргэнээс 2779 иргэн сонгуульд оролцож саналаа өглөө.

Энэ сонгуульд гадаадад байгаа сонгогчдыг нэмж тооцвол нийт сонгогчдын 67.28 хувь нь оролцож саналаа өглөө. Монгол Улсын Их Хурлын сонгуульд улс төрийн 11 нам, 2 эвсэл оролцохоо илэрхийлж Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлэн батламж авсан болно. Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчээр 544 хүн бүртгүүлсэн бөгөөд үүнээс 26 тойрогт 354 нэр дэвшигч, нам, эвслийн жагсаалтаар 190 нэр дэвшигч бүртгүүлснээс бие даан нэр дэвшигч 26, эмэгтэй нэр дэвшигч 174 байлаа.



Сонгуулийн санал авах, тоолох, дүн гаргах болон сонгогчийн бүртгэл, хяналтын үйл ажиллагааг Монгол Улс анх удаа автоматжуулсан системээр амжилттай зохион байгуулж явууллаа. Улсын Их Хурлын сонгуулийн 26 тойрогт нийт 130 хүний бүрэлдэхүүнтэй Мэдээллийн технологийн 26 баг, 1905 хэсгийн хороонд нийт 2625 Мэдээллийн технологийн даамлууд сонгуулийн техник хэрэгслийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллалаа.

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурлын сонгуулийн 26 тойргийн 1905 хэсэгт ашиглагдах 2446 ширхэг санал тоолох төхөөрөмж, 2412 ширхэг сонгогчийн бүртгэлийн техник хэрэгслийг Тагнуулын ерөнхий газар, Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар, тус Хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн хамтарсан Ажлын хэсэг шалган туршиж гэрчилгээжүүлсний үндсэн дээр сонгуульд ашиглалаа. Түүнчлэн 2012 оны 6 дугаар сарын 23 -ны өдөр улсын хэмжээнд 1905 хэсэгт санал тоолох төхөөрөмжөөр туршилтын саналын хуудас уншуулж мэдээллийг дамжуулах ажлыг зохион байгуулан явуулсан нь санал авах өдөр техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангахад чухал ач холбогдолтой туршилт боллоо. Сонгуулийн хууль тогтоомж болон сонгогч саналаа хэрхэн тэмдэглэх талаарх журмыг иргэдэд тайлбарлан таниулах ажлыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчилж ажиллалаа. Нийслэлийн дүүргүүдэд санал тоолох төхөөрөмжийн ажиллагааг иргэд олон нийтэд танилцуулах ажлыг 2012 оны 6 дугаар сарын 26 -ны өдөр зохион байгуулсан.

Энэ удаагийн сонгуульд автоматжуулалтыг амжилттай хэрэгжүүлж чадлаа. Автоматжуулах техник хэрэгсэл, программ хангамжийг нийлүүлж хамтран ажилласан гадаад, дотоодын компаниудад талархлаа илэрхийлж байна.

УИХ -ын сонгуулийг хуулийн дагуу зохион байгуулж явуулахад анхаарч идэвхтэй хамтран ажилласан төрийн байгууллагууд, Гадаад харилцааны яам, гадаад оронд байгаа Дипломат төлөөлөгчийн газрууд, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Зэвсэгт хүчний жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Монголын Үндэсний радио, телевиз болон хэвлэл мэдээллийн болон харилцаа холбоо, тээвэр, эрчим хүч, үйлдвэрлэл үйлчилгээний бусад байгууллагуудад талархал илэрхийлж байна. УИХ-ын сонгуулийг хуулийн дагуу зохион байгуулж явуулах сонгуулийн тойрог, салбар, хэсгийн хороодод ажилласан төрийн албан хаагчиддаа Сонгуулийн ерөнхий хорооны өмнөөс гүн талархал илэрхийлье.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль тогтоомжийг сонгуулийн хороод, сонгуульд оролцогч бусад байгууллагууд хэрхэн биелүүлж байгаад хяналт шинжилгээ хийхээр Сонгуулийн ерөнхий хорооноос зөвшөөрөл авсан 8 төрийн бус байгууллага ажиллаж, 11 төрийн бус байгууллагын 350 гаруй ажиглагчид сонгуулийг ажигласан нь сонгуулийн үйл явцад хуулийн шаардлагыг хангуулахад чухал ач холбогдолтой боллоо. Монгол Улсын Их Хурлын сонгуулийг АНУ, Англи, Канад, ОХУ, Япон, БНСУ, Киргиз, Тайвань зэрэг улс орны болон Олон улсын байгууллагаас 50 гаруй ажиглагч ажиглах хүсэлтээ гаргаж Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлэн сонгуулийг ажиглалаа. Мөн гадаадын 15 улсын 25 хэвлэл мэдээллийн байгууллагын 42 сурвалжлагч сонгуулийг сурвалжиллаа.

УИХ -ын гишүүнээр МАН-аас 25, АН-аас 31, ИЗНН-аас 2, “МАХН-МҮАН -ын Шударга ёс эвсэл”-ээс 11, бие даан нэр дэвшсэн 3 хүн тус тус сонгогдсоныг Монгол Улсын Ерөнхийлөгчид айлтган, нийтэд мэдээлсэн болно.

УИХ -ын гишүүнээр сонгогдогчдын 9 нь буюу 11.8 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь өмнөх сонгуулиас ихээхэн ахисан дүнтэй байна. УИХ-ын гишүүнээр 15 хуульч, 23 эдийн засагч,

16 инженер, 3 багш, 1 хүний их эмч, 14 бусад мэргэжлийн хүмүүс сонгогджээ. УИХ-ын сонгуулийн 10 дугаар тойргоос УИХ-ын гишүүний түр үнэмлэх авсан 2 нэр дэвшигчдийн талаар шүүхийн шийдвэр гарсан тул тойргийн хороо хуулийн дагуу хэлэлцэн шийдвэрлэх шаардлагатай болсон, мөн УИХ -ын 22, 26 дугаар тойргийн тус бүр 1 мандатын төлөө дахин санал хураалт явуулахаар болж байна.

УИХ -ын 2012 оны ээлжит сонгууль хуулийн хүрээнд амжилттай явагдсан болохыг Сонгуулийн ерөнхий хороо тэмдэглэж байна. УИХ -ын гишүүнээр сонгогдсон нэр бүхий 72 гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн шийдвэр гаргаж өгөхийг УИХ-ын анхдугаар чуулганы тус хуралдаанаас Сонгуулийн ерөнхий хороо хүсч байна. Төр төвшин, түмэн олон амгалан байх болтугай! Анхаарал тавьсанд баярлалаа.

\* \* \*



**УИХ -ын зургаа дахь удаагийн сонгуулиар УИХ -ын гишүүнд нэр дэвшигчдийн авсан саналын тоо**

(Хүснэгт 1, тойргийн дарааллаар)

№	Аймаг, дүүрэг	Саналын тоо	Нэр дэвшигчид	Авсан санал	Саналын эзлэх хувь	Зарим тодруулга
1	Архангай	39766	Н.Батбаяр /АН/	15710	39,51	/2 мандат/
			Б.Болор /АН/	13591	34,18	
			Ж.Мөнхбат /МАН/	13421	33,75	
			Ё.Баатарбилэг /МАН/	12640	31,79	
			Н.Удвал /МАХН-МҮАН/	11370	28,59	
			Б.Цогтгэрэл /МАХН-МҮАН/	6342	16,95	
			Ц.Дуламсүрэн	508	1,28	
			Г.Хаш-Эрдэнэ /МНН/	438	1,10	
			Т.Наранцэцэг /ИЗНН/	286	0,72	
			Ж.Хүрэлбаатар /ИЗНН/	203	0,51	
			Ч.Сэвжидмаа /ИХН/	172	0,43	
			Б.Чүлтэмсүрэн /МУНН/	151	0,38	
Г.Дүүрэнбилэг /3 хүчний эвсэл/	116	0,29				
2	Баян-Өлгий	38814	А.Телейхан /МАН/	19257	49,61	/2 мандат/
			А.Бакей /АН/	16606	42,78	
			А.Жекей /МАН/	15679	40,04	
			Ч.Куланда /АН/	12769	32,9	
			А.Хавсад /МАХН-МҮАН/	3315	8,54	
			А.Нота /МАХН-МҮАН/	3285	8,46	
			С.Бакитан /ИЗНН/	879	2,26	
3	Баянхонгор	38201	Х.Баттулга /АН/	21552	56,42	/2 мандат/
			Д.Ганбат /АН/	17748	46,46	
			Г.Занданшатар /МАН/	15175	39,72	
			М.Билэгт /МАН/	12019	31,46	
			Б.Анхныбаяр /МАХН-МҮАН/	3383	8,86	
			Б.Баярсайхан /МАХН-МҮАН/	1823	4,77	
			Ё.Нандинцэцэг /ИЗН/	326	0,85	
			Д.Нямхүү /МСДН/	323	0,85	
			С.Батбаатар /ИЗНН/	253	0,66	
			Д.Ичинноров /МНН/	174	0,46	
			С.Намсрай /МНН/	173	0,45	
			Г.Намхайбал /ХХН/	31	0,08	

4	Булган	26365	Ё.Отгонбаяр /МАН/	12220	46,35	/1 мандат/
			Д.Түмэнжаргал /АН/	7632	28,95	
			С.Дашдондог /МАХН-МҮАН/	3144	11,92	
			Ц.Буянзаяа /ИЗНН/	1422	5,39	
			Л.Цэвэг-Очир /МНН/	228	0,86	
			Л.Нацаг /ИХН/	199	0,75	
			Ж.Баасанхүү /3 дахь хүчин/	121	0,46	
			Б.Болдсайхан	104	0,39	
			Н.Эрдэнэ-Очир /МУНН/	92	0,35	
Б.Бадамгарав /ХХН/	31	0,12				
5	Говь-Алтай	24367	Ц.Дашдорж /МАН/	13429	55,11	/1 мандат/
			Б.Ариунсан /АН/	6536	26,82	
			Б.Оюунбилэг /МАХН-МҮАН/	2877	11,81	
			Г.Нямдорж /ИЗНН/	295	1,21	
			Д.Баттогтох /МНН/	112	0,46	
			Ч.Батбаяр /3 дахь хүчний эвсэл/	79	0,32	
			Л.Хатанбаатар /МУНН/	44	0,18	
			Х.Золбаяр /ХХН/	30	0,12	
6	Дорноговь, Говьсүмбэр	32156	Ж.Батсуурь /МАН/	11830	36,79	/1 мандат/
			Я.Батсуурь /АН/	11475	35,69	
			Ч.Чимэдсүрэн /МАХН-МҮАН/	4283	13,32	
			Ц.Батзул /МНН/	1459	4,54	
			Г.Батгэрэл /ИХН/	625	1,94	
			Д.Батдэлгэр /ИЗНН/	362	1,13	
			Х.Чулуунбаатар /3 хүчин/	259	0,81	
			Б.Пүрэвсүрэн /бие даагч/	222	0,69	
Б.Буянмөнх /ХХН/	33	0,1				
7	Дорнод	32840	Х.Болорчулуун /бие даагч/	14017	42,68	/2 мандат/
			Н.Номтойбаяр /МАН/	10058	30,63	
			П.Алтангэрэл /АН/	9262	28,2	
			Д.Одбаяр /МАН/	6890	20,98	
			Б.Мөнхцэцэг /АН/	6623	20,17	
			С.Отгонбаатар /ИЗНН/	4721	14,38	
			Ж.Энхжаргал //	3569	10,87	
			Ч.Хурц /МАХН-МҮАН/	2349	7,15	
			Д.Дэмчигсүрэн /МАХН-МҮАН/	1535	4,67	
			Ц.Шинэбаяр /3 хүчин/	1316	4,01	
			Л.Оюунцэцэг /ИЗНН/	772	2,35	
			Г.Энхцэцэг /МНН/	376	1,14	
			М.Мөнхөө /МУНН/	356	1,8	
Д.Төмөрбаатар /МНН/	324	0,99				

8	Дундговь	18944	Б.Наранхүү /АН/	8064	42,57	/1 мандат/
			Б.Амарсанаа /МАН/	6485	34,23	
			О.Ганбат /МАХН-МУАН/	2316	12,23	
			Л.Данзанноров	971	5,13	
			З.Эрдэнэбилэг	158	0,83	
			Д.Бямбасүрэн /ИХН/	140	0,74	
			Д.Нарангэрэл МНН	123	0,64	
9	Завхан	34107	Х.Мөнгөннавч /ХХН/	14	0,07	
			Я.Санжмятав /АН/	15970	46,82	/2 мандат/
			Д.Оюунхорол /МАН/	15299	44,86	
			Д.Балдан-Очир /МАН/	13,586	39,83	
			Б.Шинэбаатар /АН/	10597	31,07	
			Д.Чимид-Юндэн /Бие даагч/	5298	15,83	
			Л.Батсайхан /МАХН-МУАН/	2444	7,17	
			П.Гансүх /МАХН-МУАН/	1201	3,52	
			Ц.Төмөрхуяг /ИЗНН/	482	1,4	
			Т.Эрдэнэчимэг /ИЗНН/	437	1,28	
			Ц.Махбал /МНН/	302	0,89	
10	Өвөрхангай	49370	Д.Оюун /3 хүчин эвсэл/	291	0,85	
			С.Чинзориг /МАН/	23493	47,59	
			Н.Төмөрхүү /МАН/	21267	43,08	
			Г.Батхүү /АН/	19939	40,39	/2 мандат/
			Д.Зоригт /АН/	16795	34,02	
			Г.Шийлэгдамба /МАХН-МУАН/	6316	12,79	
			Ж.Цэдэнсодном /Бие даагч/	1561	3,16	
			Б.Мөнх-Алдар /ИЗНН/	712	1,44	
			Б.Энхбаяр /МНН/	373	0,76	
			С.Мандахсүрэн /ИХН/	309	0,63	
			Р.Адьяасүрэн /МНН/	281	0,57	
			Д.Гантулга /Эх орон/	260	0,53	
			Р.Төмөрбаатар /3 хүчин/	219	0,44	
11	Өмнөговь	26626	Л.Норжмаа /ИХН/	187	0,38	
			Д.Бат-Эрдэнэ /АН/	15408	57,87	/1 мандат/
			Х.Бадамсүрэн /МАН/	5288	19,86	
			Д.Чинзориг /МАХН-МУАН/	3655	13,73	
			Г.Гансүх /ИЗНН/	691	2,6	
			Ц.Бээжин /МСДН/	251	0,94	
			Т.Түвшинжаргал /МУНН/	208	0,78	
			Н.Сугар /МНН/	169	0,63	
			Р.Оюунбат /ИХН/	158	0,59	
12	Сүхбаатар	27488	Л.Ундрах /ХХН/	27	0,10	
			М.Зоригт /АН/	10898	39,65	/1 мандат/
			Р.Буд /МАН/	8989	32,7	
			Д.Дэлгэрцогт /МАХН-МУАН/	5319	19,35	
			Ж.Отгонсүрэн /МНН/	131	0,48	
			М.Ариунбат /МУНН/	133	0,48	
Д.Сүхгэрэл /ИХН/	91	0,33				

13	Сэлэнгэ	45291	С.Баярцогт /АН/	18444	40,72	/2 мандат/
			Ж.Эрдэнэбат /МАН/	17062	37,67	
			Г.Цогт-Очир /АН/	12334	27,23	
			П.Болд /МАХН-МҮАН/	10420	23,01	
			А.Энхболд /МАХН-МҮАН/	9888	21,83	
			С.Гэрэлмаа /МАН/	11146	21,61	
			Г.Ганбат /ИЗНН/	1673	3,69	
			П.Баянжаргал /ИЗНН/	1125	2,48	
			А.Оюунгэрэл /МНН/	675	1,49	
			М.Мягмар /МНН/	458	1,01	
			Т.Чимэддорж /3 хүчин/	222	0,49	
			Н.Аюур /3 хүчин/	177	0,39	
			А.Саруул /ИХН/	107	0,24	
			Н.Бат-Эрдэнэ /ХХН/	105	0,23	
14	Төв	39731	М.Энхболд /МАН/	17821	44,85	/2 мандат/
			Су.Батболд /МАН/	16685	41,99	
			Д.Доржпүрэв /АН/	12,392	31,19	
			Г.Баярсайхан /АН/	9589	24,13	
			М.Ганбат /МАХН-МҮАН/	6897	17,36	
			Н.Чулуунбаатар /МАХН-МҮАН/	6671	16,79	
			Л.Мөнхсайхан /ИЗН/	1111	2,8	
			У.Хүрэлбаатар /ИЗН/	1016	2,56	
			Ц.Түвшинжаргал /3 хүчин/	362	0,91	
			Д.Сандагсүрэн /Эх орон/	304	0,77	
			Б.Буянбадрах /ХХН/	102	0,26	
15	Увс	37429	Ч.Хүрэлбаатар /МАН/	21515	57,48	/2 мандат/
			Б.Чойжилсүрэн /МАН/	19533	52,19	
			Д.Нямхүү /АН/	12528	33,47	
			Т.Мэндсайхан /АН/	11621	31,55	
			С.Жавхлан /МАХН-МҮАН/	4251	11,36	
			А.Даваасамбуу /МАХН-МҮАН/	802	2,14	
			Х.Оюунбилэг /3 хүчин/	373	0,99	
			Г.Байгальмаа /МНН/	96	0,26	
			Д.Баатархүү /МУНН/	201	0,54	
			Б.Бат-Эрдэнэ /ИЗНН/	196	0,53	
			А.Эрдэнэ-Соёл /ИХН/	177	0,48	
Г.Чулуунболд /ИЗНН/	127	0,34				



16	Хөвд	34936	С.Бямбацогт /МАН/	14817	42,3	/2 мандат/
			Д.Батцогт /МАХН-МҮАН/	11503	32,63	
			Ш.Адъяаа /бие даагч/	11125	31,56	
			Д.Батбаяр /АН/	8695	24,67	
			Г.Нямдаваа /МАН/	7370	20,91	
			Б.Пүрэвдорж /АН/	6383	18,11	
			Н.Эрдэнэтунгалаг	4062	11,52	
			Г.Доёд /МАХН-МҮАН/	1599	4,54	
			А.Баясгалан	514	1,46	
			Т.Баярхүү /МСДН/	371	1,06	
			Б.Батдорж /МНН/	320	0,91	
			Л.Алтанхуяг /ИЗНН/	256	0,73	
			Г.Хүдэрчулуун /ИЗНН/	233	0,66	
			Х.Жавзандулам /МНН/	189	0,54	
Ч.Нанхир /МУНН/	179	0,51				
17	Хөвсгөл	56043	Л.Энх-Амгалан /МАН/	24166	43,12	/2 мандат/
			Ц.Даваасүрэн /Бие даагч/	19400	34,62	
			Л.Мөнхбаатар /МАН/	17830	31,81	
			Ц.Сэвдванчиг /АН/	14101	25,16	
			Л.Гүндалай /АН/	12029	21,46	
			Б.Эрдэнэбат /Эх орон/	11980	21,38	
			Х.Батсайхан /МАХН-МҮАН/	3846	6,86	
			Б.Санчир /МАХН-МҮАН/	1356	2,42	
			П.Энхцэцэг /МНН/	552	0,98	
			Л.Доржпалам /МНН/	430	0,77	
			Б.Бат-Очир /МУНН/	264	0,47	
			Т.Мөнх-Оргил /3 хүчин/	243	0,43	
			Б.Дүгэржав /ИЗНН/	229	0,41	
			18	Хэнтий	31321	Б.Бат-Эрдэнэ /МАН/
Б.Гарамгайбаатар /АН/	10737	34,28				
Н.Ганбямба /МАН/	10686	34,12				
М.Хүдэрбаатар /АН/	9491	30,3				
С.Жаргал /ИЗНН/	4068	12,99				
Л.Ганбат /МАХН-МҮАН/	3477	11,11				
Б.Туяа /МАХН-МҮАН/	3128	9,99				
Б.Хүдэр-Ян /ИЗНН/	2920	9,32				
Б.Гансүх /3 хүчин эвсэл/	517	1,65				
Д.Алтаннавч /МНН/	314	1				
Т.Цамбалхүндэв /МНН/	265	0,85				
Д.Одгэрэл /МУНН/	241	0,77				
Л.Отгонцэцэг /ИХН/	233	0,74				

19	Дархан-Уул	41756	С.Ганбаатар /Бие даагч/	22464	53,8	/2 мандат/
			Д.Хаянхярваа /МАН/	12368	29,62	
			Ж.Сүхбаатар /МАН/	11573	27,72	
			Б.Тулга /МАХН-МҮАН/	6264	15	
			Б.Мөнхтуяа /АН/	6214	14,88	
			Ж.Мөнхтөр	6147	14,72	
			М.Энхсайхан /МАХН-МҮАН/	5963	14,28	
			Г.Гантулга /АН/	5076	12,16	
			Г.Арслан /3 хүчин эвсэл/	1962	4,7	
			Ц.Ширэндэв /ИЗНН/	798	1,91	
			Б.Бат /Эх орон/	525	1,25	
			Ч.Пүрэвсүрэн /ИХН/	299	0,72	
			С.Цолмон /ХХН/	261	0,63	
			А.Пүрэвжав /МНН/	253	0,61	
Ц.Төрбадрах /МНН/	143	0,34				
20	Орхон	43044	О.Содбилэг /МАН/	17519	40,7	/2 мандат/
			Л.Цог /МАХН-МҮАН/	12140	28,2	
			Д.Дамба-Очир /МАН/	11773	27,35	
			Б.Одхүү /АН/	10814	25,12	
			Х.Золжаргал /АН/	10889	25,3	
			Д.Галбаатар /МАХН-МҮАН/	8572	19,91	
			З.Алтанхуяг /ИЗНН/	4290	9,97	
			М.Батцоож /ИЗНН/	2178	5,06	
			Ц.Эрдэнэчулуун /МСДН/	958	2,23	
			Г.Дашдэмбэрэл /Бие даагч/	911	2,12	
			Ц.Сарантуяа /МНН/	777	1,81	
			П.Баттөр /3 хүчин эвсэл/	606	1,41	
			О.Нямдаваа /МНН/	274	0,64	
			П.Алтан-Эрдэнэ /ЭЧХН/	202	0,47	
Ч.Адъяахүү /ХХН/	195	0,45				
21	Хан-Уул, Багануур, Багахангай	62074	Ц.Оюунгэрэл /АН/	27239	40,69	/2 мандат/
			Л.Болд /АН/	21556	32,2	
			Б.Лхагважав /МАН/	16271	24,31	
			Ц.Батбаяр /МАН/	15256	22,79	
			Л.Жамбалжав /МАХН-МҮАН/	12793	19,11	
			Х.Амарсайхан /МАХН-МҮАН/	10869	16,24	
			С.Болдбаатар /МНН/	929	1,39	
			Л.Баярхүү /3 хүчин эвсэл/	833	1,24	
			Ө.Уртнасан /3 хүчин эвсэл/	730	1,09	
			Ц.Чинбат /Эх орон/	653	0,98	
			Л.Энхжаргал /ХХН/	388	0,58	
			Я.Батцэцэг /ИХН/	3562	5,32	
			Ч.Энхтуяа /ИЗНН/	3106	4,64	
			Э.Сугар /ИЗНН/	2239	3,34	
Ц.Энхбат	1800	2,69				
Э.Нарантуяа /МНН/	1264	1,89				

22	Баянзүрх, Налайх	131447	Ж.Батзандан /АН/	44390	33,77	
			Д.Ганхуяг /АН/	43658	33,21	
			Б.Батзориг /МАН/	32409	24,66	
			Д.Арвин /МАН/	32350	24,61	
			И.Нарантуяа /АН/	32091	24,41	
			Б.Мөнхбаатар /МАН/	30951	23,55	
			О.Чулуунбат /МАХН-МҮАН/	29434	22,39	
			З.Алтай /ИЗНН/	25895	19,7	
			Х.Оюунцэцэг /МАХН-МҮАН/	21900	16,66	
			Г.Цэрэнчунт /МАХН-МҮАН/	17407	13,24	
			Р.Булгамаа /ИЗНН/	7377	5,61	
			Г.Баасан /Бие даагч/	6746	5,13	
			Э.Зоригт /ИЗНН/	6150	4,68	
			Н.Наранцэцэг /МНН/	2899	2,21	
			Б.Чулуунбат /МУНН/	2808	2,14	
			Д.Баатаржав	2348	1,79	
			Б.Батзаяа /МУНН/	2239	1,7	
			Д.Мөнхцэцэг	2012	1,53	
			Б.Болдбаатар /3 хүчин/	1626	1,24	
			Б.Одсүрэн /3 хүчин эвсэл /	1591	1,21	
			М.Эрдэнэбилэг /МНН/	1438	1,09	
			Д.Батнасан /3 хүчин эвсэл/	1410	1,07	
			А.Диваачанд /МУНН/	1240	0,94	
			А.Ариунцацрал /ИХН/	996	0,76	
			Л.Түвшинцэнгэл /ЭЧХН/	677	0,52	
			Б.Энхсайхан /ИХН/	674	0,51	
Ш.Сүхбат /МСДН/	562	0,43				
Б.Ихбаяр /ХХН/	548	0,42				
23	Сүхбаатар	57563	Л.Гантөмөр /АН/	22490	39,07	/2 мандат/
			Р.Амаржаргал /АН/	19240	33,42	
			Ч.Ганхуяг /МАН/	17733	30,81	
			Ц.Цогзолмаа /МАН/	17574	30,53	
			Ц.Баярхүү /МАХН-МҮАН/	7616	13,23	
			Ц.Мөнхжин /МАХН-МҮАН/	7520	13,06	
			Ч.Базар /ИЗНН/	2929	5,09	
			Д.Баттулга /ИЗНН/	2607	4,53	
			Г.Тэмүүжин /3 хүчин эвсэл/	2368	4,11	
			Н.Наранцэцэг /МНН/	1152	2	
			З.Байгальмаа /МНН/	1148	1,99	
			Д.Бадарч /МУНН/	491	0,85	
			Р.Ууганбаатар /ИХН/	451	0,78	
			Д.Даваадорж /Эх орон/	381	0,66	
			Ж.Сандуйжав /МСДН/	273	0,47	
			С.Дэлгэрцогт /ХХН/	208	0,36	

24	Чингэлтэй	67062	Г.Уянга /МАХН-МҮАН/	21199	31,61	/2 мандат/
			Г.Баярсайхан /АН/	21134	31,51	
			Д.Зоригт /МАН/	19753	29,45	
			Б.Батбаатар /АН/	16368	24,41	
			Д.Очирбат /МАН/	16251	24,23	
			Г.Оюунгэрэл /МАХН-МҮАН/	12,622	18,82	
			Д.Уламбаяр /ИЗНН/	2935	4,38	
			Т.Алтаншагай /ИЗНН/	2477	3,69	
			Д.Гансүрэн /МУНН/	1700	2,53	
			Б.Мөнхцэцэг /МНН/	1384	2,06	
			Т.Болд /Бие даагч/	1001	1,49	
			С.Төмөр /Бие даагч/	925	1,38	
			Б.Хосбаяр /3 хүчин эвсэл/	863	1,29	
			Р.Очир /3 хүчин эвсэл/	698	1,04	
			Н.Пүрэвсүрэн /МНН/	688	1,03	
			Н.Жамсран /ЭЧХН/	486	0,72	
			Ц.Алтан - Утас /ИХН/	475	0,71	
			С.Хаш-Эрдэнэ /Эх орон/	432	0,64	
			Д.Энхтуяа /ХХН/	383	0,57	
25	Баянгол	80017	С.Эрдэнэ /АН/	32036	40,04	/2 мандат/
			С.Одонтуяа /АН/	30768	38,45	
			Х.Алтанцацралт /МНН/	959	1,02	
			Н.Дашзэвэг /МАХН-МҮАН/	21225	26,53	
			Ц.Мөнх-Оргил /МАН/	20309	25,38	
			Л.Амгалан /МАН/	16979	21,22	
			Д.Батмөнх /МАХН-МҮАН/	11162	13,95	
			М.Энхтайван /ИЗНН/	4291	5,36	
			Б.Туул /ИЗНН/	3053	3,82	
			Г.Баярсайхан /3 хүчин эвсэл/	1460	1,82	
			Ж.Сарантуяа /МНН/	1299	1,62	
			Д.Үүрцайх /ИХН/	814	1,02	
			А.Эрдэнэбилэг /МСДН/	1100	1,37	
			Х.Оюунцэцэг /3 хүчин эвсэл/	1020	1,27	
			Б.Одончимэг /ИХН/	680	0,85	
			Л.Сайнбаяр /МУНН/	569	0,71	
			Б.Батнасан /Эх орон/	452	0,56	
М.Жавзандулам /ХХН/	316	0,39				





26	Сонгинохайрхан	113964	Д.Тэрбишдагва /МАХН-МҮАН/	42386	37,19	
			Л.Эрдэнэчимэг /АН/	35578	31,22	
			Л.Эрхэмбаяр /АН/	30657	26,09	
			Д.Сумъяабазар /МАН/	28517	25,02	
			Д.Ганболд /АН/	28178	24,73	
			Ж.Хатанбаатар /МАХН-МҮАН/	25652	22,51	
			С.Түмэнгэрэл /МАН/	24346	21,36	
			Г.Тэнгэр /МАН/	23790	20,88	
			Г.Бямбасүрэн /МАХН-МҮАН/	20414	17,91	
			Б.Жаргалсайхан /3 хүчин/	12527	10,99	
			Х.Бат-Ялалт /ИЗНН/	11128	9,76	
			Ш.Пүрэвсүрэн ИЗНН	3624	3,18	
			Ц.Мөнхбаяр	2856	2,51	
			Ө.Нямцэвээн /ИЗНН/	/2626	2,3	
			П.Давааням /МНН/	2477	2,17	
			П.Баярсайхан /МНН/	1947	1,71	
			Э.Амар /3 хүчин эвсэл/	1836	1,61	
			А.Цэрэндолгор /3 хүчин/	1731	1,52	
			Н.Даваа /ИХН/	1607	1,41	
			О.Наранчимэг /ИХН/	1503	1,32	
			П.Төмөрбаатар /Бие даагч/	1386	1,22	
			Б.Хишигбаяр /МНН/	1329	1,17	
			Б.Батцэнгэл	1288	1,13	
			Б.Энхгэрэл /Эх орон/	1188	1,04	
			Д.Өрнөхбаяр /Бие даагч/	876	0,77	
			Д.Байгальмаа /ХХН/	686	0,60	
Ж.Ням /МУНН/	571	0,5				

\*\*\*



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БҮРЭЛДЭХҮҮН**



УИХ-ын дарга  
З.Энхболд



УИХ-ын дэд дарга  
Р.Гончигдорж



УИХ-ын дэд дарга  
М.Энхболд



УИХ-ын дэд дарга  
Л.Цог



УИХ-ын гишүүн  
Н.Алтанхуяг



УИХ-ын гишүүн  
Р.Амаржаргал



УИХ-ын гишүүн  
Д.Арвин



УИХ-ын гишүүн  
О.Баасанхүү



УИХ-ын гишүүн  
А.Бакей



УИХ-ын гишүүн  
Н.Батбаяр



УИХ-ын гишүүн  
Сү.Батболд



УИХ-ын гишүүн  
Сү.Батболд



УИХ-ын гишүүн  
Ж.Батзандан



УИХ-ын гишүүн  
Ж.Батсуурь



УИХ-ын гишүүн  
Х.Баттулга



УИХ-ын гишүүн  
Г.Батхүү



УИХ-ын гишүүн  
Д.Батцогт



УИХ-ын гишүүн  
Н.Батцэрэг



УИХ-ын гишүүн  
М.Батчимэг



УИХ-ын гишүүн  
Д.Бат-Эрдэнэ





УИХ-ын гишүүн  
Б.Бат-Эрдэнэ



УИХ-ын гишүүн  
З.Баянсэлэнгэ



УИХ-ын гишүүн  
Ц.Баярсайхан



УИХ-ын гишүүн  
Г.Баярсайхан



УИХ-ын гишүүн  
С.Баярцогт



УИХ-ын гишүүн  
Л.Болд



УИХ-ын гишүүн  
Б.Болор



УИХ-ын гишүүн  
Х.Болорчулуун



УИХ-ын гишүүн  
Р.Бурмаа



УИХ-ын гишүүн  
С.Бямбацогт



УИХ-ын гишүүн  
С.Ганбаатар



УИХ-ын гишүүн  
Д.Ганбат



УИХ-ын гишүүн  
Л.Гантөмөр



УИХ-ын гишүүн  
Д.Ганхуяг



УИХ-ын гишүүн  
Б.Гарамгайбаатар



УИХ-ын гишүүн  
Ц.Даваасүрэн



УИХ-ын гишүүн  
Ц.Дашдорж



УИХ-ын гишүүн  
Д.Дэмбэрэл



УИХ-ын гишүүн  
С.Дэмбэрэл



УИХ-ын гишүүн  
М.Зоригт



УИХ-ын гишүүн  
Д.Зоригт

УИХ-ын гишүүн  
Д.Лүндээжанцан

УИХ-ын гишүүн  
Б.Наранхүү

УИХ-ын гишүүн  
Н.Номтойбаяр




УИХ-ын гишүүн  
Ц.Нямдорж

УИХ-ын гишүүн  
С.Одонтуяа

УИХ-ын гишүүн  
Ё.Отгонбаатар

УИХ-ын гишүүн  
С.Оюун



УИХ-ын гишүүн  
Ц.Оюунбаатар

УИХ-ын гишүүн  
Ц.Оюунгэрэл

УИХ-ын гишүүн  
Д.Оюунхорол

УИХ-ын гишүүн  
Ч.Сайханбилэг



УИХ-ын гишүүн  
Я.Санжмятав

УИХ-ын гишүүн  
Д.Сарангэрэл

УИХ-ын гишүүн  
Я.Содбаатар

УИХ-ын гишүүн  
О.Содбилэг



УИХ-ын гишүүн  
М.Сономпил

УИХ-ын гишүүн  
Д.Сумъяабазар

УИХ-ын гишүүн  
А.Тлейхан

УИХ-ын гишүүн  
Ш.Түвдэндорж





УИХ-ын гишүүн  
Х.Тэмүүжин

УИХ-ын гишүүн  
Д.Тэрбишдагва

УИХ-ын гишүүн  
Ч.Улаан

УИХ-ын гишүүн  
Г.Уянга



УИХ-ын гишүүн  
Д.Хаянхярваа

УИХ-ын гишүүн  
Ч.Хүрэлбаатар

УИХ-ын гишүүн  
У.Хүрэлсүх\*

УИХ-ын гишүүн  
Ц.Цолмон



УИХ-ын гишүүн  
Б.Чойжилсүрэн

УИХ-ын гишүүн  
Л.Энх-Амгалан

УИХ-ын гишүүн  
Ж.Энхбаяр

УИХ-ын гишүүн  
Н.Энхболд



УИХ-ын гишүүн  
Ө.Энхтүвшин

УИХ-ын гишүүн  
С.Эрдэнэ

УИХ-ын гишүүн  
Ж.Эрдэнэбат

УИХ-ын гишүүн  
Д.Эрдэнэбат

УИХ-ын гишүүн  
Л.Эрдэнэчимэг



Байнгын ажиллагаатай парламентын сонгуулийн дүнд байгуулагдсан Улсын Их Хурлын анхдугаар чуулганы бүрэлдэхүүн, УИХ -ын нэгдсэн хуралдааны танхим, 2012.7.06







# 2

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААН (2012 - 2016)



**УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТОЙМ<sup>1</sup>**

(2012.7.06 - 2016.5.24)

**НЭГ. УЛСЫН ИХ ХУРЛЫН АНХДУГААР ЧУУЛГАН (2012.07.06 - 2012.08.21)**

2012.07.06

Улсын Их Хурлын зургаа дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хурлын чуулганы анхдугаар чуулганыг Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж удирдан явуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.1.2-т заасны дагуу Улсын Их Хурлын 2012 оны ээлжит сонгуулийн дүн, сонгогдсон гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай илтгэлийг Сонгуулийн ерөнхий хорооны дарга Н.Лувсанжав тавив.

Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдвол зохих 76 гишүүнээс 72 гишүүн сонгогдсон ба Монгол ардын намаас 25, Ардчилсан намаас 31, “Иргэний зориг-Ногоон нам”-аас 2, “МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвслээс 11, бие даан нэр дэвшсэн 3 гишүүн тус тус сонгогдлоо. Улсын Их Хурлын сонгуулийн 10 дугаар тойргийн 2, 22, 26 дугаар тойргийн тус бүр 1 мандатын төлөө дахин сонгууль явуулах тухай мэдэгдэв.

Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсэн 72 гишүүнээс 69 гишүүн хуралдаанд оролцож, “МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвслээс нэр дэвшиж Улсын Их Хурлын гишүүний түр үнэмлэхээ гардан авсан Ц.Цолмон, О.Баасанхүү, Ц.Оюунбаатар нар нэгдсэн хуралдааны танхимд хүрэлцэн ирээгүй байв.

Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд заасны дагуу шинээр сонгогдсон гишүүд тангараг өргөх ёслол явагдаж, тангараг өргөсөн 69 гишүүнд Улсын Их Хурлын гишүүний үнэмлэх, энгэрийн тэмдгийг гардуулан өгөв.

Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх нь хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж баяр хүргэж, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу насаар хамгийн ахмад гишүүн Д.Дэмбэрэл хуралдааныг удирдаж, “Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

2012.07.20

Энэ өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэх байсан боловч Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд уг асуудлаар Монгол ардын намтай зөвшилцөөгүй тул Монгол ардын намын гишүүд хуралдаанд оролцох боломжгүй байгаа талаар мэдэгдэж, нэгдсэн хуралдааны танхимыг орхин гарав.

Хуралдаан даргалагч Улсын Их Хурлын гишүүн Д.Дэмбэрэл хуралдаан хаасныг мэдэгдэв.

2012.07.24

Улсын Их Хурлын даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэв. Хуралдаанд оролцож буй

<sup>1</sup> УИХ -ын Анхдугаар чуулган явцыг дотор нь 2 ангилж, “задалж” тусгав. УИХ -ын дарга, дэд дарга нарыг сонгох, Монгол Улсын Засгийн газрыг байгуулах, УИХ -ын “өөрийгөө зохион байгуулах” үйл явцыг бүлнийг II дэд гарчгийн дор тоймлов.

Улсын Их Хурлын гишүүдийн ахмад гишүүн болох Улсын Их Хурлын гишүүн Л.Цог хуралдааныг удирдан явуулахаар тогтов.

Улсын Их Хурлын гишүүн Зандаахүүгийн Энхболдыг Улсын Их Хурлын даргаар сонгож, Монгол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсын Их Хурлын даргаар сонгогдсон Зандаахүүгийн Энхболдод Улсын Их Хурлын гишүүн Л.Цог хуралдаан даргалагчийн зүгээс болон Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, Улсын Их Хурлын тамгыг алд цэнхэр хадган дээр тавьж гардуулан өгөв.

Улсын Их Хурлын даргад сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн Зандаахүүгийн Энхболд үг хэлэв.



Улсын Их Хурлын дарга Зандаахүүгийн Энхболд

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Ардчилсан намаас Ардчилсан намын бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн гишүүдийн нэрсийн жагсаалтыг бичгээр ирүүлснийг уншиж танилцуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг албан ёсоор байгуулагдсаныг зарлав. Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн даргаар Улсын Их Хурлын гишүүн Дондогийн Эрдэнэбат сонгогдсоныг мэдээлэв.

Мөн “МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвслээс ирүүлсэн бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн гишүүдийн нэрсийн жагсаалтыг бичгээр ирүүлснийг уншиж танилцуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг албан ёсоор байгуулагдсаныг зарлав. Улсын Их Хурал дахь “МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвслийн бүлгийн даргаар Улсын Их Хурлын гишүүн Намдагийн Батцэрэг сонгогдсоныг мэдээлэв.

2012.07.25

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны бүрэлдэхүүний тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.



2012.08.01


“МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвслээс нэр дэвшин сонгогдсон О.Баасанхүү, Ц.Цолмон нар Улсын Их Хурлын гишүүний тангараг өргөж, энгэрийн тэмдгээ гардаж авлаа. Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Агипарын Бакейг сонгов.

Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав.

\* \* \*

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ДОТООД БҮТЭЦ<sup>2</sup>**



<sup>2</sup> УИХ -ын зохион байгуулалтын бүтцийн “Мянганы хөгжлийн зорилтууд болон ядуурлыг бууруулах асуудлын дэд хороо” (хожим, явцын дунд) Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо болж нэр нь нь өөрчлөгдсөн. [Ред.]

2012.08.07

Улсын Их Хурлын Байнгын хороодын бүрэлдэхүүний тухай, Төрийн байгуулалтын байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолуудыг батлав.

Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох тухай Улсын Их Хурлын тогтоолыг баталж, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Цэрэндашийн Цолмон, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Гарьдхүүгийн Баярсайхан, Төсвийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн, Эдийн засгийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Батхүүгийн Гарамгайбаатар нарыг тус тус сонгов.

2012.08.08

Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай Улсын Их Хурлын тогтоолыг баталж, Улсын Их Хурлын гишүүн Чүлтэмийн Улааныг Улсын Их Хурлын дэд даргаар сонгов.

Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох тухай Улсын Их Хурлын тогтоолыг баталж, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Зангадын Баянсэлэнгэ, Хууль зүйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Шаравдоржийн Түвдэндорж нарыг тус тус сонгов.



Улсын Их Хурлын дэд дарга С. Баярцогт



Улсын Их Хурлын дэд дарга Ч. Улаан

2012.08.09

Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуягийг Ерөнхий сайдаар томилуулах саналыг Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж танилцуулж, Норовын Алтанхуягийг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилов.

2012.08.16

Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай, Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулиудыг батлав.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлээд, анхны хэлэлцүүлгийг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.



2012.08.17

Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай Улсын Их Хурлын тогтоолыг баталж, Улсын Их Хурлын гишүүн Сангажавын Баярцогтыг Улсын Их Хурлын дэд даргаар сонгов.

Өргөдлийн байнгын хорооны даргыг сонгох тухай Улсын Их Хурлын тогтоолыг баталж, Өргөдлийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Раднаагийн Бурмааг сонгов.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч батлах тухай Улсын Их Хурлын тогтоол, хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувийн хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Инновацийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жолоочийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Концессын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын хөгжлийн банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиуд болон Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын 2010 оны 34 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах тухай, Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолуудыг батлав.

\* \* \*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭЛДЭХҮҮН

(Шинэчлэлийн Засгийн газрын кабинетийг бүрдүүлсэн нь)

2012.8.17

Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Засгийн газрын гишүүдийг томилуулах саналыг Монгол Улсын Ерөнхий сайд Норовын Алтанхуяг танилцуулав.

- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар Чимэдийн Сайханбилэгийг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гадаад хэргийн сайдаар Лувсанвандангийн Болдыг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүйн сайдаар Хишигдэмбэрэлийн Тэмүүжинг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайдаар Цэвэлмаагийн Баярсайханыг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайдаар Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнийг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайдаар Лувсаннъямын Гантөмөрийг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн сайдаар Амаржаргалын Гансүхийг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлалын сайдаар Цэдэвдамбын Оюунгэрэлийг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Уул уурхайн сайдаар Даваажавын Ганхуягийг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдаар Халтмаагийн Баттулгыг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хөдөлмөрийн сайдаар Ядамсүрэнгийн Санжмятавыг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдаар Содномзундуйн Эрдэнийг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эдийн засгийн хөгжлийн сайдаар Нямжавын Батбаярыг тус тус томилов.

Монгол Улсын Засгийн газрын зарим гишүүнийг томилох тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

2012.8.20

Чүлтэмийн Улааныг Улсын Их Хурлын дэд даргын үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг томилох тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.





## ШИНЭЧЛЭЛИЙН ЗАСГИЙН ГАЗАР



Монгол Улсын сайд,  
ЗГХЭГ-ын дарга  
Ч.Сайханбилэг



Монгол Улсын Ерөнхий сайд  
Норовын Алтанхуяг



Монгол Улсын  
Шадар сайд  
Д.Тэрбишдагва



Байгаль орчин, но-  
гоон хөгжлийн сайд  
С.Оюун



Гадаад харилцааны  
сайд Л.Болд



Сангийн сайд  
Ч.Улаан



Хууль зүйн сайд  
Х.Тэмүүжин



Барилга, хот  
байгуулалтын сайд  
Ц.Баярсайхан



Батлан хамгаалахын  
сайд Д.Бат-Эрдэнэ



Боловсрол, шинжлэх  
ухааны сайд  
Л.Гантөмөр



Зам, тээврийн сайд  
А.Гансүх



Соёл, спорт, аялал  
жуулчлалын сайд  
Ц.Оюунгэрэл



Уул уурхайн сайд  
Д.Ганхуяг



Үйлдвэр, хөдөө  
аж ахуйн сайд  
Х.Баттулга



Хөдөлмөрийн сайд  
Я.Санжмятав



Хүн амын хөгжил,  
нийгмийн хамгаал-  
лын сайд С.Эрдэнэ



Эдийн засгийн  
хөгжлийн сайд  
Н.Батбаяр



Эрчим хүчний сайд  
М.Сономпил



Эрүүл мэндийн  
сайд  
Н.Удвал

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайдаар  
Дэндэвийн Тэрбишдагвыг;

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдаар  
Санжаасүрэнгийн Оюуныг;

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайдаар Чүлтэмийн Улааныг;

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрчим хүчний сайдаар Мишигийн  
Сономпилийг;

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайдаар Нацагийн Удвалыг тус  
тус томилов.

Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай Улсын Их Хурлын тогтоолыг баталж, Улсын  
Их Хурлын гишүүн Логийн Цогийг Улсын Их Хурлын дэд даргаар сонгов.

2012.08.21

Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын  
тогтоолыг батлав.

Монгол Улсын Их Хурлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай Улсын Их Хурлын  
тогтоолыг батлав.

Монгол Улсын Их Хурлын 2012 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан Улсын  
Их Хурлын анхдугаар чуулган бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөн 71 гишүүнтэйгээр  
үйл ажиллагаагаа явуулж, Улсын Их Хурлын дарга З.Энхболд хааж үг хэлснээр өндөрлөв.

\* \* \*



## ХОЁР. УЛСЫН ИХ ХУРЛЫН ДОТООД ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТОЙМ

## А. УИХ -ын үйл ажиллагааны эрхзүйн зарим зохицуулалт

1. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19.1 дүгээр зүйлээс ...
  - Байнгын хороо нь хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх, эрхлэх асуудлын хүрээнд төрийн бодлого, Улсын Их Хурлын үйл ажиллагааг боловсронгуй болгох санал боловсруулах, Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэйгээр ажиллана.
2. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24.3 дугаар зүйлээс ...
  - Дэд хороод нь харьяалагдах Байнгын хорооны эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцаж бодлогын баримт бичиг, асуудал боловсруулах буюу санал, дүгнэлт гаргаж, түүнийгээ харьяалагдах Байнгын хороонд, шаардлагатай бол Байнгын хороогоор уламжлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, түүнчлэн хариуцсан асуудлын хүрээнд хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх эрхтэй бөгөөд дараахь асуудлыг эрхэлнэ.
3. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлээс ...
  - Тодорхой асуудлыг шалган судалж санал боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий түр хороог Улсын Их Хурлын тогтоолоор байгуулан ажиллуулж болно.
  - Түр хороо зөвхөн гишүүдээс бүрдэх бөгөөд түүний бүрэлдэхүүн, ажиллах хугацааг тухай бүр тогтооно.
  - Түр хороо хариуцуулсан ажлын гүйцэтгэлийг хангахдаа Байнгын хороотой адил эрх эдэлнэ.
  - Түр хороо хариуцуулсан ажлын гүйцэтгэлийг хангаж, ажлынхаа дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулан зохих шийдвэр гаргуулмагц түүнийг Улсын Их Хурал татан буулгана.

## В. УИХ -ын эрхэм зорилго, зорилтууд

Монгол Улсын Их Хурал ээлжит нэгэн бүрэн эрхийнхээ хугацаанд, өмнө бодлогын баримт нэгэнт тодорхойлогдсон эрхэм зорилгын төлөө ажилласан.

- Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх, Монголын ард түмний засаглах эрхийг хангах нь Улсын Их Хурлын эрхэм зорилго мөн.

Улсын Их Хурлын стратеги зорилтууд нь УИХ -ын Стратеги төлөвлөгөөнд Монгол тодорхойлогдсон болно. Үүнд:

1. Ардчилсан нийгмийн хөгжлийн чиг хандлага, зарчмын дагуу хууль тогтоох үйл ажиллагааны зохион байгуулалтыг бүх талаар хөгжүүлэх, чанар, үр дүнг дээшлүүлэх.
2. Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагааны арга хэлбэр, зохион байгуулалтыг улам боловсронгуй болгож, түүний үр нөлөөг дээшлүүлэх.
3. Улсын Их Хурал нь ардчилсан зарчимд тулгуурлан үйл ажиллагааныхаа ил

тод, нээлттэй байдлыг бүх талаар хангах.

4. Улсын Их Хурлын гадаад харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, парламент хоорондын хамтын ажиллагааны үр дүнг дээшлүүлэх.
5. Парламентын ажлын мэргэшсэн алба болох Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагааны зохион байгуулалт, үйлчилгээний арга хэлбэр, чанарыг сайжруулах.

**В. УИХ -ын үйл ажиллагааны төрөл, хуралдааны хэлбэр (УИХ -ын тухай хуулийн заалтыг үндэслэв)**



**УИХ -ын чуулганы хуралдааны хэлбэр**



**С. Улсын Их Хурлын байнгын хороодын бүтэц (2012 - 2016)**

Монгол Улсын Их Хурлын 6 дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаандаа Улсын Их Хурлын зохион байгуулалтын хэлбэр болох Байнгын, дэд хороод дараах бүтэцтэй байв. Үүнд:

**Улсын Их Хурлын байнгын ба дэд, түр****а. Байнгын хороо**

- Аюулгүй байдал, гадаад бодлогын;
- Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн;
- Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны;
- Өргөдлийн;
- Хууль зүйн;
- Төрийн байгуулалтын;
- Төсвийн;
- Эдийн засгийн;

**б. Дэд хороо**

- Агаарын бохирдлыг бууруулах асуудлын;
- Тусгай хяналтын;
- Ёс зүйн;
- Нутгийн удирдлагын;
- Улсын Их Хурлын гишүүдийн халдашгүй байдлын;
- Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын;
- Төсвийн зарлагын хяналтын;
- Хүний эрхийн;
- Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн;
- Тогтвортой хөгжлийн зорилгуудын дэд хороо (Мянганы хөгжлийн зорилтууд болон ядуурлыг бууруулах)

**Д. Улсын Их Хурлын байнгын хороодын бүрэлдэхүүн (2012 - 2016)****1. АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО**

Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, Монгол Улсын батлан хамгаалах, зэвсэгт хүчин, төрийн нууцын хадгалалт, хамгаалалт, гадаад бодлого, гадаад улс, олон улсын байгууллагад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах, Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улс олон улсын байгууллагад элсэх тухай, цөмийн энерги ашиглах, цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах бодлогын чиг үүрэг хариуцна.

**Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга нар**

- Ц.Цолмон (2012 - 2013)
- Ц.Оюунбаатар (2013 - 2014)

- Ж.Энхбаяр (2014 - 2016)
- М.Сономпил (2016)

Байнгын хорооны гишүүд (2016 оны байдлаар)

- |                |                |              |
|----------------|----------------|--------------|
| - Р.Амаржаргал | - Л.Болд       | - М.Сономпил |
| - Сү.Батболд   | - Б.Болор      | - Л.Цог      |
| - Х.Баттулга   | - Д.Дэмбэрэл   | - Ц.Цолмон   |
| - Г.Батхүү     | - Н.Номтойбаяр | - Н.Энхболд  |
| - М.Батчимэг   | - С.Оюун       | - Ж.Энхбаяр  |
| - Д.Бат-Эрдэнэ | - О.Содбилэг   | - З.Энхболд  |
| - Ц.Баярсайхан |                |              |

2. БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРОО

Газар тариалан, үрийн аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн бодлого, хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хяналт, тэдгээрийн аюулгүй байдал, хөдөөгийн хөгжлийн бодлого, хөдөөг хөгжүүлэх бодлоготой холбоотойгоор хэрэгжих гадаад орны болон олон улсын байгууллагын зээл тусламжийн асуудал, мал аж ахуйн бодлого, малын даатгал болон малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал, агаар мандал болон байгалийн бусад баялаг, улсын тусгай хамгаалалттай газар, бэлчээр, тариалангийн газар, геологи, уул уурхайн холбогдолтой эрэл, хайгуул, ашиглалтын ажилд тавих байгаль орчны хяналт, агаарын бохирдол, хорт бодис, байгаль орчны асуудал, цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын болон цаг уур, орчны хяналтын асуудал, усны бодлого, нөөц, усны бохирдол, хог хаягдал, дахин боловсруулалт, байгаль орчны бодлого, байгаль орчны судалгаа, хөгжил, ан агнуур, газрын сангийн нэгдсэн бодлого, зохицуулалт, газрын кадастр, зураглалын чиг үүрэг хариуцна.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга нар

- Г.Баярсайхан (2012 - 2014)
- Су.Батболд (2014 - 2015)
- Л.Эрдэнэчимэг (2015-2016)

Байнгын хорооны гишүүд (2016 оны байдлаар)

- |                |                 |                 |
|----------------|-----------------|-----------------|
| - Д.Арвин      | - Г.Баярсайхан  | - С.Оюун        |
| - О.Баасанхүү  | - Х.Болорчулуун | - Ц.Оюунгэрэл   |
| - Су.Батболд   | - Р.Бурмаа      | - Я.Содбаатар   |
| - Ж.Батзандан  | - Ц.Дашдорж     | - Д.Тэрбишдагва |
| - Х.Баттулга   | - Б.Наранхүү    | - Ч.Хүрэлбаатар |
| - Б.Бат-Эрдэнэ | - Н.Номтойбаяр  | - Ж.Энхбаяр     |
|                |                 | - Л.Эрдэнэчимэг |

3. НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРОО

Хүн ам, хөгжлийн бодлого, эрүүл мэнд, нийгмийн халамж, хамгааллын бодлого, нийтийн биеийн тамир, спортын талаархи бодлого, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр хамгаалал, боловсрол, соёл, урлаг, шинжлэх ухаан, ард түмний түүх, соёл, оюуны өвийг хамгаалах, сэргээх бодлого, монгол хэл, бичиг, үндэстний

цөөнхийн хэл, бичиг, ёс заншил, жендерийн тэгш байдлыг хангах бодлогын чиг үүрэг хариуцна.

Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дарга нар

- З.Баянсэлэнгэ (2012 - 2013)
- Д.Батцогт (2013-2016)

Байнгын хорооны гишүүд (2016 оны байдлаар)

- |                 |                |                 |
|-----------------|----------------|-----------------|
| - Д.Арвин       | - С.Одонтуяа   | - Д.Сумъяабазар |
| - А.Бакей       | - Ё.Отгонбаяр  | - А.Тлейхан     |
| - Д.Батцогт     | - Ц.Оюунгэрэл  | - Д.Хаянхярваа  |
| - З.Баянсэлэнгэ | - Я.Санжмятав  | - Л.Энх-Амгалан |
| - Г.Баярсайхан  | - Д.Сарангэрэл | - С.Эрдэнэ      |
| - Л.Гантөмөр    | - Я.Содбаатар  | - Л.Эрдэнэчимэг |
| - С.Дэмбэрэл    |                |                 |

#### 4. ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРОО

Иргэд, байгууллагаас Улсын Их Хурал, түүний Байнгын болон дэд, түр хороо, тэдгээрийн удирдлага, гишүүнд ирүүлсэн өргөдлийг судлах, шийдвэрлэх асуудлын чиг үүрэг хариуцна.

Өргөдлийн байнгын хорооны дарга нар

- Р.Бурмаа (2012 - 2015 )
- О.Баасанхүү (2015 - 2016 )
- Ж.Батзандан (2016)

Байнгын хорооны гишүүд (2016 оны байдлаар)

- |               |               |                |
|---------------|---------------|----------------|
| - Д.Арвин     | - Р. Бурмаа   | - Д.Сарангэрэл |
| - О.Баасанхүү | - С.Бямбацогт | - О.Содбилэг   |
| - Ж.Батзандан | - С.Ганбаатар | - Ш.Түвдэндорж |
| - Ж.Батсуурь  | - М.Зоригт    | - Д.Хаянхярваа |
| - М.Батчимэг  | - С.Одонтуяа  | - М.Энхболд    |

#### 5. ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРОО

Эрх зүйн бодлого, хүний эрх, эрх чөлөө, түүний баталгаа, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого, улсын хил хамгаалалтын бодлого, хууль зүйн хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэс, ялын бодлого, шүүх, прокурор, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, нийтийн болон хувийн өмчийн эрх зүйн үндэс, эрүү, иргэн, захиргааны байцаан шийтгэх ажиллагаа, өршөөл үзүүлэх асуудал, патент, зохиогчийн эрх, барааны тэмдэг, цагаачлал, иргэний харьяалал, архив, эрх зүйн туслалцаа, өмгөөлөл, иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиг үүрэг хариуцна.

Хууль зүйн байнгын хорооны дарга нар

- Ш.Түвдэндорж (2012 - 2014 )
- Д.Ганбат (2014 - 2016 )

Байнгын хорооны гишүүд (2016 оны байдлаар)

- О.Баасанхүү	- Д.Лүндээжанцан	- Ш.Түвдэндорж
- Ж.Батзандан	- Ц.Нямдорж	- Х.Тэмүүжин
- Б.Бат-Эрдэнэ	- Ё.Отгонбаяр	- Б.Чойжилсүрэн
- З.Баянсэлэнгэ	- Ц.Оюунбаатар	- З.Энхболд
- Л.Болд	- Ц.Оюунгэрэл	- Ө.Энхтүвшин
- Д.Ганбат	- Д.Оюунхорол	- С.Эрдэнэ
- Р.Гончигдорж		

## 6. ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО

Төрийн эрх барих дээд болон гүйцэтгэх дээд байгууллага, Ерөнхийлөгчийн асуудал, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, хилийн цэс, төрийн алба, төрийн бэлгэ тэмдэг, төрийн дуулал, ард нийтийн санал асуулга, төр, сүм хийдийн харилцаа, хэвлэл мэдээллийн хараат бус байдал, төрийн ба төрийн бус байгууллага, улс төрийн намтай харилцах, гишүүний бүрэн эрхийн асуудал, гишүүний ёс зүй, гишүүний хөдөлмөр, ахуйн асуудал, Улсын Их Хурал, гишүүний төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт, гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлэг, чуулганы хуралдааны дэгийн асуудлын чиг үүрэг хариуцна.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга нар

- А.Бакей (2012-2016)

Байнгын хорооны гишүүд (2016 оны байдлаар)

- Н.Алтанхуяг	- М.Батчимэг	- Ч.Сайханбилэг
- А.Бакей	- С.Баярцогт	- О.Содбилэг
- Н.Батбаяр	- Р. Гончигдорж	- Х.Тэмүүжин
- С.Батболд	- Ц.Дашдорж	- Г.Уянга
- Су.Батболд	- С.Дэмбэрэл	- Л.Цог
- Г.Батхүү	- Д.Лүндээжанцан	- М.Энхболд
		- Н.Энхболд

## 7. ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

Улсын нэгдсэн төсөв, түүний гүйцэтгэл, хяналт, төрийн санхүү, зээлийн болон татварын бодлого, аудитын асуудал, гадаад улс, олон улсын санхүүгийн байгууллагатай байгуулсан зээлийн гэрээ, хэлцэл, Улсын Их Хурлын төсөв, төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор Засгийн газраас гаргах үнэт цаасны тухай асуудлын чиг үүрэг хариуцна.

Төсвийн байнгын хорооны дарга нар

- Ц.Даваасүрэн (2012 - 2014)
- Б.Болор (2014 - 2015)
- Ч.Улаан (2015-2016)

-



Байнгын хорооны гишүүд (2016 оны байдлаар)

- |                 |                 |                 |
|-----------------|-----------------|-----------------|
| - Р. Амаржаргал | - Д.Ганхуяг     | - Ч.Улаан       |
| - Н.Батбаяр     | - Ц.Даваасүрэн  | - Ч.Хүрэлбаатар |
| - Б.Болор       | - Ц.Оюунбаатар  | - Б.Чойжилсүрэн |
| - Д.Батцогт     | - Д.Оюунхорол   | - Ж.Эрдэнэбат   |
| - М.Зоригт      | - Я.Санжмятав   | - Д.Эрдэнэбат   |
| - Д.Дэмбэрэл    | - Д.Сумъяабазар | - Л.Эрдэнэчимэг |
| - Б.Наранхүү    |                 |                 |

## 8. ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО

Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, эдийн засгийн дотоод, гадаад бодлого, бүсчилсэн хөгжил, төрийн мөнгөний бодлого, банк, Монголбанкны үйл ажиллагаа, даатгалын бодлого, төрийн өмчийн удирдлага, зохицуулалт, хувьчлалын бодлого, гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламжийн нэгдсэн бодлого, ашигт малтмалын суурь судалгаа, эрэл хайгуул, ашиглалтын бодлого, газрын тосны асуудал, үйлдвэрлэл, үйлчилгээ, хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого, шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах бодлого, төрөөс аж ахуй эрхлэлтийг дэмжих бодлого, стандартчилал, хэмжил зүй, чанарын баталгаажуулалт, албан ёсны статистикийн үйл ажиллагааны зохицуулалт, үйлдвэрлэлийн бүтээмжийн өсөлт, барилга, хот байгуулалт, түлш, эрчим хүч, зам тээвэр, шуудан, орон сууц, нийтийн аж ахуй, аялал жуулчлалын хөгжлийн стратеги, аялал жуулчлалын дэд бүтцийн хөгжил, мэдээлэл, технологийн хөгжил, харилцаа холбоо, техник, технологийн шинэчлэл, газрын эдийн засгийн үр ашгийн бодлогын чиг үүрэг хариуцна.

Эдийн засгийн байнгын хорооны дарга нар

- Б.Гарамгайбаатар (2012 - 2014)
- Ж.Батсуурь (2014 - 2015 )
- Ц.Баярсайхан (2015 - 2016)

Байнгын хорооны гишүүд (2016 оны байдлаар)

- |                 |                    |                 |
|-----------------|--------------------|-----------------|
| - Н.Батбаяр     | - Д.Ганбат         | - Ц.Нямдорж     |
| - Н.Батцэрэг    | - Д.Ганхуяг        | - С.Одонтуяа    |
| - Ж.Батсуурь    | - Б.Гарамгайбаатар | - А.Тлейхан     |
| - Д.Бат-Эрдэнэ  | - Ц.Даваасүрэн     | - Г.Уянга       |
| - Ц.Баярсайхан  | - С.Дэмбэрэл       | - Л.Энх-Амгалан |
| - Х.Болорчулуун | - Д.Зоригт         | - Ө.Энхтүвшин   |
| - С.Бямбацогт   |                    |                 |

## Е. Дэд хороодын бүрэлдэхүүн (2012 - 2016)

## 1. Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо (БОХХААБХ)

Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо нь улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах асуудлаархи хууль тогтоомжийн биелэлтийн асуудлын чиг үүрэг хариуцна.

Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хорооны дарга нар

- Л.Эрдэнэчимэг (2012 - 2015)
- Ц.Оюунгэрэл (2015 - 2016)

Дэд хорооны гишүүд (2016 оны байдлаар)

- О. Баасанхүү, Су.Батболд, Х.Баттулга, Б.Наранхүү, С.Оюун, Ц.Оюунгэрэл, Я.Содбаатар, Ч. Хүрэлбаатар, Л. Эрдэнэчимэг

2. Тусгай хяналтын дэд хороо (АБГББХ)

Тусгай хяналтын дэд хороо нь төрийн нууцын хадгалалт, хамгаалалт, тагнуул болон гүйцэтгэх ажлын талаархи хууль тогтоомжийн биелэлт, улсын хил хамгаалалт, төрийн тусгай хамгаалалтын асуудлын чиг үүрэг хариуцна.

Тусгай хяналтын дэд хорооны дарга нар

- Р.Гончигдорж (2012 -2014)
- Г. Батхүү (2014 -2016)

Дэд хорооны гишүүд (2016 оны байдлаар)

- М. Батчимэг, Г. Батхүү, Д. Дэмбэрэл, Ц.Цолмон

3. Ёс зүйн дэд хороо (ТББХ)

Ёс зүйн дэд хороо нь гишүүний ёс зүй, хөрөнгө, орлогын мэдүүлэг, чуулганы хуралдааны дэгийг сахиулах асуудлын чиг үүрэг хариуцна.

Ёс зүйн дэд хорооны дарга нар

- М.Батчимэг (2012-2016)

Дэд хорооны гишүүд (2016 оны байдлаар)

- Су.Батболд, М. Батчимэг, Ж. Батзандан, З. Баянсэлэнгэ, Б.Наранхүү, Д.Сарангэрэл, Ш.Түвдэндорж, Д.Тэрбишдагва, Н. Энхболд

4. Нутгийн удирдлагын дэд хороо (ТББХ)

Нутгийн удирдлагын дэд хороо нь нутгийн өөрөө удирдах ёс, нутгийн удирдлагын байгууллагын төлөвшил, хөгжил, удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлын чиг үүрэг хариуцна.

Нутгийн удирдлагын дэд хорооны дарга нар

- Д.Батцогт (2012-2015)
- Н.Батцэрэг (2015-2016)

Дэд хорооны гишүүд (2016 оны байдлаар)

- А. Бакей, Н. Батбаяр, Су.Батболд, Н. Батцэрэг, М.Батчимэг, С.Баярцогт, Р.Гончигдорж, О. Содбилэг, Н. Энхболд

5. Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо (ТББХ)



Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо нь Улсын Их Хурал, түүний гишүүний бүрэн эрхтэй холбогдсон асуудлын чиг үүрэг хариуцна.

Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны дарга

- Р. Гончигдорж, (2012 - 2016)

Дэд хорооны гишүүд (2016 оны байдлаар)

- Р. Гончигдорж, Д. Дэмбэрэл, Д. Лүндээжанцан, С. Оюун, Ч. Улаан

#### 6. Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хороо (ТББХ)

Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хороо нь Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурлын, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын асуудлын чиг үүрэг хариуцна.

Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны дарга нар

- Ж.Батзандан (2012 - 2015)
- О. Содбилэг (2015 - 2016)

Дэд хорооны гишүүд (2016 оны байдлаар)

- Н. Алтанхуяг, Н. Батбаяр, Су. Батболд, М. Батчимэг, С. Баярцогт, О. Содбилэг, Х.Тэмүүжин, Л. Цог, Н.Энхболд

#### 7. Төсвийн зарлагын хяналтын дэд хороо (ТБХ)

Төсвийн зарлагын хяналтын дэд хороо нь улсын болон орон нутгийн төсвийн орлого, зарлага, төсвийн хяналтын асуудлын чиг үүрэг хариуцна.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга нар

- Ж.Эрдэнэбат (2012-2015)
- Ч.Хүрэлбаатар (2015 - 2016)

Дэд хорооны гишүүд (2016 оны байдлаар)

- Д. Ганхуяг, М. Зоригт, Б.Наранхүү, Я. Санжмятав, Д. Сумъяабазар, Ч. Улаан, Ч.Хүрэлбаатар, Б. Чойжилсүрэн

#### 8. Хүний эрхийн дэд хороо (ХЗБХ)

Хүний эрхийн дэд хороо нь хүний эрх, эрх чөлөөний баталгаа, өршөөл, цагаачлал, иргэний харьяаллын асуудлын чиг үүрэг хариуцна.

Хүний эрхийн дэд хорооны дарга нар

- Д.Ганбат (2012 - 2015)
- Ё.Отгонбаяр (2015 - 2016)
- Л.Болд (2016)

Дэд хорооны гишүүд (2016 оны байдлаар)

- О. Баасанхүү, Ж. Батзандан, З. Баянсэлэнгэ, Л. Болд, Д. Ганбат, Ё. Отгонбаяр, Ц.Оюунбаатар, Х. Тэмүүжин, С. Эрдэнэ

9. Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо (ЭЗБХ)

Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо нь жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжил, хөрөнгө оруулалт, зээл, тусламжийн бодлого, зохицуулалтын асуудлын чиг үүрэг хариуцна.

Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хорооны дарга нар

- Х. Болорчулуун (2012 - 2013)
- С. Дэмбэрэл (2013 - 2016)

Дэд хорооны гишүүд (2016 оны байдлаар)

- Ж. Батсуурь, Х. Болорчулуун, С. Бямбацогт, Д. Ганбат, Д. Ганхуяг, С. Дэмбэрэл, С.Одонтуяа, Г. Уянга

10. Тогтвортой хөгжлийн зорилгуудын дэд хороо (НББСШУБХ) /Мянганы хөгжлийн зорилтууд болон ядуурлыг бууруулах/

Тогтвортой хөгжлийн зорилгуудын дэд хороо нь Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилгуудыг хууль тогтоомжид тусган хэрэгжүүлэх асуудлын чиг үүрэг хариуцна.

Тогтвортой хөгжлийн зорилгуудын дэд хорооны дарга нар

- Г.Уянга (2012 - 2016)
- Д.Сумъяабазар (2016)

Дэд хорооны гишүүд (2016 оны байдлаар)

- Л. Гантөмөр, С. Одонтуяа, Я. Санжмятав, Д.Сумъяабазар, А. Тлейхан, Д.Хаянхярваа, С.Эрдэнэ, Л. Эрдэнэчимэг

\* \* \*

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭЭЛЖИТ БА ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНУУД<sup>3</sup> (2012.8.29 - 2016.5.24)

1. УЛСЫН ИХ ХУРЛЫН 2012 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН (2012.08.29 - 2012.09.18)

2012.08.29

Монгол Улсын Их Хурлын 2012 оны ээлжит бус чуулганыг нээж, Улсын Их Хурлын дарга З.Энхболд үг хэлэв.

2012.08.30

Шүүхийн захиргааны тухай хуульд хэсэгчлэн тавьсан Ерөнхийлөгчийн хоригийн тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Шүүх байгуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн болон “Шүүгчийн орон тоо тогтоох тухай”, “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн болон холбогдох Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлаар Улсын Их Хурал дахь “МАХН, МҮАН -ын Шударга ёс” эвслийн бүлгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Батцэрэг завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав.

2012.09.04

Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Орон нутгийн сонгуулийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулиудын болон холбогдох Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийг батлав.

Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2012 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2012 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

<sup>3</sup> УИХ -ын Хүндэтгэлийн хуралдаанууд (2013.07.10, 2013.10.25, 2014.08.22, 2015.05.17, 2015.09.13) -ын мэдээг чуулганы нэгдсэн хуралдааны энэхүү тоймд оруулав. Харин, Хүндэтгэлийн хуралдаанууд дээр төр засгийн тэргүүн, гадаад дотоодын хүндэт зочид, албаны хүмүүсийн хэлсэн үгсийг дараагийн III бүлэгт ялгаж байршуулав.

тухай хуулиудын төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороодод шилжүүлэв.

2012.09.07

Шүүхийн захиргааны тухай хуулийн 13 дугаар зүйлд хэсэгчлэн тавьсан Ерөнхийлөгчийн хоригийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Хууль зүйн байнгын хорооноос боловсруулан оруулсан Шүүхийн захиргааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг батлав.

Шүүх байгуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон Шүүгчийн орон тоо тогтоох тухай, Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, цалингийн сан тогтоох тухай тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолуудыг батлав.

Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2012 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2012 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн болон Тогтоолд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв. Харин Хүний хөгжил сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх асуудлыг хойшлуулах горимын саналыг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт гаргасан нь дэмжигдсэнээр уг хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хойшлуулахаар болов.

2012.09.11

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиуд болон Тогтоолд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай Улсын Их Хурлын тогтоолуудыг батлав.

Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2012 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2012 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийн гурав дахь хэлэлцүүлгийг хийж, дөрөв дэх хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.



Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

2012.09.14

Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг батлав.

Монголбанкны Ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөх, томилох тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2012 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2012 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг батлав.

«Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2012 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай тогтоолд нэмэлт оруулах тухай» Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Орон нутгийн сонгуулийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулиудын болон Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлав.

«Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай» Улсын Их Хурлын тогтоолын төсийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

2012.09.18

Виз олгох нөхцөлийг хөнгөвчлөх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг батлав.

Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012 оны ээлжит бус сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Зардлын хэмжээг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Улсын Их Хурлын 2012 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлыг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх, гишүүнээр томилох тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

“Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай» Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг анхны хэлэлцүүлгээр нь батлав.

\*\*\*

## 2. УЛСЫН ИХ ХУРЛЫН 2012 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН (2012.10.01 - 2013.02.08)

2012.10.01

Улсын Их Хурлын 2012 оны намрын ээлжит чуулганыг нээж, Улсын Их Хурлын дарга З.Энхболд үг хэлэв.

2012.10.04

Монгол Улсын 2011 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2011 оны санхүүгийн нэгдсэн тайланг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон холбогдох Байнгын хороодод шилжүүлэв.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсаас Бутаны Вант Улстай дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсаас Бүгд Найрамдах Панам Улстай дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Хүнсний тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

2012.10.05

Энэ өдрийн хуралдаанд Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчдийн талаар Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Ц.Зориг танилцуулав.

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай, Сонгуулийн ерөнхий хорооны даргыг томилох тухай, Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн даргыг томилох тухай, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох тухай, Монголбанкны Дэд ерөнхийлөгчийг томилох тухай Улсын Их Хурлын тогтоолуудыг батлав.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг “Засгийн газрын үйл ажиллагааны талаар” мэдээлэл хийв.

2012.10.11

Монгол Улсын Ерөнхий аудиторовын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай, Монгол Улсын Ерөнхий аудиторовын үүрэгт ажилд томилох тухай Улсын Их Хурлын тогтоолуудыг батлав.

Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг анхны хэлэлцүүлгээр нь батлав. Монгол Улсын 2013 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуулиудын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхлэв.





2012.10.12

Монгол Улсын 2013 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуулиудын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг хийж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон холбогдох Байнгын хороодод шилжүүлэв.

“Үнэт цаас гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын болон Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн болон Төсвийн байнгын хороодод шилжүүлэв.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

“Чингис хаан” одон бий болгох тухай Улсын Их Хурлын 2002 оны 21 дүгээр тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

2012.10.18

УИХ –ын чуулганы нэгдсэн хуралдаан (2012.10.19 –ний өдрийн) –аар хэлэлцэх асуудлын хуваарь гарав. Уг хуваарьт,

- Улсын Их Хурлын зарим гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай асуудал,
- Монгол Улсын 2011 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2011 оны санхүүгийн нэгдсэн тайлан /хоёр дахь хэлэлцүүлэг/ ... гээд нийт 11 асуудал орсон байв.

2012.10.19

УИХ -ын чуулганы нэгдсэн хуралдаан 10.00 цагт эхлэх ёстой байсан ч үүсээд буй нөхцөл байдлын улмаас хуралдаан цагтаа эхлээгүйгээр барахгүй хэзээ эхлэх нь тодорхойгүй байдалд орсон.

Урьд өдөр нь Төрийн ордны гадна МАН-ын гишүүд, дэмжигчид СЕХ-ны шийдвэрийг эсэргүүцэн жагсаж, Төрийн ордон руу гишүүдийг нэвтрүүлэхгүй, орж, гарах гарцыг хэсэг зуур хаасан бол энэ өдөр Төрийн ордон дотор ч МАН -аас УИХ-д сонгогдсон гишүүд чуулганы нэгдсэн хуралдааны танхимын ар, өвөр хаалгыг таглан суулт хийснээр УИХ -ын чуулган бүтэн өдөржингөө хуралдаж чадаагүй юм.

УИХ -ын чуулганы нэгдсэн хуралдаан “дивантай суулт” аас болж тасалдсантай холбогдох мэдээг Эмхэтгэлийн агуулгын “Үйл явдлын товчоон” бүлэгт дэлгэрэнгүй тэмдэглэсэн тул энд товч дурдав.

2012.10.24

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2013 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2014-2015 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн зарим заалтыг

хүчингүй болсонд тооцох тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Концессын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн болон “Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2013 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл (Монгол Улсын 2013 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуулиудын төслийг дагалдан өргөн мэдүүлсэн)-ийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон холбогдох Байнгын хороодод шилжүүлэв.

Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул Хуулийн төсөл буцаах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийн анхны хэлэлцүүлгийг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Үнэт цаас гаргах зөвшөөрөл олгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын 2011 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг батлав. Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсын Засгийн газраас Арабын Нэгдсэн Эмират Улс, Нидерландын Вант Улс, Люксембургийн Вант Улс, Кувейт Улстай тус тус байгуулсан “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээр”-ийг соёрхон баталсан тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

2012.10.25

Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.



Монгол Улсын нэгдсэн төсвийн 2013 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2014-2015 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Концессын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд болон “Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2013 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолыг анхны хэлэлцүүлгээр батлав.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд болон Үнэт цаас гаргах зөвшөөрөл олгох тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

#### 2012.10.26

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийг батлав.

Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгаас Сангийн сайдад тавьсан “Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2012 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай Улсын Их Хурлын 2011 оны 53 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар” асуулгын хариуг Сангийн сайд Ч.Улаан танилцуулав.

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

#### 2012.11.01

Компанийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 04 дүгээр дүгнэлтийг хэлэлцэв.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын 2013 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуулиудын төслийн

хоёр дахь хэлэлцүүлгийг хийж, гурав, дөрөв дэх хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг анхны хэлэлцүүлгээр нь батлав.

2012.11.02

Монгол Улсын Засгийн газраас Арабын Нэгдсэн Эмират Улс, Нидерландын Вант Улс, Люксембургийн Вант Улс, Кувейт Улстай тус тус байгуулсан “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээр”-ийг соёрхон баталсан тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийг анхны хэлэлцүүлгээр нь батлав.

“Чингис хаан” одон бий болгох тухай Улсын Их Хурлын 2002 оны 21 дүгээр тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг “Гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах талаар Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, үйл ажиллагаа, цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийг ашиглах талаар” Засгийн газраас баримталж буй бодлогын талаар мэдээлэл хийв.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй болно.

2012.11.08

Хуулийн төсөл буцаах тухай /Улсын Их Хурлын гишүүн Р.Гончигдорж, Д.Батцогт, Х.Болорчулуун, Р.Бурмаа, Д.Эрдэнэбат нарын өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай/ Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлахыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй тул хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаахааргүй болов.

Ухнаагийн Хүрэлсүхийг Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас Цэрэнхүүгийн Шаравдоржийг чөлөөлөх тухай, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргаар Бямбадоржийн Болдбаатарыг томилох тухай Улсын Их Хурлын тогтоолуудыг батлав.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг батлав.

“Чингис хаан” одон бий болгох тухай Улсын Их Хурлын 2002 оны 21 дүгээр тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.





УИХ -ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга  
Бямбадоржийн Болдбаатар

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав. Монгол Улсын 2013 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуулиуд болон Монгол Улсын 2013 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хууль батлагдсан холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолыг анхны хэлэлцүүлгээр нь батлав.

Сонгуулийн нэмэлт зардлын тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

2012.11.09

Сонгуулийн нэмэлт зардлын тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байр, биеийн тамирын заалны барилга, хангамжийн талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх

тухай хуулийн төсөл, Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай, Хувь хүний нууцын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсаас Бүгд Найрамдах Кени Улстай дипломат харилцаа тогтоох тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат уг асуудлаар түр завсарлага авч байгаага мэдэгдэж, завсарлага авав.

Үдээс хойшхи хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв. Сонгуулийн нэмэлт зардлын тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

2012.11.23

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Татварын мэргэшсэн зөвлөхийн үйл ажиллагааны тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэг, Р.Бурмаа, С.Одонтуяа, Л.Эрдэнэчимэг нараас Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан “Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн эрчим хүчний талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн талаар” асуулгын хариуг Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг танилцуулав.

2012.11.29

Энэ өдрийн нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурал дахь “МАХН-МҮАН -ын Шударга ёс” эвслийн бүлгийн болон Монгол ардын намын гишүүд ирээгүй учраас ирц хүрээгүй болно.

2012.11.30

Энэ өдрийн нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурал дахь Иргэний зориг-Ногоон намын, “МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвслийн бүлгийн болон Монгол ардын намын гишүүд



ирээгүй учраас ирц хүрээгүй ба дараа долоо хоног хүртэл хуралдааныг хойшлуулав.

2012.12.05

Авлигын эсрэг олон улсын академийг олон улсын байгууллага болгон үүсгэн байгуулах хэлэлцээрт нэгдэн орох тухай хуулийг батлав.

Хүнсний тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

2012.12.06

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийг төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн төсөл, Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай, Хувь хүний нууцын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Хуулийн төсөл буцаах тухай /Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай/ Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Хадгаламжийн даатгалын тухай /шинэчилсэн найруулга/ болон Хадгаламжийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

2012.12.07

Монгол Улсаас гадаад улсад суух Элчин сайд, Бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүн нарыг томилох, эгүүлэн татах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг хэлэлцэв.

- Монгол Улсаас Лалын Бүгд Найрамдах Афганистан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Отгоны Дамбийнямыг;
- Монгол Улсаас Кувейт Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Содномын Энхбатыг;
- Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Баасанжавын Ганболдыг;
- Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Бадамдоржийн Батхишигийг;
- Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гунаажавын Батжаргалыг;
- Монгол Улсаас Бүгд Найрамдах Казахстан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Жагарын Сүхээг;

- Монгол Улсаас Америкийн Нэгдсэн Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Булгаагийн Алтангэрэлийг;
- Монгол Улсаас Бельгийн Вант Улс болон Европын холбоонд суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Хишигдэлгэрийн Даваадоржийг тус тус томилов.

Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ж.Энхсайхан, Америкийн Нэгдсэн Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Х.Бэхбат, Бельгийн Вант Улс болон Европын Холбоонд суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд А.Баттөр, Бүгд Найрамдах Казахстан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Х.Аюурзана, Кувейт Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд К.Сайраан, Бүгд Найрамдах Солонгос Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Д.Гэрэл, Бүгд Найрамдах Турк Улсад суугаад Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд О.Очиржав нарыг тус тус эгүүлэн татав.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг “Олон улсын зах зээл дээр арилжаалсан 1.5 тэрбум америк долларын үнэт цаасны тухай” мэдээлэл хийв.

Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

2012.12.13

Монгол Ардын намаас жагсаалтаар нэр дэвшиж, Улсын Их Хурлын гишүүнээр нөхөн сонгогдсон Даваажанцангийн Сарангэрэл, Улсын Их Хурлын сонгуулийн 10 дугаар тойргоос Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон Гаваагийн Батхүү, Улсын Их Хурлын 22 дугаар тойргоос дахин санал хураалтаар Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон Дашжамцын Арвин нарын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрүүлэх асуудлаар Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн танилцуулга хийв.

Д.Арвин, Г.Батхүү, Д.Сарангэрэл нар Улсын Их Хурлын гишүүний тангаргаа өргөж, энгэрийн тэмдгээ гардан авлаа. Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон Дашжамцын Арвин, Гаваагийн Батхүү, Даваажанцангийн Сарангэрэл нарын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн төсөл, Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай, Хувь хүний нууцын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудыг батлав.

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байр, биеийн тамирын заалны барилга, хангамжийн талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат Төсвийн байнгын хороогоор хэлэлцүүлсний дараа үргэлжлүүлэн хэлэлцье гэсэн горимын санал гаргасан нь дэмжигдсэнээр уг асуудлыг Төсвийн байнгын хороогоор хэлэлцүүлж, санал авсны дараа үргэлжлүүлэн хэлэлцэхээр болов.

Хүний хөгжил сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай Улсын Их Хурлын тогтоолын





төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Жагсаалтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Үдээс хойшхи хуралдаанаар Хүний хөгжил сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг анхны хэлэлцүүлгээр батлав.

Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай Улсын Их Хурлын тогтоолыг анхны хэлэлцүүлгээр батлав.

2012.12.14

Сэтгэцийн эрүүл мэндийн тухай /шинэчилсэн найруулга/ болон Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүүгээс Соёл, спорт, аялал жуулчлалын сайдад тавьсан “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах Үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт, соёлын өвийг хамгаалах тал дээр зохион байгуулж байгаа арга хэмжээний талаарх асуулгын хариуг Соёл, спорт, аялал жуулчлалын сайд Ц.Оюунгэрэл танилцуулав.

2012.12.20

Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтын зарим хэсэг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн Хуулийн цэцийн 2012 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 05 дугаар дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Наранчимэг танилцуулав.

Багаажавын Өнөбаатарыг Төрийн албаны зөвлөлийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх тухай болон Даваанямын Даваа-Очирыг Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнээр томилох тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Хүнсний тухай /шинэчилсэн найруулга/, Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай, Давс иоджуулж, иод дутагдлаас сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүнсний тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг батлав.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ариун цэврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд болон Хүнсний тухай болон хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Биологийн олон янз байдлын конвенцийн Генетик нөөц болон тэдгээрийг ашигласнаас үүдэх үр ашгийг шударга, эрх тэгш хуваарилах тухай Нагоягийн протоколыг соёрхон батлах тухай, Биоаюулгүй байдлын тухай Картагенийн протоколын Хариуцлага ба хохиролгүй болгох, Нагоя-Каула Лумпурын нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулиудыг батлав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Бага, дунд боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Дээд боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

2012.12.21

Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг батлав.

Жагсаалтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг анхны хэлэлцүүлгээр батлав. Татварын мэргэшсэн зөвлөхийн үйл ажиллагааны тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь “МАХН-МУАН-ын Шударга ёс” эвслийн бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Н.Батцэрэг уг асуудлаар нэг цагийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар нэг цагийн завсарлага авав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай /шинэчилсэн найруулга/, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулиуд болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай, Хуулийн төсөл буцаах тухай Улсын Их Хурлын тогтоолуудыг батлав.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг батлав.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг “Жижиг, дунд үйлдвэрийн талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаашид дэвшүүлж буй зорилтын талаар” мэдээлэл хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ө.Энхтүвшин Монгол ардын намын бүлгийн гишүүд хуралдаж, Монгол ардын намын бүлгийг албан ёсоор байгуулсан тухай шийдвэр болон бүлгийн бүрэлдэхүүнийг уншиж танилцуулав. Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурал дахь МАН-ын бүлэг байгуулагдсаныг зарлаж баяр хүргэв. МАН-ын бүлгийн даргаар Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд сонгогдсоныг мэдээлэв.

2012.12.27

Улсын Их Хурлын гишүүн Миеэгомбын Энхболдыг Улсын Их Хурлын дэд даргаар сонгох тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Улсын Ерөнхий прокурорын орлогчийг томилох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг хэлэлцэж, Улсын Ерөнхий прокурорын орлогчоор Ганбатын Эрдэнэбатыг томилов.

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай

хуулиудыг батлав. Хадгаламжийн даатгалын тухай /шинэчилсэн найруулга/ болон Хадгаламжийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийж эхлэв.

2012.12.28

Хадгаламжийн даатгалын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хуульд нэмэлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн болон “Хадгаламжийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудыг анхны хэлэлцүүлгээр батлав. Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохыг хориглох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Сэтгэцийн эрүүл мэндийн тухай /шинэчилсэн найруулга/ болон Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Улсын Их Хурлын гишүүнээр шинээр сонгогдсон Ц.Оюунбаатар Улсын Их Хурлын гишүүний тангаргаа өргөж, энгэрийн тэмдгээ гардан авлаа. Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон Цэрэндашийн Оюунбаатарын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохыг хориглох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг анхны хэлэлцүүлгээр батлав.

“Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай”, “Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

2013.01.03

Сэтгэцийн эрүүл мэндийн тухай /шинэчилсэн найруулга/ болон Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг батлав.

Шүүхийн тухай багц хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн захиргааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.



2013.01.04

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг “Хаврын бүтээн байгуулалтын ажлын бэлтгэлийн талаар” мэдээлэл хийв.

2013.01.10

Шүүх байгуулах тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн болон “Шүүгчийн орон тоо батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Хууль, тогтоолын төсөл буцаах тухай Улсын Их Хурлын тогтоол батлав.

“Улсын Их Хурлын даргын ажлын хэсгийн орон тоог батлах тухай” тогтоол хүчингүй болсонд тооцох тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Дорждамбын Зүмбэрэлхамыг Төрийн албаны зөвлөлийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай, Балтавын Цогоог Төрийн албаны зөвлөлийн даргаар томилох тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Хадгаламжийн даатгалын тухай /шинэчилсэн найруулга/, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиуд болон Хадгаламжийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав. Хуулийн төсөл буцаах тухай /Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай/ Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Шүүхийн тухай багц хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн захиргааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаахаар болов.

2013.01.11

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Байнгын хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

2013.01.17

Шүүхийн тухай багц хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Монгол улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн захиргааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиуд болон Шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав.

Шүүх байгуулах тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн болон “Шүүгчийн орон тоо батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Хилийн боомтын тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол улсын Хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн болон Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Хууль зүйн байнгын хороодод шилжүүлэв.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах болон барилгын салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны болон Эдийн засгийн байнгын хороодод шилжүүлэв.

2013.01.18

Газрын тухай /Шинэчилсэн найруулга/, Газрын төлбөрийн тухай /Шинэчилсэн найруулга/, Газрын кадастрын тухай /Шинэчилсэн найруулга/, Газар албадан чөлөөлөх тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн зарим зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Дашбалын Батбаярыг Төрийн албаны зөвлөлийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх тухай, Тогмидын Хадхүүг Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнээр томилох тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг “Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн байдлын талаар” мэдээлэл хийв.

2013.01.24

Шүүх байгуулах тухай /шинэчилсэн найруулга/, Шүүх байгуулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх байгуулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хууль болон “Шүүгчийн орон тоо батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай / шинэчилсэн найруулга/ хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Монгол Улсын Ерөнхийлөгч Хэвлэлийн эрх чөлөөний тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулиудын төслөө татан авсан тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлсэнийг уншиж танилцуулав. “Уул уурхайн хөгжил” түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

2013.01.25

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Зоригт нарын өргөн мэдүүлсэн/-ийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын өргөн мэдүүлсэн/-ийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Хаягжуулалтын тухай, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтоос Монгол Улсын Ерөнхий сайдад “Яамдын төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга нарыг үүрэгт ажлаас нь чөлөөлсөн үндэслэл болон бусад асуудлаар тавьсан” асуулгын хариуг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүүгээс Монгол Улсын Ерөнхий сайдад “Хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон малчдыг нийгмийн даатгалд хамруулах үйл ажиллагааны хэрэгжилтийн талаар” тавьсан асуулгын хариуг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэ танилцуулав.

2013.01.31

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиудын шинэчилсэн найруулгын

төслүүд болон Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай / шинэчилсэн найруулга/, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудыг батлав.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнийг томилох саналыг Улсын Их Хурлын дарга З.Энхболд танилцуулав.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнээс Пүрэвийн Оюунчимэг, Жадамбын Дашдорж нарыг чөлөөлөв. “Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнээр Пүрэвийн Оюунчимэг, Нанзадын Ганбаяр нарыг томилов. “Хүний эрхийн үндэсний комиссын гишүүдийг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсаас гадаад улсад суух зарим Элчин сайдыг томилох, эгүүлэн татах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Ерөнхийлөгчийн Хүний эрх, хуулийн бодлогын зөвлөх Ч.Өнөрбаяр танилцуулав.

- Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Шүхэрийн Алтангэрэлийг;
- Монгол Улсаас Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Нархүүгийн Тулгыг;
- Монгол Улсаас Шведийн Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Зоригийн Алтайг;
- Монгол Улсаас Бүгд Найрамдах Болгар улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Лхамсүрэнгийн Дүгэржавыг;
- Монгол Улсаас Бүгд Найрамдах Чех Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дорждамбын Зүмбэрэлхамыг тус тус томилов.

Долоожингийн Идэвхтэнг Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдын, Булгаагийн Алтангэрэлийг Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдын, Балдангийн Энхмандахыг Шведийн Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдын, Цэрэндоржийн Ганхуягийг Бүгд Найрамдах Болгар Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдын, Сүрэнгийн Цоггэрэлийг Бүгд Найрамдах Чех Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдын үүрэгт ажлаас тус тус эгүүлэн татав.

Уул уурхайн хөгжил түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг анхны хэлэлцүүлгээр батлав.

Хаягжуулалтын тухай, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах болон барилгын салбарын талаар авах





зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны болон Эдийн засгийн байнгын хороодод шилжүүлэв.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Бага, дунд боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

#### 2013.02.01

Иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотголыг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг “Оюутолгой төслийн талаар” мэдээлэл хийв.

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн болон “Тамгын газрын дүрэм батлах тухай” тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн А.Бакей нарын өргөн мэдүүлсэн/-ийг хэлэлцэхийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаахаар болов.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Сундуйн Батболд нарын өргөн мэдүүлсэн/-ийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

#### 2013.02.07

Сонгуулийн ерөнхий хорооны 2012 оны 160 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох

заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2013 оны 01 дүгээр дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Сугар танилцуулав.

Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотголыг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг батлав.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Бага, дунд боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиуд болон Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Хаягжуулалтын тухай, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудыг батлав.

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Улсын Их Хурлын 2013 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Ганхуяг нараас 2011.03.25 -ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг татан авсан тухай танилцуулав.

2013.02.08

Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр Шагдарын Батцэцэгийг томилох тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030



он хүртэл хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг батлав.

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав.

Улсын Их Хурлын 2012 оны намрын ээлжит чуулганыг хааж Улсын Их Хурлын дарга З.Энхболд үг хэлэв.

\* \* \*



### **3. УЛСЫН ИХ ХУРЛЫН 2013 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН (2013.04.05 - 2013.07.10)**

2013.04.05

Улсын Их Хурлын 2013 оны хаврын ээлжит чуулганыг нээж Улсын Их Хурлын дарга З.Энхболд үг хэлэв. Чуулганы нээлтэд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж үг хэлэв.

2013.04.11

Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Ц.Зориг танилцуулав.

“Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн товыг товлон зарлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав. “Дахин санал хураалтын зардал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

“Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, үндсэн болон гүйлгээ сангийн зарлагын 2013 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хаалттай хуралдааны горимоор хэлэлцэв.

Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Үнэт цаасны зах зээлийн тухай /шинэчилсэн найруулга/, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

2013.04.12

Монгол судлалыг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Хууль зүйн сайд Х.Тэмүүжин Улсын Их Хурлын гишүүн Р.Амаржаргалаас “Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан Компанийн тухай хуулийн хэрэгжилтийн талаарх” асуулгын хариуг танилцуулав.

2013.04.18

Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах эсэх тухай асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар ажлын 5 хоногийн завсарлага авав.



Улсын Их Хурлын дэд дарга С.Баярцогтыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь “МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвслийн бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Н.Батцэрэг завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав.

Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

2013.04.19

Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг “Монгол Улсын эдийн засгийн төлөв байдлын талаар” мэдээлэл хийв.

Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

2013.04.25

Цагдаагийн албаны тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Галт зэвсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрдэнэсийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын цагдаагийн байгууллагын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох тухай Улсын Их Хурлын тогтоолыг баталж, Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр Дондовын Ганзоригийг томилов. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоолыг баталж, Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс Дүгэржавын Мөнхгэрэлийг чөлөөлөв.

Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогтын ёс зүйн зөрчлийн асуудлаар Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэв.

Монгол Улсын Их Хурлын дэд даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоолыг баталж, Улсын Их Хурлын дэд дарга С.Баярцогтыг үүрэгт ажлаас нь чөлөөлөв.

Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах эсэх тухай асуудлыг хэлэлцэж, Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах шаардлагагүй гэсэн саналыг дэмжив.

Маршлын албаны тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

2013.04.26

Монгол Улсын эдийн засаг, санхүү, төсвийн төлөв байдлын талаарх мэдээллийг Сангийн сайд Ч.Улаан танилцуулав.

Улсын Их Хурлын Байнгын хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнээс Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан “Монгол Улс 1990 оноос одоог хүртэлх хугацаанд дотоодоос болон гадаадын олон улсын санхүүгийн байгууллагуудаас авсан зээл, түүний ашиглалт, эргэн төлөлтийн талаарх” асуулгын хариуг Сангийн сайд Ч.Улаан танилцуулав.

2013.05.02

Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар ажлын 5 хоногийн завсарлага авав.

Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй тул Хуулийн төсөл буцаах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлагдсанд тооцлоо.

2013.05.09

Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах хэлэлцээрт оруулахаар санал



болгосон нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийг батлав.

2013.05.10

Улсын Их Хурлын дэд даргаар Улсын Их Хурлын гишүүн Р.Гончигдоржийг сонгож, Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлагдсанд тооцлоо.

Уул уурхайн сайд Д.Ганхуяг Улсын Их Хурлын гишүүн Д.Батцогтоос “Уул уурхайн сайдад тавьсан Ховд аймгийн Дарви, Цэцэг сумдын нутагт орших Хөшөөтийн нүүрсний уурхайг эзэмшиж буй “Мо Эн Ко” компанийн үйл ажиллагааны талаарх” асуулгын хариуг танилцуулав.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр - 4 төслийн нэмэлт санхүүжилт” -ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг батлав. Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг батлав.

Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон Д.Зоригт, Д.Сумъяабазар нарын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрүүлэх тухай танилцуулгыг Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн танилцуулав. Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон Д.Зоригт, Д.Сумъяабазар нар Улсын Их Хурлын гишүүний тангараг өргөж, энгэрийн тэмдгээ гардаж авлаа. Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

2013.05.16

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Прокурорын байгууллагын тухай хууль, Авлигын эсрэг хууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2013 оны 02 дугаар дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Наранчимэг танилцуулав.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай /шинэчилсэн найруулга/, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Терроризмтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Үнэт цаасны зах зээлийн тухай /шинэчилсэн найруулга/, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулиудын төслийг

эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын 2014 - 2016 оны төсвийн хүрээний мэдэгдлийн тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

2013.05.17

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг “1.5 тэрбум америк долларын Засгийн газрын үнэт цаасны зарцуулалтын талаар” мэдээлэл хийв.

2013.05.23

Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсын 2014-2016 оны төсвийн хүрээний мэдэгдлийн тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв. Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн болон “Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

“Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, цалингийн санг тогтоох тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

2013.05.24

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг анхны хэлэлцүүлгээр батлав. Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав. Монгол Улсын 2014 оны төсвийн хүрээний мэдэгдлийн тухай, 2015-2016 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг батлав.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг батлав.

Үнэт цаасны зах зээлийн тухай /шинэчилсэн найруулга/, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн





тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулиудын төсөл болон Үнэт цаасны тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Үнэт цаасны зах зээлийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төслийг дагалдан өргөн мэдүүлсэн) хуулиудын төслийг анхны хэлэлцүүлгээр батлав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Гарамгайбаатараас Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдад тавьсан “Монголбанк Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамтай хамтран 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдөр баталсан Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, байдал, Улсын Их Хурлын 2011 оны “Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоолын хэрэгжилт, үр дүнгийн талаарх асуулга”-ын хариуг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга танилцуулав.

2013.05.30

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай /шинэчилсэн найруулга/, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Терроризмтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулиудын төслийн анхны хэлэлцүүлгийг хаалттай хуралдааны горимоор хэлэлцэв.

2013.05.31

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай /шинэчилсэн найруулга/, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Терроризмтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг батлав. Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг “Барилга, хот байгуулалтын салбарын бүтээн байгуулалтын талаар” мэдээлэл хийв.

2013.06.06

“Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн болон “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /24-өөс дээш суудалтай, 45-аас дээш зорчигчийн багтаамжтай автобус, троллейбусыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай/-ийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиудын төсөл /Газрын тосны бүтээгдэхүүнийг гарган авах төслийн хүрээнд

импортоор оруулж байгаа технологийн тоног төхөөрөмж, сэлбэгийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай/-ийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиудын төсөл /Импортоор оруулж байгаа бүрэн ба хагас боловсруулалт хийсэн модон эд анги, бэлдэц, төрөл бүрийн модлог хавтан, модон хуулга, хуудсан материалыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай/-ийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

2013.06.07

“Монгол Улсын Элчин сайдын яам, Ерөнхий консулын газар, Консулын газрыг гадаадын зарим улсад нээн ажиллуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн болон “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /24 -өөс дээш суудалтай, 45 -аас дээш зорчигчийн багтаамжтай автобус, троллейбусыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай/, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиудын төсөл /Газрын тосны бүтээгдэхүүнийг гарган авах төслийн хүрээнд импортоор оруулж байгаа технологийн тоног төхөөрөмж, сэлбэгийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай/, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиудын төсөл /Импортоор оруулж байгаа бүрэн ба хагас боловсруулалт хийсэн модон эд анги, бэлдэц, төрөл бүрийн модлог хавтан, модон хуулга, хуудсан материалыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай/-ийн анхны хэлэлцүүлгийг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Хуралдаан түр завсарласан /Төсвийн байнгын хороо хуралдсан болно/-ы дараа үргэлжлүүлэн хуралдаж, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль болон “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоол, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиудыг батлав.

Үдээс хойшхи хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг цаг үеийн асуудлаар, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр “Тудамж төсөл”-ийн талаар тус тус мэдээлэл хийв.

2013.06.27

“Монгол Улсын 2012 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нэг дэх хэлэлцүүлгийг хийж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороод, нам, эвслийн бүлгүүд болон Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлэв.



2013.06.28

Улсын Их Хурлын гишүүн Б.Гарамгайбаатараас Уул уурхайн сайдад тавьсан “Газрын тосны бүтээгдэхүүний үнийн хэлбэлзлийг тогтворжуулах ажлын хүрээнд Монголбанк, Уул уурхайн яамтай хамтран 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдөр баталсан Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн явц байдлын талаарх асуулга”-ын хариуг Уул уурхайн сайд Д.Ганхуяг танилцуулав.

Статистикийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

2013.07.03

Монгол Улсын Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуулийн дүнгийн тухай Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн танилцуулав. Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөх тухай хуулийг батлав.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд хувиасаа болон Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс Ерөнхийлөгчөөр дахин сонгогдсон Цахиагийн Элбэгдоржид баяр хүргэв. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх тов тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав. Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсын 2012 оны төсвийн гүйцэтгэлийг батлав. Улсын Их Хурлын 2013 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав. Статистикийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг анхны хэлэлцүүлгээр батлав.

Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

2013.07.04

Газрын тосны тухай /шинэчилсэн найруулга/, Газрын тосны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Газрын тосны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Монгол Улсын төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нөхөрлөлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын мэргэшсэн зөвлөх

үйлчилгээний тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Маршлын албаны тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв. Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Цагдаагийн албаны тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Галт зэвсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрдэнэсийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын цагдаагийн байгууллагын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Засгийн газар, Японы олон улсын хамтын ажиллагааны банк хооронд байгуулсан экспортын зээлийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг батлав.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

2013.07.05

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нөхөрлөлийн



тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Тахарын албаны тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудыг батлав.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудыг батлав.

Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийг батлав.

Цагдаагийн албаны тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Галт зэвсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрдэнэсийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Согтууруулах ундаа ээтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын цагдаагийн байгууллагын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг батлав.

Мөрдөх албаны тухай, Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Прокурорын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг цаг үеийн асуудлаар мэдээлэл хийв.

2013.07.09

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд тус бүлгээс завсарлага авч байгаа тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нөхөрлөлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудыг батлав.

Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригтой холбогдуулан авсан завсарлагааны хугацаа дууссаныг мэдэгдэв.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд тавьсан Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсан тул “Ерөнхийлөгчийн хоригийн тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав. Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав.

2013.07.10

Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогт Монголын Парламентын гүйцэтгэх хорооны даргаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасны дагуу Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Раднаасүмбэрэлийн Гончигдоржийг Монголын Парламентын бүлгэмийн гүйцэтгэх хорооны даргаар, Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболдыг Монголын Парламентын бүлгэмийн гүйцэтгэх хорооны дэд даргаар тус тус сонгов.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын 2013 оны хаврын ээлжит чуулганыг хааж үг хэлэв.

\*\*\*

2013.07.10

УЛСЫН ИХ ХУРЛЫН ХҮНДЭТГЭЛИЙН ХУРАЛДААН болов.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолын ажиллагаа Төрийн ордны урд талбай, Их эзэн Чингис хааны хөшөөний өмнө эхлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж хүндэт харуулын цэргүүдээр хамгаалуулан Чингисийн хөшөөний зүүн урд хаалгаар гарч ирэн ард иргэдтэйгээ гар даллан мэндчилж, Чингисийн хөшөө, Есөн хөлт Их цагаан туганд хүндэтгэл үзүүлэн, суудалдаа суув. Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин хоёрдугаар зүйлд зааснаар Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон Цахиагийн Элбэгдорж Улсын Их Хуралд тангараг өргөв.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд тангаргаа өргөсөн Ерөнхийлөгчид баяр хүргэж үг хэлэв. Мөн иргэд, сонгогчдыг төлөөлж, Монгол Улсын Ерөнхий сайд асан, Монгол Улсын



гавьяат эдийн засагч Дашийн Бямбасүрэн баяр хүргэж үг хэлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж индэрт гарч Улсын Их Хурал болон ард түмэндээ хандаж үг хэлэв.

Тодруулга

*Монгол Улсын Төрийн тэргүүнээр дахин сонгогдсон Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж энэ өдрийн 11.40 цагаас буюу морин цагт Ерөнхийлөгчийн тангараг өргөв.*



**Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж**

*Энэ удаагийн Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслол анх удаа Чингис хааны хөшөөний өмнө, ард иргэдийнхээ өмнө болсноороо онцлог байсан.*

*Тангараг өргөх ёслолын өмнө Төрийн есөн хөлт цагаан туг, төрийн тамга, Үндсэн хуулийн уг эх зэргийг Төрийн ордноос залан гаргаж ирэв..*

*Монгол Улсын Ерөнхийлөгчийг тангараг өргөх ёслолын эхэнд эзэн Чингис хааны хөшөөний өмнө УИХ-ын хүндэтгэлийн чуулган хуралдсан. Уг чуулганд Ерөнхий сайд Н.Алтанхуяг, Засгийн газрын гишүүд, Үндсэн хуулийн Цэц, Улсын дээд шүүхийн гишүүд, гадаад, дотоодын зочид төлөөлөгчид оролцлоо. Гадаадын зочдын дунд Бүгд найрамдах Польш улсын Ерөнхийлөгч асан, Нобелийн шагналт, Польшийн ардчиллын бэлгэ тэмдэг Лех Валенса, АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргын ахлах зөвлөх Томика Тиллман, ОХУ-ын Холбооны зөвлөлийн нэгдүгээр орлогч дарга А.П.Торшин, БНХАУ-ын БХАТИХ-ын Байнгын хорооны дэд дарга Сянба Пинцуо, Японы Үндэсний аюулгүй байдал, хулгайлагдсан иргэд, байгалийн гамшигийн асуудал эрхэлсэн сайд Фүрүя, Энэтхэг улсын Шинэ болон сэргээгдэх эрчим хүчний сайд Ф.Абдулла, Францын Хөдөө аж ахуй, хүнс, ойн асуудал эрхэлсэн төлөөний сайд Г.Гаро, Ираны Газрын тосны сайд Р.Гасеми, БНСУ-ын Ерөнхийлөгчийн нарийн бичгийн дарга Жү Чол Ги нарын хүмүүс байв.*

*Хүндэтгэлийн чуулганы хуралдаанд УИХ-ын 76 гишүүний 69 нь хүрэлцэн ирж 90,7 хувийн ирцтэй байгааг УИХ-ын дарга З.Энхболд танилцуулж хуралдааныг нээлээ. Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржид хандан УИХ-ын дарга З.Энхболд “Энэ мөчөөс эхлэн та Үндсэн хуульд заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхээ дахин шинээр хэрэгжүүлж эхэлж байна. Та өмнөх дөрвөн жилийнхээ ажлыг тууштай үргэлжлүүлж Монгол түмнийхээ эв нэгдлийг эрхэмлэн ажиллана гэдэгт итгэж байна. Монгол төрийн тэргүүний хүндтэй ажилд тань өндөр амжилт хүсье” хэмээв.*

*Төрийн дуулал эгшиглэсний дараа Монгол Улсын Ерөнхий сайд асан Д.Бямбасүрэн баяр хүргэн үг хэлж “Ц.Элбэгдоржийг Монгол Улсын Ерөнхийлөгчөөр дахин сонгосон нь монголчууд шударга ёсны төлөө, авлигын эсрэг, Монгол орон, гэр бүл, өөрийнхөө сайн сайхны төлөө хийсэн сонголт юм. Ирэх дөрвөн жилд Монгол Улсынхаа төлөө зүтгэж чадна гэдэгт итгэснийх юм. Цагаан морин жилийн хувьсгалыг үргэлжлүүлнэ гэсэн үг юм. Төрийн их цагаан сүлд, эзэн Чингис хааны хөшөөний өмнө, ард иргэдийнхээ өмнө тангаргаа өргөж байгаад баяртай байна. Монгол түмний сүлд хийморь мандан бадрах болтугай” гэлээ.*

*Ерөнхийлөгчийг тангараг өргөж үг хэлсний дараа 2250 цэргийн албан хаагч оролцсон парад болсноор ёслолын ажиллагаа өндөрлөв.*

\* \* \*





**4. УЛСЫН ИХ ХУРЛЫН 2013 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН (2013.09.16 - 2013.09.27)**

2013.09.16

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын 2013 оны ээлжит бус чуулганыг нээж үг хэлэв.

2013.09.18

Хөрөнгө оруулалтын тухай, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тосны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Концессын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын болон Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Хөрөнгө оруулалтын сангийн тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Инновацийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

2013.09.20

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

2013.09.26

Хөрөнгө оруулалтын сангийн тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Инновацийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Хөрөнгө оруулалтын тухай, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тосны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Концессын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын болон Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Эдийн засгийн байнгын хороодод шилжүүлэв.

2013.09.27

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын 2013 оны ээлжит бус чуулганыг хааж үг хэлэв.

\* \* \*



**5. УЛСЫН ИХ ХУРЛЫН 2013 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН (2013.10.01 - 2014.01.30)**

2013.10.01

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын 2013 оны намрын ээлжит чуулганыг нээж үг хэлэв.

2013.10.03

Хөрөнгө оруулалтын тухай, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тосны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Концессын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиуд болон “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль /Хөрөнгө оруулалтын тухай хуультай хамт өргөн мэдүүлсэн/-ийг батлав.

Хөрөнгө оруулалтын сангийн тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Инновацийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудыг батлав.

Бүгд Найрамдах Солонгос Улс болон Бүгд Найрамдах Турк Улсаас Монгол Улсад тус тус суугаа Элчин сайдын яаманд олгосон газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

2013.10.04

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг цаг үеийн асуудлаар мэдээлэл хийв.

2013.10.10

Монгол Улсын 2014 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг хийж эхлэв.

2013.10.11

Монгол Улсын 2014 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр бүх Байнгын хороо, нам, эвслийн бүлэг, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлэв.

Монгол Улсаас гадаад улсад суугаа элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, гадаад бодлогын зөвлөх Л.Пүрэвсүрэн танилцуулав.

Монгол Улсаас Бүгд Найрамдах Франц Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шүхэрийн Алтангэрэл, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Балдоржийн Даваадорж, Канад Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Түвдэндоржийн Залаа-Уул, Швейцарийн Холбооны Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Лувсанцэрэнгийн Оргил нарыг тус тус эгүүлэн татав.

Бүгд Найрамдах Франц Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Мундагбаатарын Батсайханыг, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цолмонгийн Болорыг, Канад Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Раднаабазарын Алтангэрэлийг, Швейцарийн Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Ваанчигийн Пүрэвдоржийг тус тус томилов.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд явагдсан санал хураалтын дүнг Монгол Улсын Ерөнхийлөгчид албан бичгээр хүргүүлэхээр болов.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Л.Энх-Амгалан нараас Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдад тавьсан асуулгын хариуг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтоос Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдад тавьсан “Махны нөөц бүрдүүлэх, хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх асуулга”-ын хариуг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга танилцуулав.

2013.10.17

Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлж Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлэв. Дараагийн хуралдаанаар үргэлжлүүлэн хэлэлцэхээр болов.

2013.10.18

Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 334 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2013 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 03 дугаар дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Ганзориг танилцуулав. Үндсэн хуулийн цэцийн 2013 оны 03 дугаар дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоолын батлав.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг “Үнэ тогтворжуулах дэд хөтөлбөрүүд”-ийн талаар мэдээлэл хийв.



Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай Улсын Их Хурлын тогтоолыг анхны хэлэлцүүлгээр батлав.

2013.10.24

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн болон “Засгийн газарт үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай”, “Төсвийн тодотгол батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоол /Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг дагалдан өргөн мэдүүлсэн/-ыг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй тул Хуулийн төсөл буцаах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлагдсанд тооцов.

Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

2013.10.25

“Засгийн газарт үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай” Улсын Их Хурлын тогтоолыг анхны хэлэлцүүлгээр нь батлав.

Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дөрөв дэх хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

“Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолыг анхны хэлэлцүүлгээр нь батлав.

Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудыг батлав.

Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн болон Хууль зүйн байнгын хороодод шилжүүлэв.

Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр

шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Дипломат албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

\* \* \*

2013.10.25

#### УЛСЫН ИХ ХУРЛЫН ХҮНДЭТГЭЛИЙН ХУРАЛДААН

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Канад Улсын Амбан захирагч эрхэмсэг ноён Дэвид Жонстоныг Монгол Улсад албан ёсны айлчлал хийж байгаатай холбогдуулан зарласан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаан нээж үг хэлэв.

Канад Улсын Амбан захирагч эрхэмсэг ноён Дэвид Жонстон үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга хүндэт зочинд талархлаа илэрхийлж, Хүндэтгэлийн хуралдаан хаасныг мэдэгдэв.

\* \* \*

2013.10.31

Соёлын өвийг хамгаалах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрдэнэсийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Шүүхийн захиргааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүгчийн эрх



зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Архивын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын болон “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2014 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2015-2016 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуулийн зарим хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн болон “Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2014 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн/-ийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

#### 2013.11.01

Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Дипломат албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудыг батлав.

Төсвийн албаны эрх зүйн байдлын тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг Чингис бондын зарцуулалт, Монгол Улсын гадаад өр, төлбөрийн талаар мэдээлэл хийв.

#### 2013.11.07

Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль болон “Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, цалингийн санг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт

бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Шүүхийн захиргааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Архивын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн болон “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2014 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2015-2016 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуулийн зарим хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль болон “Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2014 онд хүртээх хишиг, хувийн хэмжээ тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолыг анхны хэлэлцүүлгээр нь батлав.

#### 2013.11.13

Монгол Улсын 2014 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай хуулиудын төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг анхны хэлэлцүүлгээр батлав.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэл” батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

#### 2013.11.14

Алтны худалдаанд ил тод байдлыг бүрдүүлэх тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хаалттай хуралдааны горимоор хэлэлцэв.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл / Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2013 оны 09 сарын 30-ны өдөр Монгол Улсын 2014 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн/-ийг хэлэлцэх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй тул Хуулийн төсөл буцаах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлагдсанд тооцов.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2014 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2015-2016 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

“Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт





бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын 2014 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай хуулиудын төслийг дөрөв дэх хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2014 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2015-2016 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав.

2013.11.15

Монгол Улсын 2014 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай хуулиудыг батлав.

“Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг “Гудамж” төсөл болон улсын чанартай авто замын талаар мэдээлэл хийв.

2013.11.21

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

“Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

2013.11.22

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт ажлын 5 хоногийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав.

Хилийн боомтын тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын болон Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг дараа долоо хоногийн хуралдаанаар хэлэлцэхээр хойшлуулав.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандангаас Эрүүл мэндийн сайдад тавьсан “Хордлогын яаралтай үндэсний төвийн үйл ажиллагаа болон хор судлал, хордлогын мэдээллийн талаарх асуулга”-ын хариуг Эрүүл мэндийн сайд Н.Удвал танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандангаас Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдад тавьсан “Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх асуулга”-ын хариуг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандангаас Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан “Цөмийн энергийн тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулиудын хэрэгжилтийн талаарх” асуулгын хариуг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун танилцуулав.

2013.11.28

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2013 оны 04 дүгээр дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Ганзориг танилцуулав.

Үндсэн хуулийн цэцийн 2013 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Хилийн боомтын тухай. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн болон “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо болон Хууль зүйн байнгын хороодод шилжүүлэв.

“Ногоон хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудыг анхны хэлэлцүүлгээр батлав.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

!2013.11.29

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг “Нээлттэй, ухаалаг төр лүү хийгдэж байгаа ажлуудын талаар” мэдээлэл хийв.

2013.12.05

Хилийн боомтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулиудын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэхийг хойшлуулав.



2013.12.06

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг цаг үеийн асуудлаар мэдээлэл хийв.

2013.12.12

Алтны худалдааны ил тод байдлыг бүрдүүлэх тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хаалттай хуралдааны горимоор хэлэлцэв.

Ринчиннямын Амаржаргалыг Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтийн тухай танилцуулгыг Улсын Их Хурлын дэд дарга Л.Цог, Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Бакей нар танилцуулав.

Ринчиннямын Амаржаргалыг Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөгдөх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй болно.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг анхны хэлэлцүүлгээр батлав.

Шүүхийн захиргааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Архивын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль болон “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсын төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төсөл /Газрын тосны тухай / шинэчилсэн найруулга/ хуулийн төслийг дагалдан өргөн мэдүүлсэн/-ийг хэлэлцэх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй тул Хууль санаачлагчид нь буцаах тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцов.

2013.12.13

Хяналтыг хэрэгжүүлэх журмын тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй болно.

Хуралдааны ирц хүрээгүй учраас 10 цаг 02 минутаас 11 цаг 32 минут хүртэл завсарлав.

Улсын Их Хурлын гишүүн Д.Сумъяабазараас Боловсрол, шинжлэх ухааны сайдад тавьсан “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурах нөхцөл бололцоог сайжруулах болон сурагчийн дүрэмт хувцасны талаарх” асуулгын хариуг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөр танилцуулав.

2013.12.19

Улсын Их Хурлын гишүүдийн ирцийг хурууны хээгээр бүртгэх ажил 09.00 цагаас эхэлж, санал хураалтын систем дээр Улсын Их Хурлын гишүүд туршилт хийв.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2013 оны 05 дугаар дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Наранчимэг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүд Үндсэн хуулийн цэцийн 2013 оны 05 дугаар дүгнэлтийг сонсов.

Энэ өдрийн хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт ажлын 2 хоногийн завсарлага авах тухай мэдэгдэж, энэ өдрийн хуралдааны хэлэлцэх асуудлаас завсарлага авав.

2013.12.20

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг “Хөдөлмөр эрхлэлт - 2013” мэдээллийг танилцуулав.

2013.12.24

Засгийн газрын гишүүнийг огцруулах тухай саналыг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, уг асуудлаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогт, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Хаянхярваа, Улсын Их Хурал дахь МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслийн бүлгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батцэрэг нар танилцуулав.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эдийн засгийн хөгжлийн сайд Нямжавын Батбаяр, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Чүлтэмийн Улаан нарыг огцруулах саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй болно.

2013.12.26

Үндсэн хуулийн цэцийн гишүүдэд нэр дэвшигчдийн талаар Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч Ц.Зориг танилцуулав.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр Шарын Цогтоо, Дамдинсүрэнгийн Солонго нарыг томилох саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжсэн тул Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох тухай болон Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлагдсанд тооцов.

Равсалын Ринчинбазарыг Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн даргаар, Батболдын Амарсанаа, Дүгэрээгийн Цэрэнбадам, Агваандоржийн Өнөржаргал, Жадамбаагийн Эрдэнэбилэг нарыг Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн гишүүнээр томилов. Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн даргын үүрэгт ажлаас Галбадрахын Даваажаргалыг, Хяналтын зөвлөлийн гишүүний үүрэгт ажлаас Дамдинсүрэнгийн Цэцэгмааг, Бямбажавын Ганбатыг, Гомбодоржийн Цэцгээг тус тус чөлөөлөв.



“Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлагдсанд тооцов.

Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодод шилжүүлэв.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Хилийн боомтын тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиуд болон “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Хилийн боомтын тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Харьяатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудыг анхны хэлэлцүүлгээр батлав.

2013.12.27

Байнгын хороодын дарга нарыг сонгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэв.

- Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Цэрэндашийн Оюунбаатарыг;
- Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Гарьдхүүгийн Баярсайханыг;
- Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Догсомын Батцогтыг;
- Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Агыпарын Бакейг;
- Хууль зүйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Шаравдоржийн Түвдэндоржийг;

- Эдийн засгийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Батхүүгийн Гарамгайбаатарыг;
- Өргөдлийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Раднаагийн Бурмааг тус тус сонгов.

Байнгын хороодын дарга нарыг сонгох тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны даргаар ажиллаж байсан Улсын Их Хурлын гишүүн З.Баянсэлэнгэ болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар ажиллаж байсан Улсын Их Хурлын гишүүн Ц.Цолмон нарыг чөлөөлж, энэ тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зарим заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь “МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвслийн бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Н.Батцэрэг ажлын 5 хоногийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав.

2014.01.09

Хяналтыг хэрэгжүүлэх журмын тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн эсэх тухай Үндсэн хуулийн цэцийн 06 дугаар дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн П.Очирбат танилцуулав. Үндсэн хуулийн цэцийн 2013 оны 06 дугаар дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Захиргааны хариуцлагын тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийг батлав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зарим заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, С.Бямбацогт нарын өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгтгэсэн/-ийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.



Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай болон Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудыг батлав.

Антигуа Барбуда Улстай дипломат харилцаа тогтоох тухай, Бүгд Найрамдах Бурунди Улстай дипломат харилцаа тогтоох тухай, Эритри Улстай дипломат харилцаа тогтоох тухай, Бүгд Найрамдах Палау Улстай дипломат харилцаа тогтоох тухай, Бүгд Найрамдах Сьерра Леон Улстай дипломат харилцаа тогтоох тухай, Бүгд Найрамдах Суринам Улстай дипломат харилцаа тогтоох тухай, Бүгд Найрамдах Того Улстай дипломат харилцаа тогтоох тухай, Бүгд Найрамдах Вануату Улстай дипломат харилцаа тогтоох тухай, Ямайка Улстай дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолуудыг батлав.

Хотыг дахин хөгжүүлэх тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол судлалыг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

#### 2014.01.10

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль /Хүнсний улирлын нөөц бүрдүүлэхэд шаардагдах 100.0 мянга хүртэл тонн улаан буудайг импортоор оруулах/ болон Газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг хангах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороодод шилжүүлэв.

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт эрдэс баялгийн бодлогыг намын бүлгүүд дахин ярьж нэгдсэн ойлголттой болсны дараа хэлэлцэх саналтай байгаагаа хэлж, ажлын 5 хоногийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороодод шилжүүлэв.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил,

үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Хуулийн төсөл хууль санаачлагчид нь буцаах тухай /Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай/ Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

2014.01.16

Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэнг Төсвийн байнгын хорооны даргаар сонгож, Төсвийн байнгын хорооны дарга сонгох тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг батлав.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиуд /Хүнсний улирлын нөөц бүрдүүлэхэд шаардагдах 100.0 мянга хүртэл тонн улаан буудайг импортоор оруулахад/-ыг батлав.

Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Дотоодын цэргийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Онц байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт ажлын 5 хоногийн завсарлага авах тухай мэдэгдэв.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн үүрэгт ажлаас Бадамдоржийн Батбаярыг чөлөөлж, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн үүрэгт ажлаас чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт үдээс өмнөх хуралдаан дээр Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай болон дагалдан өргөн мэдүүлсэн бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан авах завсарлагыг өгөх боломжгүй бөгөөд 2013 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн пүрэв гаригийн хуралдаанаас энэ асуудлаар завсарлага авсан учир дахин авах боломжгүй болохыг мэдэгдсэнээр үдээс хойшхи хуралдаан уг асуудлаар үргэлжлэв.





Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Дотоодын цэргийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Жагсаал цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Онц байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиуд болон Монгол Улсын төрөөс орон нутгийн хамгаалалтын талаар баримтлах бодлого батлах тухай тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Уул уурхайн сайд Д.Ганхуяг танилцуулав.

- Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнээр Монголбанкны дэд ерөнхийлөгч Энхбаярын Батшугарыг;
- Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнээр Ерөнхий сайдын эдийн засгийн бодлогын зөвлөх Одонгийн Цогтгэрэлийг;
- Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнээр Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн нарийн бичгийн дарга Хүрэлбаатарын Ганцогтыг;
- Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнээр Эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн нарийн бичгийн дарга Бэгзсүрэнгийн Шинэбаатарыг;
- Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнээр Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Жамьянгийн Батсайханыг;
- Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн гишүүнээр Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимын орлогч дарга Магваны Оюунчимэгийг тус тус томилов.
- Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол судлалыг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Галт зэвсгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр

шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн болон Төсвийн байнгын хороодод шилжүүлэв.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Прокурорын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

2014.01.17

“Үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Өргөдлийн болон Төрийн байгуулалт, Төсвийн байнгын хороодод шилжүүлэв.

Малын индексжүүлсэн даатгалын тухай, Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Эдийн засгийн байнгын хороодод шилжүүлэв.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг “Шинэчлэлийн Засгийн газрын 2013 оны үйл ажиллагааны талаар” мэдээлэл хийв.

Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Галт зэвсгийн тухай /шинэчилсэн найруулга/, Галт зэвсгийн албан татварын тухай / шинэчилсэн найруулга/, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Галт зэвсгийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Галт зэвсгийн албан татварын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Амьтны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай /шинэчилсэн найруулга/, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үйлдвэрчний эвлэлийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Худалдаа, аж



Үйлдвэрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн бус байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай /шинэчилсэн найруулга/ хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувийн хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улс төрийн намын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дээд боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Компанийн тухай /шинэчилсэн найруулга/ хуульд өөрчлөлт оруулах тухай, Хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монголын улаан загалмайн нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нөхөрлөлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны болон Төсөв, Хууль зүйн байнгын хороодод шилжүүлэв.

2014.01.23

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342 дугаар зүйлийн 342.1 дэх хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 01 дүгээр дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Сугар танилцуулав.

Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 01 дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Галт зэвсгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Хуулийн төсөл буцаах тухай /Төрийн аудитын тухай хуульд нэмэлт оруулах тухай/ Улсын Их Хурлын тогтоолын батлав.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Прокурорын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат ажлын 5 хоногийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав.

Монгол Улсын эрдэнэсийн сангийн орлого, үндсэн болон гүйлгээний сангийн зарлагын 2014 оны төсвийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хаалттай хуралдааны горимоор хэлэлцэв.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай болон Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиудын төсөл /ДЦС-4 ТӨХК -ийн суурилагдсан хүчин чадлыг өргөтгөхөд шаардагдах тоног төхөөрөмжийг импортлох/-ийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулиудын болон “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат ажлын 5 хоногийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав.

Соёлын өвийг хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийн анхны хэлэлцүүлгийг дараагийн хуралдаанаар үргэлжлүүлэн хэлэлцэхээр болов.

2014.01.24

Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Галт зэвсгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудыг батлав.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг батлав.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав.

Хамтын тэтгэврийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт ажлын 5 хоногийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав.

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатараас Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан “Дархан-Сэлэнгийн бүсийн ордуудыг түшиглэн баригдах төмөрлөгийн цогцолбор үйлдвэрийн төслийн хэрэгжилтийн явц, дотоодын хувийн хэвшлийн оролцоо болон цаашид авах арга хэмжээний талаар асуулга”-ын хариуг Уул уурхайн сайд Д.Ганхуяг танилцуулав.



Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодод шилжүүлэв.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон “Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг батлав.

2014.01.29

Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 92 дугаар тогтоол, 2012 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн 155 дугаар тогтоолын холбогдох заалт Үндсэн хуулийн зарим заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 02 дугаар дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Сугар танилцуулав.

Газрын тосны тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс хоорондын “Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийн санал хураалтыг дараагийн хуралдаанаар хураахаар болов.

Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

2014.01.30

Нууц протоколыг ил болгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хаалттай хуралдааны горимоор хэлэлцэв.

Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсын Засгийн газар, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага хооронд байгуулсан “Улаанбаатар хотын 4 дүгээр цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төслийн зээлийн хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийг батлав.

Улсын Их Хурлын 2014 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлахыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй тул уг асуудлыг Улсын Их Хурлын 2014 оны ээлжит бус чуулганаар хэлэлцэхээр болов.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын 2013 оны намрын ээлжит чуулганыг хааж үг хэлэв.

\*\*\*

**6. УЛСЫН ИХ ХУРЛЫН 2014 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН (2014.4.07 - 2014.7.01)**

2014.04.07

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын 2014 оны хаврын ээлжит чуулганыг нээж үг хэлэв.

2014.04.08

Улсын Их Хурлын 2014 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

2014.04.10

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.7, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 03 дугаар дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Т.Лхагваа танилцуулав.

Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 03 дугаар дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудыг батлав.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь МАХН-МҮАН -ын “Шударга Ёс” эвслийн бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Н.Батцэрэг ажлын 5 хоногийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав.

Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт ажлын 5 хоногийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

2014.04.11

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатаас “Уул уурхай, газрын тосны салбарт хөрөнгө оруулагчтай байгуулсан тогтвортой байдлын хөрөнгө оруулалтын болон бүтээгдэхүүн хуваах гэрээ, тэдгээрийн биелэлт, Оюутолгой төслийн хөрөнгө оруулагчтай холбоотой асуудлаар” Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Уул уурхайн сайд Д.Ганхуяг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Сундуйн Батболдоос “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдад тавьсан асуулгын хариуг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга танилцуулав.



Улсын Их Хурлын гишүүн Д.Сумъяабазараас “Агаарын бохирдол хүний эрүүл мэнд, эхийн урагт хэрхэн нөлөөлж байгаа, түүнээс урьдчилан сэргийлэх асуудлаар хийж буй ажлын талаар” Эрүүл мэндийн сайдад тавьсан асуулгын хариуг Эрүүл мэндийн сайд Н.Удвал танилцуулав.

2014.04.17

Монгол Улсаас Бүгд Найрамдах Индонез, Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд нарыг томилох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Ерөнхийлөгчийн гадаад харилцааны бодлогын зөвлөх Л.Пүрэвсүрэн танилцуулав. Бүгд Найрамдах Индонез улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Шагдарын Батцэцэгийг, Холбооны Бүгд Найрамдах Бразил улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Чулуунбаатарын Сосормааг тус тус томилов.

Чуулганы нэгдсэн хуралдаан дээр хураагдсан санал хураалтын дүнг Монгол Улсын Ерөнхийлөгчид албан бичгээр хүргүүлэхээр тогтов.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Соёлын өвийг хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

2014.04.18

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Хамтын тэтгэврийн тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Шилэн дансны тухай хуулийн төслийг хэлэлцэхийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцов.

Онцгой албан татварын тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг “Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлын талаар” мэдээлэл хийв.

2014.04.24

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудыг батлав.

Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй тул Хуулийн төслийг буцаах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлагдсанд тооцов. Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг устгах тухай протоколыг соёрхон батлах тухай хуулийг батлав.

2014.04.25

Эдийн засгийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Оюунхорол, Ж.Эрдэнэбат нараас Сангийн сайдад “2013 оны төсвийн гүйцэтгэлийг хэрэгжүүлэхэд үүссэн нөхцөл байдал, төсвийн урьдчилсан гүйцэтгэл болон Монгол Улсын Засгийн газраас Япон Улсын санхүүгийн зах зээл дээр арилжаалагдсан “Самурай” бондын хөрөнгийн эх үүсвэр, түүний зарцуулалтын талаар тавьсан асуулга”-ын хариуг Сангийн сайд Ч.Улаан танилцуулав.

2014.05.01

Эдийн засгийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь МАХН-МҮАН-ын “Шударга Ёс” эвслийн бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Н.Батцэрэг ажлын 1 хоногийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг батлахыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй тул Хуулийн төслүүдийг буцаах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлагдсанд тооцов.

Засгийн газрын гишүүнийг огцруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат ажлын 5 хоногийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл, А.Бакей, Р.Гончигдорж, Д.Лүндээжанцан, Сү.Батболд, Н.Батцэрэг нар 2014.03.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, агаарын бохирдлын талаар/-ийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Эмийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын





төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

2014.05.02

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын гишүүн, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулгын гаргасан Засгийн газрын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт заасны дагуу Засгийн газрын гишүүний үүрэгт ажлаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлтийг Улсын Их Хурлын гишүүдэд уншиж танилцуулав.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиудын төсөл /Амгалангийн дулааны станцын тоног төхөөрөмжийн тухай/-ийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Эдийн засгийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн хэлэлцэхэд ирц хүрэлцэхгүй байсан тул уг асуудлыг хойшлуулахаар болов.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг “Чингис бондын эх үүсвэрээр санхүүжиж буй төслүүдийн талаар” мэдээлэл хийв.

2014.05.07

Эдийн засгийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

2014.05.08

Засгийн газрын гишүүнийг огцруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хаалттай хуралдааны горимоор хэлэлцэв.

Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

2014.05.09

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиуд /Амгалан дулааны станцын тоног төхөөрөмжийг татвараас чөлөөлөх/-ыг батлав.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлоготой нийцүүлэх чиглэлээр/-ийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороодод шилжүүлэв.

Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг хийж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр бүх Байнгын хороодод шилжүүлэв.

2014.05.15

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурал дахь “МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвслийн бүлгийн гишүүн Д.Батцогт Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 26.12-

т заасныг үндэслэн бүлгээс гарах хүсэлтээ ирүүлснийг хүлээн авсан тухай Улсын Их Хурал дахь “МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвслийн бүлгийн шийдвэрийг мэдээлэв.

Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүүгээс Засгийн газрын гишүүнийг огцруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслөө татан авах тухай 2014 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 7/3444 тоот албан бичгийг танилцуулж, хууль санаачлагч төслөө татан авсанд тооцов.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2014 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2015-2016 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Хяналтын тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй тул Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцов.

Соёлын өвийг хамгаалах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрдэнэсийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудыг батлав.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг батлахыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй тул Хууль санаачлагчид нь буцаах тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцов.

Гарын тосны тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төслийг батлах саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй тул Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцов.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль /Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл, А.Бакей, Р.Гончигдорж, Д.Лүндээжанцан, Сү.Батболд, Н.Батцэрэг нарын өргөн мэдүүлсэн, агаарын бохирдлын талаар/-ийг батлав.

2014.05.16

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг “Эдийн засгийг эрчимжүүлэх 100 хоногийн ажлын талаар” мэдээлэл хийв.

2014.05.22

Арбитрын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн



эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 04 дүгээр дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Т.Лхагваа танилцуулав.

Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийн үед санал хураахад ирц хүрэлцэхгүй болсон тул дараагийн хуралдаанаар үргэлжлүүлэн хэлэлцэхээр болов.

2014.05.23

Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2014 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2015-2016 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2014 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2015-2016 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав.

Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг дөрөв дэх хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудыг батлав.

Монгол Улсын Засгийн газар, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага хооронд байгуулсан “Инженер, технологийн дээд боловсрол төсөл”-ийн зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийг батлав.

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг батлав.

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Хүнс, тэжээл, нийгмийн халамжийн төсөл: Нэмэлт санхүүжилт”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлан тухай хуулийг батлав.

2014.05.27

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиудын төсөл /Жижиг, дунд үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж буй тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг татвараас чөлөөлөхийг 2016.12.31-ний өдөр хүртэл сунгах тухай/-ийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл / Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан хөрөнгө оруулагчийн импортолж байгаа тоног төхөөрөмжийн татварыг 2 жил хүртэл хугацаагаар хойшлуулах тухай/-ийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай /шинэчилсэн найруулга/ болон Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон “Чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлэг дахин хэлэлцэх шаардлагатай байгаа тул ажлын 2 хоногийн завсарлага авах тухай Улсын Их Хурлын гишүүн Д.Оюунхорол мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав.

Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд / Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар нар 2013.05.02-ны өдөр, Улсын Их Хурлын гишүүн Б.Гарамгайбаатар нар 2013.08.28 -ны өдөр өргөн мэдүүлсэн, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах тухай/-ийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

2014.05.29

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогыг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл, Чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй тул Хууль санаачлагчид нь буцаах тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцов.

Гэмт хэргийн тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв. Зөрчлийн тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

2014.05.30

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн болон “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Газрын тосны тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

“Цагаан суваргын ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.



Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг хэлэлцэж эхлэв.

2014.06.05

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг хэлэлцэж, Улсын Их Хурлын тогтоол гаргах шаардлагагүй гэж үзэж, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг сонслоо.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиуд болон Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Ногоон хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

2014.06.06

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг батлав.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг батлав.

Малын индексжүүлсэн даатгалын тухай болон холбогдох бусад хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Р.Гончигдорж, Д.Батцогт, Б.Чойжилсүрэн нар 2014.01.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, далай аварга цолыг хасах тухай/-ийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Нягтлан бодох бүртгэлийн тухай, Аудитын тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг “2013 оны улсын төсвөөс Ерөнхий сайдын багцад хуваарилагдсан 50 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зарцуулалт, ажлын гүйцэтгэлийн талаар” мэдээлэл хийв.

2014.06.12

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдаар Шаравдоржийн

Түвдэндоржийг томилж, Засгийн газрын гишүүнийг томилох тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт энэ өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх бүх асуудлаар ажлын 5 хоногийн завсарлага авах тухайгаа мэдэгдэж, завсарлага авав.

2014.06.13

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /шинэчилсэн найруулгын болон холбогдох бусад хуулийн төслүүдийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль /"Далай аварга" цолыг хасах тухай, Улсын Их Хурлын гишүүн Р.Гончигдорж, Д.Батцогт, Б.Чойжилсүрэн нарын 2014.01.20-ны өдөр өргөн мэдүүлсэн/-ийг анхны хэлэлцүүлгээр батлав.

Ногоон хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Малын индексжүүлсэн даатгалын тухай, Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг батлав.

Цагаан суваргын ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн З.Баянсэлэнгэ Улсын Их Хурал дахь МАХН-МҮАН-ын "Шударга ёс" эвслийн бүлгээс ажлын 5 хоногийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав.

Монгол хэлний тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэг, Н.Батцэрэг, А.Бакей, Г.Батхүү, Л.Гантөмөр, Н.Энхболд нар 2014.5.16-ны өдөр өргөн мэдүүлсэн/-ийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын болон Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

2014.06.17

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2014.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, татварын 90.0 хувийг буцаан олгох тухай/-ийн анхны хэлэлцүүлгийг хийх үед Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг үг хэлж, Засгийн газар уг хуулийн төслөө татаж авахаар болов. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

2014.06.19

Шилэн дансны тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болгох



тухай болон Дипломат албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Хяналтын тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төсөл /Улсын Их Хурлын гишүүн А.Бакей нарын 2014.06.10-ны өдөр өргөн мэдүүлсэн/-ийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Газрын тосны тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төсөл /Засгийн газар 2014.05.23-ны өдөр өргөн мэдүүлсэн/-ийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

2014.06.20

Монгол Улсын 2013 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхлэв.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг “Эзэн-100” хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар мэдээлэл хийв.

2014.06.26

Монгол Улсын 2013 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон холбогдох бусад Байнгын хороодод шилжүүлэв.

Засгийн газрын гишүүнийг огцруулах тухай асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат ажлын 5 хоногийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт ажлын 5 хоногийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав.

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Төлбөрийн системийн шинэчлэл төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг батлахыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй болно.

Харилцаа, холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Цагаан суваргын ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслийн бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Н.Батцэрэг тус бүлгээс авсан завсарлагын хугацаа дууссан ч энэ өдрийн хэлэлцэх асуудлаас хасах санал гаргаж, Улсын Их Хурлын дарга З.Энхболд уг асуудлыг ажлын хэсэг дээр сайн ярилцах шаардлагатай гэж үзэн дараагийн 7 хоног хүртэл хойшлуулав.

Эмийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай болон Дипломат албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудыг анхны хэлэлцүүлгээр батлав.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээр батлав.

Чөлөөт бүсийн тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төсөл /Засгийн газар 2014.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, улс хоорондын шуудангийн илгээмжийн тухай/-ийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

2014.07.01

Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсын 2013 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай болон Монгол Улсын 2013 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль /Засгийн газар 2014.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, Үндэсний их баяр наадмаар 14, 15-ны өдрүүдэд амрах тухай/-ийг анхны хэлэлцүүлгээр батлав.

Улсын Их Хурлын 2014 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээр батлав.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуулиудын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь “МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвслийн бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Н.Батцэрэг завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар үдээс хойшхи хуралдаан хүртэл завсарлага авав.





Газрын тосны тухай /шинэчилсэн найруулга/, Газрын тосны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай болон Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудыг батлав.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуулиудын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь “МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвслийн бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Н.Батцэрэг тус бүлгээс авсан завсарлагын хугацаа дууссаныг мэдэгдэв.

Ашигт малтмалын тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороодод шилжүүлэв.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Шилэн дансны тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Цагаан суваргын ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хаалттай хуралдааны горимоор хэлэлцэв.

Байнгын хорооны даргыг чөлөөлөх, Байнгын хорооны даргыг сонгох тухай Улсын Их Хурлын тогтоолыг баталж, Улсын Их Хурлын гишүүн Ш.Түвдэндоржийг Хууль зүйн байнгын хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлж, Хууль зүйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбатыг сонгов.

Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохыг хориглох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай болон Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудыг батлав.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн

өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудыг батлав.

Шилэн дансны тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудыг батлав.

Цагаан суваргын ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсын Их Хурлын 2014 оны хаврын ээлжит чуулганы үйл ажиллагааг хааж Улсын Их Хурлын дарга З.Энхболд үг хэлэв.

\* \* \*

2014.08.22

#### УЛСЫН ИХ ХУРЛЫН ХҮНДЭТГЭЛИЙН ХУРАЛДААН

Улсын Их Хурлын дарга З.Энхболд БНХАУ-ын Дарга Си Зиньпинийг Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн урилгаар Монгол Улсад төрийн айлчлал хийж байгаатай холбогдуулан зарласан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдааныг нээж үг хэлэв.

БНХАУ-ын Дарга Эрхэм хүндэт зочин Си Зиньпин танхимын голд байрлуулсан индэрт очиж үг хэлэв.

\* \* \*



**7. УЛСЫН ИХ ХУРЛЫН 2014 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН (2014.10.01 - 2015.02.18)**

2014.10.01

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын 2014 оны намрын ээлжит чуулганыг нээж үг хэлэв.

2014.10.02

Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хаалттай хуралдааны горимоор хэлэлцэв.

2014.10.03

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг “Эдийн засгийг эрчимжүүлэх 100 хоногийн хүрээнд хийсэн ажлуудын талаар” мэдээлэл хийв.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын болон “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2012 оны 14 дүгээр тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

2014.10.07

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиуд болон “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2012 оны 14 дүгээр тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Завсарлагааны дараа Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиуд болон “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2012 оны 14 дүгээр тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

2014.10.09

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн 05 дугаар дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ш.Цогтоо танилцуулав.

“Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенц”-ийг соёрхон батлав.

Монгол Улсын Засгийн газар, Бельгийн Вант Улсын Засгийн газар хооронд 2014 оны 6 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан “Баруун бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг бэхжүүлэх төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлав.

Эмийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Эрүүл мэндийн албан журмын даатгалын тухай болон холбогдох бусад хуулиудын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Зөвшөөрлийн тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан асуулттай гишүүдийн нэрийг бүртгэлд авч дараагийн хуралдаанд үргэлжлүүлэн хэлэлцэхээр болов.

2014.10.10

Зөвшөөрлийн тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Сангийн сайд Ч.Улаан Засгийн газарт эргэж танилцуулах, төслөө татаж авах тухай мэдэгдсэнээр хуралдаан даргалагч хэлэлцүүлгийг 12 цаг 55 минутад зогсоож, хуралдаан завсарлав.

Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй тул Хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлагдсанд тооцов.

Галын аюулгүй байдлын тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг дараагийн хуралдаанаар хэлэлцэхээр тогтож, асуудлыг хойшлуулав.

2014.10.14

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Засгийн газрын бүтцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд нийцүүлэн холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

2014.10.15

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав.

Засгийн газрын бүтцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд нийцүүлэн холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

2014.10.16

Монгол Улсын Засгийн газрын зарим гишүүнийг үүрэгт ажлаас чөлөөлөх тухай саналыг Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг танилцуулав.

- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайдын үүрэгт ажлаас Чүлтэмийн Улааныг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайдын үүрэгт ажлаас Лувсанвандангийн Болдыг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайдын үүрэгт ажлаас Цэвэлмаагийн Баярсайханыг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн сайдын үүрэгт ажлаас Амаржаргалын Гансүхийг;



- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрчим хүчний сайдын үүрэгт ажлаас Мишигийн Сономпилийг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Уул уурхайн сайдын үүрэгт ажлаас Даваажавын Ганхуягийг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эдийн засгийн хөгжлийн сайдын үүрэгт ажлаас Нямжавын Батбаярыг тус тус чөлөөлөв.

Монгол Улсын Засгийн газрын зарим гишүүнийг үүрэгт ажлаас чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Засгийн газрын бүтцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд нийцүүлэн холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийв.

Инновацийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Концессын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хилийн боомтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шилэн дансны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд болон “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг батлах саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дэмжээгүй тул Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцов.

2014.10.17

Галын аюулгүй байдлын тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулиудын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлэв.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг цаг үеийн асуудлаар мэдээлэл хийв.

2014.10.21

Монгол Улсын 2015 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай болон холбогдох бусад хуулиудын төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр бүх Байнгын хороо, нам, эвслийн бүлэг, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлэв.

2014.10.23

“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим

арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

2014.10.24

“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Хөдлөх эд хөрөнгийн болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай болон холбогдох бусад хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн болон Эдийн засгийн байнгын хороодод шилжүүлэв.

Номын сангийн тухай болон Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэгээс Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдад тавьсан “Дотоодын фермерийн аж ахуйн нэгжүүдийг хивгээр хангах үүднээс экспортыг улирлын чанартайгаар зогсоож болох эсэх талаар асуулга”-ын хариуг сонсов.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгээс Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдад тавьсан “Монгол мал” хөтөлбөрийг батлах тухай Улсын Их Хурлын 2010 оны 23 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар асуулгын хариуг сонсов.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв. Иргэний хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

2014.10.30

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн зарим зүйлийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн болон “Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”, “Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2015 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.



2014.10.31

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй тул Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцов.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /Засгийн газрын өргөн мэдүүлсэн/ хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /Улсын Их Хурлын гишүүн Я.Содбаатарын өргөн мэдүүлсэн/ хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай болон Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв. Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав.

2014.11.05

Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах тухай асуудал /Улсын Их Хурлын гишүүн Д.Хаянхярваа нарын 28 гишүүн 2014.10.16-ны өдөр өргөн мэдүүлсэн/-ыг хэлэлцэв.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуягийг огцруулахыг хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын гишүүдийн олонхи дэмжсэн тул Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцов. Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуягийг огцруулав.

2014.11.07

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 06 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлыг хэлэлцэж, уг асуудлыг Хууль зүйн байнгын хороогоор дахин хэлэлцүүлэхээр болов.

2014.11.13

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсын 2015 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуулиудын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийж, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

2014.11.14

“Монгол Улсын 2015 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуулиудын төслийн гурав дахь хэлэлцүүлгийг хийж, дөрөв дэх хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

“Монгол Улсын 2015 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуулиудыг батлав.

“Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

2014.11.21

Монгол Улсын Ерөнхий сайдад нэр дэвшигчийн талаар Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж танилцуулав. Монгол Улсын Ерөнхий сайдаар Чимэдийн Сайханбилэгийг томилох саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжсэн тул Чимэдийн Сайханбилэгийг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцов.

Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 06 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх эсэх асуудал /Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1.3 дахь заалтын талаар/-ыг хэлэлцэж хүлээн зөвшөөрсөн тул Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Иргэний хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Олон талын хөрөнгө оруулалтыг баталгаажуулах байгууллагын конвенцид орсон нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийг батлав.

Далайн хөдөлмөрийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 2006 оны конвенцид нэгдэн орох тухай хуулийг батлав.

Аврах ажиллагааны тухай 1989 оны Лондонгийн конвенцид нэгдэн орох тухай хуулийг батлав.

Гэр бүлийн тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулиудын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлэв.

2014.11.27

Гэр бүлийн тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Соёлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.





Хүүхэд харах үйлчилгээний тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Батын Хурцыг Авлигатай тэмцэх газрын дэд даргын үүрэгт ажлаас чөлөөлж, энэ тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцов. Улсын Их Хурлын тогтоолыг уншиж танилцуулав.

2014.11.28

Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах цогц бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Гэр бүлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

2014.12.04

Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Концессын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын бүтцийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулиудын болон “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Дээрх хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёрын саналаар дэмжээгүй тул Хуулийн төсөл буцаах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлагдсанд тооцов.

Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Концессын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын бүтцийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулиудын болон “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиуд болон “Төрийн

захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

2014.12.05

Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг батлав.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудыг батлав.

Иргэний хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Нийгмийн даатгалын тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Засгийн газрын зарим гишүүнийг томилох талаар Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг танилцуулав.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын шадар сайдаар Ухнаагийн Хүрэлсүхийг томилов.

Засгийн газрын зарим гишүүнийг томилох тухай асуудлыг дараагийн хуралдаанаар үргэлжлүүлэн хэлэлцэхээр болов.

2014.12.09

Засгийн газрын зарим гишүүнийг томилох тухай асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэв.

- Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар Сангажавын Баярцогтыг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдаар Дуламсүрэнгийн Оюунхоролыг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гадаад хэргийн сайдаар Лүндэгийн Пүрэвсүрэнг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайдаар Жаргалтулгын Эрдэнэбатыг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүйн сайдаар Дамбийн Дорлигжавыг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Аж үйлдвэрийн сайдаар Дондогдоржийн Эрдэнэбатыг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайдаар Дамдины Цогтбаатарыг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайдаар Цэрэндашийн Цолмонг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдаар Лувсаннъямын Гантөмөрийг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн сайдаар Намхайн Төмөрхүүг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Уул уурхайн сайдаар Рэнцэндоогийн Жигжидийг;



## ШИЙДЛИЙН ЗАСГИЙН ГАЗАР



Монгол Улсын сайд,  
ЗГХЭГ-ын дарга  
С.Баярцогт



Монгол Улсын Ерөнхий сайд  
Чимэдийн Сайханбилэг



Монгол Улсын  
Шадар сайд  
У.Хүрэлсүх



Байгаль орчин, но-  
гоон хөгжлийн сайд  
Д.Оюунхорол



Гадаад харилцааны  
сайд Л.Пүрэвсүрэн



Сангийн сайд  
Ж.Эрдэнэбат



Хууль зүйн сайд  
Д.Дорлигжав



Барилга, хот  
байгуулалтын сайд  
Д.Цогтбаатар



Батлан хамгаалахын  
сайд Ц.Цолмон



Боловсрол, шинжлэх  
ухааны сайд  
Л.Гантөмөр



Зам, тээврийн сайд  
Н.Төмөрхүү



Аж үйлдвэрийн  
сайл Д.Эрдэнэбат



Уул уурхайн сайд  
Р.Жигжид



Хүнс, хөдөө аж  
ахуйн сайд  
Р.Бурмаа



Хөдөлмөрийн сайд  
С.Чинзориг



Хүн амын хөгжил,  
нийгмийн хамгаал-  
лын сайд С.Эрдэнэ



Эрчим хүчний  
сайд Д.Зоригт



Эрүүл мэнд, спортын  
сайд Г.Шийлэгдамба



Монгол Улсын  
сайд М.Энхсайхан

- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хөдөлмөрийн сайдаар Содномын Чинзоригийг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдаар Содномзундуйн Эрдэнийг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуйн сайдаар Раднаагийн Бурмааг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэнд, спортын сайдаар Ганхуягийн Шийлэгдамбыг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрчим хүчний сайдаар Дашзэвэгийн Зоригтыг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайдаар М.Энхсайханыг тус тус томилов.

Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг томилох тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

2014.12.11

Номын сангийн тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Төрөөс ойн талаар баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

"Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцийн нэмэлт Протокол"-ыг соёрхон батлах тухай хуулийг батлав.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлэв.

2014.12.12

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй тул Хуулийг төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцов.

Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр бүх Байнгын хороо, нам, эвслийн бүлэг, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлэв.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбатын өргөн мэдүүлсэн/ хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлэв.

2014.12.18

Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил



сангийн 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

“Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг батлав.

2014.12.19

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцов.

Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 07 дугаар дүгнэлтийг хэлэлцэж, Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 07 дугаар дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоол батлав.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг батлав.

Номын сангийн тухай хуулийг батлав.

“Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогыг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, асуудлыг дараагийн хуралдаанаар үргэлжлүүлэн хэлэлцэхээр болов.

Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг мэдээлэл хийв.

2014.12.25

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогыг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын үүрэгт ажлаас Д.Баярсайханыг, Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүний үүрэгт ажлаас Б.Даажамба, Г.Хэрлэн нарыг, Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний үүрэгт ажлаас Б.Лхагвасүрэн, Б.Батбаяр нарыг тус тус чөлөөлж, Загдхүүгийн Нарантуяаг Санхүүгийн зохицуулах хорооны даргаар, Харьюугийн Бум-Эрдэнийг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүнээр, Эрдэнэбилэгийн Батболдыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүнээр, Данжилаагийн Ганбатыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр, Жалцангийн Цэдэнрагчааг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр тус тус томилов.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга, зарим гишүүдийг томилох тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Батжаргалын Батбаяр, Баастын Золбаяр, Дэндэвийн Нямсамбуу, Дэшигрэнцэнгийн Оюун-Эрдэнэ, Довдонгийн Цэндсүрэн, Балдангийн Энхмандах, Зургаанжингийн Энхболд нарыг Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилж, Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн

Үндэсний зөвлөлийн гишүүнээс Шагдарын Батцэцэг, Баасанжавын Ганболд, Дамбын Гантөмөр, Цэрэнпилийн Гомбосүрэн, Чойжилжавын Дамбажав, Цэрэнчимидийн Зоригтбаатар, Сүрэнгийн Цэрэндорж нарыг чөлөөлөв.

Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Сундуйн Батболд, Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Төсвийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Б.Болор, Эдийн засгийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Д.Батцогт нарыг томилж, Байнгын хорооны даргаар сонгох тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

“Тогтоолын хавсралтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэхтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, уг асуудлыг дараагийн хуралдаанаар үргэлжлүүлэн хэлэлцэхээр болов.

2014.12.26

“Тогтоолын хавсралтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Улсын Их Хурлын гишүүн С.Оюуныг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны бүрэлдэхүүнд оруулж, “Байнгын хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Эрүүл мэндийн албан журмын даатгалын тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

“Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

2015.01.08

Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийн нэг дэх хэлэлцүүлэг дуусаж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр бүх Байнгын хороо болон Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлэв.



2015.01.09

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Инновацийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Орон сууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт, шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн болон Тогтоолын заалт хүчингүй болгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон холбогдох Байнгын хороодод шилжүүлэв.

Нийслэл хотын албан татварын тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлэв.

2015.01.10

Нийслэл хотын албан татварын тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Хөрөнгийн албан татварын тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2015 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай, Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Онцгой албан татварын тухай болон Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

2015.01.15

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

2015.01.16

Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 08 дугаар дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Сугар танилцуулав.

“Тогтоолын хавсралтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Өргөдлийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Октябрийн Баасанхүүг сонгов.

2015.01.20

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг анхны хэлэлцүүлгээр нь батлав.

2015.01.22

Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй, Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарын гаргасан “Бүх яамдын дэд сайдын орон тоог хасаж, тэдний ажлын албаны нарийн бичгийн дарга, жолооч, автомашины болон холбогдох зардлыг хасах” гэсэн санал дэмжигдсэн тул үүнтэй уялдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тоон үзүүлэлтэд өөрчлөлт хийлгэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай /Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2015 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоол/ Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

“Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.





2015.01.23

Монгол Улсын Засгийн газрын тухай, Төрийн албаны тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын болон “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул Хууль, тогтоолын төсөл буцаах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Онцгой албан татварын тухай болон Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Инновацийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Статистикийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудыг анхны хэлэлцүүлгээр батлав.

Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Орон сууцны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын болон Тогтоолын заалт хүчингүй болох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв. Хуралдаан түр завсарлаж Төсвийн байнгын хороо хуралдав. Завсарлагааны дараа Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг батлав. Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав. Онцгой албан татварын тухай болон Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав.

Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудыг батлав.

Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолыг анхны хэлэлцүүлгээр нь батлав.

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

2015.01.29

Өрийн удирдлагын тухай болон холбогдох бусад хууль, тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Эдийн засгийн байнгын хороодод шилжүүлэв.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн бус байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэрээт харуул, хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улс төрийн намын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дээд боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монголын улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нөхөрлөлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиудыг батлав.

"Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого"-ыг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд



нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг батлав.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав.

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга П.Цагаан танилцуулав.

- Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Түвдэндоржийн Жанабазар,
- Бүгд Найрамдах Сингапур Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Банзрагчийн Дэлгэрмаа,
- Бүгд Найрамдах Куба Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Отгонбаярын Даваасамбуу,
- Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Санжаасүрэнгийн Баяраа,
- Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Банзрагчийн Одонжил,
- Австрали Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Равдангийн Болд,
- Бүгд Найрамдах Польш Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Адъяагийн Ганбаатар,
- Тайландын Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Чимиддоржийн Баттөмөр нарыг тус тус эгүүлэн татав.
- Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Лодойдамбын Галбадрах,
- Бүгд Найрамдах Сингапур Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Төмөрийн Лхагвадорж,
- Бүгд Найрамдах Куба Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цэдэндамбын Батбаяр,
- Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гончигийн Ганболд,
- Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Чулууны Баярмөнх,
- Австрали Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Батлайн Чулуунхүү,
- Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Нэмэхийн Бат,
- Тайландын Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Төмөрхүлэгийн Төгсбилгүүн,
- Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэд суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Сүхээгийн Сүхболд нарыг томилов.

Чуулганы нэгдсэн хуралдаан дээр явагдсан санал хураалтын дүнг Монгол Улсын Ерөнхийлөгчид албан бичгээр хүргүүлэхээр тогтов.

2015.01.30

Бүгд Найрамдах Кирибати Улстай дипломат харилцаа тогтоох тухай, Бүгд Найрамдах Маврики Улстай дипломат харилцаа тогтоох тухай, Бүгд Найрамдах Чад Улстай дипломат харилцаа тогтоох тухай, Экваторын Гвиней Улстай дипломат харилцаа тогтоох тухай, Бүгд Найрамдах Гаити Улстай дипломат харилцаа тогтоох тухай, Холбооны Микронез

Улстай дипломат харилцаа тогтоох тухай, Бүгд Найрамдах Руанда Улстай дипломат харилцаа тогтоох тухай, Бүгд Найрамдах Уганда Улстай дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

“Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Нийтийн сонсголын тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Хүүхэд харах үйлчилгээний тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг дараагийн хуралдаанаар үргэлжлүүлэхээр тогтов.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журмын тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн болон “Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого батлах тухай”, “Монгол Улсын Их Хурлын тогтоолын зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Зарим дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсын Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тухай” 88 дугаар конвенцид нэгдэн орох тухай хуулийг батлав. “Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын тухай” Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 181 дүгээр конвенцид нэгдэн орох тухай хуулийг батлав.

“Антарктидийн тухай гэрээ”-нд нэгдэн орох тухай хуулийг батлав.

Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг анхны хэлэлцүүлгээр нь батлав.

2015.02.05

Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоол, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав.

“Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслийн бүлгийн дэд дарга, Улсын Их Хурлын



гишүүн З.Баянсэлэнгэ ажлын 5 хоногийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав.

Чөлөөт бүсийн тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийж, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг буцаах санал дэмжигдсэн тул Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцов.

2015.02.06

“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол хэлний тухай болон Төрийн албан ёсны хэлний тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны болон Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг нийгэм, эдийн засгийн голлох тоон үзүүлэлтүүдийг нэгтгэх, нийгэм, эдийн засгийн тоон үзүүлэлтүүдийг гаргадаг төрийн байгууллагууд тоон мэдээллийг нэгдсэн байдлаар тогтмол гаргах талаар мэдээлэл хийв.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн болон “Монгол Улсын цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого батлах тухай”, Монгол Улсын Их Хурлын тогтоолын зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь “МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвслийн бүлгийн дэд дарга, Улсын Их Хурлын гишүүн З.Баянсэлэнгэ ажлын 5 хоногийн завсарлага авч байгаа тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав.

Соёлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг дараагийн хуралдаанаар үргэлжлүүлэн хэлэлцэхээр тогтов.

2015.02.11

Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны даргыг томилох тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Авлигатай тэмцэх газрын дэд даргыг томилох тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэхтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслийн бүлгийн дэд

дарга, Улсын Их Хурлын гишүүн З.Баянсэлэнгэ ажлын 5 хоногийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав.

“Гацууртын ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэхтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь “МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвслийн бүлгийн дэд дарга, Улсын Их Хурлын гишүүн З.Баянсэлэнгэ ажлын 5 хоногийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав.

2015.02.12

Чөлөөт бүсийн тухай, Чөлөөт бүсийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Цагааннуур худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хилийн боомтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиуд болон Цагааннуур худалдааны чөлөөт бүс байгуулахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай тогтоол хүчингүй болсонд тооцох тухай, Цагааннуур худалдааны чөлөөт бүс байгуулах тухай тогтоолд өөрчлөлт оруулах тухай, Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай тогтоолд өөрчлөлт оруулах тухай, Алтанбулаг худалдааны чөлөөт бүс байгуулах тухай тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Өрийн удирдлагын тухай болон холбогдох бусад хууль, тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

“Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав. Соёлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг батлав. Монгол хэлний тухай хуулийг батлав.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын болон Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлэв.



2015.02.13

Магванноровын Энх-Амгаланг Улсын ерөнхий прокуророор томилов.

Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Цог, Ц.Оюунбаатар нар үг хэлж, Улсын Их Хурал дахь “МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвслийн бүлэг дээрх асуудлаар ажлын 5 хоногийн завсарлага авав.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн болон “Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого батлах тухай”, “Монгол Улсын Их Хурлын тогтоолын зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

“Эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

“Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын болон холбогдох бусад хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Зөрчлийн тухай болон холбогдох бусад хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

2015.02.17

Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг батлав.

“Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

“Гацууртын ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

“Эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлэв.

2015.02.18

“Эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Цэдэн-Ишийн Болдсайхан, Чойнзонгийн Содномцэрэн, Рэнцэнгийн Содхүү нарыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилж, бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон Батнямын Алтанжаргалыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөв. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүдийг томилох, чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Өрийн удирдлагын тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

“Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

“Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

“Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг батлав.

Өрийн удирдлагын тухай, Өрийн удирдлагын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Валютын зохицуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төв банк / Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Концессын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулиуд болон Өрийн удирдлагын тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг батлав.

Чойнзонгийн Содномцэрэнг Сонгуулийн ерөнхий хорооны даргаар улираан томилж,





Цэдэн-Ишийн Болдсайханыг Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн даргаар томилж, Батнямын Алтанжаргалыг Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөв. Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Сангажавын Баярцогтыг огцруулах саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй болно.

\* \* \*

## **8. УЛСЫН ИХ ХУРЛЫН 2015 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН (2015.04.06 - 2015.07.10)**

2015.04.06

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганы ажиллагааг нээж үг хэлэв.

2015.04.09

Хөрөнгө оруулалтын тухай, Монгол Улсын Их Хурлын тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай, Онц байдлын тухай, Хүний хөгжил сангийн тухай, Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн холбогдох заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 02 дугаар дүгнэлтийг хэлэлцэж, “Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 02 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалт үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 03 дугаар дүгнэлтийг хэлэлцэж, “Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 03 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Захиргааны ерөнхий хуулийн төсөл болон түүнтэй хамт өргөн мэдүүлсэн Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн болон Төрийн байгуулалтын байнгын хороодод шилжүүлэв.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсон тухай, Захиргааны хариуцлагын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан “Тогтвортой амьжиргаа III төслийн санхүүжилтийн хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийг батлав.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын бүтцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,



Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гадаадын зээл тусламжийг зохицуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дайны байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аймаг, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улс төрийн намуудын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн болон Төрийн байгуулалтын байнгын хороодод шилжүүлэв.

2015.04.10

Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Хууль зүйн байнгын хороодод шилжүүлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн тайланг сонсов.

2015.04.16

Казиногийн тухай, Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын гэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Г.Алтанчимэг, П.Золзаяа, П.Соёл-Эрдэнэ, Ч.Хосбаяр нарыг Улсын Дээд шүүхийн шүүгчээр томилуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналтай танилцав.

Төсвийн тогтвортой байдлын тухай болон Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг дараагийн долоо хоногт хэлэлцэхээр хойшлуулав.

“Олон улсын валютын сангийн ерөнхий хэлэлцээр”-т оруулах нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийг батлав. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн “Мэдээлэл хүргүүлэх журмын тухай” Нэмэлт Протоколыг соёрхон батлах тухай хуулийг батлав.

Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

2015.04.17

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогтын мэдээлэлтэй танилцаж, “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлттэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

2015.04.23

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсгийн заалт нь Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 04 дүгээр дүгнэлтийг хэлэлцэж, “Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 04 дүгээр дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

2015.04.24

Ирээдүйн өв сангийн тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд нэмэлт оруулах тухай, Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төв банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай болон холбогдох бусад хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.



2015.04.30

“Авлигатай тэмцэх, хариуцлага, шударга ёсыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөрийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй тул тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Мөнгөн усны тухай Минаматагийн конвенцид нэгдэн орохыг соёрхон батлах тухай хуулийг батлав.

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Улаанбаатар хотын нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг батлав.

Төрөөс ойн талаар баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

2015.05.01

Худалдааны тухай болон Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Худалдааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв. Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг “Татварын эрх зүйн орчин, цаашид авах арга хэмжээний талаар” мэдээлэл хийв.

Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн гишүүд “Улсын Их Хурлын гишүүдийн санаачилсан хуулийн төсөлд хувийн үзэмжээр ханддагаа зогсоо”, “1 хувийн орлогын татварыг аж ахуйн нэгжүүд хүлээж байна”, “Улсын Их Хурлын гишүүд хуулийн төслөө хэлэлцүүлэх бүрэн эрхтэй” гэсэн лоозонгуудыг ширээн дээрээ байрлуулсан байв.

2015.05.07

Шүүхийн захиргааны болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэх тухай Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 05 дугаар дүгнэлтийг хэлэлцэж, “Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 05 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай /шинэчилсэн найруулга/ болон Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хуульд өөрчлөлт оруулах тухай, Цахим гарын үсгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Санхүүгийн түрээсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны хороонд шилжүүлэв.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

2015.05.08

Улсын Их Хурал дахь Монгол-Оросын парламентын бүлгийн зүгээс дэлхийн хоёрдугаар дайны ялалтын 70 жилийн ойг тохиолдуулан Георгийн туузыг тараан өгснийг Улсын Их Хурлын гишүүд энгэртээ зүүсэн байв.

Нийслэл хотын албан татварын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн хийлгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Нягтлан бодох бүртгэлийн тухай, Аудитын тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэв.

2015.05.14

Төрөөс ойн талаар баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав.

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг анхны хэлэлцүүлгээр батлав.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Шүүхийн захиргааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг батлав.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын 2016-2018 оны өрийн удирдлагын стратегийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь МАХН-МҮАН-ын "Шударга ёс эвслийн бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Н.Батцэрэг ажлын 5 хоногийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай /шинэчилсэн найруулга/ болон хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жолоочийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн болон Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороодод шилжүүлэв.

2015.05.15

Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг “Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцүүлгийн явцын тухай” мэдээлэл хийв.

\* \* \*

2015.05.17

УЛСЫН ИХ ХУРЛЫН ХҮНДЭТГЭЛИЙН ХУРАЛДААН болов.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Ерөнхий сайд Эрхэмсэг ноён Нарендра Модийг Монгол Улсад албан ёсны айлчлал хийж байгаатай холбогдуулан зарласан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдааныг нээж үг хэлэв.

Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Ерөнхий сайд Эрхэмсэг ноён Нарендра Модийг үг хэлэв.

Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Ерөнхий сайд Эрхэмсэг ноён Нарендра Модийг үг хэлж дуусахад Улсын Их Хурлын дарга хүндэт зочинд талархлаа илэрхийлж, товч үг хэлэн Хүндэтгэлийн хуралдаан хаасныг мэдэгдэв.

Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Ерөнхий сайд Эрхэмсэг ноён Нарендра Модийг Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Улсын Их Хурлын дарга З.Энхболд, Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг нар дурсгалын зураг татуулав.

\* \* \*

2015.05.21

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн болон хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газрын 2016-2018 оны өрийн удирдлагын стратегийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг

эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудыг батлав.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг батлав.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журмын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг батлав.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг анхны хэлэлцүүлгээр батлав.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн холбогдох заалт Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 06 дугаар дүгнэлтийг хэлэлцэж, “Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 06 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Засгийн газрын 2016-2018 оны өрийн удирдлагын стратегийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

2015.05.22

Засгийн газрын 2016-2018 оны өрийн удирдлагын стратегийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Хүүхэд хамгааллын тухай болон Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Барилгын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтоос Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай болон Эдийн засгийн өршөөлийн тухай хуулийн төсөл хэлэлцэхтэй холбогдуулан Хууль зүйн сайд, Сангийн сайдад тавьсан асуулгын хариуг сонсов.

Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг Оюу толгойн асуудлаар мэдээлэл хийв.





Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурал дахь “Хүн амын хөгжил, гэр бүл, хүүхдийн асуудлыг дэмжих” лобби бүлэг байгуулагдсан. Тус лобби бүлэгт Улсын Их Хурлын гишүүн Д.Арвин, Д.Батцогт, Н.Батцэрэг, З.Баянсэлэнгэ, Г.Баярсайхан, Ц.Баярсайхан, Д.Ганбат, С.Ганбаатар, Ё.Отгонбаяр, С.Оюун, Ц.Оюунгэрэл, Д.Сарангэрэл, Д.Сумъяабазар, Л.Энх-Амгалан, Л.Эрдэнэчимэг нар орсон болохыг танилцуулав.

2015.05.28

Монгол Улсын Их Хурлын 2014 оны 54 дүгээр тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 07 дугаар дүгнэлттэй танилцлаа.

Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай болон Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай болон хамт өргөн мэдүүлсэн Гүйцэтгэх ажлын тухай хуулийн зарим зүйлийг хүчингүй болсонд тооцох тухай, Шүүхийн шинжилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Прокурорын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

2015.05.29

Цагдаагийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ болон Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Согтууруулах ундаа хэрэглэх, хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хүчингүй болгох тухай, Цагдаагийн албаны тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Прокурорын байгууллагын тухай /шинэчилсэн найруулга/ болон Прокурорын байгууллагын тухай хуулийг хүчингүй болгох тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журмын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн

тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 2001 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр баталсан Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулиуд болон Монгол Улсын Их Хурлын 1998 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 103 дугаар тогтоолын зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн Засгийн байнгын хороонд шилжүүлэв.

2015.06.04

Шүүх байгуулах тухай /шинэчилсэн найруулга/, Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүх байгуулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулиудын болон “Шүүгчийн орон тоо батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудыг анхны хэлэлцүүлгээр батлав.

Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт ажлын 5 хоногийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг



хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

2015.06.05

Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг Монгол Улсын Засгийн газраас иргэдийг орон сууцжуулах бодлогын хүрээнд авч буй зарим арга хэмжээний талаар мэдээлэл хийв.

Монгол Улсын Засгийн газар, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага хооронд байгуулсан Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх онгоцны буудал барих төслийн нэмэлт зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийг батлав.

2015.06.11

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Аудитын тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Ирээдүйн өв сангийн тухай болон холбогдох бусад хуулиудын төслийн анхны хэлэлцүүлгийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар түр зогсоов.

Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

2015.06.12

Захиргааны ерөнхий хууль болон холбогдох бусад хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зарим зүйл, заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох бусад зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн 2015 оны 08 дугаар дүгнэлтийг хэлэлцэж, “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 08 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай болон Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох бусад зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн 2015 оны 09 дүгээр дүгнэлтийг хэлэлцэж, “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 09 дүгээр дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Нийслэл хотын албан татварын тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Галын аюулгүй байдлын тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай болон холбогдох бусад хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

2015.06.18

Шүүх байгуулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүх байгуулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулиудын болон Шүүгчийн орон тоо батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэх тухай Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 10 дугаар дүгнэлттэй танилцлаа.

Дуламсүрэнгийн Давааг Зэвсэгт хүчний Жанжин штабын даргаар томилох талаар Монгол Улсын Ерөнхийлөгчөөс зөвшилцөхөөр ирүүлсэн саналыг дэмжив.

Гацууртын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар дэмжээгүй болно.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав.

2015.06.19

Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай болон холбогдох бусад хуулиудын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийг төлөөлөн Улсын Их Хурлын гишүүн Ө.Энхтүвшин ажлын 5 хоногийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав.

Шүүх байгуулах тухай /шинэчилсэн найруулга/, Монгол Улсын шүүхийн тухай хуульд



нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүх байгуулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулиуд болон Шүүгчийн орон тоо батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай, Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банк бус санхүүгийн байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг батлав.

Аудитын тухай, Аудитын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг батлав.

Захиргааны ерөнхий хууль, “Захиргааны ерөнхий хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Нийслэл хотын албан татварын тухай хууль, “Нийслэл хотын албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Үйлдвэрлэлийг дэмжих тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Технологи дамжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн болон “Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээг батлах” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудыг батлав. Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав.

Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай Улсын Их Хурлын тогтоолыг анхны хэлэлцүүлгээр батлав.

Хотыг дахин хөгжүүлэх тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Эрүүгийн хууль болон холбогдох бусад хуулиудын төслийн анхны хэлэлцүүлгийг хойшлуулав.

2015.06.24

Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хэлэлцэж байгаатай холбогдуулан ажлын 5 хоногийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав.

2015.06.25

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Төлбөрийн системийн шинэчлэл төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг батлав.

Монгол Улсын 2014 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Улсын төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн тайлан сонсох асуудлын талаар Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт үг хэлж, Улсын Их Хурлын дарга З.Энхболд Монгол Улсын Ерөнхий сайд, Сангийн сайд нарыг ирсний дараа асуудлыг хэлэлцүүлэхээр хойшлуулав.

Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай болон холбогдох бусад хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв. Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон холбогдох бусад хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Нийтийн сонсголын тухай болон холбогдох бусад хуулиудын төслийн анхны хэлэлцүүлгийг хойшлуулав.

Хүүхэд харах үйлчилгээний тухай болон холбогдох бусад хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай болон холбогдох бусад хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

2015.06.26

Хотыг дахин хөгжүүлэх тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудыг батлав.

“Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Галын аюулгүй байдлын тухай /шинэчилсэн найруулга/ болон Барилгын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай болон “Халх гол” чөлөөт бүс байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганхуяг, С.Одонтуяа, Л.Эрдэнэчимэг нараас “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцын талаар” Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан асуулгын хариуг сонсов.

Галт зэвсгийн тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.



Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

2015.06.30

“Монгол Улсын 2014 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Улсын төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн тайлангийн нэг дэх хэлэлцүүлгийг хийв.

2015.07.02

“Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Эрүүгийн хуулийн /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг анхны хэлэлцүүлгээр батлав.

Монгол Улсын Их Хурлын 2015 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

“Монгол Улсын 2014 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоол, “Монгол Улсын 2014 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай, Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудыг батлав.

Галын аюулгүй байдлын тухай /шинэчилсэн найруулга/, Барилгын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Галын аюулгүй байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг батлав. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудыг батлав.

Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийг батлав.

Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хойшлуулав.

Нийтийн сонсголын тухай болон холбогдох бусад хуулиудын төслийн анхны хэлэлцүүлгийг хойшлуулав.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай болон холбогдох бусад хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиудыг анхны хэлэлцүүлгээр батлав.

2015.07.03

Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Нийтийн сонголын тухай болон холбогдох бусад хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

“Уурхай дахь аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 176 дугаар конвенцид нэгдэн орох тухай хуулийг батлав.

Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын үндсийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг, Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулиудын төслийг хэлэлцэх эсэх асуудлуудыг хаалттай хуралдааны горимоор хэлэлцэв.

2015.07.08

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 03 дугаар дүгнэлтийг хэлэлцэж, “Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 03 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Захиргааны хариуцлагын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг батлав.

Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг батлав.

Үйлдвэрлэлийг дэмжих тухай болон холбогдох бусад хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

“Халх гол” чөлөөт бүс байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудыг батлав.

Нийтийн сонголын тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд болон “Нийтийн сонголын тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”, “Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.





Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуулиудын төслийн анхны хэлэлцүүлгийг хаалттай хуралдааны горимоор хэлэлцэв.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

2015.07.09

Үйлдвэрлэлийг дэмжих тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Технологи дамжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиуд болон “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав. Хөдөө аж ахуйн Халх гол чөлөөт бүс байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай болон Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудыг батлав.

Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуулиудын төслийг хаалттай хуралдааны горимоор хэлэлцэв.

Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Боловсролын чанарын шинэчлэл төслийн санхүүжилтийн хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийг батлав.

Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Цахим эрүүл мэнд төслийн санхүүжилтийн хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийг батлав.

Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Ухаалаг засаг төслийн санхүүжилтийн хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийг батлав.

Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Мянганы сорилтын корпорацийн хооронд байгуулсан “Мянганы сорилтын компакт гэрээг боловсруулахад дэмжлэг үзүүлэх буцалтгүй тусламжийн тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийг батлав.

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг батлав. Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах хуулийг батлав.

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг анхны хэлэлцүүлгээр батлав.

Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аймаг, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улс төрийн намын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын болон Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Ирээдүйн өв сангийн тухай, Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд нэмэлт оруулах тухай, Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн болон Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Хохирлын сангийн тухай болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Органик хүнсний тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв. Хөдөлмөрийн тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын “Хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, гамшгийн үр дагаврыг арилгах болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах ажиллагааны чиглэлээр сургалт хэрэгжүүлэхэд хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийг батлав.

“Хараагүй, харааны бэрхшээлтэй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүст зориулан хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хүртээмжтэй болгох тухай Марракешийн гэрээг соёрхон батлах тухай” хуулийг батлав.

2015.07.10

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганыг хааж үг хэлэв.

\*\*\*

**9. УЛСЫН ИХ ХУРЛЫН 2015 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН (2015.08.03 - 2015.08.14)**

2015.08.03

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын 2015 оны ээлжит бус чуулганыг нээж үг хэлэв.

2015.08.05

Галт зэвсгийн тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төсөл /Улсын Их Хурлын Х.Тэмүүжин нарын 11 гишүүн 2015.06.05-ны өдөр өргөн мэдүүлсэн/-ийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Өршөөл үзүүлэх тухай хуулийн төслийг хаалттай хуралдааны горимоор хэлэлцэв.

2015.08.06

Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Засгийн газрын зарим гишүүдийг огцруулах саналыг Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг танилцуулав.

- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Шадар сайдын үүрэгт ажлаас Ухнаагийн Хүрэлсүхийг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайдын үүрэгт ажлаас Жаргалтулгын Эрдэнэбатыг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайдын үүрэгт ажлаас Дамдины Цогтбаатарыг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн сайдын үүрэгт ажлаас Намхайн Төмөрхүүг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хөдөлмөрийн сайдын үүрэгт ажлаас Содномын Чинзоригийг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын үүрэгт ажлаас Дуламсүрэнгийн Оюунхоролыг тус тус огцруулав.

Монгол Улсын Засгийн газрын зарим гишүүдийг үүрэгт ажлаас нь огцруулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

2015.08.07

Галт зэвсгийн тухай, Галт зэвсгийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Бууны албан татварын тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Галт зэвсгийн албан татварын тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудыг батлав.



Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг батлав.

2015.08.11

Энэ өдрийн хуралдаан Өршөөлийн тухай хуулийн төслийг хаалттай хуралдааны горимоор хэлэлцэв.

2015.08.14

Комисс байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын 2015 оны ээлжит бус чуулганыг хааж үг хэлэв.

\* \* \*



## 10. УЛСЫН ИХ ХУРЛЫН 2015 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН (2015.09.07 - 2015.09.18)


2015.09.07

Улсын Их Хурлын дэд дарга Р.Гончигдорж Улсын Их Хурлын 2015 оны ээлжит бус чуулганыг нээж үг хэлэв. Улсын Их Хурлын 2015 оны ээлжит бус чуулганы нээлтийн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг оролцов.

2015.09.08

Монгол Улсын Засгийн газрын зарим гишүүдийг томилох тухай саналыг Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг танилцуулав.

- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Шадар сайдаар Улсын Их Хурлын гишүүн Цэрэндашийн Оюунбаатарыг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайдаар Улсын Их Хурлын гишүүн Баярбаатарын Болорыг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайдаар Улсын Их Хурлын гишүүн Зангадын Баянсэлэнгийг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн сайдаар Улсын Их Хурлын гишүүн Мөнхчулууны Зоригтыг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хөдөлмөрийн сайдаар Улсын Их Хурлын гишүүн Гарьдхүүгийн Баярсайханыг;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдаар Улсын Их Хурлын гишүүн Намдагийн Батцэрэгийг тус тус томилов.



Сангийн сайд  
Б.Болор

Монгол Улсын Шадар сайд  
Цэрэндашийн Оюунбаатар

Барилга, хот  
байгуулалтын сайд  
З.Баянсэлэнгэ



Зам, тээврийн  
сайд Т.Зоригт

Хөдөлмөрийн сайд  
Г.Баярсайхан

Байгаль орчин,  
ногоон хөгжил,  
аялал жуулчлалын  
сайд Н.Батцэрэг

Эрүүл мэнд,  
спортын сайд  
С.Ламбаа

[Нөхөн томилогдсон] **Монгол Улсын Засгийн газрын гишүүн, сайд нар**



Монгол Улсын Засгийн газрын зарим гишүүдийг томилох тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

\*\*\*

2015.09.13

УЛСЫН ИХ ХУРЛЫН ХҮНДЭТГЭЛИЙН ХУРАЛДААН

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Бага Хурлын гишүүд 25 жилийн өмнө 9 сарын 13-ны энэ өдөр тангаргаа өргөж, анхны хуралдаанаа хийсэн өдөр болохыг дурдаж, Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойд тохиолдуулан хийж байгаа Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдааныг нээж үг хэлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж үг хэлэв.

Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Бага Хурлын дарга асан Р.Гончигдорж үг хэлэв.

\*\*\*

2015.09.15

Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай хуульд тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэж, хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, 7 дугаар зүйлд хэсэгчлэн тавьсан Ерөнхийлөгчийн хоригийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар хүлээж авах нь зүйтэй гэж үзэж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийн тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

2015.09.18

Улсын Их Хурлын дэд дарга Р.Гончигдорж Улсын Их Хурлын 2015 оны ээлжит бус чуулганыг хааж үг хэлэв.

\*\*\*

## **11. УЛСЫН ИХ ХУРЛЫН 2015 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН (2015.10.01 - 2016.02.05)**

2015.10.01

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын 2015 оны намрын ээлжит чуулганыг нээж үг хэлэв.

2015.10.02

Өршөөл үзүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт холбогдох материал тараагдаагүй, мөн уг хуулийн төслийг Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар дахин хэлэлцэх нь зүйтэй гэсэн санал хэлж, ажлын 5 хоногийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав.

Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын үндсийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хаалттай хуралдааны горимоор хэлэлцэв.

Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг “Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах арга хэмжээний талаар” мэдээлэл хийв.

2015.10.08

Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын үндсийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хаалттай хуралдааны горимоор хэлэлцэв.

Хууль зүйн байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал маргаантай байгаатай холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Б.Гарамгайбаатар ажлын 5 хоногийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 11 дүгээр дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн 2015 оны 12 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлав.

Монгол-Оросын “Эрдэнэт үйлдвэр” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2003 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатарын гаргасан санкцтай холбоотой хэсгийг Засгийн газраас тодруулах хүртэл хугацаанд соёрхон батлах асуудлыг түр хойшлуулав.

Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрийг соёрхон батлав.

Ялтан шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газар хоорондын гэрээг соёрхон батлах тухай хуулийг батлав.





Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Барилгын тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Газар хөдлөлтийн асуудлаар Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Т.Бадрал, Шинжлэх ухааны академийн Одон орон, геофизикийн хүрээлэнгийн захирал С.Дэмбэрэл нар мэдээлэл хийв.

2015.10.09

Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн холбогдох бусад хуулиудын төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороодод шилжүүлэв.

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2016 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2016 оны төсвийн тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн холбогдох бусад хуулиудын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг хийж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороодод шилжүүлэв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Б.Бат-Эрдэнэ, Х.Болорчулуун, С.Ганбаатар, Г.Уянга, Л.Цог нараас “Оюу толгой төслийн хэрэгжилтийн өнөөгийн явц, татвар төлөлтийн байдал болон “Эвлэрлийн гэрээ”-ний талаар” Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэгт тавьсан асуулгын хариуг сонсов.

2015.10.15

Гаалийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар дэмжээгүй тул Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцлоо.

Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбатыг Хууль зүйн байнгын хорооны даргаар сонгож, энэ тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцов.

Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тэрбишдагва Улсын Их Хурал дахь “МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвслийн бүлгээс ажлын 5 хоногийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав.

“Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 13 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

#### 2015.10.16

Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг дагалдан өргөн мэдүүлсэн холбогдох хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороодод шилжүүлэв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэгийн “Цацраг идэвхт ашигт малтмалыг эдийн засгийн эргэлтэд оруулах талаар” хийх мэдээллийг хаалттай хуралдааны горимоор сонсов.

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2016 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2016 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг дагалдан өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

#### 2015.10.22

Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь “МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвслийн бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Н.Батцэрэг ажлын 3 хоногийн завсарлага дахин авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав.

Гаалийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн болон хамт өргөн мэдүүлсэн “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолд



өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол-Оросын “Эрдэнэт үйлдвэр” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2003 оны 7 сарын 01-ний өдрийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын протоколыг соёрхон батлах тухай хуулийг батлав.

Монгол-Оросын “Монголросцветмет” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2007 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын протоколыг соёрхон батлах тухай хуулийг батлав.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхийг дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаах тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцов.

Эрчим хүч хэмнэлтийн тухай болон холбогдох бусад хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Эрүүл ахуйн тухай болон холбогдох бусад хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Малын генетик нөөцийн тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Тариалангийн тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

2015.10.23

Зөрчил хянан шийдвэрлэх тухай болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийн хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Хог хаягдлын тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт

бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгаас Монголбанкны Ерөнхийлөгчид тавьсан асуулгын хариуг сонсов.

2015.10.28

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Концессын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн болон "Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг хууль санаачлагчид буцаах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

2015.10.29

Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцэв.

2015.10.30

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав.

Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын тухай



хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Концессын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг батлав.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав.

Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийн гурав дахь хэлэлцүүлгийг хийв.

Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудыг батлав.

Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхлэв.

2015.11.06

Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг Шилэн дансны тухай хуулийн талаар мэдээлэл хийв.

2015.11.10

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Нийгмийн халамжийг дэмжих хөтөлбөр”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг батлав.

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн нэмэлт санхүүжилт”-ийн зээлийн хэлэлцээрүүдийг соёрхон батлах тухай хуулийг батлав.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувиргасан амьд организмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Тагнуулын байгууллагын тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Авлигын эсрэг хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд

өөрчлөлт оруулах тухай хуулийн болон “Төрийн өмчийг 2015 - 2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг анхны хэлэлцүүлгээр батлав.

2015.11.11

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2016 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2016 оны төсвийн тухай хуулиудын төслийг гуравдугаар хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

2015.11.13

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг батлав.

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2016 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2016 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Статистикийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Орон сууц хувьчлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Агаарын тухай хуулийн зарим зүйл, хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулиуд болон Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай, Бүх шатны шүүхийн шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай, Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд хүртээх хишиг хувь, хэмжээг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2016 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2016 оны төсвийн тухай хуулиудыг батлав.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

2015.11.19

Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав. Шүүх байгуулах тухай хуулийн 1, 2 дугаар зүйлийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 14 дүгээр дүгнэлтийг хэлэлцэж, Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 14 дүгээр дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай болон холбогдох бусад хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн болон Төрийн байгуулалтын байнгын хороодод шилжүүлэв.



Эрчим хүч хэмнэлтийн тухай болон холбогдох бусад хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Зөрчлийн тухай хуулийн төсөлтэй хамт хэлэлцүүлэн батлуулах холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Монголын Улаан Загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

“Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Хамтын тэтгэврийн тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

2015.11.20

Олон Улсын цахилгаан холбооны байгууллагын Үндсэн дүрэм, конвенцид оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийг батлав.

Ялтан шилжүүлэх тухай Европын зөвлөлийн конвенцид нэгдэн орох тухай хуулийг батлав.

Ард нийтийн санал асуулга явуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 5 гишүүн өргөн мэдүүлсэн/-ийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Сундуйн Батболд нарын 6 гишүүн өргөн мэдүүлсэн/-ийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү нарын 8 гишүүн өргөн мэдүүлсэн/-ийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг цаг үеийн асуудлаар мэдээлэл хийв.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай болон холбогдох бусад хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай болон холбогдох бусад хуулиудын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

2015.11.26

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг анхны хэлэлцүүлгээр батлав.

Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улс төрийн намын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиуд болон Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Эрчим хүч хэмнэлтийн тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг батлав.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Экспорт Импортын банк хооронд байгуулах 1.0 тэрбум ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийг батлав.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг анхны хэлэлцүүлгээр батлав.

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлэв.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхлэв.

2015.11.27

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Юмжаагийн Цэдэнбалын мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай





Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуунаас Газрын тосны тухай хуулийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг сонсов.

Улсын Их Хурлын гишүүн Л.Цог, О.Баасанхүү, Г.Уянга, Д.Сумъяабазар, Ё.Отгонбаяр нараас “Монгол Улсын уул уурхайн салбарын гол үйлдвэрлэл болох зэсийн баяжмалыг дахин боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилт болон “Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай” Засгийн газрын 2015 оны 247 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар” Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг сонсов.

2015.12.03

Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 14 дүгээр дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоолд тавьсан Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн зарим гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 15 дугаар дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дэд дарга, Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаяр ажлын 5 хоногийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав.

Хамтын тэтгэврийн тухай хуулийг батлав.

Гаалийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг батлав.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн болон “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Эрүүгийн хууль болон Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Терроризмтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний

хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай, Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг батлав.

2015.12.04

Зөрчлийн тухай, Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Автотээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Амьтны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ариун цэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Архивын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аялал жуулчлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Бага, дунд боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгууллагын нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Биеийн тамир, спортын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Валютын зохицуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Векселийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Гадаадын цэргийн хүчнийг байрлуулах, дамжин өнгөрүүлэх тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын хэвлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Давс иоджуулж иод дутлаас сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дайны байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дайчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дампуурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дархлаажуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дээд боловсролын тухай хуульд

17	2015-02-13	Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай тухай хуульд нэмэлт ооруулах тухай хуулийн төсөл /анхны хэлэлцүүлэг/	“МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвслийн бүлэг /ажлын 5 хоног Нэгдсэн хуралдаан
2015 оны хаврын ээлжит чуулган			
1	2015.5.14	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл, ЗГ-ын 2016-2018 оны Өрийн удирдлагын стратегийг батлах УИХ-ын тогтоолын төсөл / хэлэлцэх эсэх/	“МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвслийн бүлэг /ажлын 5 хоног Нэгдсэн хуралдаан/
2	2015.6.04	Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого батлах тухай УИХ-ын тогтоолын төсөл /эцсийн хэлэлцүүлэг/	МАН-ын бүлэг /ажлын 5 хоног эгдсэн хуралдаан /
3	2015-6-16	Хүүхэд харах үйлчилгээний тухай болон холбогдох бусад хуулийн төсөл / анхны хэлэлцүүлэг/	МАН-ын бүлэг /ажлын 5 хоног НББСШУБХ-ны хуралдаан /
4	2015-6-19	Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /анхны хэлэлцүүлэг/	МАН-ын бүлэг /ажлын 5 хоног Нэгдсэн хуралдаан/
5	2015-6-24	Эрүүгийн хуулийн төсөл / анхны хэлэлцүүлэг/	МАН-ын бүлэг /ажлын 5 хоног Нэгдсэн хуралдаан/
6	2015-6-26	Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл / хэлэлцэх эсэх /	“МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвслийн бүлэг /ажлын 5 хоног Нэгдсэн хуралдаан/
7	2015-7-03	Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын үндсийг батлах тухай УИХ-ын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг/	АН-ын бүлэг /ажлын 5 хоног Нэгдсэн хуралдаан /
8	2015-7-07	Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн төсөл / хэлэлцэх эсэх/	МАН-ын бүлэг /ажлын 5 хоног ТБХ-ны хуралдаан/
9	2015-7-07	Өршөөлийн тухай хуулийн төсөл /хэлэлцэх эсэх/	МАН-ын бүлэг /ажлын 5 хоног ХЗБХ-ны хуралдаан /
Ээлжит бус чуулган 2015-09-07-ноос 18-ны өдөр			
10.	2015-09-08	Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай хуульд тавьсан МУ-ын Ерөнхийлөгчийн хориг хэлэлцэх	“МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвслийн бүлэг ажлын 5 хоног завсарлага авав. ХЗБХ-ны хуралдаан дээр

2015 оны намрын ээлжит чуулган			
1	2015-10-02	Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан Өршөөл үзүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	МАН-ын бүлэг /ажлын 5 хоног Нэгдсэн хуралдаан/
2	2015-10-06	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнийг сонгох тухай	АН-ын бүлэг /ажлын 5 хоног НББСШУБХ-ны хуралдаан/
3	2015-10-08	ХЗБХ-ны даргыг сонгох, чөлөөлөх тухай	АН-ын бүлэг /ажлын 5 хоног Нэгдсэн хуралдаан /
4	2015-10-09	Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан Өршөөл үзүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	МАН-ын бүлэг /ажлын 3 хоног Нэгдсэн хуралдаан /
5	2015-10-15	Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан Өршөөл үзүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	“МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвслийн бүлэг /ажлын 5 хоног Нэгдсэн хуралдаан/
6	2015-10-22	Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан Өршөөл үзүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	“МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвслийн бүлэг /ажлын 3 хоног нэмж авсан Нэгдсэн хуралдаан /
7	2015-12-03	Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 15 дугаар дүгнэлт	МАН-ын бүлэг /ажлын 5 хоног Нэгдсэн хуралдаан /
8	2015-12-08	Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан Өршөөл үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах комиссын тайлан Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журамд өөрчлөлт оруулах тухай	МАН-ын бүлэг /ажлын 5 хоног ХЗБХ-ны хуралдаан/
9	2015-12-10	Гацууртын ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох тухай УИХ-ын тогтоолын төсөл /хэлэлцэх эсэх/	“МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвслийн бүлэг /ажлын 5 хоног Нэгдсэн хуралдаан /
10	2015-12-10	“Авлигатай тэмцэх, хариуцлага, шударга ёсыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөрийг батлах тухай” УИХ-ын тогтоолын төсөл	“МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвслийн бүлэг /ажлын 5 хоног Нэгдсэн хуралдаан/
11	2015-12-10	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд тухай хуулийн төсөл / анхны хэлэлцүүлэг/	МАН-ын бүлэг /ажлын 5 хоног Нэгдсэн хуралдаан/

12	2015-12-10	Ард нийтийн санал асуулга явуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл / анхны хэлэлцүүлэг/	МАН-ын бүлэг /ажлын 5 хоног Нэгдсэн хуралдаан /
13	2015-12-10	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /анхны хэлэлцүүлэг/	МАН-ын бүлэг /ажлын 5 хоног Нэгдсэн хуралдаан/
14	2015-12-10	Хөдөлмөрийн тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулийн төслүүд / анхны хэлэлцүүлэг/	АН-ын бүлэг /ажлын 5 хоног Нэгдсэн хуралдаан /
15	2015-12-10	“Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай” УИХ-ын тогтоолын төсөл / хэлэлцэх эсэх /	МАН-ын бүлэг /ажлын 5 хоног Нэгдсэн хуралдаан/
16	2015-12-10	Олон улсын гэрээний тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төсөл /хэлэлцэх эсэх/	МАН-ын бүлэг /ажлын 5 хоног Нэгдсэн хуралдаан/
17	2015-12-10	Гааль, татварын ерөнхий газрын эрх зүйн байдлын тухай болон холбогдох бусад хуулийн төслүүд / хэлэлцэх эсэх/	МАН-ын бүлэг /ажлын 5 хоног Нэгдсэн хуралдаан /
18	2015-12-10	Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл / хэлэлцэх эсэх/	МАН-ын бүлэг /ажлын 5 хоног Нэгдсэн хуралдаан /
19	2015-12-10	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /хэлэлцэх эсэх/	МАН-ын бүлэг /ажлын 5 хоног Нэгдсэн хуралдаан/
20	2015-12-17	Гацууртын ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох тухай УИХ-ын тогтоолын төсөл /хэлэлцэх эсэх/	“МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвслийн бүлэг /ажлын 3 хоног Нэгдсэн хуралдаан/
21	2015-12-18	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /хэлэлцэх эсэх/	МАН-ын бүлэг /ажлын 5 хоног ТБХ-ны хуралдаан /
22	2016-01-19	Хяналтын тухай болон холбогдох бусад хуулийн төсөл /анхны хэлэлцүүлэг/	МАН-ын бүлэг /ажлын 5 хоног Нэгдсэн хуралдаан/
23	2016-01-21	Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах тухай /УИХ-ын гишүүн Г.Уянга нарын 19 гишүүн 2016-01-19 нд өргөн мэдүүлсэн/	МАН-ын бүлэг /ажлын 5 хоног ТББХ-ны хуралдаан /

24	2016-01-21	“Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуулийн санал авах өдрийг тогтоох тухай” УИХ-ын тогтоолын төсөл; “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай” УИХ-ын тогтоолын төсөл; “Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” УИХ-ын тогтоолын төсөл.	АН-ын бүлэг /ажлын 5 хоног ТББХ-ны хуралдаан/
25	2016-01-22	Гацууртын ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох тухай УИХ-ын тогтоолын төсөл /эцсийн хэлэлцүүлэг/	АН-ын бүлэг /ажлын 5 хоног Нэгдсэн хуралдаан/
26	2016-01-28	Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг эгүүлэн татах талаарх УДШ-ийн санал	МАН-ын бүлэг /ажлын 5 хоног Нэгдсэн хуралдаан/
27	2016-02-04	Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг эгүүлэн татах талаарх УДШ-ийн санал	МАН-ын бүлэг /ажлын 3 хоног нэмж авав. Нэгдсэн хуралдаан /
28	2016-02-04	Боловсролын тухай хуульд болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /анхны хэлэлцүүлэг/	МАН-ын бүлэг /ажлын 5 хоног Нэгдсэн хуралдаан/
2016 оны хаврын ээлжит чуулган			
1	2016.4.27	Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 05 дугаар дүгнэлт /Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх маргааныг ханан шийдвэрлэсэн тухай/	“МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвслийн бүлэг /Нэгдсэн хуралдаан
2	2016.5.03	Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуулийн төсөл /Ерөнхийлөгч 2016.04.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/; Прокурорын байгууллагын тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулийн төсөл /ЗГ 2015.05.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/; Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулийн төсөл /ЗГ 2016.02.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/; Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /УИХ-ын гишүүн Х.Тэмүүжин 2016.04.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/; Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгын санал;	МАН-ын бүлэг /ажлын 5 хоног Хэлэлцэж байгаа бүх асуудлаар ХЗБХ-ны хуралдаан /
3	2016-05-06	Авлигатай тэмцэх газрын даргыг томилох тухай асуудал	АН-ын бүлэг /ажлын 5 хоног ХЗБХ-ны хуралдаан /



4	2016-05-12	“Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай” УИХ-ын тогтоолын төсөл	МАН-ын бүлэг / 25 минут Нэгдсэн хуралдаан/
5	2016-05-20	Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /УИХ-ын гишүүн Н.Батбаяр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	МАН-ын бүлэг / ажлын 5 хоног Нэгдсэн хуралдаан/
6	2016-05-20	Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрүүл мэнд, спортын сайдыг томилох тухай	АН-ын бүлэг / 4 цаг Нэгдсэн хуралдаан/

\* \* \*



# 3

УИХ -ЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН БА ХҮНДЭТГЭЛИЙН ХУРАЛДААНД ТАВЬСАН ИЛТГЭЛ, ХЭЛСЭН ҮГ (2012 - 2016)



**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2012 ОНЫ АНХДУГААР ЧУУЛГАН**

(2012.07.06 - 2012.08.21)

**Анхдугаар чуулганыг нээж Монгол Улсын Ерөнхийлөгч  
Ц. Элбэгдоржийн хэлсэн үг**

(2012.07.06)

Монгол Улсын иргэд, эрхэм сонгогчид оо,  
Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд аа,  
Улсын Их Хуралд сонгогдсон эрхэм гишүүд ээ,  
Хүндэт зочид, хатагтай, ноёд оо,

Монголын ард түмэн ардчилсан шинэ Үндсэн хуулийнхаа дагуу зургаа дахь удаагаа чөлөөт сонголтоо хийлээ. Хууль тогтоох байгууллагаа бүрэлдүүлэх дээд шийдвэрээ гаргалаа. Төр оршихын үндэс бол хуулийн хэрэгжилт. Олон мянган төрийн албан хаагчид хуулийг хэрэгжүүлж ажиллалаа. Сонгуулийн шат, шатны байгууллагууд сонгуулийн дүнг нэгтгэж, Сонгуулийн ерөнхий хороо Улсын Их Хуралд шинээр сонгогдсон гишүүдийг нэрсийг надад өргөн барилаа.

Манай сонгогчдын энэ удаагийн сонголт тэдний хүсэл тэмүүллийн илэрхийлэл байж чадсан гэдэгт би эргэлзэхгүй байна. Ард түмнийхээ нийтлэг эрх ашгийн төлөөлөл болсон та бүхэн ч цаг алдалгүй бүрэн эрхээ хэрэгжүүлж, шуурхай ажиллах шаардлага байгаа. Ингээд Монгол Улсын Их Хурлын зургаа дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулган нээснийг мэдэгдье.

\* \* \*

**Чуулганы хуралдаан дээр Монгол Улсын Ерөнхийлөгч  
Ц. Элбэгдоржийн хэлсэн үг**

(2012.07.06)

Та бүхэн хуулийг чандлан баримталж, ард түмнийхээ нийтлэг эрх ашгийн төлөө зүтгэхээ баталж, төр түмэндээ тангаргаа өргөлөө. Манай ард түмэн сонгогч бүр Улсын Их Хурлын энэ бүрэлдэхүүн, гишүүн нэг бүрээс асар их зүйлийг хүлээж байгаа. Юуны өмнө хууль, шударга ёсны хэлбэрэлтгүй хэрэгжилтийг хүлээж байгаа. Энэ ажлыг Улсын Их Хурлын гишүүд өөрөөсөө эхэлнэ гэж харж байгаа.

Шударга ёс бол хэлснээр хэрэгждэг зүйл биш, хуулийн тэгш хэрэгжилт, шийдвэр гүйцэтгэлээр хэмжигддэг нийтийн үнэт баялаг юм. Та бүхэн Монголын төрд хэцүү ажил хийх гэж ирсэн. Улс орон, ард түмнийхээ өмнө тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд идэвхтэй оролцохоо ч өөрсдөө илэрхийлсэн. Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэн бүрэн эрхийнхээ хугацаанд сонгогч иргэдээ, тэдний эрх ашгийг, захиа даалгаврыг хормын төдий ч мартаггүй ажиллаж чадна гэдэгт би итгэж байна. Монголын түүхт төрийн түшээгээр сонгогдсон та бүхэнд баяр хүргэе. Ёс журамтай, хариуцлагатай, өндөр дээд албандаа төр түмнийхээ төлөө нэгэн үзүүрт сэтгэлийг баримтлан ажиллах их үйлс тань амжилт хүсье.

Монгол түмэн мандан бадрах болтугай.

**Д. Дэмбэрэл (Хуралдаан даргалагч)**

(2012.07.06)

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,  
Өнөөдөр Монгол төрийн дээд эрх мэдэл шинээр байгуулагдсан Улсын Их Хуралд шилжиж

байна. Улсын Их Хуралд сонгогдсон эрхэм гишүүддээ баяр хүргэе. Та бидний хууль тогтоох, бодлого боловсруулах үйл ажиллагаанаас улс орны хөгжил дэвшил, ард түмний маань амьдрал үйлс бүхэлдээ шалтгаалах болно. Ийнхүү та бидний өмнө төр түших хариуцлагатай үүрэг өнөөдрөөс эхлэн ногдож байна. Энэ хариуцлагатай үүргээ нэр төртэй биелүүлнэ гэдэгт би итгэл дүүрэн байгаагаа илэрхийлье. Та бүхний ажилд амжилт хүсч байна. Төрийн нуруу түвшин байж, түмэн олон аз жаргалтай байх болтугай. Баярлалаа, Монгол Улсын Ерөнхийлөгчид баярлалаа, Монгол Улсын Ерөнхий сайдад баярлалаа, энд хүрэлцэн ирсэн бүх хүмүүст баярлалаа, сайн сайхныг хүсье.

\* \* \*

### **Чуулганы хуралдаан дээр Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг**

(2012.07.24)

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, өөрсдийн сонгож байгуулсан төрийн эрх барих дээд төлөөллийн байгууллагаараа дамжуулан төр засгийн эрхийг хэрэгжүүлдэг билээ. Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш 6 дахь удаагийн сонгууль шинэчлэн батлагдсан хуулийн дагуу явагдлаа. Энэ сонгуулийн үр дүн нь улс төрийн намуудыг хамтарч, эвсэж ажиллахыг даалгасан ард түмний сонголт байлаа.

Улсын Их Хурлын даргын хариуцлагатай албан тушаалд миний нэрийг дэвшүүлсэн Ардчилсан нам, түүний мянга мянган гишүүд, ардчиллыг дэмжигч нийт иргэд сонгогчиддоо талархаж байгаагаа илэрхийлье. Мөн манай намын саналыг дэмжиж надад итгэл хүлээлгэн Улсын Их Хурлын даргаар сонгосон Иргэний зориг ногоон нам, МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслийн гишүүдэд талархаж байна. Цаашид дөрвөн жилийн туршид хамтран ажиллах үүрэг хүлээсэн МАН-аас болон бие дааж сонгогдсон нийт гишүүддээ талархал илэрхийлье.

Би Улсын Их Хурлын даргын хувьд нэг намын төлөөлөл гэдэг утгаар биш монголын ард түмний нийтлэг эрх ашгийн төлөө Улсын Их Хуралд суудалтай намууд, эвсэл, бие дааж сонгогдсон гишүүдтэй хамтран ажиллаж, хуулийн хүрээнд туйлшрахгүйгээр та бүхний хүлээлгэсэн итгэлийг дааж өөрийн мэдлэг чадвар, дадлага туршлагадаа тулгуурлан бие сэтгэл, оюун ухаанаа бүрэн дайчлан ажиллана гэдгээ илэрхийлж байна.

Энэ удаагийн Улсын Их Хурлаас улс орон, ард түмний өмнө тулгарч буй тулгамдсан асуудлуудыг цаг алдалгүй шуурхай шийдвэрлэх, гаргасан шийдвэрээ иргэддээ нээлттэй байлгаж хэрэгжүүлэх торгон мэдрэмжийг барьж ажиллахыг шаардсан түүхэн үүрэг оногдож байна.

Монгол Улс Үндсэн хуулиндаа ардчилал, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах хууль дээдлэхийг төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэж тодорхойлсон билээ.

Монгол Улсын Их Хурал нь төрийн эрх барих дээд байгууллага бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлдгийн хувьд Улсын Их Хурлын бүрэлдэхүүн “цэвэр ариун” байх учиртай. Иймээс одоогоор маргаантай байгаа тойргуудын асуудал хуулийн дагуу түргэн, шуурхай шийдвэрлэгдэх ёстой гэж үзэж байна. Иргэд сонгогчид ч үүнийг нийтээрээ шаардаж, энэ удаагийн сонгуулиар шударга ёс хэрэгжиж чадаж байгаад сэтгэл хангалуун үлдэхийг хүсэж байгааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, иргэдийн яриа, хүсэлтээс бид өдөр тутам мэдэрч байгаа билээ.

Монгол Улсын хувьд ирэх дөрвөн жил их өөрчлөлт, шинэчлэл, их бүтээн байгуулалтын он жилүүд байх болно. Үүнийг шинээр байгуулах Засгийн газрын баримтлах үйл ажиллагааны хөтөлбөрт баримтлан тусгаж хамтарсан Засгийн газрын амжилттай ажиллах эрх зүйн орчинг бүрдүүлэн дэмжин ажиллана. Би Улсын Их Хурлын даргын хувьд хууль, эрх зүйн болон төрийн албаны шинэчлэлийг хэрэгжүүлэхэд анхаарлаа хандуулна. Түүнээс гадна нийгэмд үгүйлэгдэж буй шударга ёсыг тогтоохын тулд хуулийн хэрэгжилтэд тавих Улсын Их Хурлын хяналтад онцгой анхаарч ажиллах болно.

Шинээр байгуулагдах Засгийн газар улс орны нийтлэг эрх ашгийг эрхэмлэн хууль хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, төрийн бодлогын шинэчлэлтийг тасралтгүй явуулах, эхлүүлсэн бүтээн байгуулалтын ажлуудыг цаг алдалгүй, эрчимжүүлэхэд хяналт тавьж ажиллана.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Та бүхнийг төрийн сүлдэнд өргөсөн тангаргаа ямагт дээдэлж, нийт ард түмний элч гэдгээ ухамсарлан идэвхи зүтгэлтэй, хариуцлагатайгаар нэг баг болон хамтран ажиллана гэдэгт би итгэл төгс байна.

Монгол хүн бүрийг хүн шиг амьдруулахын төлөө, Монгол Улсаа улс шиг хөгжүүлэхийн төлөө бүгдээрээ хамтран ажиллахыг Та бүхэндээ уриалж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

\*\*\*

**Чуулганы хуралдаан дээр Монгол Улсын Ерөнхий сайд  
Н.Алтанхуягийн хэлсэн үг**

(2012.08.09)

Эрхэм хүндэт Монгол Улсын Ерөнхийлөгч өө,  
Эрхэм Улсын Их Хурлын дарга аа,  
Эрхэм Улсын Их Хурлын гишүүд, хатагтай, ноёд оо,  
Энд хүрэлцэн ирсэн хэвлэл мэдээллийн байгууллага, түүгээр дамжуулан учран золгож байгаа монгол ахан дүүс ээ,

Өнөөдөр миний бие монгол түмний ардчилсан сонголтын үр дүнд байгуулагдаж байгаа шинэ Засгийн газрын тэргүүнээр томилогдож байна. Надад оногдсон энэхүү их үүрэг, ард түмний ардчилсан сонголтоор эхэлж, намын нөхдийн итгэлийг хүлээж, Улсын Их Хурлын гишүүд та бүхний дэмжлэгээр баталгаажиж байна. Иймд итгэл хүлээлгэсэн монгол түмэн, журмын нөхөд, Улсын Их Хурлын эрхэм гишүүддээ гүн талархал илэрхийлье.

Аль ч цаг үед Монгол Улсын Ерөнхий сайд хэмээх хариуцлагатай албаны босго нь өндөр, шалгуур нь чанга байдаг. Тэрхүү өндөр босго, чанга шалгуурын чухам учир нь ард түмний сонголтод оршдог. Энэ удаа монголын ард түмэн та бидэнд хамтынхаа хүчээр улс орноо авч явах үүрэг ногдууллаа. Ард түмнийхээ үүрэг даалгаврыг гүнээ ухамсарлаж, иргэдийнхээ итгэл найдвар, эх орныхоо хөгжил дэвшлийн төлөө хамтарч ажиллах шийдвэр гаргасан ИЗНН, МАХН, МҮАН-ын Шударга ёс эвсэл, бие даагч гишүүддээ бас гүн талархлаа илэрхийлье.

Миний бие энэ цаг үеийг монгол хүн монголдоо сайхан амьдрах боломжийг бүрдүүлэх хамгийн тохиромжтой, алдаж болохгүй агшин гэж харж байна. Энэ агшинд монголын төр хүчирхэг байж, ард түмний үүрэг болгосон шинэчлэл өөрчлөлтийг хийсэн шиг хийх хэрэгтэй.

Төр хүчирхэг байнаа гэдэг нь аливаа албан тушаалтан ард иргэддээ төмөр нүүр гаргаж, хүнд

суртлаар далайлгахыг хэлэхгүй ээ. Эсвэл төсвийг тонож, сангаа цөлмөхийг бас ойлгохгүй ээ. Харин төр хүчирхэг байнаа гэдэг ард түмний өмнө амласнаа ажлаараа биелүүлж харуулдаг, бага зардлаар их үр ашгийг бүтээдэг, авлига хүнд суртлын аранга байдаг, чиг үүрэг нь тодорхой, үйл ажиллагаа нь шуурхай байхыг ойлгож байгаа юмаа. Тийм төрийн бодлогыг түмэн олон дэмжиж, түмэн олныхоо итгэл дэмжлэгээр төр өөрөө хүчирхэгждэг.



**Монгол Улсын Ерөнхий сайд Норовын Алтанхуяг**

Бидний хамгийн түрүүн шийдвэрлэх ёстой асуудал бол монгол хүн ажилтай, орлоготой болох явдал юм. Өмнөө зорилготой, шаргуу зүтгэлтэй, хүрсэн амжилтандаа сэтгэл нь ханадаггүй мянга мянган монголчууд байгаа гэдэгт би итгэдэг. Тэдгээр хүмүүс амьдралыг илүү сайн сайхан болгох хүсэл эрмэлзэлтэй, ажилсаг, авьяас чадвараар бусдынхаа хүндэтгэлийг хүлээж, монголын бахархал болно гэдэгт ч би бас итгэдэг. Бид ажиллаж, хөдөлмөрлөх, хийж бүтээх хүсэлтэй иргэдээ шуурхай, ил тод, хариуцлагатай, шударгаар дэмжих болно.

Манай Засгийн газрын шийдвэрлэх дараачийн асуудал бол авлигал юмаа. Төр засгийн олон бүтэц яг энэ чигээрээ, яг энэ өнөөдрийнх чигээрээ байвал бид авлигалд идэгдсэн нэг хүнд сурталтныг нөгөө л нэг өөр хүнд сурталтнаар солихоос хэтрэхгүй учраас бид тогтолцоо, тоглоомын дүрэм хоёрыг өөрчлөхөөс бас аргагүй болж байна. Монголын төр авлигачийг хаалгаа дэлгэн угтвал маргааш тэр авлигач хойморт заларч, монгол хүн бүрийг өөртөө бялдуучлахыг авлигал өгөхийг шаардах болно. Авлигалын үнэр шингэж, ад хор шүгэлсэн хэнийг ч болов монголын төр хоймортоо ч байтугай хатавчиндаа л суулгах ёсгүй ээ.

Ардчилсан засаг авлигалын аранга байх болно. Энэ бол бидний шийдэл бишээ. Ард түмний





даалгавар гэдгийг бид мартаж болохгүй ээ. Монголын төр өөрөө эрх чөлөөг мэдэрдэг, эрүүл саруул сэтгэдэг, болохгүй байгаа бүхнийг засахыг эрмэлздэг, хүн бүхний нээлттэй индэр, тунгалаг, тусгал нь байх учиртай юмаа.

Ард түмэн бидэнд шинэчлэл өөрчлөлтийг захиалсан учраас шинэчлэл өөрчлөлтийг бид өнөөдрөөс эхэлнэ. Аливаа шинэчлэл өөрчлөлтийг бол багаар л хийдэг, баг л хийдэг. Хэн нэгэн ардын баатар, суут ухаантан ганцаараа тоглох биш монгол түмнийхээ мэргэн ухаан, хамтын хүчээр улс төрийн хүчнүүд хамтарч хийх ёстой шүү. Алдар нэр, аливаа хүндлэл бол ардчилсан засгийн хувьд чухал бишээ. Албан тушаал бол ирж л байдаг, буцаж л байдаг зүйл. Харин ард түмнийхээ итгэлийг тээж, найдлагыг өвөрлөсөн энэ цаг үед тэднийхээ хамтраад зүтгээ гэсэн даалгаврыг та бид биелүүлэх үүрэгтэй шүү. Энэ даалгавар Засгийн газарт орсон ороогүй улс төрийн бүх хүчинд хамаатай.

Төрийн ажлыг гацаахын тулд биш засаж сайжруулах, эрчимжүүлж хурдасгахын төлөө хамтарч ажиллах ёстой. Түмэн олон төр улсынхаа төлөөх аливаа улс төрийн шийдэл, санал, санаачлага, тэр байтугай хатуу шүүмжлэлийг ч бид талархан хүлээж авах болно. Ард түмэн та биднээс зоримог шийдэл, бодитой шинэчлэл, өөрчлөлтийг хүлээж байна. Өдөр өнгөрөөсөн, аргацааж хуурсан, ядмаг аргыг тэд бас хүсэхгүй л байна шүү.

Монгол төрийн хамгийн үнэт зүйл бол монгол хүн юм. Тэдэнд ямар нэгэн дарамт шахалтгүй, тэгш эрхтэй ажиллах боломжийг бүрдүүлэх шаардлага байна. Төрд ажил үүргийн давхцал ихдэж, хянадаг, дарамталдаг, шалгадаг, шантаажилдаг байгууллага олширсноор элдэв бугшсан үзэгдэл газар авсан байна. Тиймээс төрийн байгууллагуудын ажил үүргийн давхцыг салгаж, чиг үүргийг нь тодорхой болгож, үр ашгийг нь нэмэгдүүлж, үр дүнг нь тооцож, хариуцлагыг нь ил тод болгоно. Бид төрд дөрлөгдсөн биш, нийтэд зориулагдсан албыг бий болгож, байгууллага хэсүүлж, хаалга сахиулдаг чирэгдлийг нэг цонхонд төвлөрүүлж, иргэнээ захирдаг биш, иргэндээ үйлчилдэг тунгалаг төрийг цогцлоох болно.

Элэг нэгт ахан дүүсээ, бүгдээрээ хамтаараа шинэчилье, өөрчилье, хүн шиг амьдарч, улс шиг хөгжицгөөе.

\* \* \*

### **Чуулганыг хааж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг**

(2012.08.21)

Эрхэм хүндэт Ерөнхий сайд аа,  
Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2012 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан Улсын Их Хурлын анхдугаар чуулган хуульд заасны дагуу зохион байгуулалтын асуудлаа хэлэлцэн шийдвэрлэж, тавьсан зорилтуудаа хэрэгжүүлснээр үйл ажиллагаагаа өндөрлөж байна.

2012 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар Ардчилсан намаас 31, МАН-аас 25, ИЗНН-аас 2, "МАХН-МҮАН-ын Шударга ёс эвсэл"-ээс 10, бие даан нэр дэвшсэн 3 хүн тус тус сонгогдон төрийн сүлдэндээ тангаргаа өргөсөн 71 гишүүнтэйгээр Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлж байна.

Энэ парламентыг Улсын Их Хурлын Сонгуулийн шинэчилсэн хуулиар анх удаа сонгуулийн холимог хэлбэр, санал хураалтын автоматжуулсан системээр сонгож бүрдүүллээ. Сонгуулийг санал тоолох дэвшилтэт арга хэлбэрээр явуулснаар сонгууль шударга болсныг сонгогчид, гадна дотны ажиглагчид үнэлж дүгнэж байна. Иймээс ирэх дөрвөн жилд шинээр бүрдсэн Улсын Их Хурал, Засгийн газар, улс төрийн хүчнүүд эв эийг хичээн үндэсний эв нэгдлийг эрхэмлэж, улс төрийн тогтвортой байдлыг хадгалж улс орны хөгжлийн төлөө

бүтээлч, шуурхай, шинэ арга барилаар хандаж ажиллах шаардлага гарч байна. Энэ үндсэн дээр сонгуулийн үр дүнгээр Улсын Их Хуралд хамгийн олон суудал авсан Ардчилсан нам ИЗНН, МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвсэлтэй хамтарсан Засгийн газар байгуулах гэрээ байгуулж ажиллахаар улс төрийн тохиролцоонд хүрч, Улсын Их Хурал дахь олонхийг бүрдүүлэн ажиллаж байна.

Анхдугаар чуулганаар Улсын Их Хурлын дарга, дэд дарга нарыг сонгон, бүтцийн нэгж болсон Байнгын хороо, дэд хороодоо байгуулж, дарга нарыг сонгож баталлаа. Ардчилсан Нам 2012 оны Улсын Их Хурлын сонгуулийн мөрийн хөтөлбөртөө Улсын Их Хуралд Өргөдөл, гомдлын байнгын хороог байгуулж, шууд ардчиллын элементийг парламентын хяналтад оруулахаар тусгасны дагуу энэ Байнгын хороог байгуулав. Ингэснээр парламентын нээлттэй, ил тод байдлыг хангах, иргэд олон түмний санал бодлыг хууль тогтоох үйл явцад тусгах, ойртож ажиллах нөхцөл бүрдэх юм. Түүнчлэн Байнгын хороодын үйл ажиллагааг түргэн, шуурхай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс нэг Байнгын хороо 10-19 гишүүний бүрэлдэхүүнтэй байх, нэг гишүүн нэгэн зэрэг гурваас дээшгүй Байнгын хороонд харьяалагдах зэрэг өөрчлөлтүүдийг тусгаж Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орууллаа.

Анхдугаар чуулганаар Монгол Улсын Ерөнхий сайдыг томилж, Ерөнхий сайдын өргөн мэдүүлсний дагуу Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулан баталж, сайд нарыг томилсноор Засгийн газрыг эмхлэн байгуулж, үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн боломжийг бүрдүүлж өгөв. Улсын Их Хурал Засгийн газрын бүтцийг тодорхойлохдоо үр дүнтэй ажиллах, хийх ажлынх нь чиг үүрэг тодорхой, ажил үүрэг нь давхцалгүй, хүлээх хариуцлага нь тодорхой байж ард иргэдээрээ ил тод хянуулах зэрэг зарчмуудыг дэмжин баталж өгөв. Хамтарсан Засгийн газар үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрөө яаралтай боловсруулан батлуулж, шинэ байгуулагдсан яамдын бүтцийг шинэчлэн, цаг үеийн тулгамдсан асуудал, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах талаар шуурхай арга хэмжээ авч, эрч хүчтэй ажиллах шаардлага тулгарч байна.

Улсын Их Хурлын анхдугаар чуулган 30 хоног хуралдаж, Улсын Их Хурлын бүрэн эрх, бүтэц, бүрэлдэхүүний тухай болон Засгийн газрын бүтэц, зохион байгуулалттай холбоотой бие даасан хоёр хууль баталж, 38 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны зэрэгцээ Улсын Их Хурлын 18 тогтоолыг баталлаа. Хэдийгээр анхдугаар чуулган өндөрлөж байгаа ч шинээр байгуулагдсан Улсын Их Хурлын бүрэн бүрэлдэхүүн хараахан бүрдэж чадаагүй байна. Сонгуулийн дүнгээс үүдэлтэй зарим тойргийн маргаантай асуудлыг хуулийн дагуу яаралтай шийдвэрлэж, Улсын Их Хурал бүрэн бүрэлдэхүүнээр ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд Сонгуулийн ерөнхий хороо, хууль хяналтын байгууллагууд анхаарлаа хандуулах нь зүйтэй.

Улсын Их Хуралд 25 суудал авсан МАН Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.1-д зааснаар Улсын Их Хурлын даргыг сонгосноос хойш 24 цагийн дотор бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн гишүүдийн нэрсийн жагсаалтаа Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх заалтыг баримтлаагүйгээс МАН-ын бүлэг байгуулагдаагүй байна. Улсын Их Хуралд сонгогдсон МАН-ын гишүүд бүлэг байгуулах талаар хуульд зохих өөрчлөлт оруулах тухай төслөө өргөн мэдүүлвэл Улсын Их Хурал энэ асуудлыг хуулийн дагуу аль ч чуулганаараа хэлэлцэж шийдвэрлэх боломжтой юм.

Эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурал анхдугаар чуулганаа өндөрлүүлж байгаа ч бидэнд ойрын үед шийдвэрлэх тулгамдсан асуудал цөөнгүй байна. Үүний дотор Улсын Их Хурлын ээлжит бус чуулганыг хуралдуулж, Орон нутгийн хурлын сонгуулийн тухай хууль, 2012 оны Улсын төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, сонгуулийн товыг зарлах шаардлагатай байна. Улсын Их Хурал дахь намын бүлэг, холбогдох Байнгын хороод энэ талаар идэвхийлэн ажиллаж, төрийн байгууллагын болон орон нутгийн өөрөө удирдах

байгууллага бүрэлдэн бий болох, цаашид тогтвортой ажиллах эрх зүйн үндсийг бүрдүүлэх нь чухал байна.

Шинээр бүрдсэн Улсын Их Хурал төрийн залгамж чанарыг хадгалан төрийн бодлого тодорхойлох, эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэх, парламент хоорондын хамтын ажиллагааг улам өргөжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллах болно.

Сонгогч түмний итгэлийг хүлээж, төрийн эрх барих дээд байгууллагад сонгогдон ажиллах нь Улсын Их Хурлын гишүүд бидний нэр төрийн хэрэг төдий биш, ихээхэн итгэл найдвар, үүрэг хариуцлага хүлээлгэж буй явдал юм. Ийм учраас Улсын Их Хурал, Засгийн газар олон түмний итгэл найдвар, цаг үеийн шаардлагыг дааж шинэ арга барил, шинэ бодол санаа, шинэ эрч хүчээр ажиллана гэдэгт итгэж байна. Улсын Их Хурлын Анхдугаар чуулганы үйл ажиллагаа өндөрлөснийг мэдэгдэе.

\* \* \*

## УЛСЫН ИХ ХУРЛЫН 2012 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН

(2012.08.29 - 2012.09.18)

### Ээлжит бус чуулганыг нээж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг

(2012.08.29)

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,  
Ерөнхий сайд аа,  
Засгийн газрын гишүүд ээ,

2012 оны Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнд Засгийн газар байгуулагдаж, бүтэц, бүрэлдэхүүнээ шинэчлэн батлуулаад ажилдаа орлоо. Улс орон даяар намрын их ажил эхэллээ. Намрын ээлжит чуулганыг хүлээлгүй яаралтай шийдэх асуудлууд хуримтлагдсанаас Улсын Их Хурал ч гэсэн ээлжит бус чуулганаа эхлүүлэх гэж байна.

Хоёр сарын дараа болох Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийг шинэчилсэн найруулгыг хэлэлцэн батлах, Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон цаг хугацааны хувьд яаралтай шийдвэрлэх зарим хуулиудыг хэлэлцэх зорилгоор энэ удаагийн ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулж байна.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг энэ оны 6 сард Улсын Их Хурлын сонгуультай нэг өдөр явуулсан тул одоо үйлчилж байгаа Орон нутгийн сонгуулийн хуулийг шинэчлэн найруулах зайлшгүй шаардлага гарлаа.

Аймаг, сум, дүүргийн сонгуулийг энэ жилийн амжилттай явагдсан Улсын Их Хурал, нийслэлийн сонгуулийн сайн туршлага, тухайлбал, санал тоолох машин хэрэглэх, сонгогчдын бүртгэлийн системийг ашиглан явуулахаар Улсын Их Хурлын зарим гишүүд хуулийн төсөл өргөн бариад байна. Иймд Орон нутгийн сонгуулийн тухай хуулийг хүчингүйд тооцож, аймаг, сум, дүүргийн хурлын сонгуулийн тухай хуулийг шинээр хэлэлцэн батлах шаардлагатай байна.

Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулиар 1990 - 1995 онуудад нийгмийн даатгалын шинэ тогтолцоо бүрэлдэх явц, 1995 - 2000 он хүртэлх нийгмийн даатгалын шинэ тогтолцоог шат дараалан хэрэгжүүлэх явцад хувь хүнээс өөрөөс нь үл хамаарсан нийгмийн шилжилтийн улмаас албан бус хөдөлмөр эрхэлж байсан, эсвэл ажил хөдөлмөр эрхлээгүй, эрхлэх боломжгүй байсан хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон, нөхөн тооцуулах, цаашид тэдний тэтгэврийн даатгалын баталгааг хангаж өгөх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх нь тэтгэвэр тогтоолгох насандаа ойртсон иргэд ажилласан жилээ нөхүүлж тэтгэвэр тогтоолгох эрхээ эдлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх юмаа.

Хүн амын тоо олширсон, шилжилт суурьшилт нэмэгдсэн зэрэг нөхцөл байдлыг харгалзан тухайн орон нутагт шүүх прокурорын байгууллага, төрийн үйлчилгээг иргэдэд цаг алдалгүй хурдан шуурхай хүргэж, зөрчигдсэн эрхийг сэргээх бодит шаардлага бий болж байгаатай холбогдуулан Өмнөговь аймгийн Ханбогд суманд сум дундын шүүх, прокурорын газар байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг мөн хэлэлцэн шийдвэрлэнэ.

Дээр нь түрүүчийн Улсын Их Хурлаар хэлэлцэж эхэлсэн Улсын Их Хурлын тухай болон Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиудад завсарлага авахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийг оруулах хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Энэ нь нам, эвслийн бүлэг, Улсын Их Хурлын нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаанаас завсарлага авахдаа гагцхүү тухайн хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан авдаг, мөн



тодорхой хугацаатай байж Улсын Их Хурлын үйл ажиллагаанд бүтээлчээр цаг үеийн тулгамдсан асуудлыг сааталгүй, түргэн шуурхай хэлэлцэн шийдвэрлэх боломж бүрдүүлэх, түүнчлэн цөөнхийг тухайн асуудалд иргэдийн анхаарлыг хандуулахад цаг гаргаж өгөх зорилготой юмаа.

Төсвийн тодотголтой холбоотойгоор өмнөх Засгийн газар хариуцлагагүй ажиллаж, төсвийн орлогыг хэдэн зуун тэрбум төгрөгөөр тасалснаас болж нийгмийн болон хөрөнгө оруулалт шаардлагатай зарим санхүүжилт хүрэлцэхгүй байгаа. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан төсвөө дахин хуваарилах, түүнчлэн үлдэж байгаа хугацаанд төсвийн хөрөнгө оруулалтыг үр өгөөжтэй зарцуулах зорилгоор 2012 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг мөн хэлэлцэн шийдвэрлэнэ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Улсын Их Хурлын ээлжит бус чуулганы ажиллагааг нээснийг мэдэгдье.

\* \* \*

### **Ээлжит бус чуулганыг хааж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг**

(2012.09.18)

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын энэ удаагийн ээлжит бус чуулган төлөвлөсөн асуудлаа цаг хугацаанд нь хэлэлцэн шийдвэрлэлээ. Ээлжит бус чуулган ажлын 21 хоног үргэлжилж, нэгдсэн хуралдааныг 7 удаа хуралдуулсан байна. Чуулганаар хоёр шинэ хууль болон шинэчилсэн найруулга, 17 хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, хүчингүй болсонд тооцох тухай хууль нэг, Улсын Их Хурлын 15 тогтоолыг тус тус хэлэлцэн батлаллаа.

Ардчилсан намаас дэвшүүлсэн “Монгол хүн” хөтөлбөрт үндэслэн Иргэний зориг, ногоон намын “Амьдрал” хөтөлбөр, МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслийн “Монголоо аврах таван хувьсгал” хөтөлбөрүүд, Улсын Их Хуралд бие даан сонгогдсон гишүүдийн зарим тодорхой саналуудыг тусган боловсруулсан “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг Улсын Их Хурлаар хэлэлцэн баталлаа. Хөтөлбөрт үндэсний эрх ашгаа дээдэлсэн, хувь хүн, өрх гэрийн хөгжлийг эрхэмлэж, баялгийг бүтээгч, чинээлэг, эрх чөлөөт иргэдийн хариуцлагатай нийгмийг төлөвшүүлэх эрхэм зорилго тусгагдаж, нээлттэй, иргэдийн оролцоотой нийгэм, төрийн тогтолцоог бүрэлдүүлэх шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэхээр боллоо. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр нь шинэтгэлийн томоохон арга хэмжээ, үйл ажиллагаа тусгагдсан баримт бичиг боллоо.

Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэн батлав. Орон нутгийн сонгуулийг холимог хувилбараар автоматжуулсан системийг ашиглан явуулах бөгөөд иргэний улсын бүртгэлд “сонгогчийн” гэсэн бүртгэлийг бий болгосон нь сонгууль хэвийн будлиангүй явагдах, сонгогчдын нэрсийн жагсаалтын талаар маргаан, зөрчил, хууль бус үйлдэл гарахаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой боллоо. Энэ хуулийг баталж сонгууль явуулах хугацааг товлосноор орон нутгийн өөрөө удирдах байгууллага бүрэлдэн бий болох эрх зүйн орчин бүрэлдэж, Сонгуулийн ерөнхий хороонд сонгуулийг хуулийн дагуу, цаг тухайд нь, шударга явуулах ажлыг зохион байгуулах үүргээ гүйцэтгэх бололцоотой боллоо.

Улсын Их Хурал Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг хэлэлцэн батлав. Бүх төрлийн нүүрсний зах зээлийн үнийн уналтаас шалтгаалан нүүрсний экспортын хэмжээ буурсанаар улсын төсөвт төвлөрүүлэхээр тооцсон төсвийн орлого буурч байна. Мөн түүнчлэн зэсний үнэ төсөөллийн үнээс бараг 2000 ам.доллараар багассантай холбогдуулан улсын төсөвт тодотгол хийх шаардлага гарсан.

Төсвийн тодотголыг хийхдээ төсвийн орлогын боломжит эх үүсвэрийг дайчлах, татварын зарим хуульд өөрчлөлт оруулах замаар төсвийн орлогыг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийг тооцон зардлыг бууруулах, ажил нь эхлээгүй төсөвлөгдсөн хөрөнгийг 2013 оны төсөвт тусгахаар шилжүүлэх, ахмад болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд Хүний хөгжил сангаас олгох мөнгийг ондоо багтаан бүрэн болгох, Засгийн газрын бүтэц, яамд, агентлагийн бүтцийн өөрчлөлтийг тусгах зэрэг зарчмуудыг баримтлав.

Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийг баталж, 1990-1995 оны хооронд ажил, хөдөлмөр эрхлээгүй буюу эрхлэх боломжгүй байсан, 1995-2000 оны хооронд нийгмийн даатгалын шимтгэл нь төлөгдөөгүй буюу төлөх боломжгүй байсан иргэдийн сард нөхөн төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг тогтоож өглөө. Ингэснээр олон жилийн туршид тэтгэврээ бодит байдлаас доогуур тогтоолгож хохирч байсан ахмадуудад олгох тэтгэврийг нь шударгаар тогтоох эрх зүйн боломж бүрдлээ.

Хуулиар иргэдийнхээ эрүүл мэндийг сахин хамгаалах, архи, тамхины хор хөнөөлтэй тэмцэх, тэдгээрийн хэрэглээг хязгаарлах, зохистой түвшинд байлгах зорилгоор архи, тамхинд ногдуулах онцгой албан татварын хэмжээг нэмэгдүүлэх шийдвэрийг Улсын Их Хурлаас гаргалаа.

Нийгмийн даатгалын болон халамжийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулснаар халамжийн тогтолцоог нэгдсэн удирдлагатай болгож, халамж хүртэх шаардлагатай иргэдэд халамжийн үйлчилгээг шуурхай хүргэх эрх зүйн зохицуулалт сайжирлаа.

Ээлжит бус чуулганаар Шүүхийн захиргааны хуульд хэсэгчлэн тавьсан Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авч, улмаар хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулсан нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн бие даасан байдлыг хангахад чухал алхам боллоо гэж үзэж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын намрын ээлжит чуулган удахгүй эхэлнэ. Энэ чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг Улсын Их Хурлаар баталлаа. Иймээс хэлэлцэх хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлыг Засгийн газар, Байнгын хороод, холбогдох бусад байгууллагууд цаг хугацаанд нь зохион байгуулах шаардлагатай байна. Ээлжит бус чуулганы ажиллагаа өндөрлөснийг мэдэгдье.

\* \* \*



**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2012 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН**

(2012.10.01 - 2013.02.08)

**Чуулганыг нээж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг**

(2012.10.01)

Монгол Улсын Ерөнхийлөгч өө,  
 Монгол Улсын Ерөнхий сайд аа,  
 Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,  
 Хатагтай, ноёд оо,

Улсын Их Хурлын 6 дахь удаагийн сонгуулийн үр дүнд байгуулагдсан Улсын Их Хурлын 2012 оны намрын ээлжит чуулган эхэлж байна. Та бид анхдугаар болон ээлжит бус чуулганаар сонгуулийн үр дүнг баталгаажуулж, бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлсэн. Мөн Засгийн газрыг эмхлэн байгуулах, мөрийн хөтөлбөрийг нь батлах, төсвийн тодотгол хийх зэрэг улс орны тулгамдсан асуудлууд, шаардлагатай хуулиудыг хэлэлцэн баталсан билээ.

Сүүлийн гурван жилд Монгол Улсын эдийн засаг эрчимтэй тэлсэн хэдий ч, дотоодын эдийн засгийн дархлааг сайжруулах, эрсдэлийг багасгах замаар эдийн засгийн урт хугацааны тэнцвэртэй бөгөөд хүртээмжтэй өсөлтийг хангах, гадаад зах зээлийн сөрөг нөлөөлөл, хямралыг зөөллөх хариуцлагатай цаг үе тулгарч байна. Бараа бүтээгдэхүүний болон үйлчилгээний үнийн өсөлт, инфляцийн түвшин хоёр оронтой тооноос давж, ард иргэдийн худалдан авах чадварт сөргөөр нөлөөлөн ядуурал, амьдралын түвшний ялгааг улам нэмэгдүүлсээр байна.

Иргэдийн орлого амьдралд нь хүрэлцэхгүй, үнийн өсөлт, авлига, хээл хахууль, хүнд сурталд дарамтлагдаж, өвөг дээдсээс өвлөгдөн ирсэн онгон байгаль маань сүйдэн бохирдож, монгол хүний аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж байна. Цөөн тооны уул уурхайн бүтээгдэхүүний экспорт, тэдгээрийн дэлхийн зах зээл дэх үнийн төлөв байдлаас хамааралтай манай улсын эдийн засаг эмзэг, хараат байдалтай байсаар байна. Иймээс иргэдийнхээ санал санаачлагад суурилан тэдний оролцоотойгоор эдийн засаг, нийгмийн шинэчлэлийн бодлогыг эхлүүлэх, хэрэгжүүлэх зорилтыг биелүүлэхээр Улсын Их Хурал, Засгийн газраас дорвитой шийдэмгий алхмууд хийх шаардлагатай байна.

Энэ намрын ээлжит чуулганаар ирэх 2013 оны Улсын төсөв, Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл, Хүний хөгжил болон Нийгмийн даатгалын сангийн төсөв, 2011 оны улсын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгдсэн тайлан зэрэг хуулиар тогтоогдсон асуудлуудыг хэлэлцэн батлах болно.

2013 оны төсөв нь шинээр батлагдсан Төсвийн тухай хуулийн дагуу Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоогдсон шаардлагад нийцүүлэгдэн батлах ёстой. Төсвийн бодлогыг оновчтой тодорхойлон хэрэгжүүлэх үүднээс эдийн засгийн хямрал, экспортын гол нэрийн бараа, бүтээгдэхүүн болсон зэс, бүх төрлийн нүүрсний эрэлт багасч, үнэ буурснаас төсвийн орлого төлөвлөж байснаас багасч байгаа нь төсвийн орлогыг нэмэгдүүлэх, бусад боломжит эх үүсвэрүүдийг дайчлах, зардлыг хэмнэх шаардлага үүсч байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу 2013 онд “Төсвийн тогтворжуулалтын сан”-д нэлээд их хэмжээний хөрөнгө төвлөрүүлэхээр тооцоолж байгаа нь зөвхөн төсөвт өөрт нь үүсч болзошгүй эрсдэл төдийгүй төсвөөс шалтгаалан эдийн засаг, нийгэмд үүсч болзошгүй эрсдлээс хамгаалах чухал баталгаа болно.

Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, “Орон нутгийн

хөгжлийн сан"-д олгох хөрөнгийг ихээхэн нэмэгдүүлэх замаар орон нутгийн хөгжлийг дэмжих, төсвийн ил тод байдал, иргэдэд төсвийн төлөвлөлтөнд оролцох, гүйцэтгэлд хяналт тавих боломжийг олгох зэрэг шууд ардчиллын зарчмууд Төсвийн тухай шинэ хуулиар хэрэгжиж эхлэх болно.

Дэд бүтэц болон бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг санхүүжүүлэхдээ зөвхөн төсвийн хөрөнгө болон Засгийн газрын бондыг зарсан хөрөнгөөр хязгаарлагдахгүйгээр эдийн засгийн болон мөнгөний бодлогын хүрээнд бусад арга механизмыг эрэлхийлэн олж, ашиглах шаардлагатай.

Монгол Улсын эдийн засгийн голлох хүч болсон уул уурхайн салбарт байгалийн баялгийг түүхийгээр нь зөөвөрлөж, богино хугацаанд шавхах биш, харин нэгдсэн, цэгцтэй бодлогын үндсэн дээр эдийн засгийн тогтвортой өсөлтөд чиглэгдсэн, байгаль орчинд ээлтэй, ногоон хөгжлийн загварт суурилсан боловсруулах үйлдвэрүүдийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

Халамжийн бодлогын хүрээнд хүүхэд бүрт сар бүр 20 мянган төгрөг олгох, Хүний хөгжил сангийн тухай хуулийн дагуу 2010 - 2012 онд хишиг хувиа аваагүй иргэдийн мөнгийг 2013 онд нөхөж олгохоор төлөвлөж байна. Санхүүгийн тогтвортой байдлыг хадгалсан, эрэлтийн гарал үүсэл, нийлүүлэлтийн хомсдолоос үүдэлтэй инфляцийг хязгаарласан, бараа бүтээгдэхүүний үнийг бүхэлд нь тогтворжуулахад чиглэсэн, шинэлэг бөгөөд идэвхтэй мөнгөний бодлогыг баримтална.

Макро эдийн засгийн түвшинд хөгжлийн урт хугацааны зорилт тавьж, ирээдүйгээ харсан, хэтийн өсөлтийг баталгаажуулсан, харилцан уялдаатай төсөв, мөнгөний бодлого хэрэгжүүлж эхлэх шаардлагатай байна.

Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийг эргэн харах, боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор гарч байна. Үүний тулд 2016 он хүртэл хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлийг энэ удаагийн чуулганаар хэлэлцэж батална. Энэхүү үндсэн чиглэлийг баталснаар ирэх дөрвөн жилд нийгмийн харилцааг зохицуулах хууль тогтоомжийн эрэмбэллийг тогтоох, хууль тогтоох үйл ажиллагааг системтэй, төлөвлөгөөтэй явуулах, нийгэмд тулгамдаж буй асуудлуудыг зохицуулах хуулиудыг батлах өргөн утгаараа эрх зүйн шинэчлэлийн дараачийн үе шатыг эхлүүлэх чухал ач холбогдолтой юм.

Өнгөрсөн жилүүдэд шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч болон хууль сахиулах байгууллагуудтай холбоотой шүүмжлэл тасралтгүй гарч, эдгээр шүүмжлэлүүдийн цаана иргэн хүний хамгийн үнэт баялаг болох эрх, эрх чөлөө хөсөр хаягдаж ирлээ.

Мөнгөтэй хөрөнгөтөйд нь үйлчилдэггүй атлаа эгэл борчуудыг олон жилээр торны цаана суулгадаг манай эрүүгийн хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэгчдийн үйл ажиллагаа бизнес эрхлэгчдэд хүртэл дарамт саад учруулж, эдийн засгийн хөгжилд чөдөр тушаа болж байгааг бид харсаар, мэдсээр байсан хэрнээ олон жилийн туршид энэ байдлыг засах, шинэчлэх талаар ямар нэг алхам хийгээгүйгээс болж, хөрөнгө мөнгө, эрх мэдэл, албан тушаалтанд хуулийг үл хүндэтгэх хандлага газар авч байна.

Иргэдийн хууль хяналтын байгууллагуудад итгэх итгэл суларч байгаа нь нууц бишээ. Иймээс шүүх болон хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжуудыг боловсронгуй болгох асуудал зүй ёсоор тавигдаж байна.

Монгол Улс залгамж чанараа хадгалсан, энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлогоо хэрэгжүүлнэ. Дэлхийн улс орнуудтай эдийн засгийн харилцан



хамтын ажиллагаагаа өргөжүүлж, найрсаг харилцаагаа бэхжүүлнэ. Бүс нутгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцож, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлэхэд Улсын Их Хурал анхаарч ажиллана.

Хилийн чанадад сурч, ажиллаж, амьдарч буй Монгол Улсын иргэдийн эрх ашгийг тууштай хамгаалж, иргэдээ гадаадад зорчих визийн нөхцөлийг хөнгөвчлүүлэхэд санаачлагатай ажиллах, монгол эх орноо гадаад улс оронд сурталчлан таниулах ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна. Эрдэс баялгийн болон бусад салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох замаар гадаадын хөрөнгө оруулагчидтай харилцан ашигтай байх зарчмыг баримтлан ажиллах хэрэгтэй.

Стратегийн болон иж бүрэн түншлэлийн харилцаагаа хоёр хөрш болон гуравдагч хөрш улс холбоодтой бататган бэхжүүлж, тэнцвэртэй, нэгдмэл гадаад бодлого, гадаад харилцааны зарчмыг баримтална.

Хадгаламжийн даатгалын тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай зэрэг хуулийн төслүүдийг хэлэлцэн батлахаар төлөвлөөд байна. Мөн түүнчлэн Улсын Их Хурал үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг боловсронгуй болгох үүднээс Монгол Улсын Их Хурлын тухай болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиудад өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэнэ.

Улсын Их Хурлын Тамгын газраас Улсын Их Хурал, Байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүдэд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд үзүүлж буй мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэгийг үр дүнтэй, оновчтой, шуурхай болгох зорилгоор Тамгын газрын бүтэц, үйл ажиллагааны зохион байгуулалтыг боловсронгуй болгох саналыг боловсруулж байна.

Удахгүй улс орон даяар Орон нутгийн сонгууль болно. Сонгуулийг цаг хугацаанд нь сонгогч иргэдийн оролцоог бүрэн хангасан, элдэв зөрчил, хууль бус үйлдлийг гаргахгүй, шударга зохион байгуулах нь Сонгуулийн ерөнхий хороо болон бүх шатны сонгуулийн байгууллагуудын үүрэг юмаа.

Эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ,

Улсын Их Хурлын 2012 оны намрын ээлжит чуулганы ажиллагаа нээснийг мэдэгдье.

\*\*\*

### **Чуулганыг хааж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг**

(2012.02.08)

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын 2013 оны намрын чуулган төлөвлөсөн асуудлаа хэлэлцэн шийдвэрлэлээ. Намрын чуулган ажлын 93 хоног үргэлжилж нэгдсэн хуралдааны 34 удаа байнгын болон дэд хорооны хуралдааны хуралдааныг давхардсан тоогоор 131 удаа хийсэн байна.

Чуулганаар бие даасан хууль 16, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 68. Олон Улсын гэрээ конвенци зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хууль 3, хууль, хуулийн хэсэг зүйл заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хууль 16, Улсын Их Хурлын 59 тогтоолыг тус тус хэлэлцэн батлав.

Хуулийн дагуу Монгол Улсын 2013 оны төсвийн тухай Нийгмийн даатгалын сан, Хүний хөгжлийн сангийн тухай хуулиуд, Төрөөс 2013 онд баримтлах мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг хэлэлцэн баталлаа.

Нэгдсэн төсвийн нийт тэнцэл 356.3 тэрбум төгрөг буюу ДНБ -ий 2 хувьтай тэнцэж дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл төсвийн тусгай шаардлагуудыг хангасан төсвийг баталлаа.

Макро эдийн засгийг мөнгөний бодлогоор тогтворжуулж ирснийг өөрчилж төсөв мөнгөний харилцан уялдсан бодлогыг хэрэгжүүлэхээр болсон нь нийлүүлэлтийн гаралтай инфляцийн нөлөөг бууруулах, эерэг үр дүн гарах нөхцөлийг бүрдүүлж байна. Төсвийн нийт орлого 7 их наяд 88 тэрбум 300 сая төгрөгт хүрлээ. Төвлөрлийг сааруулах чиглэлээр төсвийн тухай хуульд хийсэн шинэчлэлт, өөрчлөлт хэрэгжиж орон нутгийн төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлсэн алхам боллоо.

2013 оны орон нутгийн төсвийн орлого 1 их наяд, 813 тэрбум 600 сая төгрөг буюу нийт төсвийн 20.7 хувьд хүрч байна. Орон нутагт хийх улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын хэмжээ нэг их наяд 498 тэр бум 400 сая төгрөг, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ 152 тэрбум, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийн хэмжээ 247.6 тэрбум төгрөгөөр батлагдсан байна. Төсөв хөрөнгө оруулалтыг оновчтой зөв хуваарилж, үр дүнтэй зарцуулж чадвал орон нутаг эдийн засгийн хувьд чадавхижих бүрэн боломжийг Улсын Их Хурал бүрдүүлж өглөө.

Төсвийн хэмжээ нэмэгдэж төсвөөс гадуурх төрийн хөрөнгөөр баталгаажсан хөрөнгө оруулалт ихсэж байгаа нь төсөв хөрөнгө оруулалтад тавигдах төсвийн болон орон нутгийн хяналтыг илүү сайжруулах төсвийн төлөвлөлт хуваарилалт зарцуулалтыг олон нийтэд ил тод байлгах шууд ардчиллын зарчмыг хэрэгжүүлэхийг шаардаж байна. Улсын Их Хурал төрийн аудитын байгууллагыг удирдлага, бүтэц зохион байгуулалт, санхүүгийн хувьд бэхжүүлж түүнийг хараат бус хөндлөнгийн байр суурьнаас ажиллах нөхцөлийг хангасан эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болгон гаалийн бүрдүүлэлтэд хүнд суртал чирэгдэл учруулдаг байсан баримт бичгийн тоог цөөллөө.

Газрын тосны салбарт аж ахуйн нэгжүүдийн газрын тос хайх олборлох ашиглах зориулалтаар импортлох бараа бүтээгдэхүүнийг татвараас чөлөөлдөг байсан бодлогыг өөрчилж татварын тэгш, шударга зарчим бизнесийн ижил нөхцөлийг хангасан хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийлээ. Бизнес эрхлэгчдийг татвараа өөрөө тодорхойлж төлөхөд туслах мэргэшсэн зөвлөх ажиллаж тэдгээрийг татварын эрсдэлээс хамгаалж байх эрх зүйн орчныг шинээр бий болгож татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийг баталлаа.

Улсын Их Хурал эдийн засгийн өсөлтийг хангах урт хугацааны хөгжлийн хөрөнгө оруулалт, экспортыг дэмжих хүрээнд таван тэрбум хүртэлх Америк долларын Чингис бонд, малчид үйлдвэрлэгчдийг урамшуулахад 140.4 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 5 жилийн хугацаатай үнэт цаас гаргаж арилжаалахыг Засгийн газар зөвшөөрсөн. Улсын Их Хурал эдгээр бондын борлуулалт түүний үр ашиг санхүүжүүлэх төслүүдийн чанар, үр дүн хэрэгжилтэд хяналт тавин ажиллах болно.

Чингис бондын эх үүсвэрийг техник, эдийн засгийн үндэслэл судалгаа нь үндэслэлтэй хийгдсэн ажлын байр нэмэгдүүлэх, дэд бүтэц, бүтээн байгуулалтын чиглэлийн үр ашигтай төслүүдийг санхүүжүүлэхэд хэрэглэх хэрэгтэй.

Иргэдийн банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын шинэ тогтолцоог бий болголоо. Банкн дахь мөнгөн хадгаламжийн даатгалын хуулийг баталснаар мөнгөн хадгаламжийн найдвартай байдал, санхүүгийн салбарын тогтвортой ажиллагаа хангагдсанаас гадна, татвар төлөгчдийн мөнгөөр дампуурсан банкны алдагдлыг хааж төр хариуцлага хүлээхгүй боллоо.

Эрүүл чийрэг эрдэм боловсролтой Монгол хүнийг хөгжүүлэх шинэчлэлийн Засгийн газрын бодлогыг дэмжиж боловсролын багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт орууллаа. Сургууль, цэцэрлэгийн багш ажилчдыг өндөр насны тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг олгодог боллоо. Өөрөөс нь хамаарахгүй шалтгаанаар ажилласан жил нь тасарсан иргэдийн 1990 - 1995 онд төлөгдөөгүй нийгмийн даатгалын шимтгэлийг төлснөөр тооцох. 1995 - 2000 онуудад төлөх байсан Нийгмийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож нөхөн төлж болохоор нийгмийн даатгалын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

ДОХ -оос сэргийлэх тухай хуулийг мөн шинэчлэн баталлаа. Хүний дархлалын олдмол хомсдолтой вирусын халдвартай иргэдийн тоо нэмэгдэж байгааг эрүүл мэндийн салбарынхан иргэд байгууллага анхаарах шаардлагатай байна. Халдвар авахгүй байх иргэдийн ухамсрыг дээшлүүлэх халдвартай иргэдийн эрхийг хамгаалахад энэ хууль ахиц гаргана гэж бодож байна.

Зөвшөөрөлгүй барилга барьж, барилгын болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг биелүүлээгүйгээс иргэдийн амь нас, эд хөрөнгөд хохирол учрах явдал гарсаар байна. Энэ салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлын хэсгийг Улсын Их Хурлаас томилон ажиллуулж тайланг сонсоод холбогдох шийдвэрийг гаргасан болно.

Шүүхийг шүүн таслах ажлын төрлөөр болон тойргийн зарчмаар байгуулах журмыг шүүх байгуулах тухай хуульд тусгасан. Хууль батлагдсанаар шүүхийн ачаалал буурах хэрэг маргааныг тухайн чиглэлээр мэргэшсэн шүүгч шүүх бүрэлдэхүүн хянан шийдвэрлэх боломж бүрдлээ.

Сар шинийн босгон дээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар улс төрийн мэтгэлцээний сэдэв болоод байсан Оюутолгой төслийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг чуулганаар бүгдээрээ нэгдмэл байр суурьтай сонсож чадлаа.

Энэ онд болох томоохон үйл явдал Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль 6 дугаар сард болно. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгуулийн хуулийн зарчимтай нийцүүлж шинэчлэн баталлаа. Гадаадад ажиллаж амьдарч байгаа иргэд саналаа өгөх боломжтой болсон. Сонгуульд автоматжуулсан техник хэрэгслийг ашиглахаар Улсын Их Хурлын тогтоол гаргасан.

Эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж шийдвэрүүд амжилттай хэрэгжсэнээр улс орны хөгжлийг түргэтгэж их бүтээн байгуулалтыг өрнүүлнэ гэдэгт итгэлтэй байна. Үндэсний уламжлалт баярыг тохиолдуулан ард түмэндээ сар шинийн мэндийг дэвшүүлж эрүүл энх, аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Та бүхэн сар шинэдээ сайхан шинэлээрэй. Монгол Улсын Их Хурлын 2013 оны намрын чуулганы ажиллагаа өндөрлөснийг мэдэгдье.

\*\*\*

## УЛСЫН ИХ ХУРЛЫН 2013 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

(2013.04.05 - 2013.07.10)

### Чуулганыг нээж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг

(2013.04.05)

Монгол Улсын Ерөнхийлөгчөө,  
Монгол Улсын Ерөнхий сайдаа,  
Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,  
Хүндэт зочид оо,

Өнөөдөр Монгол Улсын Их Хурлын 2013 оны хаврын ээлжит чуулган эхэлж байна. Намрын чуулганы завсарлагааны үеэр Улсын Их Хурлын гишүүд иргэд, сонгогчидтойгоо уулзан хууль тогтоомжийг сурталчилж, хэрэгжилтийн явцтай танилцан, хаврын чуулганаар хэлэлцэх хуулийн төслүүдийн талаар иргэдийн санал, хүсэлтийг авлаа.

Миний бие Улсын Их Хурлын зарим гишүүдийн хамт Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймагт ажиллаж сургууль, эмнэлэг, аж ахуйн байгууллагуудын ажилтай танилцаж иргэдийн санал бодлыг сонсон Тамсагийн газрын тосны үйлдвэр, Бичигтийн боомтын үйл ажиллагаатай танилцлаа.

Энэ онд Монгол Улс анх удаа газрын тос олборлогч орон боллоо. Дорнодын политехник коллеж анх удаага ажил олгогчийн захиалгаар хэдэн зуун мэргэжилтэй ажилчид бэлдэж тэд бүгдээрээ ажилдаа орсон байна. Мөн АНУ-ын Конгрессын тэргүүн болон Канадын Парламентын даргын урилгаар Америк, Канад улсад албан ёсны айлчлал хийлээ. Энэ удаагийн айлчлалын үеэр Монгол-Америкийн улс төрийн харилцаа, хамтын ажиллагааны түвшинг стратегийн түншлэлийн хэмжээнд хүргэж өргөжүүлэх, Канад улстай нийгэм эдийн засаг, бизнесийн салбарын хамтын ажиллагаагаа улам гүнзгийрүүлэх чиглэлээр олон чухал уулзалт ярилцлагууд боллоо. АНУ-ын Хойд Дакота мужийн нүүрснээс байгалийн хий гаргах Дакота газ шиг үйлдвэр байгуулвал Улаанбаатар хотын утааг бүрмөсөн арилгах боломжтойг судалж ирлээ.

Айлчлалын үеэр НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга ноён Бан Ги Мүүнтэй уулзлаа. Тэрээр Монгол Улсын ардчилалыг хөгжүүлэх, эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлт, далайд гарцгүй орнуудын эрх ашгийг хамгаалах чиглэлээр гаргаж байгаа манай улсын санал санаачлага, түүний дотор Судан улсад үзүүлсэн цэрэг, эмнэлгийн тусламж, Судан дахь энхийг сахиулах үйл ажиллагааны явцтай газар дээр нь очиж танилцсан Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн айлчлалыг өндрөөр үнэлж байгаагаа хэлсэн.

Улсын Их Хурлын чуулганы завсарлагааны хугацаанд Улсын Их Хурлын даргын урилгаар БНХАУ-ын Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хорооны дарга У Бангуо, Данийн Вант Улсын Парламентын дарга Могенс Ликкеттофт нар манай улсад айлчилж хоёр орны хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар чухал асуудлуудыг хэлэлцлээ. Мөн Ерөнхий сайдын урилгаар Япон Улсын Ерөнхий сайд Шинзо Абэ хэдхэн хоногийн өмнө Монгол Улсад айлчилж хоёр орны парламентын болон улс төр, эдийн засгийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргахаа илэрхийллээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын энэ удаагийн ээлжит чуулганаар Үнэт цаасны зах зээлийн тухай, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулиудын шинэчилсэн найруулга, Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Нийслэлийн

гэр хорооллыг дэд бүтэцжүүлэхэд шаардагдах санхүүгийн арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоол болон намрын чуулганаар хэлэлцэж эхэлсэн бусад хууль тогтоомжийн хэлэлцүүлэг үргэлжлэн явагдана.

Эдгээр хууль тогтоомжуудыг хэлэлцэхийн хамт Улсын Их Хурлын 2012 оны 60 дугаар тогтоолын дагуу Засгийн газраас өргөн баригдах улс орны хөгжлийн бодлогын олон чухал асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Тухайлбал, Монгол Улсын 2012 оны төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг хэлэлцэж дүгнэлт гаргана. Мөн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Монгол Улсын 2014 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2015-2016 оны төсвийн төсөөллийн тухай Улсын Их Хурлын тогтоолууд, 2014-2016 онд төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр зэргийг батална. Засгийн газар эдгээр асуудлыг боловсруулахад онцгой анхаарч, эдийн засгийн нөхцөл байдлыг нарийвчлан тооцсон, улс орны хөгжлийг хурдасгах, ард иргэдийн аж амьдралыг мэдэгдэхүйц дээшлүүлэхэд чиглэгдсэн бодитой бодлогыг боловсруулж хуулийн хугацаанд Улсын Их Хуралд оруулах шаардлагатай. Учир нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл, хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан шинэчлэлийн бодлого, арга хэмжээг бодитой хэрэгжүүлж эхлэх бодлогын баримт бичиг гэдгээрээ онцлог юм.

Нийт нутгаар хаврын урь орж байгаа хэдий ч цаг агаарын хүндрэл, бэрхшээл гарсаар байна. Малчин түмэндээ тусалж дэмжих ажлыг эрчимжүүлж тэдний гэр бүл, хүүхдийн эрүүл мэндэд онцгой анхаарах хэрэгтэй. Нөгөө талаар энэ хавар эхлэх бүтээн байгуулалтын ажлын сонгон шалгаруулалтын хугацаа алдаж байгаа талаар гарч байгаа шүүмжлэлд анхаарлаа хандуулж, ажлаа эрчимжүүлэхийг Засгийн газарт даалгаж байна. Нэг л мэдэхэд бид өвөлтөйгөө дахин золгоно. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахад дэлхийн түвшинд ашиглаж байгаа шинэ технологийг цаг алдалгүй нэвтрүүлж, ирэх өвлийн утааг багасгахад холбогдох яам, агентлаг, нийслэлийн удирдлагууд одооноос анхаарлаа хандуулан дорвитой арга хэмжээ авч ажиллахыг анхааруулж байна.

Улсын Их Хурлаас баталсан Мянганы хөгжлийн зорилтыг дүгнэх хүртэл 1000 хоног үлдээд байна. Монгол Улс шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, нярайн эндэгдлийг бууруулах, бүх нийтээр анхан шатны боловсрол эзэмших зэрэг хэд хэдэн үзүүлэлтээр чамлахааргүй амжилтад хүрсэн байна. Гэвч залуучуудын хөдөлмөр эрхлэлт, сүрьеэ болон бусад халдварт өвчний тархалт, ядуурлыг бууруулах, байгаль орчны тогтвортой байдлыг хангах талаар улам эрчимтэй ажиллах шаардлагатай байна.

Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль болно. Сонгуулийн Ерөнхий хороо болон бүх шатны холбогдох байгууллагууд Монгол Улсын Ерөнхийлөгчийг сонгох сонгуулийг хуулиа ягштал биелүүлэн сонгогч иргэдийн оролцоог хангаж, элдэв зөрчил, хууль бус үйлдлийг гаргахгүй, шударгаар зохион байгуулах үүрэгтэйг сануулъя. Улс төрийн намууд болон иргэддээ улс орныхоо эрх ашиг, үндэсний эв нэгдэл, шударга ёсыг эрхэмлэн дээдэлж, улс төрийн өндөр соёлтойгоор энэхүү сонгуульд оролцохыг уриалж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын хаврын чуулганаар батлах хууль тогтоомж, шийдвэрүүдэд ард түмнийхээ санал бодлыг өргөнөөр тусгаж, Байнгын хорооны болон чуулганы үйл ажиллагаанд хариуцлагатай, идэвхи санаачилгатай оролцохыг уриалж байна. Улсын Их Хурлын 2013 оны хаврын чуулганыг нээснийг мэдэгдье.

\*\*\*

**Чуулганы нээлт дээр Монгол Улсын Ерөнхийлөгч  
Ц. Элбэгдоржийн хэлсэн үг**

(2013.04.05)

Эрхэм хүндэт ард иргэд ээ,  
Улсын Их хурлын дарга, Ерөнхий сайд, эрхэм гишүүд ээ,  
Эрхэмсэг зочид, хатагтай ноёд оо,

Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулган эхэлж байгаа энэ өдрийн мэндийг Та бүхэнд хүргэе. Жилийн өмнөх энэ цаг мөч Улсын Их Хурлын сонгуулийн эхлэлтэй давхцаж байсан. Тэр үед та бүхэн юунд санаа зовж, юу ярьж, амлаж явснаа сайн санаж байгаа байх.

Саяхан би нийслэлийн зарим хороо, хөдөө орон нутагт сум, багийн хуралд оролцож иргэдийн санал бодлыг сонслоо. Хүмүүс улс оронд маань юу болж бүтэж байгаа тухай, юу хийх шаардлагатай талаар ний нуугүй ярьж байна. Би та бүхэнд мөн энэ тухай хэлье гэж бодсон юм. Болж бүтэж байгаа зүйлээс эхэлье.

1. Хүмүүс өөрчлөгдөж байна. Энэ өөрчлөлт зөвхөн Монголд ч биш дэлхий нийтэд болж байна. Хүмүүсийн ухамсар, оюун санаа, амьдралын хэв маяг хурдацтай өөрчлөгдсөөр байна. Хүмүүсийн эрхэндээ, эд баялагтаа эзэн байх эрмэлзлэл нэмэгдэж байна.

Сүүлийн 20 гаруй жил манай оронд олон үйл явц гүйлгэсэн зураг мэт хурдтай өрнөлөө. Нийгэмд явагдаж буй өөрчлөлт бүр хүмүүсийн амьдралд ул мөрөө үлдээсээр байна. Хүн бүр л алдсанаасаа сургамж авч, оносноосоо урам авч урагшилж байна. Монголчууд хөгшин залуугүй улам хэрсүү болж байна. Асуудалд бусдын зааснаар бус өөрийн үнэлэмжээрээ ханддаг болж байна

Өөрийн гэсэн үнэлэмжтэй бүхэл бүтэн үе Монголын нийгэмд түрэн орж ирлээ. 1990 онд 10 настай байсан хүүхэд энэ жил 33-ны босго алхаж өрх гэрийнхээ ч, улс орныхоо ч хувьд ачааны хүндийг үүрэх чадалтай болжээ. 1980-аад оны сүүлч, 1990-ээд оны эхэнд их шуурганаар хөлд орж байсан хүүхдүүд өнгөрсөн жилүүдэд сургууль номоо дүүргэж ажил амьдралын гараагаа ид эхэлцгээж байна. 20 гарч 40 шүргэж яваа эдгээр залуус, эдгээр шинэ цагийн хүмүүс хувь заяандаа эзэн болж чадна гэдэгт би эргэлзэхгүй байна. Хүний хойч үе өмнөхөөсөө илүү хэрсүү, илүү эрдэм чадалтай, илүү ихийг бүтээж чаддагийг хүн төрөлхтний түүх нотолсон.

2. Хүмүүс шийдэлд, ажилд оролцохыг хүсэж байна. Учир нь иргэний оролцоотой шийдэл, хувь хүний бүтээсэн зүйл, түүний үр дүн хүнд наалдаж байна. Улс орны хувьд ч аливаа ажил амжилт хүндээ хүрч байж л ололт болж байна. Манай Улсад бий болж байгаа баялгийн гуравны хоёроос илүү хувийг төрийн мэдлийн бус салбар бүтээж байна.

Орон нутгийн хөгжлийн санд хуваарилагдсан мөнгөө хэрхэн үр бүтээлтэй зарцуулах тухай иргэд ид хэлэлцэж байна. Багийн хурлын хэлэлцүүлэг Улсын Их Хурлын хуралдаанаас дутахгүй сонирхолтой, дутахгүй бүтээлч болж байна. Яам агентлагийн мэргэжилтэн, сайд дарга нар баг, хорооны хуралд очих хэрэгтэй. Хүмүүс асуудлыг өөрсдөө оролцож шийдсэнээр уг шийдлийн хяналт сайжирна. Хяналт сайжирснаар гүйцэтгэл нь чанаржина.

Иргэд оролцоод асуудал шийдээд ирэхээр асуудлын шийдэл амьдралд ойртож байна. Тэд аль нэг намыг, сонгуулийн хөтөлбөр, эсвэл хэн нэг даргын нэр төрийг бодсон бус өөрсдийгөө бодсон шийдвэр гаргаж байна. Шуудхан хэлэхэд амьдралтайгаа, амьдарч байгаа орчинтойгоо уялдуулж шийдвэр гаргаж байна. Энэ нь хүндээ ч хэрэгтэй, байгальдаа ч ээлтэй шийдэл болж чадаж байна. Ийм шийдэл нь Монголчуудыг эрүүл амгалан, тэгш дүүрэн амьдрал руу хөтлөх болно.



3. Хуулийн засаглал тогтож эхэлж байна. Монгол Улс даргын засаглалтай биш, хуулийн засаглалтай орон болж байна. Манай оронд хууль ижил тэгш хэрэгждэг болж эхэлж байна. Алба тушаалтай ч бай, мөнгөтэй хөрөнгөтэй ч бай, танилтай талтай ч бай, хэнбугай ч хууль зөрчсөн бол хууль араас нь очиж байна. Энэ хэрээрээ бид гадаад улсын иргэнийг ч, өөрийн орны иргэнийг ч ялгалгүй хууль биелүүлэхийг шаардаж чадаж байна. Монголын хөрсөн дээр гишгэж л байгаа бол.

Манай иргэд төрөөс бурууд хатуу, зөвд зөөлөн байхыг нэхдэг боллоо. Нэг үгээр хэлбэл хуулийн тэгш хэрэгжилтийг шаарддаг боллоо. Тамхины хууль хатуу талдаа хууль. Хэрэгжиж л байна. Энэ бол хууль Монголд хэрэгжих орчин бүрдэж байгааг харуулж байгаа юм. Тамхины хуулийн сайн, мууд асуудал байгаа юм биш. Хуулийг биелүүлэх соёл манай нийгмийн үнэт зүйл болж эхэлж байна. Энэ бол маш сайн мэдээ. Энэ бол монголчууд үеийн үедээ өвлөн хөгжүүлэх үнэтэй ололт.

Төр оршихуйн үндэс бол хуулийн хэрэгжилт. Улс оршихуйн үндэс бол сайн өв соёл. Хоёулаа оршихуйн үндэс бол түүнийг тээгч, бүтээгч ард түмэн. Шударга ёс бол нэг намын, эсвэл нэг хүний баялаг биш. Энэ бол Монголын баялаг. Монголчууд гэртээ ороод ёс заншлаа дагадаг. Гэрээсээ гараад хууль дүрмээ дагадаг. Энэ бол Монголыг өмнө нь ч авч явсан, одоо ч авч яваа үнэтэй ололт. Бидний ирээдүй ч үүнээс хамаарна. Монголын нэр төр дэлхийд ямараар гарах нь бас хамаарна.

4. Монгол Улсын нэр хүнд өсч байна. Дэлхийн хамтын нийгэмлэг ч үүнийг үнэлж байна. Монголын нэр дэлхийн сонорт хүрлээ. Ерөөлөөр Монголын нэртэй холбоотой яриа муугаасаа сайнаар гарах нь олонтоо боллоо. Хүний хууль ёсны эрхийг дээдлэх, хуулийн засаглалыг хэрэгжүүлэх, иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах Монгол Улсын бодлого бүс нутагтаа төдийгүй, олон улсад талархал хүлээж байна.

Өнгөрсөн жил Монгол Улс дэлхийд авлигын төвшин нь хурдацтай буурч байгаа орноор тодорлоо. Монгол Улсын нэр олон улсын санхүүгийн зах зээлд үнэтэй хөрөнгө боллоо. Үүнийгээ бид ухаалаг ашиглах ёстой. Монгол Улсын энх тайванч, цөмийн зэвсгээс ангид байх бодлогыг НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн Байнгын гишүүн таван орон тавуулаа дэмжиж албан ёсоор баталгаажууллаа. Монгол Улс Европын хамтын ажиллагаа, аюулгүй байдлын байгууллагын бүрэн эрхт гишүүн боллоо. Энэ сарын сүүлчээр Монгол Улсад Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн сүүлийн гурван жилийн ажил үйлсийг дүгнэсэн олон улсын бага хурал болох гэж байна. Монгол Улс дэлхийн ардчилсан хөдөлгөөнийг даргалагчийн хувьд ажлаа тайлагнана.

Манай иргэд, албаныхан ардчиллын туршлага судлах гэж гадагш явдаг байсан. Одоо биднээс юм сонсох гэж олон газрын төлөөлөгчид Монголд ирдэг боллоо. Монгол Улсыг ардчилсан, нээлттэй хуулийн засаглалтай орон гэдгийг хаана ч орчуулгагүй мэддэг боллоо.

Би 1990 оны өвлийн тэсгим хүйтэн, хаврын хавсаргад хувьсгалын гал авалцсан улс төрийн тэмцэлд оролцож явахдаа өнөөдөр Монгол төрийн энэ хүндэт индрээс дээрх ололтуудын тухай ярьж зогсох юм гэж зүүдлээ ч үгүй. Харин сайн сайхан үйлсийг мөрөөдөж, монголчуудад түүнийг бүтээх боломж бий гэдэгт итгэж явсан. Энэ бүхэн бол Монгол түмний нийтлэг ололт. Бид Монголын сайныг бүтээлцсэн, бүтээлцэж байгаа ард түмэндээ, сайн анд нөхдөдөө “баярлалаа” гэж хэлэх ёстой.

5. Нийгэмд олон зүйл эмх цэгцэндээ орж байна. Монгол Улсад тулгамдаж байгаа олон хүндрэл бэрхшээл бий. Хамгийн гол нь тэр хүндрэл бэрхшээлийг бодитой харж, бас ний нуугүй хэлэлцэж чадаж байгаа нь Монгол Улсын ололт юм. Бид бүгдээрээ алдаа дутагдлаа хэлэлцдэг боллоо. Шийдэл гарцаа ч ярилцаж байна. Сайн мэдээ бол бидэнд муугаа засах боломж байна. Асуудал бүрт шийдэл харагдаж байна. Шийдлийн зэрэг

сөрөг талыг дүгнэж цэгнэхдээ, заримдаа засаж залруулахдаа хугацаа алдаж байгаа тал бий. Үүнийг анхаарах ёстой.

Төрийн байгууллагын ажилтанг хууль бус зүйлд уруу татаж, “найрах” гэж орсон хүний ажил нь бүтэхгүй буцсан тухай жишээ сонсогдож байна. Түшмэдийн гар хүндрүүлэхгүйгээр тодорхой ажил гүйцэтгэх эрх авсан ажил хэрэгч хүний талархал хэвлэлийн хуудаснаа үзэгдэх боллоо. Хууль завшихыг оролдогчид цөхрөнгөө барж байна. Харин хууль сахиулагчид ажлаа урамтай хийдэг болж байна. “Яаж ч яриад болсонгүй, хууль яриад хөдлөхгүй байна” гэж. Төрийн албан хаагчийн ийм үйлдэл, ийм шинэ хандлагын тухай хүмүүс ярьж байна.

Эрхэм нөхөд өө,

Чамлахаар чанга атга гэж. Багагүй зүйл цэгцэрч, бас зөв тийшээ салхи эргэж байна. Хүний амь, хүний эрх, хүний амьдрал үнэ цэнэтэйг төр нь ч, олон нийт нь ч ярьдаг боллоо. Хуулийг хэрэгсдэггүй, хүний амийг тоодоггүй ёрын бодлого саяхан болтол газар сайгүй, хот хөдөөгүй ноёрхож байсан юм шүү. Төр бол завшдаг, хүн бол хохирдог. Ийм л замтай. Эсвэл идэх уухын донтнууд эмээл хазааргүй юм шиг аашилдаг. Хууль үйлчилдэг, эс үйлчилдэг давхаргын хямрал дэлбэртлээ даамжирсан үе бас байсан юм шүү. Одоо тийм адгийн ёс зүй бүрэн алга болоогүй ч хорхойтсон баавгай шиг аашилдаг байсан нөхдүүд үүр үүрэндээ шургасан.

Төрийн албыг үнэлдэг, түүнийгээ ид бах болгодог байдал эцэс болж байна. Эцэс болох ч ёстой. Мөнгөний өмнө хууль мөхөсддөг байсан. Одоо хуулийн өмнө мөнгө мөхөсдөж эхэлж байна. Гэхдээ мөнгө хүчтэй байна. Хүмүүс харж байна. Олон түмэн ам амандаа муугийн жишээ болгон ярьж байна. Өмнө нь мөнгөөр бүхнийг шийддэг байсан бол одоо мөнгөөр шийдүүлдэг хэрэг жишээ авах хэмжээнд хүртлээ цөөрч байна. Цөөхөн ч бай энэ дутагдал бол мэдээж тодорхой хуульчтай, тодорхой хүнтэй холбоотой асуудал. Энэ бол нөгөө талаар хууль шүүхийн байгууллагад явагдаж байгаа эерэг зөв өөрчлөлтөд үзүүлж байгаа тэдний эсэргүүцэл.

Дураараа дургиддаг байсан хуучин цагаа санагалзагчид Монголын нийгэмд өрнөсөн шударга ёсны хувьсгалыг зогсооно гэвэл санааны гарз. Учир нь хүмүүс шударга ёсыг ус агаар адил хэрэгтэй зүйл гэдгийг ойлгосон. Одоо хуулийн засаглал, шударга ёс Монголын үндэсний баялаг болсон. Монголын төр авлигачдын атганд байсан үе бий. Одоо тэр нүгэлт савраас аажмаар ангижирч байна. Шударга бусын үрийг таригчид, түүний жимсийг хураагчид Монгол орныг сайн зүйлд хүргэхгүй гэдгийг манай иргэд ойлгодог болсон.

Одоогоос арав хоногийн дараа Улсын Их Хурлаас баталсан хууль шүүхийн шинэтгэлтэй холбоотой багц хуулийн эхний хэсэг нь хэрэгжиж эхэлнэ. Миний өмнө ярьсан зүйл бол хууль хэрэгжээгүй, өнгөрөгч жил, саруудад гарч байгаа эерэг өөрчлөлтүүд. Шүүхийн хууль хэрэгжсэнээр энэ салбарт иргэдийн оролцоо, хяналт бодитой болно. Иргэдийн төлөөлөгч анхан шатны журмаар шийдвэрлэж байгаа хэрэг маргааныг шүүх бүрэлдэхүүнд орно. Өмнө нь иргэдийн төлөөлөгч шүүх хуралд суугч байсан. Одоо шийдвэр гаргагч болно. Шүүх хэргийг хянан шийдвэрлэхэд таслах эрхтэй оролцоно. Ингэж иргэн хүний оролцоо, эрх, хяналт шүүн таслах үйл ажиллагаа, шүүхийн практикт бүрэн утгаараа нэвтэрнэ.

Шүүхийн шийдвэр хуулиар ил тод болно. Зөвхөн шүүхийн шийдвэр бус шүүх тэр чигээрээ ил тод, нээлттэй, иргэнд үйлчилдэг, хүний эрхийг хамгаалдаг төв байгууллага болно. Хоёр хоногийн өмнө та бүхэн харсан байх. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс эхэлж байгаа “Нээлттэй шүүх” төслийн хэрэгжилтийг. Шүүх зөвхөн хүнийг шүүдэг биш, хуулийн засаглалтай Монголд хууль эрх зүйн мэдлэгийг иргэдэд түгээдэг, хууль тойрсон нийгмийн амьдралын сайн жишиг стандартыг тогтоогч институт болно.

Шүүх иргэний хэрэгт эвлэрүүлэн зуучлах үүрэг гүйцэтгэнэ. Шүүхийн салбарт өмнө нь нэр



төдий байсан энэ харилцаа бие даасан тусгай хуулиар, механизмаар дамжиж хэрэгжинэ. Өмнө нь анхан шатны журмаар яллаж шийддэг байсан энэ төрлийн ихэнх хэрэг иргэдийг эвлэрүүлэн зуучлах сайн дурын болон мэргэжлийн багийн тусламжтайгаар иргэд эвлэрч, сайдалцаж, ойлголцож, шийдэгддэг болно. Энэ асуудлаар шийтгүүлэгчдийн тоо эрс цөөрнө. Ингэж Монголын шүүх иргэдийнхээ нурууг тэнийлгэхэд бодит хувь нэмэр оруулна.

Шүүгч, прокурор, өмгөөлөгчид тавигдах шаардлага, шалгуур өндөрсөнө. Энэ салбар шинэ, чадварлаг боловсон хүчнээр байнга сэлбэгдэнэ. Шүүн таслах үйл ажиллагаанд оролцогчдын ажил байдлыг 3-5 жил тутамд Мэргэжлийн Хороо, Хуульчдын Холбоо үнэлж, дүгнэлт гаргана. Шүүгч бүр нөлөөллийн мэдүүлэг гаргадаг болно. “Шүүхэд нөлөөлөөд өг” гэдэг, эсвэл нөлөөлөх гэдэг сонин, эрүүл биш шаардлага, тийм оролдлого хууль бус болно. Шүүхэд нөлөөлөх гэсэн этгээдүүд хуулийн цээрлэл, хариуцлага хүлээдэг болно. Шүүхийн шийдвэртэй холбоотой тусгай санал ил болно. Шүүгч, ялагч хохирогчид шаардлагатай гэж үзвэл гомдол гаргадаг, түүнийг хянан шийдвэрлэдэг механизм тодорхой болно.

Шүүхийн захиргаа, шүүн таслах ажиллагаа хоёр хуулиар тусгаарлагдана. Ерөнхий шүүгч, шүүхийн Ерөнхий зөвлөлийн дарга гэсэн 2 албан тушаалыг 1 хүн давхардуулан хаших явдлыг зогсооно. Шүүх эрх мэдэл санхүү эдийн засаг, улс төрийн нөлөөллөөс хараат бус болж, гагцхүү хуульд захирагдан мэргэших үйл явц бодитой эхэлнэ. Шүүхийн төсвийг Улсын Их Хуралд шууд өргөн мэдүүлнэ.

Би энд шүүх, хуулийн байгууллагын шинэтгэлтэй холбоотой 10 хоногийн дараа хэрэгжих, эхний шатны цөөн хуулиас зарим нэг зүйлийг мэдээлэл болгож хэллээ. Мөн хаврын энэ чуулган, бас ирэх чуулгануудаар дамжин хэлэлцэх хууль шүүхийн салбарын болон хуучнаар эрүү, иргэн, захиргааны хэргийн, мөн түүнийг мөрдөн шалгах, илрүүлэх, хянан шийдвэрлэх, дээр нь хууль сахиулах, шийдвэр гүйцэтгэх байгууллага, цагдаа, маршалын алба, ял эдлүүлэх асуудал, иргэн хохирогчийн эрх хамгаалал гээд олон суурь хуулийн төслүүд бэлтгэгдэж, ид хэлэлцэгдэж байгаа тул нэмж ярилгүй орхиё. Монгол Улс ийнхүү хуулийн засаглалтай орон болох замаа тууштай, бодлоготой эхлүүлж байна. Монголын ард түмэн шударга ёсыг хүсэж байгаа учраас энэ ариун үйлс бүтнэ гэдэгт би эргэлзэхгүй байна.

Эрхэм гишүүд ээ,

Би зарим амжилт ололтын тухай, түүнийг хэрхэн бататгах талаар ярилаа. Одоо бид юун дээр алдаж байна вэ гэдгээ ярья. Мөн алдаагаа яаж засах талаар ч товчхон саналаа хэлье.

1. Хүнээ мартаад байна. Энд л бидний гол алдаа байна. Бид уул уурхай, бүтээн байгуулалт, шинэчлэл гээд олон зүйл ярьж байна. Хүнээ хэзээ ярих юм вэ? Хавар цагт махны үнэр ч авч чадахгүй хонож байгаа айл олон байна. Намар болоход аяга самраас 10 төгрөг унагах гэж суудаг хүмүүсээ яах вэ. Эмнэлгийн хонгил дүүрэн зулаад хэвтчихсэн өвчтэй, ханиадтай хүүхдүүдээ яах вэ. Нэг ангид 70, 80-аараа сууж хичээллэх сурагчдаа яах вэ? Цэцэрлэгт орж чадахгүй гэртээ цоожлогдон айж бүлтэгнэх нялхсаа яах вэ. Төрөх газар ор олдохгүй өнөө маргаашгүй нярайлах гэж яваа тулгар биетэй сандарсан ээжийн зовлонг хэн нимгэлэх вэ? Харж хандах хүнгүй ганцаардлын галд унасан ахмадуудаа яах вэ? Гудамжинд таних тэмдэггүй харанхуйд тэмтчиж яваа хараагүй, эсвэл өндөр шатнаас унаж гэмтэж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ яах вэ?

Хүний нийгмийн мөн чанар бол нэгэнтэйгээ халамж хайраа хуваалцахад оршдог. Мөн аливаа асуудлыг шийдэхдээ хүнийг голд нь тавьж шийддэгт л оршдог. Хүний зовлон жаргалаас ургуулж асуудлаа харвал зөв болно. Би үүнийг хөндөхдөө халамжийн тухай ярих гэсэнгүй. Мэдээж төрөөс халамжлах шаардлагатай нийгмийн хэсэг бий. Би энэ тухай ярихдаа эрхийн тухай ярих гэсэн юм. Ялангуяа асуудал шийдэхэд цөөнх болоод байгаа тэр хүмүүсийн эрхийн тухай.

Энэ танхимд хүүхдүүд, эсвэл гавьяаныхаа амралтад гарсан ахмадууд олонх болж орж

ирээд асуудал шийдэлцэх боломж алга. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тулгар биетэй ээжүүд, эрх нь зөрчигдөж байгаа охид залуус, оюутнуудад тийм боломж байхгүй. Тэд нийгэмд олуулаа байгаа ч асуудал шийдэх танхимд цөөнх болчихоод байна. Тэр хэсгээ бодож, тэр хүмүүст хүний эрхээ эдлэх, асуудлаа шийдүүлэх боломж нь байнга нээлттэй байх тухай би ярьж байгаа юм. Асуудлыг хүнээсээ эхэлж, тэднээс эхэлж шийд, тэгвэл бүтэн болно. Ингэвэл манай улс хүмүүнлэг нийгэмтэй орон болно. Хүнийхээ төлөө ажилладаг төр засагтай орон гэж яригдана.

Би энд эх хүн айх аюулгүй амаржих эрхийн тухай ярьж байна. Эрхээ эдлээд ч бусдын энд хүрч чадахгүй тэр хүмүүсийн тухай бас ярьж байна. “Та тэтгэврийн хүн учраас байрны зээлд хамрагдах боломжгүй”. Эсвэл “Ажилласан жил чинь хүрэхгүй учир боломжгүй” гэдэг. Ийм л гол зурсан үгийг манай ахмадууд, бас ажил хөдөлмөр эрхлээд удаагүй, эсвэл ажилгүй яваа залуус, залуу гэр бүл сонссоор байх уу. Эдгээрт шийдэл бий. Олон оронд үүнийг шийдээд ирсэн сайн туршлагууд ч бий. Гагцхүү түүнийг ойлгох сэтгэл, цэгцтэй бодлого хэрэгтэй байна.

Нийслэлийн захиргаа ахмадууддаа зориулсан орон сууцны хөтөлбөр эхлүүлж байгаа юм байна. Бусад хот сууринд ч үүнийг эхлүүлэх цаг болсон. Засгийн газар залуус, залуу гэр бүлийн орон сууцны хөтөлбөрийг энэ хавар тодорхой болгож эхлүүлэх хэрэгтэй. Би Монгол Улс эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний 100 жилийн ойгоор олон асуудал, түүний шийдлийн тухай энэ индрээс тодорхой ярьсан. Одоо гүйцэтгэлийг л шаардана. Манай эрүүл мэнд, боловсролын салбарын хөрөнгө оруулалт үнэхээр санаа зовоож байна. Энэ салбарт хөрөнгө оруулагчдын хувьд тусгай бодлого хэрэгтэй байна. Энэ өгүүлбэрээр дамжиж бидний алдаад байгаа хоёр дахь асуудал руу оръё.

2. Монголын төр бүтээгчдээ дэмжихгүй байна. Юм бүтээж, ажил хийж яваа хүнээ дэмжихгүй байна. Энэ бол том алдаа. Ямар учраас эрүүл мэндийн болон боловсролын салбарт төрийн бус хөрөнгө оруулалт хамгийн бага байна вэ? Мэдээж энэ салбар хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахгүй байна. Ерөөс Монгол Улс хөрөнгө оруулагчид баялаг үйлдвэрлэгчдэдээ хандсан тогтвортой, тодорхой бодлогогүй явж ирлээ. Бидний уриад дуудаад байсан уул уурхай, дэд бүтцийн салбар хүртэл бодит хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтаар гачигдсаар байна. Хөрөнгө оруулалтын тогтвортой орчин алга байна. Холоос бараа бүтээгдэхүүн зөөх болдог учир манай импортын, нэмүү өртгийн татвар ч нэрмээс болж байна.

Нөгөө бидний яриад байсан дэлхийд хамгийн хурдтай хөгжиж байгаа эдийн засаг нэгхэн жилийн настай байсан юм гэж үү? Бас гайхагдаад байсан уул уурхайн хөгжлийн тэсрэлт ийм хурдан болоод өнгөрөв үү? Юу ч болсон нэг юм тодорхой. Тоо худал хэлэхгүй. 2011 оны эцсээр 18 хувь хүрч байсан эдийн засгийн өсөлт жилийн дотор 10 руу эргэж уналаа. Өнгөрсөн оныг түүний өмнөх онтой харьцуулахад гадаад дотоодын хувийн хөрөнгө оруулалтын хэмжээ 60 гаруй хувиар буурлаа. Үүнийг сонгуультай битгий холбоорой. Сонгууль бол ардчиллын чухал механизм. Бас эрх баригчидтай хариуцлага тооцох хэлбэр. Төрөө сонгож байгуулах хүний үндсэн эрхийн нэг үзүүлэлт.

Дээрхийн шалтгааныг хүмүүс өөр өөрийнхөөрөө тайлбарлаж байна. Нээлттэй нийгмийн давуу тал ч энэ юм. Би үүний шалтгааныг хариуцлагагүй улс төртэй холбон харж байгаа. Хариуцлагагүй алхам хийвэл улсаараа амсах хохирол дэндүү их болж магадгүй талаар би ярьж сануулж байсан. Одоо ч сануулъя. Ер нь манай бодлого тодорхойлоход оролцдог хүмүүс зах замбараатай, хариуцлагатай байх цаг болсон.

Барилгад нэг тоосго өрж, замд хүрз шороо хаяж, улсын хөгжилд нэг хадаас ч нэмэрлээгүй хүн манай улстөрчдийн дунд олон бий. Тэгсэн атлаа ард түмнийхээ амьдрах байшингийн суурийг үг үйлдлээрээ дэлбэлж явдаг. Нөгөө хайр зарладаг ард түмэндээ гай тарьж байдаг. Шинэ баян цээж өвчтэй гэж ярьдаг. Улс төрд орох гэж,

эсвэл ороод “баян” болсон этгээдүүд жаахан даруулгатай баймаар юм.

Би та бүхэнд нэг зүйлийг зориуд сануулж хэлье. Алба ажлаа эх орныхоо төлөө зориулах, эх орноо алба ашгийн төлөө золих хоёр бол их ялгаатай. Монгол хүнд өнөөдөр юу хэрэгтэй байна вэ? Ажил хэрэгтэй байна. Орлого хэрэгтэй байна. Монгол оронд өнөөдөр юу хэрэгтэй байна вэ? Бүтээн байгуулалт хэрэгтэй байна. Хөгжил дэвшил хэрэгтэй байна. Таны яриад байгаа зүйл зөвхөн танд хэрэг болоод байна уу, эсвэл Монголд хэрэг болоод байна уу гэдгийг бодох л хэрэгтэй. Сайн бодох хэрэгтэй.

Монгол Улсад нүүрлэж байгаа санхүү, эдийн засгийн хүндрэлийн үр дагаврыг, хор уршгийг манай ард түмэн л төлнө. Нөгөө улсаа, ард түмнээ хайрласан улстөрчийн гялгар нүүрэнд үсрээд нэг үрчлээ л нэмэгдэнэ. Их юм уншиж, их юм бодох хэрэгтэй. Ер нь бодлого гэдэг үг бол бодох гэсэн үгнээс гаралтай. Төрийн хүн өөрийн сэтгэл хөдлөлийг, өөрийн сайхан санааг бодлого гэж эндүүрч болохгүй. Улс гүрнүүдийн түүхэнд тохиосон олон гай зовлонгийн ихэнх нь нэг болон нэг хэсэг улстөрчийн ард түмнээ жаргаах гэсэн сайхан санаанаас үүдсэн байдаг.

Төрийн хүн бол “би юунд хүрэх вэ” гэж бодохоос илүүтэй, “улс маань юунд хүрэх бол” гэж сэтгэлээ чилээж явах ёстой. Би төрөөс нь гаргасан зарим шийдвэрт үнэн сэтгэлээсээ хорсож гомдож явдаг, хохирсон манай ажил хэрэгч олон хүнтэй таарч байсан. Бизнесийн аливаа шийдэл үнэтэй байдаг. Мөнгөөр хэмжигддэг. Хохирогч нь Монгол хүн. Ялангуяа хөрөнгө оруулалттай холбоотой. Шийдэл бүрийн цаана асар их цаг хугацаа, хөрөнгө хүч, заримдаа хүний амьдралын утга учир ч зориулагддаг юм байна л даа. Гэтэл нөгөө бодлого нь, орчин нь нэг өдөр өөрчлөгддөг. Хийсэн тооцоо, зарсан бүтээсэн бүхэн нь шатдаг. “Хазахаас бусдыг хийж байж бид жаахан юм бүтээдэг” гэж нэг бизнес эрхлэгч хэлж байсан нь миний санаанаас гардаггүй юм.

Манай төр бүтээгчид, хөрөнгө оруулагчид, хувийн хэвшил рүүгээ амьдрах орон зайгүй болтол нь дайрч байна. Төрийн ийм бодлогод ташуур биш хазаар хэрэгтэй болжээ. Бизнес орчны хувьд, амьдралаа бие даагаад авч явж байгаа иргэдийн хувьд улс төр хамгийн том эрсдэлд тооцогдсоор байна. Хөгжил бол чөлөөт үйлдвэрлэгчдийн бүтээл. Улсын хөгжил дэвшил, популист улс төр хоёр урвуу хамааралтай. Миний бодлоор бол одоо шоу хийдэг цаг биш. Ажил хийдэг цаг. Бүтээдэг цаг.

“Монголын эдийн засаг хурдан өслөө” гэж яригдсан боловч манай эдийн засаг түүхий эд голлон экспортод хөгжлийн хувьд доод эрэмбийн эдийн засаг хэвээр л байна. Тэр тусмаа ухаж зөөх салбараас хараат. Монгол орон хөгжлийн хувьд дунд эрэмбийн эдийн засагтай орон болох гэвэл байгаа нөөц боломжоо ашиглаад бусдад хэрэгцээтэй бараа бүтээгдэхүүн, өртөг шингэсэн баялаг үйлдвэрлэх, экспортлоход бодлогоо чиглүүлэх ёстой. Ингэхийн тулд бидэнд бүтээгчдээ, хөрөнгө оруулагчдыг дэмжихээс өөр зам алга.

Хөрөнгө оруулагч гэхээр гадаадынх гэж бүү ойлго. Дотоод гадаадгүй хөрөнгө оруулалтад тогтвортой, тодорхой Монгол Улсын бодлого, хууль хэрэгтэй байна. Ингэхийн тулд монголчууд дотроо ойлголцох хэрэгтэй. Наад зах нь шийдвэр гаргах түвшинд. Сүүлийн үед энэ чиглэлд дэвшил гарч байгаа. Нэгнийхээ хийсэн бүтээсэн зүйлийг үргэлжлүүлэх хэрэгтэй. МАН өмнөх Улсын Их Хуралд олонх, намын дарга нь Ерөнхий сайд байхдаа Оюутолгойн ордын хөрөнгө оруулалтын гэрээг батлуулж эхлүүлсэн. Энд ярилцах зүйл бий. Гэхдээ энэ нь хөрөнгө оруулалтыг түлхэх шалтгаан болох ёсгүй. Эндээс бидэнд авах сургамж бий. Бид шийдвэр гаргахдаа олон зүйлийг бодох ёстой. Нийгэм, эдийн засаг, улс төр, хүрээлэн буй орчин, хүн ард, бүс нутаг, аюулгүй байдал гээд.

Монголд хөрөнгө орж ирэхэд саад бэрхшээл их бий. Олон даваа давах, олон ус гол гатлах хэрэгтэй болдог. Бид биднэ. Хуучны хүмүүс хамгийн хэцүү юмыг хүний төрлийг олж төрөхтэй зүйрлэдэг. Зүүний үзүүрт асгарч буй буудайнаас нэг нь тогтож үлдэхтэй адил

юм гээ биз. Хөрөнгө босгож юм хийнэ гэдэг ямар хэцүүг тэр ажлыг хийж яваа хүмүүс л мэдэх байх. Манай орны бизнесийн орчинд агаарын бохирдол нүүрлэснийг одоо бүгдээрээ хүлээн зөвшөөрье. Алдаагаа хүлээе. Сургамжаа авъя. Алдаагаа засъя.

Хөрөнгө оруулагчид тэр бүр татварын хөнгөлөлт хүсэхгүй байна. Улсын бодлого, хууль тууштай тогтвортой байхыг л харж байна. Бүгдээрээ энэ байдалдаа дүгнэлт хийе. Бодлогоо тогтвортой, тодорхой болгоё. Улаанбаатарт, эсвэл орон нутагт хичнээн хөрөнгө оруулбал хэдэн жил тогтвортой байхыг баталгаажуулъя. Уул уурхай, дэд бүтэц, үйлдвэрлэл, эсвэл эрүүл мэнд, боловсрол, өндөр технологид оруулсан ямар хөрөнгө, ямар хугацаанд тогтвортой байхыг хэлж өгье. Уг хуулийг тогтвортой хэлбэрэлтгүй мөрдөнө гэдгийг баталгаажуулж өөрчлөлт оруулах босгыг нь ч тусгайлан өндөр хувиар зааж өгье.

Жижиг, дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдэд ямар хүндрэл байгааг нь сонсьё. Хүү багатай, хугацаа урттай зээлийг тэд хүсдэг. Нэмүү өртөг болон зарим татвар, төрийн олон шахалт дарамтыг хөнгөвчлөхийг тэд хүсдэг. Ажлын байр бий болгож байгаа, тэр тусмаа 40 -өөс дээш насны эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг авч ажиллуулж байгаа бол жижиг, дунд бизнес эрхлэгчдэд хөнгөлөлт үзүүлэх хэрэгтэй. Мөн хот хөдөө, салбар орчин нөхцөлд нь тохирсон тодорхой, тогтвортой бодлого гаргая. Энд шийдлүүд, гарц бий. Тэдэнд туслахын тулд бүгдээрээ ухаанаа уралдуулцгаа. Ингэж чадвал Монгол Улс хөрөнгө оруулахад бизнес эрхлэхэд ээлтэй орон болно. Том нь ч босно. Жижиг, дунд бизнес ч сэргэнэ.

Би энд нэг юмыг онцгойлон дурдах гэсэн юм. Монгол Улс бол дэлхийд байгаа ганц улс биш. Гэхдээ Монгол бол дэлхийн хамгийн их хүн амтай, хамгийн том газар нутагтай хоёр улсын хооронд оршдог цорын ганц орон. Манай орны газар зүйн байршилд давуу тал ч бий. Өвөрмөц хүндрэл бэрхшээл ч бий. Монгол Улс хоёр хөрштэйгөө бүх талаар найрсаг сайхан, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэхийг эрмэлздэг. Мөн манай орон дэлхийн хамтын нийгэмлэгийн нэг гишүүний хувьд бусад орон, олон улсын байгууллагатай харилцдаг. Энэ бүхэн манай ард түмний ажил амьдрал, улс орны хөгжил дэвшилд тодорхой байдлаар нөлөөлдөг. Монголоо газар зүйн байршлын хувьд бусад газар оронтой зүйрлэж бүү ярьцгаа. Монгол бол байршлын хувьд зүйрлэх юмгүй орон. Бидний дээр тэнгэр л нээлттэй байна. Энэ бол түрүүчийн миний хэлдэг бүтээгчдээ дэмжих, хөрөнгө оруулалтын бодлогод ч хамаатай зүйл.

3. Гурав. Бид төрөө засалгүй уджээ. Төр томорч байна. Улам өөхөлж байна. Бидний нэн даруй засах ёстой нэг алдаа бол энэ. Төрийн зардлын хэмжээ нэмэгдсэн байна. Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх жин нь жил ирэх тусам өссөөр байна. Ханшны нөлөөллөөр үүсч байгаагаас бусад зардлын зүйл ангийг дээрээсээ аваад царцаах хэрэгтэй. Энэ хавар Засгийн газар төсвийн хүрээний мэдэгдлийг төлөвлөж орж ирэхдээ энэ зарчмыг баримтлахыг чиглэл болгоё.

Нийгмийн амьдралд төрийн хэт оролцоог багасгах хамгийн сайн арга бол эрхийн шилжилт юм. Төрд, үнэн чанартаа дарга, шийдвэр гаргагчдад төвлөрсөн эрхийг боломжтойгоос нь эхлээд бусдад шилжүүлэх хэрэгтэй. Иргэдэд, олон нийтийн үүсгэл санаачилгын, мэргэжлийн болон бизнесийн байгууллагуудад төрөөс хуульчилж шат дараатай шилжүүлэх олон эрх, үйлчилгээ бий. Хуулийг нь баталж, жагсаалтыг нь гаргаад энэ ажлыг хурдан эхэлье. Эс бөгөөс төр маань хүнд суртал, эрхийн таргаа даахгүй болох нь. Энэ асуудлыг шийдэх ёстой гэсэн хатуу итгэл үнэмшилтэй эрхэм гишүүдийн тоо олширсонд би баяртай байна. Төрийг урлах, засах ажил цаашид улам амжилттай явна гэдэгт итгэж байгаа.

Хүн өөртөө төртэйг мартаж болохгүй. Хувь хүний төр хүчин мөхөсдсөн үед л нийтийн төр оролцож байх учиртай. Төрийн гол үүрэг бол хуулийг хэрэгжүүлэх, хүнд үйлчлэх

хоёрт л оршдог. Иймээс ч төрийн хүний мөн чанарыг хууль биелүүлэх чадвараар нь, иргэддээ тохиож байгаа асуудлыг шийдэх сэтгэл зүтгэлээр нь хэмждэг. Төрийн албыг нийтийн үйлчилгээ гэж хэлдэг нь бас санамсаргүй зүйл биш. Үйлчилгээнд л сэтгэл шингэдэг.

“Чөтгөр гоймонд дурлав” гэж. Зарим хүн төрийн албанд оронгуутаа, юун туханд хүрэлгүй эрх цуглуулах өвчинд автах юм. Дарга, сайдуудын тушаал захирамж гаргадаг замбараагүй эрхийг хуулиар журамлах ёстой. Дур зоргоороо хэм хэмжээ тогтоож, хүний эрхийг зөрчөөд байгаа юм. Шаардлагатай бол дүрэм журмаа өөрчил. Хуульд өөрчлөлт оруулах саналаа Засгийн газраар дамжуулж гарга.

Бас хүн ажлаас халах өөрчлөхөд учиртай хандмаар байна. Тэр хүнийг хамт олон нь ил тод хэлэлцээд өөрчилье гээгүй бол, өөрөө хүсэлт гаргаагүй бол, тавигдаж байгаа шаардлага бодлогыг хэрэгжүүлж чадаж байгаа бол хамаагүй халаа солио хийдгээ зогсоох хэрэгтэй. Энэ шаардлага бол төв Засгийн газарт ч, яам агентлагт ч, орон нутгийн засаг захиргаанд ч хамаатай. Ер нь шинэчлэл хийх гэж байгаа бол эхлээд хуулиа өөрчил, дүрмээ өөрчил. Түүнд зохицож ажиллахыг албатуудаасаа шаард. Гэхдээ даргад таалагдахгүйг бус харин иргэнд таалагдахгүйг өөрчлөхийг шинэчлэл гэж байгааг сана.

Би хэлж сануулах үүрэгтэй. Би ард түмэн гэж ярих эрхтэй. Би та нарт улсын зовлон ярих гэсэн юм. Байх газраа байхгүй мөртлөө, хүний замд тээглээд байдаг. Үүнийг л харалган төр гэж нэрлэдэг. Эрхэм гишүүд ээ, та нарын яриад байсан шударга ёс тогтоох ажил чинь юу болж байна аа? Жаахан орж ирж байсан хөрөнгө оруулалт зугтаж байна. Юм бүтээж хийх гэсэн хэсэг маань мохож байна. Хулгайтай, худалтай, авлигатай тэмцэх, Монгол Улсыг хөгжүүлэх босгох, ард түмний амьдралыг өөд нь татах амлалтууд чинь юу болсон бэ? Надтай уулзсан хүмүүс үүнийг та нараас асуу гэсэн учраас би үүнийг асууж байгаа юм. Улсын Их Хурлын гишүүд ээ, улсаасаа төөрчихсөн юм шиг явдгаа болих хэрэгтэй. Амьдрал дунд ор.

Би манай улс төрчдийн юунд юлган гүймхийг, бас юунд шилээ татдагийг сайн мэднэ. Би та нарт хэлэхгүй бол хэн хэлэх юм бэ? Үнэн шүүмжлэл, хатуу үг бол худал магтаалаас олон дахин тустай шүү. Би зарим хийж байгаа, хийх шаардлагатай байгаа ажлын талаар ярилаа. Зарим зүйлийг хамтарч хийх гэж та нарыг уриалж байна. Авлигатай тэмцэх, ядарсан нэгэнд туслах бол миний араншин. Авлига бол мөөгөнцөр шиг. Үе үе хусаж л байхгүй бол ургаад гараад ирдэг. Авлига бол хавдар шиг хортой. Огтолж хаяхгүй л бол үсэрхийлдэг. Түмэнд үйлчлэх тангараг өргөчихөөд эргээд иргэдээсээ хулгай хийхийг зөвшөөрч болох уу?

Арван цэцэрлэг барих мөнгө нэг авлигачийн холын хамаатны данснаас гарч ирж байна. Ахмадуудын тэтгэврийг бүтэн улирлаар тавьж өгөх мөнгийг хэсэг этгээдүүд иргэдээсээ дээрэмдсэн нь илэрч байна. “Болохгүй”, “хориглолоо” гээд байхад л ашигт малтмалын лицензийг олон арваар нь олгочихсон, зарчихсан л байна. Хавар худалдах гэж нөөцөлсөн махыг хэдэн арван машинаар нь муудсан, хөгцөрсөн махаар сольчихсон л байна. Төр ийм хүмүүсийн толгойг илэх гэж үү? Би хэлдэг “Төр хулгайтай тэмцдэг, хууль зөрчигчтэй тэмцдэг газар” гэж.

Хулгай нь илчлэгдсэн, илчлэгдэж байгаа этгээдүүд зүгээр сууж байна гэж бодож байна уу? Тэд амь тэмцэж байна. Тэд хорихоос мөнгөө, гар хөлөө удирдаж байна. Тэд бүгсэн газраасаа бүхнийг зохицуулж байна. Хуулийн байгууллагын ажилтнуудыг мөнгөөр ч өнгөөр ч дарамталж байна. Хэргийнх нь анатомийг ярьсан хэвлэлийнхнийг хүртэл айлгаж сүрдүүлж байна. Тэд боломж хүлээж байна. Эргэж сэргэх тухай ярилцаж, төлөвлөж, бас хөдөлж байна. Тайвширч болохгүй.

Хуулийн засаглал, шударга ёс л Монголыг аварна. Үүнийг өглөө бүр санаж босох

ёстой. Ээжүүд нярай хүүхдийнхээ живхийг бохирдонгуут нь сольдог шиг, Монгол Улс бохирдсон албан тушаалтнуудаасаа салж л байх ёстой.

Монголчуудад эв нэгдэл хэрэгтэй. Би үүнийг сайн ойлгож байна. Гэхдээ бидний эв нэгдэл шударга ёсонд суурилах ёстой. Ийм эв нэгдэл урт настай, удаан жаргалтай, өгөөжтэй байх болно. Манай оронд тогтвортой байдал чухал. Бидэнд гашуун сургамж бий. Муу засаг огцорсон ч дараачийнх нь түүнээс улам дорддог. Тогтворгүй байдлаас улс орон иргэд л хохирдог. Намайг Ерөнхийлөгчөөр ажиллах хугацаанд Монгол Улсад нэг ч Засгийн газар огцроогүй. Улс оронд тогтвортой байдал чухал юм бол, би үүнийг ололт гэж бодож байгаа. Та бид улс төрийн ч, эдийн засгийн ч тогтвортой байдлыг бодит ажил бүтээлээр, хууль тогтоомжоор баталгаажуулах ёстой.

4. Дөрөв. Би бас нэг алдааны тухай хэлэхгүй өнгөрч болохгүй байна. Нийгэмд бий болж байгаа баялаг нийтийн хүртээл болж чадахгүй байна. Монгол Улс цөөн баянтай, олон ядуутай хэвээрээ л байна. Бараг зуун жилийн өмнө бүгдээрээ баяжих тухай яриа Монголд гарч байсан. Олонх болж байгаа ядуустайгаа баялгаа хуваалцахгүй бол бөөн цөөн баячуудаа ч бид алдах болно. Энэ асуудлыг шийдэхийн тулд дахиж дугуй бүтээх хэрэггүй. Баялаг бүтээх үйлсэд иргэдээ оролцуулах үүд хаалгыг л нээх хэрэгтэй. Баялаг нэг хүнийх, нэг гэр бүлийнх байнга байх боломжгүй. Аливаа баялаг нийтийн шинж чанартай байдаг. Түүнийг албажуулах, амьдралд буулгах л хэрэгтэй.

Хөгжлөөрөө дээд гэж эрэмбэлэгдэж байгаа эдийн засгийн дийлэнх хувь нь олон нийтийн эзэмшилд байна. Зарим судалгааны газар “Дэлхийн нийт баялгийн 95 хувийг олон нийтийн хувьцаат компани бүтээж байна” гэж гаргажээ.

Монгол Улсад дэлхийн энэ хандлага урвуугаараа байна. Манай оронд бий болж байгаа нийт баялгийн 95-иас илүү хувь нь цөөн гэр бүл, эсвэл цөөн дарга нарын, уучлаарай “төрийн” гэх ёстой, эсвэл төрийн мэдэлд байна. Ерөөс төрийн савлагаатай шийдвэрийн, манай улсын тогтворгүй бодлогын эх үндэс энд л байгаа юм.

Улстөрчид бол өвөрмөц амьтад. Нийтийн санаа бодлын салхийг дагадаг. Олонх нь баячуудаа загнавал дагаад загнана. Гадаадынхныг хараавал ганцаараа ч хамаагүй чулуу авч шиднэ. Аягүй бол мөнгө өгснийг нь мартаж, мөнгө өгөөгүй рүү нь дайрна. Ийм л өнгө манай улс төрд их байна. Хэрэв өнөөдөр нэг өмчлөгчтэй хувийн компани 10 мянган хувьцаа эзэмшигчтэй болчихвол, тухайн бизнесийн эрх ашгийг нэг улстөрч самрах биш тэр 10 мянган хувьцаа эзэмшигч нь хамгаалах болно. Энэ тоо ерөөлөөр 100 мянга, сая хүрэх юм бол монголчуудын ихэнх нь хамтарч бүтээж байгаа баялгийнхаа төлөө зүтгэх болно. Бодлого тодорхойлогчид нь тэр салхийг дагана. Иймээс манай бизнесийнхэн улс төрчдөд мөнгө өгч аргадах биш, иргэдэд хувьцаагаа худалдсан нь хамаагүй өлзийтэй.

Үнэт цаасны болон хөрөнгийн биржийн шаардлагатай хуулийг хурдан гаргая. Дотоод гадаадгүй Монголд орж ирж байгаа баялаг бүтээгчид тэр баялгаа Монгол Улсын иргэдтэй хамтарч бүтээцгээ. Тийм боломжийг хуулиар, бодлогоор нээж баталгаажуулж өгье. Монголд ажиллаж л байгаа бол Монгол Улсын иргэдтэй хамтарч ашгаа хий, хамтарч баяж, хамтарч баялгаа бүтээ. Ингэвэл манай төрөөс бизнес эрхлэгчид та бүхэнд уддаг олон зовлон дуусгавар болно. Та бүхний бизнест аль нэг Улсын Их Хурлын гишүүний хийлгэсэн хэвлэлийн бага хурал, хэлсэн үг, эсвэл хийтэй хууль гай болохоо болино. Тэднийг, төрийг танай компанийн хувьцаа эзэмшигчид, манай иргэд л номонд нь оруулна, сургаад өгнө.

Нийтийн гэдгийг төрийн гэж орчуулдаг гаж ойлголт бас багагүй гай тарьж байна. “Public” гэдэг англи үгийг төрийн гэж биш “нийтийн” гэж орчуулж ойлгож хэвшье. Бүр утгачилбал олон нийтийн, иргэдийн, хүмүүсийн, олон хүний гэсэн ойлголт зөв

болно. “Public компани” гэдэг бол “олон хүний”, “нийтийн компани” гэсэн үг.

Манай улсад нийгмийн даатгалын шимтгэл төлөгч бүр хувьцаа эзэмшигч, баялаг бүтээгч байх боломжтой. Ажил хийж байгаа хүн бүр, тэтгэврээ авч байгаа ахмад нэг бүрийн тэтгэврээр улсынхаа баялгаар баталгаажна гэсэн үг. Баялаг бүтээлцэх хүчин зүйл болж хувирна гэсэн үг. Өнөөдрийн нялх хүүхдүүд ч удахгүй өсч том болно. Ажил алба хийнэ. Ирээдүйд ахмадууд болно. Ингэж л тэтгэврийн сан баялгийн сан болдог. Тухайн улсын иргэдийн хүүхэд хөгшин ялгаагүй, бүгдийнх нь хадгаламж, хуримтлал өсдөг. Муу төр иргэддээ өр үлдээдэг. Сайн төр иргэддээ хадгаламж үлдээдэг. Эрхэм гишүүд ээ, үүнийг хийхэд та нарын саналаа өгөхөд хэрэглэдэг долоовор хурууны хөдөлгөөн л хэрэгтэй.

Иргэд маань баялаг бүтээхэд дээрхийн адил оролцоод эхэлбэл иргэдийн хяналт бодитой болно. Нийгэм бүхэлдээ хариуцлагатай болно. Ямар баялаг бүтээгчийг дэмжих, эс дэмжихээ иргэд шийднэ. Бодлогыг хүмүүс гаргадаг болно. Харин түүнийг төр нь хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. Монгол Улсад олон нийтээсээ иргэдээсээ тасарсан баяны, эх орончийн, эрхтэн дархтаны зовлон арилна. Монголын нэрийг дуртай нь хугалахаа болино. Миний нэр хугарвал хугараг. Монголын нэр бүү хугараг. Энэ үгийн үнэ цэн Монгол хүн бүрийн ясанд шингэнэ. Бид чинь нэр хугарснаас яс хугар гэж ярьдаг ардын хүүхдүүд шүү дээ. Улсынхаа нэрийг сайнаар гаргаж чадахгүй юм бол улс төрд, бодлого тодорхойлоход оролцох гэх хэрэггүй. Өөрийн нэрээ сайнаар гаргах өөр салбар, ажил манай эрх чөлөөт оронд бишгүй л байна.

5. Байгаль орчиндоо хүйтэн цэвдэг хандсаар байгаа нь бид бүхний уучилж боломгүй алдаа шүү гэдгийг би иргэддээ хэлэх гэж бодсон юм. Эрүүл залуу хүн шиг, ургаа залуу модыг олон зуугаар нь хөрөөдөж унагадаг, шатааж явдгийг юу гэж ойлгох вэ? Булаг шандны эхийг хамгаалах биш ухаж төнхөж, бохирдуулж байгааг яавч зөвтгөж болохгүй.

Биднийг хүрээлэн буй орчин хүнгүй бол байгаад л байна. Байгаад ч ирсэн түүх бий. Харин хүн бид хүрээлэн байгаа орчноосоо ангид амьдарч чадах уу? Амьсгалах агаар, уух ус, гишгэх газаргүй. Би хувьдаа Улаанбаатарын утааг зун ч мартаж болохгүй гэж боддог. Говь талын усны асуудал манай хөгжлийн хамгийн хурц, хамгийн эдрээтэй асуудлын нэг болж босож ирж байна. Нийслэлийг хаяалсан Туул гол хэд хэд тасарлаа. Манай ихэнх иргэдийн хэрэглэдэг усны ундарга бохирдолтой нянтай болж байна.

Улсынхаа хөгжлийг хүнтэйгээ холбож ярь гэж би хэлсэн. Нийслэл хотын орчны бохирдлын тухай ярихад л улсын хөгжлийн бүх асуудал хөндөгдөж байсан. Энэ асуудалд хамааралгүй ажилтай сайд дарга, салбар гэж байхгүй. Би энэ тухай сануулж хэлж Засгийн газрын хуралд оролцохдоо зөвхөн машины зөв, буруу хүрд, сэтгэгдлийн бичилт ярих гээгүй. Би улсын зовлонг хэлэх гэж л оролдсон юм.

Иргэдээс үнэн үг гарч байгаа юм. Мөн иргэдийн оролцоотой шийдэл бүр зөв болж байгаа юм. Сумын байгаль орчны байцаагчийг сумаасаа л томилдог байг. Сум, аймгийн төрийн байгууллагууд боловсон хүчний сонголтоо орон нутгаасаа, иргэдийнхээ оршин байгаа газраасаа л хийг. Харин тэднийг сонгох, ажиллуулах шалгуурыг мэргэжлийн байгууллага, орон нутаг хамтраад тогтоо. Хариуцлагыг газар дээр нь тооц. Тэр амьдрал дотор байгаа хүмүүс л ажлаа, нутаг орныхоо онцлогийг сайн мэднэ. Байгаль орчны асуудал алга эргүүлэхэд иргэдийн шууд оролцооны асуудал болох нь энэ.

Монголчууд хүүхдээ өмөөрөхөөс өмнө нутгаа эхэлж өмөөрдөг ард түмэн. Энэ бол амьдрах, ажиллах орчныхоо үнэ цэнийг их эртнээс мэдэрсэн гэсэн үг. Хүн л амьдрах орчноо боддог. Хүндээ эрх өг гэдгийн цаана маш чухал санаа энд нуугдаж байгаа. Байгалиа, орчноо хамгаалах өөд татах бодлого үйл ажиллагаанд иргэд оролцвол бас л зөв болно. Энэ бодлогыг даргын мэдлээс иргэний мэдэлд шилжүүлбэ гэдэг бол энэ

салбарын ажлыг цоо шинэ, бүтээлч шатанд гаргана гэсэн үг.

Монгол бол ус мод цөөтэй улс биш. Газар нутаг багатай ч улс биш. Магадгүй бодлогоо оновчтой тодорхойлж чадахгүй байгаа, чадаагүй улс юм. Устай мөртлөө усны гачигдалтай, нүүрс ихтэй атлаа цахилгааны хомсдолтой, баян орон гэхэд ядуугийн зовлонтой. Бид энэ тухай зөндөө ярьсан. Явж явж хүрээлэн буй орчинтойгоо зохицож, тэр орчноо өөд татаж амьдрахыг л зөв бодлого гэж хэлээд байгаа юм. Бид бодлого ярихдаа байгаль орчин, иргэд олон нийт, эдийн засаг санхүү, төр улс төрийн тогтолцоо, соёл уламжлал, гадаад аюулгүй байдал гэсэн манай нийгмийн зургаан гол бүрэлдэхүүн хэсгийг заавал бодолцох ёстой болж байна. Магадгүй эдгээрийн анхдагч нь бидний хүрээлэн буй орчноос эхлэх байх. Тиймээс би улсын нийслэл тойрсон асуудлыг хөдөөгийн хөгжлийн ч, дэд бүтцийн ч, эрүүл мэндийн ч, хог хаягдлын ч, аюулгүй байдлын ч, хот төлөвлөлтийн ч асуудал болчихлоо гэж хэлээд байгаа юм.

Манай ард түмэн ямар ирээдүйг хүсч байна вэ? Бид бүгдээрээ амгалан тайван, тэгш дүүрэн амьдралыг л хүсч байна. Энэ мөрөөдөлд хүрэх зам ногоон өнгөтэй, байгальд ээлтэй байхыг шаардаж байна. Энэ зам өмнөхөөсөө суралцсан, өнөө болон хойч үеийн сайн сайханд зориулагдсан зам байх ёстой. Монгол ахуй бол хүрээлэн буй орчиндоо зохицсон иргэншил юм. Сайн, үнэтэй юм хуучин авдраас олдох нь бий. Монголчууд өөрийн явж ирсэн замтай бас сонголттой. Бид энэ зам сонголтлоосоо хазайж болохгүй.

Монгол Улс байгальд ээлтэй хөгжилд, технологид, санаачилгад хөрөнгө зарах хэрэгтэй. Монгол руу хур бороо татаж байгаа, хиймэл нуур, гол үүсгэж байгаа, мод, хүнсний бүтээгдэхүүн тарьж байгаа санал санаачилга бүрийг дэмжих хэрэгтэй.

Монголд юу л байна сэргээгдэх болон газрын гүний эрчим хүчний эх үүсвэр байна. Монгол орон улсаа төдийгүй Азийн бүс нутгийг цэвэр, сэргээгдэх эрчим хүчээр хангах нөөцтэй орон. Монголд зоргоороо тусах нар, хөх салхинаас их юм алга. Удахгүй ашиглалтад орох Салхитын цахилгаан станц бол сайн эхлэл. Манай айл өрхүүд ялангуяа малчин өрхийн хувьд сэргээгдэх эрчим хүчний ашиглалт, түүний үр шимийн тухай сайн мэднэ.

Орчлон ертөнцийн ааш аяг, цаг уур өөрчлөгдөж байгаа өнөө цагт Монгол Улс олон улсын хамтын нийгэмлэгийн амин чухал санаачилгаас хоцорч болохгүй. Энэ бол байгаль орчинтой холбоотой санаачлагууд. Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлттэй, цөлжилттэй, дэлхий дахинд тулгамдаж байгаа ус болон хүнсний асуудлаарх санал санаачилга, оролцоо хувь нэмрийг олон орон, тэдгээрийн удирдагчид, олон улсын байгууллагууд үнэлдэг юм. Монгол орон энэ салбарт бусдыг оройлон манлайлагчдын тоонд зүй ёсоор орох боломжтой.

Эрхэм хүндэт иргэдээ, гишүүдээ,

Би та бүхэнд бидний зарим амжилт ололт, мөн алдаа дутагдал, сургамж түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар би товчхон ярилаа. Монголчууд бидний сайн сайхан, олон амжилт бол нийтлэг шинж чанартай. Ер нь аливаа амжилт ололт нь сая сая хүний бүтээл байдаг. Харин алдаа дутагдал нь цөөн хүн, тодорхой албан тушаалтнаас үүддэг атал түүний уршгаар олон хүн хохирдог. Олуулаа, нийгмээрээ эргэж ямар нэг байдлаар төлбөрийг нь төлдөг. “Муугийн уршиг олонхид” гэж их үнэн үг.

Асуудлыг шийдэгдсэн гэж бодох хэрэггүй. Шийдвэр бол цаг хугацааны л асуудал. Аливаа юмны шийдэл цаашид улам л төвөгтэй болно. Олны эрх ашгийн төлөө яваа хүн ямар нэг асуудлыг сайн шийдэхийг эрмэлздэг. Тийм төгс шийдэл байхгүй. Сайн санаж эхлүүлсэн ажил тааруу төгсгөлтэй байх нь олон. Монголд асуудалгүй салбар гэж өнөөдөр байхгүй. Хүндрэлгүй шийдэл гэж бас байхгүй. Дээр нь Монголын онцлог гэж бас бий. Аль нэг шийдлийн ард ахиад олон асуудлын үр соёолж байдгийг бүү март. Тэр бий болж байгаа



олон асуудлын, үйлийн үрийг яаж засахаас олон юмны хувь заяа шалтгаалдаг.

Би өнөөдөр иргэний оролцооны тухай ярилаа. Энэ нь иргэн хүнд жаргал амлаж байгаа зүйл биш. Зүгээр л хүний хувьд эрхээ эдлэх боломжийг л олгох асуудал. Амьдрал ахуй, хувь заяаг нь гарт нь атгуулах гэж байгаа юм. Ардчилал ч бай, эрх чөлөө ч бай аль аль нь хүнийг жаргаах зорилго тавиагүй. Харин ардчилал, эрх чөлөөний орчинд л эрх бүхэн шударга хуваарилагддаг. Хүний эрхийг дагаж хариуцлага нь очдог. Хариуцлага нь эргээд нийгмийн ёс зүйг бүрдүүлдэг. Нийгмийн дархлаа ёс зүйдээ байдаг. Эрх чөлөөнд л хүн өөрөөрөө байх боломжтой. Ийм учраас хүний эрх, бүтээлч боломжид суурилсан нийгэм л удаан оршин тогтнох нигууртай. Яагаад гэвэл тэр нийгмийг бүтээгч нь хүн өөрөө. Иргэн нь эрхтэй нийгэмд л халамжийн, үзүүлэнгийн төр халаагаа өгдөг. Хүн бүр эрх үүрэгтэй, ажлаа дор бүрнээ хариуцлагатай сайн хийвэл Монгол Улс хөгжинө.

Иргэний оролцоогүй баялаг, түүний хуваарилалт хулгай болж хувираад байгааг бид харж байна. Эцэг эхээсээ мөнгө аваад талханд явсан хүүхэд хариулт мөнгөө аваад ирдэг. Талх авахад ээж хүү хоёр оролцсон бол тэр эргээд хариуцлагатай шийдэл болж байгаа юм. Ингэж хүний оролцоо шийдлээр дамжиж хариуцлага, хяналт, шударга ёс гэдэг хамтын баялаг бий болдог.

Амьдрал мөнгө дагаад явааг ажиглаж байгаа байх. Ямар учраас баг, хорооны хурал сонирхолтой болоод эхлэв. Тэнд одоо бодитой мөнгө, хөрөнгийн хуваарилалт яригдаж байна. Тэнд тэр мөнгөөр юу хийх тухай хүмүүс ярилцаж байна. Тэд юуны өмнө тэндээ тулгамдсан асуудлаа шийдэж эхэлж байна. Тэд мөнгөний хойноос, шийдвэрийн хойноос Төрийн ордон руу зүглэхээ, дээрээс юм шаардахаа больж байна. Тэд одоо “дарга аа, надад олон юм хэрэггүй. Надад эрхээ эдлэх боломж олгочих” гэж хэлэхээ сайн ухаарч байна. Төр хэчнээн сайн байгаад хүний өмнөөс хүндэрдэггүй гэдгийг иргэд мэдэж эхэлж байна. Зүгээр л хүн эрхээ эдэлсэн шиг эдлэх нь чухал байна. Эрхийн араас үүрэг, хариуцлага, ёс зүй гээд олон юм дагалдана. Үүнийг бид иргэддээ айлгаж биш ойлгуулж хэлэх хэрэгтэй. Иргэд эрхээ эдлээд эхэлбэл түүнийгээ тэд алдахгүйгээ мэднэ.

Асуудал бол улс орны хувьд ч адилхан. Монголын өмнөөс манай асуудлыг хэн ч шийдэхгүй. Бидний өмнөөс бидний зовлон бэрхшээлийг хэн ч нимгэлэхгүй. Иймээс асуудал шийдэхэд манай орны гурван хүн тутмын нэг нь оролцдог байг. Хөгшин, хүүхэд, боломж нь болохгүй байгаа иргэдээ тооцоод 3 хүн бүрийн нэг нь нөгөө хоёрыгоо аваад явдаг чадалтай улс болцгооё. Шаардлага гарвал гурван монголын нэг нь нөгөө хоёроо хамгаалъя. Би иргэний оролцоотой шийдлийн цаана ийм чадавхитай улс орныг харж байгаа юм.

Удахгүй бид гурван саяуулаа болно. Амьдралаа аваад явж байгаа олон мянган айл өрх бол манай улсын хөгжил, дэвшлийн суурь үндэс юм. Монгол Улсад татвар төлж байгаа бүхэн эх орончид юм. Манай бизнес эрхлэгчид, малчид, чөлөөт үйлдвэрлэгчид бүр Монголын сайн сайхныг бүтээн босгогчид юм. Өөрөөсөө илүү гаргаж бусдад тусалж яваа бүхэн ачтан буянтнууд юм. Манай оронд ийм олон сайн үйлстнүүд байна. Хүний түүх энэ олон сайн үйлстэн, баялаг бүтээгчдийн гараар дандаа урагш ахиж байдаг. Иймээс би улс орныхоо ирээдүйд, сайн сайханд гүн итгэлтэй байна.

Би өнөөдөр улс төрийн албан тушаалтнууд, зарим төрийн албан хаагчдад жаахан хатуу үг хэллээ. Би сайныг бодож зарим мууг санууллаа. Монголын төр бол түүхтэй төр. Нэртэй төр. Ийм төрд алба хашна гэдэг бол их хувь заяа. Монголын төр бол эрхэмсэг төр. Хууль хэрэгжүүлэх чадвараараа, түмний төлөө зүтгэлээрээ Монгол төрийн албан хаагч онцгойрч байх ёстой. Тэд ёс зүйгээрээ, ажил үйлсээрээ, сайнаараа бусдад жишиг болох ёстой. Тэд төрийн дэглэм журам, хүний ёсыг гүнзгий ойлгодог хүмүүс байх ёстой. Манай төрийн албан хаагчид сайн соёл түгээгчид, тээгчид байх учиртай. Ингэж чадвал Монголын төр хүчтэй байна. Монгол Улс хүчтэй байна.

Монголчуудыг сайн соёлын эзэд гэдгийг дэлхийд бүр олон хүн мэддэг боллоо. Монгол хүний шударга нээлттэй, эрхийн мэдрэмжтэй, бие даах чадвартай, шинэ зүйлд хурдан суралцдаг чанарыг үнэлж байна. Олон сар хүний нутагт бусдын зовлонг хуваалцаж явсан манай энхийг сахиулагчид бол энэ цагийн баатрууд юм. “Монгол оронд төрсөндөө би үнэхээр бахархаж байна. Миний эх орон чинь ямар сайхан юм бэ” гэж тэд хэлж байна. Хол явж зовлон үзсэн хүмүүс хэтрүүлэгтэй үг хэлэхгүй. Би ч бас ийм сайхан эх орноороо бахархаж байна. Би ийм орны эзэд болсон ард түмнээрээ бахархаж байна. Цөмөөрөө энэ бахархлыг улам дэлгэрүүлэн бүтээцгээе.

Эрх чөлөө, Эх орон минь бүтэн байг ээ.  
Миний Монгол мөнх оршиг ээ.

\* \* \*

### Чуулганыг хааж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг

(2013.07.10)

Монгол Улсын Ерөнхийлөгч өө,  
Монгол Улсын Ерөнхий сайд аа,  
Эрхэм гишүүд ээ,

Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгъя.

Улсын Их Хурлын 2013 оны хаврын чуулганы нэгдсэн хуралдааныг 26 удаа, байнгын болон дэд хорооны хуралдааныг давхардсан тоогоор 86 удаа хийсэн ба бие даасан хууль 13, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль 45, олон улсын гэрээ, конвенци, зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хууль 4, хууль, хуулийн хэсэг, зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хууль 5, Улсын Их Хурлын тогтоол 26-г тус тус хэлэлцэж баталлаа.

Монгол Улсын 2014 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2015-2016 оны төсвийн төсөөлөл, 2012 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэж баталлаа.

Хаврын чуулган Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд газрын тос боловсруулах үйлдвэр барих, шатдаг занараас шатахуун гаргах төслүүдийг эхлүүлэх, дэд бүтцийн бусад томоохон бүтээн байгуулалтыг төсвийн болон төсвийн бус эх үүсвэрээр, төр-хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тусгалаа. Эдгээр бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх нөхцлийг ханган ажлаа шуурхай зохион байгуулахад Засгийн газар болон холбогдох бусад байгууллагууд анхаарч, үйл ажиллагаагаа эртнээс төлөвлөж, тооцож ажиллах хэрэгтэй.

Стратегийн ач холбогдол бүхий салбарт хөрөнгө оруулж буй гадаадын хөрөнгө оруулагч этгээдэд зөвшөөрөл олгоход саад болж байсан 100 тэрбум төгрөгийн босгыг арилгаж, зөвхөн төрийн өмчит компанитай холбоотой хэлцлийг Улсын Их Хурал шийдвэрлэж байхаар хуулийн холбогдох заалтыг өөрчлөн найруулсанаар зөвшөөрөл олгох үйл явц түргэн шуурхай шийдэгдэх эрх зүйн боломж бүрдлээ.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар монголчууд уул уурхайн томоохон төслүүдийг хэрэгжүүлж байгаа гадаад, дотоодын хөрөнгө оруулагч компаниудын өндөр өгөөжтэй хувьцааг өөрийн орны хөрөнгийн биржээс шууд худалдан авах боломж бүрдлээ. Дотоодын компаниуд гадаадын хөрөнгийн бирж дээр давхар бүртгэл хийлгэснээр гаднын хөрөнгийн биржийн шаарддаг олон төвөгтэй үйл ажиллагааг дамжихгүйгээр үнэт цаасаа шууд Лондон, Хонконг, Нью-Йоркийн хөрөнгийн биржид арилжаалах эрх зүйн орчинг бий болсон.

Террорист үйл ажиллагааг санхүүжүүлэх, мөнгийг угаах үйлдлээс дотоодын санхүүгийн салбараа хамгаалж, урьчилан сэргийлэх зорилгоор Мөнгө угаах болон терроризмтой тэмцэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт орууллаа. Сэжигтэй гүйлгээнд тавих хяналтын тогтолцоог сайжруулсанаар Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцид дотоодын хууль тогтоомжоо нийцүүлээ.

Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн татварын бодлогыг хөдөө аж ахуй, нийтийн тээвэр, барилгын салбарт хэрэгжүүлэх зорилгоор үржлийн мал амьтны үр хөврөл, үр, том оврын автобус, троллейбус, мод, модон материалыг импортын болон гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас тус тус чөлөөллөө. Эдгээр бараа, бүтээгдэхүүний импортын хэмжээ нэмэгдэж, энэ чиглэлийн үйлдвэрлэл, үйлчилгээний ажиллагаа дэмжигдэн ажлын байр шинээр бий болох нийгэм, эдийн засгийн эерэг үр дагаврыг авчирна гэдэгт итгэж байна.

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр”-ийн 4,5 дугаар төслийн санхүүжилтын зээлийн хэлэлцээрийг соёрхон баталж, Сонгинохайрхан дүүрэгт загвар болохуйц 300 ортой дүүргийн нэгдсэн эмнэлэг байгуулах, Цус сэлбэлт судлалын үндэсний төвийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, эмнэлгийн хог хаягдлыг боловсруулах төвийн барилга байгууламжийг шинэчилэхээр боллоо.

Эрхэм гишүүдээ,

Хаврын чуулганы сүүлийн өдрүүдэд Улсын Их Хурал Цагдаагийн болон Тахарын албаны тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай болон Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль зэрэг хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд өөрчлөлт шинэчлэлт хийсэн багц хуулиудыг баталлаа.

Цагдаагийн байгууллага олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйлчилгээг иргэддээ үзүүлэх шинэ үүргийг гүйцэтгэхээр болж байна. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэдийн туслалцаа, хамтын ажиллагаанд түшиглэн зохион байгуулж ажиллана. Гэмт хэргийг хянан шийдвэрлэх явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хуулиар хамгаалах цоо шинэ зохицуулалтыг бий болголоо.

Цагдаагийн байгууллагын статистик мэдээгээр 16.000-17.000 орчим эрүүгийн хэрэгт шалгагдаж байгаа холбогдогч төлбөрийн чадваргүйн улмаас өөрийгээ хамгаалуулах эрх зүйн тусламжийг авч чаддаггүй байна. Энэ хууль батлагдсанаар эдгээр иргэдийн Үндсэн хуулиар баталгаажсан хууль зүйн туслалцаа авах эрх хангагдана.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдал, яллагдагч, ялтныг хамгаалах үүргийг хууль сахиулах бусад байгууллагын үүргээс салгаж, бие даасан хэлбэрээр зохион байгуулах болж байгаа бөгөөд энэ үүргийг Тахарын алба хариуцаж байхаар хуульчлан баталлаа. Хуулийн засаглалыг бэхжүүлэх, батлагдсан хуулиудыг хэрэгжүүлэх чиглэлээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан олон санал, санаачилгыг бодит ажил болгож, шийдвэрлэхэд Улсын Их хурал, Засгийн газар бүх талаар хамтран ажиллаж чадна гэдэгт итгэлтэй байна.

Наадмын дараа намар гэдэг. Өвлийн бэлтгэлээ хангаж, хадлан тэжээл бэлтгэх, нөөцлөх ажлаа шуурхай зохион байгуулахыг холбогдох байгууллагууд болон нийт иргэддээ анхааруулъя.

Ард иргэд ээ,

Та бүхэнд тулгар төр байгуулагдсаны 2222 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 807 жилийн ой, Ардын хувьсгалын 92 жил, Ардчилсан хувьсгалын 23 жилийн ойн баярын мэндийг дэвшүүлж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Сайхан наадаарай.

Монгол Улсын Их Хурлын 2013 оны хаврын чуулганы ажиллагаа өндөрлөснийг мэдэгдье.

## УЛСЫН ИХ ХУРЛЫН 2013 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН

(2013.09.16 - 2013.09.27)

### Ээлжит бус чуулганыг нээж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг

(2013.09.16)

Монгол Улсын Ерөнхий сайд аа,  
Эрхэм гишүүд ээ,

Эдийн засагт учирч байгаа хүндрэл, бэрхшээлийг даван туулах, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Засгийн газраас өргөн барьсан хуулиудыг яаралтай хэлэлцэх шаардлагыг үндэслэн Улсын Их Хурлын ээлжит бус чуулганыг энэ сарын 16 - 27-ны өдрүүдэд хуралдуулахаар захирамж гаргасан билээ.

2012 оны 3 дугаар улирлаас эхлэн хөрөнгө оруулалтын хэмжээ багасч улмаар 2013 оны эхний хагас жил гэхэд өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 42 хувиар буураад байна.

Гадаадын хөрөнгө оруулалт буурахад дэлхийн эдийн засгийн байдал, зарим хууль, эрх зүйн зохицуулалт, Оюутолгой төслийн хөрөнгө оруулалтын эхний үе шат дуусгавар болж, хоёр дахь үе шатны хөрөнгө оруулалт зогссон зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байна. Ялангуяа өмнөх Улсын Их Хурал тооцоо судалгаа муутай хууль баталсанаас улс орны эдийн засагт хүндрэл бэрхшээл учирч байна.Тухайлбал:

Нэгдүгээрт, Өнгөрсөн оны 5 дугаар сард сонгуулийн өмнө Стратегийн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийг баталснаар гадаадын хөрөнгө оруулалт дайжих шалтаг болжээ. Хуулиа гадаадын хөрөнгө оруулагчдад сурталчлаагүй, дагаж гаргах журмыг оройтуулж гаргасан зэрэг нь тодорхойгүй байдал үүсгэжээ. Засгийн газрын өргөн барьсан энэ ээлжит бус чуулганаар батлагдах “Хөрөнгө оруулалтын тухай” хуулийг баталснаар уг хууль хүчингүй болно.

Хоёрдугаарт, Улсын Их Хурал 2009 оны 07 дугаар сард Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль” болон “уг хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг баталсан. Хуулийн үзэл санаа зөв ч гэсэн хууль гарах үед олборлолтоо явуулж байсан “А” лицензтэй компаниудын шилжилтийн зохицуулалтыг тодорхойгүй үлдээснээс эдгээр компаниудийн алт олборлолт нууц хэлбэрт шилжих, татвар төлөхгүй байх, алт нууцаар хил давах, байгаль орчин нөхөн сэргээх ажил нь эзэнгүй болох зэрэг сөрөг үр дагаварууд гарсаар байна. Зөвхөн тусгай зөвшөөрлүүдийн төлбөр, хайгуулын талбайд оруулсан хөрөнгө оруулалтын зардал Засгийн газрын тооцоолсоноор 659.5 тэрбум төгрөгт хүрсэн нь тусгай зөвшөөрлийг цуцлах тохиолдолд хамгийн багадаа ийм хэмжээний нөхөн олговор улсын төсөвт ачаалал болж ирэхээр байна. Энэ чуулганаар уг урт нэртэй хуульд биш хуулийг дагаж гарсан шилжилтийн хуульд өөрчлөлт орох юм.

Гуравдугаарт, Улсын Их Хурал 2010 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохыг хориглох тухай хуулийг баталж, хугацааг хэд хэдэн удаа сунгаж, улмаар 2012 оны 1 дүгээр сард Ашигт малтмалын тухай хуулийг шинээр баталснаар 3 жилийн турш ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгогдсонгүй. Шинээр батлах тухай ярьснаар хууль батлаагүй юм байна. Энэ лицензийн хориг нь хаа дуртай газраа ухаж төнхдөг замбараагүй лиценз олголтыг цэгцэлсэн боловч хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх сайн хуулиа гаргаж чадалгүй удсанаас тус салбарын хөрөнгө оруулалтыг үндсэнд нь зогсоосон байна.



Энэ бүхнийг харгалзан үзээд Засгийн газраас Хөрөнгө оруулалтын тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Алтны худалдаанд ил тод байдлыг бүрдүүлэх тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай зэрэг 5 хуулиудыг холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиудын хамт өргөн барьсан юм. Эдгээр хуулиудыг баталснаар:

- Монгол Улс хөрөнгө оруулалтын татварын эрх зүйн орчныг тогтвортой байлгах, Гадаад, дотоод гэж ялгахгүйгээр хөрөнгө оруулагчдын нийтлэг эрх зүйн баталгааг хангах, Түгээмэл тархацтай ашигт малтмалын харилцааг ашигт малтмалын хуулиас салгаж бие даасан хууль болгоод улмаар орон нутагт зөвшөөрөл олгох эрх, хяналт тавих үүргийг шилжүүлэх, Монгол Улсад ашигтай төслийн татварын орчинг тогтворжуулах замаар хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, Төрийн хүнд суртлыг бууруулж, бизнесийн орчныг сайжруулах,
- Аж ахуйн нэгж, бичил уурхайчдын олборлосон алтыг худалдан авах, экспортлох, алтны хөдөлгөөний бүртгэл, тооцоог эрхлэх асуудлыг Монголбанкны бүрэн эрхэд хамааруулах зэрэг олон асуудлыг шийдэх юм.
- Мөн Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар зохицуулагдаж байсан хөрөнгө оруулалтын сангийн харилцааг тусгай хуулиар зохицуулахаар хууль өргөн барьсан нь санхүүгийн зах зээлийн зөв, тэнцвэртэй бүтэц бий болж, жижиг дунд үйлдвэр, компаниуд ганц банкны зээл бус хөрөнгө оруулалт хэлбэрээр санхүүжилт босгож үйл ажиллагаагаа тэлэх боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой гэж үзэж байна.

Эрхэм гишүүд ээ,

Ээлжит бус чуулганы хугацаанд Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг, байнгын хороод эдгээр хуулиудыг нухацтай хэлэлцэж, алдаа оноог шүүн тунгааж, улс орны эдийн засгийн өсөлтийг тогтворжуулах, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын үйл ажиллагааг дэмжихэд чиглэгдсэн агуулгаар баяжуулж, чанартай хууль гаргахын төлөө хамтран ажиллахыг та бүхэнд уриалж байна.

Ингээд Улсын Их Хурлын 2013 оны 9 дүгээр сарын 16 -ны өдрийн ээлжит бус чуулганы ажиллагааг нээснийг мэдэгдье.

\*\*\*

### **Ээлжит бус чуулганыг хааж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг**

(2013.09.27)

Эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын даргын 2013 оны 09 сарын 10-ны өдрийн 156 тоот захирамжийн дагуу Улсын Их Хурлын ээлжит бус чуулган энэ сарын 16-27-ны өдрүүдэд хуралдаж өнөөдрөөр өндөрлөж байна. Энэхүү чуулганаар Засгийн газраас өргөн барьсан Хөрөнгө оруулалтын тухай түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай Гол мөрний урсац бүрэлдэх эх усны сан бүхий газрын хамгаалалтын бүс ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Алтны худалдаанд ил тод байдлыг бүрдүүлэх тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиудыг холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиудын хамт хэлэлцлээ.

Бид Хөрөнгө оруулалт, эрдэс баялгийн салбарт үүссэн нөхцөл байдлыг эрх зүйн хувьд засч

залруулах зорилгоор дээрх хуулиудыг ээлжит бус чуулганаар хэлэлцүүлэхээр оруулсан ч тодорхой шалтгааны улмаас энэ 2 долоо хоногийн хугацаандаа баталж амжсангүй.

Нэгдүгээрт, Хөрөнгө оруулалтын тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиуд дээр Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан 170 гаруй ажил хэрэгч санал дүгнэлтийг тусгаад эцсийн хэлэлцүүлэгт шилжүүлсэн ч нэмэлтээр орсон саналуудыг нэгтгэж, нэр томъёоны хувьд цэгцлэх болон бусад техник шалтгаанаар өнөөдөр батлах боломжгүй болсон учраас дараагийн 7 хоногийн ээлжит чуулган уруу шилжиж байна.

Хоёрдугаарт, Ардчилсан намын болон МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслийн бүлэг Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуультай холбогдсон нэмэлт мэдээлэл цуглуулах газар дээр нь очиж үзэх сайтар судлах санал албан ёсоор гаргасан учраас мөн намрын ээлжит чуулган уруу шилжиж байна.

Гуравдугаарт, Алтны худалдаанд ил тод байдлыг бүрдүүлэх тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийг Эрдэс баялгийн салбарт төрөөс баримтлах бодлогыг хэлэлцэж уялдуулсны дараа хэлэлцэх нь зүйтэй гэж МАН-ын бүлэг үзсэн учраас мөн ирэх чуулган уруу шилжиж байна.

Энэ удаагийн ээлжит бус чуулганы хугацаанд Улсын Их Хурлын гишүүд улс орны эдийн засгийн нөхцөл байдлын талаар холбогдох яамдын мэдээлэл, Улсын Их Хурлаас томилсон ажлын хэсгийн дүгнэлтийг Байнгын хороон дээр сонсож, экспортын орлого, гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ буурсан шалтгааныг хэлэлцэн, цаашид авах шаардлагатай арга хэмжээний талаар нэгдсэн ойлголттой болж чадлаа.

Ажлын хэсэгт орж ажилласан болон олон зуун санал гаргаж Засгийн газрын өргөн барьсан хуулиудыг сайжруулсан гишүүддээ баярласнаа илэрхийлье.

Эдийн засгийн өсөлт өнгөрсөн жилүүдтэй харьцуулахад буурсан ч энэ жил 11 гаран хувьтай байхаар байна. Ийм нөхцөлд эдийн засгийг хямарсан гэж үзэх нь өрөөсгөл бөгөөд харин үүссэн зарим хүндрэл бэрхшээлийг арилгахад дээрх хуулиуд тодорхой үүрэг гүйцэтгэнэ гэж үзээд намрын чуулганы эхний хуралдаануудаар улсын төсвийн өмнө баталж гаргахаар шилжүүлж байна. Иймээс холбогдох Байнгын хороо, ажлын хэсэг бэлтгэл ажлыг шуурхай хангаж дээрх хуулиудаа яаралтай батлуулах хэрэгтэй байна.

Ээлжит бус чуулганы үйл ажиллагаанд идэвхтэй оролцож хэлэлцүүлгийн явцад идэвхтэй, санаачилгатай ажилласан нийт гишүүддээ баярлалаа. Улсын Их Хурлын 2013 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр эхэлсэн ээлжит бус чуулганы ажиллагааг хаасныг мэдэгдье.

\* \* \*



**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2013 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН**

(2013.10.01 - 2014.01.30)

**Чуулганыг нээж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг**

(2013.10.01)

Монгол Улсын Ерөнхий сайд аа,  
Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,  
Хүндэт зочид оо,  
Хатагтай, ноёд оо,

Хаврын чуулганы завсарлагааны хугацаанд Улсын Их Хурлын гишүүд хөдөө орон нутагт ажиллан Улсын Их Хурлын чуулганаар батлагдсан хууль тогтоолыг сурталчилж, хэрэгжилтийн байдалтай танилцан, цаашид хэлэлцэх хуулийн төслүүдийн талаар ард иргэдийн санал бодлыг сонсож, өвөлжилтийн бэлтгэл, намрын ургац хураалтын явцтай биечлэн танилцсан байна.

Баянзүрх, Хан-Уул дүүрэг дэх гэр хорооллын дахин төлөвлөлт, орон сууцны зарим хорооллын барилгажуулалтын ажлын явцтай танилцахад барилгын компаниуд болон барилгын материал үйлдвэрлэгчдэд төрөөс үзүүлсэн дэмжлэг тодорхой хэмжээнд үр дүнд хүрч байгаа нь харагдаж байна.

Өнгөрсөн сард Өмнөговь аймгийн “Эрдэнэс-Тавантолгой”, “Энержи ресурс”, Нарийн сухайтын нүүрсний уурхай болон Шивээ хүрэнгийн боомтын үйл ажиллагаатай танилцлаа. Үндэсний уул уурхайн компаниуд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийж цахилгаан станц, авто зам, нүүрс угаах үйлдвэр, сургуулийн барилгыг ашиглалтад оруулснаар хөдөө орон нутагт уурхай дагасан хөгжил бий болж байна. Гэхдээ нүүрс тээвэрлэлтийн хүндрэл, давхацсан татвар хураамжууд нь нүүрсний үнэ унасан өнөөгийн нөхцөлд Монголын нүүрсийг өрсөлдөх чадваргүй болгосноор экспортоо хязгаарлаж байгаа тухай ярьж байна. Улсын Их Хурал эрдэс баялгийн бодлогоо боловсруулахдаа энэ бүхнийг тооцож шийдвэрээ гаргах нь зүйтэй.

Улсын Их Хурлын чуулганы завсарлагааны хугацаанд манай улсад албан ёсны айлчлал хийсэн Бүгд Найрамдах Белорусс Улсын Ерөнхий сайд М.В Мясникович, Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Ассамблейн дарга эрхэмсэг ноён Кан Чан Хи болон Япон, Франц, Тайланд Улсын төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа. Уулзалтын явцад Монгол Улсын уул уурхай, дэд бүтэц зэрэг бүтээн байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрт хөрөнгө оруулалт хийх, техник технологи, хүний нөөц, менежментийн чиглэлээр харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, иргэдийн зорчих нөхцөлийг хөнгөвчлөх зэрэг асуудлаар санал солилцлоо.

9 дүгээр сард Азийн бүс нутгийг төлөөлж Монгол Улсад анх удаа дэлхийн 15 орны төлөөлөгчид оролцсон «Төрийн албаны мерит тогтолцоо, туршлага сургамж, сорилт боломж» сэдэвт олон улсын Төрийн албаны төв байгууллагын удирдлагын бага хурал болж өнгөрлөө. Энэ бага хурлын үеэр олон орны төрийн албаны төв байгууллагын удирдлага, зохион байгуулалттай танилцаж, туршлага солилцсон нь манай улсын төрийн албаны шинэтгэлийн стратегийг тодорхойлоход чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон гэж үзэж

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Намрын чуулганаар 2014 оны Монгол Улсын төсөв, хүний хөгжил сангийн болон нийгмийн даатгалын сангийн төсөв, төрөөс мөнгөний талаар баримтлах үндсэн чиглэлийг хэлэлцэж батална. 2013 оны төсвийн орлогыг хэт өндөр, өөдрөгөөр тавьж баталснаас орлого, зарлагын

тэнцвэр алдагдаж чуулганаар 2013 оны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага гарч байна.Тиймээс Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг мөрдлөг болгож 2014 оны төсвийг улс орны нийгэм, эдийн засгийн хүрээнд үүссэн нөхцөл байдалтай нягт уялдуулан нухацтай хэлэлцэж батлах нь Та бидний эрхэм зорилт болж байна.

Энэ удаагийн чуулганаар Шүүх байгуулах тухай, Хилийн боомтын тухай, Төрийн аудитын тухай, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай, Газрын тосны тухай, Газрын тухай багц хуулиудын шинэчилсэн найруулга, Ногоон хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөтөлбөр батлах тухай, Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого батлах тухай тогтоолын төслүүд болон хаврын чуулганаар хэлэлцэж эхэлсэн бусад хууль тогтоомжийг үргэлжлүүлэн хэлэлцэж батлах болно

Хэдхэн хоногийн өмнө Улсын Их Хурлын ээлжит бус чуулганаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт шилжүүлсэн Хөрөнгө оруулалтын тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон бусад эрдэс баялаг, уул уурхайн холбогдолтой хуулийг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын хамт яаралтай баталж гаргах нь чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Эрхэм гишүүд ээ,

Намрын чуулганаар улсын төсөв, мөнгөний бодлогыг тусгай дэгийн дагуу тодорхой хугацаанд хэлэлцдэг хуультай. Тийм учраас цаг хугацааг бүрэн дүүрэн ашиглаж, нам, эвслийн бүлгүүд санал дүгнэлтээ гаргаж, Байнгын хороод хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тусгагдсан өөрт хамааралтай хуулиудыг төлөвлөгдсөн хугацаанд нь хэлэлцэж нэгдсэн чуулганаар батлуулахын төлөө шамдан ажиллана гэдэгт итгэж байна.

Та бүхэнд ажлын амжилт хүсч, Улсын Их Хурлын 2013 оны намрын ээлжит чуулганы ажиллагааг нээснийг мэдэгдье.

\* \* \*

### Чуулганыг хааж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг

(2014.01.30)

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын 2013 оны намрын чуулган хэлэлцэхээр товлосон асуудлуудыг үндсэнд нь хэлэлцэж шийдвэрлэлээ.

Намрын чуулган ажлын 86 хоног үргэлжилж, нэгдсэн хуралдааныг 36 удаа, Байнгын болон дэд хорооны хуралдааныг давхардсан тоогоор 112 удаа хийсэн байна. Чуулганаар бүгд 143 хууль, тогтоол, Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл хэлэлцэж баталсаны 9 нь бие даасан хууль, 72 нь нэмэлт өөрчлөлт оруулах тухай, 5 нь хууль хүчингүй болгох тухай хууль, 47 нь Улсын Их Хурлын тогтоол байна. Энэ чуулганаар Монгол Улсын 2014 оны Төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай болон Нийгмийн даатгалын сангийн 2014 оны Төсвийн тухай хуулиудын төслийг хэлэлцэж баталлаа. Монгол Улсын 2014 оны Төсвийн тухай хуулиар Улсын нэгдсэн төсвийн хувьд нийт орлого 6,8 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 33.6 хувь, нийт зарлага 7,2 их наяд буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 35.6 хувь, нэгдсэн төсвийн алдагдал 409.9 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувьтай тэнцэж байна.

Улсын Их Хурал төсөв хэлэлцэх явцад “авилгажсан” гэх тодотгол бүхий 139,123,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 243 төсөл, арга хэмжээний 2014 онд санхүүжүүлэх 106,2500 сая төгрөгийн төсвийг царцааж шалтгааныг тогтоолгохоор Үндэсний аудитын байгууллагад шилжүүлэн шалгуулж байгаа. Аудитын дүгнэлтийг үндэслээд, эдгээр төсөл, арга хэмжээ



цаашид үргэлжлүүлэх эсэх асуудлыг Улсын Их Хурал цаашид шийдвэрлэх болно.

Энэ намрын чуулганаар “Хөрөнгө оруулалтын тухай” хуулийг баталж, “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай” хуулийг хүчингүй болгосонд хөрөнгө оруулагчид талархаж байна. Төсвийн тогтвортой байдлыг хангах, гадаад валютын урсгалыг сайжруулах, экспортыг нэмэгдүүлэх дотоодын үйлдвэрлэлийг дэмжихэд төсвийн болон төрөөс 2014 онд баримтлах мөнгөний бодлого чиглэгдэж байгаа. Үүсэж болзошгүй нөхцөл байдалд эдийн засгийг түргэн зохицуулах чиглэлээр бодлогын болон зохицуулалтын арга хэмжээг богино хугацаанд шуурхай хэрэгжүүлэх, ялангуяа хувийн сектор энэ нөхцөл байдалд дасан зохицох боломжийг бүрдүүлэхэд Монголбанк, Засгийн газар санаачилгатай ажиллах хэрэгтэй байна.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, Монголбанк, түүнээс эрх олгосон банкинд алтаа худалдсан тохиолдолд алтны нөөц ашигласны төлбөр 2.5 хувь, нэмэлт төлбөр 0 хувь байхаар, бусад этгээдэд худалдсан тохиолдолд холбогдох татварууд хэвээрээ үлдсэн болно. Энэ зохицуулалт нь гадаад валютын улсын нөөцийг бүрдүүлэх, төгрөгийн тогтвортой байдлыг хангахад үр дүнтэй зохицуулалт болно гэж үзэж байна. Мөн Улсын Их Хурал анх удаа Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг баталлаа. Түүнчлэн ДЦС-4 өргөтгөлийн тоног төхөөрөмжийг Гаалийн болон Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг баталснаар энэ намраас эхлэн цахилгаан эрчим хүчний дутагдлыг нөхөх ажил 120 мВт-аар ахиц дэвшил гарна гэж үзэж байна.

Намрын чуулган шүүх, цагдаагийн байгууллагад хийж байгаа шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд чиглэсэн хэд хэдэн хуулиудыг баталсны дээр Авилгын эсрэг болон холбогдох зарим хуулиудад өөрчлөлт оруулж прокурорын байгууллагын дэргэдэх Мөрдөн байцаах албыг Авилгатай тэмцэх газарт шилжүүлээ. Үнэт цаасны зах зээл дэх хууль бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, хяналт, хариуцлагыг чангатгах зорилгоор Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулиудад мөн зохих нэмэлт өөрчлөлтийг оруулсан болно.

Улсын Их Хурлын Тамгын газар хууль тогтоох үйл ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр иргэдэд нээлттэй, ил тод хүргэж байгаа нь гишүүн бүрийг сонгогчдынхоо өмнө хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих боломжийг бий болгож байгаа. Энэ чиглэлээр цаашид ч хийх зүйл багагүй байна. Нөгөө талаас Улсын Их Хурлын үйл ажиллагааг илүү үр дүнтэй, боловсронгуй болгоход Улсын Их Хурлын гишүүн нэг бүрийн хариуцлагатай, ажил хэрэгч хандлага чухал байна.

Хууль санаачлагчид Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ дагуу олон хууль боловсруулж өргөн барьж байна. Энэ нь сайшаалтай хэдий ч нийгмийн бодит хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлж, үндэслэл бүхий судалгаа, тооцоо сайтай хуулийг чанартай боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Энэ нь Улсын Их Хурлын үйл ажиллагааг үр дүнтэй, шуурхай, хууль тогтоох үйл ажиллагааг чанартай байлгахад чухал ач холбогдолтой болохыг онцлон тэмдэглээд Улсын Их Хурлын чуулганы болон байнгын хороодын хуралдаанд идэвхтэй оролцсон нийт гишүүддээ талархал илэрхийлж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Том төрөөс ухаалаг төр рүү” санаачилгын агуулгад хөгжлийн бодлоготой уялдсан олон асуудал багтаж байна. Улсын Их Хурлын гишүүдийн өргөн барьсан Хөгжлийн бодлого төлөвлөлтийг боловсронгуй болгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг холбогдох Байнгын хороод хэлэлцэж байгаа. Миний бие “Үндэсний хөгжлийн стратеги” сэдэвт симпозиумыг санаачлан Хэнтий, Дархан аймагт зохион байгуулсан. Иргэд энэ асуудалд анхаарлаа хандуулж идэвхитэй оролцож байна. Тийм учраас та бүхнийг завсарлагын хугацаанд энэ сэдвээр иргэд, сонгогчдынхоо дунд

хэлэлцүүлэг өрнүүлэхийг уриалж байна. Иргэдийн санал бодол хөгжлийн оновчтой, цэгцтэй, аль ч нам нь засгийн эрх барьж байсан, хэлбэрэлтгүй дагаж мөрддөг урт хугацааны зөв бодлогыг тодорхойлоход чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Улсын Их Хурлаар одоо хэлэлцэж байгаа Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай, Хамтын тэтгэврийн тухай, Нэмэгдсэн өртгийн болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Газрын тосны тухай хуулиудыг хаврын чуулганаар үргэлжлүүлэн хэлэлцэж батлах болно. Тийм учраас нам, эвслийн бүлгүүд дээрх хуулиудын үзэл баримтлалын талаар харилцан ойлголцож хаврын чуулганы өмнө нэг мөр болгохыг хүсэж байна.

Эрхэм гишүүд ээ,

Монголчууд бид сар шинэдээ аливааг өөдрөгөөр харж, гарч буй жилээ сайн сайхан билэгтэй ерөөлөөр угтдаг сайхан уламжлалтай. Улсын Их Хурлын энэ удаагийн чуулганаар баталсан хууль тогтоомж, шийдвэрүүд нь Монгол Улсын хөгжлийг эрчимжүүлэх бодлогын чухал баримт бичиг болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

Маргааш “Ялгуулсан” хэмээгч Модон морь жилээ угтан золгох гэж байна. Үндэснийхээ уламжлалт цагаан сарын энэ баярыг тохиолдуулан Та бүхэнд болон эх орныхоо дөрвөн зүг найман зовхист болон дэлхийн улс орнуудад ажиллаж амьдарч байгаа Монгол түмэндээ сар шинийн мэндийг дэвшүүлж, айл саахалтаараа амар амгалан, улс хотлоороо энх тунх, эрүүл саруул, жаргалтай сайхан байхын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлж байна. Та бүхэн сар шинэдээ сайхан шинэлээрэй. Улсын Их Хурлын намрын ээлжит чуулган хаасныг мэдэгдье.

\* \* \*

**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2014 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН**

(2014.04.07 - 2014.07.01)

**Чуулганыг нээж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг**

(2014.04.07)

Монгол Улсын Ерөнхий сайд аа,  
Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,  
Чуулганы нээлтэнд ирсэн Хүндэт зочид оо,

2012 оны сонгуулиас хойших Улсын Их Хурлын дөрөв дэх удаагийн ээлжит чуулган өнөөдөр эхэлж байна. Өнгөрсөн намрын чуулганы төгсгөлд энэ хаврын чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг баталж чадалгүй тарсан. Тиймээс энэ чуулган хэлэлцэх асуудлыг батлахаас ажлаа эхэлнэ.

Хаврын чуулганд хууль санаачлагчид, Байнгын хороод, Улсын Их Хурал дахь намуудын бүлэг, эвслээс 252 хууль, тогтоолын төслийг хэлэлцүүлэхээр санал гаргасан ч дөнгөж 52 хууль тогтоомжийн төсөл өргөн баригдсан байна. Өргөн мэдүүлсэн болон санал болгосон хууль, тогтоол, шийдвэрүүдийн төслүүдийг судалж үзэхэд улс орны өмнө тулгамдсан гол асуудлыг хөндсөн, тооцоо судалгааг нарийвчлан хийж боловсруулсан, хэлэлцэхэд бэлэн болсон төслүүд цөөн байна. Тийм болохоор өргөн баригдсан болон хэлэлцүүлгийн шатанд байгаа төслүүдээс улс орны хөгжил, эдийн засаг, нийгмийн амьдралын амин чухал шаардлагатай бодлогын асуудлыг хөндсөн хууль тогтоомжийг бодит хэрэгцээ, шаардлага, ач холбогдлоор зөв эрэмбэлж цаг алдалгүй хэлэлцэж батлах нь та бидний үүрэг гэж үзэж байна.

Дутуу дулимаг боловсруулсан, цаг үеийнхээ шаардлага, төрийн урт хугацааны бодлогын баримт бичгүүдэд нийцээгүй төслүүдийг өргөн барьдаг, түүнийг нь гүйцээн боловсруулж хэлэлцэн батлах гэж цаг хугацаа алддаг хуучин арга барилаасаа бид салах хэрэгтэй байна. Засгийн газар “Хуулийн тухай хууль”-ийн төслийг боловсруулж байгаа. Энэ хуулийн төслийг баталснаар хуулийг төлөвлөх, хуулийн чанарыг сайжруулах, хууль санаачлагчдын хариуцлагыг өндөржүүлэх тодорхой зохицуулалтууд бий болох ёстой.

Хаврын чуулганаар хуульд заасны дагуу Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт болон Монгол Улсын Засгийн газрын 2013 оны санхүүгийн нэгдсэн тайлан, Монгол Улсын 2013 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай болон Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэн батална.

Чуулганы завсарлагааны хугацаанд Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд царцаагдсан аймаг, нийслэл, сум, дүүргийн нутаг дэвсгэрт баригдаж буй “Авлигажсан” гэх тодотголтой барилга байгууламж, зам гүүр, тоног төхөөрөмж, их засварын 272 төсөл, арга хэмжээг шалгаж, бодит гүйцэтгэлд дүн шинжилгээ хийсэн аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны хурлаар хэлэлцсэн. Улсын Их Хурал хуулийн дагуу аудитын тайланг Байнгын хорооны ажлын хэсгийн дүгнэлтийн хамт хэлэлцэж, Засгийн газарт чиглэл өгөх болно. Энэ чиглэлийн дагуу Засгийн газар улсын төсөвт хийх тодотголын төслийг яаралтай боловсруулж Улсын Их Хуралд өргөн барих хэрэгтэй.

Өнгөрсөн 2013 онд дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 11.7 хувьтай байж, гадаад худалдааны алдагдал буурсан таатай мэдээ байгаа ч экспорт, импортын хэмжээ хоёулаа буурсан, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш суларсан зэрэг эдийн засгийн өсөлтийг саармагжуулсан хүчин зүйлүүд байсаар байна. Хоёр оронтой тоогоор өсч байгаа эдийн

засгийн өсөлтөө тогтворжуулах, эрчээ алдахгүй байх бодлого чухал байна. Их бүтээн байгуулалтыг идэвхижүүлэх, эдийн засгийн бодит секторыг дэмжих эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох хэрэгтэй байна.

Чингис бондыг анх авахад яригдаж боловсруулагдсан Өрийн удирдлагын тухай хуулийг Засгийн газар нэн даруй оруулж ирэхгүй бол энэ талаар санаа зовж байгаа Улсын Их Хурлын гишүүдийн өргөн барих хуулийг Улсын Их Хурал хэлэлцэн баталж томоохон бүтээн байгуулалт, хөгжлийн зээлүүдийг цаг алдалгүй эргэлтэд оруулж, гацааг арилгана.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсанаар олон жил царцсан хайгуулын тусгай зөвшөөрлийг зөвхөн зөвшөөрөгдсөн газарт олгох, түүнчлэн хариуцлагатай уул уурхайн зарчмууд шинээр орсноор байгаль орчны нөхөн сэргээлт шинэ шатанд гарах болно.

Өргөн баригдсан нэмүү өртгийн албан татварын босгын тухай хуулийг хэлэлцэхээс гадна, уул уурхайн салбартай холбож 25 хувиар өндөр тогтоосон аж ахуйн нэгжийн орлогын татварын одоогийн 2 шатлалын хувь хэмжээг бизнесийн бусад салбарын ачааллыг бууруулах зорилгоор дахин авч үзэж, нэг шатлалтай болгох асуудлыг ч судалж шийдвэрлэх хэрэгтэй байна.

Олон жил яригдсан боловч цагаан сарын өмнөхөн Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэ нарын өргөн барьсан Хамтын тэтгэврийн тухай хуулийг яаралтай хэлэлцэж батлах захиа даалгаврыг уулзалтад оролцсон ахмадууд өгсөн гэдгийг онцлон тэмдэглэж байна.

Өргөн баригдсан эдгээр хуулиудаас гадна Улсын Их Хурал эдийн засгийн өсөлтийг тогтворжуулахад чухал үүрэг гүйцэтгэх төрийн өмчийн менежментийн талаар болон хувийн өмчийн халдашгүй байдлыг хамгаалсан олон улсын жишигт нийцсэн цоо шинэ эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна. Мөн Засгийн газраас 2014 онд хувьчлах төрийн өмчийн жагсаалтаа өргөн барихыг хүлээж байна.

Хөгжлийн банкны тухай хуулийн дагуу Улсын Их Хурал Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг жил бүр хаврын чуулганаараа батлах учиртай. Эдгээр төсөл хөтөлбөрийг боловсруулахдаа улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал ач холбогдол бүхий тодорхой төслүүдийг санхүүжүүлэх эх үүсвэрийг Хөгжлийн банкаар дамжуулах бондын эх үүсвэрүүдтэй нягт уялдуулахад онцгой анхаарахыг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад үүрэг болгож байна. Ингэснээр хөрөнгө мөнгө, бондын эх үүсвэрийг үр ашиггүй зарцуулж байна гэсэн шүүмжлэлээс салж, хардлага сэрдлэгээс ангижрах болно. Хяналт тавьж холбогдох хүмүүст хариуцлага тооцох тогтолцоо ч бүрдэнэ гэж үзэж байна.

Төр эдийн засгийн харилцаанд зохицуулагчийн хувиар оролцохдоо аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх зарчмаа зөв тодорхойлж, олон улсын туршлага, сургамжтай уялдуулан эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгтэй.

Авлигатай бүх талаар тэмцэх, Төрийн байгууллагын үйл ажиллагааны бүх шатанд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, нээлттэй, ил тод байдлыг хангахад чухал ач холбогдолтой Шилэн дансны тухай хуулийг яаралтай баталж гаргамаар байна.

Шүүхийн шинэтгэлийн багц хуулийг Улсын Их Хурал баталсан. Түүнтэй холбоотой хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах хуулиудад оруулах нэмэлт, өөрчлөлтийг баталж, шинэчлэлийг хэрэгжүүлэхэд саад тотгор болсон зүйл, заалтуудыг өөрчилж, үйл ажиллагаагаа эрчимтэй явуулахад нь шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлж байна.

Хууль хэрэгжүүлэх явцад зарим бэрхшээл гарч болно. Улсын Их Хуралд тавьж буй асуудал нь үндэслэлтэй, нотолгоотой, бодитой байх ёстой. Явцуу эрх ашгийн үүднээс элдэв шалтаг, шалтгаан тоочиж шинэтгэлийн агуулга, үзэл санааг гутаах, хэрэгжүүлэх ажиллагаанд хойрго хандах, далдуур эсэргүүцэх аливаа үйлдэл байж болохгүй. Тийм учраас бэрхшээлийг

даван туулахын тулд эрх зүйн шинэ орчинд шүүх, хуулийн байгууллагууд түргэн дасан зохицож, шинэ хуулиудын агуулга, үзэл баримтлалыг амьдралд бодитой хэрэгжүүлэхийн тулд үйл ажиллагаагаа уян хатан зохицуулж, бие биедээ дэмжлэг үзүүлж ажиллах хэрэгтэй.

Хамгийн гол нь үйл ажиллагааны шинэ хандлагыг хэвшүүлэх явцад иргэн, хуулийн этгээдэд чирэгдэл үүсгэхгүй байхад онцгой анхаарвал зохино. Манай шүүгч, хуульч, хууль сахиулагч бүр энэ салбарт явуулж буй төрийн бодлого, үйл ажиллагааг дэмжиж, идэвхи санаачлагатай ажиллана гэдэгт эргэлзэхгүй байна.

Эрхэм гишүүд ээ,

Намрын чуулганы завсарлагаанаар миний бие БНСУ-д албан ёсны айлчлал хийлээ. Айлчлалын хүрээнд БНСУ-ын Үндэсний Ассамблейн дарга ноён Кан Чан Хий-тэй уулзлаа. Мөн БНСУ-ын Ерөнхийлөгч хатагтай Пак Гын Хэ-д бараалхлаа. Уулзалтуудын явцад хоёр орны хооронд тогтоосон иж бүрэн түншлэлийн харилцаагаа өргөжүүлэн хөгжүүлэх, Парламент хоорондын хамтын ажиллагаагаа улам гүнзгийрүүлэх талаар санал бодлоо солилцлоо. Мөн БНСУ-д хувиараа болон гэрээгээр ажиллаж, хөдөлмөрлөж байгаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах, визний нөхцөл, хураамж төлбөр, барьцааны асуудлаар цаашид авах арга хэмжээний талаар тодорхой саналуудыг тавьсан. Хөндсөн асуудлуудыг анхааралдаа авч, зарим асуудлыг шат дараалан шийдвэрлэх болно гэдгээ БНСУ-ын талаас мэдэгдсэнийг энд дуулгая.

Намрын чуулганыг хааж хэлсэн үгэндээ Улсын Их Хурлын гишүүд та бүхнийг чуулганы завсарлагаар сонгогчидтойгоо уулзахдаа Монгол Улсын хөгжлийн бодлогын асуудлаар иргэдийнхээ санал бодлыг сонсож ирэхийг уриалсан.

Миний бие Баян-Өлгий, Баянхонгор, Өвөрхангай аймагт томилолтоор ажиллаж иргэдтэй уулзлаа. Шинэчлэлийн Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн дагуу хэрэгжсэн Баянхонгор аймгийн Баянлиг, Бууцагаан сумын “Шинэ сумын төв”, нэгдсэн эмнэлгийн оношлогоо эмчилгээний төвийн нээлтэд тус тус оролцлоо. Баян-Өлгийн Асгатын мөнгөний орд, уг ордыг хүртэл манай талаас тавьсан авто зам, Өвөрхангайн сүүний чиглэлийн ямааны фермерийн аж ахуй зэрэг бүтээн байгуулалтын ажлуудтай танилцлаа.

Баруун аймгуудын эдийн засагт чухал түлхэц авчрах Асгатын мөнгөний ордыг яаралтай ашиглалтад оруулахад Засгийн газар онцгойлон анхаарч ажиллах хэрэгтэй байна. 11 аймгийн нэгдсэн эмнэлэгт Ерөнхий сайдын багцаас тус бүр тэрбум гаруй төгрөгийн орчин үеийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэнтэй Баянхонгор аймагт танилцлаа. Цаашид энэ төвүүдэд ажиллах эмч сувилагчдын давтан сургалтад Эрүүл мэндийн яам онцгой анхаарах хэрэгтэй.

Улсын Их Хурал, Засгийн газрын үйл ажиллагаанд иргэд ерөнхийдөө эерэг үнэлэлт өгч байгаа ч бидний цаашид анхаарах олон чухал асуудал байгааг сануулан хэлж байна.

Хаврын чуулганаар улс орныг богино хугацаанд зөв хөгжүүлэхэд чиглэсэн бодлогын олон асуудлыг шийдвэрлэхийг нийт иргэд захиж анхааруулж байна. Иргэд хөгжлийн урт хугацааны, сонгууль бүрээр савлаад байдаггүй тогтвортой бодлого зайлшгүй гэдгийг бүрэн дэмжиж байна. Энэ бүхнийг Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороод, нам, эвслийн бүлгүүд, холбогдох байгууллага, албан тушаалтнууд анхааралдаа авч үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана гэдэгт итгэж байна. Та бүхэнд ажлын амжилт хүсээд, Улсын Их Хурлын 2014 оны хаврын ээлжит чуулганы ажиллагааг нээснийг мэдэгдье.

\*\*\*

**Чуулганыг хааж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг**

(2014.07.01)

Монгол Улсын Ерөнхий сайд аа,  
Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын дөрөв дэх удаагийн ээлжит чуулган өнөөдөр өндөрлөж байна. Хаврын чуулган ажлын 62 хоног үргэлжилж, нэгдсэн хуралдааныг 29 удаа, Байнгын болон дэд хорооны хуралдааныг давхардсан тоогоор 108 удаа хийсэн байна.

Хаврын чуулганы хугацаанд Улсын Их Хурлын даргын урилгаар Мьянмарын Холбооны Бүгд найрамдах улсын Холбооны Парламентын дарга бөгөөд Төлөөлөгчдийн танхимын дарга Тура У Швэ Манн тэргүүтэй төлөөлөгчид, ОХУ-ын Холбооны Хурлын Холбооны Зөвлөлийн дарга Валентина Ивановна Матвиенко, Бүгд Найрамдах Турк Улсын Үндэсний Их Хурлын дарга ноён Жемил Чичек нар Монгол Улсад албан ёсны айлчлал хийлээ.

Миний бие хаврын чуулганыг нээж хэлсэн үгэндээ эдийн засгийн бодит секторыг дэмжих эрх зүйн орчныг улам боловсронгуй болгож томоохон бүтээн байгуулалт, хөгжлийн зээлүүдийг цаг алдалгүй эргэлтэд оруулах, олон жил царцсан хайгуулын тусгай зөвшөөрлийг зөвхөн зөвшөөрөгдсөн газарт олгох, аж ахуйн нэгжийн орлогын татварыг нэг шатлалтай болгох, Хамтын тэтгэврийн тухай хуулийг хэлэлцэж батлах, төрийн өмчийн менежментийг боловсронгуй болгож 2014 онд хувьчлах төрийн өмчийн жагсаалтыг батлах, Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг батлуулж, төслүүдийг санхүүжүүлэх эх үүсвэрийг бондын эх үүсвэрүүдтэй уялдуулахад анхаарлаа хандуулж ажиллахыг чиглэл болгосон.

Хаврын чуулганаар 79 хууль, тогтоол, Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл хэлэлцэж баталсаны 9 нь бие даасан хууль, 43 нэмэлт өөрчлөлт оруулах тухай, 2 нь хүчингүй болгох тухай, 4 нь гэрээ соёрхон батлах тухай хууль, 21 нь Улсын Их Хурлын тогтоол байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай, Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Малын индексжүүлсэн даатгалын тухай, Шилэн дансны тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай, Ногоон хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөтөлбөр батлах тухай, Цагаан суваргын ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох тухай зэрэг улсын орны эдийн засгийн чухал ач холбогдолтой хууль тогтоолуудыг баталлаа.

Түүнчлэн Амгалангийн дулааны цахилгаан станцын угсралтын ажлыг гүйцэтгэх тоног төхөөрөмж, Жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг Гаалийн болон Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, төлөх хугацааг 2 хүртэл жилээр сунгах тухай хуулиудыг баталж их бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх нөхцлийг бүрдүүлээ.

Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг устгах тухай протоколыг соёрхон батлах тухай, “Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай, “Инженер, технологийн дээд боловсрол” төслийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай, “Хүнс тэжээл, нийгмийн халамжийн төсөл, нэмэлт санхүүжилт”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай” хуулиудыг мөн баталлаа.

Хаврын чуулганы хугацаанд Хяналтын тухай, Газрын тосны тухай, Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Төлбөрийн системийн шинэчлэл төсөл”



-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай болон Чиглэл өгөх тухай хэд хэдэн хууль, тогтоолын төслүүд эргэж буцаж цаг хугацаа ихээхэн алдлаа. Энэ нь Засгийн газраас өргөн баригдсан зарим хууль, тогтоол дутуу дулимаг боловсрогдсон төдийгүй Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг, гишүүдийн үзэл баримтлалтай зөрчилдөж байгаатай холбоотой юм.

Нөгөө талаар хаврын чуулганы хугацаанд Улсын Их Хурлын нэгдсэн чуулган болон Байнгын хорооны хурлаар хэлэлцсэн 16 асуудлаар Ардчилсан намын бүлэг 3 удаа 15 хоног, Монгол Ардын намын бүлэг 9 удаа 37 хоног, МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслийн бүлэг 4 удаа 16 хоног нийтдээ 16 удаа 68 хоногийн завсарлага авсан нь зарим хууль, тогтоолыг цаг хугацаанд нь шийдвэрлэхэд хүндрэл учруулсан гэдгийг тэмдэглэж байна.

Улсын Их Хурал Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэлийг батлахдаа инфляцийг энэ оны эцэст 8 хувьд байлгаж, улмаар 2015-2016 онд 7 хувьд хүргэн дунд хугацаанд макро эдийн засгийн тогтвортой байх нөхцлийг бүрдүүлэх зорилт тавьсан. Гэвч энэ оны 5 дугаар сарын байдлаар инфляци 13.7 хувьтайгаас харахад энэ зорилт биелэх боломж бага байна. Гадаад валютын орлого төсөөлж байснаас илүү багасч, төсвийн орлого төвлөрүүлэлт тасалдаж, бодит салбарт олгосон зээлийн чанар муудах төлөвтэй байна.

Урсгал тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 56 хувиар буюу 728.2 сая ам.доллараар буурсан хэдий ч 580.5 сая ам.долларын алдагдалтай байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом буурсан өнөөдрийн нөхцөлд уул уурхайн салбарын өсөлтөөр дэмжигдсэн эдийн засгийн өндөр өсөлтийг хэвээр хадгалах гэж оролдсон нь төлбөрийн тэнцэл алдагдах, төгрөгийн ханш унах, инфляци нэмэгдэх үндэс болсон байна. Иймээс макро эдийн засгийн бодлогоо хатууруулах чиглэлд бодлого хэрэгжүүлж, эрэлтийг хязгаарлах шаардлага тулгарч магадгүй.

Зээл олголтыг хязгаарлах нь бодит эдийн засагт, тэр тусмаа иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хүнд тусна гэдгийг ойлгож байгаа ч эдийн засгаа бүхэлд нь хямралд оруулахаас арай дээр хувилбар гэж үзэж байна. Иргэд, аж ахуйн нэгж үүнийг ойлгож, богино хугацаанд тулгамдаж байгаа эдийн засгийн хүндрэлийг хамтдаа даван туулахын төлөө сэтгэл, зүтгэл нэгтэй ажиллана гэдэгт итгэж байна. Гэхдээ бага, дунд орлоготой иргэдийн ажлын байр, бодит орлогыг хамгаалах, дотоодын үйлдвэрлэл болон үндэсний компаниудын тогтвортой хөгжих орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бодлогоо эрчимжүүлэх шаардлага нэмэгдэж байгааг анхаарч ажиллах нь зүйтэй.

Засгийн газрын тэвчиж болох зардал, төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалтыг төсвийн гадуурхи Хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжүүлэх ажлыг үргэлжлүүлсээр байвал төлбөрийн тэнцэл улам муудаж, хямралыг бодитойгоор бий болгох магадлал байна. Засгийн газар Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу жил бүрийн хаврын чуулганд Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн жагсаалтыг Улсын Их Хуралд оруулж батлуулах ёстой. Гэвч өнөөдрийг хүртэл энэ жагсаалтыг Улсын Их Хуралд оруулж ирсэнгүй.

Судлагаанаас үзэхэд Хөгжлийн банк ДНБ-ний 5 хувьтай тэнцэх хэмжээний санхүүжилтийг төсвийн гадуур зарцуулсан байгаа. Хэрэв энэ байдал үргэлжилж Хөгжлийн банкны дансан дахь 1.0 тэрбум ам. долларын бондын хөрөнгөөр Хөгжлийн банкин дахь хүлээгдэж байгаа төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлбэл төсвийн нийт алдагдал 2 дээр нэмэх нь 8 буюу ДНБ-ний 10 хувьд хүрэхээр байна. Тиймээс Хөгжлийн банкнаас хийж байгаа Чингис, “Самурай бондын санхүүжилт, тэдгээрийн зардал, төсвийн шинж чанартай бүх үйл ажиллагааг нэгдсэн төсөвт тусгаж, нийт төсвийн алдагдлыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан түвшинд хүртэл үе шаттайгаар буулгах бодлогоор төсвийн тодотголыг боловсруулж 8 дугаар сард Улсын Их Хуралд оруулж ирэх хэрэгтэй байна.

Цаашид Засгийн газар бондын хөрөнгийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжид заасан зарчмаар зарцуулж, түүний хэрэгжилтэд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороод анхаарал хандуулж хяналт тавьж ажиллах хэрэгтэй.

Эдийн засагт учирч байгаа хүндрэлийг даван туулах, цаашид тасралтгүй өсгөх таатай нөхцлийг бүрдүүлэхэд санхүүгийн салбарын тогтвортой байдал чухал ач холбогдолтой. Ялангуяа банк, санхүүгийн салбарын хяналт шалгалтыг улам чангатгаж, уламжлалт бус замаар олгогдсон эрсдэл үүсгэж болзошгүй байгаа зээлийн томоохон багцад дүн шинжилгээ хийх хэрэгтэй байна. Түүнчлэн зээлийн чанар нь муудаж байгаа салбарын зээлийг хязгаарлах арга хэмжээг ч цаг алдалгүй авах нь зүйтэй. Гадаад валютын зээлийн зохистой бус харьцааг өөрчлөх, валютын зээлийг бүхэлд нь зохицуулах эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр Монголбанк санаачилга гарган ажиллавал зохино.

Эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурал 2014 оны 5 дугаар сарын 8-ны өдөр Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай 34 дүгээр тогтоолыг баталсан. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх хугацаа тодорхой учраас хэрэгжилтийг хангахад анхаарлаа хандуулж ажиллахыг Та бүхэнд уриалж байна. Улсын Их Хурлаас шалтгаалах асуудал гарвал ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулах шаардлага гарахыг ч үгүйсгэхгүй байна. 8 дугаар сарын хоёрдугаар хагаст айлчлах хоёрын хөршийн Ерөнхийлөгч нараас Улсын Их Хурлын хүндэтгэлийн чуулганд үг хэлэх хүсэлт гаргаж эхэлж байгаа тул бас нэг ээлжит бус чуулган хуралдуулах шаардлага гарч магадгүйг бас зарлая. Хамгийн гол нь Засгийн газар ажил, амралтаа зохицуулж “ЭЗЭН - 100” хөтөлбөрөө хэрэгжүүлэхийн төлөө цаг хугацаа алдалгүй идэвхитэй ажиллах хэрэгтэй гэдгийг анхааруулж байна.

Та бүхэнд ажлын амжилт хүсч, Улсын Их Хурлын 2014 оны хаврын ээлжит чуулганы ажиллагааг хаасныг мэдэгдье.

\* \* \*



**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2014 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН**

2014.10.01 - 2015.02.18

**Чуулганыг нээж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг**

(2014.10.01)

Монгол Улсын Ерөнхий сайд аа,  
Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,  
Хүндэт зочид оо,

Өнөөдөр Улсын Их Хурлын 2014 оны намрын ээлжит чуулган эхэлж байна. Хаврын чуулганы завсарлагааны хугацаанд Монгол Улсын гадаад харилцаа томоохон үйл явдлаар дүүрэн байлаа. Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийн урилгаар манай хоёр хөрш орны тэргүүн БНХАУ-ын дарга ноён Си Зиньпин, Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч ноён Владимир Владимирович Путин нар Монгол Улсад айлчлал хийлээ.

БНХАУ-ын дарга ноён Си Зиньпин Монгол Улсын Их Хурлын чуулганы хүндэтгэлийн хуралдаанд элэгсэг дотно үг хэлж, төрийн айлчлалын хүрээнд Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал гаргаж, хоёр орны Засгийн газар болон аж ахуйн нэгжүүдийн хооронд Төмөр замын дамжин өнгөрөх тээвэр, далайн боомтыг ашиглах, худалдаа эдийн засаг, нийгмийн салбарыг хөгжүүлэх 24 баримт бичигт гарын үсэг зурлаа.

Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгчийн ажлын айлчлалын хүрээнд хоёр орны иргэд харилцан визгүй зорчих асуудал бүрэн шийдэгдэж, “Улаанбаатар төмөр зам” Хувь нийлүүлсэн нийгэмлэгийн шинэчлэл, хөгжлийн стратегийн түншлэлийн хэлэлцээр байгуулагдаж, төмөр замыг цахилгаанжуулах, хос болгох ажлыг цаг алдалгүй эхлүүлэхээр боллоо. Халхын голын ялалтын 75 жилийн ойг хамтран тэмдэглэлээ. Олон салбарыг хамарсан Засгийн газар хоорондын нийт 15 бичиг баримтад гарын үсэг зурлаа.

Эдгээр айлчлалууд нь манай орны хөрш хоёр оронтойгоо харилцах харилцаанд шинэ үе шатыг эхлүүлсэн түүхэн үйл явдал болсныг онцлон тэмдэглэж байна.

Хоёр том гүрний дунд оршиж байгаа манай орны хувьд газар зүйн байршлын давуу талаа ашиглан төмөр замын, авто замын, нефтийн болон хийн хоолойн, эрчим хүчний, интернетийн шилэн кабелийн дамжин өнгөрөх стратегийн зорилтыг хэрэгжүүлэхийн төлөө идэвхтэй, санаачилгатай ажиллах цаг хугацаа тохиож байна.

Энэ сарын сүүлчээр Улсын Их Хурлын даргын БНХАУ-д хийх албан ёсны айлчлалын хүрээнд хоёр орны парламент хоорондын харилцааны байнгын ажиллагааг бэхжүүлэх баримт бичигт гарын үсэг зурахын зэрэгцээ бусад асуудлуудаар Засгийн газар, аж ахуйн нэгжүүдийн хооронд хамтран ажиллах гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурах ажлыг амжуулахаар хоёр тал идэвхтэй хамтран ажиллаж байна.

Цаашид төрийн тэргүүнүүдийн айлчлалын хүрээнд гарын үсэг зурсан баримт бичгүүдийг ажил хэрэг болгохын төлөө Засгийн газар цаг алдалгүй шуурхай ажиллаж, үр дүнд хүргэх хэрэгтэй байна.

Монгол Улсын хоёр хөрштэйгээ харьцах харилцаанд гарсан сүүлийн үеийн ололт амжилт нь манай улсад Гурав дахь хөршийн бодлогоо эрчимтэй хэрэгжүүлэх боломжийг олгож байна. Гурав дахь хөршийн холбоогоо бэхжүүлэхэд энэ удаагийн чуулганаар хэлэлцэх Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах нь чухал ач холбогдолтой гэдгийг онцлон тэмдэглэж байна.

Хаврын чуулганы завсарлагааны хугацаанд Улсын Их Хурлын гишүүд хөдөө орон нутагт ажиллахын зэрэгцээ ХБНГУ, Бельги, Англи, АНУ, Канад, Швед, Турк, Франц, Австри зэрэг улсад олон улсын хурал, чуулганд оролцож тухайн орнуудын хууль эрх зүйн орчинг судалж, парламентын үйл ажиллагаатай танилцсан байна.

Миний бие чуулганы завсарлагааны хугацаанд Баян-Өлгий, Говь-Алтай, Орхон, Булган аймгуудад ажиллаж, нийслэлийн эрчим хүчний бүтээн байгуулалт, Дөргөн, Тайшир, Эгийн голын усан цахилгаан станцын үйл ажиллагаа, төслийн явцтай танилцаж, Орхон аймгийн Молибдены баяжмал боловсруулах үйлдвэрийн нээлтэд оролцлоо.

Монголд нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэлийг хөгжүүлэх, эрчим хүчний дэд бүтцийг өргөтгөх ажил эрчимтэй явагдаж байна. Өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэгцээг хангахын тулд хуучин ТЭЦ-3,ТЭЦ-4 станцын хүчин чадлыг 50 болон 128 мВт-аар нэмэгдүүлж өргөтгөсөн нь цаг хугацаа хожсон зөв бодлого байсныг харуулж байна. Улаанбаатар хотын зүүн хэсгийг дулаанаар хангах “Амгалангийн дулааны станц” хугацаандаа ашиглалтад орох боломжтой болжээ. Үүний үр дүнд нийслэлийн эрчим хүчний хангамж сайжрах нөхцөл бүрдэж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын энэ удаагийн намрын чуулган Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацааны хоёр дахь хагасын эхлэлтэй давхцаж буйгаараа онцлог юм. Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурлын эрхэм гишүүд Та бид ард түмнээрээ ажлаа дүгнүүлэхэд хоёр хүрэхгүй жилийн хугацаа үлдээд байна. Улсын Их Хурлаас өнгөрсөн хоёр жилд Монгол Улсын хөгжил, эдийн засгийг эрчимжүүлэх ач холбогдолтой хууль, тогтоол, шийдвэр олныг гаргасан нь зохих үр дүнгээ өгсөн гэж үзэж байна. Тухайлбал, Монгол Улс НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид нэгдэн орсноос хойш гишүүн орны хувьд хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор энэ удаагийн Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд хууль хяналтын байгууллагын эрх зүйн шинэтгэлтэй холбоотой багц хуулиудыг батлан гаргаж мөрдүүлсэн.

Олон улсын “Транспарэнси интернэшнл” байгууллагаас жил бүр гаргадаг Авлигын төсөөллийн индексийн судалгааны дүнгээр Монгол Улс 124 дүгээр байрнаас 83 дугаар байранд шилжсэн нь авлигатай тэмцэх талаар төрөөс авч хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны үр дүн юм. Гэсэн хэдий ч эдийн засаг, нийгэм, хууль хяналтын салбарын олон эмзэг асуудлыг шийдвэрлэх үүднээс цаг алдалгүй хэлэлцүүлж, батлуулах шаардлагатай хууль, тогтоолын төслүүд цөөнгүй байна

Намрын чуулганаар 2015 оны Монгол Улсын төсөв, хүний хөгжил сангийн болон нийгмийн даатгалын сангийн төсөв, төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийг хэлэлцэж батална. 2014 оны эхний 8 сарын байдлаар Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 13.6 хувиар буюу 605.8 тэрбум төгрөгөөр тасарч, Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 3 их наяд 798 тэрбум төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 3 их наяд 951 тэрбум төгрөгт хүрч улсын нэгдсэн тэнцвэржүүлсэн тэнцэл 153 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Сүүлийн жилүүдэд манай эдийн засагт төгрөгийн ханшийн савлагаа, инфляцийн өсөлт, экспортын бүтээгдэхүүний үнийн уналт зэргээс хамаарч ард иргэдийн зарим хэсгийн амьжиргааны түвшин буурч байна.

Эдийн засагт үүссэн эдгээр нөхцөл байдлыг болон удахгүй төлбөр нь нэхэгдэж эхлэх Хөгжлийн банкны Чингис, Самурай бондуудын төлбөрийг хэрхэн төлөх талаар одооноос сайтар тооцож, 2015 оны төсөв, мөнгөний бодлогыг үндэслэл сайтай баталж мөрдүүлэх шаардлага Улсын Их Хурлын эрхэм зорилт болж байна. Өнгөрсөн хаврын чуулганаар баталж амжаагүй Өрийн удирдлагын хуулийг ч гэсэн яаралтай батлан гаргах шаардлагатай байна.

Энэ удаагийн чуулганаар Татварын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн болон шинэчилсэн найруулгын төсөл, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Гэмт хэргийн тухай, Зөрчлийн тухай, Худалдааны тухай зэрэг олон чухал хуулиудыг хэлэлцэнэ.

Мөн Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай, авто зам, боловсрол, эмийн талаар төрөөс баримтлах бодлогыг шинэчлэн батлах тухай тогтоолын төслүүд болон хаврын чуулганаар хэлэлцэж эхэлсэн бусад хууль тогтоомжийг үргэлжлүүлэн хэлэлцэж батлах болно.

Улс төрийн намууд сонгуульд зориулан иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас их хэмжээний хандив авдаг, намын санхүүжилт ил тод биш байгаа талаар ихээхэн шүүмжлэл дагуулж байна. Үүнтэй холбоотойгоор Улс төрийн намын тухай, Улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулийн төслийг энэ чуулганаар хэлэлцэхээр төлөвлөөд байна.

Улс орныхоо эдийн засагт суурь чанартай томоохон өөрчлөлтүүдийг хийж, улсынхаа хөгжлийг дунд, урт хугацаанд төлөвлөх талаар бид олон удаа ярьж байгаа. Харамсалтай нь бодит ажил хийгдсэнгүй өнөөдрийг хүрч байна. Үүнтэй холбоотойгоор Хөгжлийн стратеги, бодлого боловсруулах чиглэлээр байгуулагдсан Улсын Их Хурлын ажлын хэсэг ажилдаа яаравчлан орохыг сануулж байна.

Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтцэд өөрчлөлт оруулна гэдгээ ард түмэндээ зарласан нь нийгмийн сэтгэл зүйд ихээхэн хүлээлт бий болгоод байна. Тийм учраас бүтцийн өөрчлөлтийг Улсын Их Хурлын гишүүд, олон нийтийн дунд өрнөж байгаа санал шүүмжлэл, салбаруудын уялдаа холбоог нарийвчлан тооцож, оновчтой хувилбараар боловсруулж ойрын хугацаанд Улсын Их Хуралд өргөн барих хэрэгтэй байна.

Улсын Их Хурал бүрэн эрхийнхээ дагуу цаг хугацаа, дараалал харгалзахгүйгээр яаралтай хэлэлцэж батлах болно. Энэ нь засаглалын ажлыг тасралтгүй үргэлжлүүлэх алхам гэж үзэж байна. Харин Засгийн газрын бүтэц өөрчлөхтэй холбоотойгоор засаглалын аль ч шатанд ажил цалгардуулж болохгүй гэдгийг төрийн албан хаагчид, албан тушаалтнуудад анхааруулж байна.

Эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүдийн ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор Улсын Их Хурлын Тамгын газар, БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран БНСУ-ын Засгийн газрын 3.5 сая ам.долларын буцалтгүй тусламжаар “Цахим парламент” төслийг амжилттай хэрэгжүүлж, хуралдааны танхимуудад иж бүрэн цахим системийг шинээр суурилууллаа.

Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааны цагийг долоо хоногийн Пүрэв, Баасан гарагт өглөө 09 цагаас эхэлж, үдээс хойш 14 цагаас үргэлжлүүлж байхаар өөрчилж захирамж гаргалаа.

Намрын чуулган дараа жилийн төсөв, мөнгөний бодлогыг тусгай дэгээр хэлэлцдэг учраас цаг хугацааг үр ашигтай, бүтээлчээр ашиглаж, төлөвлөгдсөн олон чухал хууль тогтоолыг батлахын тулд эрхэм гишүүд Та бүхнийг чуулганы үйл ажиллагаанд идэвхтэй, санаачилгатай оролцохыг уриалж байна.

Та бүхэнд ажлын амжилт хүсч, Улсын Их Хурлын 2014 оны намрын ээлжит чуулганы ажиллагааг нээснийг мэдэгдье.

\*\*\*

**Чуулганы хуралдаан дээр Монгол Улсын Ерөнхий сайд Н. Алтанхуягийн хэлсэн үг**

(2014.11.05)

Улсын Их Хурлын эрхэм дарга,  
Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Миний бие ард түмнийхээ өгсөн итгэл, оногдуулсан үүргийн дор Монгол Улсын 27 дахь Ерөнхий сайдаар 2 жил гаруй хугацаанд ажиллаж байна.

Итгэл найдвар, шинэчлэл өөрчлөлтийн асар их хүлээлтийг хөсөрдүүлэхгүй гэсэн зүтгэл маань сайн хамт олон, зорилго нэгт танхимын гишүүд, шинэчлэлийн төлөө сэтгэл гарган зүтгэсэн аймаг, орон нутгийн удирдлагууд болон төрийн бүх шатны албан хаагчид, бүтээн байгуулалтыг гардан хийсэн ажилсаг түмэн, итгэл өгөн дэмжих ард түмний дэмжлэгтэйгээр хүндхэн цаг үед бас боломжийн үр дүн, бодит бүтээмжтэйгээр үргэлжилж байна.

Бид цаасан дээр ажиллаж, цэцэрхэж хийрхэх нь цаг алдалгүйгээр хийж бүтээхэд бүхий л цаг хугацаа, ажил үйлс, хүсэл зорилгоо дайчлан зориулсан нь өнөөдөр та бүхний өмнө нүүр бүтэн зоригтой зогсох боломж олгож байгааг шуудхан хэлмээр байна. Хийж бүтээсэн бодитой ажлууд цаашдаа хийж бүтээх ажил үйлс маань бүгдийн нүдэн дээр ил тод, хангалттай хурдтайгаар үргэлжилж байгааг та бүхэн надаар хэлүүлэлтгүй харж байгаа.

Огцор гэж сөрөг хүчин шаардсан. Огцрохын тулд бодит шалтгаан хэрэгтэй. Монгол Улсын Засгийн газар улс орныхоо эдийн засаг, ард түмнийхээ амьжиргаа, Монгол Улсын гадаад нэр хүнд, харилцаа, хамтын ажиллагааг бүхэлд нь нуруундаа үүрч явдаг онцгой ач холбогдол үүрэг бүхий төрийн том багана юм. Хэсэг бүлгийн хангагдаагүй эрх мэдэл, хэн нэгний явцуу эрх ашгаас үүдсэн үндэслэлгүй, бодлогогүй тэмцэлд ганхаж тогтворгүйтэх юм бол ард түмний язгуур эрх ашигт шууд харшлахуйц хариуцлагагүй үйлдэл болно. Тиймээс сөрөг хүчний өргөн барьсан огцруулах үндэслэлд бодитой тоо баримттай хариултыг товчхон өгье.

Эдийн засаг 17.3 хувийн өсөлттэй байснаа 6.3 хувь боллоо. Энэ тоо бодитойгоор ингэж гарсан нь үнэн. Тэгэхдээ 17.3 хувийн эдийн засгийн өсөлтийг өгч байхад тэр үед бол Оюу толгой зэрэг томоохон үйлдвэрийн нөлөө бараг энэний тал хувийг бүрдүүлсэн байгаа. Өнөөдөр яагаад Монголын эдийн засгийн өсөлт ийм бага гарч байгаа юм бэ гэж. Өнөөдөр бол бид нар бодитой хөрсөн дээрээ буусан, гаднын хөрөнгө оруулалт, гаднын дэмжлэг тусалцаагүй болсон энэ цаг үед өөрийнхөө дөрвөн булчингаараа хийж бүтээснээрээ энэ эдийн засгийн өсөлт бий болж байгаа юмаа.

Жишээлбэл бол 2014 оны хагас жилийн статистикаас үзэх юм бол 5.3 хувийн өсөлтийн маань 3 пунктийг нь бол уул уурхайн олборлолтын өсөлт эзэлж байгаа юм. Импортын бус буюу гаднаас хамааралтай биш гэсэн үг. Олборлолтын өсөлт эзэлж байгаа юм. 1.9 хувийг нь бол хөдөө аж ахуйн үйлдвэрлэл бүрдүүлж байгаа юм. Энэ бол дотоодын эдийн засгаар бүрдүүлж байгаа цэвэр өсөлт юм.

Монголчууд бид нар ингэж л амьдрах хэрэгтэй. Айлаас эрэхээр авдраа уудал. Гаднаас хайхаар өөрснөө хөдөлмөрлө, монголдоо бүтээцгээе, хийж болох юмаа өөрснөө хийе гэсэн энэ зорилтын хүрээнд өөрийн гэсэн эдийн засгийн өсөлт бий болж байгаа юмаа. Хоосон тоогоор хөөцөлдөж хэрэггүй ээ. Дараа нь Засгийн газар, Улсын Их Хурлын хяналтгүй 7 их наяд орчим төгрөгийн тооцоо судалгаагүй, бодлогогүй зарцуулсан их хөрөнгө улс орны эдийн засгийг өвчлүүлснийг олон улсын хөндлөнгийн байгууллага дүгнэлээ гэх үндэслэлд хариу өгье. Энэ бол худлаа байгаа юмаа.

Дэлхийн банк 2014 оны 10 сард хийсэн илтгэлдээ “Монголын төсвөөс гадуурх зардал нь эдийн засгийн өсөлтийг бууруулах биш харин ч олон улсын зах зээлийн дээр эрдэс баялгийн



үнэ унасан ийм гадаад орчны ихээхэн таагүй нөхцөл байдалд эдийн засгийн өсөлтийг хангах гол хүчин зүйл болжээ” гэж та бүхний хэлээд байгаа байгууллагууд дүгнэсэн байгаа юмаа. Гэвч энэ нь төлбөрийн тэнцэлд дарамт учруулах эрсдэлийг бий болгосон тул Засгийн газар, Монголбанкны энэ онд эхлүүлсэн төсөв, мөнгөний хумих бодлого нь энэхүү эрсдэлийг хязгаарлахад чухал арга хэмжээ боллоо гэж энэ олон улсын байгууллагууд дүгнэсэн байна аа.

Монгол Улсад өрийн дарамт бодитойгоор нүүрлэн, өр 50 хувиар нэмэгдэж, жилийн ДНБ-нээс давлаа гэх асуудлын тухайд:

Олон улсын валютын сангаас хөгжиж байгаа улс орнуудын хувьд өрийн шалгуур үзүүлэлтийг тогтоохдоо бодлого болон институцийнх нь үнэлгээний индексийг тооцож, үр дүнгий нь сул, дундаж, хүчтэй гэсэн 3 ангилалд хувааж үздэг юм байна аа. Монгол Улсын гадаад дотоод өрийн үлдэгдлийн ДНБ-нд эзлэх хувийг Олон улсын валютын сан, Дэлхийн банкны шинжээчид тооцож үзээд дундаж гэсэн ангилалд оруулсан.

Монгол Улсын өрийн үлдэгдэл ДНБ-нд харьцуулсан шалгуур үзүүлэлтийн төвшин нь бол энэ 9 дүгээр сарын 30-ны байдлаар 49.3 хувьтай байна. Засгийн газрын чадамжгүй, эдийн засгийн бодлогогүй, урагшгүй байдлаас гадаадын шууд хөрөнгө оруулалт буурлаа гэж та бүхэн хэлсэн байна лээ. Энэ бас залруулж хэлэх нь зүйтэй гэж бодож байна.

Оюу толгойн эхний шатны хөрөнгө оруулалт 2010- 2012 онд хийгдэж байхад 1 тэрбумаас 4.9 тэрбум ам.доллар болтлоо өсөж, гадаадын хөрөнгө оруулалт өсөж, энийг дагалдсан бизнесийн хөдөлгөөн бол Монголд нэлээн голлох нөлөө үзүүлж байсан.

Нэгдүгээр үе шат дууссанаар хөрөнгө оруулалтын хэмжээ бол үндсэндээ зогссон.

Хоёрдугаарт, 2010-2012 онуудад дэлхийн зах зээл дээр нүүрсний үнэ өндөр байснаар манай 40 орчим аж ахуйн нэгж олон улсын зах зээл дээр IPO хийх замаар хөрөнгө татсан бол 2012-2014 онуудад нүүрсний үнэ тасралтгүй унасаар өмнөх шиг хувьцаа гаргаж, хөрөнгийн биржээс хөрөнгө босгох төслийг өргөтгөхөд шинэ хөрөнгө оруулалт татах үйл ажиллагаа багассан байна аа.

Гуравдугаарт, 2010 оноос эхлэн 2012 оны 5 дугаар сар хүртэл гадаадын шууд хөрөнгө оруулалтыг хязгаарлах эрх зүйн актуудыг Улсын Их Хурал баталж, улс төржүүлэх, хөрөнгө оруулагчдыг шахах хандлага бол давамгайлсан. Ийм учраас гадаадын хөрөнгө оруулалт багассан.

Харин бид шинэчлэлийн Засгийн газар байгуулагдсанаас хойш гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр Улсын Их Хуралтайгаа хамтраад Хөрөнгө оруулалтын тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай, Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл шинээр олгох хуулиудыг баталж, зарим хориглогдсон байсан хуулиудыг бол цуцалсан. Ингэснээр хөрөнгө оруулалт нэмэгдэх боломж нөхцөл бүрдэж байна.

Монгол Улсад бүртгэлтэй 54337 аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа зогсоосон гэх үндэслэлийг дэлгэрэнгүй манай Засгийн газрын байгууллагууд, статистикийн байгууллагуудтай нягталж үзлээ. Энэ 54 мянга гэж байгаа аж ахуйн нэгж байгууллагууд нэг өдөр үйл ажиллагаагаа зогсоогоогүй юм байна. Энэний 10.2 хувь нь байгуулагдсанаасаа хойш ямар ч тайлан ирүүлдэггүй. Тэрнийг оруулдаг юм байна. 36 хувь нь бол үйл ажиллагаа явуулаагүй тайлан ирүүлсэн. Ингэхээр бараг энэний 45-50 орчим хувь нь бол байгуулагдсанаасаа хойш тайлан ирүүлээгүй, үйл ажиллагаа явуулдаггүй аж ахуйн нэгжүүд байдаг юм байна аа. Дээр нь Монгол 999 гэх ажиллагаагаар Таван толгойн хувьцаа авах зорилгоор маш олон зохиомол олон компаниуд бүртгэлийн төдий үүссэн байсан юм.

Өрийн асуудал дээр би бас тодорхой зүйл хэлье гэж бодлоо. Одоо бид энэ нар тав дахь өдөр Улсын Их Хурал дээр тоогоо нэг мөр болгоё гэсэн материалыг би та бүхэнд хүргүүлсэн

байгаа. Энэ өрөн дээр бол бид нар тогтож ярилцаж, ард иргэддээ ч гэсэн нэг мөр ойлголт өгөх шаардлагатай байгаа юмаа.

Би хоёр өрийн тухай ярья.

Нэгдүгээрт, одоо бид нар хамтраад ажиллаж байхад ямар хэмжээний өр тавиад, тэрнээс хэчнээн хэмжээний нь бид нар төлөөд, хэдийг нь бас төлж чадахгүй өртэй явж байгаагаа эхлээд хэлье гэж бодож байна.

Ер нь бол бид нар нэг буруу ойлголттой боллоо. Бүх юм сайхан байхад л одоо бүгдийг нь эдийн засгийн хамаг юмыг баллачихсан юм шиг ийм ойлголтыг ийм юмыг манай Ардын намынхан олон нийтэд их хүргэх юмаа. Хүн бүхэн л нэг тийм хар амтай л юм ярих юм.

Тийм учраас би энийг одоо нэг удаа буцаан эргүүлээд, энэ киног үзүүлэхээр шийдлээ. Кино гэдэг нь өмнөх онуудад ямар байдалтай байсныг нь хэлье.

Нэгдүгээрт бол бүгдээрээ мэдэж байгаа маргах юм байхгүй. Өмнө нь Засгийн газар Оюу толгойгоос 250 сая долларын урьдчилгаа төлбөр нэртэй хүүтэй мөнгө авсан. Яахав уг нь урьдчилгаа төлбөр нэртэй. Тэгэхдээ энэ бол хүүтэй мөнгө л дөө. Энэнээс бид нар 166 сая долларыг нь төлчихөөд байна. Одоо цаана нь 90 гаруй сая доллар бол төлөгдөөгүй байна. Хоёр янзын хэлбэрээр төлж байгаа юм. Нэгийг нь бол бэлнээр төлж байгаа. Сая 10 сард бид нар 115 сая долларыг бэлнээр төлсөн.

Нөгөө нэг хэлбэр нь бол Оюу толгой Монгол Улсын төсөвт төлөх татвараас нь суутгаж байгаа. Үнэн хэрэгтээ бид нар бол Монгол Улсын төсөвт мөнгө авахгүй байгаа. Харин нүүрсний үнэ хямдхан ч гэсэн орж ирсэн хэдэн төгрөгөө өр төлөхөд зарцуулж байгаа. Энэ дээр та бүхэн маргахгүй байх аа гэж бодож байна. Оюу толгойн 250 сая доллар. Энэ мөнгийг бид нар юунд зарцуулсан юм. Энэ бол үндсэндээ 450-460 тэрбум төгрөг. Энийг бид нар ард иргэддээ өмнөх засгийн үед амласан 21 мянган төгрөг, 1 сая төгрөгийг тарааж өгөхөд зарцуулсан байгаа.

Хоёрдугаарт, Эрдэнэс МГЛ гэдэг компани хэчнээн төгрөгийн өртэй, өчигдөр билүү та нар Байнгын хороон дээр татан буулгана гээд юм ярьсан байна лээ. Энэ хэчнээн тэрбум төгрөгийн өртэй ирсэн гэхээр 416 тэрбум төгрөгийн өртэй ирсэн. Бүгдээрээ мэдэж байгаа бас. Чалкотой гэрээ хийгээд, бусад газраас гэрээ хийгээд, нүүрсээ бид нар та нарт өгнөө гэж хэлээд мөнгийг нь авчраад тараачихсан юм. Өнөөдөр бид нар энэ өрийг хараахан төлж дуусаагүй байна. 2014 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар 97 орчим тэрбум төгрөгийг төлөөд байж байна аа.

Гуравдугаар зүйл нь Монголбанкны зээлийн өр. Энэ бол 361 тэрбум төгрөг. Энийг бол бид бас тодорхой хэмжээгээр төлж барагдуулсан. Ахмад настны хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох 1 сая төгрөгийг өмнөх Засгийн газрын үед бол бүрэн өгч чадахгүйгээр орхисон байсан юм. Энийг бид нар ямар өмнөх Засгийн газар амлаад хаячихсан юмаа гэж хэлээд төлөхгүй байлтай биш ард иргэд хараад сууж байгаа учраас бид нар дотоодод бонд босгож, 122 тэрбум төгрөг төлсөн.

Ингээд нийт байдлаар бихэлье та бүхэнд. Энэ шинэчлэлийн Засгийн газар байгуулагдсанаасаа хойших 2 жилийн хугацаанд 2 их наяд 600 тэрбум төгрөгийн өр төлөөд байна.

Тэгэхдээ өмнөх Засгийн газраас үлдсэн бүх өр төлөгдсөн үү гэвэл төлөгдөөгүй. Одоо 500 тэрбум төгрөгийн өр үлдэж байна. Юу юу үлдэж байгаа гэдгээ хэлье. Чалкогийн өрийг бид бол бүрэн төлж чадаагүй байгаа, одоо Чалкод 200 орчим тэрбум төгрөгийн өрийг төлж дуусгана. Нүүрсээ гаргаж байгаа. Хуучин 1 тонн нүүрс гаргаад олдог байсан мөнгийг одоо 3 тонн нүүрс гаргаж байж тэр хэмжээний мөнгийг олж байгаа учраас энэ процесс удааширч байгаа.

Тэгэхээр Чалкод 200 тэрбумыг төлнө, Эрдэнэс Таван толгой бол маш их өр зээл тавьсан байсан. Тэр нь 100 тэрбумыг төлнө. Бондын үлдэгдэл 190 тэрбум ингээд 500 орчим тэрбум төгрөгийн өрийг бид нар төлнө. Энэ бол ирээдүй цаг дээр. 2 их наяд 600 тэрбум төгрөгийг бол бид нар төлөөд дуусгалаа. 2 жилд 2 их наяд 600 тэрбум төгрөг гэдэг бол бараг үндсэндээ бид нарын бондын мөнгө шүү. Чингис бонд чинь өөрөө 1.5 тэрбум доллар юм байгаа юм. Энэ чинь өөрөө 2 их наяд 600 орчим тэрбум төгрөг юм байгаа юм.

Тэгэхээр одоо хэдүүлээ энэ танхим дотор би бол 2 жилийн хугацаанд та бүхэнд зөндөө хэлсэн. Тоогоо нэг болгоод, нэг юм ярья л даа. Дандаа л юмыг еэ, еэ, бөөө болохгүй байна гэж хэлдгээ боль л доо. Хамтраад бид нар ард түмэндээ амлачихсан, хэлчихсэн, өгчихсэн, өгч чадаагүй өчнөөн өр зээл байна аа. Энийг чинь бас нэг чардайгаад мардайгаад бид нар нэг юм төлөөд яваад байна аа. Ийм ийм юмаа яагаад ойлгохоо больчихсон юм бэ. Яагаад ингэж их улс төржүүлээд байдаг юм бэ гэж би сайн хэлдэг юмаа.

Ингээд өмнөх өр ширийг орхичихъя. Одоо Чингис бондтой холбоотой би бас хэдүүлээ нэг ойлголттой болъё. За яагаад гэхээр энэ бондыг хэзээ яаж төлөх юм. Нэгдүгээрт нэг ийм юмыг ойлголцох ёстой. За би тоог нь эхлээд хэлье. Чингис бондоос бол 2.5 их наяд хэмжээний төгрөг бий болсон. Өөрөөр хэлбэл түрүүчийн миний хэлдэг 1.5 тэрбум ам.доллар гэдэг бол монгол төгрөгөөр дундажлаад шилжүүлэхээр 2.5 их наяд төгрөг байгаа юм. Ийм хэмжээний зээлийг авсан.

Энэнээс гадна та бүхэн бас мэдэж байгаа. 580 сая ам.долларын евро бонд, 30 тэрбум иений Самурай бонд гээд ингээд нэлээн олон зээл авсан. Энэний мөнгөн хэмжээ нь бол дахиад явсаар байгаад 2 их наяд гаруй төгрөг болж байгаа юм.

Тэгэхээр ийм бараг 4 гаруй их наяд төгрөгийг яаж төлөх юм бэ. Хэзээ төлөх юм бэ гэдэг дээр бас асуудал гарч байгаа. Энийг бид яаж төлөх вэ гэхээр хуваарийг нь гаргуулж үзсэн. Хоёр эх үүсвэрээс төлнө. Энэ гаднаас авчирч байгаа бондын мөнгийг нэг хэсгийг нь бол төсвөөс заавал төлөх ёстой хөрөнгө оруулалт уруу хийж байгаа. Аймгуудын зам, станц энэ бол дандаа төсвөөс төлөгдөх мөнгө болж хөрөнгө оруулалт хийгдэж байгаа.

Нөгөө хэсэг нь цементийн үйлдвэр, гурилын үйлдвэр, гутлын үйлдвэр, ноосны үйлдвэр, ноолуурын үйлдвэр гэх шинжтэй төслийг дэмжсэн арга хэмжээнд энэ зээлүүд явж байгаа. Тийм хоёр эх үүсвэрээс энэ мөнгийг төлнөө. За би төсөв дээр ямар ачаалал ирэхийг та бүхэнд өнөөдөр хэлье.

Зээлийг бол хоёр удаа төлнө, 2017 онд нэг хэсэг мөнгө төлнө, 2022 онд нэг хэсэг мөнгө төлнө. 2017 онд төсөв дээр ирэх, төсвөөс гарах мөнгө бол 660 тэрбум төгрөг. Үлдэгдэл мөнгө нь бол нөгөө арилжааны банкаар дамжуулаад компаниудад өгчихсэн зээлээс төлөгдөнөө нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ өөрөө ямар хэмжээний мөнгө вэ 660 тэрбум төгрөг гэж. Би хоёр тоо хэлье. Энэ жил манай нийт хөрөнгө оруулалт 800 орчим тэрбум төгрөг байгаа. 2017 онд манай нийт хөрөнгө оруулалт бол 1.6 орчим их наяд төгрөг байна. Тэгээд тэрний 30 хувиар нь бид нар зээлээ төлнө гэсэн үг. 2017 онд нийт хөрөнгө оруулалт маань өнөөдөр энэ 800 тэрбум байгаа гэдэг чинь өсөөд 1.6 их наяд болно. Тэрнээсээ 660 тэрбумыг нь бид нар төсвөөсөө гаргаад Чингис бондынхоо мөнгийг төлнөө.

Хоёр дахь нь за би нэг тоо харъя. Хоёр дахь нь бол 2022 онд 1.6 их наяд төгрөгийг төлнө. Тэрнээс Чингис бондын мөнгө буюу төсвөөс бол 1.5 их наядыг төлнө. За та нар бас ингээд асуух байх. Яаж 1.5 их наядыг 2022 онд төлдөг юм гэж. 2022 онд манай улсын эдийн засаг хөгжиж, төсвийн нийт хөрөнгө оруулалт өөрөө 4.5 их наяд болохоор байна. Тэгэхээр 4.5 их наядын хөрөнгө оруулалтаасаа бид нар 1.5 их наядыг нь бол Чингис бондын төлөлтөнд бол өгнөө.

Энэ дээр бол дахиж улс төр хийх шаардлагагүйгээр би та бүхэнд Хөгжлийн банкны энэ бүх тоонуудыг өгмөөр байна аа. Эх орныгоо өр ширэнд оруулчихъя, үр хүүхдээ өртэй болгочихъё гэдэг боддог ширхэг монгол хүн байхгүй.

Өнөөдөр энэ хэмжээний мөнгөөр нь юм босгочих юмсан, бүтээчих юмсан, хийчих юмсан, овойлгочих юмсан, оцойлгочих юмсан, шовойлгочих юмсан гэсэн ийм л хүсэл тэмүүлээр шинэчлэлийн Засгийн газар ажилласан. Үнэхээр яаж ч муулаад одоо нүдэнд бол харагдаж байгаа юмаа.

Улс орны хөгжсөн түүхэн туршлагаудыг бид нар үзсэн. Улс орон ч тэр, компани ч тэр, айл өрх ч бол ингэж л хөгждөг юм байна. Тодорхой хэмжээний зээлийг авлаа, тэрүүгээрээ харин хэрэгтэй юм хийлээ. Үр ашигтай юм хийлээ, тэгээд урт хугацаанд төллөө. Одоо бид нар нэг ийм бодлого гаргах хэрэгтэй байна. 2017, 2022 гээд хоёрхон жил дээр их өндөр мөнгө гарч байгаа. Энийг бид нар жил жилд төлдөг зээл уруу шилжүүлэхээр Засгийн газар бас ажиллаж байна. Тэгэх юм бол нэг жилд төлөх ачаалал бол нэлээн бага болноо гэж ингэж үзэж байгаа юмаа.

Би ийм байдлаар та бүхэнд, та бүхний хэлээд байгаа, санаа зовоогоод байгаа юм уу, зүгээр гуйвуулаад байгаа юм уу мэдэхгүй, тэр бүх зүйлд одоо би хариу өгье гэж бодсон юм. Ингэхгүй бол бид нарын энэ нэг бие биеэ хэмлэсэн, худал үнэн ярьсан, хүмүүст буруу ойлголт өгсөн юм чинь хэрээс хэтэрлээ. Энэ дээр бол зогсоогооч ээ. Ингэснээр бол улс орон хөгжихгүй ээ. Аль болохоор ард иргэдтэй наалдацтай, хүртэцтэй, тэр ажлыг хийж байж манай улс орон хөгжинөө гэж би ойлгож байгаа юмаа.

Би цааш нь үргэлжлүүлээд хэдэн зүйлийг хэлье. Би Ерөнхий сайд, намын даргын хувьд биш, ер нь би хувь хүн гэдэг үүднээсээ та бүхэнд эмзэглэж явдаг нэг зүйлээ хэлье гэж бодсон юм. Бид улс орноороо 25 жилийн өмнө ардчиллын замыг сонгосон. Ардчилсан улс гэж өөрснөө ярьж байгаа. Улс орныхоо хөгжил дэвшлийн төлөө сайдаж муудаж, эвлэж нэгдэж, бас хамтдаа засаг хүртэл байгуулж, зүтгэсээр өнөөдөртөө золголоо. Гэвч яг өөрсдийнхөө бодож, хүсэж, зүтгэж байсан зөв замаараа явж байна уу, үгүй юу гэдгийг эргэж нэг бодож, эргэцүүлэх цаг бас ирж байгаа юм байна. Хэт их улс төржсөн, талцсан, толхилцсон, өөр өөрийнхөө эрх ашгийг нэгдүгээрт эрэмбэлсэн, амин хувийн нэр хүндээ дээдэлхсэн, ашиг хонжоо хайсан, явцуу үзэл, явцуу үйл ажиллагаанууд хэрээс хэтэрлээ.

Өөрийнх нь харалган зорилго л бүтэж байх юм бол өрсөлдөгч нартаа, өрсөлдөгч нарыгаа зохиомол хэрэгт унагаадаг, гүтгэн доромжилдог, нийгмийн шаар шавхруу болгох увайгүй үйлдлүүд хэвийн үзэгдэл мэт боллоо.

Ялангуяа манай зарим улс төрчид энэ хэвлэл, мэдээллийн хэрэгслийг өмчилж, худалдаж авч, хөлслөн ажиллуулж, асар их хэмжээний гүтгэлгийг орон даяар цацдаг боллоо. Хамгийн харамсалтай нь монгол хүний уугуул мөн чанарт хэзээ ч байгаагүй, энэ мэт ёс бус үйлдлүүдэд нийгмийг соён гэгээрүүлэх үүрэгтэй зарим хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, шударга ёсыг тогтоох ёстой хууль хүчний байгууллагууд улс төржиж, буруу зорилготой хүмүүсийн гар хөл болж оролцож байгаа нь өөрийн эрхгүй сэтгэлийг минь их эмзэглүүлж байна аа. Миний сэтгэл тэгэхдээ 2 жил шахуу эмзэглэж яваа. Өнөөдөр ч эмзэглээд байгаа юм биш.

Би өнгөрсөн 2 жилийн хугацаанд гүтгэлэг доромжлолыг бол хангалттай амссан. Дуугуй байна аа гэдэг нь би доройдоо дуугуй байсан юм бишээ. Гагцхүү би монгол төрийн өндөр хариуцлагатай албан тушаалыг хэрүүл тэмцэл, хов живтэй хутгаж бохирдуулахыг, хүссэнгүй учраас хүлцлээ, тэвчлээ 2 жил. Гэвч нэг зүйлд үнэн голоосоо сэтгэл эмзэглэж хэлэхээс өөр аргагүй байдалд хүрлээ. Аавынх нь албан тушаалыг авахын тулд охиныг нь хэрэгтэн болсон мэтээр байнга зарладаг, найзынх нь ажлыг өгүүлэхийн тулд нөхөрлөлийг нь барьцаалдаг эрх мэдлийн төлөөх шунал ардчилсан улсад байж болохгүй дээ.

Бид төрт ёсоор, төрт ёсны мянганаар хэмжигдэх түүхтэй, туршлагатай ард түмэн шүү. Ёс



зүй, хэм хэмжээ гэдэг бол монгол төрийн дархлаа юмаа. Бид монголын улс төрийг зарчим дээр тулгуурласан шударга өрсөлдөөний талбар байлгах ёстой шүү.

Бид монголын улс төрийг хийж бүтээн, хөгжиж дэвшин, нэгдэж хүчирхэгжихийн зорилго дээр суурилдаг болгох учиртай. Бид монголын улс төрийг хувь хүний тавилан, амь насаар дэнчин тавьж, шунал хүслээ гүйцэлдүүлдэг бохир тоглоомын оромж болгох ёсгүй юмаа.

Бид монголын улс төрийг хөмсөг зангидан хэвлэлээр гомдоллож, хүн бүхэн, юм бүртэй тэмцэн хашгирдаг, юу ч бүтээдэггүй, юуг ч бүтээлгэдэггүй хоосон улс төржилт, хийрхэл бухимдлын талбар болгох ёсгүй юмаа.

Эрхэм гишүүд ээ,

Надаас маш олон хүн яагаад Ардын намтайгаа хамтраад цаашаагаа гацаж түгжрээд байлгүй хөгжлийн төлөө хамтдаа зүтгэж болдоггүй юм бэ гээд байнга асуудаг юм. Энэ асуултын хариулт бол ёс зүй, хэм хэмжээний асуудал юм байгаа юм.

Би МАН-ын 90 гаруй жилийн туршлага, зуу зуунаар хэмжигдэх үйл хэргийг нь үгүйсгэхгүй ээ. Гэвч энэ цаг үед эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнол, хөгжил дэвшлийн төлөө хамтдаа, хариуцлага хүлээж, МАН-ыг төлөөлөн энэ танхимд сууж байгаа монгол төрийн түшээд та бүхэнд бас хандаж хэлье.

МАН улс төрийн тэмцэл нэрээр улсаа хорлодог байж болохгүй юм даа.

МАН түмний төлөөлөл гэдгээ умартаж, төрийн ажлыг гацаадаг байж хэрэггүй дээ

МАН ард түмний дайсан бол АН гэж сурталтдаг байж хэрэггүй дээ.

МАН бид л биш бол бусад нь чаддаг байх ёсгүй гэдэг аминч үзэлтэй байж бас болохгүй шүү дээ.

МАН ард түмнээ ардчиллынхан гэж ялган ад үзэн гадуурхдаг байж болохгүй ээ.

МАН төрийн төсвийг намын түрийвч болгодог байж болохгүй ээ.

МАН ард түмний хөрөнгөөр Ардын нам гэсэн хаягтай байшин барилга барьж, өмчилдөг байж болохгүй ээ.

МАН хийж бүтээхийг хөшөө барих гэж ойлгодог байж бас болохгүй ээ.

МАН хөгжил дэвшилд хөшүүн хойрго, хүнд сурталтай ханддаг байж болохгүй ээ.

Эдгээр дутагдлаа ойлгон ухамсарлаж, эх орныхоо язгуур эрх ашгийг улс төрийн ашиг хонжооныхоо өмнө тавих болсон тэр цагт хамтран ажиллахад бэлэн байгаагаа би хувь хүнийхээ хувьд илэрхийлж байгаа.

Ардчилсан Ерөнхийлөгч өө,

Ардчилсан Их Хурлын даргаа,

Эрхэм гишүүд ээ,

Өнөөдөр 2014 оны 11 сарын 5-ны өдөр. Өнгөрсөн 2 жилийн хугацаанд үр дүнгүй улс төрийн хэрүүл тэмцэл хийсээр бүрэн эрхийнхээ хугацааны талыг өнгөрөөсөн гашуун үнэн харамсалтайгаар үргэлжилж байна.

Харин шинэчлэлийн Засгийн газар шүүмжлэл, доромжлолын ширүүн шуурган дундуур Монгол Улсын сүүлийн 20-30 жилд хийгдэж байгаагүй олон бодит ажлыг гарт баригдаж, нүдэнд үзэгдэхүйц үр дүнтэйгээр бүтээн бий болгоод байгаатай хэн ч маргахгүй биз ээ.

Цаашид ч олон бүтээлч ажлуудыг би хүлээж байна. Зам, барилга, үйлдвэржилт, дэд бүтцийн бүтээн байгуулалт улам эрчтэй өрнөж, хоёрхон жилийн дараа гэхэд бид нар 21 аймагтайгаа хатуу хучилттай замаар бүрэн холбогдож, аймаг, сум бүрийн иргэд эмнэлэг оношилгооны төв, дэд бүтцийн асуудлууд нь бүрэн шийдэгдсэн тохилог орчинд амьдарч, монголчууд

бид өөрсний хэрэгцээнийхээ нэлээдгүй хувийг дотоодынхоо чанартай үйлдвэрлэлээр хангадаг болно. Мөн төрийн үйлчилгээ улам шуурхай, нээлттэй болж, төмөр замын бүтээн байгуулалт саадгүй үргэлжилж, шинэ нисэх буудал, цахилгаан станцууд ашиглалтад орноо.

Монголчууд хоёр хөршөөрөө дамжиж далайд гарцтай болж, дэлхийн хамгийн том хэрэглэгч, нийлүүлэгч хоёр хөршөө холбосон транзит тээврийн сүлжээтэй болох ажлуудын бодит эхлэл бас тавигдаад байгаа.

Таван толгойн уурхайн бүтээмж ашиглалтыг эрс нэмэгдүүлж, стратегийн олон том төсөл хөтөлбөрүүдийг шинээр эхлүүлэх ажлууд эрчимтэй өрнөж байна аа. Монгол бол газар нутаг өргөн уудам, газар зүйн байршил онцгой давуу талтай, ард түмэн нь авьяас билэгтэй, ахуй соёлын өвөрмөц зан заншилтай ард түмэн юмаа.

Монгол бол найрсаг гадаад харилцаа, нээлттэй чөлөөт эдийн засаг, шавхагдашгүй байгалийн асар их баялаг, эрх чөлөөт ардчилсан засаглалтай ард түмэн. Монгол бол хөгжлийн зам дээр нэгэнт гарч, хүн төрөлхтний эдийн засгийн гол тоглогч болох нөхцөл боломж нь дүүрэн бүрдсэн ард түмэн. Одоо хоорондынхоо явган хэрүүл, танай манай гэсэн явцуу өрсөлдөөн, тольхилцож, түлхэлцсэн жижиг эрх ашгаа хойш тавьж, нэгэн зүгт зорин зүтгэвэл монголын маргааш илүү гэрэлтэй, дэлхийд тэргүүлэгч эдийн засагтай улсуудын нэг болох боломж тун их ойрхон харагдаж байна даа.

Би Ерөнхий сайдын хувьд Монгол Улсын ирээдүйг дараах 3 чиглэлээр хөгжүүлэх үндсэн зорилго тавин ажилласан билээ.

Монгол хүний хөгжил, эдийн засгийн хөгжил, нийгмийн хөгжил гэсэн 3 зүйл дээр анхаарах ёстой. Монголчууд бид нэн яаралтай өөрийнхөө монгол үндэстний онцлог шинжийг тодорхойлж, ард түмнээрээ нэгдмэл үнэт зүйл, хүсэл тэмүүлэлтэй болох энэ ажлыг бид хийнээ.

Монгол иргэний үнэлэмжийг өсгөх, суурь судалгааны ажлуудыг нэгтгэж, монгол хувь хүний хөгжлийн түгээмэл хэм хэмжээг тодорхойлж дэвшүүлнээ. Монгол хүн бүрийг боловсрол, эрүүл мэндийн үзүүлэлтээрээ дэлхийд дээгүүр өрсөлдөх нөхцөл боломжийн төлөө ажилланаа.

Эдийн засгийн хувьд. Дэлхийн эдийн засгийн шинэ төв болж байгаа хоёр хөршөө хооронд нь холбосон транзит тээвэр, санхүүгийн зах зээлийн гол тоглогч улс орон болно. Уул уурхайн баялгаас олсон орлогоороо бааз сууриа бүрдүүлж, эко хүнс үйлдвэрлэл, боловсрол, шинжлэх ухаан, интернет технологийн салбар нь дэлхийн хэмжээнд өрсөлддөг улс болно.

Монголчууд бид өөрсдөө бүтээгч, үйлдвэрлэгч ард түмэн болж, тэргүүлэгч эдийн засагтай ард түмэн болно. Нийгмийн хөгжлийн хувьд монгол иргэн бүр эрүүл аюулгүй, эрдэм боловсролтой, элбэг хангалуун амьдрах бодит нөхцөлөөр хангагданаа. Монгол орныхоо өргөн уудам газар нутгийнхаа хаана ч дэд бүтцийн асуудлаа бүрэн шийдсэн тохилог орчинд тухтай амьдрах боломжтой болно.

Энэ бүхэн шинэчлэлийн Засгийн газрын маань хийж бүтээх ажлын гол алсын хараа юмаа. Бид эх орноо хөгжил дэвшил, хүсэл зорилгод нь хүргэхийн төлөө цаг нартай уралдан, амралтгүй, хагас бүтэн сайнгүй ажилланаа. Миний бие монгол оронд гэрэлтэй өдрүүд олон бий гэдэгт итгэлтэй байгаа. Бидний хийх ёстой үүрэгт ажлын ердөө хагас нь л хийгдлээ. Хийж бүтээх итгэлийн галыг монгол хүний сэтгэлд асааж чадсан энэ цаг үе зогсолтгүй үргэлжлэх ёстой гэж би бодож байгаа. Бөхөх ёсгүй тэр галыг унтраахгүйн тулд төлөвлөсөн ажлаа хийх цаг бидэнд хэрэгтэй байна аа. Үлдсэн хугацаанд хаашаа явах, хаа хүрэх маань тодорхой байна. Улс төр, намчирхал, үл ойлголцлыг хойш нь тавьж, хийж бүтээхэд гол анхаарал, хүсэл тэмүүлээ нэгтгэх, хойшлуулшгүй нөхцөл байдал үүсээд байна аа.

Би АН-ын гишүүд, Шударга ёс эвслийн бүлгийн гишүүд, бие даагчиддаа хандан, дахин гүн

талархлаа илэрхийлье. Бидний 2 жилийн хугацаанд хийсэн, олсон бүх ололт амжилт бол та бүхэнтэй салшгүй холбоотой, та бүхний минь хамтын зүтгэл байсан юмаа. Манай Ардын намынханд бас талархлаа илэрхийлье. Та бүхний маань гүтгэлэг биш, бодитой шүүмжлэл бол бас алдаа дутагдлыг засахад үнэхээрийн их нэмэр болсон гэдгийг би хэлье.

Төгсгөлд нь эвсэл болоод АН-ын гишүүддээ хандахад МАН-ын санаачилсан 4 үндэслэлээр Засгийн газраа огцруулахгүй байхыг би та бүхнээс хүсэж байна аа. Бидэнд цаашаа хийх ажил зөндөө их байна. Дотроо хэл амаа ололцоод явах өргөн дүүрэн боломж байна аа. Тэрийгээ нам дотроо, эвсэл дотроо яриад шийдэж чаднаа гэдэгт би итгэлтэй байна аа.

Ард түмний язгуур эрх ашиг, би төгсгөлд нь энэ үгийг хэлье гэж бодсон юм. Ард түмний язгуур эрх ашиг гэж юу юм бэ. Эв нэгдэл, харилцан ойлголцол, эрх чөлөөн дээр суурилсан нийтлэг үнэт зүйл ирээдүйд итгэх итгэл юмаа. Энэ итгэл дээр бидний хойч үе хөгжин дэвшиж, эдийн засаг өсөн дээшилж, нийгмийн хөгжил цэцэглэх болноо. Энэ бол монголын ард түмнийхээ өмнө хүлээсэн үүрэг, зүтгэх зүтгэлийн минь шалтгаан юмаа. Ард түмнийхээ язгуур эрх ашгийг би эцсээ хүртэл өмөөрнө, өмгөөлнө, хамгаалнаа.

Бидний монгол үүрд мандан бадраг ээ.

\* \* \*

**Чуулганы хуралдаан дээр Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэгийн хэлсэн үг**  
(2014.11.21)

Монгол Улсын Ерөнхийлөгч,  
Улсын Их Хурлын дарга,  
Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхий сайдын хүндтэй, хариуцлагатай албанд томилох шийдвэр гарган дэмжсэн Ардчилсан намын болон Ардчилсан намын Үндэсний зөвлөлдөх хорооны нийт гишүүд, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн бүх гишүүдэд, 2012 оноос эхлэн хамтарсан Засгийн газрыг байгуулан хүчин зүтгэж байгаа МАХН-МУАН-ын “Шударга ёс” эвсэл, эвслийн бүлгийн нийт гишүүд, ИЗНН -ын парламент дахь гишүүд, бие даагч гишүүддээ болон өнөөдөр сэтгэлийнхээ үг, захиас, саналыг харамгүй хайрласан та бүхэндээ юуны өмнө гүн талархлаа илэрхийлье.

Мөн нэг их зорилгын төлөө хоёргүй сэтгэлээр хамтран нэг баг болж зүтгэсэн Монгол Улсын 27 дахь Ерөнхий сайд Норовын Алтанхуяг, Засгийн газрын нэг танхимын нийт нөхөддөө сайн сайхныг хүсэж, та бүхний бүтээлч, хөдөлмөрч, уйгагүй, шинэчлэлийн бусад ажлуудыг үргэлжлүүлэн ажиллана гэдгээ илэрхийлж байна. Өнөөдөр санал хураалтад хэдийгээр оролцоогүй ч Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн хурлаар бүтэн зургаан цагийн турш улс орны өмнө тулгамдаад байгаа асуудлууд, шийдвэрлэх арга замын олон асуудлаар санал нэг байсан Монгол ардын намын бүлгийн гишүүд та бүхэнтэй ч улс орны эрх ашигтай холбоотой олон чухал асуудлаар цаашид хамтран ажиллах шаардлага гарна гэдэгт итгэж байгаагаа энэ дашрамд илэрхийлье.

Надад их итгэл хүлээлгэн, намайг Улсын Их Хуралд зөвшилцөн оруулж, хэлэлцүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчид талархлаа илэрхийлэхийн ялдамд хэдхэн хоногийн өмнө Ардчилсан намын шинэ даргаар сонгогдсон Улсын Их Хурлын даргад бас баяр хүргэж, Монгол Улсын үндэсний эрх ашиг, ард иргэдийнхээ сайн сайхны төлөө та бүхэнтэй мөр зэрэгцэн, нэг баг болж, их үйлсийн төлөө хамтран зүтгэж чадна гэдгээ энэ индрээс бас илэрхийлж байна.

Монгол Улсын шинээр томилогдсон Ерөнхий сайдын хувьд шинэ Засгийн газар чухам юуг хийж бүтээх талаар товч үг хэлье.

Хүн бүр янз бүрээр ярьж, маргалдаад байгаа хүндрэлтэй, хэцүү байдал, эдийн засгийн эсвэл төлбөрийн тэнцлийн хямрал гэдэг эцэс төгсгөлгүй маргаанаа орхиод улс орон хямралтай байгаа гэдгийг юуны өмнө шууд хүлээн зөвшөөрцгөөе.



Монгол Улсын Ерөнхий сайд Чимэдийн Сайханбилиг

Төгрөгийн ханш суларлаа, хөрөнгө оруулалт огцом буурлаа, аж ахуйн нэгжүүд хаалгаа барьж байна, өрийн сүлжээ газар авлаа гэсэн эцэс төгсгөлгүй олон зүйлсийг энд дахин нуршмааргүй байна. Харин одоо үүсээд байгаа нөхцөл байдлаас хэрхэн гарах вэ гэдэг чухал. Шинээр байгуулагдах Засгийн газрын тэргүүлэх, гол чиглэл юу байх вэ.

Шинэ Засгийн газар гурван чиглэлд ач холбогдол өгч ажиллана. Үүнд, нэгдүгээрт, эдийн засаг, хоёрдугаарт, эдийн засаг, гуравдугаарт, мөн эдийн засаг байх болно. Эдийн засгийн энэхүү асуудлын угтвар нөхцөл нь улс төрийн тогтвортой байдал, дагавар үр дүн нь ард иргэдийн аж амьдрал байх болно. Шинэ Засгийн газрын гурван гол шинж. Нэгдүгээрт, дэмжлэгтэй Засгийн газар, хоёрдугаарт, шийдлийн Засгийн газар, гуравдугаарт шуурхай Засгийн газар байх болно.

Нэгд, энэ хямралаас бид зөвхөн олон жил хурсан хүнд асуудлуудыг шийдэж байж л гарна. Хүнд шийдвэрийг гаргахад хүссэн хүсээгүй парламент дахь дийлэнх олонход тулгуурлах учиртай.

Хоёрт, бидний гаргах шийдвэрийг хэзээ ч 100 хувь алга ташин хүлээж авахгүй нь ойлгомжтой. Зарим шийдвэр өнөөдөр утгагүй, алдаатай мэт санагдавч маргааш нь үр дүнгээ өгөх шийдвэрүүд ч биднийг хүлээж байгаа. Улс төрөөс болж олон жил хойш тавьсан хулгасан, халгасан энэхүү хэцүү шийдвэрүүдийг бид гаргаж гэмээн хямралаас гарах хугацаа наашлуулна. Гол нь шийдэл гаргах чадвар, зориг зүрх бүхий шийдлийн Засгийн газар бий болох учиртай.

Гуравдугаарт, танхим шуурхай ажиллах ёстой. Эдийн засгийн чухал асуудлыг штабын маягийн зохион байгуулалт, хурдаар шийдэх ёстой. Шинэ Засгийн газарт цаг хугацааны “Аль болох хурдан” гэдэг ганцхан хэмжээс үйлчлэх болно.

Ерөнхий сайдын зүгээс өдөр тутмын салбарын асуудлуудын эрх мэдлийг сайдад бүрэн шилжүүлж, зөвхөн эдийн засгийн хүндрэлтэй асуудлуудад гол анхаарлаа хандуулна. Ийм сайд болгон салбартаа Ерөнхий сайд шиг ажиллах учиртай. Бид үүсээд байгаа хямралаа зөв оношлох хэрэгтэй бөгөөд энэ нь мэдээж гадаад хүчин зүйлтэй холбоотой гэдгийг хэлсэн.



Манай гол экспортлогч Хятадын эдийн засгийн өсөлтийн хурд саармагжсан, нүүрс, төмрийн хүдрийн үнэ унасан. Саяхнаас алтны үнийн огцом уналт байдлыг улам дордуулж байна. Гэхдээ энэ хямралын гол буруутан нь бид өөрсдөө. Өнөөдрийн энэ хямрал нэг өдрийн дотор бий болоогүй. 2007-2008 оны нүүрсний болон зэсийн үнийн огцом өсөлт биднийг тэрүүхэн хугацаанд олсныхоо хэрээр зардлаа өсгөдөг муу занд сургаж амжсан.

Оюу толгойн анхны хөрөнгө оруулалт, долларын их урсгал биднийг дандаа ийм байх юм шиг, дангаараа бид хөгжиж чадах юм шиг ойлголтыг ч зарим хүмүүст төрүүлсэн. Сонгуулийн бэлэн мөнгөний том амлалтууд, түүний хэрэгжилт, улс төр тойрсон популизм, арилжааны зээлийг бүгдэд нь бэлнээр тараадаг шинэ үзэгдэл өнөөдрийн энэ байдлын үндсэн шалтгаануудын нэг болсон юм. Нөгөөтэйгүүр эргэн харахад гадаадын хөрөнгө оруулалтыг үргээх чиглэлээр бид хамтдаа нэлээд хүчин зүтгэл гаргаж иржээ. Тухайлбал, 2012 оны Улсын Их Хурлын сонгуулийн өмнө Стратегийн салбарын хөрөнгө оруулалтын тухай хууль, “Урт нэртэй” хуулиудыг баталж, хөрөнгө оруулагчдаа бид цочирдуулсан. Хайгуулаар орж ирдэг хөрөнгө оруулалтынхаа урсгалыг зогсоосон. 106 лицензийг шүүхээр цуцалж, түүнийг тойрсон олон улс дахь үр дагавар, Оюу толгойг тойрсон эрүүл бус улс төржилт, Тавантолгойн төслийг гацаасан үйл явдлын өрнөлт, улс төрчдийн цагаа олоогүй, популизм нэвт ханхалсан хэвлэлийн бага хурлууд, гадна дотны хөрөнгө оруулагчдыг хорьсон, барьсан, цагдсан хууль хяналтын байгууллагатай холбоотой мэдээнүүд энэ бүхнийхээ төлбөрийг бид өнөөдөр өөрсдийнхөө халаасанд байгаа монгол төгрөгөөрөө, эдийн засгийн өсөлтийнхөө аажмаар буурч байгаа дүнгээр төлсөөр байна.

Одоо улс төрөө хойш тавьж, ултай, суурьтайгаар асуудлаа шийдэх цаг болжээ. Энэ хямралыг бид өөрсдөө бий болгосон. Энэ хямралыг бид өөрсдөө засах ёстой. Энэхүү хямралаас яаж гарах вэ. Хямралаас гарах үйл ажиллагаагаа хоёр түвшинд авч үзэх ёстой.

Нэгдүгээрт, урт болон дунд хугацаанд хийх ажлууд.

Бид эдийн засгаа системээр нь нэг оношлох цаг болсон. Нартай өдөр найрлаж, бороотой өдрүүдэд нь бөмбөгнөн суудаг байдлаасаа одоо гарцгаая. Бороотой өдрүүд эхлэхэд хөрөнгийн хангалттай нөөцтэй, менежментийн зөв тогтолцоотой, эрсдэлийн шуурхай удирдлагатай эдийн засгаа одооноос бий болгох учиртай. Эдийн засгаа солонгоруулах бодлогоо жинхэнэ ажил хэрэг болгоцгооё.

Эхний ээлжид аялал жуулчлал, мэдээллийн технологи, хөдөө аж ахуй. Тэр дундаа мах, ноолуурын салбараа уул уурхайгаа зэрэгцүүлж хөгжүүлэе. Урт болон дунд хугацааны бодлогоо зангидах эдийн засгийн үндэсний зөвлөлийг Ерөнхий сайдын дэргэд эрдэмтэн, судлаачид, эдийн засагчид, бизнесийнхэн, гадна, дотны зөвлөхүүдийг оролцуулан байгуулах болно.

Хоёрдугаарт, ойрын хугацаанд хийх ажлаа танилцуулъя.

Энэ ажлын үндсэн суурь нь 2014 онд Улсын Их Хурлын 34 дүгээр тогтоолд заасан арга хэмжээнүүдийг бүрэн утгаар нь хэрэгжүүлэх үйл ажиллагаа болох учиртай. Юуны өмнө хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээл хоёрын зөв хослол дээр суурилсан өрийн удирдлагын шинэ тогтолцоог бий болгоно. Засгийн газрын гадаад өрийн үйлчилгээний цогц төлөвлөгөөг боловсруулж, энэ хүрээнд төсвийн зохистой бодлого болон өрийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх, макро эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг хангах арга хэмжээг тусгах болно. Бидэнд өнөө маргаашдаа бэлэн мөнгөний шинэ урсгал яаралтай бий болгох бодит шаардлага байна. Энэ оны эхнээс эхэлсэн ажлаа дуусган, хөрөнгө оруулалтын сангаа байгуулна. Мөн зарим арилжааны банкны гаднаас хөрөнгө босгох, одоо явагдаж байгаа ажлыг Засгийн газрын зүгээс идэвхтэй дэмжинэ. Мөн зарим томоохон төслийг хөдөлгөснөөр

урьдчилгаа төлбөрийн асуудлыг шийднэ. Ингэснээр америк долларын ханшийн өсөлтийн эсрэг эерэг дохиог зах зээл дээр өгөх юм.

Нөгөө талаас долларын ханшид сар тутам 100 сая долларын дарамт учруулдаг шатахууны импортод яаралтай хоёр арга хэмжээ авах шаардлагатай байна. Ирэх 12 дугаар сард багтаан ОХУ-ын Төв банктэй рублийн своп хэлцэл байгуулна. Нөгөөтэйгүүр ОХУ-тай хийх гадаад худалдаагаа рублээр хийдэг тогтолцоонд шилжүүлнэ. Ингэснээр манай долларын хамгийн том зардал болох шатахууны зардал рубльд шилжиж, ханш нь шууд эерэг нөлөөлөл бий болох юм.

БНХАУ-ын дарга Си Зиньпиний Монголд айлчладаа амласан нэг тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийг бид авч, эргэлтэнд оруулах учиртай. Бид цаашдаа алдаан дээрээсээ суралцан 30, 40 жилийн дараа төлөгдөх бага хүүтэй, урт хугацааны хөнгөлөлттэй зээлээр зам, төмөр зам болон дэд бүтцийн удаан хугацаанд үр ашгаа өгдөг, нөхдөг төслүүдийг санхүүжүүлэх харин бондын, богино хугацаатай, хүү харьцангуй өндөр зээлээр үйлдвэрийн төслүүдээ санхүүжүүлж байх зарчимд шилжицгээе. Дээрх хөнгөлөлттэй зээлийг авснаар зам болон төмөр зам руу хийсэн Чингис бондын хөрөнгөө суллаж авах бололцоотой болох юм. Суларсан бондын мөнгөө хувийн хэвшлийнхэнд зориулсан хөрөнгө оруулалтын баталгааны сан байгуулах, үр ашиг бүхий экспортыг дэмжсэн, импортыг орлосон үйлдвэрлэлийн төслүүдийг санхүүжүүлэх, 2017 оноос эхлэн хийгдэх бондын төлбөрийг төлөх бэлтгэлээ хангахад тус тус зориулах боломжтой болно.

Хамгийн гол нь хямралаас бид хувийн хэвшлээ дэмжиж, хувийн бизнесийг дэмжсэн бодлогоор л гарна. Бизнесийн орчинг ээлтэй болгох бодлогоо эрчимжүүлж, тусгай зөвшөөрөл, лицензийн хуулиа баталж, хяналтын реформоо дуусган, бизнесийнхэнд үзүүлж буй хууль, хяналтын байгууллагууд, татварын гаалийнхны дарамтыг хөнгөлөх ажлаа бодитой үр дүнд хүрэх ёстой. Энэ хүрээнд Эдийн засгийн ил, тод байдлын тухай хуулиа бид бас батлах ёстой. 2008-2009 оны санхүүгийн хямралын үед бусад орнуудад үр дүнтэй хэрэглэсэн "Bail Out"-ын аргыг одоо бид хэрэглэх цаг болсон. Компаниуд банкнаас нэмж зээл авах, барьцаалах хөрөнгө үндсэндээ байхгүй болж, бие биедээ авлага, өглөгийн асар том сүлжээг үүсгээд байна. Иймд компанийн хувьцаа, өөрийн үнэлгээг барьцаалан зээлжих шинэ бололцоог энэхүү арга хэмжээний хүрээнд бий болгож, энэхүү үйл ажиллагаагаа үр дүнд хүрэх учиртай.

1990-ээд оны эхээр хүн болгон ганзганд гарч байсан шиг компани болгон гаднаас хөрөнгө босгохоор гарах цаг иржээ. Манай хувийн хэвшлийнхэн хүч, хөдөлмөрөө гарган Тэвшийн говийн болон Бөөрөлжүүтийн тус бүр 600 мегаватт цахилгаан станцын төсөлд нийт 2 гаруй тэрбум ам.долларын хөрөнгийг өөрсдөөсөө босгож чадлаа. Цаашид энэ мэтийн хувийн хэвшлийнхний оруулж ирэх ийм хөрөнгө оруулалтуудыг дэмжиж, төрөөс баталгаа гаргах тусгай санг яаралтай бий болгох шаардлагатай байна. Бид тамын тогооны үлгэрээ орхиж, одоо төр засгийн төр засгийн бодлогоор үндэсний компаниудаа гаргаж ирэх цаг болжээ. Энэ компаниудын ард 1000 дунд хэмжээний, тэдний ард 10 мянган жижиг аж ахуйн нэгж өөрөө өндийх болно. Орон сууцны моргейжийг бид ярьж, эхлүүлж чадсан. Одоо жижиг, дунд бизнесээ дэмжин бизнесийн моргейжийг гаргаж ирэх цаг нь болжээ. Бид том төслүүдээ урагш нь түлхэнэ.

Нүүрснээс хий, шингэн гаргах, хос төмөр зам барих, талын зам төслүүдээ урагшлуулж, ирэх жилдээ 900-1200 мегаватт чадал бүхий цахилгаан станцуудын хоёр төслөө эхлүүлнэ. Улаанбаатарын хурдны зам, шинэ онгоцны буудал, нисэх буудлын хурдны зам болон Дорнод, баруун таван аймгийг холбосон замын төслүүдээ 2016 оноос өмнө амжуулна.

Монгол руу хөрөнгө оруулах сонирхол бүхий 180 компаниас авсан судалгаагаар 140 нь

“Оюутолгой, Тавантолгойн асуудал хэрхэн шийдэгдэхээс тэдний шийдвэр шалтгаална” гэж хариулсан байна. Бид урт нас, удаан жаргалтай энэ хоёр төслөө улс төрийг нь орхиж, бизнесийн утгаар нь хүссэн хүсээгүй шийдэх учиртай. Шинэ Засгийн газар энэ хоёр төслийг хөдөлгөх шийдвэрээ удахгүй Улсын Их Хуралд танилцуулан, энэ хоёр асуудлыг нэг тийш болгоно. Оюу толгой, Тавантолгойн араас Засгийн газар дэлхийн санхүүгийн төвүүд болох Хонконг, Нью-Йорк, Лондонд хөрөнгө оруулалтын чуулга уулзалтуудыг хувийнхантайгаа хамтран зохион байгуулж, Монгол руу чиглэсэн хөрөнгө оруулалтын итгэлийг нэмэгдүүлэх идэвхтэй үйл ажиллагааг явуулна. Бид олон жил Оюу толгой, Тавантолгой гэж ярилаа. Одоо ядаж 2-3 стратегийн шинэ орд газрыг нэмж хөдөлгөх цаг болсон. Ингэж байж л баялгийн сан зохих хөрөнгөтэй болно. Монгол хүн бүрийн гар дээр байгаа хувьцаа үнэтэй, утгатай болно.

Гаднын хөрөнгө шууд орж ирдэг хайгуулын үйл ажлыг зөв зохион байгуулах учиртай. Зэрлэг капитализм шиг хэн, хаана ч хамаагүй аргаар бус үе шаттай зөв зохион байгуулалттай зарчим дээр суурилсан бодлоготойгоор энэ ажлаа ирэх хавраас эхлүүлэх бэлтгэлийг хангана.

Саяхан Улсын Их Хурал 2015 оны төсвийг ялангуяа урсгал зардал талдаа нэлээд танаж баталсан. Зөв зүйтэй энэ алхмыг үргэлжлүүлж, хүссэн хүсээгүй шинэ Засгийн газар ирэх оны төсвийг орлого талд нь дахин нэг их наяд төгрөгийг асуудлыг төсвийн тодотголоор бодитой болгож, бууруулж оруулж өөр аргагүй болно. Мэдээж шинэ орлого, урсгал орж ирвэл бид зарах зүйлээ амархан олдог. Гэхдээ одооноос бид асуудлаа амьдралд ойртуулж, бодитой төлөвлөх ёстой. Хөрөнгийн биржээ хөдөлгөөнд оруулж, хоёр дахь зах зээлийг хувийн хэвшил, иргэдээ дэмжих асуудлыг барьж авах цаг болсон.

Төрийн өмчийг эзэнжүүлэх асуудал бидний гол анхаарлаа хандуулах асуудал. Хувьчилсны дараа төр ядаж 51 хувийг эзэмшдэг одоогийн хувилбарыг шинэчилнэ. Төр үнэхээр хувь эзэмших шаардлагатай бол хяналтын багцын 34 хувь байхад л хангалттай. Харин тухайн компанийн төрийн өмчийн 51 ба түүнээс дээш хувийг хувийнхан эзэмшиж, менежментийг нь хариуцдаг шинэ зарчимд шилжинэ.

Хувьчлалын дараах төрийн өмчүүдээ нэгтгэн Сингапурын “Темасек” маягийн тогтолцоонд шилжин хувь, хувьцаа, хөрөнгө, хэрэглээн дээр нь суурилсан шинэ баялгийн санг байгуулж, ард иргэдээ хөрөнгөжүүлэх нь манай хөгжлийн зөв зам байх болно. Төрийн өмчийг эзэнжүүлэх ажил зөвхөн бизнесийн салбараар хязгаарлагдах учиргүй. Нийгмийн салбарт хувьчлалыг эхлүүлж, үйлчилгээнд компанийн засаглалын шинжийг нэвтрүүлэх гол реформыг бид эхлүүлнэ. Биднийг 2017 онд зөвхөн бондын эргэн төлөлт хүлээж байгаа ч юм биш. Нийгмийн даатгалын сан дээрх өр төлбөр 2017 оноос өөрийгөө мэдрүүлж эхэлнэ. Иймд Нийгмийн даатгалын санг шинэ зохион байгуулалтад оруулж, Скандинав, Чилийн туршлагаар менежментийг нь өөрчилснөөр хөрөнгө оруулалтын сангийн шинэ төрхөнд оруулна. Ингэснээр 2017 оноос бондын өрнөөс гадна нийгмийн даатгал, тэтгэвэр гэсэн дараагийн нуман тулгуураас гарах эхлэлээ бид одооноос базаах учиртай.

Эрхэм гишүүд ээ,

Уинстон Черчилль дэлхийн хоёрдугаар дайны өмнөхөн Английн ард түмэнд хандан хөлс, цус, нулимс гурвыг л амлаж чадах нь гэж хэлж байсан. Түүнтэй нэгэн адил энэ хямралаас бид ойлголцол, шийдэл, зүтгэл гурваар л гарч чадна. Засгийн газар үнэхээр зовлонтой шийдвэрүүд гаргахаас өөр аргагүй болно. Улсын Их Хурал ч улс орноо бодож, улс төрөө хойш тавьж, биднийг дэмжиж өгөөрэй гэж та бүхнээс хүсье.

Зарим хүмүүсийн ярьдагчлан бид хийдгийн хомсдолд ороогүй. Бид шийдвэр гаргалтын

хомсдолд ороод байна. Засаг солигдох саяны хоёр долоо хоногт хэвлэл мэдээлэл, социал ертөнцөд жинхэнэ амралтын улирал өрнөлөө. Нийгэм асар их талцлаа, арай дэндүү улс төржлөө. Одоо ах дүү нараа, амралтын улирал өндөрлөсөн. Хүнд хэцүү, хямралаас гарах ажлын үе эхэлж байна. Бөхийн ямар ч засуул атаархмаар бие биенээ цоллохоо больж, ажил бизнес, ахуй амьдралаа дээш татах ажилдаа шамдан орцгооё. Хүн будах биш, ажил бодох цаг ирлээ. Хувь хүн, хувийн хэвшил, төр засаг дор бүрнээ шамдацгаая. Одоо цалгардаж болсон. Яам, тамгынхан өнөөдрөөс эхлэн үндсэн ажилдаа ханцуй шамлан орцгоо. Өнөөдөр засгийн газрын ээлжит бас хуралдаан болно. Шинээр томилогдсон Ерөнхий сайдын хувьд одоо танхимаа бүрдүүлэх ажилдаа шууд орно. Ардчилсан намын Үндэсний зөвлөлдөх хорооноос өгсөн чиглэлийн дагуу бид парламентад суудалтай бүх улс төрийн хүчинтэй шинэ Засгийн газар байгуулах асуудлаар ирэх өдрүүдэд зөвшилцөнө.

Нэг хэсэг нь эрх барьснаараа, нөгөө хэсэг нь хурц шүүмжилснээрээ рейтинг, нэр хүнд нь суга өссөн зүйл хэнд нь ч алга. Харин улс төрийн намуудын энэ их талцалд гутарсан, итгэл алдарсан олны тоо нэмэгдэх хандлагатай байна. Энд манай, танай гэдэг эрх ашгаас илүүтэй яаж ч даамжирч мэдэх хямралыг хэрхэн шийдэх вэ гэдэг асуудал, нөгөөтэйгүүр улс төрийн намуудаас илүү зохион байгуулалтын болон хүний нөөцийн олонлог, хариуцлагаа бүрэн ухамсарлаж, хүлээдэг өөр хүчтэй нэгдэл байхгүй гэдгийг нийгэмд ойлгуулах журам дүрэм л биднийг хүлээж байна. Энэ үүргийг бид олонх цөөнх болж, хагарч бутрах замаар бус хамтарч, нэгдэх замаар л биелүүлж чадна. Бид 2008-2009 оны үүнээс хүнд санхүүгийн хямралыг хамтдаа ингэж л нийлж гарч ирсэн.

Монгол Улс маань гуравхан сая хүн амтай. Аравхан тэрбум ам.долларын эдийн засагтай улс. Бодлогын зөв өөрчлөлт, гацсан ганц, хоёр асуудлыг байрнаас нь хөдөлгөх, урагшлуулсан ганц хоёр гуравхан том төсөл бидний хямралт байдлыг эрс өөрчлөх болно. Тийм учраас үүрэг хариуцлагаа ухамсарлая. Хэрэгтэй шийдвэрүүдийг зориг, зүрхтэй гаргацгаая. Өөдрөг байж, итгэл үнэмшлээ эргүүлж олж авцгаая. Хамгийн гол нь эв нэгдлийг эрхэмлэж, эх орноо бодон хамтдаа зүтгэцгээе. Монгол орныг минь хөх тэнгэр нь мөнхөд ивээх болтугай.

Анхаарал тавьсанд баярлалаа.

\* \* \*

### Чуулганы хуралдаан дээр Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн хэлсэн үг

(2015.01.09)

Эрхэм хүндэт ард иргэд ээ,  
Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд аа,  
Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд ээ,  
Эрхэмсэг хатагтай, ноёд оо.

Шинэ он гараад удаагүй байна. 2015 оны ажлын анхны бүтэн долоо хоног үргэлжилж байна. Иймээс эхлээд өнгөрсөн жилийн тухай өнгөрсөн жилийнхээ ажлыг товч дүгнэж ярья гэж бодож байна. Манай малчид нэгдэл хувьчлагдсанаас хойш мал сүргийнхээ тоог анх удаа хоёр нугалж өсгөлөө. Тариаланчид, ногоочид маань бахдам сайхан амжилт гаргалаа. Сүүлийн 17 жилд байгаагүй арвин ургац хурааж авлаа.

Манай Улсын худалдааны тэнцэл эерэг гарлаа. Үүнд эдийн засгийн агшилт, хөрөнгө оруулалтын бууралт нөлөөлсөн тал бий. Гэвч бид дотооддоо илүүтэй хийж бүтээж үйлдвэрлэж эхэллээ. Эдийн засгийн хямралт байдлыг сөрж, Монголдоо хийж, бүтээж үйлдвэрлэж болох юм байна гэсэн итгэл манай иргэд, бизнес эрхлэгчдэд бий болж байна.

Энэ бол их сайн мэдээ. Баялгаа боловсруулалгүй гаргавал хямралд бүтэн өртдөг, хагас



боловсруулаад зарвал хагас хямардаг, бүтэн боловсруулж чадвал хямралд бага өртдөг, харин өөрсдөө үйлдвэрлэж бүтээж өөрийн болон бусдын хэрэгцээг хангаж чадвал хөгжил ирдгийг бидний явж ирсэн зам, сургамж бэлээхэн нотолж байна.

Гадаад бодлогын орчинд ч бид өнгөрсөн онд ахиц амжилттай байлаа. Хоёр хөрштэйгээ харилцах бидний харилцаа идэвхжиж сэргэх бодитой эхлэл тавигдлаа. Манай хоёр хөршийн төрийн тэргүүн тус бүрийн айлчлалаар тал талын харилцаанд хүлээгдэж байсан олон асуудлыг дээд түвшинд хэлэлцэж ойлголцож, бас шийдвэрлэж чадлаа. Мөн олон асуудлыг цаашид шийдвэрлэх эхлэл тавигдлаа. Айлчлалын үр дүнг баталгаажуулж хийх ажил их байгааг энд сануулъя.

Зөвхөн хоёр талын бус Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын төрийн тэргүүн нарын гурвалсан дээд түвшний уулзалт манай орны санаачлагаар анх удаа 2014 онд боллоо. Энэхүү өндөр дээд түвшний уулзалт цаашдаа тогтмолжино. Мөн хэлэлцэж, шийдвэрлэх асуудлын хүрээ, агуулга тодорхойлогдож гурвалсан болон талуудын хооронд яриа хэлэлцээ, уулзалтууд ид явагдаж байна. Энэ бол Монгол Улсын хувьд хоёр хөрштэйгээ харилцан ашигтай хамтран ажиллах, гурван талын зайлшгүй оролцоотой шийдвэрлэх асуудлаа тодорхойлж, ахиц дэвшилд хүрэх ховор боломж юм.

Өнгөрсөн онд хоёр хөршийнхөө төрийн тэргүүнийг эх орондоо амжилттай хүлээн авсан манай улс ирэх жил 2016 онд хоёр тивийн, тодруулж хэлбэл Ази, Европын төр засгийн тэргүүнүүдийн ээлжит уулзалтыг хүлээн авах бэлтгэл ажилдаа ороод байна. Мөн манай гуравдагч хөршүүдийн харилцаа, хамтын ажиллагаанд ахиц дэвшил арвин байлаа. Анх удаа эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр амжилттай хийгдэж, хоёр талын асуудлууд шийдэгдэж, зарим гэрээ, хэлэлцээрийг Улсын Их Хурал соёрхон баталлаа. Улс орныхоо нэрийг сайнаар гаргах эрхэм үйлсэд хичээн зүтгэсэн нийт дипломатууд, ажлын хэсэг, албаны хүмүүст энэ хүндэт индрээс талархал илэрхийлье.

Манай иргэн бүрийн амжилт бол Монголчуудын нийтлэг ололт юм. Хүмүүс ажил амьдралдаа ахиц дэвшил гаргахын төлөө цаг нартай уралдан зүтгэсээр байна. Хамгийн гол нь хүн бүр хувь заяандаа эзэн болж ажлаа сайн хийж чадвал энэ л манай орны өөдлөн дэвжихийн суурь болж чадна. Монгол Улс хөгжинө дэвжинэ гэдэгт би эргэлзэхгүй байна. Ингээд нийт иргэддээ өнгөрсөн онд олсон ололт амжилтаа улам бататгаж, дөнгөж түүхээ бичиж эхэлж байгаа шинэ 2015 ондоо хийж бүтээх үйлс нь улам өөдрөг байхыг Улсын Их Хурлын энэ хүндэт танхимаас, энд хуран чуулсан шийдвэр гаргагчдын нэрийн өмнөөс хүсэн ерөөж баяр хүргэе.

Байгаль, цаг уур, улс төр, эдийн засаг, санхүү мөнгөний хүндрэл бэрхшээлийг сөрж “Бид чадна” гэж итгэл өвөрлөн зүтгэж бахархам амжилтад хүрсэн малчид, тариаланчид, ногоочид, үйлдвэрлэгчид, нийт бүтээлч иргэддээ дахин дахин энэ танхимаас халуун баяр хүргэж улам их амжилтыг хүсэн ерөөе.

Эрхэм гишүүд ээ,

Эвлүүлэх хэцүү, эвдрэлцэх амархан болохыг бид хангалттай үзлээ. Бүтээх бүр хэцүү, нураах зогсоох хичнээн хялбар бас хорлонтой болохыг, түүний горьг амсахаараа нэг болж байна. Шийдэх бүтээх гэсэн нь буруутдаг, бүтээлгэхгүй нураах гэсэн нь зөвдөг ёрын хандлагыг газар авахуулж болохгүй. Бид бүгд үүнд дүгнэлт хийх ёстой. Учир нь ийм хандлага бол Монголыг мохоох хандлага.

Бид Монголын зовлонг нимгэлэхийн төлөө зүтгэх ёстой болохоос нэмэх ёсгүй. Ялангуяа улс орны хувь заяанд нөлөөлөхүйц шийдвэр гаргах эрхтэй, хариуцлага үүрсэн, үүрэг хүлээсэн хүмүүс ийм буруу хандлагад, явцгүй ёс зүйд донтож, автаж болохгүй. Ийм байдлыг харсан ч хараагүй юм шиг өөгшүүлж болохгүй. Надаас холуур юм гэж хойш суух эрх бидэнд байхгүй.

Учир нь ийм байдлаас Монгол Улс хохирдог юм. Тэр хохирлын төлбөрийг Монгол хүн бүр төлдөг юм.

Асуудлыг шийдсэний хариуцлага, буруузөвийг хэзээ ч нэхэж болно. Учир нь тэр байгаа. Харин асуудлыг шийдүүлээгүйн хариуцлагыг яах вэ. Учир нь тэр боломж, цаг хугацаа алдагдсан, байхгүй болсон. Энэ тухай ярих хэрэгтэй, хариуцлага нэхэх хэрэгтэй. Ингэж чадвал бидний улс бүтээгч, хариуцлагатай улс болно. Бүтээлч, хариуцлагатай чанарыг дэмждэг нийгмийн зөв хандлага бүрдэнэ. Бид алдсан цаг хугацаанаасаа, алдсан боломжоосоо сургамж авч байна гэсэн үг.

Улсын Их Хурлын ээлжит сонгууль болж, Та бүхэн тангарагаа өргөж байсан нь саяхны мэт санагдаж байна. Энэ бол цагийг бид ачаалж чадаагүй, хурдан өнгөрөөсний илрэл. Бид хичнээн олон шийдвэрээсээ эргэж буцав. Хичнээн их бүтээн байгуулалт, боломжийг алдаваа. Цаг хугацаа бол манай өнөөгийн нөхцөлд хамгийн чухал хөрөнгө оруулалт. Алдсан цагийн хором бүр гадаадын мөнгөн тэмдэгтийн тооноос ч үнэтэй бидэнд тусаж байна. Энэ бүхний төлбөрийг манай иргэд дордсон амьдралаараа, мөнгөө алдаж, ажлаа алдаж, хөрөнгөө үнэгүйдүүлж, хүүхэд эхнэрээ нөмгөн гүйлгэж, нийтээрээ бухимдаж, алдаж төлж байна. Үүнээс том сургамж яаж байх билээ. Улс орлого нь нэмэгдсэн үед төсвөө бүү тэлж бай. Таатай боломж ховор олддог. Бас түр зуурынх байдаг. Эдийн засаг бол сонгуулийн амлалтаар, хоосон уриа, цээжээ дэлдэлтээр биш мөнгөөр, бодит хохирол, төлбөрөөр хэмжигддэг. Энэ бол том сануулга, том сургамж. Бид алдаагаа давтахгүй байх ёстой. Бид давтахгүй биш, хууль тогтоомжоор, үйл ажлаараа засах ёстой.

Бид хувь улс төрчийн болон бүлэглэлийн тоглолт, балмад үйл ажиллагааг амжилт, ололт гэж андуурч болохгүй. Харин мөнгөөр төлбөр нь үнэлэгдэж байгаа бүхнийг Монголын хохирол гэж тооцох ёстой. Манай зовлонгийн ихэнх нь дотроосоо үүсэлтэй байгаа. Бид аль нэг улстай хүйтэн дайн хийгээгүй. Харин бидний үүсгэсэн дотоодын хүйтэн дайн өнгөрөгч 2 жил гаруйн хугацаанд Монгол Улсыг 8 их наяд гаруй төгрөгийн хохиролд унагалаа. Хохиролыг хэн яаж тооцох дээр их, бага гэж маргаж магадгүй. Манай улсын эдийн засгийн албан ёсны мэдээнд тулгуурлаад харахад ийм л харагдаж байна.

Алдагдсан боломж, цаг хугацаа, үнэгүйдсэн хөрөнгө, хохирсон иргэд, зугатсан хөрөнгийг харахад дээрхи тоог би ханатай гэж бодож байгаа. Улсаа, Монголоо хохироож болохгүй. Ийм зүйлд хязгаар хэмжээ байх ёстой. Энэ бол бидний авах ёстой сургамж.

Монголчууд бидэнд, Та бидний түүх гарцаагүй нэг үнэн сургамж үлдээсэн. Үүнийг бид бүгд мэднэ. Бид эвдрэлцсэн үедээ уруудаж доройтож байсан. Харин бид эвэлсэн үедээ сэргэж урагшилж байсан. Бид их гүрнээс буурай улс болтлоо бууж үзсэн. Өнөөгийн бидэнд түүх, цаг хугацаа маань бүтээх, шийдэх дээр нэгдэхээс өөр сонголтыг үлдээсэнгүй. Та бидний амьдарч буй орчин эмзэг, байршил өвөрмөц, тоо цөөн байна. Үүнийг би хэлэхгүй юм бол хэн хэлэх юм бэ? Үүнийг та бид хоорондоо хэлэлцэж ярилцахгүй юм бол хэн бидний өмнөөс хэлэлцэж, шийдвэрлэх юм бэ?

Улсын Их Хурлын гишүүд бол Монголын их ард түмнийг төлөөлсөн бага ард түмэн. Та бүхний гаргаж байгаа шийдвэрээр Монголыг төсөөлдөг. Их Хурал, Засгийн газрын гишүүний хэлж буй үг, хийж буй үйлдлээр дамжуулж манай улсыг хүмүүс тольддог. Улсаа төлөөлж шийдвэр гаргах эрх бол чухал эрх. Тэр тусмаа манай Үндсэн хуулиар хууль тогтоох эрх бол зөвхөн Улсын Их Хуралд л байдаг ганцхан хувь эрх. Монголын хувь заяаг шийдэлцэх эрх бол ховор эрх. Монголд ийм эрхтэй хүн Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Ерөнхийлөгчөө нэмээд зуу хүрэхгүй. Ийм эрхтэй төрийн албан хаагч бол зөвхөн улс орны дээд эрх ашигт үйлчлэх ёстой. Тэр бол ард түмний нийтлэг эрх ашиг. Би Монголын ард түмний нийтлэг эрх ашгийг Монгол Улсын хөгжиж дэвжих эрх ашиг гэж хардаг. Бидний бүх үйлдэл, үйл ажиллагаа Монголын хөгжил дэвшлийг урагшлуулахад чиглэх ёстой.

Хоёр хоногийн өмнө би манай үйлдвэрлэгчдийн төлөөлөлтэй уулзлаа. Тэд үйлдвэрлэлийг дэмжинэ гэж хоосон ярьдагаа зогсоо гэж байна. Тийм бодлого байгаа бол хуульчлаад өгөөч гэж байна. Юуг яаж дэмжихээ тодорхой болгооч гэгцгээж байна. Улс төрчдийн ааш араншинг дагаж савж унасаар байгаад сэнсэрч дууслаа гэж ярьж байна. Бүтээгчдэд, хувийн хэвшилд хандах хандлагаа төр өөрчлөөч гэж тэд хэлж байна. Хувийн хэвшлийг хонь гэж хардагаа болио, төр өөрөө чоно шиг аашилдагаа болио гэж ярьцгааж байна. Манай дарга нар тууз хайчлахдаа дуртай. Харин бүтээгчдийн хаалгыг хүлсэн хүлээсээ давхар хайчилж хаяач гэж шаардаж байна. Тэд төрийн үйлчилгээг өрийн үйлчилгээ болсон, хүлээс цоож болсон гэж шүүмжилж байна. Төрийн эрх мэдэлд шургалсан бизнес хийгчид биднийг талцуулахаа зогсоогооч гэж байна. Бидэнд бусдын төр биш өөрийн төр хүндрэл учруулж байна гэж ярьж байна.

Бид цаг нартай уралддаг. Харин улс төрчидтэй цаг уралддаг байж магадгүй. Бидний алтан цаг, боломж, орлого ашгийг хүнд суртлын галаар битгий шатаагаач. Хийж бүтээх бол хэцүү. Үүн дээр төрийн хэцүүг бүү нэмээч гэгцгээж байна. Татварын бодлогоо уян хатан болгооч. Тийм эрх боломжоор Засгийн газар, орон нутгийн хурлыг хангаж өгөөч. Монголдоо хийж чадаж байгаа бараа үйлчилгээг л манай төр худалдаж аваач. Шалгаруулалтаа дотоодын үйлдвэрлэгчдийн дунд л явуул. Гадны ижил төрлийн бараа үйлчилгээг тендерт оролцуулахыг хориглооч гэж байна.

Ноос, ноолуур, арьс шир боловсруулаад дотоодын үйлдвэрт өгөхөөр татвартай. Гадагш гаргахаар татваргүй болчихдог гэж тогтолцоо байна. Үүнийгээ хурдан засаач гэж байна. Яам, албан газартаа ажлаа мэддэг, бизнесийг ойлгодог дэмждэг мэргэжлийн хүн ажиллуулаач. Яам байгуулснаар асуудал шийдэхгүй. Бодлогодоо, хандлагадаа өөрчлөлт гаргаач гэж дахин дахин хэлж байна. Энэ утаа, бохирдол чинь хүний эрүүл мэндэд аюул тариад зогсохгүй, Монголын өрсөлдөх чадварыг хойш татаж байна. Хурдан шийдээч гэж байна.

Төрөөс бүтээгчдээ дэмжих гэж байгаа бол бидэнтэй ирж уулзаач. Бидний хийж байгаатай, хүндрэл зовлонтой биечлэн танилцаач гэж хэлж байна. Өрийн тааз гэж худал юмаа өөрчлөөч. Өр чинь таазаа цоолчихлоо. Одоо засгийн өрийн ДНБ-д эзлэх дээд хэмжээ 40 хувь биш 53 хувь болсон. Бодитоор хар, мөнгөө зээл. Мөнгөгүй зээлгүй бол яаж үйлдвэр босох юм бэ гэж байна. Жилийн 24 хувийн хүүгээр үйлдвэр босохгүй. Энэ хэдэн банк чинь ломбард шиг ажиллаж байна. Өөр боломжуудыг нээгээч. Сайд нартаа шалгуур тавиаач. Ядаж салбартаа хувийн бизнесгүй, ашиг сонирхлын зөрчилгүй хүнийг сайд, даргаар ажиллуулж өгөөч гэж байна.

Би зөвхөн тэдний ярианаас Та бүхний анхааралд цөөн хэдэн санааг хүргэлээ. Надтай уулзсан үйлдвэрлэгчдийн төлөөллийг би эх орончид гэж харж байгаа. Татвар төлөгчид бол өнөөгийн нөхцөлд хамгийн эх оронч хүмүүс. Тэдний татварт төлсөн мөнгийг бид ахмадууддаа тэтгэвэр болгож олгодог. Тэднээс авсан мөнгийг манай төрийнхөн багш, эмч нартаа цалин чинь энэ байна гэж дамжуулж өгдөг. Тэр мөнгөөр хил манаж байгаа цэргийнхээ хоол хүнсийг дөхүүлдэг. Цагдаагаа хувцасладаг. Тэдний мөнгөөр та бид, төрийнхөн бүгдээрээ цалинждаг. Энэ танхимын дулаан, халуун, цахилгааныг ч тэдний мөнгөөр төлж байгаа. Монголын төрийг татвар төлөгчид тэжээдэг. Энэ өдрүүдэд хэлэлцэж байгаа төсвийн тодотгол ч тэр хүмүүсийн төлсөн мөнгийг яаж хуваах тухайд л юм.

Бүтээгч, үйлдвэрлэгчдээ дэмжиж байж л төр, төрийн байгууллага, төрийн албан тушаалтан оршихуйн ёс зүйтэй болдогийг мартаж болохгүй. Юм хийх бүтээх гэсэн иргэдээ Монголын төр хамгаалах ёстой. Явж явж үндэсний үйлдвэрлэгч, аж ахуйн нэгжүүдээ дэмжих нь Монголд хожоотой. Бүтээж хийх гэсэн хүмүүсийг мохоодог тэдний аранга нь болсон, тийм аргыг ажил амьдралынхаа хэвшил болгосон этгээдүүдэд бид үгээ хэлж чаддаг байх ёстой. Монголын төр бүтээгчдээ өмөөрөхөөс ичих ёсгүй. Тэдний бүтээж бий болгох үйлсэд саад учруулдаг хүнд сурталтан, дарга, сайд гишүүн ичихгүй бол би ичихгүй. Би үйлдвэрлэгчдээ,

бүтээгчдээ, юм хийж бүтээхийн төлөө яваа иргэдээ цаашид ч өмөөрнө. Тэд ч “Та биднийг дэмжээд өгөөч, цааш хэлээд өгөөч, биднийг хамгаалаач” гэж надад хэлдэг юм.

Би Чимэдийн Сайханбилэг Ерөнхий сайдын тэргүүлсэн Засгийн газрыг бүтээгч үйлдвэрлэгчдээ дэмжих гэж байгуулагдсан гэж харж байгаа. Тэдний өмнө тулгамдаж ирсэн хүнд, хэцүү асуудлыг шийдвэрлэхэд туслах нь энэ Засгийн гол зорилго гэж ойлгож байгаа. Иймээс ч энэ Засгийн газар Аж үйлдвэрийн яам гэж тусад нь яам байгуулсан, хариуцсан сайд томилуулсан гэж үзэж байгаа. Хамгийн гол нь энэ яам Монголын үйлдвэрлэгчдэд тушаа болох ёсгүй. Түлхээс дэмжлэг, өмөг түшиг нь болох ёстой. Би ч үүнд хувиа нэмэрлэж үйлдвэрлэлийг дэмжих талаар Засгийн газарт чиглэл өгсөн зарлиг удахгүй гаргах болно.

Монгол Улс цаашдаа үйлдвэрлэл тойрсон асуудлаар хэрэлдэж талцдаг биш харин үйлдвэрлэлийг дэмжсэн нэгдсэн бодлого, хууль, үйл ажиллагаатай болно гэдэгт итгэж байгаа. Үйлдвэржилт Монголын хөгжлийн өнгийг тодорхойлох болно. Бүгдээрээ тамын тогооноосоо гаръя. Бүтээгч үндэстэн болъё. Хариуцлагатай улс болъё. Монгол Монголоо дэмжье. Үүний төлөө бүгдээрээ нэгдэж хамтарч ажиллая гэж би та бүхэнд уриалж байна.

Эрхэм нөхөд өө,

Би жил гаруйн өмнө “Том төрөөс ухаалаг төр лүү” гэсэн санаачлага дэвшүүлсэн. Манай эрхэм гишүүд, нам эвслийн бүлэг, бие даагчид ялгаагүй бүгд тэр санаачлагыг дэмжиж хэрэгжүүлэхээ илэрхийлсэн. Иргэд, олон нийт, төрийн албаныхан, бизнес, хэвлэл мэдээлэл, шинжлэх ухааны салбарынханаас эхлээд олон байгууллага, иргэд энэ санаачлагад нэгдсэн. Энэ санаачлагыг хэрэгжүүлэх үйл явц олон газар үргэлжилсээр байна.

Би тэр санаачлагыг өрнүүлж хэлэлцүүлж байхдаа хоёр үндсэн асуудалд олны анхаарлыг хандуулахыг хичээсэн. Нэг. Эдийн засгаа яаж өсгөх вэ? Хоёр. Төрөө яаж засах вэ? Би энэ хоёр асуудлын түлхүүрийг олсон гэж бодож байгаа. Нэг. Эдийн засгаа өөд татахын тулд эхлээд бид үндэсний үйлдвэрлэгчдээ дэмжих хэрэгтэй. Хоёр. Төрөө засахын тулд эхлээд бид төрд хариуцлагыг авч ирэх хэрэгтэй. Шийдэл мэдээжийн, энгийн сонсогдож байгаа байх. Гэвч үйл явц амаргүй байх болно. Амаргүй ч байгаа.

Би сая үйлдвэрлэл, үйлдвэрлэгчдийн талаар цухас ярилаа. Энд ахиц дэвшил гарна гэдэгт найдаж байна. Харин би өнөөдөр төрд хамгийн чухал байгаа, гэхдээ хамгийн их дутагдаж байгаа тэр сэдвийг хөндөхийг хичээнэ. Тэр асуудлыг төр түмний анхааралд авч ирэхийн төлөө хойшид ч хатамжлан зүтгэнэ. Тэр сэдэв бол хариуцлага. Монголын төрд одоогоор хамгийн дутагдаж байгаа, хамгийн хэрэгтэй байгаа тэр зүйл бол хариуцлага. Монгол Улсад аливаа соёл иргэншилт нийгэмд байдаг бүх л юм байна. Харин нэг л зүйл үгүйлэгдэж байна. Тэр бол дахиад л хариуцлага. Монгол Улс нэр төртэй орон байя гэвэл хариуцлагатай улс болох ёстой. Бурханаа бүтээгээд шүншгийг нь хаяж болохгүй. Гэрээ бариад галаа мартаж болохгүй.

Манай ард түмэн Улсын Их Хуралд, Ерөнхийлөгчид, Засгийн газарт бүхнээ өгсөн. Манай иргэд сонгогчид өөрт нь хадгалагддаг төрийн эрх барих дээд эрх мэдлээ Та бидэнд өгсөн. Тэр хууль тогтоох, төсөв мөнгийг нь шийдэх, тэр бүү хэл баялгийг нь захиран зарцуулах эрхийг. Тэр том эрх мэдэлтнүүдийг холоос хайх хэрэггүй. Тэд бүгд энэ танхимд байна. Зарим нь хурлаа тасалсан ч сандал нь, шийдвэр гаргалцдаг товчлуур нь нэртэйгээ байна.

Төрд итгэхгүй байна. Төрд итгэх ард түмний итгэл бага байна гэж зарим шийдвэр гаргагчид гомдоллодог. Төрд гэдэг нь дам утгаар “өөрт нь” итгэхгүй байна гэж хэлж байгаа юм. Энэ үнэн. Гашуун ч үнэнийг хүлээн зөвшөөрье. Ерөнхийлөгчид итгэх хүмүүсийн итгэл муу байгаа. Их Хуралд итгэх итгэл тааруу байгаа. Засгийн газарт итгэх итгэл тийм өндөр биш байгаа. Та бидний ажил нэг иймэрхүү л байгаа.

Би та бүхэнд, өөртөө ч нэг зүйл сануулах гэж байна. Бүгдээрээ үүнийг өглөө бүр санаж

явъя. “Сонгогдлоо” гэсэн үг сонсоод ард түмэндээ баярласан тэр мөчөө бүү март. Тэр шөнө дөлөөр ард түмэндээ илэрхийлж байсан баяр талархлаа, тэр сонгуулийн өдрийн маргааш өглөө босоод “түмнийхээ төлөө зүтгэнэ” гэсэн тэр андгайгаа бүү март. Сонгуулийн үеийн амлалтаа, сонгуульд ялаад хэлж ярьж байсан үгээ бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа өдөр бүрийн тоогоор санаж яв.

Сонгуулийн үеэр, эрхэм гишүүдээ, хаана Монгол хүн зовно, би тэнд байна гэж та бид яриагүй гэж үү? Монголд хаана хариуцлага шударга ёс дутна би тэнд байна, би түүнийг шийдүүлэхийн төлөө зүтгэнэ, ажиллана гэж Та бид амлаагүй бил үү? Гэтэл албан тушаалын цоорхой хаана гарч байна, хаана мөнгө хувааж байна, тэнд л манай сонгогдсон хүмүүс тамираа барагдтал үзэлцэж байна. Өөрт нь албан тушаал өгсөнгүй, нам, бүлэг фракцад нь сайд ноогдсонгүй, бүр сүүлдээ дэд сайд, төрийн нарийн гэж хэрэлдээд бүхэл бүтэн Улсын Их Хурлын хуралдааныг хэдэн цаг, өдрөөр зогсоож байна. Гэтэл хариуцлагын ширээ өнчин, ардын зовлон хөсөр хаягдсан хэвээр л байна. Хүмүүс бүгдийг харж байгаа. Хүмүүс нэг юманд үнэн голоосоо дургуй байдаг. Итгэсэн сонгосон хүнийх нь үг үйлдэл хоёр зөрөхөд тэд үнэхээр бухимддаг.

Их Хурал хариуцлага, шийдэл шаардсан асуудлыг нэг өдрөөр хойшлуулахад Монголын хөгжил нэг алхамаар саардаг. Иргэдийн амьдралд ирэх дарамт улам нэмэгддэг. Гэр бүлээ тэжээх гэсэн хүнийг зовлон нь нойрон дунд нь сэрээж байна. Шөнөөр босгож байна. Олон хүн өнөөдөр балга тос, атга гурил, хэрчим мах, тал талх, ширхэг эмний төлөө өдөр шөнө, ажил амралтаа ялгахгүй зүтгэж байна. Найман хувийн хүүтэй орон сууцны зээл авсан айлынхан ажил таслах нь байтугай, ажил нэмж олж хийх гэж гүйлдэж байна. Хүмүүс амьдралдаа урьд өмнө байгаагүйгээр хариуцлагатай хандаж байна. Гэтэл төр яаж байна. Тэдний “эрхэм” төлөөлөл хурлаасаа хэдэн цаг хоцордогийг, ажилдаа яаж ханддагийг сонгогчид андахаа байжээ. Их Хурлын гишүүд салхинд гарч яваа амрагчид шиг байж болохгүй. Чөлөөлт цаг гарахаар хуралдаа ирдэг юм шиг зан гаргаж болохгүй. Ийм гишүүн олон биш байх. Гэхдээ “муугийн уршиг олонхид” гэж үгтэй. Энэ байдалдаа дүгнэлт хийх хэрэгтэй.

Их Хуралд хамгийн тулгамдаж байгаа асуудал гэхээр ихэнх нь “ирц” гэж хариулж байна. Гэтэл ард иргэдэд бол ажил амьдралын асуудал чухал байна. Улс оронд бол, би хэлсэн, хариуцлагын асуудал. Монгол Улс мөнгөгүйдээ хөгжихгүй байгаа юм бишээ. Монголын ард түмэн баялаггүйдээ ядарч байгаа юм бишээ. Манай дарга нарт эрх мэдэл дутагдсанаас асуудал шийдэхгүй байгаа юм бишээ. Бидэнд хариуцлага дутсанаас ийм байгаа юм. Улс нийгэм өөрчлөгдөж байна, өөрчилж байна гэж хорин хэдэн жил Та бид “хонины найр” шиг явлаа. Хариуцлага, ёс зүйг хаялаа. Бүр үүндээ дасал боллоо. Хариуцлагагүй төр бол удирдлагагүй онгоцтой адилхан. Удирдлага нь ажиллахгүй онгоцоор иргэдээ тээж яваа нисгэгч гээд өөрсдийгөө төсөөлөөд үз. Одоо ухаарах цаг болсон. Одоо зогсоё. Одоо болно. Үүнээс цааш хязгаар байхгүй. Одоо хариуцлагатай улс больё. Харин энэ ажлыг толгойноосоо, дээрээсээ, төрөөсөө эхэлж хийе. Үүнийг Их Хурал хийж чадна. Би чадна. Засаг ч чадна. Манай иргэд ч чадна. Бид чадна. Хийцгээе бүгдээрээ.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хяналт хүмүүсийн дунд эхэлчилхсэн байна. “Тэр байгууллага, тэр дарга хуулиар хийх ёстой ажлаа хийхгүй” байна гэсэн яриа гарч байна. Их Хурал мөнгөний зарцуулалтаа төдийгүй ирцээ шилэн болгох хэрэгтэй. Засаг төр, бүх албан тушаалтнууд шийдвэрээ шилэн болгох хэрэгтэй. Шүүхийн шийдвэр шилэн болоод удаж байгаа. Цаашдаа төрийн хяналт шалгалтыг шилэн болгоё. Хэн юу шалгав, юу илрүүлэв, үр дагавар нь юу байв гээд хянагч шалгагч, байцаагч нэг бүрийн удирдамж нь, шийтгэл сануулга нь, торгууль нь, авсан өгсөн нь, нэхсэн шаардсан нь бүгд шилэн болох ёстой. Үйлдвэрлэгчид гаалийг, татварыг шилэн болгоё. Нэмээд улс төрийн нам, сонгуулийн санхүүжилтийг шилэн болго гэж шаардаж байна.

Бүсээ дээрээсээ эхэлж чангалъя. Өрхийг оройгоос нь татдаг. Надаас эхлээд төсвөө таная.

Ерөнхийлөгчийн, гишүүний, сайдын төсөв яаж тэлсэн, яаж хассан тийм хэмжээгээр бусдаас тэгэж шаардая. Би Ерөнхий сайдад хэлсэн. Наад сайд дарга нарынхаа ажлын өрөөнд хэмжээ тогтоож өг гэж. Ингэж чадвал зарим яамны ажилтнууд сайдынхаа өрөөнд багтах байх. Засаг дарга нарынхаа өрөөнд тамгын газар нь шингэчих байх шүү. Тэр сайд, дарга нарт ноогдох өрөөний зай талбайг манай урд хөршид тогтоосон шиг дунджаар 16 метр квадрат гэж тооцвол. Энэ албан тушаал, сандал суудал тойрсон тансаглалаа эхлээд хасах хэрэгтэй. Засаг нь чадахгүй бол хурал нь хас, хурал нь чадахгүй бол засаг нь хас. Хоёулаа чадахгүй бол иргэдээр хасуул, татвар төлөгчдөөр хасуул.

Үйлчилгээг тусад нь гаргах, түрээс болгох, хувийнхнаар хийлгэх яасан бэ! Яамдыг аж ахуйн ажлаас, тендерээс, барилга барих, засах, зам тавих ажлаас чөлөөлөх яасан бэ. Улс төр, мөнгө хоёрыг салгах юу болсон бэ? Мөнгө төсөвгүй болоод хаалгаа барьсан яам, төрийн байгууллага гэж би сонсоогүй. Харин аж ахуйн нэгжүүд олон зуугаараа хаалгаа барьж, аргагүйн эрхэнд ажилчдаа олноор нь халж байна гэх яриа тасрахгүй байна. Төсөв нь дутаад цалингаа, албаны нэмэгдлээ авч чадахгүй яваа гишүүн, сайд, дарга байна гэж та бүхэн сонссон уу? Нэг бол тэр сайдын, тэр гишүүний компани дампуурлаа гэж та сонссон уу?

Бид яам, албан газар биш аж ахуйн нэгж хаалгаа барихад илүүтэй санаа зовох ёстой. Уялдаа холбоогоор авч үзвэл нэг татвар төлөгч хаалгаа баривал, нэг төрийн байгууллага хаалгаа баримаар юм. Төрийн байгууллага байгаа учраас аж ахуйн нэгж байгаа биш, харин тэдний төлсөн татвар байгаа учраас төрийн тэр нэгж оршиж байгаа юм. Тиймээс хэчнээн шахаад ч гарах шүүсгүй болсон аж ахуйн нэгжийг биш, харин хэмжээ хязгаар нь хэтэрсэн тансаглал, зардлыг нь төрөөс олж шахбал, хасбал мөнгө төсөв хэмнэгдэнэ.

Эрхэм гишүүдээ.

Төр лүү очих ардын зам хүний итгэлээр хучаастай байдаг гэж ярьдаг. Итгэл амархан сэргэдэг зүйл. Тэр тусмаа төрдөө итгэх ардын итгэл. Төр нь төр шиг байх юм бол хүмүүсийн итгэл сэргээд л ирнэ. Төр ард түмний итгэл эргээд л бэхжинэ. Би энэ бүхнийг гурван “Ш”-ээс хамаарна гэж хэлэхэд хэтрүүлэг болохгүй байх. Гурван “Ш” үсгээр эхэлсэн үгнээс. Шийдвэр, шийтгэл, шүүр.

Би сүүлээс нь санаагаа товч тайлбарлая. Шүүрээр би төрийн үйлчилгээг төлөөлүүлж байгаа юм. Төрийн үйлчилгээ аливаа газрын үйлчлэгчийнх шиг хөнгөн шуурхай, ойлгомжтой, иргэдийн итгэл сэтгэлд нийцтэй байх ёстой. Үйлчилгээ цоож шиг байж болохгүй. Тэр тусмаа төрийн үйлчилгээ нь мөнгөөр онгойдог цоож шиг байж болохгүй. Иргэдийг чирэгдүүлдэг, хохироодог тийм үйлчилгээнд төр мөнгө төсөвлөх хэрэггүй. Төсөвгүй учраас тийм ёс бус үйлчилгээ, алба өөрөө л алга болно.

Хоёрт нь, Шийтгэл гэдэг үгээр би хариуцлагыг төлөөлүүлж хэлж байгаа юм. Иргэдийн бухимдлын ихэнх нь мөнгөнөөс гэхээс илүүтэй шийтгэл хүлээх этгээд шийтгэлгүй яваад байгаагаас үүддэг. Гэртээ бухимдаж байгаа иргэнийг төлөөлж сонгосон гишүүн нь хурлынхаа танхимд хариуцлага алдсан этгээдэд уураа гаргаж байх учиртай. Ард түмний төлөөлөгч ард түмнийг төлөөлж албан тушаалтнаас хариуцлага асуух, шаардах, түүнийг тооцох эрхтэй.

Би энэ дутагдаж байгаа харилцааг зохицуулахад чиглэсэн “Нийтийн сонсгол”-ын хууль санаачлаад Их Хуралд өргөн барьсан. Энэ хууль бол ардчиллыг ажиллуулах хууль. Учир нь ардчилалын амин сүнс бол хариуцлага. Энэ хуулиар ард түмний элч нар албан тушаалтнаас хариуцлага асуух юм. Энэ хуулиар та бүхэн төсвийн зарцуулалтыг асуух эрхтэй. Хуулийн хэрэгжилтийг асуух эрхтэй. Томилгоог ч сонсох эрхтэй. Байгалиа ч, иргэдээ ч өмөөрч өмнөөс нь хариуцлага ярих эрхтэй. Мөрдөн шалгах ч эрхтэй. Тийм арга хэрэгсэлээ гартаа, мэдэлдээ авцгаа, эрхэм гишүүдээ, хурлын төлөөлөгчидөө.

Улсын хэмжээний асуулга хариуцлагыг Улсын Их Хурал ярьдаг, аймгийн хурал нь аймагтаа,

дүүрэг нийслэлийнх нь Улаанбаатартаа, сумынх нь сумандаа ярьдаг, тооцдог болно. Дуудсан, дурын албан тушаалтнаасаа, бүр тодруулбал өөрөөсөө бусад, ажил алба хариуцсан хүмүүсээр “Би зөвхөн үнэнийг хэлнэ” гэж тангараг өргүүлж байгаад хариуцлага асуух ярих эрх та нарт байгаа. “Нийтийн сонсголын хууль хэрэгжиж эхэлснээс хойш нэг жилийн дотор төдөн сайд, дарга, нэжгээд өндөр албан тушаалтан хариуцлага хүлээлээ, сануулга авлаа, ард түмний төлөөлөгчдөөр загнууллаа, байцаагдлаа” гэсэн мэдээ гарвал би Монгол Улс хариуцлагатай улс болж байна гэж ойлгох болно.

Хариуцлага асуух, сонсох бол Монголын төрийн уламжлал. Хариуцлагыг асуух ёстой эзэд нь асууж чаддаг, бас тооцож чаддаг байхдаа Монголын төр хүчтэй байсан. Ерөөс тийм төр нэр хүндтэй, түмэн олныхоо итгэлийг хүлээсэн байдаг. Өнөөдөр манай парламент албан тушаалтнаас тухайн цагт нь хариуцлага асууж тооцож чадахгүй байгаа учраас, тэр бүрэн эрхээ бүрэн хэрэглэхгүй байгаа учраас нэр хүнд нь унаад байгаа юм. Хүмүүс төрөөс хариуцлага, мөнгө хоёр дээр хатуу, ил тод, тайлагнаж тооцож хандахыг л хамгийн их хүсэж байна. Бидний улсын зорилго бол ардчилал, зах зээл гэсэн хоёр үгэнд байгаа юм бишээ. Монголын туйлын зорилго бол Монгол хүн эрхтэй, Монгол төр хариуцлагатай байхад оршино. Иймээс Нийтийн сонсголын хуулийг цаг алдалгүй баталж хэрэгжүүлэх боломжоор хангахыг эрхэм гишүүд Та бүхнээс би хүсэж байна.

Дараагийн миний Улсын Их Хуралд өргөн барихаар бэлдэж байгаа хууль Иргэний оролцооны тухай болон зарим дагалдаж гарах хуулийн төсөл юм. Иргэдийнхээ оролцоогүйгээр бид иргэний нийгэм байгуулах Үндсэн хуулийн зорилгоо хангаж чадахгүй. Иргэдийнхээ эрх үүрэг, хийх ажил, оролцоог бид тодорхой хуульчлах ёстой. Монголын хүч бол манай ард түмний хүч юм. Монголын зам бол албан тушаалтанд их эрх ямба эдлүүлэхэд биш, харин иргэддээ эдлэх ёстой эрхийг нь хуульчлан эдлүүлэхэд оршино. Иргэдийнхээ оролцоо, идэвхийг дэмждэг, урамшуулдаг төр л иргэний, ардчилсан, ард түмний төр гэж нэрлүүлэх, үнэлэгдэх эрхтэй болдог. Манай орны хувьд иргэний оролцоо бол зөвхөн ардчиллын агуулгатай асуудал биш. Монгол Улсын аюулгүй, тусгаар, бүрэн эрхт байдал, сайн сайхан, хөгжил дэвшил нь эргээд иргэдийнхээ эрх оролцоогоор хангагддаг, түүнтэй салшгүй холбоотой байдгаараа онцлогтой юм. Үүнд л манай ард түмний түүхэн, шинэ сонголтын мөн чанар, ач холбогдол оршиж байгаа юм.

Манай иргэд өөрсдөө оролцвол, хүсвэл ямар ч хүндрэлийг байгаа суугаа газраа шийдэж чадна. Орон нутгийн хөгжлийн сангийн сум, баг, хороо, дүүрэгтээ ноогдсон буурай хөрөнгийг иргэд яаж хувиарлаж зарцуулж, хянаж байгааг, юу бүтээж хийж байгааг та бүхэн мэднэ. Тэр мөнгө нь цаг хугацаандаа, хуулийн дагуу бүрэн очдог бол хүмүүс бүр ихийг хийж чадна. Харин орон нутгийн хөгжлийн сангийн мөнгийг одоо энэ хэлэлцэж буй төсвийн тодотголоор бүү хасаарай. Иргэн бүрт, байгаа суугаа газар нь тулгамдаж байгаа бүх асуудлыг энэ танхим руу чирэх хэрэггүй. Түүнийг шийдэх боломжийг нь, эрхийг нь, санхүүжилтийг нь иргэддээ өгчих. Хүмүүс асуудлаа өөрсдөө шийдээд л явна. Үүнийг л төрийн мэргэн бодлого гэж байгаа юм. Иргэн хүнд ололт нь, хувь нь хүртдэг бодлогыг зөв бодлого гэдэг юм. Аливаа амжилт хүндээ хүрч байж л ололт болдог.

Эрхэм гишүүдээ, ард иргэдээ,

Миний дараагийн ярих сэдэв бол төрийн сонгогдсон болон томилогдсон өндөр албан тушаалтантай ямар тохиолдолд, яаж хариуцлага тооцох тухай асуудал юм. Манай хуулинд дарга, албан тушаалтанг яаж сонгох, томилохыг тодорхой заасан байдаг. Харин тэдэнтэй яаж хариуцлага тооцох, хариуцлага гэж яг ямар утга агуулгатай, хэм хэмжээтэй, зөрчвөл ямар үр дагавартай харилцаа болохыг тодорхойлсон бие даасан хууль тогтоомжгүй явж ирлээ. Иймээс би Сонгогдсон болон томилогдсон төрийн өндөр албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх тухай хуулийн төсөл санаачлаад өргөн мэдүүлэхэд бэлэн болгож байна.

Тэнгэр оройгоосоо цоорвол цэлмэдэг. Төр дээрээсээ хариуцлагатай байвал зөв болдог.

Манай өндөр албан тушаалтнууд “хариуцлага” гэж чанга ярьдаг. Харин өөрсдөө түүнээс зугтаадаг. Одоо энэ ажлыг үг яриа биш үйл хэрэг болгоё. Хуулиа батлая. Хэрэгжүүлбэ. Асуудал гарвал улам сайжруулаад, чамбайруулаад явъя. Хариуцлагыг өөрсдөөсөө эхэлбэ. Албан тушаалтан нь хариуцлага хүлээдэг нийгэмд л шударга ёс тогтдог. Хуулийг дарга, сайд, гишүүн, ерөнхийлөгч, төлөөлөгч ялгаагүй бүгд ягштал биелүүлдэг байх ёстой. “Хууль яахав” гэдэг ойлголтыг бид эхлээд энэ улс төрөөс халах ёстой. Тийм ойлголттой хүн улс төр, төрийн ямар ч албанд ойртох учиргүй.

Би энд шинэ юм яриагүй. Хариуцлага, шударга ёсыг тогтоох, бэхжүүлэх бол миний ч ард түмэндээ өгсөн амлалт, эрхэм гишүүн таны ч сонгуулийн үеэр ярьж явсан гол сэдэв. Шударга ёс бол сонгуулиар яриад орхидог сэдэв биш. Албан тушаалтай байхдаа л шударга бай. Улс төрчийн улсын шалгалт бол авилгатай тэмцэх, шударга байх, хууль хэрэгжүүлэх гэсэн гурван шалгуураас бүрддэг. Шалгалтандаа унавал ажлаа өгөх хэрэгтэй. Шударга ёс бол хүнээс өөрөөс нь эхэлдэг. Ярьсанаа хийж хэрэгжүүлэхээс эхэлдэг. Та бидний хувьд бол хариуцлагын тухай багц хуулийг баталж, тэр тогтолцоог бий болгож, ажилуулахаас эхэлнэ.

Хариуцлага, шударга ёс гэдэг нэрийг манай иргэд залхатлаа сонссон. Харин дүрийг нь харалгүй өдий хүрлээ. Одоо бид тэр “хэцүү нэрт”-ийг амилуулж ажиллуулах цаг болсон. Сонгосон хүнээ болохгүй бол буцаагаад татах сонгогчдынхоо эрхийг бид хуульчлах ёстой. Өнөөдөр Монголын сонгогч хагас эрхтэй, сонгогдсон хүн бүрэн эрхтэй, гишүүн сайд давхар эрхтэй байна. Ташуур далайхад хашин морь ч шогшдог. “Буцаагаад татна шүү” гэхэд сонгогдсон хүний чих зөөлөрдөг, нүд нь нээгддэг, сонгосон томилсон эзэнтэй гэдгээ тэр хүн мэдэрдэг, хариуцлага байгааг санадаг. Үүнээс шалтгаалаад тэр улс төрийн албан тушаалтны ажилдаа хандах хандлага өөр болдог, сайжирдаг, тэд ажлаа улам үр бүтээлтэй хийхийг хичээдэг. Үүнээс Монгол Улс, Монголын ард түмэн л хожих болно.

Хариуцлага бол өргөн ойлголт. Зөрчлийн цар хэмжээ, тоогоор хүлээх хариуцлагын түвшин, зэрэглэл, тогтдог. Манайханд хариуцлагын хоёр туйл байна. Нэг туйл нь албан тушаалтан сонгогддог, томилогддог. Тэгээд дархлагддаг. Нөгөө туйл нь албан тушаалтанг ажлаас нь буухаар орц, орон, эмнэлэг, шорон хэсүүлж хариуцлага тооцох гэж хөөцөлддөг. Энэ тогтолцооны гажгаас болж албан тушаалтнууд нэг бол эргүү болтлоо сандалтайгаа зууралддаг, нэг бол эрүү яланд очиж унадаг. Гэтэл албан тушаалын хариуцлага гэдэг бол албан тушаалтнаас өөрөөс нь эхэлдэг зүйл. Албан тушаалтан буруу үйлдлийнхээ төлөө уучлалт гуйх бол хариуцлага мөн. Албан тушаалтныг хууль дуудсан үед яваад очих бол хариуцлага мөн. Ёс зүйн хариуцлага гэж бий. Улс төрийн хариуцлага гэж бий. Торгууль, шийтгэл, сануулга гэж бий. Энэ бүхнийг хуулиар тодорхойлж, таарсан зөрчилд нь тохирсон хариуцлагыг тухай бүрд нь тооцож байх нь л чухал. Ийм юмнаас сонгогдсон, томилогдсон албан тушаалтнууд тойрч зугатах хэрэггүй.

Хариуцлага гэдэг бол хүний нийгэмд л байдаг хэм хэмжээ. Хариуцлагатай хүн ёс зүйтэй байдаг. Ёс зүйтэй хүн хариуцлагатай байдаг. Ёс зүй, хариуцлага гэдэг эрх чөлөөнд байдаг ойлголт. Ардчилсан нийгэмд хэвшсэн зүйл. Нийгмийн дархлаа ёс зүйдээ байдаг. Тэр дархлаа, хариуцлага хүлээж байгаа хүмүүсээс бүр их хамаардаг. Ухамсартай төрийн түшээ хүн уучлал гуйхаас, улс төрийн болон ёс зүйн хариуцлага хүлээхээс эмээдэггүй. Харин ч түүнийг хүсдэг. Учир нь түүнийг зөрчвөл дараагийн шатан дээр эрүүгийн хариуцлага түүнийг тосдог.

Албан тушаалтны халдашгүй байдал бол түүнийг хариуцлагаас чөлөөлөх хамгаалалт биш. Бүрэн эрхээ хуулийн хүрээнд хэрэгжүүлэх боломж юм. Хариуцлагын тухай хуулийн төсөлд энэ асуудлыг ч нарийвчлан зохицуулсан байгаа. Хариуцлага гэдэг бол гадаад орнуудын албан тушаалтанд хамаардаг ойлголт биш. Энэ бол Монголын төрийн гүн ухаан, чимэг нь, амин сүнс нь болсон ойлголт. Монголчууд дэг журам, хууль ёс, хариуцлага гэдгийг дэлхийд мэдрүүлж явсан үндэстэн. Төрийн цэвэр нандин байдал, төрийн хүний явдал суудал ямар байх ёстойг заасан Монголын хууль, түүний хэрэгжилтийг хүн төрөлхтөний



соёл иргэншлийн ололт гэж дүгнэдэг юм. Төрөө цэвэр, журамтай байхыг Монголчууд гэрээ цэвэр хоггүй байхаас илүүд үздэг. “Надаас сайн нь, цэвэр нь, хариуцлагатай нь төрд байх ёстой. Би бол болоогүй” гэж өөрийгөө голдог иргэдтэй улс, бид чинь.

Япон улсад парламентын гишүүн, бас сайд хүн сонгогчдодоо дэвүүр тараагаад огцорч гэнэ гэсэн мэдээг та нар саяхан л уншсан байх. Тэнд хүн дэвүүр тараагаад огцорч байхад, манай улс төрчид гивлүүртэй юм шиг суугаад л байх уу? Хийсэн машиныг нь унах дуртай дарга нар яавал хүн огцордог, хариуцлага хүлээдэгийг нь гаднаас, тэднээс санаа авч, суралцаж болохгүй гэж үү? Бид хариуцлагыг ярих цаг болсон. “Өрхийг нь тараая гэвэл хүүхдийг нь эрхлүүл. Улсыг нь тараая гэвэл түшмэдийг нь эрхлүүл” гэж үгтэй юм. Манай түшмэдүүд, өндөр албан тушаалтнууд дэндүү эрх, дэндүү дураараа байгаа. Энэ хуулиудыг бүр ойрын өдрүүдэд батлах хэрэгтэй байгаа юм.

Эрхэм гишүүдээ,

Манай парламентад суудал авсан намын гишүүд Засгийн газарт хамтарч ажил албан тушаал хаших болсныг хүмүүс янз бүрээр л харж байгаа. Хамтраад хэцүү тулгамдсан асуудлыг шийдэх байх гэж нэг хэсэг нь харж байгаа. Нөгөө хэсэг нь хариуцлага, ёс зүйгүй, хяналтгүй дураараа загнах нь бүр хэтрэх вий гэж болгоомжилж байгаа. Улс төрд ялах дуртай. Албан тушаалт очих дуртай. Ажлаа хийх дургүй. Ийм байж болохгүй. Хариуцлагагүй төр дотроосоо ялзардаг. Төрөө ялзарлаас сэргийлэх ажил бол Та бидний хийх ёстой хамгийн чухал ажил. Энэ ажлаа хамтдаа одоо хийцгээе.

“Мөнгө төсөв дутаж байна, зарим юмыг тэвч” гэж шийдлийн засаг хэлдэг юм байж. Харин “хариуцлагагүй байдлыг тэвч” гэж бидний хэн нь ч хэлэх эрхгүй. Монголд хариуцлага, шударга ёсыг тогтоох ажилд гадаадын олон тэрбумын зээл, хөрөнгө оруулалт хэрэггүй. Бид өөрсдөө хийчих ажил. Харин Монгол Улс хариуцлагатай, албат түшээд, удирдлага нь ёс зүйтэй, хууль, шударга ёс ялгамж үгүй хэрэгждэг орон болчихвол, ийм байдал Монголын сайн сайханд их тустай. Ард түмний амьдралд наалдах наалдац, өгөөж нь нэмэгдэх болно. Нийгмийн харилцаа бүхэлдээ шударга зөв болно.

Хариуцлага бүтэн байх ёстой. Сонгогдсон болон томилогдсон өндөр албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх хуулийг хэлэлцэж батлах дээр эсэргүүцэх гишүүн энэ танхимаас гарахгүй байх. Учир нь шударга ёсонд суурилсан эв нэгдэл хүчтэй байдаг. Хариуцлагатай төр хүчтэй байдаг. Хууль биелүүлдэг албан тушлаалтан нэр хүндтэй байдаг. Их түүх, соёл уламжлал, шударга ёс ард түмнийг нэгтгэдэг. Улс төржилт, албан тушаалын хэнээрхэл, хариуцлагагүй байдал хүмүүсийг хуваадаг, талцуулдаг. Иймээс бүрэн хариуцлагатай улс болохын тулд бид гэмт хэргийн, зөрчлийн, хуулийн байгууллагуудын болон хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой хуулиудаа нухацтай хэлэлцэж батлах учиртай. Мөн улс төрийн нам, түүний санхүүжилт, төрийн албаны болон бусад олон арван хууль, багц асуудал байгааг Та бүхэн мэдэж байгаа.

Эдгээрээс боловсруулалт нь бэлэн болж байгаа Захиргааны ерөнхий хуулийг онцолж хэдэн үг хэлье. “Дээрээ ихэнх нь ил тод, хариуцлагатай болох нь. Харин төрийн албаны анхан, дунд шатны хүнд суртал, хариуцлагагүй байдал гэж том асуудал бий шүү” гэж саяхан нэг судлаач иргэний танхимд ярьж байсан. Үнэхээр тэнд асуудал байгаа. Түүнийг шийдэхийн тулд бие даасан хуульгүй явж ирсэн төрийн захиргааг хуультай болгох хэрэгтэй. Энэ хуулинд Засгийн газраас эхлээд төрийн бүх шатны алба, захиргааны харилцаа багтаж байгаа. Монгол Улс захиргааны хэргийг хэлэлцэх бие даасан шүүхээ байгуулсан атлаа захиргааны хуулийг нь баталж өгөөгүй хугацаа алдаад байна. Замын цагдаагаа бий болгочихоод жолооны дүрмийг нь баталж өгөөгүйтэй ижил юм.

Төрийн захиргааны ажил хуулиар тогтоосон хэм хэмжээтэй байх ёстой. Бүртгэл хяналттай байх ёстой. Хариуцлагатай, буух эзэнтэй, буцах хаягтай байх ёстой. Иймгүйгээс Монгол

Улсад төрийн захиргааны задрал, завхрал, тэнд дур зоргоороо авирлах байдал төрийн оршин байх аюулгүй байдалд нөлөөлөх хүртлээ даамжирч байгаа. Албан тушаалтнууд хувийн сонирхлоор шийдвэр тушаал гаргадаг, түүнийгээ нууцалдаг, устгадаг. Хариуцлагаас зугатдаг. Нэгдсэн бүртгэлгүй, ажил албаа хүлээлцэх хууль журамгүй явж ирлээ. Тэнд ажиллаад тэтгэмжээ нэхэхээс биш, “тойрох хуудас” зуруулах хуучны ёс ч алга болсон.

Хариуцлага хаана алга байна төрийн захиргааны шатанд л бүрэн алга байна. Төрийн албаны үйл ажиллагаа, шийдвэрээс хуудас цаас ч дутах ёсгүй. Хэрэв зөрчил гарвал мөнгөөр үнэлж хохирлыг тооцдог байх, түүнийг нь тэтгэмж цалинтай нь холбох хэрэгтэй. Захиргааны хариуцлага тооцох ёстой. Бүр хүндэрвэл эрүүгийн хариуцлагад татагдана. Дээхэн үед томилолтоос 10 төгрөг дутаасан, бичиг баримтын хадгалалт, хамгаалалт зөрчсөн хүн цалингаасаа төлдөг, бас арга хэмжээ авагддаг байсан тухай манай ахмадууд ярьдаг.

Ардчилсан нийгэм бол хуульгүй нийгэм биш. Харин албан тушаалтны алхаа гишгээ бүрийг хүртэл хуулиар тогтоосон хариуцлага тооцдог нийгэм. Ардчилал бол хэлбэрэлтгүй хэрэгждэг хууль, хэм хэмжээ, хариуцлага, хатуу сахилга бат, өндөр ёс зүй юм. Шинэчлэлийн хэцүү нь шинийг хийхэд биш, хуучнаасаа салахад байдаг.

Хариуцлагагүй байдлаа эрх чөлөөтэй холбож болохгүй. Энэ бол хүн төрөлхтний олон үеийг өнгөрөөсөн, одоо шийдэл гаргалгаа нь олдсон асуудал. Ардчилалтай улс авилгатай, ёс зүйгүй, хариуцлагагүй байдаг юм биш. Харин ардчилал өөрөө тийм муу зүйлийг улс орны амьдралаас шахаж гаргадаг тогтолцоо юм.

Манай иргэд, залуус “Төрийн алба хэцүү болсон. Хатуу болсон. Тэнд илүү дутуу мөнгө байхгүй. Нэг л буруу гишгэвэл нэрээ алдана, баларна. Тэндээс хол явъя” гэж ярьж байвал би Монголын төрд зөв соёл тогтож байна гэж бодно. Төрийн алба бол иргэн хүний хувьд ухамсартай сонголт байх ёстой. Улс төр бол хэцүү. Их нарийн шинжлэх ухаан. Ялангуяа төрийн захиргааны алба нарийн мэргэжил, мэргэшил шаарддаг ажил. Улс төрд мөнгө байхгүй. Хариуцлага байгаа. Үүнийг Та бид хуулиар л тогтоож хэвшүүлэх ёстой.

Манай нийгмийн давуу тал бол нээлттэй байдал. Бид алдаагаа харж болдог, ярьж болдог, засаж болдог тогтолцоог сонгосон. Харин ч эрт сонгосондоо, үүндээ үнэнч байгаадаа алдаатай, оноотой өдий дайтай яваа юм. Монголчууд сортоотой хүмүүс. Зөв зүйлийг олж харж чаддаг, түүнд хурдан суралцдаг хүмүүс. Монголыг энэ замаас нь хазайлгахад хэцүү. Хүмүүс дуу хоолойгоо боолгохыг, хувь заяагаа бусдаар шийдүүлэхийг хүсэхгүй. Муу ч гэсэн хэнээр удирдуулах эрхээ бусдад шилжүүлэхийг хүсэхгүй. Зовж олсоноо, эргүүлж авсан эрхээ алдахыг хүсэхгүй.

Сайн соёл, сайн үнэлэмж бол нийтийнх байдаг. Үнэт зүйлтэй хүн, нийгэм үнэ цэнтэй байдаг. Ардчилсан нийгэмд ганц хүн соёлыг бүтээх, гайхамшигийг цогцлоох боломжгүй. Манайхан ч “ганц хүн гал болдоггүй” гэж ярьдаг. Төрийн сайн соёл, олны сайн уламжлал бол цагийг эзэгнэн оршдог юм. Хувийн онцгойрсон тоглолт нээлттэй нийгэмд хувь хүнтэйгээ л дуусдаг. Нийгмээрээ бүтээсэн, нийтээрээ олсон ололтыг нээлттэй нийгмийн үнэт зүйлд тооцдог юм.

Өнөөдөр та ямар гишүүн, сайд дарга байгаа нь, эсвэл бидний хэн нь ямар эрх ямба эдэлж байгаа нь түүхэнд сонин биш. Түүх тийм юмыг тоодоггүй юм. Зүгээр л арчаад өнгөрдөг. Харин удирдагч манлайлагч хүнээс үлддэг өв бол нийтийн эрх ашиг, хөгжил дэвшилд нийцсэн сайн хууль, тогтолцоо, сайн соёл, сайн үлгэр дууриалал юм. Төрийн хүн нуруутай байх ёстой. Их боддог байх ёстой. Дотогшоо ярьдаг байх ёстой. Түүнээс биш мэдрэлийн түвшинд үзүүлж байгаа хариу үйлдлээ бодлого гэж, мундаг юм хэллээ гэж андуурч болохгүй. Тэр бол зөвхөн сэтгэл хөдлөлөө илэрхийлэх төдий юм. Тийм үгийг хэлэхгүй нь дээр байдаг.

Эрхэм гишүүдээ,

Улс төрчид сонгуулийн үед ард түмнээ боддог, бусад үед өөрсдийгөө боддог байж болохгүй.

Хаврын өдрүүд жилээ даадаг гэж ярьдаг. Энэ Улсын Их Хурал, Засгийн газарт маш бага хугацаа үлдлээ. Үндсэндээ хоёр хавар, нэг урт намар л үлдлээ. Шийдэх асуудал ямар их байгааг Та нар харж байгаа байх. Шийдэх асуудал дэндүү их, хугацаа дэндүү бага байгаа учраас Та бүхнийг би Шийдлийн Засгийн газрыг хамтарч байгууллаа гэж ойлгож байна. Түүнээс биш зүгээр албан тушаалд очиж, нэгнийхээ хашаанд хургаа таргалуулах гэж нийлээгүй гэж бодож байгаа.

Хамтарч Засгийн газраа байгуулсан намууд бусдын хатгаас, дарамт, саналаар нийлсэн эр эм хоёр шиг ааш гаргаад байж болохгүй. Сэтгэлээсээ улс орныхоо хүндрэлтэй асуудал, ард иргэдийн зовлонд хандах ёстой. Ажил хэрэгч байх хэрэгтэй. Энэ Засагт хамтарсан хамтын ажиллагаа их үнэтэй. Зорьсоноо, хийх ёстойгоо хийж чадахгүй бол дахиад намууд хүнд бэрхийг сөрж хамтрахад, тэгээд ард иргэдээсээ дэмжлэг авахад хэцүү болно. Нийгэм, улс төр, эдийн засгийн үр дагавартай байх болно. Та нар хийж, шийдэж, шийдүүлж чадахгүй бол нүүр тулж байгаа Монголын хүндрэл бэрхшээл улам нэмэгдэх болно.

Та бид нийлээд зүтгэхэд олон асуудлыг шийдэж чадна гэж би итгэж байна. Би Та нарт итгэж байна. Та нар надад итгэ. Би зүтгэнээ. Хамтраад зүтгэе. Монгол Улс хариуцлагатай, бүтээгч улс болох ёстой. Би энэ Их Хурлын эрхэм гишүүдийг Монголын улс төрийн олон жилийн хариуцлагагүй байдалд сүүлчийн цэг тавьсан анхны гишүүд байж чадна гэж итгэж байна. Тийм хууль, тийм шийдвэрийг цогцоор нь гаргасан манай эхний парламентчид болоорой гэж Та бүхнээс хүсэж байна

Сайн сайхан ойрхон байдаг, муу муухайгаас салж болдог гэдэгт би итгэдэг. Та бүхнийг улс орноо эдийн засаг, санхүүгийн хүндрэлээс гаргаж, уруудал бууралтыг зогсоож, бас ололт амжилт, хөгжлийн урт удаан суурийг Засгийн газартайгаа хамтраад тавьж чадна, тийм шийдвэрүүдийг гаргаж чадна гэдэгт би итгэж байна.

Монголын бүтээгч, үйлдвэрлэгчид Та бүхэнд хандаад “эрхэм гишүүн ээ, баярлалаа” гэж хэлэх тийм урмын үгийг сонсох шийдвэрүүдийг хэцүү ч байсан Та нар гаргаж чадна гэж итгэж байна. Чадах уу! Чадах уу! Тэгвэл дагаад хэл. Чадна. Бүгдээрээ чадах ёстой. Монгол Улс бүтээлч, хариуцлагатай улс болно. Бид чадна. Та бүхэнд баярлалаа.

\* \* \*

### **Чуулганыг хааж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг**

(2015.02.18)

Монгол Улсын Ерөнхий сайд аа,  
Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы хуралдаан өндөрлөж байна. Чуулганаар Улсын Их Хурлын 48 дугаар тогтоолд тусгагдсан хууль, тогтоолын төслүүдийг амжилттай хэлэлцэн шийдвэрлэлээ. Монгол Улсын Засгийн газар огцорсонтой холбогдуулан шинэ Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнийг батлах, Монгол Улсын 2015 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэж батлахад багагүй хугацаа зарцууллаа.

Ардчилсан нам Монголын ард түмний нийтлэг ашиг сонирхол, эв нэгдлийг эрхэмлэж, улс оронд тулгамдаж буй эдийн засгийн хүндрэлийг даван туулах зорилгоор Улсын Их Хуралд суудалтай улс төрийн бүх намуудтай хамтран их эвслийн Засгийн газрыг байгууллаа.

Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль

баталсантай холбогдуулан Монгол Улсын төсвийн 2008-2014 онуудын хөрөнгө оруулалтад тусган бүрэн хэрэгжүүлж дууссан, гэрээний үлдэгдэл санхүүжилт бүхий 96 төсөл, арга хэмжээг 32.9 тэрбум төгрөгийн векселиэр санхүүжүүлэх, бодит гүйцэтгэл нь 80 -аас дээш хувьтай хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнүүдийг вексель гарган санхүүжүүлэх, тендерийн шалгаруулалт зарлагдаагүй, хэрэгжиж эхлээгүй төсөл, арга хэмжээг дахин хянаж зориулалтын дагуу үргэлжлүүлэх, дуудлага худалдаанд оруулах эсэхийг шийдвэрлэх, улс төрийн албан тушаалтны урсгал зардлын норм, норматив тогтоосон тогтоол, шийдвэрүүдийг хянан үзэх зэрэг асуудлыг Улсын Их Хурлын тогтоолоор Засгийн газарт даалгалаа.

Улсын Их Хурал анх удаагаа олон жил алдагдалтай явж ирсэн, өөрсдийгөө хуурсан төсвөөс татгалзаж, төсвийн сахилга бат тогтоосон төсвийг баталлаа. Энэ төсвөөр эдийн засгийн бодит байдалд нийцсэн, үр ашигтай байх зарчмыг баримталж олон жил дамжин үргэлжилж байгаа хуучин объектуудаа дуусгах хариуцлага хүлээсэн шийдвэр гаргасан нь онцлог байлаа.

2015 оны мөнгөний бодлогын гол зорилтыг тодорхойлж, Хөгжлийн банкаар дамжуулан хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний зарцуулалтыг төсөвт тусган тодотгол хийж, улсын өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг 2015 оны төсвийн жилд 58.3 хувиас хэтрүүлэхгүй байхаар тогтоолоо. Гэхдээ улсын өрийн буцаан төлөх график, макро эдийн засгийн бусад тооцоо, үзүүлэлтийг харгалзаж үзэхгүйгээр дээд хэмжээг ийнхүү хуульчилсан нь эдийн засагт хүндрэл дагуулж болзошгүй байна.

Засгийн газрын хавтгайрсан нийгмийн халамжийн тогтолцоог өөрчлөх, үр ашиггүй зардлыг бууруулах, богино хугацаанд тэвчиж болох зардлуудыг хэмнэх бодлогыг нухацтай хэлэлцэж, энэ удаад Монгол Улсын нэгдсэн төсвийн зарим орлогыг нэмэгдүүлэх замаар цалин, тэтгэврийг тодорхой хувиар нэмэгдүүлж, хүүхэд болон одонтой эхчүүдийн мөнгийг хэвээр үлдээхээр болсон. Цаашид төсвийн зарцуулалтыг үр ашигтай, хэмнэлттэй зохион байгуулж, эдийн засгийг эрчимжүүлэх замаар нийгмийн хөгжилд бодит үр дүн авчирсан хэм хэмжээг тогтоох нь чухал байна.

2015 оны төсвийн тодотголоор Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалт нэлээд буурлаа. Энэ нь эдийн засгийн бодит нөхцөлтэй холбоотойгоос гадна сангийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх шаардлагатай уялдан гарч байна.

Улс орны эдийн засгийн ирээдүйн хөгжилд чухал ач холбогдолтой том хэмжээний төслүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр Улсын Их Хурал онцгой анхаарч байна. Оюутолгой төслийн ажиллах эрх зүйн орчныг Улсын Их Хурал 2010 онд бүрэн бүрдүүлж өгсөн бөгөөд энэ төсөл цаашид амжилттай хэрэгжих ёстой. Засгийн газраас Оюутолгой төслийн хамтрагч талтай харилцан ашигтай, хамтын ажиллагааг зах зээлийн зарчимд нийцүүлэн үр дүнтэй үргэлжүүлнэ гэж найдаж байна.

Монгол Улсын стратегийн чухал орд болох Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах Хөрөнгө оруулалтын болон холбогдох бусад гэрээг байгуулахдаа Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон бусад хууль, тогтоомжид нийцүүлж, улс орны эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилтыг хангах нь төслийн амжилттай хэрэгжилт, ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг баталгаажуулах болно. Энэ төслийг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын иргэдийн эзэмшиж байгаа 1072 хувьцааг яаралтай эдийн засгийн эргэлтэд оруулж, бодитой үр ашгаа өгөх хэлбэрээр шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Гацууртын ордыг стратегийн ордод хамааруулж, эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлаар Улсын Их Хурал шийдвэр гаргасан нь эдийн засагт эерэг дохио болно. Улсын Их Хурлаас

энэ асуудлыг шийдвэрлэхдээ уг ордод төрийн эзэмшлийн хувийг тогтоох замаар бус, харин ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийг тооцож авах хэлбэрээр ордыг ашиглуулахаар Ашигт малтмалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг баталлаа. Тус ордоос 10 жилийн хугацаанд олборлох 70 тонн алтыг Монголбанкинд худалдах зохицуулалт хийсэн нь чухал ач холбогдолтой шийдвэр боллоо.

Улсын Их Хурлын гишүүд ээ,

Намрын чуулган ажлын 99 хоног үргэлжилж, нэгдсэн хуралдаан 48 удаа, Байнгын болон дэд хороод давхардсан тоогоор 170 удаа хуралдсан байна. Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганаар 165 хууль, 44 тогтоол хэлэлцэж баталснаас бие даасан хууль 13, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 124, хууль хүчингүй болгох тухай хууль 15, олон улсын гэрээ, конвенц соёрхон батлах, нэгдэн орох тухай тухай хууль 11 байна.

Чуулганаар Номын сангийн тухай хууль, Монгол хэлний тухай хууль, Чөлөөт бүсийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай, Чөлөөт бүсийн тухай, Нийгмийн даатгалын багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Боловсролын болон Эмийн талаар төрөөс баримтлах бодлого, Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогод нэмэлт, өөрчлөлт оруулах, Эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний тухай, Засгийн газарт чиглэл өгөх тухай тухай тогтоол зэрэг нийгэм, эдийн засгийн чухал ач холбогдолтой хууль, тогтоолуудыг баталлаа.

Хилийн боомтын бүсэд чөлөөт бүс байгуулж, хил орчмын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, хөрөнгө оруулагчдад татварын таатай орчинг бүрдүүлж, дэд бүтэц бүтээн байгуулалтыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар байгуулах зохицуулалт бүхий Чөлөөт бүсийн тухай хуулийг шинэчлэн баталлаа.

Соёлын тухай хууль, Монгол хэлний тухай хууль, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогыг батлан гаргасан нь үндэсний соёл иргэншлээ хамгаалан хөгжүүлэх, орчин цагийн монгол хүний сэтгэлгээний хэв маягийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Монгол хэлний тухай хуулиар монгол хэл, бичиг үсгээ эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж монгол үндэстний оюуны соёлын үнэт өв, үндэсний соёл иргэншлийн язгуур үндэс, улс орны нэгдмэл байдал, үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын баталгаа болохыг хуульчиллаа.

Эх оронч үндэсний үзлийг төлөвшүүлэх, соёл иргэншлийн аюулгүй байдлын дархлааг бий болгох, хүүхэд, залуучуудад үндэсний соёл, түүх, зан заншлаа таниулах чухал хөшүүрэг бол олон нийтийн мэдээллийн хэрэгсэл гэж үзэж телевиз, радио, кабелийн суваг, кино театр, үзвэрийн цэгээр нэвтрүүлэх уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлэгт үндэсний нэвтрүүлэг болон үндэсний киноны эзлэх хувийг тодорхой зааж хязгаарлалт тогтоолоо. Ингэснээр үндэсний контентын үйлдвэрлэлийг дэмжсэн эрх зүйн орчинг бүрдүүллээ. Бид энэ цаг үед эдийн засгийн түр зуурын хүндрэлийг даван туулах талаар онцгой анхаарч ажиллахын сацуу нийгмийн оюун санааны хөгжил талыг ч чухалчлан авч үзэх ёстой.

Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолоор Тавантолгой-Гашуун сухайт, Хөёт-Бичигт чиглэлийн төмөр замын царигтай холбоотой асуудлыг эцэслэн шийдвэрлэлээ. Дээрх чиглэлд шинэ төмөр зам барьснаар уул уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэх, хөрш орон болон гуравдагч зах зээлд эскпортод гаргах өргөн боломж бүрдэнэ.

Намрын чуулганы сүүлийн өдрүүдэд хэд хэдэн чухал хууль, тогтоолыг хэлэлцэн баталлаа. Монгол Улс, Япон Улсын хооронд байгуулсан “Эдийн засгийн түншлэлийн тухай хэлэлцээр”-ийг Улсын Их Хурал соёрхон баталлаа. Энэхүү хэлэлцээрийг баталснаар манай улс бүс

нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэн орох, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд нийцсэн гуравдагч хөршийн бодлогыг эдийн засгийн агуулгаар баталгаажуулахад том алхам болсон төдийгүй гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, аж үйлдвэрийн салбарын нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх, валютын орлогыг нэмэгдүүлэх болно.

Хэрэгжилт нь зогсонги байдалд ороод байсан Гол, мөрний урсац бүрэлдэх, эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг хэрэгжүүлэхийн тулд уг хуульд бус, харин түүнийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орууллаа.

Өрийн удирдлагын тухай хуулийг баталснаар цаашид арилжааны нөхцөлтэй зээллэгийн эргэн төлөлтөөс үүсэх төлбөрийн дарамтыг багасгаж, төсөв, санхүүгийн урт хугацааны тэнцвэрт байдлыг хадгалах үүднээс өрийн удирдлагын бодлого, стратеги, түүнд нийцсэн арга хэмжээг боловсруулах, гадаад өр үүсгэх замаар хөгжлийн бодлогыг тодорхой хэмжээнд дэмжих, дотоодын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, тэдгээрийн зохистой төвшинг хадгалах боломжтой болж байна.

Мөн Эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний хөтөлбөр баталлаа. Уг хөтөлбөр нь богино болон дунд хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдээс бүрдэж байгаа бөгөөд санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, макро эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж, ажлын байрыг хадгалах, эдийн засгийн тогтвортой өсөлтийн суурийг бэхжүүлэхэд чиглэсэн цогц агуулгатай юм.

Үндэсний үйлдвэрлэгчийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний хүрээнд ноосны чанараас хамаарсан ялгавартай урамшууллыг олгох, үйлдвэрийн эцсийн бүтээгдэхүүний чанарыг сайжруулж экспортыг нэмэгдүүлэх хүрээнд үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх тогтоол баталлаа.

Улсын Их Хурлын гишүүд ээ,

Улс орны эдийн засаг хүндрэлтэй байгаа цаг үед нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг цаг алдалгүй шийдэхэд Улсын Их Хурлын шийдвэр, санаачилга, хяналт маш чухал гэдгийг онцлон тэмдэглэж байна.

Монголын нийт ард иргэд ээ,

Та, бид хөх морин жилээ үдэж, 17 дугаар жарны модон хонь жилийн шинийн нэгнээ угтан золгох гэж байна. Эх орны дөрвөн зүг найман зовхист болон дэлхийн улс орнуудад ажиллаж амьдарч байгаа нийт монгол түмэндээ сар шинийн мэндийг дэвшүүлж, айл гэр аз жаргалаар дүүрэн байхын өлзий дэмбэрэлтэй ерөөлийг өргөн барья. Та бүхэн сар шинэдээ сайхан шинэлээрэй. Улсын Их Хурлын намрын чуулган хаасныг мэдэгдье.

\* \* \*



**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2015 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН**

(2015.04.06 - 2015.07.10)

**Чуулганыг нээж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг**

(2015.04.06)

Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд аа,  
Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,  
Хүндэт зочид оо,

Өнөөдөр Монгол Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулган эхэлж байна. Чуулганы завсарлагааны хугацаанд Та бид иргэд, сонгогчидтойгоо уулзан хууль тогтоомжийг сурталчилж, хэрэгжилтийн явцтай танилцан, хаврын чуулганаар хэлэлцэх хуулийн төслүүдийн талаар иргэдийн санал, бодлыг сонслоо.

Миний бие Дундговь, Өмнөговь аймагт ажиллаж, аймаг, сумын төвүүдэд иргэдтэй уулзаж, Оюутолгойн уурхай, Тавантолгой-Гашуунсухайтын төмөр замын бүтээн байгуулалттай танилцлаа. Дундговь аймгийн Гурвансайхан сумын төвд Төсвийн болон НҮБ, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр сумын төвийн усан хангамжийг сайжруулах төсөл хэрэгжиж хашаанд амьдарч буй айлын хувийн байшин дотроо цэвэр бохир устай болсон байна. Засгийн газрын мөрийн хөтөлбөрт 100 сумын усан хангамжийн асуудлыг шийднэ гэж тусгасны дагуу одоогоор төсөв болон НҮБ-ын төслийн хөрөнгөөр нийтдээ 30 орчим суманд ийм ажил хийгдээд байна. Энэ бол хот хөдөөгийн ялгааг арилгах, Монгол хүний хорин нэгдүгээр зуунд амьдрах үндсэн нөхцөлийг хангахад чухал ач холбогдолтой төсөл учраас тууштай үргэлжлүүлэх хэрэгтэй байна.

Өмнийн говьд дэлхийн хамгийн том, тэргүүний таван үйлдвэрийн нэг байгуулагдаж үйл ажиллагаа явуулж байна. 3000 хүн ажиллаж байгаагийн 95 хувь нь Монголчууд байна. Эдгээр залуучууд дэлхийн шилдэг техник, технологийг эзэмшиж эрч хүчтэй ажиллаж байна. “Эрдэнэт” үйлдвэрээс хоёр дахин их бүтээгдэхүүн үйлдвэрлэж, “Монголд үйлдвэрлэв” гэсэн шошготой зэсийн баяжмал савлагдаад экспортлогдож байна. Ил уурхай дээр Монголын Засгийн газар өөрт хамаарах бүх асуудлаа шийдсэн болохоор одоо хөрөнгө оруулагчид зээлээ аваад далд уурхайгаа ажиллуулах хэрэгтэй байна. Энэ талаар Оюутолгойн удирдлагуудтай уулзах үед байр сууриа илэрхийллээ.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын ажил эрчимтэй явагдаж байна. Төмөр замын тээврийн тухай хууль, Үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдал, үндэсний төмөр замын сүлжээ байгуулах зэрэг шаардлага, зорилтыг үндэслэн Тавантолгой-Гашуунсухайтын төмөр зам бол төрийн өмчит компанийн мэдэлд байна гэдэг шийдвэрийг 2011 онд Үндэсний аюулгүй байдлын Зөвлөл гаргасан. Энэ шийдвэрийг Засгийн газар мөрдөж ажиллах ёстой.

Уул уурхайн бүтээгдэхүүний үнийн уналт эдийн засгийн өсөлтөд муугаар нөлөөж байгаа хэдий ч уул уурхайн бус зарим салбарын экспортод ахиц дэвшил гарч байна. Үүнийг өмнөх онтой харьцуулахад 2015 оны эхний хоёр сарын байдлаар нэхмэлийн материал болон нэхмэл бүтээгдэхүүний экспорт 60 хувиар, малын гаралтай бүтээгдэхүүний экспорт 25 хувиар гэх мэтээр өссөн дүн харуулж байна. Энэ нь хүнд, хөнгөн аж үйлдвэрийн салбар, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлогоо тууштай үргэлжлүүлэхийг бидэнд сануулж байгаа хэрэг.

Иргэд парламентад суудалтай бүх нам, эвсэл хамтарч Засгийн газар байгуулсныг дэмжиж

байгаа ч итгэлцлээ батжуулж харилцан зөвшилцөж ажлаа эрчимжүүлэхийг анхааруулж байна. Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэн үүнд анхаарлаа хандуулж ажиллахыг хүсэж байна.

Улсын Их Хурлын даргын Япон, ХБНГУ, БНПУ-д хийсэн албан ёсны айлчлал амжилттай болж хоёр талын парламент хоорондын харилцааг өргөтгөх талаар хэлэлцээр хийж, хамтын ажиллагааны олон чухал асуудлаар санал солилцлоо.

Монгол Улсын Их Хурал Япон Улстай байгуулсан Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг богино хугацаанд хэлэлцэж баталсан. Япон Улсын парламент ойрын хугацаанд батална гэдгээ илэрхийллээ. Хоёр орны эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулагдаж байгаа нь Япон Улсын аж үйлдвэрийн глобал сүлжээнд нэгдэн орж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг олгох юм.

Бид хөрш хоёр оронтой харилцах харилцаанд тулгуурлан гуравдагч хөрш орнуудтай идэвхтэй хамтран ажиллаж эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг хийх бодлогыг тууштай баримтлах хэрэгтэй байна. Япон, ХБНГУ бол нэг нь Азийн, нөгөө нь Европын Холбооны нөлөө бүхий хамгийн том эдийн засагтай улс орнууд. Аль алинд нь машин үйлдвэрлэл, аж үйлдвэрийн салбар өндөр хөгжсөн болохоор түүхий эдийн тогтвортой хангамж хэрэгтэй байна. Тэр нь Монгол Улсад байна. Ийм таатай нөхцөлд энэ хоёр улсын техник, технологиос суралцаж, түүхий эддээ хоёр, гурав дахь шатны боловсруулалт хийж экспортын хэмжээг нэмэгдүүлэхэд эдгээр улсуудын хөгжсөн эдийн засгийг ашиглах хэрэгтэй.

Энэ жил Монгол, БНПУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ой тохиож байна. Хоёр орны хоорондын эдийн засаг болон худалдааны эргэлтийг нэмэгдүүлэхийн тулд Улаанбаатар дахь Польшийн Элчин сайдын яамны үйл ажиллагааг сэргээх, уул уурхай, эрчим хүч, дэд бүтцийн салбарт хамтран ажиллах, хоёр улсын хооронд дамжин өнгөрөх тээврийн хэлэлцээр байгуулж, худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх талаар хоёр талын сонирхол нэгдмэл байна.

Дээрх гурван улсын төр засаг, аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудтай уулзахад өмнө нь ярьсан, хэлэлцсэн асуудлаа ажил хэрэг болгохын төлөө санаачлагатай ажиллахыг бидэнд анхааруулж байна. Энэ бол бодитой шүүмжлэл гэж бид хүлээн авч Засгийн газар, улс хооронд хийгдсэн гэрээ хэлцлийн гүйцэтгэлд хатуу хяналт тавьж ажиллах хэрэгтэй.

Эрхэм гишүүд ээ,

2012 оны сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан энэ удаагийн Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа дуусахад 1 жилийн хугацаа үлдэж байна. Бидэнд хугацаа бага, шийдэх асуудал их байна. Өнгөрсөн хугацаанд бид улс орны хөгжлийн бодлогын олон чухал асуудлуудыг шийдвэрлэсэн хэдий ч зайлшгүй хэлэлцэж шийдвэрлэх багагүй асуудал хүлээгдэж байна.

Энэ удаагийн хаврын чуулганаар хуульд заасны дагуу Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт болон Монгол Улсын Засгийн газрын 2014 оны санхүүгийн нэгдсэн тайлан, Монгол Улсын 2014 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэн батална.

Түүнчлэн Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тэмцэх тухай, Сонгуулийн тухай, Улс төрийн



намуудын тухай, Намуудын санхүүжилтийн тухай зэрэг олон чухал хууль хэлэлцэгдэнэ. Мөн Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах цогц бодлого батлах тухай, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичгийг батлах тухай, Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай, Үйлдвэрлэлийг дэмжих тухай, Төрийн албаны тухай зэрэг хуулийн шинэчилсэн найруулгын төсөл зэрэг хууль тогтоолын төслүүдийг хэлэлцэж батлахаар тусгаад байна.

Улсын Их Хурлын даргын захирамжаар Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Улс төрийн намын тухай, Улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулийг нэгтгэх, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай, Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулиудыг нэгтгэж Монгол Улсын сонгуулийн нэгдсэн хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгүүд байгуулагдан ажиллаж байна.

Сонгуулийн тухай болон улс төрийн намын тухай хуулийн төслүүдийг энэ чуулганаар хэлэлцэж батлах нь улс төрийн чухал ач холбогдолтой болохыг эрхэм гишүүд Та бүхэн ойлгож байгаа гэдэгт итгэж байна. Миний ойлгож байгаагаар эдгээр хуулиудын үзэл баримтлалыг намууд харилцан зөвшилцсөн тохиолдолд тийм ч олон өөрчлөлт орохгүй. Ялангуяа Сонгуулийн тухай хууль аль болохоор тогтвортой мөрдөгдөх нь төрийн тогтвортой байдалд ч чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Сүүлийн үед төрийн албан хаагчдыг хоморголон халж байгаа талаар Улсын Их Хуралд олон арван гомдол, санал ирж байгаад сэтгэл эмзэглэж байна. Төрийн албан хаагчдыг халж солихын тулд намууд хамтарч ажиллаагүй гэдгийг Засгийн газар, салбар хариуцсан сайд нар анхааралдаа авч бүх шатанд халаа сэлгээгээ яаралтай зогсоох хэрэгтэй. Төрийн албан хаагчид бол төрийн албаны хуулиар зохих ёсоор хамгаалагдсан хүмүүс. Тийм учраас Төрийн албаны зөвлөл энэ асуудалд анхаарлаа хандуулж хуулийн хүрээнд хатуу хяналт тавьж ажиллахыг үүрэг болгож байна.

Тавантолгойн ордыг ашиглах хэлэлцээрийн явцыг Улсын Их Хурлын зүгээс анхааралтай ажиглаж байна. Монгол Улсын Үндсэн хуулинд зааснаар “газрын хэвлий, түүний баялаг төрийн өмч мөн”. Тавантолгойн нүүрсний ордыг улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн орд юм.

Засгийн газар Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолын хүрээнд Тавантолгойг ашиглах уралдаант шалгаруулалтыг явуулж байна. Гэтэл Тавантолгойн ордыг ашиглах талаар явагдаж байгаа хэлэлцээр нь Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг зөрчиж байна.

Энэ талаар Улсын Их Хурлын удирдлага байр сууриа албан ёсоор илэрхийлж, 2015 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр Засгийн газарт хүргүүлсэн. Энэхүү хэлэлцээрийг байгуулж байгаа нөхцөлөөс харахад Монгол Улсын эдийн засаг нэг зах зээлээс бараг бүрэн хамааралтай болох нөхцөл үүсэж байна.

Энэ нь 2010 онд Улсын Их Хурлаар баталсан Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан нэг улсын хөрөнгө оруулалтыг нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс ихгүй байлгана гэсэнтэй нийцэхгүй байна.

Засгийн газрын байгуулахаар төлөвлөж байгаа гэрээ, хэлэлцээрийн төслийг өнөөдөр өглөө нэхэж авлаа. Гэрээ, хэлэлцээрийн төслийг эрхэм гишүүд Та бүхэнд хүргүүлсэн. Та бүхэн

эдгээр гэрээг уншаад, Засгийн газар яагаад Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхгүйгээр, чуулган нээгдэж байгаа энэ өдөр яаран шийдвэрлэх гэж байгааг ойлгох болно.

Өнөөдөр байгуулахаар төлөвлөж байгаа эдгээр гэрээ, хэлэлцээрийн төслийг харахад Монгол Улсын үндэсний эрх ашгийг хангаж чадаагүй байна. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын үүрэг маш тодорхой хугацаатай байгаа бол нөгөө талын үүрэг нь хугацаагүй, зорилтын шинж чанартай, зорилт биелэгдээгүй тохиролдолд хүлээх хариуцлага байхгүй байна.

Мөн Тавантолгойн ордыг ашиглах гэрээг 30 жилээр байгуулж, дахин 30 жилээр сунгах, Иргэдийн эзэмшиж буй 1072 ширхэг хувьцааг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай ямар ч тохиролцоо хийгдээгүй, Нэмэлт хайгуул хийгээд нөөцийг нь яах нь тодорхойгүй, 4 тэрбумын хөрөнгө оруулалтад одоо оруулсан “Энержи Ресурс” компанийн хөрөнгө оруулалтыг хамруулсан, Төмөр зам өргөтгөх бол зөвхөн хөрөнгө оруулагч нөгөө тал хийх эрхийг олгосон, төрийн өмчит “Монголын төмөр зам” ХК-ийн зардлыг шалгасны дараа төлөх, нөгөө талын хөрөнгө оруулалтыг үнэлэхгүйгээр байгаагаар нь тооцох зэрэг заалтуудыг оруулж, гэрээг байгуулсны дараа цуцалсан тохиолдолд хөрөнгө оруулагч “Шинхуа” компанийн 30 жилд олох байсан ашгийг төлөх үүрэг хүлээсэн байна.

Эдгээр гэрээг байгуулахдаа Монголын тал ямар ч хуулийн болон санхүүгийн хөндлөнгийн зөвлөгөө аваагүй, харин хөрөнгө оруулагч тал олон улсын нэр хүнд бүхий “Deloitte”, “KPMG” зэрэг компаниас үйлчилгээ авсан байна. Ийм ноцтой үр дагавартай, Монгол Улсад илт хохиролтой гэрээ, хэлэлцээр байгуулахыг би зөвшөөрөхгүй. Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолын дагуу Тавантолгой ордыг ашиглах гэрээг Улсын Их Хурал яаралтай хэлэлцэж шийдвэрлэх ёстой.

Хэрэв Тавантолгойн ордыг ашиглах гэрээ, хэлэлцээрийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхгүйгээр өнөөдөр гарын үсэг зурах шийдвэр гаргасан, гарын үсэг зурахаар оролдсон сайд нарт хариуцлага тооцон огцруулахыг санаачлах болно.

Эрхэм гишүүд ээ,

Энэ хаврын чуулганаар цаг хугацаа тулсан олон чухал асуудал хэлэлцэгдэх учир Байнгын хороо, нам эвслийн бүлэг нэлээд ачаалалтай ажиллана. Бодит байдалд дүгнэлт хийж эрхэм гишүүд Та бүхэн нам, эвслийн бүлэг, Байнгын хороо, чуулганы үйл ажиллагаанд идэвхи, санаачлагатай оролцож, хэлэлцэхээр төлөвлөсөн асуудлаа бүрэн шийдвэрлэнэ гэдэгт итгэж байна. Бидэнд маш бага хугацаа үлдэж байгаа гэдгийг дахин сануулья.

Та бүхэнд ажлын амжилт хүсч, Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганы ажиллагааг нээснийг мэдэгдье.

\* \* \*

### **Чуулганыг хааж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг**

(2015.07.10)

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Өнөөдөр Улсын Их Хурлын 2015 оны хаврын чуулган өндөрлөж байна. Өнгөрсөн хугацаанд нэгдсэн хуралдааныг 33 удаа, байнгын болон дэд хорооны хуралдааныг давхардсан тоогоор 196 удаа хийж, бие даасан хууль 20, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль 64, олон улсын гэрээ, конвенци, зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хууль 16, хууль, хуулийн хэсэг, зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хууль 18, Улсын Их Хурлын тогтоол 32, Байнгын хорооны тогтоол 93 -ыг тус тус хэлэлцэж баталлаа.



Хаврын чуулганаар Монгол Улсын 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017 - 2018 оны төсвийн төсөөллийн тухай, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, “Засгийн газрын өрийн удирдлагын 2016 - 2018 оны стратегийн баримт бичиг” болон эдийн засаг, нийгэм, эрх зүйн чиглэлийн томоохон хуулиуд батлагдлаа. Төрөөс аж үйлдвэр, эрчим хүчний талаар баримтлах бодлого, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх, Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулиудыг шинээр баталж, Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийг тодорхойллоо.

Үндэсний үйлдвэр стандартын шаардлага хангасан бараагаар дотоодын хэрэгцээг хангах боломжтой тохиолдолд гадаадын бараа нийлүүлэгчийг тендерт шалгаруулахыг хориглох, эх орондоо үйлдвэрлэж байгаа 370 орчим нэр төрлийн импортын бараанд ногдуулж байсан 5 хувийн гаалийн албан татварыг 20 хүртэл хувиар нэмэгдүүлэх, түүхий болон анхан шатны боловсруулалт хийсэн бүтээгдэхүүнийг гадаадад гаргахад нэмэгдсэн өртгийн албан татвар төлдөг болгох өөрчлөлтийг холбогдох хуулиудад хийж, дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны жагсаалтыг батлах, гаалийн албан татварын хувь хэмжээг барааны онцлогийг харгалзан тогтоох эрхийг Засгийн газарт олголоо. Ингэснээр түүхий болон өртөг бага шингэсэн бүтээгдэхүүнийг гадагшаа гаргах урсгалыг хязгаарлаж, дотоодын үйлдвэрлэгчид, иргэдээ дэмжих нөхцөл бүрдэж байна. Түүнчлэн нэмэгдсэн өртгийн албан татварын 10 саяын босгыг 50 сая төгрөг болгон нэмэгдүүлж, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч иргэнд худалдан авалтандаа төлсөн НӨАТ-ын 2 хүртэл хувийг буцаан олгохоор боллоо.

Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлагдсантай холбогдуулан аж ахуйн томоохон нэгжүүдийг хувьчлах явцад хөрөнгийн биржээр хувьчлах ажиллагаанд Засгийн газар онцгой анхаарч холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах хэрэгтэй.

Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль батлагдаж, Улаанбаатар хот архи, тамхи, зочид буудлын жижиглэнгийн борлуулалтаас иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоосон хувиар татвар авах хуультай болсноор гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд инженерийн болон нийгмийн дэд бүтэц, орон сууц, нийтээр ашиглах барилга байгууламжийг шинээр байгуулах, орон нутгийн төсвийг бүрдүүлэх, төвлөрлийг сааруулах, орон нутгаас нийслэл хот руу чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөнийг эдийн засгийн аргаар хязгаарлах эрх зүйн орчин бүрдэж байна.

“Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоол, “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуульд нэмэлт оруулах тухай”, “Хүүхэд харах үйлчилгээний тухай” хууль баталснаар олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлж, ахмад настны тэтгэврийг урт хугацаанд тогтвортой олгох, тэтгэврийн даатгалд хамрах хүрээг өргөтгөх, төрөөс үзүүлж буй нийгмийн үйлчилгээг хүүхэд бүрт тэгш, хүртээмжтэй хүргэх эрх зүйн зохицуулалтыг хийж чадлаа.

Захиргааны байгууллагын суурь хууль болох Захиргааны ерөнхий хууль, “Нийтийн сонсголын тухай” хуулийг баталснаар төрийн үйл ажиллагааг нэгдсэн стандарт, жишигт оруулж, ил тод, нээлттэй, хариуцлагатай болгох, төрийн бодлого боловсруулах, хэлэлцэх, шийдвэр гаргах түвшинд иргэд, олон нийтийг өргөнөөр оролцож төрийн бодлого, шийдвэрт саналаа тусгуулах бодит боломжийг нээж өглөө.

Сүүлийн жилүүдэд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон этгээдийн буруугаас олон мянган хүн амь насаа алдаж, гэмтэж бэртсэнээс хөдөлмөрийн чадвараа алдаж байна. Улсын Их Хурал “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай” хуулийг шинэчлэн баталж согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодвол 384 мянган төгрөгөөр торгож, жолоодох эрхийг 6 сараас 2 жил хүртэл хугацаагаар хасах, дээрх үйлдлийг давтан үйлдвэл 384-768 мянган

төгрөгөөр торгож, 30 хоног баривчилж, жолооны эрхийг 3 жил хүртэл хугацаагаар хасахаар боллоо. Цаашид шинээр гарах Эрүүгийн хуульд давтан үйлдсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэж хорих ялтай болгохоор төлөвлөж байна.

Засгийн газрын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөх бүрд бүтцийн өөрчлөлт нэрээр төрийн албан хаагчдыг ажлаас чөлөөлдөг, халдаг буруу жишиг тогтсоноор төрийн албан хаагчдын дархлаа суларч, боловсон хүчний чадавх доройтож байна. Энэ буруу жишгийг таслан зогсоохын тулд хэдхэн хоногийн өмнө Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөн барьсан Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурал хэлэлцэхээр болсон.

Эрхэм гишүүд ээ,

Оюу толгойн ордыг ашиглах асуудлаар Улсын Их Хурал холбогдох шийдвэрийг гаргасан. Оюутолгой орд эдийн засгийн эргэлтэд орж, бүтээгдэхүүнээ экспортолж байна. Монгол улсын Засгийн газар Оюутолгойн далд уурхайг ашиглах төлөвлөгөөг хөрөнгө оруулагчтай хамтран баталсан нь зах зээлд эерэг дохио өглөө. Одоо Оюутолгойн далд уурхайг ашиглах хөрөнгө оруулалтыг Монгол Улс хүлээж байна.

Таван толгойн ордыг ашиглах асуудлыг шийдвэрлэхдээ тухайн ордын зах зээлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, “Эрдэнэс-Таван толгой” компанид хувьцаа эзэмшиж байгаа Монгол Улсын төр болон 1072 ширхэг хувьцаа эзэмшигч Монгол Улсын иргэд, үндэсний аж ахуйн нэгжүүдийн хүртэх эдийн засгийн өгөөжийг хамгийн өндөр хэмжээнд байлгах нь чухал. Тус ордыг эдийн засгийн эргэлтэд оруулсны нэг чухал үр дүн нь Монгол Улс иргэд, үндэсний аж ахуйн нэгж ногдол ашиг хүртэх эдийн засгийн бүтцийг бий болгох явдал юм. Тиймээс зөвхөн Цанхийн хэсгийг биш, тус ордыг бүхэлд нь дэд бүтцийн хамт цогцоор нь ашиглах асуудлыг шийдвэрлэх нь Монголын эрх ашигтай нийцэж байгаа юм. Тиймээс Таван толгойн бүлэг ордоос урагшаа болон зүүн чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах хөрөнгө оруулалтын асуудлыг хамтад нь цогцоор шийдвэрлэх ёстой гэж үзэж байна. Ингэснээр тус ордын үнэ цэнэ нэмэгдэж, эдийн засгийн үр өгөөж өндөр байх болно.

Таван толгойн ордыг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай хамтран ашиглахаар Засгийн газраас боловсруулсан Хөрөнгө оруулалтын гэрээ болон бусад дагалдах гэрээ нь Монгол Улсын эрх ашгийг хангаагүй, Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомжийг зөрчсөн гэж Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг дүгнэсэн. Энэ үндэслэлээр Засгийн газар төслөө буцаан татсан. Цаашдаа бид уул уурхайн том төслүүдийг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай хамтран ашиглахдаа Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлийн 2-т заасан “... газрын хэвлий түүний баялаг төрийн өмч мөн” гэснийг хатуу мөрдөж ажиллах ёстой. Үндсэн хуулийн энэ заалтын дагуу уул уурхайн том төслийн үр өгөөжийг нэн тэргүүнд ард түмэн хүртдэг байх ёстой. Үүнд хяналт тавих нь төрийн үүрэг мөн. Тиймээс Монгол Улсын Их Хурал хууль тогтоох төрийн эрх барих дээд байгууллагын хувьд Таван толгой зэрэг стратегийн ордыг ашиглахтай холбогдсон гэрээ, хэлэлцээрийг байгуулах явцад Монгол Улсын язгуур эрх ашиг, үндэсний аюулгүй байдал, олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалж хуулийн хүрээнд Засгийн газарт хяналт тавьж ажиллах болно. Засгийн газар Гацууртын ордын асуудлаар Улсын Их Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхэд анхаарлаа хандуулж ажиллах хэрэгтэй.

Миний бие Улсын Их Хурлын хаврын чуулганы хугацаанд Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн газартай хамтран хэрэгжүүлж байгаа “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд зохион байгуулагдаж байгаа сургалтын нээлтэд оролцож Сэлэнгэ, Дархан-Уул, Говь-Алтай, Завхан аймгуудад ажиллалаа.

Энэ явцад Алтанбулагийн чөлөөт бүс, Дархан хот дахь төмөрлөгийн үйлдвэр, Дархан нэхий, Хөтөлийн цементийн үйлдвэр, Алтай хотод баригдаж буй 1000 айлын орон сууцны хороолол, “Эрүүл ус” орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагаатай танилцсан. Мөн “Чингис”, “Самурай” бондын санхүүжилтээр хийгдэж буй авто зам, төмөр зам, үйлдвэрлэл, уул уурхай, цахилгаан станц, агаарын тээвэр, дэд бүтэц, жижиг дунд үйлдвэрлэлийн салбарын томоохон төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үр дүнтэй газар дээр нь танилцлаа.

Дээрх бондын хөрөнгөөр өргөтгөсөн, шинээр байгуулсан орчин үеийн дэвшилтэт технологи, тоног төхөөрөмж бүхий үйлдвэр аж ахуйн газрууд дэлхийн жишигт нийцсэн чанар, стандарттай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, аймаг, нийслэлийг холбосон болон дотоод сүлжээний авто замын бүтээн байгуулалт эрчимтэй хийгдэж, олон зуун хүнийг ажлын байртай болгож байна. Энэ бол бондын хөрөнгийн нүдэнд харагдаж гарт баригдаж байгаа бодит үр дүн. Эдгээр үйлдвэр, аж ахуйн газруудын зайлшгүй шаардлагатай тохиолдолд тоног төхөөрөмж техник хэрэгслийг татвараас чөлөөлөх, боловсон хүчнийг нь давтан бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх шаардлага байгааг Засгийн газар анхааралдаа авч дэмжиж ажиллах хэрэгтэй.

Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы хугацаанд хэлэлцэхээр төлөвлөгдсөн ч МАН-ын завсарлагаас болж Өршөөлийн тухай, Эдийн засгийн ил тод байдлын тухай хуулиудыг баталж чадсангүй. Түүнчлэн Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Сонгуулийн тухай, Улс төрийн намуудын тухай, Улс төрийн намын санхүүжилтийн тухай хууль өргөн баригдаагүй учраас хэлэлцэж амжсангүй.

Эрүүгийн болон Зөрчлийн тухай, Өршөөлийн тухай, Эдийн засгийн ил тод байдлын тухай хуулийг яаралтай батлах, Ардчилсан нам, МАН-ын хооронд байгуулсан “Харилцан итгэлцэл, хамтын ажиллагааны гэрээ” цуцлагдаж байгаагаар холбогдуулан МАН-ын зургаан сайдыг чөлөөлж, шинэ сайдуудыг нөхөн томилох асуудлыг шийдвэрлэх зорилгоор 2015 оны 8-р сарын 3-ны өдөр Улсын Их Хурлын ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулахаар төлөвлөж байна.

Түүнчлэн Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг 9-р сарын дундуур ээлжит бус чуулган зарлаж тусгайлан хэлэлцэж, өөр ямар нэгэн асуудал хэлэлцэхгүйгээр намрын чуулганы нээлт хүртэл явахаар ингэж бас төлөвлөж байгаа. Энэ зуны амралт дундаа хоёр удаагийн ээлжит бус чуулган хийхээр байгааг тооцож гишүүд ажил, амралтаа зохицуулах хэрэгтэй. Энэ амралтын хугацаанд болох хоёр том олон улсын арга хэмжээ байна.

7 дугаар сарын 29-нд Монгол Улсад анхны ардчилсан чөлөөт сонгууль явагдсан, байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тэмдэглэнэ, 9 дүгээр сарын 15-18-ны хооронд Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Парламентын ассамблейн хурал Монгол Улсад болно. Парламентын ассамблейн гишүүн болон ажиглагч 72 улсын 400 орчим төлөөлөгч оролцсон намрын хуралдаан Монгол Улсад зохион байгуулахад гишүүд бас идэвхтэй оролцох хэрэгтэй.

Эрхэм гишүүд ээ,

Маргааш Тулгар төрийн 2224, Их Монгол Улсын 809, Ардын хувьсгалын 94 жилийн ой, Үндэсний их баяр наадмын үйл ажиллагаа эхлэх гэж байна. Наадмын маргааш намар гэдэг. Энэ жил хур бороо бага, хэт халуун болж байгаагаас олон аймаг, сум гандуу байна. Тариа будаа, төмс хүнсний ногооны гарц ч тааруухан байна. Тийм болохоор төр засгийн бүх шатны байгууллын эрх баригчид, монголчууд та бүхэнд өвөлдөө өнөтэй орохын тулд өвөлжилтийн бэлтгэлээ хангах арга хэмжээг эртнээс төлөвлөж, бодитой ажлуудыг хийх шаардлага тулгарч байна. Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэн тойрогтоо ажиллах үедээ энэ асуудалд онцгой анхаарч ажиллах хэрэгтэй.

Монголын нийт ард түмэндээ баярын мэнд дэвшүүлж аз жаргал хамгийн сайн сайхныг хүсэн ерөөе. Та бүхэн сайхан наадаарай. Улсын Их Хурлын 2015 оны хаврын чуулган өндөрлөснийг мэдэгдье.

\* \* \*



**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2015 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН**

(2015.08.03 - 08.14)

Ээлжит бус чуулганыг нээж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг

(2015.08.03)

Монгол Улсын Ерөнхий сайд аа,  
Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын ээлжит бус чуулганыг 2015 оны 8 дугаар 03-14 хүртэлх хугацаанд хуралдуулахаар 015 оны 7 дугаар сарын 28-ны өдөр 156 тоот захирамж гаргасан.

Үүний дагуу хаврын чуулганы хугацаанд хэлэлцэж байсан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Зөрчлийн тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Галт зэвсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Эдийн засгийн ил тод байдлын тухай хуулийн төсөл, Өршөөл үзүүлэх тухай хуулийн төслийг тус тус үргэлжлүүлэн хэлэлцэх гэж байна.

Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг “Засгийн газрын зарим гишүүдийг огцруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг өргөн мэдүүлэх асуудал хуульд заасан процессын дагуу явагдаж байгаа гэж мэдэгдсэн тул энэ 7 хоногийн хэлэлцэх асуудлын дараалалд өөрчлөлт орж, уг асуудлыг өргөн баригдмагц хэлэлцэхээр даргын зөвлөл дээр шийдвэрлэсэн болно.

Эдгээр асуудлыг энэ 14 хоногийн дотор хэлэлцэж, ээлжит бус чуулганыг өндөрлөхөөр төлөвлөсөн тул эрхэм гишүүд та бүхнийг нам, эвслийн бүлэг, холбогдох Байнгын хороо, чуулганы хуралдаанд идэвхтэй оролцож дээрх асуудлуудыг цаг хугацаанд нь багтаан батална гэдэгт итгэж байна.

Улсын Их Хурлын ээлжит бус чуулганы хуралдааныг нээснийг мэдэгдье.

\* \* \*

**Ээлжит бус чуулганыг хааж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг**

(2015.08.14)

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

2015 оны 08 дугаар сарын 03-ны өдөр нээгдсэн Улсын Их Хурлын ээлжит бус чуулган 11 өдөр хуралдаж, өнөөдөр өндөрлөж байна.

Ээлжит бус чуулганаар Галт зэвсгийн тухай, Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай, Өршөөл үзүүлэх тухай зэрэг хаврын чуулганы хугацаанд хэлэлцэгдэж байсан хуулиудыг үргэлжлүүлэн хэлэлцэж баталлаа. Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын өргөн мэдүүлсний дагуу Засгийн газрын зарим гишүүдийг чөлөөлөх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Ээлжит бус чуулганаар хэлэлцэхээр төлөвлөсөн Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, Зөрчлийн тухай хуулийн төслүүдийг намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэхээр хойшлууллаа.

Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль батлагдсанаар хувь хүн, хуулийн этгээд бусдын нэр дээр бүртгүүлсэн, нуун дарагдуулсан хөрөнгө, орлогоо сайн дурын үндсэн дээр

ил тод болгон үнэн зөв, шударгаар санхүү, татварын болон нийгмийн даатгалын тайланд тусгаж, шинээр тайлагнасан, гаалийн байгууллагад нөхөн мэдүүлсэн, улсын бүртгэлд шинээр бүртгүүлсэн тохиолдолд хуульд заасан хариуцлагаас чөлөөлөх, албан татвар, хүү, торгууль, алданги нөхөн оногдуулахгүй байх нэг удаагийн чөлөөлөлтийг зохицуулахаар шийдвэрлэлээ. Энэ хуулийн үйлчлэх хүрээнд Авилгын эсрэг хуулийн дагуу хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргадаг албан тушаалтануудад хамаарахгүй болохыг онцлон тэмдэглэж байна.

Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдээс өргөн барьсан Галт зэвсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдлаа. Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн галт зэвсэг, түүнтэй адилтгах хэрэгсэл, сум өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг хангах, галт зэвсэг, сумны эргэлтэд хяналт тавьж, аюулгүй ажиллагааг мөрдүүлэх илүү нарийвчилсан зохицуулалтыг бий болгож, өмнө нь зохицуулагдаагүй байсан зарим харилцааг хуульчилж өгсөнөөрөө ач холбогдолтой хууль боллоо.

Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн, ял шийтгүүлсэн этгээдэд өршөөл үзүүлэх тухай хуулийг баталлаа. Энэ удаагийн Өршөөл үзүүлэх тухай хуульд иргэн бүр хууль, шүүхийн өмнө адил тэгш эрхтэй байх Үндсэн хуулийн тулгуур зарчмыг баримталсан болно. Өршөөлийн хуулийн дагуу тухайн этгээд ялаас өршөөгдөх болон үүсгэн шалгагдаж байгаа эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох нь тухайн гэмт хэргийн улмаас бусдад учирсан хохирлыг нөхөн төлөхөөс чөлөөлөхгүй юм. Мөн энэхүү хуульд зааснаар гэмт хэргийг хэрэгсэхгүй болгоход сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс гэм буруугаа хүлээн зөвшөөрч, хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн байхаар тусгасан болно.

Өршөөл үзүүлэх тухай хуульд Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавихаа мэдэгдсэн. Энэ хориг ирэх 7 хоногт орж ирэх гэж байгаа тул дахин ээлжит бус чуулган хуралдуулах шаардлага гарч байгааг бас тэмдэглэе. Мөн Ерөнхий сайдын өргөн мэдүүлсний дагуу шинээр томилох 6 сайдын асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэхээр ийм хоёр шалтгаанаар ээлжит бус чуулганы товыг ирэх 7 хоногт дээрх хоёр асуудлыг өргөн баригдмагц зарлах болно.

Улсын Их Хурлын ээлжит бус чуулган хаасныг мэдэгдье.

\* \* \*





**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2015 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН**

(2015.09.07 - 2015.09.18)

**Ээлжит бус чуулганыг нээж Улсын Их Хурлын дэд дарга Р.Гончигдоржийн хэлсэн үг**

(2015.09.07)

Монгол Улсын Ерөнхий сайд,  
Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Засгийн газрын гишүүн албан тушаалаас огцорч орон гарсан тохиолдолд Улсын Их Хурал 30 хоногийн дотор түүнийг нөхөн томилох зохицуулалттай.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт Ерөнхийлөгч хориг тавьсан бол Улсын Их Хурал түүнийг чуулганы үеэр 14 хоногийн дотор, чуулганы чөлөөт цагт хориг тавьсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 10 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэж тогтоол батална” гэж заасан байдаг.

Иймд Засгийн газрын зарим гишүүдийг томилох асуудал болон Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэхээр энэхүү ээлжит бус чуулганыг 2015 оны 9 дүгээр сарын 07 -ноос 18 -ны өдрүүдэд хуралдуулна.

Улсын Их Хурлын 2015 оны ээлжит бус чуулганы хуралдаан нээснийг мэдэгдье.

\*\*\*

**Ээлжит бус чуулганыг хааж Улсын Их Хурлын дэд дарга Р.Гончигдоржийн хэлсэн үг**

(2015.09.18)

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

2015 оны 9 дүгээр сарын 07-ны өдөр нээсэн Улсын Их Хурлын ээлжит бус чуулганаар Засгийн газрын зарим гишүүнийг томилох тухай асуудал болон Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг хэлэлцэхээр төлөвлөсөн билээ. Монгол Улсын Засгийн газрын зарим гишүүнийг томилох тухай Улсын Их Хурлын тогтоолыг баталж, Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллах боломж бүрдлээ.

Мөн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт Ерөнхийлөгч чуулганы чөлөөт цагт хориг тавьсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 10 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэж, тогтоол батална гэж Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн хоригийг 2015 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр хэлэлцэн хүлээн авч, тогтоол гарган шийдвэрлэлээ.

Ингэснээр Өршөөлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 болон 7 дугаар зүйл уг хуулиас хасагдан Өршөөлийн тухай хуулийн бусад хүчин төгөлдөр Өршөөлийн тухай хуулийн дагуу өршөөл үзүүлэх ажиллагааг Өршөөл үзүүлэх комисс эрхлэн гүйцэтгэх болно. Ингээд Улсын Их Хурлын ээлжит бус чуулган хаасныг мэдэгдье.

\*\*\*

## УЛСЫН ИХ ХУРЛЫН 2015 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

(2015.10.01 - 2016.02.05)

### Чуулганыг нээж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг

(2015.10.01)

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,  
Хүндэт зочид оо,

Өнөөдөр Улсын Их Хурлын долоо дахь удаагийн намрын ээлжит чуулган нээгдэж байна. Хаврын чуулганы завсарлагааны хугацаанд Монгол Улсад олон чухал тэмдэглэлт үйл явдал тохиолдлоо. Тухайлбал, Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан уламжлалт арга хэмжээнүүдээс гадна Ардын Их Хурлын дарга, орлогч дарга, Улсын Бага Хурлын гишүүд, үе үеийн парламентын дарга, Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга нарыг оролцуулан хүндэтгэлийн хуралдааныг энэ танхимдаа хийсэн.

Мөн Монгол Улсад анх удаа ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн намрын хурлыг амжилттай зохион байгуулж, тус Ассамблейн ерөнхийлөгч Илкка Канерва, Оросын Холбооны Улсын Холбооны Хурлын Төрийн Думын дарга Сергей Евгеньевич Нарышкин зэрэг 47 орны 300 гаруй парламентын гишүүд, олон улсын 13 байгууллагын 19 төлөөлөгчид оролцлоо. Дэлхийн нэр хүндтэй энэхүү хурлаар “ЕАБХАБ-ын бүс нутаг болон олон улсын түвшин дэх аюулгүй байдлын сорилт бэрхшээлүүдийг хэлэлцэх нь: Бүс нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлэхэд парламентчдын гүйцэтгэх үүрэг” сэдвийн хүрээнд бүс нутгийн аюулгүй байдал, терроризм, хүний наймаатай тэмцэх, бүс нутагт тулгараад байгаа эдийн засгийн сорилт бэрхшээлүүд зэрэг олон чухал асуудлаар өргөн хэлэлцүүлэг явууллаа.

Миний бие Нью-Йорк хотод болсон Олон улсын Парламентын холбооноос 5 жил тутамд зохион байгуулдаг Парламентын спикерүүдийн дэлхийн IV бага хуралд оролцож үг хэллээ. Бага хурал 2015 онд дуусч байгаа Мянганы хөгжлийн зорилтуудыг дүгнэх, ирэх 15 жилийн зорилтуудыг тодорхойлоход парламентын түвшинд ямар ажил хийвэл зохистой талаар хэлэлцсэн.

Эцэст нь бага хуралд оролцогч 140 гаруй орны Парламентын спикерүүд “Энх тайван, тогтвортой хөгжлийн төлөөх ардчиллыг хөгжүүлэх асуудал: Бидний хүсч буй ирээдүй” сэдвээр тунхаглал батлан гаргасан. Хэдхэн хоногийн өмнө НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганаар энэхүү “Тогтвортой хөгжлийн зорилтууд 2030 хөтөлбөр”-ийг хэлэлцэж баталлаа. Энэ хөтөлбөр НҮБ-ын 2000 онд баталсан Мянганы хөгжлийн зорилтуудын шууд үргэлжлэл бөгөөд улс орнууд дээрх хөтөлбөрийг өөрийн улс орны онцлогт нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэг хүлээж байгаа.

Монгол Улсын Их Хурал Мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор 2005, 2008 онд Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтыг шалгуур үзүүлэлтийн хамт баталж, өнгөрсөн хугацаанд амжилттай хэрэгжүүлж дууссан. Тийм болохоор НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганаар баталсан “Тогтвортой хөгжлийн зорилтууд 2030 хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газар уг хөтөлбөрийг боловсруулж, шалгуур үзүүлэлтийн хамт Улсын Их Хуралд оруулж батлуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Өнгөрсөн сарын төгсгөлд миний бие Оросын Холбооны Улсын Холбооны Хурлын Холбооны Зөвлөлийн дарга В.И.Матвиенкогийн урилгаар Оросын Холбооны Улсад албан ёсны айлчлал хийж, парламент хоорондын хамтын ажиллагаа, улс төр, эдийн засаг, боловсрол, бүс нутгийн болон олон талт хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.

Оросын Холбооны Улсын Холбооны Хурлын Төрийн Думын дарга С.Е.Нарышкин болон Засгийн газрын зарим гишүүдтэй уулзах үеэр миний бие уламжлалт найрсаг харилцаатай Оросын Холбооны Улстай хийх Монгол Улсын худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлж, “Талын зам” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, 2009 онд хоёр орны Ерөнхийлөгчийн тохиролцоонд хүрсэн Монгол Улсын нутаг дэвсгэр дэх эд хөрөнгийн асуудлыг богино хугацааны дотор шийдвэрлэх, Оросын Холбооны Улс руу хийх уламжлалт экспортыг сэргээж, Монгол Улсаас экспортлох бараа бүтээгдэхүүний гаалийн тарифыг хөнгөвчлөх зэрэг асуудлыг хөндөж тавилаа.

Оросын Холбооны Улсын тал “Эрдэнэт” үйлдвэрийн Засгийн газар хоорондын хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг Монгол Улсын Их Хурал ойрын хугацаанд хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг хүсч байна. Эдгээр асуудлыг ажил хэрэг болгохын тулд Монгол Улсын Засгийн газар анхаарал хандуулж, бодитой санаачлага гаргаж ажиллах шаардлагатай болсныг онцлон тэмдэглэж байна.

Эрхэм гишүүд ээ,

Хаврын чуулганы завсарлагааны хугацаанд хоёр удаа Улсын Их Хурлын ээлжит бус чуулган хуралдлаа. Чуулганаар хэд хэдэн асуудлыг шийдсэн бөгөөд Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулийг хэлэлцэж эхэлсэн боловч дуусгаж амжилгүй намрын чуулганд шилжүүлсэн. Мөн Өршөөлийн тухай хуульд тавьсан Ерөнхийлөгчийн хоригийг Улсын Их Хурал хүлээж авсан хэдий ч зохих өөрчлөлтийг хийж чадалгүй завсарласан. Энэ асуудлыг хуулийн дагуу намрын чуулганы эхний асуудал болгон оруулж байна.

2016 оны Монгол Улсын төсөв, хүний хөгжил сангийн болон нийгмийн даатгалын сангийн төсөв, төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийг энэ чуулганаар хэлэлцэж батална. 2015 оны эхний 8 сарын байдлаар Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого 629,3 тэрбум төгрөгөөр тасарч байна. Дэлхий даяар түүхий эдийн үнэ унаж байна. 2011 онд нэг тонн коксжих нүүрс 150 ам.доллар байсан бол өнөөдөр 50 ам.доллар, нэг тонн зэс 7000-8000 ам.доллар байсан бол 5000 гаруй ам.доллар, унци алт 1500 ам.доллар байсан бол 1100 ам.доллар болж буурлаа. Түүхий эдийн үнэ унахаар манай эдийн засагт сөргөөр нөлөөлж байгаа нь үнэн. Гэхдээ бид буруутныг гаднаас биш өөрсдөөсөө хайх хэрэгтэй.

Оюутолгойн орд газрыг ашиглахад оруулсан нэг удаагийн 6 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтын үр дүнд тухайн үедээ эдийн засгийн өсөлт 17 хувьд хүрсэн. Үүнийг бодит өсөлт байнга байх мэтээр хүлээн авч, цаашид энэ түвшиндээ байх мэтээр төсөөлөн тооцоо судалгаагүй их хэмжээний хөрөнгийг үр ашиггүй зарцуулж ирсэн. Мөн хөдөө аж ахуйн болон уул уурхайн бус салбарыг хөгжүүлэх асуудлыг орхигдуулж, уул уурхай, газрын баялагт хэт шүтэж ирлээ. Бидний өмнөх үед хийсэн энэ алдаатай бодлогоос улбаалан өнөөдөр эдийн засагт бодитой хүндрэл учирч байна. Гэхдээ Улсын Их Хурал эдийн засгийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, цаг тухайд нь эрх зүйн зохицуулалт хийсний үр дүнд нааштай өөрчлөлтүүд гарч байна. Тухайлбал, эдийн засаг хүндрэлтэй гэж байгаа ч өнгөрсөн нэг жилийн хугацаанд айл өрхүүдийн хэрэглээ 4 хувиар өссөн байна. Энэ хугацаанд төрийн байгууллага болон Засгийн газрын хэрэглээ 4 хувиар буурчээ. Энэ бол Монголын эдийн засаг эрүүлжих тал руугаа явж байна гэсэн үг. Өмнөх жилүүдэд төрийн байгууллагуудын хэрэглээ хэзээ ч буурч байгаагүй бөгөөд харин ч эдийн засгаасаа хурдтай өсч ирсэн байна.

Сүүлийн 12 сард инфляцийн түвшин 6 хувьтай, гадаад худалдааны тэнцэл 2015 оны эхний 8 сард 704,8 сая ам.долларын ашигтай гарлаа. Эдийн засгийн өсөлт өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 3.1 хувьтай байгаа нь чамлахаар үзүүлэлт биш. Нэг жилийн дотор ХАА-н салбар 9.4 хувиар, аж үйлдвэр, барилгын салбар 12.1 хувиар өслөө. Статистикаар илэрхийлвэл, сүүлийн 3 жил том, жижиг 1055 үйлдвэр ашиглалтад орсоноор аж үйлдвэрийн

салбарын ажиллах хүч 10 хувиар өссөн нь сүүлийн 25 жилд гарч байгаагүй тоо юм. Ганц жишээ дурдахад Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд ноос угаах үйлдвэр ашиглалтад орсоноор 250 хүн тогтмол ажлын байртай болж, бүтээгдэхүүнийхээ 70 хувийг экспортолж байгаа нь үүний нэг жишээ юм.

Төрийн бодлогоор импортын зарим бараа бүтээгдэхүүний гаалийн албан татварыг нэмэгдүүлж, дотоодын зах зээлээ хамгаалж байна. “Чингис бонд”-ын санхүүжилтээр үндэсний үйлдвэрлэл, эрчим хүч, дэд бүтцийг хөгжүүлэх бодлогыг бодитой хэрэгжүүлж, дэлхийн түүхий эдийн үнийн огцом уналтын сөрөг нөлөөг саармагжуулж чадлаа.

Цаашид Монгол Улсын үндэсний эрх ашиг, олон нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн, хуулийн хүрээнд харилцан ашигтай, эрх тэгш байх зарчмаар стратегийн ордуудын томоохон төслүүдийг хөдөлгөөнд оруулах нь чухал ач холбогдолтой юм. Үүнд Засгийн газар бодит алхам хийх шаардлагатай байна.

Эдийн засгийн хямрал, төсвийн хүндрэлтэй холбоотойгоор Засгийн газар хэмнэлтийн горимд шилжих төсөв оруулж ирэх гэж байгааг дэмжиж байна. Шилэн дансны тухай хуулийг баталж хэрэгжүүлснээр төсвийн үрэлгэн байдал ард түмний нүдэн дээр ил тод боллоо. Анхаарал татсан нэг жишээ дурдахад нийслэл, дүүргийн хэмжээнд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нарт олгож байгаа олон арван сая төгрөгийн урамшуулал иргэдийн хатуу шүүмжлэлд өртөж байна. Иргэдийн төлөөлөгчөөр ажиллана гэдэг цалин, урамшуулалтай ажил биш учраас энэ улирлаас эхлэн дээрх урамшууллыг зогсоох хэрэгтэй гэж үзэж байна. Сүүлийн үед төсөв хөрөнгийн үрэлгэн, замбараагүй байдал шилэн дансаар ил тод болохын хэрээр төрийн байгууллагууд шилэн дансны мэдээллийг бүдэгрүүлэх сонирхолтой болж байгааг иргэд шүүмжилж байна. Энэ бол байж болшгүй зүйл. Ийм учраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих Засгийн газрын хяналтыг хүчтэй болгож, төсвийн хөрөнгийг үрэн таран хийсэн, буруу зарцуулсан албан тушаалтнуудыг албан тушаалаас нь чөлөөлөх хүртэлх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газарт үүрэг болгож байна.

Эрхэм гишүүд ээ,

Энэ удаагийн Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа дуусахад зөвхөн 1 удаагийн хаврын чуулган үлдэж байна. Хаврын чуулган сонгуулийн бэлтгэл ажилтай давхцдаг болохоор энэ намрын чуулган цаг хугацааны хувьд ч, хэлэлцэхээр төлөвлөгдсөн асуудлын хувьд ч маш чухал, хамгийн хариуцлагатай чуулган гэдгийг эрхэм гишүүд Та бүхэн сайтар ойлгож байгаа.

Улсын Их Хурлын даргын захирамжаар батлагдсан 2015 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дараалалд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай, Шүүх, Прокурор, Цагдаагийн албаны тухай болон Эрүүгийн хэргийн тухай, Зөрчлийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхэд хамгааллын тухай, Хүүхдийн эрхийн тухай зэрэг зайлшгүй батлах ёстой чухал хуулиуд тусгагдсан. Түүнээс гадна Сонгуулийн тухай, Улс төрийн намуудын тухай, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд өргөн баригдахаар хүлээгдэж байна.

Сонгуулийн тухай хууль сонгууль болохоос 6 сарын өмнө батлагдсан байх хуультай. Миний бие Сонгуулийн хуульд оруулах цөөн тооны өөрчлөлтийг улс төрийн намууд харилцан зөвшилцсөн тохиолдолд хуулийн хугацаанд батлах боломжтой гэж үзэж байна. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль ч ялгаагүй намуудын зөвшилцлөөс шууд шалтгаална.

Эдгээр асуудлыг цаг алдалгүй хэлэлцэж шийдвэрлэх нь эрхэм гишүүд Та бидний хариуцлага,

санаачлага, идэвх зүтгэлээс шууд хамаарна. Нам, эвслийн бүлэг, холбогдох Байнгын хороод асуудлыг цаг тухайд нь хэлэлцэж, хурдтай ажиллах хэрэгтэй. Эрхэм гишүүд Та бүхэн зөвхөн улс орны болон ард түмнийхээ эрх ашгийг дээдлэн хурлын үйл ажиллагаанд идэвхтэй оролцохыг уриалж байна. Ингэж чадвал бид өмнөө тавьсан зорилтоо амжилттай хэрэгжүүлж чадна.

Та бүхэнд чуулганыхаа үйл ажиллагаанд сэтгэл, зүтгэл гарган идэвхтэй оролцохыг уриалж, Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганыг нээснийг мэдэгдье.

\* \* \*

### Чуулганыг хааж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг

(2016.02.05)

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,  
Монгол Улсын Ерөнхий сайд аа,

Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацааны отгон намрын чуулган өндөрлөж байна. Энэ чуулган ажлын 90 хоног үргэлжилж, нэгдсэн хуралдаан 38 удаа, Байнгын болон дэд хороод давхардсан тоогоор 131 удаа хуралдаж, нийт 425 хууль, 65 тогтоол хэлэлцэж баталлаа. Эдгээрийн дотор бие даасан хууль 26, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 347, хууль хүчингүй болгох тухай хууль 28, олон улсын гэрээ, конвенц соёрхон батлах, нэгдэн орох тухай тухай хууль 11 байсан байна.

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2016 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн тухай, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай, Эрчим хүч хэмнэлтийн тухай, Хамтын тэтгэврийн тухай, Гааль, татварын ерөнхий газрын эрх зүйн байдлын тухай, Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, Зөрчлийн тухай хууль, Сонгуулийн тухай хууль, Монголын Улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай зэрэг бие даасан чухал хуулиудыг баталсан байна.

Хувь хүний орлогын албан татварын тухай, Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай, Татварын ерөнхий хууль, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай, Иргэний хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай, Төрийн албаны тухай зэрэг хуулиудад холбогдох нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулжээ.

2016 оны Улсын төсвийн тухай хуулиар Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогыг дотоодын нийт бүтээгдэхүүний 25.4 хувь, нийт зарлагыг 28.8 хувь, нэгдсэн төсвийн нийт алдагдал 3.4 хувь болж төсвийн алдагдлыг хуульд заасан хэмжээнээс 0.6 хувиар бага байхаар баталлаа.

Ингэснээр Улсын Их Хурал олон жил томоохон алдагдалтай явж ирснийг залруулан төсвийн сахилга бат тогтоосон төсвийг баталж чадсанаараа эдийн засгийн бодит байдалд нийцсэн, үр ашигтай байх зарчмыг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүллээ.

Сонгуулийн хуулийг шинэчлэн баталснаар Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, түүнчлэн аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуультай холбоотой харилцааг нэг хуулиар зохицуулж, эдгээр сонгуулийг нэг ижил хугацаанд явуулж байхаар тогтоож, үндсэн зарчим, журмыг нэг мөр тодорхойлж өглөө.

Ардчилсан нийгмийн үнэт зүйлсийг хамгаалах, шударга ёсыг тогтооход голлох үүрэг

гүйцэтгэдэг Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэн баталж, Эрүүгийн хуулийн зарим зүйл, заалтыг олон улсын гэрээ, конвенцийн заалтад нийцүүлж, ялын хатуу хайрцагласан бодлогыг шинээр авч үзэн, уян хатан болгож, ялыг сонгон хэрэглэх боломжийг нэмэгдүүллээ. Түүнчлэн, ялтай байдал, гэмт хэргийн ангилал, урьд ял шийтгэгдсэн, давтан үйлдсэн зэрэг хүний эрх зүйн байдлыг дордуулж байсан зохицуулалтыг халж, нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулах, ял нь гарцаагүй, үр нөлөөтэй байх зарчмыг тусгаж, зарим үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүйгээр захиргааны хариуцлага хүлээлгэхээр тогтоосон нь чухал ач холбогдолтой шинэчлэл боллоо.

Улсын Их Хурлын ээлжит бус чуулганаар Анхны ардчилсан сонгууль болж, байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай хуулийг баталж, онц аюултай гэмт хэрэгтэн, онц хүнд болон хүнд, албан тушаалын зэрэг 33 гэмт хэргээс бусад гэмт хэрэг үйлдсэн хүмүүст өршөөл үзүүлж, хорих газраас 1253 ялтан суллагдаж, 338 хүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, Өршөөлийн хуульд нийтдээ 4340 хүн хамрагдаж, төрийн хүнлэг энэрэнгүй ёсны зарчмыг хэрэгжүүлж, хорих газрын болон мөрдөн байцаах байгууллага, шүүхийн ачаалал зохих хэмжээгээр хөнгөрсөн байна.

Зөрчлийн тухай хуулийг баталж, захиргааны зөрчил гаргасан хүнд салбарын 210 гаруй хуульд зааснаар хариуцлага хүлээлгэж байсныг халж, нэгдсэн нэг хуулиар зохицуулах боломжийг бүрдүүлж, захиргааны зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааг бие даасан хуулиар зохицуулахаар боллоо. Ингэснээр захиргааны зөрчил болон түүнийг шалган шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх асуудлаар хуулийг нэг мөр ойлгон хэрэглэх боломж бүрдлээ. Иймд Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулийг хэрэгжүүлэх гол нөхцөл болох процессийн болон байгууллагын хуулиудыг нэн яаралтай баталж мөрдүүлснээр хуулийн байгууллагын үйл ажиллагаанд зарчмын шинжтэй өөрчлөлт гарна гэж үзэж байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль батлагдсанаар бодлогын баримт бичгүүдийг цэгцлэн, үндэсний, салбарын, салбар хоорондын болон орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгийн уялдааг хангах, хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах зэрэг хөгжлийн бодлого, төлөвлөлтийг тогтвортой, нэгдсэн зохицуулалтыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдлээ. Мөн энэ хуулийн хүрээнд боловсруулсан Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг баталснаар бүх шатны сонгуульд оролцох улс төрийн нам, намуудын эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын тогтвортой хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн боловсруулах бөгөөд хэрэгжилтийг нь Үндэсний Аудитын газар хянаж, Сонгуулийн ерөнхий хороонд дүгнэлтээ хүргэж байхаар хуульчлагдлаа.

Аж үйлдвэрийн хөгжлийг эрчимжүүлэх талаар сүүлийн жилүүдэд хэрэгжүүлсэн бодлого чамлахааргүй түвшинд үр дүнгээ өгч байна. Импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх чиглэлд үйлдвэрлэгчдийг дэмжсэн бодлого амжилттай хэрэгжиж байна. Жишээлбэл, барилгын материалын үйлдвэрлэл, түүний дотор цементийн үйлдвэрлэл өргөжиж, дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, улмаар экспорт хийж эхэлсэн байна. Цаашид боловсруулах үйлдвэрлэлийн салбарын хөгжлийг түлхүү дэмжиж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг өсгөх тал дээр үргэжлүүлэн анхаарах шаардлагатай.

2015 оны эдийн засгийн тоо мэдээнээс үзвэл 11 дүгээр сараас ажил эрхлэлт нэмэгдэж эхэлсэн нь сүүлийн 2 жилд гарч буй эерэг дүр зураг юм. Тухайлбал, бүртгэлтэй ажилгүй иргэдээс мөнхүү хугацаанд ажилд орсон хүний тоо улсын хэмжээнд мэдэгдэхүйц өсөж байна. Энэ үзэгдэл зүүн бүсээс бусад бүх бүс нутагт нийтлэг ажиглагдаж байна. Энэ бол үйлдвэржилтийг дэмжсэн бодлогын эхний үр дүн гарч буйн илрэл гэж үзэж байна.

Монгол Улс хүн амынхаа орон сууцжилтын түвшнээр олон улсын тавцанд хойгуур байр эзэлдэг. 2012 оноос хэрэгжүүлж эхэлсэн орон сууцны ипотекийн зээлийн тогтолцоо нь манай хүн амын амьжиргааны чанарыг дээшлүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байна. Харамсалтай нь, Үндсэн хуулийн цэцийн ташаа шийдвэрээс улбаалан энэхүү харилцаа гацаанд орж, зогссон тул Улсын Их Хурал яаралтай арга хэмжээ авч 01 сарын 19-ний өдөр Иргэний хуульд нэмэлт оруулах тухай болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийг баталснаар ипотекийн зээлийг хэвийн үргэлжлүүлэх боломжийг бүрдүүллээ. Хууль баталснаас хойших хоёрхон долоо хоногт нийт 379 зээлдэгч 23.7 тэрбум төгрөгийн ипотекийн зээлд хамрагджээ. Зөвхөн “Буянт Ухаа-2” төсөл дээр гэхэд 200 айл зээлийн гэрээ байгуулж, цагаан сарын баяраас өмнө шинэ орон сууцандаа орж амжсан байна. Цаана нь ойрын хугацаанд ипотекийн зээлд хамрагдах хүсэлтэй 18.000 орчим өрх байна.

Хүн ардаа тохилог, аюулгүй орчин, орон сууц, чанартай хүнс зэрэг амьдралын наад захын хэрэгцээгээ хангах боломжийг бүрдүүлж өгөх нь төрийн анхдагч үүрэг мөн. Ипотекийн зээл бол хөдөлмөрийн зах зээл нь боловсорч гүйцээгүй манай орны хувьд ажиллах хүчний урам зоригийг сэргээж, тогтвортой ажиллах нэг хөшүүрэг болж, ажил эрхлэлтийг хүчтэй дэмжих ач холбогдолтой юм. Ипотек нь ажил эрхлэгч төдийгүй ажил олгогчдыг ч дэмжин урамшуулж, нийгэмд урт хугацаанд үр ашгаа өгөх тогтолцоо гэж харж байгаа. Түүнээс гадна энэ тогтолцоо манай хөдөлмөрийн зах зээлд томоохон байр эзэлдэг барилга угсралтын салбарын бизнесийн сүлжээг тогтвортой дэмжиж байгаа. Тиймээс Монгол Улсын төрөөс энэ асуудалд нухацтай хандах учиртай. Ипотекийн зээлийн хүүг бууруулж 5 хувь болгох талаар Монголбанк болон холбогдох байгууллагууд судалгаа хийж, зохих бэлтгэлийг хангахаар ажиллаж байна. Энэ талаар Засгийн газар бүх талаар дэмжин ажиллах нь зүйтэй.

Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогыг Улсын Их Хурлын тогтоолоор баталж Тариалангийн тухай хуулийг баталлаа. Манай нийт өрхийн гуравны нэг нь, хүн амын тэн хагас нь хөдөө аж ахуйн салбарт хамаардаг тул энэ салбарын хөгжилд бид онцгой анхаарал тавих ёстой. Улсын Их Хурлын тогтоолд 2025 он гэхэд хөдөө аж ахуйн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүний 5 жилийн дундаж өсөлтийг 20 хувьд хүргэх, улсын төсөвт хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувийг 4-өөс доошгүй болгох, нийт сүрэгт үхрийн эзлэх хувийг 10 хувьд хүргэж, үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махны хэмжээг 200,000 тоннд, нийт сүү үйлдвэрлэлд үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүг 50 хувьд, 1 га-гаас авах буудайн ургацын хэмжээг 20 центнерт, хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр 100 хувь хангах, малын тэжээл үйлдвэрлэлд бүрэн найрлагат тэжээлийн эзлэх хэмжээг 10 хувьд хүргэх зэрэг чухал зорилтуудыг дэвшүүлэн тавьсан байна.

Хөдөө аж ахуйн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд мал аж ахуйн салбарын хөгжил голлох байр суурь эзэлнэ. Монголын мал аж ахуй нь үндсэндээ өрхийн аж ахуйд суурилан явагддаг тул бид малчин өрхүүдийн эдийн засгийн хөгжилд онцгой анхаарал тавих ёстой. Энэ оны 02 дугаар сарын 4-нд Засгийн газраас Малчдыг дэмжих зарим арга хэмжээний тухай тогтоол гарч, мал аж ахуйн бүтээгдэхүүний үнэ, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, экспортын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор малчдад олгох зээлийн хүүг 10 хувь болгох, мөн малчдын хэрэглээний зээлийг хөнгөлөх зорилгоор Төрийн банкны малчны зээлийн хүүг 18 хувь болгон бууруулахаар шийдвэрлэлээ. Нийгмийн даатгалын шимтгэлээ төлдөг, мал сүргээ эрүүл байлгах нөхцөлийг хангахаар ажиллаж буй малчдад бага хүүтэй зээл олгосноор мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой дэмжиж, малын гаралтай бүтээгдэхүүний экспортийг өсгөж, малчдын орлогыг тууштай нэмэгдүүлэх боломж бүрдэнэ. Энэ бүхэн нь мал аж ахуйг тойрсон үйлдвэрлэл, үйлчилгээ, барилга, худалдаа, тээвэр, газар тариалангийн хөгжилд таатай нөхцөл бүрдүүлнэ.

Хэдхэн хоногийн дараа XVII жарны модон хонин жил шувтарч, мичин жил урган гарах гэж байна. Өвлөө өнтэй давсан малчин түмэн маань хавраа тавтай сайхан угтах болтугай. Нийт монголчууд Та бүхэндээ сар шинээ сайхан угтахын ерөөлийг өргөн дэвшүүлье. Намрын ээлжит чуулган хаагдсаныг мэдэгдье.

\* \* \*





**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2016 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН**

(2016.02.19)

Ээлжит бус чуулганыг нээж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг

(2016.02.19)

Монгол Улсын Ерөнхий сайд аа,  
Улсын Их Хурлын гишүүд ээ,

Та бүхэн сар шинэдээ сайхан шинэлээд, тарган тавтай хаваржиж байна уу?

Монгол Улсын Их Хурлын ээлжит бус чуулганыг 2016 оны 02 дугаар сарын 15 -наас 02 дугаар сарын 26 хүртэлх хугацаанд хуралдуулахаар миний бие 2016 оны 02 дугаар сарын 12-ны өдөр 25 тоот захирамж гаргаж, хэлэлцэх асуудлуудыг баталсан байгаа.

Энэхүү ээлжит бус чуулган нь татварын шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд онцгой анхаарал хандуулах болно. Тухайлбал бид Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслүүдийг хэлэлцэнэ.

Монгол Улсын Засгийн газрын 2012 - 2016 оны үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэх, бизнест ээлтэй орчин бүрдүүлж, татварын энгийн, ойлгомжтой, тэгш шударга байх зарчмыг бүрэн утгаар нь хангасан, эдийн засгийн нөхцөл байдал, олон улсын жишигт нийцэхүйц оновчтой, тогтвортой татварын орчинг бий болгоход Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын зорилго оршиж байгаа.

2006 онд батлагдаад өнөө хүртэл мөрдөгдөж буй Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулиар аж ахуйн нэгжүүд нь 3 тэрбум төгрөг хүртэлх татвар төлөх орлогоос 10 хувь, 3 тэрбум төгрөгнөөс дээш давсан татвар төлөх орлогын дүнгийн 25 хувиар албан татвар төлдөг.

Уг хуулийн шинэчилсэн найруулгад орлогын татварын дээд шатлал буюу 25 хувиар татвар ногдуулах босгыг 10.0 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлэхээр тусгасан. Мөн жилийн борлуулалтын орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс илүүгүй жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн төсөвт төлсөн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 90 хувийг буцаан олгох, эдгээр татвар төлөгчийн татварын тайлан тооцоо хийх давтамжийг бууруулж, хялбаршуулахтай холбогдсон заалтуудыг төсөлд тусгасан нь баялаг бүтээгчдийг дэмжин урамшуулах чухал ач холбогдолтой юм.

Мөн Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгад хадгаламжийн хүүгийн орлогоос татвар авах зохицуулалтыг 2018 он хүртэл хойшлуулахаар заасан. Энэ нь эдийн засгийн өнөөгийн нөхцөлд иргэдийн мөнгөн хуримтлалыг үргэлжлүүлэн урамшуулах, банкны салбарын эрсдэлийг бууруулах, санхүүгийн илүү тогтвортой байдлыг хангах ач холбогдолтой юм.

Өнгөрсөн намрын чуулганаар Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн үйл явцад түүхэн чухал ач холбогдолтой Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулиудыг баталсан бол эдгээр хуулийн бодитой хэрэгжих нөхцлийг хангахад зайлшгүй шаардлагатай хуулиудыг энэ удаагийн ээлжит бус чуулганаар хэлэлцэхээр төлөвлөлөө. Эдгээр нь Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хууль сахиулах тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Цагдаагийн албаны тухай, Прокурорын байгууллагын тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төсөл, эдгээртэй холбогдох бусад хуулиудын төслүүд юм.

Тухайлбал Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн төслийг хэлэлцэн батлах нь хууль, шүүхийн өмнөх тэгш байдлын зарчим, хүний халдашгүй эрхийг хангах, хэргийн нөхцөл байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоох, шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдах, шүүн таслах ажиллагааг талуудын эрх тэгш байдал, мэтгэлцээний үндсэн дээр явуулах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хууль ёсны байх зэрэг зарчмуудыг бүрэн хэрэгжүүлэх үндэслэл, нөхцөл, журмыг тогтооход чухал ач холбогдолтой юм.

Хууль сахиулах тухай хуулийн төслийг шүүх эрх мэдлийн болон эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хууль сахиулах ажиллагаатай холбоотой хуулиудын давхардал, хийдлийг арилган, олон улсын хүний эрхийн стандартад нийцүүлэн, зөвхөн хуульд заасан үндэслэл, арга хэрэгсэл, журмын дагуу хэрэгжүүлэх, хүний эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлах зохицуулалтыг хуульчлан тогтоох шаардлагын дагуу боловсруулан, өргөн мэдүүлжээ. Уг хуулийг хэлэлцэн батлах нь эрх зүйт төр, хүмүүнлэг ардчилсан нийгмийг бэхжүүлэх үйлсэд том хувь нэмэр оруулах юм.

2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэн батлах шаардлага нь цаг хугацааны хүчин зүйлээс улбаатай болж байна. Мөн Эрүүгийн хуулийг шинээр баталсантай холбогдон ийм шаардлага гарч байна.

Эдгээр хуулийн байгууллагын хуулиудыг хууль санаачлагчийн зүгээс өмнө өргөн мэдүүлж байсан боловч үзэл баримтлалын шинжтэй болон зарчмын зөрүүтэй санал ажлын хэсэг дээр олон зуугаараа гарсан учраас Засгийн газраас хуулийн төслүүдийг буцаан татаж, эдгээр саналуудыг тусган өргөн барьж байгаа. Эдгээр төслийг боловсруулахдаа эрдэмтэн, судлаачдын хийсэн судалгааны ажил, хуулийн байгууллагуудын хэлэлцүүлгийн материал, үндэсний хэмжээний зөвлөгөөн, чуулганаас гарсан зөвлөмжүүд, Монгол Улсын нэгдэн орсон холбогдох олон улсын гэрээ, конвенци, бусад орны холбогдох хуулиудыг харьцуулан судалж олон арван байгууллагаас ирүүлсэн саналыг тусгасан тул хуулийн төслүүдийг энэхүү ээлжит бус чуулганаар хэлэлцэх боломж үүссэн гэж үзэж байна.

Бас нэг чухал хуулийн тухай би бас үгэндээ хэлье гэж бэлдсэн. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг 2004 онд баталснаас хойш Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд нааштай алхмууд гарсан ч энэ төрлийн хүчирхийлэл буурахгүй, харин ч хүний амь нас хохирох, гэмтэх, хүүхэд өртөх зэргээр илүү ноцтой хэлбэрт шилжих болсон. Өмнө нь Эрүүгийн хууль батлагдсан. Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж чадвал жил гаруй хүлээгдсэн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай шинэчилсэн найруулгыг араас нь залгуулан батлах бүрэн боломжтой юм.

Мөн Улсын Их Хурлаас өгсөн үүргийн дагуу Засгийн газар хязгаар нутгийн зарим сумдын хоёр хөршөөс тог авдаг, тэдний авч байгаа эрчим хүчийг гааль, НӨТ-аас чөлөөлөх асуудлыг Засгийн газарт үүрэг өгсөн. Засгийн газар шуурхай хэлэлцээд өргөн барьсан. Энэ жижиг хуулийг бас батлах хэрэгцээтэй байна.

Хамгийн сүүлд Монгол Улсын Засгийн газар, Унгар Улсын Засгийн газар хооронд байгуулсан “Санхүүгийн хамтын ажиллагааны Ерөнхий хөтөлбөрийн тухай” хэлэлцээр болон Азийн хөгжлийн банкнаас авах “Зээлийн батлан даалтын системийг дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байр бий болгох төсөл”, “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг шинэчлэн сайжруулах төсөл”-ийн зээлийн хэлэлцээрүүдийн гарын үсгийг харгалзах талууд нэгэнт зурсан тул соёрхон батлах тухай хуулийг энэ чуулганаар хэлэлцэж дуусгая.

Ингээд эрхэм гишүүд та бүхнийг нам, эвслийн бүлэг, холбогдох байнгын хороо, чуулганы хуралдаандаа оролцож, дээрх хуулиудыг хэлэлцэн баталж өгөхийг хүсье. Улсын Их Хурлын ээлжит бус чуулганы ажиллагаа нээгдсэнийг мэдэгдье.

\*\*\*

### **Ээлжит бус чуулганыг хааж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг**

(2016.02.19)

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Миний бие 2016 оны 02 дугаар сарын 12-ны өдөр 25 тоот захирамж гаргаж, ээлжит бус чуулганаар хэлэлцэх асуудлыг баталсан. Үүний дагуу 2016 оны 02 дугаар сарын 19-ний өдөр ээлжит бус чуулганыг нээж, намрын ээлжит чуулганаар хэлэлцэж баталсан Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай, Барилгын тухай, Ирээдүйн өв сангийн тухай, Зөрчлийн тухай хуулийг дагалдаж гарсан хуулиуд зэрэг нийт 291 хууль болон тогтоолын эцсийн найруулгыг сонслоо.

Эдгээр хуулиуд нь ард иргэдийн зүгээс хүлээлт үүсгээд байсан. Хуулиуд тус тусын хуульдаа бичигдсэн хүчинтэй болох хугацаагаараа буюу ердийн журмаар, “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд хэвлэгдсэнээр гэх мэтээр хэрэгжиж эхлэх болно. Энэ хуулиудыг хэрэгжүүлэхийн тулд 04 дүгээр сард хаврын ээлжит чуулганыг хүлээх шаардлагагүй боллоо.

Ээлжит бус чуулганы хуралдаанаар мөн Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг эгүүлэн татах талаарх Улсын дээд шүүхийн саналыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиудын шинэчилсэн найруулга, Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хууль сахиулах тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж үзээд ажлын хэсгийг байгуулж, Улсын Их Хурлын 2016 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцье. Ажлын хэсгүүдээ ирэх долоо хоногоос байгуулан бэлтгэлээ хийх хэрэгтэй.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газар, Унгар Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны Ерөнхий хөтөлбөрийн тухай” хэлэлцээр болон Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Зээлийн батлан даалтын системийг дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байр бий болгох төсөл”, “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг шинэчлэн сайжруулах төсөл”-ийн зээлийн хэлэлцээрүүдийг соёрхон баталж дууслаа.

Ээлжит бус чуулганы хуралдаанд идэвхтэй оролцсон Улсын Их Хурлын гишүүд та бүхэнд баярлалаа. Улсын Их Хурлын ээлжит бус чуулган хаасныг мэдэгдье.

\*\*\*

**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2016 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН**

(2016.04.05 - 2016.07.)

**Чуулганыг нээж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг**

(2016.04.05)

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,  
Хүндэт зочид оо,

Улсын Их Хурлын 2016 оны хаврын ээлжит чуулган эхэлж байна. Энэ чуулган энэ Улсын Их Хурлын бүрэн эрхийн сүүлчийн чуулган гэдгээрээ онцлогтой юм. Энэ удаагийн чуулганаар Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн тухай, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай, 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018 - 2019 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл, 2015 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газрын 2015 оны санхүүгийн нэгдсэн тайлан зэрэг хуулийн дагуу хэлэлцэх ёстой асуудлаас гадна түрүүчийн чуулганы төгсгөлд баталсан хаврын чуулганаар хэлэлцэх асуудлууд бүгдээрээ, мөн хэлэлцүүлэгт байгаа бусад бүх асуудлууд үргэлжлэн хэлэлцэгдэнэ.

Ээлжит чуулганы завсарлагын хугацаанд Улсын Их Хурлын гишүүд тойргийнхоо иргэд, сонгогчидтой уулзан Улсын Их Хурлын намрын чуулганы үйл ажиллагааны үр дүнгийн тухай тайлагнаж харилцан мэдээлэл солилцож ажиллалаа.

Миний бие Өмнөговь, Дундговь, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Архангай, Булган, Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул аймаг мөн хүн ам ихтэй гурван суманд очиж уулзалт хийлээ. Эдгээр орон нутгийн иргэд, хөдөлмөрчидтэй уулзалт хийн бүтээн байгуулалттай танилцан, Улсын Их Хурлын 2015 оны намрын ээлжит чуулганаар батлагдсан хууль, тогтоомжийн талаар болон улс орны нийгэм эдийн засгийн байдлын талаар дэлгэрэнгүй танилцуулга, мэдээлэл хийлээ.

Одоогоос яг нэг жилийн өмнө энэ танхимд Улсын Их Хурлын чуулганы нээлт дээр Тавантолгойн ордыг ашиглах Хөрөнгө оруулалтын гэрээ Монгол улсын эрх ашигт нийцээгүй тухай энэ гэрээг Улсын Их Хурлаар хэлэлцэн шийдвэрлэх нь зүйтэй гэдэг байр сууриа илэрхийлсэн. Улсын Их Хурлын дарга, дэд дарга нар нэгдсэн байр суурьтайгаар энэ асуудалд хариуцлагатай хандсан. Улсын Их Хурлын ажлын хэсэг гэрээнүүдийг шалган дүгнэлт гаргасан.

Тавантолгойн ордыг ашиглах компани санхүүгийн хүнд байдалд орсон бөгөөд хөрөнгө оруулалтыг хийх боломжгүй байсан нь Улсын Их Хурлын ажлын хэсгийн дүгнэлтээр болон энэ компани зээлийн төлбөрөө хийх чадваргүй болсноо саяхан зарласнаар батлагдаж байна.

ММС болон Энержи Ресурс компани нь Тавантолгойн ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах нэрийн дор олон улсын банк санхүүгийн байгууллагад тавьсан өөрсдийн их хэмжээний өрийг хаах зорилготой болохыг Улсын Их Хурлын ажлын хэсэг илрүүлсэн. Компанийнхаа өрийг төрийн өмчийн ашигт малтмалын ордоор хаах санаархлыг Улсын Их Хурал хэзээ ч зөвшөөрөхгүй.

Тавантолгойн ордыг ашиглах “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанид хувьцаа эзэмшиж байгаа Монгол улсын 2,5 сая иргэн, дотоодын 553 аж ахуйн нэгжийн хувьцааг үнэгүйдүүлсэн, тэдний ашиг сонирхол, эрх ашгийг зөрчсөн гэрээг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэдгийг дахин хэлье. Хэрэв Тавантолгойн ордыг ашиглах энэхүү хууль зөрчсөн гэрээг зогсоогоогүй бол ард түмний өмч болон Тавантолгойн орд өнөөдөр Кэйманы арлын офшор бүс дэх ММС



компани болон түүний охин компани “Энержи ресурс” компанийн өрийн төлбөрт гадны компанид бүрэн шилжих байлаа. Энэ бүхнээс харахад Улсын Их Хурлын шийдвэр нэг жилийн цаадахыг харж чадсан, улмаар хэдэн арван жилийн дараах Монголын эрх ашгийг дээдэлсэн шийдвэр болж чадсан байна.

Тавантолгойн нүүрсний ордыг Монгол улс цаашид хэрхэн ашиглах вэ гэдэг асуулт зүй ёсоор гарна. Тавантолгойн нүүрсний орд бол коксжих нүүрс, чулуун нүүрс аль алиныг нь агуулсан дэлхийд ховорт тооцогдох том орд юм. Тавантолгойн ордын коксжих нүүрсийг бид дэлхийн зах зээлийн үнээр борлуулна. Үүний тулд Ухаа худаг-Гашуунсухайт, Тавантолгой-Сайншанд чиглэлийн төмөр замыг барьж дуусгах шаардлагатай. Харин Тавантолгойн ордын чулуун нүүрсийг байгалийн хий болон хувиргаж Улаанбаатарыг утаагүй түлшээр хангах, мөн үлдсэн хэсгийг нь хуванцар эдлэлийн үндсэн түүхий эд болгон Япон болон бусад зах зээлд экспортлохоор холбогдох талуудтай хэлэлцэж байна. Эдгээр арга замууд нь Тавантолгойн ордыг Монголын иргэдэд хамгийн үр өгөөжтэйгээр ашиглах бодит, ойрын ирээдүй юм.

Эдийн засгийн бодлогодоо эргэлт хийж буй энэ цаг үед Засгийн газрын өр, зээлийн тухай сэдэв олон нийтийн анхаарлыг татаж байна. Олон улсын Валютын сангийн статистикийн аргачлалаар манай улсын гадаад өр 2015 оны байдлаар 20 гаруй тэрбум ам.долларт хүрчээ. 2012 оныг хүртэлх С.Баяр, Сү.Батболд нарын Засгийн газрын үед 9.936 тэрбум ам.долларын зээл, Н.Алтанхуяг, Ч.Сайханбилэгийн Засгийн газрын үед 9.924 тэрбум ам.долларын зээл авсан байна. 2008 оноос хойш эрх барьсан намуудын Засгийн газар үндсэндээ адил хэмжээний зээл авчээ.

Монгол Улсын Засгийн газар дааж давшгүй өрөнд баригдсан мэт буруу ойлголт зориудаар тарааж байна. Манай улсын өр байж болох түвшнээс хэтэрсэн эсэхийг дүгнэхдээ дор хаяж дараах хүчин зүйлүүдийг авч үзэх ёстой. Нэгдүгээрт, бусад улсын үзүүлэлттэй харьцуулах шаардлагатай. ДНБ-д Засгийн газрын өрийн эзлэх хувиар манайхаас илүү өртэй олон арван хөгжилтэй болон хөгжиж буй орнууд байна.

Хоёрдугаарт, Засгийн газрын зээлийг улс орны ирээдүйн эдийн засгийн өсөлттэй холбож авч үзэх ёстой. Өөрөөр хэлбэл, бид эдийн засгийнхаа өсөлтийг хангаж чадвал ДНБ-д эзлэх Засгийн газрын зээлийн хувь ойрын ирээдүйд түргэн буурах боломжтой. Сүүлийн жилүүдэд Засгийн газрын зээлээр дэд бүтэц, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбартаа хийсэн хөрөнгө оруулалт огцом өссөн нь эдийн засгийн ойрын ирээдүйн өсөлтийн нэгэн чухал эх үүсвэр болно. Мөн дан ганц Оюутолгойн төсөл гэхэд л манай ДНБ-ийг 30 хувиар өсгөх тооцоо бий.

Намаараа талцаж аль нь илүү зээл авсан тухай улайран маргалдаж суух нь утга учиргүй юм. Бид урд нь авсан зээлээ нийгмийн халамжид зориулан, идэж уугаад дуусгасан нь үнэн. Дэлхийн зах зээл дээр нүүрсний үнэ огцом унасан сүүлийн жилүүдэд эдийн засгаа өөд нь татахын тулд ухаан зарж ажиллахыг нөхцөл байдал биднээс шаардаж буй нь бас үнэн. Урд өмнөх алдаандаа дүгнэлт хийж, эдийн засгаа олон тулгууртай болгохоос өөр замгүй гэдгийг цаг үе бидэнд хүчээр ухааруулж байна.

Хэдхэн хоногийн өмнө Монголын эдийн засгийн чуулган 7 дахь жилдээ явж өнгөрлөө. Энэ чуулганы үеэр төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллийг хамруулсан өргөн хүрээтэй хэлэлцүүлэг явуулж Монголын эдийн засгийн өнгөрсөн, одоо, ирээдүйг шүүн хэлэлцлээ. Миний бие уг чуулганд оролцож эдийн засгийн цаашдын бодлогын талаарх саналаа илэрхийлсэн.

Эдийн засгаа уул уурхайн хэт хамаарлаас ангижруулж, манай улсын эдийн засгийн суурь болсон хөдөө аж ахуйн салбартаа ойрын хугацаанд онцгойлон хүч тавихын зэрэгцээ үйлдвэржилт, тэр дотроо боловсруулах үйлдвэрийн хөгжлөө идэвхжүүлэх бодлого

явуулсны эхний үр дүн чамлахааргүй түвшинд байгааг дурдаж, энэ тухай сайн эхлэлийг улам эрчимжүүлэх нь чухал гэдгийг тэмдэглэсэн.

Сүүлийн 4 жилд Засгийн газар бондын зээлийг дэд бүтэц, хөдөө аж ахуй, аж үйлдвэрээ өөд нь татахад голлон зарцуулсан. Энэ бодлого ч зохих үр дүнгээ өгч байна. Тухайлбал, өнгөрсөн жилийн дунд үеэс эхлэн хөдөлмөрийн зах зээлийн уналт саарсаар улмаар өсөлт ажиглагдаж эхэллээ. Сүүлийн 2 сарын туршид шинээр ажилд орсон хүний тоо өмнөх оны мөн үеэс даруй 60 хувиар өссөн нь тун чухал шинж тэмдэг юм. Энэ бол манай орны хувьд сүүлийн үед АНУ-ын хөдөлмөрийн зах зээл дээр үүсэж буй эерэг үзүүлэлттэй дүйцэхүйц хэмжээний үзэгдэл мөн.

Халамжийн бодлого идэвхтэй явуулж байсан өмнөх жилүүдэд ажил хийх хүсэлтэй хүний тоо илт цөөрсөн бол ипотекийн зээлийг нэвтрүүлсний үр дүнд иргэд, ялангуяа залуучуудын дунд ажил хөдөлмөр идэвхтэй эрхлэх сэдэл өндөр болсон гэж ажил эрхлэгчид дүгнэж байна. Ипотек нь ажил эрхлэлтийг шууд дэмжихээс гадна ажиллагсдын тогтвортой ажиллах, бүтээмжээ дээшлүүлэхийг хичээх сэдлийг өдөөж буйгаараа нийгмийн хувьд онцгой ач холбогдолтой юм.

Хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг идэвхтэй хөгжүүлэх эхлэлийг амжилттай тавьж эхэллээ. Орон нутагт томилолтоор ажиллах хугацаандаа Тавантолгойн нүүрсэнд биш, таван хошуу малдаа найдаж хөгжицгөөе хэмээн малчиддаа, хөдөө аж ахуйн салбарынхандаа уриалсаар ирлээ.

Манай улсын хүн амын дийлэнхийнх нь амь амьжиргаа хөдөө аж ахуйн салбартай нягт холбоотой. Ийм том салбарынхаа хөгжилд онцгойлон анхаарах нь манай дундаж давхаргын орлогыг нэмэгдүүлэн, дотоодын зах зээлийг хөгжүүлж, улмаар хуримтлалыг үүсгэн, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин, экспортоо тэлэх боломж олгоно. Уул уурхайн салбарын бодлогоо тал бүрээс нь нухацтай хэлэлцэн, нарийвчлан тооцоолж, хариуцлагатайгаар хэрэгжүүлэх нь чухал. Дэлхийд хамгийн томд тооцогдох Оюутолгой төслийг бид хэрэгжүүлж байна. Дор хаяж 100 жилийн настай гэж мэргэжилтнүүдийн үнэлдэг энэ төслийн 2 дугаар үе шат эхэлсэн нь манай эдийн засагт ойрын хугацаанд жинтэй нөлөө үзүүлнэ.

Олон жилийн туршид орхигдуулж ирсэн хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийг дэмжсэн бодлогын сууриа тавьж чадсан өнөөгийн амжилт дээрээ суурилан цаашид хүчтэй анхаарах нэг чиглэл бол манай компаниудын, бизнесменүүдийн менежментийн ур чадварыг дээшлүүлэх явдал юм. Энэ ажлыг үндэсний хэмжээнд нэгдсэн зохион байгуулалттайгаар өргөн хүрээнд идэвхтэй хэрэгжүүлэх шаардлагатай. Эдийн засгаа олон тулгууртай болгох чиглэлд улс төрийн намууд идэвхтэй хамтран ажиллаж, өнөөгийн бодлогыг улам боловсронгуй болгож, эрчимтэй хэрэгжүүлэхийг уриалж байна.

Эрхэм гишүүд ээ,

Энэ жил Монгол Улсад дэлхийн 50 гаруй орны 4000 гаруй төр, засгийн өндөр дээд хэмжээний зочид төлөөлөгчид АСЕМ-ын Дээд түвшний 11 дүгээр уулзалтад оролцохоор нийслэл Улаанбаатар хотноо хуран чуулах гэж байна. Энэхүү уулзалтын эхлэл болох Ази Европын орнуудын парламентын хамтын ажиллагааны уулзалт буюу ASEP энэ сарын 21, 22-нд энэ Төрийн ордонд болно. АСЕМ-ийн дээд түвшний уулзалт нь улс төр, эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлыг хэлэлцэн хоёр тивийн харилцааг ойртуулан бэхжүүлэх чухал ач холбогдолтой арга хэмжээ юм.

Энэхүү чухал уулзалтыг бид эх орондоо амжилттай зохион байгуулж чадна гэж найдаж байгаа. Ингэснээр Монгол Улсын нэр хүнд олон улсын тавцанд өсөн бэхжиж, манай

улс гадаад бодлогын үзэл баримтлалынхаа хүрээнд дэлхийн олон оронтой хамтын ажиллагаагаа өргөжүүлэх боломж нээгдэх бөгөөд мөн эх орноо сурталчлах чухал алхам болох юм. УИХ -ын гишүүд Та бүхнийг чуулганыхаа үйл ажиллагаанд идэвхтэй, бүтээлчээр оролцоно гэж найдаж байна.

Улсын Их Хурлын 2016 оны хаврын ээлжит чуулганы хуралдааныг нээснийг мэдэгдье.

\* \* \*



**ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХҮНДЭТГЭЛИЙН ХУРАЛДААН**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ ЦАХИАГИЙН ЭЛБЭГДОРЖИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАНГАРАГ  
ӨРГӨХ ЁСЛОЛЫН АЖИЛЛАГААНД ЗОРИУЛАН ХИЙСЭН УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ  
ХҮНДЭТГЭЛИЙН ХУРАЛДААН**

(2013.07.10)

**Хүндэтгэлийн хуралдааныг нээж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг**

(2013.07.10)

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,  
Хүндэт, зочид, төлөөлөгчид өө,

Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Шинэчлэн найруулсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Сонгуулийн тухай хуулийн дагуу 2013 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль амжилттай явагдаж өнгөрлөө.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны өргөн мэдүүлснээр энэхүү сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшигч Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж 622794 хүний санал буюу нийт сонгогчдын 50.23 хувийн санал авч, ялалт байгуулсан байна.

Өнөөдөр Монгол Улсын Ерөнхийлөгчөөр дахин сонгогдсон Цахиагийн Элбэгдорж Улсын Их Хуралд тангараг өргөх гэж байна. Энэ удаагийн Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолын арга хэмжээг Улсын Их Хурлын шийдвэрээр анх удаа эзэн Чингис хааныхаа сүрлэг хөшөөний өмнө ард түмнийхээ дунд нээлттэй зохион байгуулж байгаагаараа онцлог юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон Цахиагийн Элбэгдорж Улсын Их Хуралд тангараг өргөх чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Норовын Алтанхуяг, Засгийн газрын гишүүд, Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүд, Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчид, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүд, Улсын ерөнхий прокурор зэрэг төрийн өндөр албан тушаалтнууд, улс төрийн намуудын удирдлага, олон нийт, шашны болон хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдийн төлөөлөгчид оролцож байна.

Мөн Оросын Холбооны Улсын Холбооны Зөвлөлийн нэгдүгээр орлогч дарга Эрхэмсэг ноён Александр Порфирьевич Торшин, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Хурлын Байнгын хорооны орлогч дарга Эрхэмсэг ноён Сянба Пинцуо, Бүгд Найрамдах Польш Улсын Ерөнхийлөгч асан, Нобелийн шагналт Эрхэмсэг ноён Лех Валенса, Япон Улсын Үндэсний аюулгүй байдал, хулгайлагдсан иргэд, байгалийн гамшгийн асуудал эрхэлсэн сайд Эрхэмсэг ноён Кейжи Фүрүя, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Шинэ болон сэргээгдэх эрчим хүчний сайд Эрхэмсэг ноён Фарүүк Абдулла, Бүгд Найрамдах Киргиз Улсын Гадаад хэргийн сайд Эрхэмсэг ноён Эрлан Бекешович Абдылдаев, Бүгд Найрамдах Франц Улсын Хөдөө аж ахуй, хүнс, ойн асуудал эрхэлсэн төлөөний сайд Эрхэмсэг ноён Гийом Гаро, ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын тэргүүн, Засгийн газрын дарга Эрхэмсэг ноён Вячеслав Владимирович Наговицын, ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын Ардын Хурлын дарга Эрхэмсэг ноён Матвей Матвеевич Гершевич, ОХУ-ын Төрийн Думын гишүүн ноён Михаил Викторович Слипенчук, Олон улсын шатрын холбооны тэргүүн Ноён Кирсан Николаевич Илюмжинов зэрэг гадаадын зочид төлөөлөгчид, Монгол Улсад суугаа дипломат болон олон улсын байгууллагын төлөөлөгчийн газруудын тэргүүн нар урилгаар оролцож байна.



Эрхэм Ерөнхийлөгч өө,

Энэ мөчөөс эхлэн Та Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг дахин шинээр хэрэгжүүлж эхэллээ. Та Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлж ажиллахдаа өмнөх дөрвөн жилд эхлүүлсэн ажлаа тууштай үргэлжлүүлж, сонгуулийн үед ард түмнээсээ өгсөн захиа даалгаврыг биелүүлж, Монгол түмнийхээ язгуур эрх ашиг, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн Улсын Их Хурал болон Засгийн газар хоорондын харилцаа, хамтын ажиллагааг хангаж ажиллана гэдэгт итгэж байна.

Монгол Улсын Их Хурал Ерөнхийлөгч тантай улс орныхоо хөгжил дэвшил, ард иргэдийнхээ амьдралын сайн сайхныг баталгаажуулах хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлд Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд нягт хамтран ажиллах болно.

Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж Танд Улсын Их Хурлын нэрийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн халуун баяр хүргэж, Монгол төрийн тэргүүний эрхэм хүндтэй бөгөөд хариуцлагатай ажилд тань өндөр амжилтыг хүсье.

\* \* \*

**Хүндэтгэлийн хуралдаан дээр Монгол Улсын Ерөнхий сайд асан  
Д.Бямбасүрэнгийн хэлсэн үг**

(2013.07.10)

Эрхэм хүндэт Монгол Улсын Ерөнхийлөгч өө,  
Эрхэм хүндэт Улсын Их Хурлын дарга, гишүүд ээ,  
Монгол Улсын нийт иргэд ээ,  
Эрхэм хүндэт зочид, төлөөлөгчид өө,

Эрх чөлөөтэй Монгол орны ард түмэн бид Үндсэн хуулиар олгосон бүрэн эрхээ эдэлж Ерөнхийлөгчийн сонгуулиар ардчилсан хувьсгалын анхдагчийн нэг Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржид дахин итгэл хүлээлгэж, улируулан сонголоо.

Энэ сонголт Монголын ард түмний шударга ёсны төлөө, авлигын эсрэг, улс төр, эдийн засгийн тогтвортой хөгжил, өөрийнхөө, гэр бүлийнхээ амьдралын сайн сайхны төлөө хийсэн сонголт юм. Энэ сонголт эрхэм Ерөнхийлөгч таныг өнгөрсөн 4 жил эхлүүлсэн бүхнээ тууштай үргэлжлүүлж, Монгол Улсынхаа төлөө чин шударгаар зүтгэж чадна гэдэгт итгэл төгс байгаагийн илэрхийлэл юм. Энэ сонголт Монголын ард түмэн 1990 оны цагаан морин жилд өрнөсөн ардчилсан хувьсгалыг батлан тунхаглах хүсэл зоригийн нотолгоо мөн.

Эрхэм Ерөнхийлөгч өө,

Та гэгээн нар, хөх тэнгэр, хөвчин дэлхий, олон түмэнтэйгээ хамт байж, Чингис хааныхаа хөшөө дурсгал, төрийн их цагаан сүлднийхээ өмнө тангарагаа өргөсөнд сэтгэл нэн баяртай байна.

Таны эх орныхоо төлөө гэсэн чин зүтгэл, ардчиллын төлөө нугарашгүй тэмцэл, нэр хүнд, оюун ухаан, үзэл санааны тэнхээнд бид итгэж байна.

Танд төр түмнийхээ итгэлийг дээдлэн, Монгол Улсынхаа төлөө улам илүү хурд, улам илүү эрч хүчээр зүтгэж, сонгогч түмнийхээ захиа даалгаврыг бүрэн биелүүлэхийн өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье. Монгол түмний сүлд хийморь улам дээш мандан бадрах болтугай.

\* \* \*

**Хүндэтгэлийн хуралдаан дээр Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн хэлсэн үг**  
(2013.07.10)

Эрхэм хүндэт ард иргэд ээ,  
Монгол ахан дүүс ээ,  
Эрхэм төрийн түшээд ээ,  
Хүндэт зочид, хадагтай ноёд оо,

Монголын цаг дор Та бид Монгол төрийн их хүндэтгэл ёслол, Монгол түмний их наадам цэнгэлдээ хуран цуглаад байна. Миний бие дөнгөж сая Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангарагыг хоёрдохоо өргөлөө. Монголын Мөнх хөх тэнгэрийн дор ард олныхоо халуун хүндэтгэл уухайлж хурайлах дуун дунд Эзэн Богд Чингис хааныхаа мэлмий, Их цагаан сүлдний өмнө, Монгол Улсын Их Хурлын хүндэтгэлийн чуулганд Монгол төрийн тэргүүний Тангарагыг ийнхүү өргөсөнөө би их ёс төр, итгэл найдвар, их хариуцлага хэмээн хүлээн авч байна.



**Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж  
Эзэн Чингис хааны нэрэмжит талбай дээр тангараг өргөж, үг хэлэв**

Мөнх хөх тэнгэртээ баярлалаа. Монголын хийморлог ард түмэндээ баярлалаа. Их өвөг дээдэс, Эзэн Богд Чингис хаандаа баярлалаа. Улсын Их Хурлын гишүүд, төрийн түшээддээ баярлалаа. Надад дахин итгэл хүлээлгэсэн сонгогч олондоо чин сэтгэлээсээ талархаж байна.

Сонгуулийн үйл ажиллагаанд цаг заваа үл хайрлан, сэтгэл гарган ажилласан нийт ахмадууд, эмэгтэйчүүд, залуустаа их баярлалаа. Сонгуульд идэвхтэй ажилласан бүх байгууллага, нам, олон нийтийн хөдөлгөөн, иргэдэд гүн талархлаа илэрхийлье.

Эх орноосоо алсад суугаа ч иргэнийхээ эрхийг эдэлж саналаа өгсөн бүх хүмүүст баярлалаа. Сонгох эрхээ анх удаа бүрэн дүүрэн ашиглаж сонгуульдаа идэвхтэй оролцсон хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ онцгойлон баяр хүргэе. Шударгаар иргэдийнхээ сонгох эрхийг хэрэгжүүлэхэд хичээл зүтгэл гарган сонгуулийн бүх шатны байгууллагад ажилласан төрийн түшээддээ гүн талархал илэрхийлье. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд надтай хамт нэр дэвшин өрсөлдсөн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ, Нацагийн Удвал нарт баяр хүргэж, цаашдийнх нь ажил үйлсэд амжилт хүсье.



Сонгуулийн үеэр гарсан сайн санаа хөтөлбөр бүрийг ажил хэрэг болгохыг би чухалчлах болно. Намайг дэмжсэн иргэдийнхээ итгэлийг би дааж ажиллах болно. Мөн надад итгээгүй, бас эргэлзсэн иргэдийнхээ итгэлийг олж авахын төлөө би хичээн зүтгэнэ ээ.

Эрхэм төрийн түшээд ээ,

Та бидэнд Монголын ард түмэн их итгэл найдвар, урам зориг өглөө. Бидэнд цаг алдах эрх байхгүй. Монголын ард түмэнд нэг л эрх ашиг бий. Тэр эрх ашгийг гүйцэлдүүлэх зүтгэлч нэгдмэл байх учиртай. Манай иргэд эрхээ эдэлж, сайн сайхан амьдрах ёстой. Монгол Улс олсон ололтоо бататгаж илүү хурдацтай хөгжих цаг үе ирсэн. Монголын нэр олон улсад улам сайнаар дуурсах боломжтой. Энэ бүхнийг хичээнгүйлэн гүйцэлдүүлэх эрхэм үүрэг төрд ажиллаж байгаа түшээ нэг бүрт ноогдож байгаа юм. Төрийн түшээ хүн бол өөрийн жаргалыг умартаж бусдын зовлонг дааж зүтгэх учиртай. Би юунд хүрэх вэ гэхээс илүүтэй улс маань юунд хүрэх ёстойг хатамжилан бодож ажиллах ёстой.

Би 23 жилийн өмнө энэ талбай дээр цэрэг шинелиэ тайлаад хувьсгалд оролцсон. Монгол Улсын иргэдийн эрх тэдний гэрт, гарт очиж байж л баталгаажна. Манай орны иргэн бүр эрхээ бодитой, баталгаатай эдэлж чадсан цагт л Монгол айл бүрийн амьдрал тэр иргэний эрхээр, гараар, санаачлагаар дамжиж өөдлөн дэвжих болно.

Монголд өрнөж эхэлсэн их бүтээн байгуулалтын хувьсгал ч амжилтад хүрэх болно. Мөн Монгол Улс иргэнээ дээдэлсэн хуулийн засаглалтай орон болж чадна. Энэ нь Монгол Улсын бие даасан, аюулгүй, нээлттэй байдлыг баталгаажуулна. Би Монгол Улсын Ерөнхийлөгчийн хувьд энэ их үйлсийг манлайлан зүтгэх болно.

Эрхэм хүндэт иргэд ээ,

Ирэх хоёр жил манай оронд улсын хэмжээний сонгуульгүй жил байх юм. Ирэх нэг жил бол ирээдүйн арван жилтэй тэнцэх ач холбогдолтой юм. Иймээс бид том зорилт тавьж шахуу ажиллахаар шийдсэн. Байгальд ээлтэй, хямд эрчим хүчээр улсаа хангах зорилтыг бид хэрэгжүүлнэ.

Монгол Улс өөрийн гэсэн галтай, шатахуунтай болно. Ачаагаа дааж ядсан өвгөн төмөр замаа бид шинэчлэнэ. Шинээр төмөр зам барина. Бүх аймаг засмал замаар нийслэлтэйгээ холбогдоно. Гэр хороололд дахин төлөвлөлт, их бүтээн байгуулалт өрнөнө. Нийслэлд хурдны зам, метро баригдаж, орон нутагт баг сумын төвүүд шинэчлэгдэж. Монголд шинэ хотууд босно. Шинэ үйлдвэр, аж ахуйн нэгжүүд олноор нэмэгдэнэ. Манай иргэдийн баялаг бүтээхэд оролцох хувь оролцоо ч нэмж баталгаажна.

Бид иргэн бүрийнхээ өмнө тулгамдаж байгаа асуудлыг өргөн харж шийдвэрлэнэ. Монгол Улсын иргэнд төрөхөөс авахуулаад ахмад насанд хүрч жаргаж амьдрах тэр мөчлөг бүрт нь шаардлагатай дэмжлэгийг төрөөс үзүүлж чаддаг болно. Монголын төр хүүхдүүдээ, ээжүүдээ, залуус оюутан, залуу гэр бүлээ, ахмадуудаа болон дэмжлэг шаардлагатай иргэдээ дэмжих оновчтой, хаягласан бодлоготой болно. Төрийн алба, зэвсэгт хүчин, цэрэгжсэн болон хууль хяналтын байгууллагад ажилладаг иргэдийнхээ нийгмийн асуудалд онцгойлон анхаарна.

Боловсрол, эрүүл мэндийн салбар, орон нутгийн хөгжил, дэд бүтэц, шинэ технологи, үйлдвэр, бүтээн байгуулалтад чиглэсэн хөрөнгө оруулалтыг тодорхой, тогтвортой бодлогоор дэмжинэ. Бүтээлч үр ашигтай шинэчлэл өөрчлөлтийг түүчээлэн дэмжинэ.

Талцал хуваагдлыг бус хийж бүтээхийг эрхэмлэнэ. Баялаг бүтээгчдийг бүх боломжоороо дэмжинэ. Энэ бол амлалт биш. Энэ бол бидний хийх ажил. Энэ ажлыг тасалдуулах эрх хэнд ч байх ёсгүй. Би Монголын ард түмний нийтлэг эрх ашиг, Монгол Улсын хөгжлийн эрх ашгийг хэсэг бүлгийн эрх ашгаас ямагт дээгүүр тавьж ажиллах болно.

Эрхэм нөхөд өө,

Би улс орондоо хуулийн засаглал, шударга ёс, эв нэгдэл, тогтвортой, нээлттэй байдлыг хангахын тулд хичээнгүйлэн зүтгэх болно. Би шийдвэр гаргах танхимд цөөн, эсвэл түүний гадуур байгаа хэсгийн эрх ашгийг хамгаалж, төлөөлж ажиллана

Би ядарч зүдэрч яваа иргэдээ онцгой анхаарна. Таны дуу хоолой, санал санаачлагыг төр түмний анхаарал шийдвэрт оруулахад дэмжлэг үзүүлнэ. Би Монгол Улсын иргэдээ баян ядуу, нам улс төр, угсаа гарвал газар орон үл ялгаварлан жигд төлөөлж ажилланаа. Намайг Монгол Улсын Ерөнхийлөгчөөр дахин сонгогдсонд баяр хүргэсэн нийт хүмүүст гүн талархал илэрхийлье. Монгол Улс урьдын адил бүс нутаг, олон улсын хэмжээнд нээлттэй, идэвхтэй, санаачлагатай ажиллах болно. Ялангуяа хөрш орнуудтайгаа дэд бүтэц, эдийн засаг, хөрөнгө оруулалт, худалдаа, дамжин өнгөрөх гээд тулгамдаж байгаа асуудлуудыг харилцан ашигтай, бүтээлчээр шийдвэрлэхэд онцгой анхаарна.

Монгол Улс дэлхийн олон улс орон, олон улсын байгууллагуудтай урьдын бүтээлч хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэх болно. Мөн манай улсын хөгжил дэвшлийн эрх ашигт нийцсэн хариуцлагатай, нээлттэй, хууль дээдэлдэг хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллана.

Эрхэм Монголчуудаа,

Анд нөхөд өө,

Өнөөдөр Монгол газар шороон дээр 2 сая 900 мянга дахь иргэн мэндэлж байна. Маргааш өглөөг 2 сая 900 мянган Чингис сэрж угтах болно. Ерөөлөөр Монголчууд улам олуулаа болж байна. Монголчууд хүн нэмэгдэхэд баярлаж тосдог уламжлалтай. Хүний орчлонд дөнгөж мэндэлж байгаа Монголын охид, хөвгүүд, агаар нь тунгалаг, гэр нь амгалан, нийгэм нь цэвэр шударга, улс нь хөгжилтэй, хүн ард нь аз жаргалтай эрх чөлөөтэй оронд өсөж бойжих бүрэн эрхтэй.

Өнөөдөр төрж буй охид хөвгүүдээ хөл нь дөрөөнд, гар нь ганзаганд хүрэхэд өнөөгийн аав ээж, өвөө эмээ, ах эгч нь та бид хийсэн ажилтай, сүүн мөртэй, хөтөлж гарсан морио хойч үедээ унуулаад үдэх ерөөлтэй амьдрах учиртай. Та бид нэгэн үед амьдарч, нэгэн үед бүтээж, нэгэн үйлсийн төлөө зүтгэж яваа азтай, одтой, зам нийлсэн хүмүүс. Хөтөлж гарсан ачаагаа хүрэх газар нь бүрэн хүргэж өгнө. Өмнөө байгаа сорилтыг давж, боломжийг ашиглан улс орноо хөгжүүлэн мандуулахын төлөө хамтдаа зүтгэцгээе.

Хурай хурай хурай.

\*\*\*

**Хүндэтгэлийн хуралдааныг хааж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг**

(2013.07.10)

Улсын Их Хурал болон ард түмэндээ хандаж үг хэлсэн Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж Танд баярлалаа. Танд дахин ажлын амжилт, сайн сайхныг хүсье.

Эрхэм гишүүдээ,

Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хуралд тангараг өргөх ёслолын ажиллагаа өндөрлөж байна. Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолын ажиллагаанд хүрэлцэн ирсэн хүндэт зочид төлөөлөгчид, нийт ард түмэндээ баярлалаа. Өнөөдрийн Улсын Их Хурлын чуулганы хүндэтгэлийн хуралдааныг хаасныг мэдэгдье.

\*\*\*



**КАНАД УЛСЫН АМБАН ЗАХИРАГЧ ДЭВИД ЖОНСТОНЫ МОНГОЛ УЛСАД  
АЙЛЧИЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН ХИЙСЭН УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ  
ХҮНДЭТГЭЛИЙН ХУРАЛДААН**

(2013.10.25)

**Хүндэтгэлийн хуралдааныг нээж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг**

(2013.10.25)

Эрхэм хүндэт Ерөнхийлөгч өө,  
Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,  
Хүндэт зочин Канад улсын Амбан захирагч болон Хатагтай, ноёд оо,

Монгол Улсын Ерөнхийлөгчийн урилгаар Канад Улсын Амбан захирагч, эрхэмсэг ноён Дэвид Жонстон, гэргий эрхэмсэг хатагтай Шэрон Жонстон нар манай улсад төрийн айлчлал хийж байна. Монгол Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаанд Канад Улсын Амбан захирагч, эрхэмсэг ноён Дэвид Жонстон оролцож байгааг Та бүхэнд баяртайгаар мэдэгдье.

Канад Улс нь 1990 -ээд онд Монгол оронд өрнөсөн ардчилал, шинэчлэлийг тууштай дэмжиж, 1994 оноос эхлэн хоёр орны төлөөлөгчид өндөр, дээд хэмжээнд харилцан айлчилж, “Өргөн хүрээтэй түншлэл”-ийн хүрээнд хамтын ажиллагаагаа өргөжүүлж ирлээ. Үүний үр дүнд улс төр, эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалт, соёл, боловсрол, батлан хамгаалах, хөдөө аж ахуй, барилгын салбарт тодорхой үр дүн гарч байна. Канад гэдэг улсын тухай жирийн малчин, жирийн хотын иргэн монголчуудын хамгийн түрүүнд төрдөг хоёр сэтгэгдлийг хэлэхийг хүсч байна.

Нэгдүгээрт, манай улсын шинэ сумын төвд канад байшин гэдгээр, хамгийн дулаахан байшин Канад байшин гэдгийг монголчууд бүгдээрээ мэдэж авсан. Үүнийг дэлхийн хамгийн хүйтэн нийслэлд амьдардаг бид бүгдээрээ дэлхийн хоёр дахь хүйтэн нийслэл нь Канад Улсын нийслэл Оттава хот байгаа. Хоёрдугаарт, Канад Улсын уул уурхайн компаниуд Монгол Улсыг дэлхийн эрдэс баялгийн газрын зураг дээр оруулахад том хувь нэмэр оруулсан. Монгол Улсад оруулсан уул уурхайн хөрөнгө оруулалт чухал үүрэгтэй байсныг харуулж байгаа.

Манай хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ой энэ жил тохиож байгаа. Энэ түүхэн үед Монгол Улсын Ерөнхийлөгчийн урилгаар Канад Улсын Амбан захирагч, эрхэмсэг ноён Дэвид Жонстон Монгол Улсад анх удаа төрийн айлчлал хийж байна.

Таныг манай оронд төрийн айлчлал хийж байгаатай холбогдуулан зарласан Улсын Их Хурлын 2013 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хүндэтгэлийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

\* \* \*

**Хүндэтгэлийн хуралдаан дээр Канад Улсын Амбан захирагч  
Дэвид Жонстоны хэлсэн үг**

(2013.10.25)

Найрсаг дотноор угтан авч байгаа та бүхэнд баярлалаа.

Канад Улсын Амбан захирагчийн хувиар Монгол Улсад анхны төрийн айлчлалыг хийж Улсын Их Хуралд хандан үг хэлэх завшаан тохиож байгаа нь миний хувьд нэн хүндтэй үйл явдал болж байна. Гэргий Шэроны хамтаар танай улсад ирээд удаагүй байгаа ч Монголын ард түмний зочломтгой сайхан чанарыг хэдийнээ мэдэрч эхэлсэндээ бид баяртай байна.

Та бүхэнд юуны өмнө Канадын ард түмний халуун мэндчилгээг хүргэн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөж байгааг минь хүлээн авна уу.

Хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ой тохиож буй энэхүү завшааныг тохиолдуулан миний бие Канадын ард түмний дотны нөхөр бөгөөд сайн түнш байсаар ирсэн Монголын ард түмэнд талархал илэрхийлж байна.

Бид энэ жил цаг хугацааны хувьд ахархан хэдий ч эдүгээ ба ирээдүйн харилцаанд маань нэн чухал ач холбогдол бүхий Канадын Элчин сайдын яам Улаанбаатар хотноо байгуулагдсаны таван жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлж байна.



Канад Улсын Амбан захирагч Дэвид Жонстон

Канад Монголчууд бид газар зүйн байршлаараа тусгаарлагдсан хэдий ч алслагдсан орон зайг даван туулах нийтлэг туршлага чадвараараа нэгдмэл билээ. Бид: бахархам түүх, өвөрмөц соёлоо эрхэмлэн дээдлэх уламжлал, мэлмийг баясгаж, тэнхээг сорих уудам эх нутгаа хайрлах сэтгэл, ардчилал, хүний эрх, хуульт ёсыг дээдлэн хөгжих эрмэлзлээр ижилхэн.

Сүүлийн жилүүдэд арилжаа, нэн ялангуяа байгалийн нөөц ашиглалтын салбарт төвлөрч ирсэн бидний харилцаа өнөөгийн цаг үед нийтлэг сонирхол нэгдмэл үйл ажиллагаа бүхий өргөн цар хүрээг хамран хөгжиж байна.

Хоёр орны харилцаа нь бидний энх тайван, аюулгүй байдал, сайн засаглалын төлөө хичээнгүйлэн зүтгэдэг мөнхөд хувьсан өөрчлөгдөх эх дэлхийн, сорилт бэрхшээл бүхнийг даван туулахуйц болоод ард иргэдийн маань хүсэл тэмүүлэлд нийцэхүйц, нэн боловсронгуй баялаг түншлэл болон дэвжиж байгаад би сэтгэл хангалуун байна.

Өнөөдөр Канад, Монголчууд бид өөр хоорондын уялдаа холбоогоо өргөжүүлэн хөгжүүлэх сонирхолтой бөгөөд шинэлэг замаар нэгнээ танин мэдэж байна.

Монголын ардчилсан хөгжлийн замналыг Канадын ард түмэн итгэл найдвар, бахдам сэтгэлээр дүүрэн гэрчилсэн нь үүний нэгэн жишээ билээ. Бид зөвхөн ажиглаад зогсоогүй Монгол Улстай эртнээс тогтоосон түншлэлдээ тууштай хандахуйн илэрхийлэл болгож, нийгмийн бүхий л түвшин дэх Монголчуудтай хамтран, ардчилсан засаглалыг бэхжүүлэх үйлсэд идэвхийлэн оролцсон.



Төрийн албаны удирдлага болон цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, эрх зүйн ба шүүхийн шинэтгэл мөн орон нутгийн засаглалын чадавхийг бэхжүүлэх зэрэг чиглэлүүдээр бид хамтран ажиллаж байна. Түүнчлэн бид хамтдаа Улсын Их Хурал буюу нэн өндөр ач холбогдол бүхий энэ байгууллагын захиргааны болон хууль тогтоох чадамжийг хөгжүүлэхээр хамтын чармайлт гаргаж байна.

Шүүх, төрийн алба, хууль тогтоох байгууллагуудыг хүчтэй, ил тод, үр бүтээлч байдлаар хөгжүүлэх нь туйлын “ухаалаг” бөгөөд “зөв” алхам гэдэгт Канад Улс итгэдэг учраас Монгол Улстай эдгээр үйлсэд хамтран зүтгэдэг. Энэ нь зөв бөгөөд ухаалаг болохын учир нь бид сайн засаглал нь ардчилал, хүний эрх, хууль ёсыг бэхжүүлдэг тухайд итгэдэгт оршино.

Монгол Улсын иргэдийн хүсэн тэмүүлдэг, эдийн засгийн хөгжлийн тулгын гурван чулуу нь байгууллагуудын үйл ажиллагааны чадавх болох тухайд ч мөн бид итгэдэг учраас энэ нь зөв бөгөөд ухаалаг юм. Тэрхүү зорилгод хүрэхэд Улсын Их Хурал болоод хууль тогтоогч та бүгдийн хүчин зүтгэл зайлшгүй түлхэц үзүүлэх болно гэж би хувьдаа ойлгож байна.

Та бүгдийн ажил Монгол Улсын хөгжлийн явцад шууд бөгөөд урт хугацааны нөлөөг үзүүлдэг. Энэ танхимд мэндэлсэн хууль тогтоомжууд танай агуу эх орон, ард иргэдийн эдийн засгийн дэвшил болон бизнесийг хөхүүлсэн тогтвортой орчныг дэмждэг эсхүл үгүй. Тийм учраас манай хоёр орон хамтдаа Монгол Улсын төрийн албаны үйлчилгээг иргэн төвтэй, ил тод, хариуцлагатай, нам бус бөгөөд илүү мэргэшсэн чиглэлээр хөгжүүлэхийн төлөө боломжит урт хугацааны дэмжлэгийг эрэлхийлэн судалж байгаад би сэтгэл хангалуун байна. Мөн түүнчлэн хоёр улс хоорондын худалдааны эргэлт эрчимтэй өсч байгаа нь миний хувьд баярлууштай хэрэг билээ.

Монгол Улсад оруулж буй хөрөнгө оруулалтын хэмжээгээрээ дээгүүрт тооцогддог Канад Улс танай орны гурав дахь том түнш. Бидэнд, харилцан ашигтайгаар эдийн засгийн түншлэлээ өргөжүүлэн баяжуулах гайхалтай боломж бий. Миний ойлгож байгаагаар нэн ялангуяа боловсрол, барилгын технологийн салбарууд нь ирээдүйд үр өгөөжтэй байж болохуйц түвшинд тооцогдож байна.

Олон улсын тавцанд бид хамтдаа 35 гаруй байгууллагын гишүүнчлэлд багтдаг. Монгол Улс Европын аюулгүй байдлын хамтын ажиллагааны байгууллага зэрэгт амжилттай элсэн ороход Канад Улс идэвхийлэн дэмжиж ирсэн. НАТО болон Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн хүрээнд ч бид мөн хамтран ажилладаг.

Энэ ялдамд Монгол Улс Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийг тэргүүлэх хугацаанд үүргээ амжилттай гүйцэтгэж, нэн ялангуяа Монгол Улсын манлайлал дор иргэний нийгмийг бэхжүүлэн чадавхжуулах үйлсэд дорвитой ахиц гарсан явдалд баяр хүргэж байгааг минь хүлээн авна уу.

Энэхүү зорилго нь Канад Улсын хувьд ч мөн эрхэм бөгөөд бид Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн Иргэний нийгмийн асуудлаарх ажлын хэсгийг тэргүүлдгээрээ бахархдаг. Үүний сацуу Монголын болон тус нийгэмлэгийн нэлээдгүй тооны гишүүн орны сургалтын тогтолцоонд нэвтрүүлэх гэж буй “Ардчиллын боловсрол олгох хөтөлбөр”-ийг боловсруулахад оруулсан Канад, Монгол хоёр улсын хамтын хүчин зүтгэлийг би энд онцлон тэмдэглэхийг хүсэж байна.

Дэлхийн олон улс оронтой харилцан уялдаатай байх нь бидний хувьд асар их ач холбогдолтой болохыг Канадчууд ойлгодог. Тэрхүү харилцаа нь олон улсын сайн засаглал, энх тайвныг хамгаалахад хүчин зүтгэх үүрэг хариуцлагыг ч мөн дагуулдаг болохыг бид ухамсарладаг. Үүний учир яг энэ мөчид би, өөрийн орон гэр хайртай дотнын хүмүүсээ орхиж Судан, өөр бусад алс холын орнуудад НҮБ-ын энхийг сахиулах үйлсэд оролцож олон улсын энх тайван, тогтвортой байдлыг сахиулахын төлөө хүлээсэн үүргээ гүйцэтгэж яваа эрэгтэй, эмэгтэй бүхий л Монгол дайчдын зүтгэлийг хүндэтгэн, ёслохыг хүсч байна.

Канад Улс цэргийн сургуулилтын хөтөлбөрүүдээрээ дамжуулан Монгол Улсын олон улсын энхийг сахиулах чадавхыг хөгжүүлэх үйлсэд өөрийн хувь нэмрийг оруулж байна. Улам бүр шударга бөгөөд энх амгалан ертөнцийн төлөө бид бүс нутгийн болоод эх дэлхийн аюулгүй байдлыг хамтдаа бэхжүүлж чадна.

Гэргий Шэрон биднийг Монгол Улсад хүндэтгэн урьсан та бүхэндээ дахин талархлаа илэрхийлье. Ахархан ч гэсэн энэ хугацаандаа бид танай сайхан эх оронтой улам бүр дотно танилцахыг сэтгэл догдлон хүлээж байна.

Ирэх сард тэмдэглэн өнгөрүүлэх гэж буй хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ойн босгон дээр бид хүрч ирээд байгааг үгийнхээ эхэнд би онцлон тэмдэглэсэн. Өмнөх 40 жилийн хугацаанд бидний нөхөрлөл, дипломат харилцааны хүрээнээс хальж эдүгээ бусад олон түвшин, үйл ажиллагааны төрлийг хамарсан хүчирхэг бөгөөд цэцэглэнгүй хөгжлийн зэрэгт хүрчээ.

Канад Улсын нэгэн адил 1973 оны тэртээх Монгол орон бидний мэдэх өнөөгийн Монгол Улстай олон талаараа адилгүй байсан. Гэвч бидний хамтдаа туулсан замын уртад хамгийн эрхэм утга оршиж байна.

Монгол Улс өөрийн хосгүй өөрчлөлтийн замаар хөгжиж байна. Монголчууд Та бүхэн улирах хугацаа угтах ирээдүйн бэрхшээл, боломж алинтай нь ч учирсан энэхүү нөхөрлөлөө Канад Улс хэзээд эрхэмлэн дээдлэх болно. Бидний хамтын ажиллагаа өргөжин дэлгэрэх болтугай!

Та бүхэнд баярлалаа.

\* \* \*



**БНХАУ -ЫН ДАРГА СИ ЗИНЬПИНИЙ МОНГОЛ УЛСАД АЙЛЧИЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН ХИЙСЭН УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХҮНДЭТГЭЛИЙН ХУРАЛДААН**

(2014.08.22)

**Хүндэтгэлийн хуралдааныг нээж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг**

(2014.08.22)

БНХАУ -ын дарга Эрхэмсэг ноён Си Зиньпин,  
Эрхэм хүндэт Ерөнхийлөгч өө,  
Ерөнхий сайд аа,  
Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,  
Хүндэт зочид оо,

Монгол Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаанд Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийн урилгаар Монгол Улсад төрийн айлчлал хийж байгаа БНХАУ -ын дарга Эрхэмсэг ноён Си Зиньпин оролцож байна.

Монгол Улс, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ойн босгон дээр БНХАУ-ын дарга Эрхэмсэг ноён Си Зиньпин Монгол Улсад төрийн айлчлал хийж байгаа нь 1994 онд хоёр орны хооронд байгуулсан Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ болон хоёр талын харилцааны эрх зүйн үндсийг бүрдүүлж буй бусад баримт бичгийг амжилттай хэрэгжүүлж, цаашид хоёр орны иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

БНХАУ-ын дарга Эрхэмсэг ноён Си Зиньпин Танд Монгол Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс болон хувиасаа баяр хүргэж, нарлаг Монгол оронд минь тавтай морилохыг урья.

Таныг Монгол Улсын Ерөнхийлөгчийн урилгаар Монгол Улсад төрийн айлчлал хийж буйтай холбогдуулан зарласан Улсын Их Хурлын 2014 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн хүндэтгэлийн хуралдаан нээснийг мэдэгдье

\*\*\*

**Хүндэтгэлийн хуралдаан дээр БНХАУ -ын дарга Си Зиньпиний хэлсэн үг**

(2014.08.22)

Эрхэм хүндэт Элбэгдорж Ерөнхийлөгч, түүний гэргий,  
Эрхэм хүндэт Энхболд дарга аа,  
Эрхэм хүндэт Алтанхуяг Ерөнхий сайд аа,  
Эрхэм хүндэт гишүүд ээ, сайд нараа,  
Зочид оо, хатагтай ноёд оо,  
Найз нөхөд өө,

Сайн байцгаана уу. Өнөөдөр Монгол Улсын Их Хуралд зочилж найз нөхөд та нар бүхэнтэй уулзаж байгаадаа их баяртай байна. Юуны өмнө миний бие БНХАУ-ын Засгийн газар, Хятадын ард түмний нэрийн өмнөөс мөн хувиасаа энд байлцаж байгаа хүмүүс та нараар дамжуулан бүх Монголын ард түмэнд чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлж, сайн сайхныг хүсэн ерөөе.

2008 онд би БНХАУ-ын Дэд даргаар анхны айлчлал Монгол Улсад хийсэн. Монгол Улсын нутаг дэвсгэрт хүрэлцэн ирмэгц Монгол Улс ёстой баялаг, элбэг сайхан улс гэж боддог. Танай улсын нэртэй уран зохиолч Дашдоржийн Нацагдоржийн шүлэг “Миний нутаг” шүлэгт:

“Хэнтий, Хангай, Саяны өндөр сайхан нуруунууд  
Хойт зүгийн чимэг болсон ой хөвчийн уулнууд  
Мэнэн, Шарга, Номины өргөн их говиуд  
Өмнө зүгийн манлай болсон элсэн манхан далайнууд  
Энэ бол миний төрсөн нутаг Монголын сайхан орон “гэж бичсэн байдаг.

Зургаан жилийн дараа би дахин Монгол Улсад айлчилж, эндэхийн хөгжил цэцэглэлт. Би онгоцны буудлаас Улаанбаатар хотын замаар олон шинэ, шинэ барилгыг би харсан. Энд амьд хүч дүүрэн үзэмжийг хараад чин сэтгэлээсээ баярлаж байна. Миний бие ажилсаг, зорилготой Монголын ард түмэн асар их амжилт олсонд баяр хүргэе.



**Монгол Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаан дээр  
БНХАУ -ын дарга Си Зиньпин**

Өчигдөр би Ерөнхийлөгч Элбэгдоржтой хэлэлцээр хийсэн. Саяхан би Энхболд дарга, Алтанхуяг Ерөнхий сайд нартай уулзлаа. Миний бие Монгол Улсын удирдагч нартай Хятад, Монголын харьцаа болон сонирхсон асуудлаар гүн гүнзгийгээр санал бодлоо солилцож өргөн хүрээнд тохиролцоонд хүрсэн юм.



Хоёр тал Хятад, Монголын харилцааг иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа болгож дээшлүүлж хамтарсан тунхаглал гаргаж улс төр, худалдаа, эдийн засаг, хүмүүнлэг зэрэг салбарын 20 гаруй хамтын ажиллагааны баримт бичигт гарын үсэг зурсан юм. Айлчлалын үр дүнд би сэтгэл ханамжтай байна. Хятад, Монголын харилцааны ирээдүйд итгэл төгс байна.

Хатагтай, ноёд оо,  
Найз нөхөд өө,

Морины сайныг унаж мэддэг, хүний сайныг ханилж мэддэг. 65 жилийн өмнө Хятад, Монгол Улс албан ёсоор дипломат харилцаа тогтоосон билээ. Монгол Улс бол хамгийн эрт шинэ Хятад улстай дипломат харьцаа тогтоосон улсуудын нэг мөн. Танай улсаас шинэ Хятадад улсад үзүүлсэн дэмжлэгийг бид мартахагүй болно.

Би дахин тэмдэглэх гэж байна. Олон улсын бүс нутгийн нөхцөл яаж өөрчлөгдсөн ч гэсэн Хятад Улс цаг ямагт Хятад, Монголын найрсаг харьцааны гэрээний дагуу Монгол Улсын тусгаар тогтнол, бие даасан, хараат бус нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэж Монголын ард түмэн өөрөө сонгосон хөгжлийн замыг бид хүндэтгэнэ. Энд бид урт удаан хугацаанд баримтлах үндсэн бодлого болно.

Хоёрдугаар жаранд орсон Хятад, Монголын харьцаа улам өндөр төвшинд гарсан байгааг баяртайгаар тэмдэглэж байна. Ялангуяа өнгөрсөн 20 жилийн туршид Хятад, Монголын өндөр дээд хэмжээний харилцан айлчлал тогтмолжиж улс төрийн харилцан идэвхжил тасралтгүй гүнзгийрч ирсээр байна.

Хоёр улсын худалдаа, эдийн засгийн ажил хэрэгч хамтын ажиллагаа эрчимтэй хөгжиж, Хятад улс олон жил дараалан танай улсын худалдааны хамтын том түнш болон хамгийн том хөрөнгө оруулагчдын байр эзэлдэг юм. 2013 онд Хятад, Монгол харилцан зорчсон тоо 1 сая 300 мянга болж, үүний дотор Хятадад зорчсон Монгол Улсын иргэдийн тоо 1 сая давсан юм.

Хятад, Монголын иж бүрэн стратегийн харилцаа тогтоох яг цаг үед нь нийцэж байна гэж хэлж болно. Энэ нь Хятад, Монголын харилцаа хамгийн сайн үед орсныг тэмдэглэж байна.

Хятад, Монгол бол уул, усаар холбогддог найрсаг хөрш орон мөн бөгөөд тус бүс нутгийн чухал улсууд мөн. Энэ жил бол Хятад, Монгол Улс дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ой, Хятад, Монголын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ шинэчилсний 20 жилийн ой, мөн Хятад, Монголын найрсаг харилцааны жил болж байна. Хоёр тал иж бүрэн стратегийн түншлэлийн харьцаа тогтоосны боломжийг ашиглаж Хятад, Монголын харилцааг улам их өндөр төвшинд гаргах хэрэгтэй байна.

Нэгдүгээрт, Хятад, Монгол Улс харилцан туслалцах сайн хөрш болох ёстой. Олон улсын нөхцөл байдалд ямар өөрчлөлт гарсан ч гэсэн хоёр улсын харилцааны гол чиглэлийг дагаж стратегийн түншлэлийн өнцгөөс нөгөө талын төлөө бодох ёстой. Нөгөө талын бүрэн эрх, аюулгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал зэрэг гол цөмийн асуудалд анхаарч буй томоохон асуудалд харилцан тууштай дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Хоёр улс өндөр дээд хэмжээний харилцан айлчлалыг ханган хоёр улсын удирдагч нар төрөл бүрийн шугмаар уулзалт хийж, стратегийн зохицуулалтыг эрчимжүүлж улс төрийн харилцан итгэлцлийг бэхжүүлнэ.

Ерөнхийлөгч Элбэгдорж энэ оны 11 дүгээр сард Хятадад болох АПЕК-ийн удирдагч нарын албан ёсны бус хурлын үеэр зохион байгуулах дэд бүтцээр холбох тухай түншлэлийн яриа, хэлэлцээрт оролцохыг би урьж байна. З.Энхболд дарга энэ онд Хятад Улсад албан ёсны айлчлал хийхийг Хятадын тал урьж байна.

Хууль тогтоох байгууллагуудын хоорондын тогтмол солилцооны механизм, дипломат байгууллагуудын хоорондын стратегийн яриа хэлэлцээрийн механизм тогтоохоор хоёр

тал тохиролцсон бөгөөд батлан хамгаалах, аюулгүй байдлын зөвлөлдөх уулзалтын хүрээнд хоёр улсын батлан хамгаалах салбарын ажиллагааг бэхжүүлнэ. Монгол Улсыг АПЕК -ийн гишүүнээр элсэхийг БНХАУ дэмжиж байна.

Монголын тал Зүүн Азийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцож, Зүүн Азийн дээд түвшний уулзалт, Хятад, Япон, Өмнөд Солонгосын хамтын ажиллагаанд зохих хэлбэрээр оролцохыг Хятадын тал дэмжиж байна. Монголын тал санаачилсан Зүүн хойд Азийн аюулгүй байдлын талаарх Улаанбаатарын яриа хэлэлцээг дэмжиж, НҮБ, АСЕМ, АХАИББХ, ШХАБ-ын хүрээнд хамтын ажиллагаагаа бэхжүүлнэ. Хятадын тал монголын талтай “Торгоны замын эдийн засгийн бүс” санаачилгын хүрээнд ажиллахад бэлэн байна. Мөн Монголын “Талын зам” санаачилгад нааштайгаар, нээлттэй хандаж байна. Хоёр тал Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк зэрэг шинэ талбарт хамтын ажиллагааг бэхжүүлэн хамтдаа хөгжиж, хамтран ашиг хүртэх болно.

Хоёрдугаарт, Хятад, Монгол хоёр улс харилцан ашигтай, хамтдаа хожих сайн түнш болох ёстой. “Усны дэргэдэх асраас сарны тусгалыг түрүүлж харна” гэсэн үг бий. Хятад, Монгол хоёр орон газар зүйн байршлын хувьд хөрш, эдийн засгийн хувьд харилцан нөхөх шинжтэй. Хятадын талд зах зээл, хөрөнгө мөнгө, техник, технологи, зам, дэд бүтцийн талаар давуу тал бий. Монгол Улс арвин их байгалийн баялагтай. Иймд хоёр тал хамтран ажиллахад ихээхэн боломж байна.

Өнгөрсөн жил Хятад улсын импорт, экспортын барааны эргэлт 4 триллион 16 тэрбум ам.долларт хүрсэн. Ирэх 5 жилд Хятадын гадаад худалдааны эргэлт 10 триллион, гадаадын хөрөнгө оруулалт 500 тэрбум ам.долларт хүрэх урьдчилсан тооцоо байна. Өнгөрсөн жил гадаадад зорчсон хятад иргэдийн тоо бараг 100 сая болсон. Энэхүү тоо 2020 он гэхэд 150 саяд хүрнэ. Хятад улсын тасралтгүй хөгжил Монгол Улс болоод бусад түншүүдэд асар том зах зээл, боломжийг нээж байна.

Миний энэ удаагийн Монгол Улсад хийсэн айлчлалаар Монголын тал удаан хугацаанд анхаарал тавьж ирсэн дамжин өнгөрөх тээвэр, далайн гарцын асуудал тодорхой шийдэлд хүрлээ. Хоёр тал уул уурхай, эрчим хүч, дэд бүтцээр холбогдох хамтын ажиллагааны комисс байгуулж, Хятад, Монголын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрт гарын үсэг зурлаа.

2020 он гэхэд хоёр талын хоорондын худалдааны эргэлтийг 10 тэрбум ам.долларт хүргэх зорилтыг тодорхойлсон. Хоёр талын хилийн боомтын төмөр замын хамтын ажиллагааны талаар гүн гүнзгий санал солилцож, тохиролцоонд хүрлээ. Хоёр тал юань, төгрөгийн свопийн хэмжээг 10 тэрбум 500 сая хүртэл нэмэгдүүлээ. Эрээн - Замын - Үүдэд хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах талаар судалгаа хийхээр санал нэгдлээ. Хоёр тал уул уурхайн бүтээгдэхүүнийг гүнзгий боловсруулах, шинэ эрчим хүч, хөдөө аж ахуй, мал аж ахуй, байгаль орчныг хамгаалах зэрэг салбарт бүх талын хамтын ажиллагаа явуулах болно. Эдгээр шинэ хэлбэрийн хамтын ажиллагаа нь хоёр орны ард түмэнд улам их, бодит ашиг тус авчирна гэдэгт найдаж байна.

Гуравдугаарт, Хятад, Монгол хоёр улсын иргэд үргэлж харилцан зочилсон сайн найзууд болох ёстой.

Замаа мэдвэл явахад амар, хүнээ мэдвэл ярилцахад амар. Өчигдөр би Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржтой хэлэлцээ хийхэд иргэдийн солилцоог идэвхжүүлэх, харилцан зорчих нөхцөлийг хөнгөвчлөх бодлого баримтлах, залуучууд, хэвлэл, мэдээллийн салбарын тогтмол солилцоог бэхжүүлж, ингэснээрээ нийгэмд таатай уур амьсгалыг бүрдүүлж, Хятад, Монголын найрамдлыг эрчимтэй сурталчлахаар тохиролцсон.

Хятадын тал Монгол Улсын иргэн тус улсад суралцах, жуулчлах, худалдаа хийх, эмчлүүлэхэд найрсгаар хүлээн авах болно. Хятадын тал ирэх 5 жилд Монголын талд нийт 1000 хүнийг

давтан сургалтад хамрагдах квот олгож, Засгийн газрын тэтгэлэгт 1000 оюутныг хамруулах, 500 цэргийн албан хаагчдын мэргэжлийг дээшлүүлэх болно. Монголын 500 залуу, 250 сэтгүүлчийг Хятадад айлчлахыг урьж байна. Хятадын тал Монголын талд 25 шилдэг кино бэлэглэх болно. Эдгээр нь хоёр орны ард түмний хоорондын харилцан ойлголцол, найрамдлыг гүнзгийрүүлэхэд түлхэц болно гэдэгт итгэж байна.

Хатагтай, ноёд оо,  
Анд нөхөд өө,

Одоо Хятадын ард түмэн хоёр “100 жил” -ийн зорилт биелүүлэхийн төлөө хүчин зүтгэж байна. 2020 он гэхэд анхан шатны чинээлэг нийгмийг бүх талаар бүтээн байгуулж, энэ зууны дунд үе гэхэд чинээлэг, ардчилсан, соёлтой, өв тэгш, орчин үеийн социалист орныг бүтээн байгуулна. Бидний энэхүү зорилтыг товчлон хэлбэл, Хятадын үндэстний сэргэлтийн “Хятадын мөрөөдөл” гэж хэлж болно.

Монгол Улс өөрийн орны шинэчлэлт, өөрчлөлт, нийгэм, эдийн засгийн хөгжил цэцэглэлтийн төлөө хүчин зүтгэж байна. Өөрөөр хэлбэл, Монголын ард түмний зүрхэнд бас монголын мөрөөдөл бий.

БНХАУ -ын шинэчлэл өөрчлөлт, нээлттэй байх бодлого, орчин үеийн бүтээн байгуулалт нь хөрш орнуудад, түүний дотор Монгол Улсын хөгжилд нааштайгаар нөлөөлж, чухал түлхэц болно. Хятад, Монгол хоёр улсын хөгжлийн стратегийг үр дүнтэй хослуулснаар хамтран хөгжих бүрэн боломжтой юм.

Хоёр “100 жил”-ийн зорилтыг биелүүлэх нь амар хэрэг биш. Яагаад гэвэл бид 1 тэрбум 300 сая хүн амтай, алслагдсан зах хязгаар нутгийн хөгжил тэнцвэргүй, бидний ачаа хүнд, туулах зам хол байгааг бүрэн мэдэрч байна. Бид удаан хугацаанд цуцалтгүй хүчин чармайлт гаргах хэрэгтэй. Энэхүү зорилтыг биелүүлэхэд аятай таатай орчин хэрэгтэй. Хэрвээ гэрийн гадаа тайван байвал гэрийн дотор санаа зоволтгүй ажлаа хийж чадна.

Хятад улсын зогсолтгүй хөгжлийн явц дэлхий дахинд болон зарим хүмүүст эргэлзээ төрүүлжээ. Хятад улс хөгжсөнөөрөө заналхийлэл болох вий гэж санаа зовниж байна. Энэ бол буруу ойлголт, буруу үзэл бодол юм. Хятад улс энх тайванч замаар тууштай замнаж, дэлхийн улс онууд энх тайвнаар хөгжихийг дэмжиж байгаагаа олонтаа илэрхийлсэн.

Хятад улс олон улсын өмнө хүлээсэн үүргээ амжилттай биелүүлэн, дэлхийн бусад орнуудтай хамтран хүн төрөлхтний ёс суртахуун болон олон улсын нийтлэг хэм хэмжээг сахин хамгаалж, дэлхий болоод бүс нутгийн үйл ажиллагаанд шударга ёсыг эрхэмлэн оролцох болно. Хятад улс чин шударга, зоригтой, тэвчээртэй, яриа хэлэлцээний зарчмаар, энх тайван замаар аливаа зөрчил маргааныг шийдвэрлэхийн төлөө байна.

Хятад улс дэлхийн улс орнууд өөр өөрсдийн хөгжих замыг сонгох эрхийг хүндэтгэж ирснийг олонтаа мэдэгдэж байсан. Бид өөрсдийн үзэл бодлыг бусдад тулган хүлээлгэхгүй. Аливаа хүн өөрийн үзэл бодлыг хятадын ард түмэнд тулган хүлээлгэхийг бид бас зөвшөөрөхгүй. Бид олон улсын маргааныг энх тайвнаар шийдэхийн төлөө байна. Хятад улс аливаа жанжлах бодлого, хүчирхийлэгч улс төрийг эсэргүүцэж, хэзээ ч жанжлах бодлого явуулахгүй, хэзээ ч тэлэх бодлого явуулахгүй.

Хятад үндэстэн энх тайвныг эрхэмлэгч үндэстэн бөгөөд хятадын соёл, өв уламжлалыг эрхэмлэдэг. Таван мянган жилийн иргэншлийн хөгжлийн явцад хятад үндэстэн энх тайванч, эв хамтач үзлийг тууштай баримталж ирсэн билээ. Энх тайвныг эрхэмлэх, эвсэг найртай харилцах, өөрийн хүслийг бусдад тулгахгүй байх зэрэг ойлголтууд нь Хятадын эрт дээр үеэс уламжлагдан ирсэн, хятад гүн ухаанд шингэсэн, хятад хүний үйл ажлаар илэрч байдаг. Эрт дээр үеэс хятад үндэстэн гадаадад довтолхын оронд худалдаа хийх, гадаад харилцааг идэвхтэй явуулж ирсэн.

Өөрийн орныг хамгаалах эх оронч үзлийг эрхэмлэдэг. Харин нутаг дэвсгэрээ тэлэх, колончлох үзэл байхгүй. Хуучин Хятад улсын түүхээс харахад гай гамшиг дүүрэн, зовлон доромжлолд автсан гашуун түүх байдаг. Мөн хятад үндэстний гадаадын довтолгоог эсэргүүцсэн, үндэсний тусгаар тогтнолынхоо төлөө тэмцсэн аугаа их тэмцлийн түүх байдаг. Хатуу зовлонг туулсан Хятадын ард түмэн энх тайвныг эрхэмлэн хайрладаг бөгөөд өөрийн гашуун сургамжийг бусдад дахин амсуулахгүйн төлөө байна. Хятадын ард түмэн дэлхийн бусад орны ард түмэнтэй энх тайвнаар зэрэгцэн оршиж, эв хамтаар хөгжих, энх тайвныг хамтран сахин хамгаалж, энх амгаланг хамтдаа хүртэхийн төлөө бэлэн байна.

Хятад улсын шинэчлэл, нээлттэй бодлого явуулсан 30 гаруй жилийн түүх энх тайвнаар хөгжих нь БНХАУ-ын улс орны үндсэн нөхцөл байдал, нийгмийн тогтолцоо, уламжлалт соёлоос үүдсэн стратегийн сонголт гэдгийг нотлон харуулж байна. Энэ нь он цагийн урсгалд хөл нийлсэн, Хятадын үндэстний эрх ашигт нийцсэн, дэлхийн бусад орон болон хөрш орнуудын эрх ашигт зохицсон байдаг юм. Бид үүнийг өөрчлөх учиргүй.

Бид Монгол Улс болоод хөрш орнуудаа хамтдаа хөгжих сайн түнш, энх тайван тогтвортой байдлыг сахин хамгаалах сайн найз гэж үздэг. Бид дийлэнх хөршүүдтэйгээ түншлэлийн харилцаа тогтоогоод байна. Цаашид ч хөршүүдтэйгээ найрсгаар харилцах, түнш болох зарчмыг барьж, энх тайвнаар зэрэгцэн оршиж, баян чинээлэг болгох бодлогыг баримтална. Бид хөршүүдтэйгээ харилцахдаа эвтэй найрсгаар, чин сэтгэлээсээ, үнэнч шударгаар хандаж эвсэг хөрш, амгалан хөрш, баян хөрш байх бодлого баримтална.

Хамтдаа түлээ цуглуулбал гал өндөр бадарна. Хятад улс Монгол Улсыг оролцуулаад хөрш орнууддаа хөгжлийн боломж, хөгжих орон зайг олгоно. Та бүхнийг Хятадын хөгжлийн галт тэргэнд суухыг урьж байна. Галт тэрэг хурдан ч бай, удаан ч бай бид Та бүхнийг урьж байна. “Ганцаар явбал хурдан явна. Олуулаа явбал хол явна” гэж үг байдаг.

Хятад улс хөгжиж буй орнуудтай хамтын ажиллагаагаа явуулахдаа зөв үзэл бодол баримталж, “би хожиж, чи хожигдоно”, “би ихийг, чи багыг” гэх асуудал гаргахгүйгээр, зарим тодорхой төслүүд дээр нөгөө талын эрх ашгийг анхаарах болно гэдгийг би олонтаа хэлсэн. Хятад хүн хэлснээ хийдэг, хийснээ дуусгадаг. Хятад улсын хэлсэн үг, амласан амлалт заавал биелэх, хэрэгжих ёстой.

Хатагтай, ноёд оо,  
Найз нөхөд өө,

Монголд “Айл хүний амь нэг, саахалт хүний санаа нэг” гэсэн үг байдаг. Хятад хүн “Сайн хөршийг алтаар ч солихгүй” гэж ярьдаг. Хятад улс дэлхий дээр хамгийн олон хөрштэй орон. Үүнийгээ бид үнэт эрдэнэ гэж үздэг.

Өнөөгийн ертөнцөд Ази тив бол эдийн засаг хамгийн эрчимтэй хөгжиж байгаа бүс нутаг. Мөн эмзэг асуудал цөөнгүй байдаг. Азийн улс орнуудын хөршийн харилцааг хэрхэн зохицуулах, яаж энх тайвнаар зэрэгцэн орших, яаж хамтдаа хөгжих, зөрчил маргааныг эв зүйгээр хэрхэн зохицуулах зэрэг нь заримдаа төвөгтэй асуудалд хүргэдэг. Миний бодлоор эдгээр асуудлыг шийдэхийн тулд хамгийн чухал нь цаг үеийн байдал, ард түмний хүсэл зорилгод нийцүүлэх хэрэгтэй гэж үздэг. Мөн түүнчлэн харилцан хүндэтгэлтэй хандаж, үзэл бодлоо нэгтгэж, санал зөрөлдөөнөө арилган ирээдүйгээ харсан, харилцан ашигтай байх, хамтдаа хожих зарчмыг баримталж, дорно дахины оюун ухаанаар аядуу зөөлөн асуудлыг шийдэж, эвийг эрхэмлэх зүйтэй гэж боддог.

60 жилийн өмнө Хятад, Энэтхэг, Мяньюмар хамтран энх тайвнаар зэрэгцэн орших 5 зарчмыг санаачилсан нь улс хоорондын харилцааны чиглүүлэх суурь мөрдлөг болж, Азийн улс орнууд олон улсын харилцааны хөгжлийг урагшлуулахад чухал хувь нэмэр оруулсан билээ.

Бүс нутгийн хамтын ажиллагааг урагшлуулах явцад Азийн улс орнуудын солилцоог бий

болгон, харилцан хүндэтгэж, санал нэгтэй зөвшилцөн тал талд таатай Ази хэв маягийг харгалзан үзэх нь энэ бүс нутгийн онцлог, харилцаагаа зохицуулах уламжлалд нийцэх юм. Энэхүү уламжлал нь Азийн улс орны хөршийн харилцаанд илэрч байна. Өнөөдөр үүнийг үргэлжлүүлэн өргөжүүлж, Азийн орнууд болон бүс нутгийн энх тайван, хөгжил, хамтын ажиллагаанд тасралтгүй өдөөгч, дотоод хөдөлгөгч хүч болгох хэрэгтэй. Энэхүү уламжлалыг баримталж хэрэгжүүлэхэд дараах хэдэн зүйлийг хийх хэрэгтэй.

Харилцан хүндэтгэж, харилцан итгэе. Азийн олон улс, орнууд гаднын түрэмгийлэлд өртөж, зовлон зүтгүүр амссан түүхтэй. Тиймээс ч тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын үнэ цэнийг гүн гүнзгий ойлгодог. Тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал, нөгөө улсын сонгосон нийгмийн тогтолцоо болон хөгжлийн замыг хүндэтгэж, дотоод хэрэгт нь үл оролцох, бие биенийхээ анхаарал хандуулж буй томоохон асуудлыг харилцан дэмжих нь Азийн улс орнуудын найрсаг харилцааны гол үндэс юм. Азийн улс орнууд өөр өөрийн онцлогтой, нээлттэй, хүлээцтэй уламжлалтай билээ. Улс орнууд эрх тэгш зарчимд тулгуурласан өөр, өөр соёл, иргэншлийн харилцан солилцоог нэмэгдүүлэх замаар харилцан ойлголцол, итгэлцлийг гүнзгийрүүлж, Ази тивийн тогтвортой байдал, хөгжил цэцэглэлийн бат бэх үндэс суурийг бий болгоно.

Нийтлэг зүйлийг нэмэгдүүлж, зөрчлийг арилгая. Азийн улс орнуудын харилцааны түүхэнд найрсаг хамтын ажиллагаа голлож ирсэн боловч зарим нэг шийдвэрлэх асуудлууд байсаар байна. Хөрш орнуудын хооронд үл ойлголцох явдал хааяа гардгийг үгүйсгэхгүй. Гол нь асуудалд хэрхэн хандаж, яаж шийдвэрлэх нь чухал юм. Яриа хэлэлцээний нэгдсэн ойлголт болон хамтын ажиллагааны нийтлэг зүйлийг нэмэгдүүлж, зөрчилдөөнийг арилгах нь бүс нутгийн тогтвортой, аюулгүй байдлыг удаан хугацааны туршид хадгалах цорын ганц баталгаа юм. Бид алсын хараатай байж, аливаа асуудлыг найрсагаар хэлэлцэн зөвшилцөж, олон улс, бүс нутгийн үйл хэрэгт хамтран оролцож олон улсын улс төр, эдийн засгийг эрх тэгш, шударга зарчмаар хөгжүүлэхэд идэвхтэй хувь нэмэр оруулна.

Хамтын ажиллагаанд хамтдаа хожих, эдийн засгаа хөгжүүлэх, ард иргэдийнхээ амьжиргааг дээшлүүлэх нь Азийн улс орнуудад тулгарч буй эн тэргүүний зорилт бөгөөд харилцан ашигтай хамтын ажиллагааг бэхжүүлэх нь найрсаг харилцааг урагшлуулах гол түлхүүр юм. Азийн улс орнууд хамтдаа хүчирхэгжин, харилцан туслах ази чанараа хадгалан, давуу талаараа харилцан нөхөлцөж, эрх ашгаа хамтатган өргөжүүлж, чөлөөт худалдааны бүс байгуулах болон харилцан дэд бүтцээр холбох бүтээн байгуулалтаа урагшлуулан, бүс нутгийн эдийн засгийн интеграцийг гүнзгийрүүлж, хамтдаа хөгжин, нийтлэг эрх ашгийн том бялууг бүтээлцэж, улс орнуудын ард түмний аз жаргалыг нэмэгдүүлэхийг хүсэж байна.

Хатагтай, ноёд оо,  
Анд найз нар аа,

Миний бие энэ удаагийн Монгол Улсад хийж буй айлчлалаасаа Монгол, Хятадын найрамдал хэдийнээ хоёр орны ард түмний сэтгэлд соёолж буйг мэдэрлээ. Энэ нь Монгол, Хятадын харилцааны хөгжилд хамгийн том итгэлцэл, хөдөлгөгч хүч юм. Хоёр орны ард түмний дэмжлэгээр Монгол, Хятадын харилцааны маргааш улам сайхан болно гэдэгт итгэлтэй байна.

Энэ он бол Монгол, Хятадын морин жил. Морь бол хүч чадал, ахиц дэвшлийн бэлэг тэмдэг юм. Монгол, Хятад хоёр орны ард түмний хайр, хүндэтгэлийг гүн гүнзгий мэдэрцгээе.

Монгол Улс бүтээн байгуулалт морины хурдаар цэцэглэн хөгжихийг чин сэтгэлээсээ хүсэж байна. Монгол, Хятадын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа, хамтын ажиллагаанд хурдан моринд ташуур өгөх адил амжилт хүсье. Гар гараасаа барилцан хамтын чармайлтаар Монгол, Хятадын үе үеийн найрамдлын үрийг хоёр орны ард түмний сэтгэл зүрхэнд цацъя.

\*\*\*

**Хүндэтгэлийн хуралдааныг хааж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг**

(2014.08.22)

Монгол Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаанд халуун дотно үг хэлсэн Танд Улсын Их Хурлын нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлье.

Өнгөрсөн хугацаанд манай хоёр орны хооронд байгуулж хэрэгжүүлсэн 420 гаруй гэрээ хэлэлцээрээс 151 гэрээ хэлэлцээр хүчин төгөлдөр үйлчилж байна.

Энэ удаагийн өндөр хэмжээний айлчлалын хүрээнд Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал гаргаж, хоёр орны Засгийн газар хооронд Төмөр замын дамжин өнгөрөх тээвэр, далайн боомтыг ашиглах, худалдаа эдийн засаг, нийгмийн салбарыг хөгжүүлэхэд 20 гаруй бичигт гарын үсэг зурлаа. Мөн Монгол, Хятадын аж ахуйн нэгжүүд эрчим хүч, төмөр зам, авто зам, нүүрс, сүү боловсруулах зэрэг хөдөө аж ахуй, хүнд, хөнгөн үйлдвэрлэлийн салбарт хамтран ажиллахаар 10 гаруй гэрээ, хэлэлцээр, санамж бичиг байгууллаа. Эдгээр баримт бичгийг хэрэгжүүлэхэд Монголын төр засаг бүхий л анхаарлаа хандуулж хамтран ажиллах болно.

Байгалийн нөөц баялгийг ашиглах хамтын ажиллагааны хүрээнд нүүрс хийжүүлж шатдаг хий гаргах, төмөр, газрын тос боловсруулах зэрэг томоохон төслүүдийг хамтран хэрэгжүүлэх нь Монгол Улсын хөгжилд чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Монгол орны мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, махны экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр ч харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх өргөн боломж байна.

БНХАУ -аас Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд зориулж хөнгөлөлттэй зээл, тусламж олгосонд талархал илэрхийлж байна. Танд Монгол Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаанд үг хэлсэнд дахин талархал илэрхийлж, ажлын амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Монгол Улсын Их Хурлын 2014 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн хүндэтгэлийн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

\* \* \*

**БНЭУ -ЫН ЕРӨНХИЙ САЙД НАРЕНДРА МОДИ МОНГОЛ УЛСАД АЙЛЧИЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН ХИЙСЭН УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХҮНДЭТГЭЛИЙН ХУРАЛДААН**

(2015.05.17)

**Хүндэтгэлийн хуралдааныг нээж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг**

(2015.05.17)

Эрхэм хүндэт Ерөнхийлөгч өө,  
Монгол Улсын Ерөнхий сайдаа,  
Монгол Улсын Их Хурлын Эрхэм гишүүд ээ,  
Хүндэт зочин Нарендра Модиа,

Монгол Улсын Ерөнхий сайдын урилгаар Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Ерөнхий сайд Эрхэмсэг ноён Нарендра Модиа манай улсад төрийн айлчлал хийж байна.

Эрхэмсэг ноён Нарендра Модиа Монгол Улсын Нэгдсэн хуралдаанд үг хэлэхтэй холбогдуулан зарласан Улсын Их Хурлын хүндэтгэлийн чуулган 62 гишүүн хүрэлцэн ирсэн байна. 81.6 хувийн ирцтэй байна нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаанд Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Ерөнхий сайд Эрхэмсэг ноён Нарендра Модиа оролцож байгааг Та бүхэнд баяртайгаар мэдэгдье.





Монгол Улсын Ерөнхий сайдын урилгаар Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Ерөнхий сайд Эрхэмсэг ноён Нарендра Моды манай улсад төрийн айлчлал хийж байна. Монгол Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаанд оролцож байгаа Энэтхэг Улсын Ерөнхий сайд Нарендра Моды танд баяр хүргэе.

Монгол, Энэтхэгийн ард түмний харилцаа холбоо олон мянган жилийн түүхтэй бөгөөд энэ жил Монгол Улс, Энэтхэг Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ой тохиож байна.

Энэ түүхэн жил Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Ерөнхий сайд Монгол Улсад анх удаа төрийн айлчлал хийж байгаа нь хоёр орны харилцааны түүхэнд томоохон үйл явдал болж байна.

Монгол орон ардчилал, зах зээлийн замыг сонгосон 1990-ээд оны эхнээс хоёр улсын харилцаанд шинэ үе эхэлж, Бүгд Найрамдах Энэтхэг Улс манай улсын “гуравдагч хөрш”-ийн хувьд Монгол Улсын гадаад бодлогод чухал байр суурь эзэлсээр ирлээ.

Хоёр орны уламжлалт найрсаг харилцаа соёл, боловсрол, мэдээллийн технологи, сэргээгдэх эрчим хүч, аж үйлдвэр, хөдөө аж ахуй зэрэг салбаруудад “иж бүрэн түншлэл”-ийн зарчмаар өргөжин хөгжиж байна.

Одоо Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Ерөнхий сайд Эрхэмсэг ноён Нарендра Моды таныг Монгол Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаанд үг хэлэхийг урьж байна.

\*\*\*

**Хүндэтгэлийн хуралдаан дээр БНЭУ -ын Ерөнхий сайд Нарендра Модигийн хэлсэн үг**  
(2015.05.17)

Эрхэмсэг ноён, Монгол Улсын Ерөнхийлөгч өө,  
Эрхэмсэг ноён, Монгол Улсын Их Хурлын дарга аа,  
Эрхэмсэг ноён, Монгол Улсын Ерөнхий сайд аа,  
Монгол Улсын Их Хурлын Эрхэм гишүүд ээ,  
Хатагтай, ноёд оо,

Агуу үндэстний эх орон, үзэсгэлэн төгөлдөр Монгол Улсад хүрэлцэн ирсэндээ би чин сэтгэлээсээ баяртай байна.

Монгол Улсын Их Хуралд үг хэлж байгаа минь их нэр төрийн хэрэг юм. Монголын ардчиллын 25 жилийн ой тохиож буй жилд ийнхүү үг хэлэх боломж олдсон нь онцгой аз завшаан юм.

Амралтын Ням гараг гэлгүй намайг ингэж зочлон хүндэтгэж байгаа Та нарынхаа өгөөмөр сайхан сэтгэлд би гүн хүндэтгэлээ илэрхийлье. Халуун дулаанаар угтан авч, гайхалтай сайхан зочлуулж байгаад тань би гүнээ талархаж байна. Миний бие оюун санааны хөрш 1.25 тэрбум анд нөхдийн тань халуун мэндчилгээг энэ хүндтэй танхимд тээж ирлээ.

Оюун санааны хөрш байхаас илүү хүний харилцааны эрхэм дээд хэлбэр гэж үгүй ээ, мөн үүнээс илүү шүтээнлэг хэлхээ холбоо ч гэж үгүй билээ. Биднийг оюун бодолдоо тийнхүү тээж явдагт тань Энэтхэгчүүд бид Та бүхэнд нэн хүндэтгэлтэй байдаг. Хувь хүний болоод улс үндэстний амьдралд сайн анд найз нөхөд шиг үнэт бэлэг үгүй ээ. Тиймээс ч би нийт үндэстнийхээ өмнөөс Монгол анд нөхдөө гүнээ үнэлэн хүндэтгэж байдгаа илэрхийлье.

Энэтхэг, Монгол хоёр улс нь хөгжлийнхээ нэн хариуцлагатай үетэй золгож байна. Та бид дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойгоо тэмдэглэж байна. Гэвч оюун санааны ертөнц дэх бидний хэлхээ холбоо хязгааргүй юм.

Хоёр мянган жилийн тэртээ Энэтхэгээс лам нар энэ сайхан нутагт Бурхан багшийн

сургаалыг тээж хүнд бэрх бөгөөд урт замыг туулж ирж байжээ. Олон хүн эндээс оюуны мэдлэг эрэлхийлэн халуун Энэтхэг оронд очиж байжээ.

Хүний үзэл санаа, хөдөлгөөн хязгаарлагдмал байсан олон зууны тэртээ агуу Монголчууд Ази, Европыг хооронд нь холбосон билээ. Тэдний эрэлхэг зориг, адал явдал өнөөдөр ч дэлхий даяар хүмүүсийн ой тойнд үлдэн хоцорчээ. Хүн төрөлхтний түүхэн дэх тэдний нөлөө асар их юм. Түүхийн эргүүлгэнд Та бидний соёл, утга зохиол, урлаг хоорондоо хэрэн холбогдож, Энэтхэг соёлын олон янзын баялаг өнгө төрх Монгол газар ул мөрөө тод үлдээжээ.



**Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Ерөнхий сайд Нарендра Моди**

Өнөөдөр Энэтхэг, Монгол хоёр орны хооронд тогтсон зүрх сэтгэл, оюун санааны харилцаа нь орон зайн саадыг давах хүчтэйг дэлхий дахинаа нотлон харууллаа. Энэ харилцаа нь жил бүр оюун санааны эрэлд Монголоос Энэтхэгт хүрэлцэн ирдэг хэдэн зуун буддын лам нараар дамжин хөгжиж байна, мөн сургууль соёлын мөр хөөсөн хэдэн зуун оюутан залуусаар эрч хүчээ улам авч байна.

Энэ нь мөн 1990 оноос 2000 онд Энэтхэгийн Элчин сайдаар ажилласан Кушок Бакула Ринбүчийн үйл хэргээр үргэлжилж байна. Энэ хүний байгуулсан Бэтүб хийд бидний холбоо харилцааны мөнхийн бэлгэдэл юм.

Монгол дахь Йогийн дэлгэрэлт нь бидний оюун санаа нэгдмэл болохыг илтгэж байна.

Хагас зуун жилийн тэртээ бахархах түүхтэй, тусгаар Монгол Улсыг НҮБ-д гишүүнээр элсэх гэж хичээн чармайж байхад бид танай талд тууштай бат зогссон. Цаг хугацааны эргэлтэд Та нар маань НҮБ-д болон бусад олон газарт бидэнтэй нэг байсан.

Хүн хоорондын харилцаа ийм хүчтэй байсан ч эдийн засгийн харилцаа төдийлэн идэвхтэй байж ирсэнгүй. Гэвч шинэ эринд бидний харилцаа салбар бүрт өргөжин хөгжинө гэдэгт би огт эргэлзэхгүй байна. Энэ нь Энэтхэгийн эдийн засгийн өсөлтөөс эрч хүч авна.

Нэг жилийн өмнө манай орны 1.25 тэрбум сонгогчид хүн төрөлхтний түүхэнд хамгийн том ардчилсан сонгуульд тогтвортой байдал, өөрчлөлтийн төлөө саналаа итгэл төгс өгсөн. Амлалтаа биелүүлэхийн тулд бид хурдтай, шийдвэр төгс, зорилготой ажиллаж байна.



Жил хүрэхгүй хугацаанд манай эдийн засгийн өсөлт 7.5 хувьд хүрлээ. Энэтхэг улс том эдийн засагтай орнуудын дотор эдийн засгийн өсөлтөөрөө хамгийн хурдтай орон болж чадлаа.

Энэтхэг орны эдийн засаг үүнээс ч илүү хурдтай өсөх чадавхтай. Дэлхийн эдийн засаг сул байгаа үед түүнийг хөдөлгөөнд оруулж чадах шинэ хүч болж гялалзах од нь Энэтхэг гэж дэлхийн улс орнууд нэгэн дуугаар хэлж байна.

Энэтхэгийн нүсэр том нийгэм, эдийн засаг, тэдгээрийн олон янз байдал их сорилт бэрхшээлтэйг бид сайн ойлгож байна. Гэвч бид хүчирхэг бодлого, сайн засаглалдаа итгэл төгс байна.

Манай үндэстний нэгдмэл байдал, манай хүмүүсийн нэгдмэл зорилго бидэнд итгэл үнэмшил төрүүлж байна. Ингээд ч зогсохгүй 35-аас доош насны 800 сая залуус бүхий улам бүр залуужиж буй Энэтхэгээс хүсэл эрмэлзэл булаглан ундарч байна. Тэд мөрөөдлөө биелүүлэх, мөрөөдөлдөө хүрэх чадвартаа итгэл төгс байна.

Бид манай ард түмний амьдралыг өөрчлөхийн хамт дэлхийд шинэ боломж нээж, өөрийн найз нөхдөдөө туслах чадвараа дээшлүүлж байна.

Энэ бол Будда болон Гандийн орны чин эрмэлзэл юм аа. Энэ бол дэлхий нэг гэр бүл гэсэн манай эртний үзлээс гаралтай бидний төрөлхийн чанар юм.

Энэтхэгийн эдийн засаг манай бүс нутаг болон дэлхийд хүч нэмэхийн хамт энэ нь Монголд бас ач тусаа өгнө. Эдийн засгийн өсөлт ч бас Монголд сайн байна. Хэдийгээр бидний хооронд орон зай, газар зүйн саад байдаг ч манай хоёр талын харилцаа бас өснө. Монгол орны эрдсийн нөөц баялаг бидний түншлэлд хөдөлгөгч хүч өгнө. Газар зүйн байршил бол Монголчуудын түншүүдээ сонгох эрх чөлөөнд нь хязгаарлалт болохгүй гэж бид үзэж байна.

Бид хамтарч байж дижитал ертөнц дэх эдийн засгийн боломжуудыг ашиглах болон өсөн нэмэгдэж байгаа кибер аюул заналаас илүү найдвартай өөрсдийгөө хамгаалж чадна. Энэ өргөн уудам тал нутагт сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулж цагаан хувьсгалыг эхлүүлэхэд Энэтхэгийн туршлагыг ашиглаж болно. Монголын ноолуурын баялагт нэмүү өртөг шингээх ажлыг бид хамтдаа эндээс шууд эхэлж болно.

Монголд бид боломжийн үнэтэй эрүүл мэндийн орчин үеийн үйлчилгээг үзүүлэхэд түншлэн ажиллаж байна. Эмчилгээний нэгдсэн системтэй болгох замаар уламжлалт эмнэлгийн өвийг манай хоёр оронд болон гадны орнуудад улам хөгжүүлж бид чадна.

Энэтхэгчүүд гадагшаа их аялах боллоо. Монгол Улсад байгалийн болон оюун ухааны боломж их байна. Иймээс Монгол орон нь Энэтхэгчүүдийн зорьж ирэх орны нэг байж болно. Худалдаа болон хөрөнгө оруулалтаас илүү манай хөгжлийн түншлэл бидний хамтын үзэл санаа, зөн совинг илтгэж байдаг.

Түншлэлийн хамгийн дээд хэлбэр бол хүний нөөц, байгууллагын хөгжлийн хөрөнгө оруулалт юм. Энэ бол тухайн үндэстэнг хөгжлийнхөө төлөө хариуцлага хүлээх чадвартай болгодог. Энэ нь мөн тухайн үндэстний хийх сонголтынх нь харилцан хамаарлыг сайжруулж өгдөг. Эдгээр нь цугтаа хөгжил дэвшлийг илүү тогтвортой болгодог. Бид энэ үзэл баримтлалдаа нэн хариуцлагатай хандах болно.

Өнөөдөр би Атал Бихари Важпайн Мэдээлэл, холбооны технологийн шилдэг төвийг байгуулж, өргөжүүлэн шинэчлэх ажлынх нь шавыг тавина. Дараа нь үдээс хойш Монголд хавдрыг эмчлэхэд туслах Бхабхатрон багажийг гардуулж өгнө. Энэ бол бидний иргэний чиглэл дэх цөмийн хамтын ажиллагааны анхных нь болно. Эцэст нь нэг тэрбум америк долларын хөнгөлөлттэй зээлийг Монгол Улсын байгууллагын хөгжил, дэд бүтэц, хүний нөөцийг хөгжилд зориулж олгох болсноо миний бие өнөөдөр Монгол Улсын Ерөнхий сайдад уламжилсан.

Бидний аюулгүй хамтын ажиллагаа өсөн нэмэгдэж байна. Бие биеэсээ их зүйл сурч чадна. Юмыг сайн хийдэг монгол хүний ур чадварт хэн ч эргэлзэхгүй ээ.

Батлан хамгаалах дасгал сургуулилтыг хамтран хийж байгаадаа бид бахархаж байдаг. Хил хамгаалах, кибер аюулгүйн чиглэлд идэвхтэй хамтран ажиллах гэж байгаад би баяртай байна.

Бидний харилцааны бодит хүч нь хүмүүс хоорондын сайн санаа, орон зайн хүрээнд биднийг нэгтгэдэг итгэл үнэмшилд суурилдаг. Энэ бол тус хоёр орныг зүгээр нэг хооронд нь ойртуулахаас ч илүү ихийг хийж чадна. Энэ бол Ази, Номхон далайн бүс нутагт энх тайван, тогтвортой байдал, хөгжил цэцэглэлийг бэхжүүлж тусална.

Бурханы элч нар нэгэн цаг үед хайр энэрэл, энэрэнгүй үзэл санаагаар Ази тивийг холбож байв. Тэдний үзэл санааны үнэт зүйлс хэзээ ч ач холбогдлоо алдаагүй бөгөөд тэдний үлдээсэн ул мөр цаг хугацааны шалгуурыг даван гарчээ.

Номхон далайн эргээс Энэтхэгийн далайн төв хүртэл, Зүүн өмнөд Азийн далайн эргээс Гималайн алдарт өндөрлөг хүртэл, тропикийн их ойгоос энэ тал нутаг хүртэл Ази тивийн хаана ч миний аялсан газарт Будда Бурханд зориулсан хөшөө суварга, сүм хийд их тархжээ. Хүний амьдралын найман зам мөрийн тухай Бурхан багшийн сургаал нь зөвхөн хувь хүний аз жаргалд хүрэх замыг заах төдийгүй нийгэм, улс үндэстний сайн сайхан байдалд хүрэх гол хөтөлбөр юм.

Энэ бол бид бүгдээрээ сайхан сэтгэлтэй байж, хайр энэрлийг үзүүлж, энэрэнгүй сэтгэлтэй байх тухай үзэл юм. Энэ бол хүн төрөлхтөн, хүний эрхийг гүнээ хүндэтгэх тухай сургаал юм, энэ бол энхийг эрхэмлэж, хүч үл хэрэглэхийн тухай итгэл үнэмшил юм. Энэ зам бол манай нийгэм дэх ядуу, эмзэг бүлгийн хүмүүст хэрхэн туслах тухай сургаал юм. Ертөнц дэх бүх зүйлс хоорондоо учир холбоотой, төлөв даруу байхын мөн чанарыг илэрхийлсэн мэргэн ухаан юм. Тийм учраас ч энэ бол илүү тогтвортой дэлхийг бүтээх арга зам юм.

Хэт хэрэглээ, хүн ба байгалийн зөрчилдөөн дэлхийд аюултайг сургажээ. Хөгжсөн Баруун, ашиг орлого нь арвижин нэмэгдэж буй өсөн өндийх эрмэлзэлтэй Ази хоёр энэ сургаалыг дагаж мөрдөх ёстой. Дүгнэвээс энэ бол энх тайванч харилцааг эрхэмлэх, эрх тэгш байх, жижиг болоод том, буурай болоод хүчтэй ямар ч улс үндэстэн өөр хоорондоо харьцахдаа бие бие харилцан хүндэтгэх, хамтран ажиллах тухай удирдамж юм.

Энэ бол хувь хүмүүс, улс үндэстэн, бид бүгдээрээ хүн төрөлхтөн болон манай гарагийн төлөө нэгдмэл хариуцлага хүлээх ёстойн уриа дуудлага юм. Тиймээс энэ нь бүх үндэстний нийтлэг сайн сайхны төлөө зүтгэх урам зоригийг бидэнд өгдөг.

Бурхан Буддагийн сургаал нь ардчиллын зарчмуудад илрэлээ олдог. Үнэний зам нь сэтгэх, бодох, үйлдэх, үг хэлэх эрх чөлөөнд суурилдаг. Эдгээр нь ардчиллын суурь үндэс юм. Энэ нь харилцан хамаарал, олон янз байдал, хамтдаа оршин тогтнох явдлыг хүлээн зөвшөөрөх үзлээр тодорхойлогддог. Үүний мөн чанар нь хүний эрх чөлөө, үзэл бодлоо харилцан хуваалцах, хуульд захирагдах, ялгавартай байдлыг энхийн арга замаар шийдвэрлэх явдал юм. Тиймээс хэрвээ бид Их Мастерийн Үнэн Замыг дагах юм бол ардчиллын үнэт зүйлсээр замнахтай агаар нэгэн билээ.

Энэхүү хоёр сонгодог үзэл санааны нэгдлийг Монгол Улсаас харж байна. Ази тивд хандаж би үүнийг доорх байдлаар хэлье:

- Үндэстэн бүр Засгийн ямар ч хэлбэрийг сонгосон байсан, өөрсдийгөө Улс гэж яаж ч тодорхойлсон байсан, бид өөр хоорондоо харилцахдаа ардчиллын зарчмуудыг байнга хэрэглэх ёстой. Ямар ч замыг сонгосон байсан, бидний зөрчилдөөний түүх, эсвэл бидний хүсэлт шаардлага юу ч байсан, оюун санааны нийтлэг өв биднийг холбосон байдаг.

Буддизм болоод ардчилал нэгдмэл байх нь энх тайван, хамтын ажиллагаа, эв зохицол, эрх тэгш байдлыг Ази тивд буй болгох арга замыг бидэнд олгож байна.

Энэ бүс нутаг хувь заяаныхаа төлөө нойрноос сэржээ. Сүүлийн хагас зуун жилд ийм их хөгжил дэвшлийг дэлхий Азиас өөр бүс нутагт хараагүй юм. Нэгэн үед ийм их хэмжээний өөрчлөлт манай тивээс өөр бусад тивд болж байсангүй. Энэ бүс нутаг бол эртний мэргэн ухаан, залуулаг эрч хүчний өлгий нутаг юм.

XXI зуунд дэлхийг энэ тив тэргүүлнэ гэж үздэг. Гэвч амар хялбар бус тодорхойгүй байдал, шийдэгдээгүй асуудлууд, үл мартагдах дурсамжууд энэ бүс нутагт бас байна аа. Итгэл найдвар, боломж бололцоо нь улам бүр ихсэхийн хэрээр Азийн ялгавартай байдал нь олон янз байдлын дундаас илт товойн харагдаж байна.

Олон жилийн турш Ази тив дэлхийд их зүйл өгсөн. Ирээдүйгээ бүтээх үүрэг хариуцлага одоо энэ тивд оногдож байна. Иймээс хүний үндсэн үнэт зүйлс, хүн төрөлхтний өмнө хүлээсэн түгээмэл хариуцлагыг хүлээн зөвшөөрөх, улс үндэстний хоорондын харилцаанд ардчиллын хэм хэмжээг ашиглах явдал өмнө нь хэзээ ч байгаагүйгээр бидэнд шаардагдаж байна. Оюун санааны нийтлэг өвдөө бүгдээрээ анхаарлаа идэвхтэй хандуулъя. Ингээд Азийн ирээдүйг дархлахын тулд ардчиллын үнэт зүйлсээр хэлэлцүүлэг өрнүүлцгээе.

Нэг үед эрэлхэг зоригуур тэргүүлж байсан үндэстэн бол Монгол Улс юм. Одоо энэрэнгүй сэтгэлийн хүчээр манай тивийг тэргүүлэх ёстой. Эртний мөргөлийн замыг ойлголцол, хамтын ажиллагааны шинэ зам болгож өөрчлөхийн тулд Та нартай болон бүс нутаг дахь бусад улстай бид хамтдаа ажиллах болно. Бидний хүрэх гэж зорьж байгаа ирээдүйд энэ нь ганцаараа баталгаатай хүргэж чадахгүй гэдгийг бид мэднэ ээ. Гэхдээ энэ бол амжилт гаргах илүү боломжийг бидэнд олгох үүд хаалгыг дахин нээж байгааг би мэднэ.

Эрхэмсэг Ноён Монгол Улсын Их Хурлын дарга аа,

Энэ өглөөний мөргөлөө миний бие Махабодхи модны үндсийг Монгол Улсын Гандан хийдэд суулгаснаар эхэлсэн. Энэ бол оюун санааны нэгдмэл өвдөө миний үзүүлсэн хүндэтгэлийн бэлэг тэмдэг байлаа. Тарьсан мод маань ургаж төлжихийн хэрээр энэ нь манай хоёр орны хоорондын түншлэл өсөн бэхжих бэлэгдэл болох юм. Цаг хугацаа улирахын хэрээр энэ нь дэлхий дэх хүмүүнлэгийн бэлгэ тэмдэг, энэ гараг ертөнцөө хайрлан хамгаалахын бэлгэ тэмдэг бас байх болно. Баярласнаа дахин илэрхийлье. Баярлалаа.

Би танай парламентын танхимд орж ирээд нэгэн зүйлийг анзаарлаа. Танай Төрийн сүлдэнд бадамлянхуа цэцгийг бэлгэддэг юм байна. Манай улсад ч бас бадамлянхуаг бэлгэддэг юм. Энэ нь манай хоёр орны хооронд нийтлэг төсөөтэй олон зүйлс байдгийн нэг нотолгоо юм.

Сарвебхавантусухинах. Та бүхэнд аз жаргал хүсэн ерөөе.

\*\*\*

**Хүндэтгэлийн хуралдааныг хааж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг**

(2015.05.17)

Монгол Энэтхэгийн найрамдал хамтын ажиллагааны талаар манай ард түмэн Монгол Улсын Их Хуралд хандаж элэгсэг дотно үг хэлсэн Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Элчин сайд Нарендра Модиг танд баярлалаа. Эрхэмсэг ноён Ерөнхий сайд таны айлчлалын хүрээнд Монгол Улс Бүгд Найрамдах Энэтхэг Улс хооронд тогтоосон иж бүрэн түншлэлийн харилцааг ахиулан стратегийн түншлэлийн харилцаа тогтоох болсонд баяртай байна.

Танд Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн талархал илэрхийлж таниар уламжлан Энэтхэгийн найрсаг ард түмэнд аз жаргал сайн сайхныг хүсэн ерөөж Ноён Ерөнхий сайд таныг Монгол оронд тавтай морилохыг урьж байна.

Эрхэм хүндэт Монгол Улсын Ерөнхийлөгч өө,  
Эрхэм гишүүд ээ

Монгол Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

\* \* \*

**МОНГОЛ УЛСАД БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ ПАРЛАМЕНТЫН 25 ЖИЛИЙН ОЙД  
ЗОРИУЛАН ХИЙСЭН УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХҮНДЭТГЭЛИЙН ХУРАЛДААН**

(2015.09.13)

**Хүндэтгэлийн хуралдааныг нээж Улсын Их Хурлын дарга З.Энхболдын хэлсэн үг**

(2015.09.13)

Улсын Их Хурлын гишүүдэд, Улсын Бага Хурлын гишүүдэд, энд хуран цугларсан бүх зочид төлөөлөгчдөд энэ өдрийн мэндийг хүргэе.

Монгол Улсад байнгын ажиллагаатай парламентын 25 жилийн ойд тохиолдуулан хийж байгаа хүндэтгэлийн чуулган эхлэх гэж байна. 1990 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн өнөөдөр Улсын Бага Хурлын гишүүд тангаргаа өргөж, 25 жилийн өмнө анхны хуралдаанаа хийсэн өдөр байгаа юм. Тэгээд хүндэтгэлийн чуулган нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Ерөнхийлөгч өө,  
Монгол Улсын Ерөнхий сайд аа,  
Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,  
1990 оны Ардын Их Хурлын дарга, орлогч дарга нар аа,  
Улсын Бага Хурлын гишүүд ээ,  
Хүндэт зочид, ноёд хатагтай нар аа,

Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойн баярыг тохиолдуулан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаанд оролцож байгаа эрхэм хүндэт та бүхэнд болон Монголын ард түмэнд Монгол Улсын Их Хурлын нэрийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн халуун баярын мэнд хүргэе.

Ардын Их Хурлын анхдугаар хуралдаанаар Улсын Бага Хурлын дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга болон 50 гишүүнийг сонгон баталж 1990 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр Улсын Бага Хурлын гишүүд “Алд бие мину алжааваас алжаатугай, ахуй төр мину бүү алдартугай. Бүтэн бие мину алжааваас алжаатугай, бүрэн улс мину бүү алдартугай”

хэмээн тангараг өргөснөөр Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдаж өнөөдөр 25 дахь жилтэйгээ золгож байна.

Энэ бол монгол төрийн тогтолцооны нэгэн шинэ үеийн түүх бөгөөд өнөөдрийг хүртэл парламентын засаглал шинэ ардчилсан Үндсэн хуулиар баталгаажин эргэлт буцалтгүй төлөвшин хөгжиж байгаагийн илрэл юм. Тиймээс Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 18.1 дэх хэсгийг үндэслэн захирамж гаргаж энэхүү хүндэтгэлийн хуралдааныг зохион байгуулж байна. Хүндэтгэлийн хуралдаанд 1990 оны Ардын Их Хурлын дарга, орлогч дарга нар, Улсын Бага Хурлын гишүүд, үе үеийн Улсын Их Хурлын дарга, Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга нар оролцож байна.

### **Нэг. Монголын түүхэн дэх парламентын үүсэл хөгжил**

Өнөөгийн Монгол Улсын нутагт Хүннүгийн үеэс Богд хаант улсын үе шувтаргал хоёр мянгаад жил (МЭӨ 209 оноос 1924 он) оршин тогтнож байсан хаант улсуудад төрийн хэргийг хэлэлцэх, хааны эрх мэдлийг зарим талаар хязгаарлах, зөвлөх үүрэг бүхий байгууллагууд байсан түүхэн уламжлал байна.

Их Монгол улсын (1206 - 1368 он) Их хуралдай нь улс гүрний эзэн хааныг сонгодог, төр улсын тулгамдсан асуудлыг магадлан хэлэлцсэний үндсэн дээр хаанд зөвлөдөг байв. Дундад эртний үеийн Монголын улсуудын Хуралдай нь ард түмний дундаас сонгогдсон төлөөлөгчдийн байгууллага бус, язгуур угсаа, албан тушаалын зарчмыг баримтлан байгуулагдсан, хууль тогтоох эрх мэдлийг эдэлдэггүй зөвлөх үүрэгтэй байгууллагууд байсан байна. Харин Богд хаант Монгол Улсын (1911 - 1919) оны үед улс төрийн аливаа хэргийг бүгдээрээ нийлэн шүүмжлэн хэлэлцэж, олны бодлыг нийлүүлэх зорилго бүхий сонгодог парламентын зарим хэв шинжийг агуулсан Улсын Дээд, Доод хурлыг байгуулж байв. Улсын Их Хурал нь уламжлалын дагуу Хуралдайтай адил байгуулагдсан, сонгуулийн бус, зөвлөх эрх бүхий байсан боловч өмнөх үеэс ялгаатай нь Улсын доод хуралд язгууртан угсаагүй бичиг, цэргийн түшмэд орсон, төрийн хэргийг шийдэхэд олны саналыг авахын тулд төлөөлөгчдийн байгууллагаар хэлэлцдэг парламентад ёсыг Монголд анх нэвтрүүлж эхэлсэн онцлогтой.

1921 онд Монгол оронд ардын хувьсгал ялсны дараа төрийн шинэ тогтолцоог хэрхэн бүрдүүлэх талаар үзэл бодлын ялгаа болон олон улсын тухайн цагийн нөхцөл байдлаас шалтгаалан нэгдүгээрт, эртний төрт ёсны уламжлал дээр суурилан төрөө цаг үеийн бодит байдалд зохицуулан хөгжүүлэх; хоёрдугаарт, үндсэн хууль хаант засаг байгуулах; гуравдугаарт, социалист хэлбэрийн төр буюу пролетарын диктатур байгуулах гэсэн үндсэн сонголтуудтай тулгарсан байна. Түүхэн баримтаас үзэхэд тэр үеийн Монголын удирдагчдын ихэнх нь үндэсний ардчилсан үзлийг баримтлан, парламентад ёсыг тогтоохыг эрмэлзэж байжээ.

Монгол Улсын Их Хурал 1924 онд анхны Үндсэн хууль баталж, уг хуулиар Монгол Улсыг Бүгд Найрамдах Улс болгон тунхагласан. Анхдугаар Үндсэн хуулиар Улсын Их Хурал бол төрийн эрхийг барих дээд байгууллага бөгөөд хурлын чөлөө цагт Улсын Бага Хурал төрийн эрхийг барина гэж заасан байна. Ийнхүү парламентад ёс Монгол оронд төлөвших эхлэл тавигдсан хэдий ч тухайн цаг үеийн байдал, гадны улс орны шахалтаар хууль ёс гажуудан, Улсын Их Хурал ёс төдий байгууллага болон хувирчээ.

1940 онд батлагдсан хоёр дахь Үндсэн хууль нь нэг намыг улс төрийн тогтолцооны цөм болгон баталгаажуулсан хэдий ч ардчилсан шинжтэй зарим хэм хэмжээ, тухайлбал, төлөөллийн ардчиллын үндсэн зарчмыг хуульчилсан байдаг.

1944 онд сонгогчдын хувьд тавьж байсан элдэв хязгаарлалтыг хүчингүй болгож, сонгуулийн эрх нь хасагдсан хүмүүст сонгуулийн эрх олгож, 1949 онд сонгуулийн тогтолцоог ардчилах томоохон алхам хийж, Улсын Их Хурлын сонгуулийг шууд, тэгш, саналаа нууцаар хураах үндсэн дээр сонгуулийн тойргоор явуулж байхаар болсон нь парламентат ёсыг төлөвшүүлэх чухал алхам болжээ. Гэхдээ 1990 он хүртэл тухайн үеийн социалист системийн бусад орнуудын адилаар манай улсын Ардын Их Хурал нь сонгогдон байгуулагдах, хууль тогтоох эрх мэдлээ хэрэгжүүлэхдээ өнөөгийн ардчилсан парламент болон бүрэн төлөвшиж чадаагүй байсан.

#### **Хоёр. 1990 оны Ардчилсан хувьсгал ба парламентат ёсны төлөвшил**

1980 -аад оны сүүлч 1990 -ээд оны эхээр манай оронд өрнөсөн ардчилсан хувьсгал иргэдийн хувийн эрх, эрх чөлөөг баталгаажуулж, улс төрийн системийн ардчилсан тогтолцоо, өмчийн олон хэлбэр, зах зээлийн эдийн засгийн харилцааг бий болгосон юм. 1990 оны 5 дугаар сард БНМАУ-ын Ардын Их Хурлын чуулганаар “БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай” хуулийг баталж, төрийн эрх барих байгууллагыг шинэчлэхдээ нам, төрийн үүргийг зааглах, улс төрийн тогтолцооны гол цөм нь төр байх, парламентын нэгдмэл тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх, ардчиллыг хөгжүүлэх бодлогыг баримталсан байна. Ингэхдээ төрийн эрх барих уламжлалт дээд байгууллага-Ардын Их Хурал, парламентат ёсны шинэ байгууллага-Улсын Бага Хурал, төрийн тэргүүн-Ерөнхийлөгчийн институцийг бий болгож, тэдгээрийн хоорондын эрх мэдлийн харилцан хамаарал, тэнцлийг зөв тогтооход голлон анхаарсан байдаг.

Монгол оронд 1990 оны 7 дугаар сарын 29-нд анх удаа олон намын оролцоотой, нэг тойрогт олон нэр дэвшигч бүхий сонгууль явагдаж, парламентат ёсны шинэ төрийн эрх барих байнгын дээд байгууллага болох Улсын Бага Хурлыг улс төрийн намуудын төлөө сонгогчдын өгсөн саналыг үндэслэн бүрдүүлж, МАХН 33, Монголын Ардчилсан Нам 13, Монголын Социал - Демократ Нам 4, Монголын Үндэсний Дэвшлийн Нам 3 суудалтайгаар Улсын Бага Хурлыг байгуулжээ. Ийнхүү Монгол Улсад ард иргэдийн шууд оролцоотой төртэй байх бололцоо анх удаа бүрдсэн байна.

1990-1992 он бол Монгол Улсын хувьд улс төр, эдийн засаг, нийгмийн байгууллыг шинэчлэх Үндсэн хуулийн шилжилтийн үе байлаа. Энэ шилжилтийн үеийн парламентат ёсны тогтолцоонд Ардын Их Хурлаас байгуулагдсан Улсын Бага Хурал хууль тогтоох, хянан шалгах, зохион байгуулах бүрэн эрх бүхий төрийн эрх барих дээд байгууллагын хувьд Монгол Улсад байнгын ажиллагаатай парламентат ёсыг жинхэнэ утгаар нь бүрдүүлэн тогтоох үндэс суурийг тавихад чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Улсын Бага Хурал 2 жил хүрэхгүй хугацаанд ажиллахдаа шинэ нийгмийн харилцааны эрх зүйн үндсийг тогтоож олон хууль, тогтоол, олон улсын гэрээ хэлцлийг баталж Ардын Их Хурлаас даалгасны дагуу Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн төслийг хүн төрөлхтний түгээмэл үнэт зүйлсийн зарчмуудад тулгуурлан боловсруулж, өргөн барьсан нь Улсын Бага Хурал түүний гишүүд, Тамгын газрын ажилтнуудын Монгол Улсын түүхэнд оруулсан үнэлж баршгүй гавьяа мөн.

Улсын Бага Хурлаас өргөн барьсан шинэ Үндсэн хуулийн төслийг Ардын Их Хурлын депутатууд нойр хоолоо умартан 76 хоног өдөр, шөнийг үл харгалзан мэтгэлцэж 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр баталснаар Монгол Улс ардчиллын замаар эргэлтгүй замнасан, парламентын засаглалтай Бүгд Найрамдах Улс болсон юм.

Шинэ Үндсэн хуулиар төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг тэнцвэржүүлэн хуваарилж, парламентыг нэг танхимтай, 76 гишүүнтэй байхаар тогтоон, үйл ажиллагааных



нь эрх зүйн үндсийг тодорхойлж, “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална” гэж заасан байна.

Улсын Их Хурал хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ төрийн гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн байгууллагуудын зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, хууль тогтоох бүрэн эрхийнхээ хүрээнд хууль санаачлах эрх бүхий субъектүүд болох Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын өргөн барьсан хуулийн төсөл, улс орны нийгэм, эдийн засаг, төрийн байгууллагын бүхий л асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсээр ирлээ. Шинэ Үндсэн хууль үйлчилж эхэлснээс хойш 1992, 1996, 2000, 2004, 2008, 2012 онд нийт зургаан удаа парламентын сонгууль болж төрийн эрх барих төлөөллийн дээд байгууллага болох Улсын Их Хурлыг байгууллаа.

Монгол Улсын хувьд 1990-1992 онд байгуулагдсан анхны байнгын ажиллагаатай парламент болох Улсын Бага Хурал нь уламжлалт тогтолцоог халж парламентад ёсыг жинхэнэ утгаар шилжих замыг туулсан бол 1992 онд байгуулагдсан Улсын Их Хурал хууль тогтоох эрх мэдлийг дангаар хадгалсан, ард түмний сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөллийн байгууллага болсноор Монгол Улс дахь парламентад ёсны хөгжлийн төлөвшил дараагийн шатандаа орсон гэж үзэж болно.

Монгол Улсын парламентад ёсны хөгжил нь нэгд, парламентын хэлбэр, дотоод болон үндсэн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа нь улам боловсронгуй болсноор, хоёрт, парламентыг бүрдүүлэх, түүний үйл ажиллагаанд олон түмний хяналт оролцоо идэвхжиж байгаагаар, гуравт, парламент өөрийн зорилго, мөн чанараараа улам бүр төгөлдөршиж байгаагаар тодорхойлогдож байна.

Улсын Их Хурлын сонгууль 1992 онд олон мандаттай, томсгосон 26 тойргоос 76 гишүүнийг мажоритар тогтолцоогоор, 1996, 2000, 2004 онд нэг мандаттай 76 тойрогт мажоритар тогтолцоогоор, 2008 онд олон мандаттай, томсгосон 26 тойргоос 76 гишүүнийг мажоритар тогтолцоогоор, 2012 онд Улсын Их Хурлын 76 гишүүний нь мандатын зарчмаар 26 тойргоос шууд мажоритар, үлдсэн 28 нь пропорциональ тогтолцоогоор явагдсан байна. 2012 оны Монгол Улсын Их Хурлын зургаа дахь удаагийн ээлжит сонгуулийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуультай хамтатган явуулж, гадаадад байгаа сонгогчдыг оролцуулан сонгуулийн санал авах, тоолох, дүн гаргах болон сонгогчийн бүртгэл, хяналтын үйл ажиллагааг Монгол Улс анх удаа автоматжуулсан системээр зохион байгуулснаараа онцлогтой.

Сонгуулийн үр дүнгээр 1992, 2000 онд МАХН, 1996 онд МҮАН-МСДН-ын “Ардчилсан холбоо” эвсэл дангаараа, 2004 онд МАХН-“Эх орон-Ардчилал” эвсэл, 2008 онд МАХН- Ардчилсан Нам хамтарч Засгийн газраа байгуулсан бол 2012 онд олон суудал авсан Ардчилсан Нам “МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвсэл, Иргэний Зориг-Ногоон намтай хамтарсан Засгийн газар байгуулан ажиллаж байна. Намуудын нэр тухайн үеийнхээ нэрээрээ явж байгааг хэлье.

Ард түмний сонгосон үе үеийн Улсын Их Хурал ардчилсан төрийн тогтолцоог хөгжүүлэн, төрийн эрх мэдлийн хуваарилалтын механизмыг зүгшрүүлэх, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилтуудыг тодорхойлж хэрэгжүүлэх түүхэн томоохон алхмуудыг хийсэн байна.

2012 оны сонгуулийн үр дүнд байгуулагдсан парламент нь хамгийн олон намын төлөөлөлтэй, гурван намын бүлэгтэй, тэдгээрийг төлөөлсөн Улсын Их Хурлын гурван дэд даргатай, хамгийн олон эмэгтэй гишүүдтэй гэдгээрээ онцлогтой юм. Энэ удаагийн Улсын Их Хурлаар Шүүх, цагдаагийн тухай, Захиргааны тухай, Хөрөнгө

оруулалтын тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай, Шилэн дансны тухай, Үйлдвэрлэлийг дэмжих тухай, Ашигт малтмалын тухай, Өрийн удирдлагын тухай, Чөлөөт бүсийн тухай, Эдийн засгийн ил тод байдлын тухай, Нийгмийн хамгаалал, тэтгэвэр тэтгэмжийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай, Өршөөл үзүүлэх тухай зэрэг эрх зүй, эдийн засгийн, нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхтэй холбогдсон онцгой ач холбогдол бүхий олон хуулиуд батлаад байна.

Улсын Их Хурал анх удаагаа олон жил алдагдалтай явж ирсэн, өөрсдийгөө хуурсан төсвөөс татгалзаж, төсвийн сахилга батыг чангатгаж бодитой төлөвлөх тогтолцоог мөрдүүлж, аж үйлдвэр, эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлогыг баталсан. Улсын Их Хурал “Чингис” бондыг босгосноор авто зам, төмөр зам, үйлдвэрлэл, уул уурхай, цахилгаан станц, агаарын тээвэр, дэд бүтэц, орон сууц, жижиг дунд үйлдвэрлэлийн салбарт томоохон бүтээн байгуулалт хийгдэж байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын 10 саяын босгыг 50 сая төгрөг болгон нэмэгдүүлж, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч иргэнд худалдан авалтандаа төлсөн НӨАТ-ын 2 хүртэл хувийг буцаан олгохоор боллоо. Олон чухал зээлийн хэлэлцээр, төсөл хөтөлбөрийг баталсны дотор Монгол Улс, Япон Улсын хооронд байгуулсан “Эдийн засгийн түншлэлийн тухай хэлэлцээр”-ийг Улсын Их Хурал соёрхон баталснаар аж үйлдвэрийн салбарын нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлж, валютын орлогыг нэмэгдүүлэх үндэс тавигдаж байна. Улсын Их Хурлын гишүүний болон парламентын олонх, цөөнхийн эрх зүйн байдал, тэдгээрийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, гишүүдэд тавих ёс зүйн шаардлагыг өндөржүүлэх, хуулийн төсөл боловсруулах, санаачлах, хэлэлцэх зэрэг хууль тогтоох үйл явцын үндэслэл, журмыг Улсын Их Хурал бүх л үйл ажиллагааныхаа явцад боловсронгуй болгож, улс орны өмнө тулгарсан төрийн байгуулалт, улс төр, нийгэм, эдийн засгийн асуудлыг шийдвэрлэхийн хэрээр Монголын парламент өөрөө хөгжин төлөвшиж байна.

#### **Гурав. Монголын парламентын төлөвшлийг гүнзгийрүүлэх нь**

Эрхэм гишүүд ээ,

Улсын Бага Хурал болон 6 удаагийн парламент 25 жилд Анхдугаар хуралдааныг 6 удаа, ээлжит хуралдааныг 47 удаа, ээлжит бус чуулганыг 12 удаа, хүндэтгэлийн хуралдааныг 22 удаа хийж бие даасан хууль 454, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2209, гэрээ соёрхон баталсан, нэгдэн орсон тухай хууль 330, хууль хүчингүй болсон тухай хууль 145, Улсын Бага Хурлын тогтоол 167, Улсын Их Хурлын тогтоол 1779, нийт 5084 хууль, тогтоол хэлэлцэж баталжээ. Өнгөрсөн хугацаанд байнгын ажиллагаатай парламентад Төрийн байгуулалтын, Хууль зүйн, Эдийн засгийн, Нийгмийн бодлогын зэрэг давхардсан тоогоор 31 Байнгын хороо, Хүний эрхийн, Аюулгүй байдлын, Нутгийн өөрийн удирдлагын, Ёс зүйн, Төсвийн зарлагын, Тусгай хяналтын, Төсвийн зарлагын хяналтын, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын зэрэг давхардсан тоогоор 15 дэд хороо, Ажлын байр бий болгох үндэсний хөтөлбөрийг боловсруулах, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, Орон нутгийн бие даасан байдлыг хангах, төвлөрлийг сааруулах зэрэг асуудлаар 7 түр хороо байгуулагдан ажиллаж ирсэн байна.

Монголын парламент ерөнхийлөгчийн сонгуулийг 6 удаа зарлан зохион байгуулж ард түмнээсээ сонгогдсон Пунсалмаагийн Очирбат, Нацагийн Багабанди, Намбарын Энхбаяр, Цахиагийн Элбэгдорж нарын Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг баталгаажууллаа. Улсын Их Хурлын чуулганд Монгол Улсын Ерөнхийлөгч Очирбат 12 удаа, Багабанди 21 удаа, Энхбаяр 17 удаа, Элбэгдорж 11 удаа үг хэлсэн байна.

Улсын Бага Хурал болон 6 удаагийн парламентад давхардсан бус тоогоор 326 хүн, давхардсан тоогоор 534 хүн гишүүнээр сонгогдон ажилласны дотор 7 удаа сонгогдсон гишүүн 2, 6 удаа сонгогдсон гишүүн 2, 5 удаа сонгогдсон гишүүн 4, 4 удаа сонгогдсон гишүүн 14, 3 удаа сонгогдсон гишүүн 30, 2 удаа сонгогдсон гишүүн 68, 1 удаа сонгогдсон гишүүн 206 байна.

Улсын Бага Хурал болон 6 удаагийн Улсын Их Хуралд сонгогдсон хүний 321 буюу 98,5 нь дээд боловсролтой, 2 буюу 0,6 хувь нь тусгай дунд боловсролтой, 3 буюу 0,9 хувь нь бүрэн дунд боловсролтой, 27 буюу 8,3 хувь нь эмэгтэйчүүд байна. Насны хувьд гишүүдийн 19,6 хувь нь 25-35 насны, 47,0 хувь нь 36-45 насны, 33,4 хувь нь 46-аас дээш насны, мэргэжлийн хувьд 20,8 хувь нь эдийн засагч, 12,6 хувь нь багш, 28,5 хувь нь инженер, 13,2 хувь нь хуульч, 2,8 хувь нь сэтгүүлч, 0,6 хувь нь малчин, 21,5 хувь нь бусад мэргэжлийн хүмүүс байна. Эрхэлж буй ажлын хувьд, Улсын Их Хурлын гишүүдийн дотор Засгийн газрын гишүүнээр ажиллаж байсан 83, төр, захиргааны байгууллагад ажиллаж байсан 195, нам, олон нийтийн байгууллагад ажиллаж байсан 62, бизнес эрхэлж байсан 66 хүн байгаагийн дотор эрдмийн зэрэг, цолтой 97 хүн байна. Өнгөрсөн 25 жилд Улсын Их Хурлын бүрэлдэхүүнээс Улсын Их Хурлын гишүүн Бат-Үүл Монгол Улсын баатар, Улсын Бага Хурлын гишүүн Г.Лхагважав, Улсын Их Хурлын гишүүн Р.Раш, Улсын Бага Хурлын нарийн бичгийн дарга, гавьяат хуульч Б.Чимид нар Хөдөлмөрийн баатар цол хүртэж, 59 хүн гавьяат цол хүртжээ.

Парламентын гадаад харилцаа тасралтгүй өргөжиж, өнгөрсөн хугацаанд 40 гаруй орны парламенттай хамтран ажиллаж Монгол Улсын парламентын спикер давхардсан тоогоор 67 оронд айлчилж, 73 орны парламентын спикер Монгол Улсад айлчилсан байна. Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаанд Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгч Н.А.Назарбаев, Америкийн Нэгдсэн Улсын Төрийн нарийн бичгийн дарга Мадлен Олбрайт, Бүгд Найрамдах Солонгос Улсын Ерөнхийлөгч Ким Дэ Жун, Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч В.В.Путин, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Кофи Аннан, БНХАУ-ын дарга Ху Жинтао, АНУ-ын Ерөнхийлөгч Жорж Буш, ХБНГУ-ын Канцлер Ангела Меркель, Канад Улсын Амбан захирагч Дэвид Жонстон, БНХАУ-ын дарга Си Зиньпин, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Ерөнхий сайд Нарендра Моди зэрэг 11 орны төрийн тэргүүн, төлөөлөгчид үг хэлсэн байна.

Улсын Бага Хурал болон Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргаар Бяраагийн Чимид, Н.Ринчиндорж, Л.Цог, Б.Энэбиш, Д.Батбаатар, Н.Лувсанжав, Д.Сандаг-Очир, Ц.Шаравдорж, Б.Болдбаатар нарын 9 хүн томилогдож, Тамгын газарт давхардсан тоогоор 920 орчим хүн ажиллаж хууль тогтоолыг хэлэлцүүлэх, хуралдааныг зохион байгуулах, судалгаа шинжилгээ, мониторинг хийх зэрэг нөр их ажлыг гүйцэтгэж ирлээ.

Тамгын газраас парламентын үйл ажиллагааг ард түмэндээ нээлттэй, ил тод байлгах арга хэмжээг тасралтгүй авч хэрэгжүүлж ирсэн бөгөөд зөвхөн сүүлийн 5 жилийн судалгаагаар Монголоос 248500 хүн, гадаадаас 2000 гаруй хүн Улсын Их Хурлын үйл ажиллагаатай биечлэн танилцсан байна.

Парламентын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах талаар олон арга хэмжээ авсан бөгөөд сүүлийн 3 жилд мэдээллийн технологийн чиглэлээр Улсын Их Хурлын даргын уриалгыг дэмжин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан болон Байнгын хороодын хуралдааны цахим систем, парламентын сэтгүүлчдийн өрөөг шинэчлэн тоон системийн тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглож, 21 аймгийн Иргэний танхимуудыг Төрийн ордонтой холбосон дүрст хурлын систем байгуулж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааныг кабелийн болон өргөн нэвтрүүлгийн 6 телевиз, [www.parliament.mn](http://www.parliament.mn) цахим хуудсаар шууд дамжуулах, Байнгын хороодын хуралдааныг Улсын Их Хурлын гишүүдийн албан өрөөнд шууд дамжуулах дотоод сувгийн үйлчилгээ нээх, цахим сүлжээг өргөтгөх, “Төрийн

мэдээлэл” эмхэтгэлийн цахим хувилбарыг нийтэд үнэ төлбөргүй түгээх зэргээр хууль тогтоох ажиллагааны ил тод байдлыг хангаж байна.

Энэ удаагийн Улсын Их Хурал хууль тогтоох, хуулийн биелэлтийг хянан шалгахдаа иргэдийн оролцоог бодитой хангах чиглэлийг баримтлан ажиллаж байна. Энэ зорилтын хүрээнд Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр шууд дамжуулан, гишүүдийн ирц, Улсын Их Хуралд өргөн барьсан хууль тогтоомжийн төслийг нийтэд ил болгон саналаа өгөх боломжоор хангах, гаргасан хууль тогтоомжийг төрийн байгууллага, иргэдэд сурталчлах чиглэлээр “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийг үнэгүй тараах, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоолын талаар төрөл бүрийн телевизийн нэвтрүүлэг, ном товхимол зэрэг сурталчилгааны материалыг бэлдэн нийтэд хүргэх, иргэдийн үзэл бодол, саналыг үйл ажиллагаандаа тусгах Улсын Их Хурлын нээлттэй сонсголын танхимыг байгуулан, Нийтийн сонсголын тухай хуулийг батлан хуулийн хэрэгжилтэд хяналт тавих замаар иргэд, сонгогчдод хууль тогтоогчдын үйл ажиллагаанд хяналт тавих боломжийг илүү нээлттэй болголоо. Ингэснээр ард түмэн засгийн эрхийг жинхэнэ утгаараа барих боломжийг энэ бүрэн эрхийн хугацаанд улам бүр нээж өгч байна.

Парламентат ёс, парламент судлал, Үндсэн хуулийн эрх зүй, үндэсний эрх зүйн тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр үнэ цэнэтэй томоохон бүтээл туурвисан эрдэмтэн, судлаачдыг хөхиүлэн дэмжих зорилгоор Улсын Их Хурлын даргын захирамжаар 2014 онд төр нийгмийн нэрт зүтгэлтэн, Үндсэн хуулийн эх баригч, Монгол Улсын хөдөлмөрийн баатар, Ардын багш, гавьяат хуульч Бяраагийн Чимидийн нэрэмжит шагналыг бий болгож, анхны шагналыг Улсын Их Хурлын гишүүн, доктор, профессор Данзангийн Лүндээжанцан хүртсэн байна.

Эрхэм гишүүд ээ,

25 жилийн түүхурт биш гэлээ ч цаашид парламентын сонгодог жишгийг улам гүнзгийрүүлэх нь Үндсэн хуулийн болон бусад эрх зүйн орчинд улам боловсронгуй болгох шаардлага гарсаар байна. Бид дараах асуудалд анхаарлаа хандуулах нь нэн чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Нэгдүгээрт, Монгол Улсын ардчилсан шинэ Үндсэн хуулиа батлан мөрдсөнөөс хойш 23 жил болж байна. Шинэ Үндсэн хуулийг мөрдөж ирсэн хорь гаруй жилийн туршлага нь манай орны улс төр, эдийн засаг, нийгмийн салбарт зарчмын шинжтэй олон шинэтгэлийг бий болгосон нь маргаангүй үнэн. Үүний зэрэгцээ Үндсэн хуулийн шинэтгэлийг хэрэгжүүлэх явцад амьдралаас урган гарсан олон сорилтыг даван туулах шаардлага гарч, тэдгээрийг шийдвэрлэх явцад алдаа оноо аль аль нь гарч байсан гэдгийг үгүйсгэх аргагүй. 2000 онд Улсын Их Хурлаас Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт өнөө хүртэл маргаан мэтгэлцээн дагуулж байгааг та бүхэн мэдэж байгаа. Өнөөдөр ч Үндсэн хуулийг боловсронгуй болгох санал, санаачилга ард иргэдээс ч, хууль тогтоогчдын зүгээс ч гарсаар байна. Гэхдээ Үндсэн хуульд өөрчлөлт оруулах гэсэн санал, санаачилга бүрийг хүлээн авч Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулах гээд байх нь тийм ч хүсэх зүйл биш юм. Улсын Их Хурал 2010 онд “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай” хуулийг баталж, Монгол Улсын Үндсэн хуулийн амин сүнс болсон үндсэн бүтэц, суурь үзэл баримтлал, зарчмыг өөрчлөхийг хязгаарласан.

2013 оны 2 дугаар сард Улсын Их Хурлын даргын захирамжаар Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсэх асуудлыг судлах ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, энэхүү ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн 2015 оны 01 дүгээр сард Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг шинээр томилон ажиллуулж байна. Миний бие Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг боловсруулахад иргэд, иргэний нийгмийн байгууллага, улс төрийн намуудын

оролцоог жигд хангаж, боловсруулалтын шатнаасаа эхлэн нийтэд ил тод байж, зөвлөлдөх ардчиллын зарчимд нийцсэн байх учиртай гэж боддог.

Хоёрдугаарт, Монгол Улсын Их Хурал улс орны хэтийн хөгжлийн чиг хандлагад ихээхэн анхаарч 1996, 2007 онуудад урт хугацааны хөгжлийн хөтөлбөрүүдийг боловсруулах батлах оролдлого хийж байсан ч уг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаандаа мөрдөх асуудал хангалтгүй явж ирсэн. Улсын Их Хурлын даргын захирамжаар Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичгийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллуулж байна. Энэхүү баримт бичгийг ул үндэстэй олон жилийн настай байхаар боловсруулж энэ парламентаар батлах нь чухал байна. Тогтвортой мөрдөгдөх урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх асуудлаар улс төрийн намууд сонгуульд өрсөлддөг. Парламентаас баталсан Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн хөтөлбөрүүдтэй нийцүүлэн баталдаг болох хэрэгтэй байна. Засгийн газрын хөтөлбөр нь түүнд нийцдэг байх нь хөгжлийн бодлого тасралтгүй, уламжлагдан хэрэгжих нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна. Цаашлаад энэ нь улс төрийн намуудын төлөвшил, Засгийн газрын тогтвортой байдалд ч сайнаар нөлөөлнө гэж бодож байна.

Гуравдугаарт, хуулийн биелэлтийг хянан шалгах нь Улсын Их Хуралд Үндсэн хуулиар олгогдсон чухал бүрэн эрхийн нэг. Парламентын хяналт шалгалт гэдэг нь юуны өмнө парламентаас Засгийн газрын үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт бөгөөд энэ чиг үүргийг хэрэгжүүлэх тогтолцоог цаашид төгөлдөржүүлэх шаардлага тулгарч байна. Улсын Их Хурал баталсан хуулийнхаа хэрэгжилтийг Засгийн газарт даатгаад зөнд нь орхих бус, харин Үндсэн хуулиар олгогдсон хянан шалгах бүрэн эрхийнхээ хүрээнд хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн талаарх Засгийн газрын гишүүдийн тайланг ажил хэрэгчээр авч хэлэлцдэг байх, түүнчлэн өөрөө болон Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагаар дамжуулан хуулийн биелэлтийг хянан шалгаж байгаа ажлын үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

Дөрөвдүгээрт, Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнууд төсөв хэлэлцэх, төсвийн хэрэгжилт, төсвийн гүйцэтгэлд хяналт тавих чадавхыг сайжруулахад ихээхэн анхаарах болсон байна. Парламентын хууль тогтоох эрхмэдлийн хүрээнд төсвийн тухай хууль, төсвийн гүйцэтгэлийг батлах тухай хуулийг тусгай дэгийн дагуу баталдаг нь уг асуудалд улс орнуудын парламент онцгойлон ач холбогдол өгдөгийн илрэл юм. Төсвийн төслийг парламентаар хэлэлцэх, батлах, төсвийн гүйцэтгэлд хяналт тавих бүх процессыг парламентын үйл ажиллагааны жилийн турш тасралтгүй үргэлжлэх нэгэн гол чиглэл болгон хэвшүүлэх хэрэгтэй байна. Хууль тогтоох байгууллагын зүгээс шаардлагатай бол өргөн барьсан төсвийн төсөлд өөрчлөлт оруулах, эрх бүхий зарим байгууллагыг төсвийн хувьд Засгийн газраас хараат бус байлгах, улс орныхоо хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлд нийцүүлэх үүднээс төсвийн төсөлд дүн шинжилгээ хийх, төсвийн судалгаа шинжилгээ болон хэлэлцүүлэгт бэлтгэх үйл ажиллагаа, төсөв батлагдсаны дараах хяналт шинжилгээ зэрэг функциональ үйл ажиллагаануудыг тодорхой бүтцийн нэгжүүдээр дамжуулан хэрэгжүүлдэг болоход анхаарах хэрэгтэй байна.

Тавдугаарт, Сонгуулийн тухай болон Улс төрийн намын тухай хуулийн төслүүдийг энэ чуулганаар хэлэлцэж батлах нь улс төрийн энэ гэдэг нь намрын чуулганыг хэлж байна. Улс төрийн чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Эдгээр багц хуулиудын үзэл баримтлалыг намууд харилцан зөвшилцсөн тохиолдолд тийм ч олон өөрчлөлт орохгүй. Ялангуяа Сонгуулийн хууль нь аль болохоор тогтвортой мөрдөгдөх нь төрийн тогтвортой байдалд ч чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Зургаадугаарт, Монгол Улсад парламентат ёсыг хөгжүүлэн төгөлдөржүүлэх нь үе үеийн Улсын Их Хурлын байнгын анхааралд байж ирсэн, цаашид ч байх ёстой юм. Улсын Их Хурлын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, парламент хоорондын харилцааг хөгжүүлж, бусдын сайн туршлагыг нэвтрүүлэх нь хууль тогтоогчид бидний нэг чухал зорилт байх болно. Байнгын ажиллагаатай парламентын 25 жилийн ойг тэмдэглэх арга хэмжээний хүрээнд эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, парламентат ёсны хөгжлийн ололт, сургамж, цаашдын зорилтын талаар хэлэлцүүлсэн.

Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагааг боловсронгуй болгож, төсөв санхүү, зохион байгуулалтын хувьд бэхжүүлэх нь парламентат ёсны хөгжлийн салшгүй нэг чиглэл юм. Энэ дашрамд парламентат ёсны хөгжилд үнэтэй дэмжлэг, туслалцаа үзүүлж байгаа Монгол Улс дахь дипломат төлөөлөгчдийн газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, бидэнтэй хамтран ажиллаж байгаа бусад олон улсын байгууллагуудад талархал илэрхийлье.

Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент үүсэн байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан та бүхэнд дахин талархал илэрхийлж байна.

\* \* \*

**Хүндэтгэлийн хуралдаан дээр Монгол Улсын Ерөнхийлөгч Ц. Элбэгдоржийн хэлсэн үг**  
(2015.09.13)

Эрхэм хүндэт ард иргэд ээ,  
Эрхэм хүндэт Улсын Их Хурлын дарга,  
Ерөнхий сайд, эрхэм гишүүд ээ,  
Элчин сайдууд, дипломат төлөөлөгчийн тэргүүн нар аа,  
Хатагтай ноёд оо.

Өнөөдөр бид Монгол Улсад бий болсон байнгын ажиллагаатай парламентын 25 жилийн ойг тэмдэглэж Улсын Их Хурлын хүндэтгэлийн чуулган хийж байна. Сая Улсын Их Хурлын дарга энэ 25 жилд ямар ч байсан парламентын тухай, парламентат ёсны тухай, байнгын ажиллагаатай парламентуудын үйл ажиллагааны тухай ярьсан учраас үүнийг давтах хэрэггүй гэж бодож байгаа. Мөн Улсын Бага Хурлын дарга, эрхэм гишүүн Гончигдорж бас миний дараа үг хэлэх учраас Бага Хурлын үйл ажиллагааны тухай дэлгэрүүлэн энд ярих хэрэггүй болов уу гэж ингэж бодож байгаа юм.

Бид нар 5 жилийн өмнө Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент бий болсны 20 жилийн ойг тэмдэглэж бас явж ирсэн үйл ажиллагаандаа үнэлэлт дүгнэлт өгч, цаашаа юу хийх вэ гэдэг талаараа ярилцаж байсныг тод санаж байна. Тэр ойн хуралдаан дээр, тэр хүндэтгэлийн хуралдаан дээр би дэлгэрэнгүй үг хэлж байсан. Тэнд хэлж ярьж байсан олон зүйлүүд өнөөдөр ч гэсэн ач холбогдлоо алдаагүй байгааг энд тэмдэглэн хэлэх нь зөв байх гэж бодож байна.

1990 оны 7 дугаар сарын 29-нд болсон анхны ардчилсан олон намын оролцоотой сонгуулиар бүрэлдсэн Ардын Их Хурлаас Улсын Бага Хурлыг байгуулж, Улсын Бага Хурлын хуралдаан яг өнөөдөр энд эхэлж байсныг сайн санаж байна.

Тэр үед Улсын Бага Хурлын гишүүнээр ажиллаж байсан Маам гуай бид хоёрын хувьд Улсын Бага Хурлын гишүүдийн тангараг өргөх, ямар тангаргаар тангараг өргөж Улсын Бага Хурал ажилдаа орох вэ гэдгийг тэр тангаргийн үгийг бэлдэх ийм үүрэг авч байсан. Тэгээд олон янзаар оролдсон боловч үнэхээр Эзэн Чингис хааны хэлсэн тэр алд бие минь алжааваас алжаатугай, ахуй төр минь бүү алдартугай гэсэн тэр агуу үгнээс өөр үг олж чадаагүй. Ийм



үгээр Монгол Улсад анхны байнгын ажиллагаатай парламентын гишүүд үйл ажиллагаагаа эхэлж байсан юм гэдгийг энд давтан хэлье гэж ингэж бодож байна.

1990 оны 7 дугаар сарын 29 -ны сонгууль болж 7 дугаар сарын 30 болоход Монголын ард түмэн жинхэнэ ёсоор эрхээ эдэллээ, сонголтоо хийлээ гэж бид бүгд баярлаж байсан. Тэр үед ардчилсан хүчний төлөөлөл ялагдсан. Одоогоор нэлээн өндөр ялагдлыг хүлээсэн. Гэвч маш их баярлаж байсан. Ер нь сонгуульд ялагдаад сонгуульд оролцсон нам, сонгуульд оролцсон хүчин, тэр хүмүүс баярлаж байсан. Тэгэхэд чин сэтгэлээсээ баярласан түүх тэр 1990 оны 7 дугаар сарын 30 -ны өглөө байх гэж би боддог юм. Үнэхээр монголчууд яллаа, монголчууд өөрсдийн төр засгаа сонгон байгуулдаг боллоо гэж бид тэр үед нүдэндээ нулимстай баярлаж байсан. Тэр үед дангаараа төр барьж байсан Монгол ардын хувьсгалт нам ч гэсэн цаашаа дангаараа төр барихгүй, бусад намтай төрийн эрхийг хамтарч харилцаж эрх баригч сөрөг хүчин гэдэг байдлаар барьж явах ийм байдал руу орж байсан юм. Тэр үед Монгол ардын хувьсгалт намын гишүүд ч гэсэн тийм байдал руу орж байгаадаа нэг их гуньж гутарсан зүйл байхгүй. Ер нь ингэж явах нь зүйтэй юм байна гэсэн ийм ойлголтоор хоёр талаасаа нийлж нэгдэж ажиллаж байсан юм.

Одоо эргээд Улсын Бага Хурлыг бодоход монголд бий болсон, ажиллаж байсан, одоо ажиллаж байгаа байнгын ажиллагаатай парламентын бүрэлдэхүүнүүдээс онцлог зүйл байдаг. Нэгдүгээрт, тэр Улсын Бага Хурлын бүрэлдэхүүн асар их ёс зүйтэй бүрэлдэхүүн байжээ гэж ингэж боддог. Ёс зүйтэй байсан учраас ард иргэдийнхээ хүндэтгэлийг хүлээсэн, итгэлийг хүлээсэн ийм бүрэлдэхүүн байж чадсан. Нэгэнт ард иргэдийнхээ итгэл хүндэтгэлийг хүлээж байгаа учраас асар бүтээлч байж чадсан. Бүтэн 2 жил ч ажиллаагүй шүү дээ. 1990 оны 9 сард ирж цуглаад 1992 оны 6 сард ажлаа хүлээлгэж өгч байсан. 21 сар ажилласан байдаг. Тэгээд 21 сарын хугацаанд Монгол Улсын монголчуудын олон зуун жилд бодож зүтгэж явсан тэр эрх зүйт төр, монголчууд өөрөө өөрсдийнхөө бодлогыг тодорхойлоод явах тэр боломжийн бодлогын үндэс суурийг тавьж чадсанаараа гайхамшигтай парламент байжээ гэж ингэж боддог.

Анх Улсын Бага Хуралд орж ирж ажиллаж байсан хүмүүс тэр бүр өөрийнхөө хүсэл зоригоор орж ирж ажиллаагүй. Би хувьдаа Улсын Бага Хурлын гишүүн болмооргүй байна, саарал ордонд очиж суумааргүй байна гэж нөхдөдөө хэлж зугтаж байсан. Тэгэхэд санал хураагаад чи орж сууна, чи орж ажиллана Бага Хурлын гишүүн болно. Тэр үед энэ ордонд орж ирж ажиллана гэвэл бол эрх ямба юм байна гэж бодож зугтаж байсан. Дараа нь орж ирж ажиллаад энэ бол эрх үүрэг юм байна. Энэ бол хариуцлага юм байна шүү дээ. Энэ бол ачаа юм байна, ардчилсан орны парламентын гишүүн гэдэг бол тухайн улс орныхоо ард иргэдийн өмнө ачаа үүрдэг юм байна, ёс зүйтэй байх ёстой юм байна, хариуцлагатай байх ёстой юм байна гэдгийг би хувьдаа улмаар ухаарч байсан. Ингэж л бид ажиллаж ирсэн юм гэдгийг хэлье гэж бодож байна.

Манай Улсын Бага Хурлын гишүүнээр ажиллаж байсан хүмүүсийн төлөөлөл өнөөдөр энд орж ирээд ихэнх нь суусан байна. Тэгээд энэ хүмүүсийг харж байхад ер нь Улсын Бага Хурлын бүрэлдэхүүн гэдэг бие биедээ татагдсан тэр дурсамжаа ярьж ойрхон байхыг боддог. Би парламентын бүрэлдэхүүнд 4 удаа сонгогдож байсан. Тэгэхэд Улсын Бага Хурлын гишүүдийн байдал арай өөр онцлог байдаг. Ямар учраас ийм байдаг юм бол гэж бодохоор үзэл санаанд тулгуурласан асар их үүрэг хариуцлагаа ухамсарласан тийм ачаа үүрч явсан бүрэлдэхүүн насан туршдаа ийм ойрхон байдаг юм байна л даа. Тэр үзэл санаандаа үнэнч байдаг юм байна.

Улсын Бага Хурлын гишүүнээр ажиллаж байгаад цаашаа төр нийгмийн олон салбарт ажилласан хүмүүс байдаг. Ихэнх нь сайн ажилласан байдаг. Ихэнх нь өнөөдөр тэр үед тавьж

байсан үзэл санаандаа үнэнч, улс орон, ард иргэдийнхээ нийтлэг эрх ашгийн төлөө зүтгэж явсан хүмүүс байдаг. Тэгэхээр үзэл санаа гэдэг бол агуу, урт удаан амьдрах чадвартай юм байна. Хүний нэг насны амьдралыг ч давж цаашаа оршин тогтнох агуу зүйл юм байна гэдгийг энд бодож байгаа юм.

Тэгээд өнөөдөр бид нар байнгын ажиллагаатай парламентын 25 жилийн ойгоо тэмдэглэж, хүндэтгэлийн чуулган хийж байгаа. 25 жил гэдэг бол аливаа улс орон хөгжлийн нэг зам сонгож аваад, дүгнэлт хийх хугацаа. Бидний өвөг дээдэс ч тодорхой хугацааны дараа дүгнэлт хийдэг байсан, бид өмнөх үе ч дүгнэлт хийдэг байсан, одоо бид энэ дүгнэлтийг хийх цаг болжээ. Бид цаашаа ямар үйл ажиллагаа явуулах вэ, юун дээр алдав, юун дээр онов, одоо бидэнд зайлшгүй хийх шаардлагатай зүйл юу байна вэ гэдгийг бодох цаг иржээ.

Өнөөдрийн энэ Улсын Их Хурлын гишүүд бол энэ 25 жилийн буухиаг авч явж байгаа хамгийн эрхэм хүндтэй хариуцлага хүлээсэн хүмүүс шүү дээ. Энд Улсын Бага Хурлын үеэс парламентад сонгогдоод ажиллаж явж байгаа хүмүүс бий, төрд зүтгээд явж байгаа хүмүүс байна. Дараа дараагийн Их Хурлуудад сонгогдож орж ирсэн хүмүүс байна. Анх удаа энэ Их Хурлын сонгогдож орж ирж байгаа хүмүүс ч байгаа. Энэ утгаараа та бүхэн энэ 25 жилийн бүтээгдэхүүн юм. Энэ 25 жилийн парламентын ард түмний итгэлийг хүлээж авч явж байгаа хүмүүс. Маш эрхэм хүндтэй хариуцлага үүрч яваа хүмүүс. Тийм учраас бид бүхэн өнгөрсөн 25 жилд юу болов, цаашид бид юун дээр анхаарах шаардлагатай вэ гэдгийг өнөөдөр ярилцаж, нэгэнт хэлсэн бол, нэгэнт энд ярилцсан бол, нэгэнт ийм дүгнэлтэд хүрсэн бол энэ үйл ажиллагаагаа үйл хэрэг болгохын төлөө тууштай, цаг алдахгүй ажиллах ёстой гэж би бодож байгаа. Нэг үгээр хэлвэл Монголд бий болсон байнгын ажиллагаатай парламентын 25 жилийн ойн эзэд нь бол та бүхэн шүү. Энэ шийдвэрийг гаргах хүмүүс нь та бүхэн шүү. Та бүхнийг Улсын Бага Хурлын гишүүд, үе үеийн парламентын гишүүд, тэр бүх хүнийг сонгож явуулсан сонгогчид, ард иргэд итгэлийн нүдээр харж байгаа гэдгийг хэлэх нь зөв байх гэж бодож байна.

Ингээд би олон зүйл хэлэлгүйгээр гурван асуудал Монголын төрд энэ Их Хурлын бүрэн эрхийнхээ хугацаанд шийдвэрлэх шаардлагатай байгаа гурван асуудалд та бүхний анхаарлыг өнөөдөр хандуулъя гэж бодсон юм.

Эхний нэг дэх асуудал бол бүгдээрээ хариуцлагатай, ёс зүйтэй улс төртэй болъё. “Дээрээ хөлөө олохгүй бол дороо хөлөө олохгүй” гэж манай ард түмэн хэлдэг. Хариуцлага дээрээсээ л эхлэх ёстой. Хуулийг дарга нар өөрсдөө биелүүлж эхлэх ёстой. Хариуцлага дээрээсээ эхлэх ёстой гэдэг бол дээрээсээ эхэлж хариуцлага хүлээх ёстой. Энэ ажлыг бид эхлэхгүй хийхгүй бол болохгүй нь. Хариуцлагатай, албан тушаалын ёс зүйтэй ийм байх явдал чухал байна.

Би хувьдаа хариуцлага бол ялангуяа улс төрийн, төрийн өндөр албан тушаал хашиж яваа хүмүүсийн хувьд таван шатлалтай байдаг гэж боддог. Хамгийн эхнийх нь ёс зүйн хариуцлага. Энэ бол хүн болж төрсний ийм өндөр албан тушаал хашиж байгаа хүний хувьд заавал дагаж явах ёстой хариуцлага юм. Өнөөдөр ёс зүйн хариуцлагыг харуулж байгаа төрийн өндөр албан тушаалтан, сонгогдсон, томилогдсон албан тушаалтан харагдахгүй байна харамсалтай нь. Улсын Бага Хурлын үед харагддаг байсан шүү.

“Өөрийнхөө цалинг 20 дугаар тогтоолоор хоёр дахин нэмэгдүүлэх боломжийг ашигласан байна чи, тэр мөнгөнөөсөө чихэвчний хоёр ширхэг магнитофон худалдаж авсан байна” гээд тэр үед Улсын Бага Хурлын гишүүнийг бид Улсын Бага Хурлаас чөлөөлж байсан. 160 төгрөгийн үнэтэй жижиг магнитофон шүү дээ, хоёрыг худалдаж авсан байна гээд. Түүнийг эд мөрийн баримтаар тогтоосон гээд тэр хүн бид худалдаж авсан нь үнэн гэж хэлээд Улсын Бага Хурлын гишүүнээс чөлөөлөгдөж байсан. Ийм хариуцлагатай, ёс зүйтэй төртэй байсан юм шүү бид нар. Тийм парламенттай байсан юм.

Б.Чимид гуай хэлдэг байсан “8 төгрөг хөдөө томилолтоор явахдаа илүү зардал гаргасан



бол цалингаасаа төлдөг байлаа” гэж. Өнөөдөр ингэж байгаа төрийн албан хаагч байна уу? Өнөөдөр төрийн мөнгөнөөс 8 төгрөг илүү зарцуулсан, зүй бусаар зарцуулсан төрийн албан хаагч эргүүлж төлж байгаа ийм хүн байна уу? Тийм алба тушаалын, авлигын асуудалд орсон тийм хүн байна уу, төлөөд явж байгаа тэгээд хариуцлага хүлээгээд явж байгаа? Үүнийгээ бид бодох ёстой.

Нэгдүгээрт, ёс зүйн хариуцлага байгаа, хоёрдугаарт, улс төрийн хариуцлага. Улс төрийн хариуцлага гэдэг бол тухайн албан тушаалдаа би тэнцэхгүй байна, болохгүй юм байна гээд түүнээсээ чөлөөлөгдөхийг хэлж байгаа юм. Түүнээс явахыг хэлж байгаа юм. Гуравдугаарт, Монгол Улсын иргэн хүний хувьд иргэний хариуцлага байгаа. “Би ийм зүйлийн төлөө зүтгэх ёстой, би ийм нийтлэг эрх ашгийн төлөө явах ёстой”. Тэгээд дараа нь захиргааны, дараа нь эрүүгийн хариуцлага шүү дээ. Өнөөдөр явж явж эрүүгийн хариуцлага яригдах ийм түвшинд заримдаа очоод алга болж байна шүү дээ.

Энэ хариуцлагын тогтолцоо ерөөсөө алга байна. Хариуцлагын тогтолцоо байхгүй бол ардчиллын тухай ярих хэрэггүй. Хариуцлага байхгүй бол ардчилсан нийгмийн тухай ярих хэрэггүй. Дарга нар нь хариуцлага хүлээдэггүй байх юм бол ардчилсан нийгмийн тухай яриад хэрэггүй гэж бодож байгаа юм. Би хариуцлагын тухай ярихдаа хүний тухай ярьдаггүй, би Монгол Улсын тухай ярьж байгаа. Би улсаа бодож хариуцлагын тухай ярьж байгаа юм.

Бүгдээрээ улсаа бодъё л доо. Өөр өөрийн амьдралаар, өөрийн сонголтоор ажиллаж амьдраад явах боломжтой шүү дээ, энэ нийгэмд. Заавал энэ улс төрд орж ирж, хариуцлага хүлээхгүй байгаа бүдүүлэг зан авираараа, байж байгаа хэлбэрээрээ Монгол Улсыг хохироогоод байж болохгүй шүү дээ. Бид одоо ийм зүйлтэй хариуцлага тооцдог болох ёстой. Бид ийм хууль тогтоомжоо гаргах хэрэгтэй байгаа юм.

Та бүхэн мэдэрч байгаа даа, Улсын Их Хурлын гишүүн бүхэндээ одоо би та бүхэндээ ингээд уулзаад ярилцахад ард түмний итгэл хөрч байна, тэр халуун итгэл алга болж байна шүү гэхэд бүгд зөвшөөрдөг шүү дээ. Энэ хүмүүсийн сэтгэл дотор мөс хөрч байна шүү, халуун итгэл байхгүй, мөс хөрч байна. Энэ юуг сануулж байна вэ гэхээр хариуцлагын тогтолцоог авчир. Энэ парламент, энэ төрд авчир гэдгийг биднээс шахаж байгаа юм. Ирэх сонгуульд та бүхэн юу ч гэж амлаж, ярьж болно. Энэ хариуцлагын тогтолцоог л бий болгоогүй бол энэ бүхэн худлаа байх болно. Үүнийг 25 жил хангалттай харлаа. Юу ч гэж амлаад ард түмэн хүлээж авахгүй болсон доо. Үүнийг ойлгох хэрэгтэй. Үүнийгэ нам эвслийн хурал янз бүрийн газраа ярилцах хэрэгтэй шүү дээ. Байнгын хороо, намын бүлгүүд дээрээ ярилцах хэрэгтэй.

Би Сонгогдсон болон томилогдсон албан тушаалтнуудтай хариуцлага тооцох тухай хэмээн маш тодорхой нэр томъёотой хууль санаачилж Улсын Их Хуралд өргөн бариад олон сар болж байна, хэлэлцэхгүй байна. Би үнэхээр шаардаж байна. Энэ удаагийн, энэ намар аравдугаар сард эхлэх Улсын Их Хурлын чуулганаар эхний хэлэлцэх асуудлуудад энэ хуулийн төслийг оруулж өгөөч ээ. Та бүхний ард Монгол, Монголын төр үлдэх ёстой. Аливаа ажил хийж байгаа, өндөр албан тушаал хашиж байгаа үүрэг хүлээж байгаа хүн бол миний ард юу үлдэх вэ гэдгээ боддог байх ёстой шүү дээ. Энэ хуульд хариуцлагын тогтолцоог бий болгож, тэр хуульд хариуцлагын тогтолцоог өнөөгийн түвшинд оруулж өгөхийг эрмэлзсэн. Энэ хуулийг хэлэлцүүлж өг.

Өнөөдөр Монгол Улсын бодлого, улс төр тогтворгүй байна гэж та бүхэн ч гэсэн бүх хурал зөвлөгөөн дээр очиж ярьдаг. Энэ тогтворгүй байна гэдэг үгийг хурал зөвлөгөөний үг биш болгох хэрэгтэй шүү дээ. Үүнийг бид нар үйл ажиллагаагаараа засах ёстой. Бид тогтворгүй байгаа тухай хэчнээн ярих юм бэ? Тэгэхээр тогтворгүй байдал яагаад бий болоод байна вэ гэсэн чинь ерөөсөө хариуцлагагүй байдал чинь тогтворгүй байдлыг бий болгодог байна шүү дээ. Алдаатай шийдвэр гаргасан бол үүнийхээ төлөө хариуцлага хүлээдэггүй, түүнийгээ засдаггүй. Түүнд нь хүмүүсийн итгэл унаж байгааг тогтворгүй байна гэж хэлж байгаа юм. Хариуцлагатай байдал нь өөрөө тогтвортой байдлыг бий болгодог. Өөрөө тууштай байдлыг

бий болгодог. Өөрөө итгэлтэй байдлыг бий болгодог. Иймээс бид Монголын улс төрд хариуцлагыг авчрах цаг болсон.

Энэ чиглэлд Улсын Их Хурлын бүрэлдэхүүн тодорхой ажил хийсэн гэдгийг хэлэх хэрэгтэй. Захиргааны хууль, манай төрийн захиргаа гэдэг байгууллага чинь өөрөө бие даасан хуульгүй явж ирсэн шүү дээ. Захиргааны шүүх гэж бий болгоод Захиргааны хуулийг нь баталж өгөөгүй байсан. Замын цагдаа нь байж байдаг дүрмийг нь баталж өгөөгүй явсан. Одоо дүрмийг нь баталж өгсөн. Одоо энэ хуулийг захиргааны бүх шатанд хатуу хэрэгжүүлэх ёстой. Энэ хуулийн хэрэгжилтийг асуух ёстой. Дээрээс нь Нийтийн сонсголын тухай хууль зөвхөн хариуцлагыг Улсын Их Хуралд ярьдаг юм биш. Үүнийг аймгийн, сумын Хурлаар бас ярилцах ёстой, ард иргэд, олон нийт шаардаж байх ёстой. Энэ индрийг нь, энэ боломжийг нь эрх зүйг нь Улсын Их Хурал бүрэлдэхүүн хангаж өгсөн юм шүү. Одоо үүнийг ажиллуулах цаг болсон. Үүнийг манай иргэд, сонгогчид шаардах цаг болсон.

Энэ намраас эхлээд манай иргэд сум бүхэнд шаардах боломжтой. Хариуцлагагүй сумын дарга байгаа бол, хариуцлагагүй албан тушаалтан танай аймагт байгаа бол Нийгмийн сонсголын тухай хуулийн дагуу авч хэлэлцье. Томилгооны сонсгол, төсвийн сонсгол, мөнгөний сонсгол байгаль орчинтэй холбоотой сонсгол, хариуцлагын сонсгол гээд бүгд байгаа. Одоо энэ хуулийг амьдруулъя, хэрэгжүүлъя

Гурав дахь баталсан хууль бол Шилэн дансны тухай хууль. Эхлээд шилэн данс гээд олон нийтээрээ бүгд анхаардаг байсан. Одоо жаахан хаяж эхэлж байна. Үүнийг болих хэрэгтэй. Бид эргээд анхаарах хэрэгтэй. Би Шилэн дансны тухай хуулийг өргөн барьж байхдаа хэлж байсан “Монгол байгаа мөнгө зарцуулж байгаа тэр албан тушаалтан бүхэн, төсвийн мөнгө ашиглаж байгаа байгууллага бүхэн өглөө бүр Шилэн дансны тухай хууль байгаа шүү хэмээн бодож сэрдэг байх ёстой. Тэгээд тодорхой хэд хэдэн сайд хэрэгжүүлэхгүй байгаа бол, хэд хэдэн Их Хурлын гишүүн, хэд хэдэн аймгийн Засаг дарга нар, өндөр албан тушаалтнууд Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэхгүй байгаа бол хариуцлага хүлээгээсэй. Ингэх юм бол Монголд хариуцлагын зам уруу орлоо гэж бид бодох болно гэж хэлж байсан юм. Би үүнийг дахин шаардаж байна. Олон нийт ч хяналтаа тавих хэрэгтэй. Аудитын байгууллага бусад үүрэгтэй байгууллагууд үүндээ анхаарах ёстой гэж бодож байна.

Дээрээс нь өргөн барихад бэлтгэгдсэн байгаа хоёр хууль байгаа нэг нь өргөн барьчихсан. Нэг нь Төрийн албаны тухай хууль байна. Төрийн албаны тухай бид маш их ярьсан, илүү зүйлийг би яримааргүй байна. Төрийн алба шиг төрийн албатай болох цаг өнөөдөр Монголд ирсэн. Бид 25 жилийн дараа үүнийг ярих хэрэгтэй. Хариуцлагатай, ёс зүйтэй, өөрийн гэсэн хэм хэмжээтэй, шалгууртай ийм төрийн албатай болох ёстой. “Энэ нам яллаа, тэр нам яллаа, үүнийг ажлаас нь халлаа, төрийн албыг ингэж бужигнууллаа” гэж бид ярьдаг. Одоо төрийн албыг байх ёстой байранд нь оруулж ажиллуулах хэрэгтэй. Төрийн алба хэрхэн ажиллаж байгаагаас улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдал үүнтэй холбоотой шүү дээ

Энэ нь эргээд хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой байдаг. Тийм учраас төрийн албыг дураараа самардаг байдалд цэг тавья. Энд сууж байгаа парламентын хоёр голлох намын дарга нар суугаад, бусад хүмүүс нь суугаад бүрэн хэмжээний танилцуулга хийсэн. Хуулийг өргөн барьчихсан байгаа. Одоо энэ хуулийг батлаад ирэх сонгуулиас өмнө хэрэгжүүлж эхэлнэ. Төрийн албыг ингэж бужигнуулж болохгүй. “Одоо та нар бужигнуулж байна. Дараа нь бидний ээлж. Бид нэг хэсэг бужигнуулж аваад энэ хуулийг чинь баталъя” гэж хэлж болохгүй. Ийм байдалтай хандаж болохгүй. Юм сонссон ч сонсоогүй юм шиг дүлий дүмбэ суугаад байж болохгүй. Одоо бид нар энэ байгаа байдлаа ярьж, шийдвэрээ гаргах цаг болсон.

Улс төрийн намын тухай хууль, мөн энэ намын байгууллагууд, энд байгаа улс төрчид олон талаас нь оролцож олон жил ярилаа. Тэгээд энэ хуулийг бүр болохгүй болохоор нь энэ хуулийг Ерөнхийлөгч авч боловсруулъя, нэгтгэе. Саналуудыг авъя гээд ерөнхийд

нь нэгтгээд, саналуудыг аваад, олон нийтэд танилцуулаад явж байгаа. Зарим нь зохион байгуулалттайгаар тэр хуулийн төслийг унагахын тулд өөр хууль санаачилна, хэлэлцүүлэг өрнүүлнэ гэж зориуд зохион байгуулалттай зогсоохын тулд явж байна. Бид харж байгаа. Олон нийт харж байгаа. Энэ хуулийг өргөн барина. Энэ чуулганаар батлаарай гэдгийг хэлье гэж бодож байна.

Ер нь улс төрийн нам бол судалгааны байгууллага байх ёстой. Шилдэг шийдлүүд, шилдэг үзэл санаануудыг цуглуулж байдаг. Ялагдсан нөхөд нь суугаад бид нар яагаад улс орныг буруу авч явав. Ямар учраас бид ялагдав гэдэгтээ дүгнэлт хийгээд цаашдаа яаж авч явах вэ гэдэг дээр үзэл санаа, мөрийн хөтөлбөрөө бэлтгэж байдаг. Түүнийг хэрэгжүүлэх багийг бий болгож байдаг. Тэр үзэл санаа, мөрийн хөтөлбөрөө ард иргэдэд ойлгуулж байдаг. Эрхээ хэрэгжүүлж байгаа нөхдүүд нь тэр хийсэн судалсан зүйлээ улс, эх орныхоо тусын тулд хэрэгжүүлээд явж байдаг. Дээрээс нь улс төрийн нам гэдэг нь албан тушаалд дуртай хүмүүсийн цуглуулга биш. Энэ бол манлайлагчдын Монголын шинэ өнгө, төрх болсон, Монголыг авч явах шигшээ баг л энд бүрэлдэж байх ёстой.

Өнөөдөр улс төрийн намыг тойроод шигшээ баг бүрэлдэж байна уу, ямар баг бүрэлдэж байна вэ? Өөрсдөө дүгнэлт хийх хэрэгтэй. Энд хөтөлж чадах хариуцлагатай, чадвартай улс төрийн намын системийг Монголд бий болгох хэрэгтэй. Улс төрийн нам ялангуяа эрх барьж, эрх барихад оролцож байгаа бол хариуцлага хүлээдэггүй, хариуцлагаас гадна объект бий болоод байгаа шүү дээ. Байгууллага бий болчихоод байгаа шүү дээ. Бид бүх байгууллагаас хариуцлага шаарддаг мөртлөө улс төрийн намаас хариуцлага шаардаж чадахгүй л. Тийм малгайн доор орсон этгээдүүд өнөөдөр хариуцлагаас зугтах гэж гүйдэг болсон. Монгол Улсыг хариуцлагагүй болгож байгаа, энэ ардчилсан сонголтыг утга учиргүй болгож байгаа этгээдүүд энэ дор цуглардаг болсон шүү. Энэ байдалд бүгдээрээ цэг тавья. Ингэж цаашаа хөгжлийнхөө байдлыг тогтооё. Ийм шалгуурыг бий болгоё. Хэрэв нам хариуцлагатай болохгүй бол төр хариуцлагатай болохгүй байна. Бид их олон зүйл яриад, урт үг хэлээд байх хэрэггүй. Хэлсэн, ойлголцсон, одоо үүнийгээ бид хийх л хэрэгтэй.

Улс төрчдийн, ялангуяа төрийн өндөр албан тушаал хашиж байгаа хүмүүсийн ажил бол гаргаж байгаа шийдвэрээр нь л батлагддаг. Түүнээс биш телевизээр юу гэж ярьж байгаа, ямар мэдэгдэл хийж байгаагаар батлагддаггүй юм. Биелдэггүй юм гэдгийг энд хэлье гэж бодож байна. Ёс зүй гэдэг бол улс орныг урагш нь түлхдэг. Хариуцлага гэдэг бол тогтвортой байдлыг бий болгодог. Дэг журам гэдэг бол эргүүлж юмыг нэгтгэдэг. Бид нар үнэхээр нэгдэж ажиллах хэрэгтэй. Нэгдэж ажиллахдаа энэ эв нэгдэл нь шударга ёсон дээр, шударга тогтолцоонд суурилсан ийм л эв нэгдэл байх ёстой. Үүний төлөө л бүгдээрээ явъя гэж бодож байгаа юм.

Хоёрт нь миний хэлэх гэсэн зүйл бол гүйцэтгэх засаглалын бүтээлч, тогтвортой байдлыг хангая. Үнэхээр ингэхгүйгээр болохгүй байна. Бүх намуудаас гарч байгаа судалгаа байна. Манай дотоодоос хийж байгаа болон олон улсын байгууллагын судалгаа байна. Монголд байгаа хамгийн үр ашиг муутай ажиллаж байгаа нь гүйцэтгэх засаглал байна. Гүйцэтгэх засаглал үр ашигтай ажиллах орчин, тийм тогтолцоо Монгол Улсад бүрэлдээгүй байна гэсэн дүгнэлтийг маш олон газар хийж байна. Бид нар ч хийж байна. Үүнийг бид өнөөдөр амьдрал дээрээ мэдрээд гарч байгаа. Ийм учраас үнэхээр гүйцэтгэх засаглалыг бүтээлч болгоё. Нэгэнт бүтээлч болгох үйл ажиллагааг тавиад явж байгаа бол тодорхой шийдвэрээрээ харуулъя.

Өнөөдөр Засгийн газрыг яаж байгуулж байгааг мэдэж байгаа шүү дээ. Та бүхэн зарим нь бүр ичээд сууж байгаа. Бараг намайг одоо ингээд хэлэх гэвэл “Нэр хэлбэл яана даа. Үүнийг ярьчих вий дээ” гэж зарим нь дотроо ичиж байгаа. Засгийн газар руу өөр өөрийнхөө хүнийг, өөр өөрийнхөө төлөөллийг оруулж, тэднээр дамжуулж өөрсдийнхөө бизнесийг, өөрсдийнхөө ашиг сонирхлыг хангах гэсэн хэсэг бүлэг л болчихсон байгаа шүү дээ. Худлаа

юм ерөөсөө байхгүй. Үүний ард сууж байдаг, ард нь зэс хошуугаа хатгачихсан, араас нь сороод сууж байдаг, ийм л хүмүүсийн төлөөлөл болж орж ирж байгаа шүү дээ, зарим этгээд.

Үүнийг ард түмэн хараад байна. Нэг удаа хийгдэж байгаа бол нэг удаа юм байна даа. Засах байлгүй дээ гэж боддог. Хоёр удаа хийгдэж байгаа бол хоёр удаа гэж хардаг. Гурван удаа бол энэ биш боллоо шүү гэдэг. Дөрвөн удаа, таван удаа олон удаа давтагдлаа, одоо больё. Одоо арай хэтэрлээ. Ингэж Засгийн газраа байгуулдаг. Өвстэй хашаанд өөрийн хургануудаа хөөж оруулаад таргалахаар нь нядалж иддэг малчид шиг иймэрхүү хувиа бодсон хүн шиг байж болохгүй. Одоо зогсьё. Үүнээс цааш яаж явах юм бэ. Нэгэнт ийм хүмүүсээс бүрдсэн Засгийн газар яаж бүтээлч байх юм бэ. Араасаа аалзны шүлс шиг татуургатай. Ийм хүмүүсээс бүрдсэн Засгийн газар яаж улс орны, ард түмний өмнө тулгамдаж байгаа хүндрэлтэй асуудлыг зоригтой, бүтээлчээр шийдээд явж чадах юм бэ!

“Надад өгдөг татвар хаана байна” гээд зарим албан тушаалтнууд тодорхой албан тушаалтнуудаас мөнгө нэхдэг болж байгаа гэж яригдаж байна. “Чи тэдэн саяыг аваад ир. Тэр тендер, тэр уралдаан, тэр мөнгө хаана байна” гэж ярьдаг. Одоо энд байгаа сайд нар “би ардаа ийм амлалт өгч байж сайд болсон. Би амлалт өгөлгүйгээр, арай бага амлалт өгч сайд болсон шүү” гэж хоорондоо ярьдаг болсон шүү. Ийм утгагүй байдалд Монголын төрийг оруулж болохгүй шүү дээ. Энэ чинь уламжлалтай, түүхтэй төр шүү. Одоо больё. “Элбэгдорж ярьж байна. Ерөнхийлөгч ярьж байна. Яриад л өнгөрөх байлгүй дээ” гэж битгий бодоорой. Үүний ард нэхэл хатуутай ард түмэн байгаа шүү. Нэхэл хатуутай олон түмэн байгаа шүү. Би энэ олон түмний санал бодлыг хэлж байгаа юм.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн гэдэг бол өндөр нэр хүндтэй, хариуцлагатай, төрийн өндөр албан тушаал шүү дээ. Тэр өндөр нэр хүндтэй, хариуцлагатай, төрийн өндөр албан тушаалын өмнө, ёс зүйтэй албан тушаалын өмнө өөрийгөө тавиад хар л даа. Тэр өөрсдийнхөө хүнийг түлхэж байгаа фракц гэж нэрлэгддэг, хувийн үзэл бодолдоо баригдсан тэр хүмүүс өөрсдийгөө нэг тавиад хар даа. Ийм байдлаар, ийм ширэнгийн ойн хуулиар ажиллаж болохгүй. “Манай хүн орохгүй бол танай хүнийг оруулахгүй” гэж. Энэ юу гэсэн үг вэ.

Би ороогүй, миний хувийн сонирхол явахгүй бол чинийх явахгүй гэж, үүний төлөө л байлдаж байна шүү дээ. Үүний төлөө л та бүхэн хэвлэл мэдээллийг ашиглаж, үүний төлөө ард түмний тархи толгойг самууруулж байна. Үүний төлөө хүмүүсийг бүр ядаргаанд оруулж байна шүү дээ. Үүний төлөө үүнээс болж хүмүүс улс төрөөс залхаж байна. Бид ийм гашуун түүхийн дундуур яваад ирсэн юм шүү. Бид хүний эрхшээлд байхдаа ийм түүхийн дундуур явж ирсэн. Одоо өөрийн эрхээр байхдаа ийм байдалд ормооргүй байгаа юм. Ингэж шинэ сонголтыг Монголын ард түмэн хийсэн шүү.

Бидний их өвөг дээдэс, Тэмүүжин, Чингис хаан анх гарч ирж байхдаа үнэхээр хэдэн ханлиг болоод хоорондоо байлдаад байвал Монгол үндэстэн алга болох нь ээ гэдгийг тэр хүн ойлгосон шүү дээ. Яг өнөөдөр энэ ханлигуудын байлдаан олон улсын хэллэгээр бол ширэнгийн ойн хууль Монголын парламентад үйлчилж байна. Ширэнгийн ойн хуультай парламентаас олон улсын төлөөлөл, ард түмэн юу хүлээж суух юм бэ. Ширэнгийн ой гэдэг бол тэнд байгаа, ширэнгэ, ширэнгийн мухарт байгаа ахлагч нарынхаа тогтоосон дэг журмаар, тэдний хүсэл зоригоор явдаг хүмүүсийг л хэлдэг шүү дээ. Тийм хуулиар ажилладаг газрыг хэлж байгаа юм.

Ар ардаа байгаа нам, нам нь дотроо хэдэн фракц, бүлэглэлд хуваагдчихсан. Хүн бүхэн мэднэ. Монголын ажлыг ямар хүмүүс зогсоож байна. Яаж зогсоож байна. Ямар аргаар, ямар дэвийн аргаар зогсоож байна гэдгийг. Одоо энэ дэвийн, адын аргаасаа салъя, энэ ёрын муухай юмнаас больё л доо. Энд 25 жилийн өмнө Монголын төр бүрэлдэж байхад ямар ариун ёс зүйтэй бүрэлдэж байсныг би түрүүн хэллээ шүү дээ. Ямар хариуцлагатай бүрэлдэж байсныг хэллээ.

Энэ үүрэг, хариуцлага чинь ямар хүнд юм бэ гэж хүлээж авч байсныг би түрүүн хэллээ. Ингээд бид хүний муухай чанарыг, болохгүй байгааг яриад байвал яриад л байна байх. Тийм учраас тогтолцоондоо өөрчлөлт оруулъя гэж байгаа юм. Тийм учраас түрүүчийн миний хэлдэг тэр хариуцлагын тухай хуулиуд, тэр асуудлуудаа шийдье. Засгийн газрыг бид бүтээлч, хариуцлагатай, ажлын төлөө явдаг, ёс зүйтэй болгохын тулд хоёр шийдвэр гаргахаас өөр арга алга.

Нэгдүгээрт, Ерөнхий сайд өөрийн Засгийн газрын танхимдаа ажиллах гишүүд, сайд нараа өөрөө томилдог болох хэрэгтэй. Парламентыг томилгооноос салгах хэрэгтэй. Та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа, үүнийг ард түмэн хэлэхгүй байгаа шүү дээ. Бүх парламентын засаглалтай манай орон шиг ингээд сайд нараа нэг, нэгээр нь, фракц фракцаараа, нам намаараа хувааж аваад томилоод сууж байдаг ийм парламент дэлхий дээр хэд байна вэ? Байхгүй байна гэж дүгнэлт гарч байгаа, ганц хоёр гэж дүгнэлт гарч байгаа, арав хүрэхгүй байна гэж дүгнэлт гарч байгаа. Тэд нар үүнээсээ салахыг бодож байна. Тэд нар биднээс тэс өөр, Монголтой харьцуулшгүй тогтолцоо.

Бид бол асар өвөрмөц байршилтай, асар өвөрмөц сонголт хийсэн тэр нь эмзэг орон шүү дээ. Тийм учраас бид өөрийн гэсэн зөв бүтэцтэй байх ёстой. Ийм учраас Улсын Их Хурал нь Засгийн газрын Ерөнхий сайдаа томиллоо, тэр парламент нь шийдлээ. Тэр хүн гараад бүрэн бие даасан байдлаар Засгийн газрын гишүүнээр хэнийг авах, хэнийг томилохоо өөрөө шийдэх ёстой. Тэгэх юм бол тухайн салбарт юм хийж чадах, тухайн салбарт үнэхээр чадвартай гэж үзэх тухайн бодлогыг авч явах хүмүүсээ томилж чадна. Заавал тухайн намын гишүүн ч байх албагүй шүү дээ. Энэ эрхийг Ерөнхий сайдад өгөөгүй байна. Ийм учраас ар араас нь ийм татлагатай түлхээтэй, тэр хүнд татвар төлөх ёстой, нэг юмны шагнал болж орж байгаа хүмүүс чинь улс орны төлөө ажиллахгүй байна шүү дээ.

Ийм учраас улс орон, засаглал чинь болохоо байлаа гэж хүмүүс хэлээд байгаа юм. Дээрээс нь тэр сайдаа хэзээ чөлөөлөх вэ. Хэзээ огцруулах вэ гэдгээ Ерөнхий сайд өөрөө шууд мэддэг байх ёстой. Тэр хүн өөрөө мэдрэх ёстой, тэр хариуцлагыг Ерөнхий сайдаас тухайн парламент нь нэхдэг байх ёстой. Бид нар нэг юм ойлгуулчихаж. Ардчилал гэвэл ийм байдаг юм байна, парламент гэвэл ийм байдаг юм байна. Их Хурлын гишүүд нь сайдаа томилдог юм байна гээд энэ 25 жил буруу явж ирсэн ойлголт буруу байна. Дэлхий нийтэд ингэж явдаггүй юм байна. Монголд ч гэсэн ингэж явж болохгүй юм байна. Энэ асуудлыг бид нар шийдэх хэрэгтэй. Энэ парламент шийдэх хэрэгтэй.

Хоёрт, Ерөнхий сайдад өгөх ёстой гүйцэтгэх засаглалыг бид нар бүтээлч хариуцлагатай тэнцвэртэй болгохын тулд хоёр эрх бол Ерөнхий сайдад Улсын Их Хурлын ээлжит бус чуулганыг зарладаг эрхийг өгөх хэрэгтэй. Ингэж албан тушаалын хойноос хөөцөлдөөд байх, уг нь бодлого яриад хууль гаргаад сууж байх ёстой хүмүүс шүү дээ. Тэгээд албан тушаалаар дамжуулж амьдралаа өөд татдаг, тэгэх гээд бодол өвөрлөөд сууж байгаадаа санаа зовох хэрэгтэй. Зарим нь мэдэхгүй байна гэж бодож байгаа байх. Мэдэж байгаа. Та нар бодсон л бол энэ дэлхий дээр, орчлон дээр бүртгэгдэж байдаг юм шүү. Тийм хөдөлгөөн, тийм хор найруулсан л бол үлдэж байдаг. Тэр чинь үр хойчид, цаашаа Монголын ард түмэнд гай болно шүү дээ. Нүгэл болно. Тийм учраас энэ нүглийг одоо зогсоох хэрэгтэй.

Төр гэдэг бол хэцүү асуудлыг шийддэг, хэцүү ажлыг үүрч явдаг, буян хийж, нүглийг арилгахын төлөө, нүгэлтэй тэмцэж явдаг байгууллага шүү. Түүнээс биш мөнгөний хойноос, суудлын төлөө үхэлдэн хаталдан ингэж гүйлдэж байдаг. Ичих нүүрээ алдаж байгаа шүү.

Улсын Их Хуралд сууж байгаа, өмнө нь их зарчмын юм ярьдаг байсан гишүүн Засгийн газрын гишүүний суудлын үнэр сонсоод л бүх зарчмаа хаяж байгаа шүү дээ. Ямар адгийн юм бэ. Тэнд хэдэн сар, нэг, хоёр жил ажиллахын тулд ингэж зарчмаасаа, үнэт зүйлээсээ ухарч урвана гэдэг муухай шүү дээ. Яагаад хүмүүс Улсын Бага Хурлын тухай сайн ярьдаг юм бэ. Тэнд үзэл санаа байсан. Тэр зарчимдаа үнэнч явсан хүмүүс байсан. Тэр зарчимдаа

үнэнч 21 сар ажилласан хүмүүс. Тэр Бага Хуралд байсан сайн зүйлээс нь бид суралцаж төрд байгаа сайн юмаа авч явах хэрэгтэй. Энд дүгнэж хэлэхэд танхимын гишүүдээ авч, томилох асуудлаа Монголын Ерөнхий сайд бие дааж шийддэг байх хэрэгтэй. Дээрээс нь Улсын Их Хурлын ээлжит бус сонгуулийг зарлах эрхийг Ерөнхий сайдад өгөх хэрэгтэй. Ингээд үзье. Их олон юм бужигнуулахаа больё. Үүн дээр нэгдье л дээ.

Дээрээс нь Үндсэн хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг та бүхэнд уншиж өгөх гэсэн юм. “Засгийн газрын бүрэн эрх Улсын Их Хурлаас Ерөнхий сайдыг томилсноор эхэлж, шинэ Ерөнхий сайдыг томилсноор дуусгавар болно” гэж байгаа. Энэ 2 дахь заалтад 17 үг байгаа. “Ерөнхий сайдыг томилсноор” гэсэн үг хоёр удаа орсон байгаа юм даа. Тэр үед бид нар ярьж байсан юм. Үндсэн хуулийн үг, үсэг бүхэн, цэг таслал бүхэн учир утгатай. Ийм учраас маш их бодож оруулна тэр үеийн хамгийн гайхамшигтай эрдэмтэд, бичгийн их хүмүүс үүн дээр сууж Үндсэн хуулийн редакцийг хийсэн юм шүү. Тэгэхээр би санаандгүйгээр “шинэ Ерөнхий сайдыг томилсноор” гэдгийг нь 17 үг дотор 2 удаа оруулаагүй гэж бодож байна.

Бид нар нэг юмыг маш буруу хэрэгжүүлж ирсэн байгаа юм. Үндсэн хуулийн үзэл санааны эсрэг хэрэгжүүлж ирсэн. Ерөөсөө нэг удирдлага томилоод л түүнтэйгээ маргааш өдрөөс нь эхлээд л ноцолддог. Энэ маш буруу. Үндсэн хуульд удирдлага томилоод түүнтэйгээ маргааш өдрөөс нь эхэлж ноцолдож болохгүй гэдгийг хэлээд өгчихсөн байгаа. Шинэ Ерөнхий сайдыг томилсноор өмнөх Ерөнхий сайдын бүрэн эрх дуусгавар болно. Засгийн газрын эрх, шинэ Ерөнхий сайдыг томилсноор эхэлнэ гээд байгаа. Энэ юу гэсэн үг вэ. Одоо та бүхэн миний хэлэх гээд байгаа санааг сайн ойлгосон байх. Өнөөгийн байгаа Ерөнхий сайдыг өөрчлөх гэж байгаа бол дараагийн Ерөнхий сайдыг Их Хурлаараа сонгоод баталчих. Тэгэхээр өмнөх Ерөнхий сайдын бүрэн эрх шууд дуусгавар болно.

Үүнийг улс төрийн намууд дээр ч авч хэрэгжүүлэх хэрэгтэй. Өмнө нь байгаа даргынхаа дараа намынхаа дүрмийн дагуу дараагийн дарга нь тодроод л намын шийддэг газар нь шийдчих юм бол өмнөх даргын бүрэн эрх дуусаж байх ёстой. Манайд яадаг вэ гэхээр өмнөхтэйгөө томилсныхоо маргаашаас зууралдаад эхэлдэг. Түүнийгээ муухай болгодог. Ийм байгаа учраас намын дарга нь ч бүрэлддэггүй. Дараагийн Монголын Ерөнхий сайд ч бэлтгэгдээгүй байдаг байхгүй юу. Бид нэг жишээ хэлдэг шүү дээ.

1990 оноос хойш бид нар 14 Ерөнхий сайд солилоо. ХБНГУ-д 3 канцлер солигджээ гэж. ХБНГУ-д байдаг юм үзсэн, сургамж авсан орнуудын хууль яг ийм байна. Дараагийн канцлерыг парламент нь томилох юм бол өмнөх канцлерын бүрэн эрх дуусдаг. Тиймээс учраас өмнөхтэйгөө чадахгүй байгаа улсууд, мэдэхгүй байгаа улсууд тэнд орё гэж бодсон адын шуналтай улсууд тэгж зууралдаад байдаггүй юм байна. Жинхэнэ тэр орныг авч явах манлайлагч, гүйцэтгэх засаглалыг авч явах манлайлагч тодорсон үед нь өмнөх хүний бүрэн эрх дуусдаг юм байна шүү дээ. Ойлгогдож байна уу, одоо?

Ийм байх юм бол энэ төр, улс чинь тогтвортой байдаг юм байна. Ийм байх юм бол бодлого чинь тогтвортой байдаг юм байна. Энэ олон нийтийн байгууллага дээр ч адилхан, улс төрийн намууд дээр ч адилхан, Монголын төрд ч адилхан. Энэ Үндсэн хуулийн язгуур үзэл санааг хэрэгжүүлэе л дээ. Чи үнэхээр дараагийн Ерөнхий сайд болох гээд байгаа юм уу. Тэгвэл Улсын Их Хурал дээр очоод батлагдаад гараад ир. Тэгээд хөтөлбөрөө дэвшүүл. Түүнийхээ төлөө зүтгэ. Түүнийгээ зарла. Чи үнэхээр дараагийн намын дарга болох гээд байгаа бол намын байгууллагынхаа хамт олны олонхын саналыг аваад гараад ир.

Бид нар томилсон хүнээ өмнө нь унагах тухай бодоод байдаг юм байна шүү дээ. Тийм байгаа биз дээ. Тийм учраас бидний ажил унаад байна. Тийм учраас олон Ерөнхий сайд солигдоод байна. Тийм учраас Монголын тогтолцоо итгэлгүй гэж харагдаад байна. Хүн итгэхээ больчихоод байна шүү дээ. Одоо цаашдаа батлах гэж байгаа хууль, бүх зүйлээ Үндсэн хуулийн энэ язгуур үзэл санаанд нийцүүлэх хэрэгтэй. Ингэж чадах юм бол Монголын гүйцэтгэх засаглал тогтвортой байна. Ингэж чадах юм бол Монголын гүйцэтгэх засаглал

бүтээлч байна гэж би харж байгаа. Тэгэхээр үүн рүү бид нар явъя. Тийм учраас хамгийн гол нь парламентыг энэ томилгооноос нь салгаж өгье. Дараагийн хүн нь тодорсноор өмнөх хүний бүрэн эрх автоматаар дуусдаг Үндсэн хуулийн язгуур үзэл санааг тууштай хэрэгжүүлбэ л гэж байгаа юм. Тэгэх юм бол миний түрүүчийн хэлдэг хоёр дахь асуудлаар та бүхэнд хэлж байгаа үйл ажиллагаа явна.

Бид нар улс орон, ард түмнийхээ сонгож авсан сонголтын тухай ярихдаа “бид нээлттэй нийгэм байгуулж байгаа. Энэ бол бидний давуу тал” гэж ярьж байгаа. Үнэхээр ч энэ давуу тал. Бүгдээрээ л хамт сурч яваа. Бүгдээрээ л үүний дундуур явж байгаа. Бас болж байгаа юмыг огт туулах ёсгүй зам байсан. Огт бүтэхгүй байсан гэж үзэх болохгүй. Болдог л юм өнөөгийн тогтолцоон дотроо болж байгаа. Эндээс сургамж авсан бол муугаа хаяад л тэр сургамжаа сайн хууль, сайн тогтолцоо, сайн бодлогодоо оруулаад цаашаа явах хэрэгтэй. Би хувьдаа үүнээс сургамж авлаа гэж бодож байгаа.

Ийм учраас Улс төрийн намуудын тухай хууль, Сонгогдсон болон томилогдсон төрийн албан тушаалтнуудын хариуцлагын тухай хууль, Төрийн албаны хууль, ийм учраас гүйцэтгэх засаглалын чиглэлд оруулах хоёр алхмыг бид хийж хэрэгжүүлэх хэрэгтэй. Бид сургамж авах хэрэгтэй. Нээлттэй нийгэм сургамжийг нь өгөөд байна. Ард иргэд өгөөд байна, хэлээд байна. Дамжуулж хэлээч гээд цаана чинь бүгдээрээ харж байна, хэлж байна. Үүнийг сонсоогүй юм шиг суугаад байж болохгүй. Тэгэх юм бол нээлттэй нийгмийн утга учир алдагдана. Ард түмний сонголтын утга учир алдагдана гэдгийг хэлэх гэсэн юм. Ингээд миний энэ хэсэгт хэлэх гэсэн зүйл бол хариуцлагатай, ёс зүйтэй улс төрийг бий болгоё. Бүтээлч, тогтвортой гүйцэтгэх засаглалыг бий болгоё. Гүйцэтгэх засаглалыг ингэж ажиллуулъя гэдэг энэ хоёр арга хэмжээг авах хэрэгтэй.

Гуравт нь хэлэх санаагаа хэлье. Монгол Улс байнга төвийг сахих бодлоготой орон болъё. Өмнө нь би дотоод асуудлаар, улс төрийн харилцаатай холбоотой асуудлаар хоёр зүйл хэлсэн бол одоо гадаад бодлоготой холбоотой асуудлаар нэг зүйлийг хэлье гэж бодсон юм. Ер нь бидний өвөг дээдэс гол ноён нуруутай бодлого гэж ярьдаг байсан. Төрийн бодлого бол голыг нь олсон, голчийг нь олсон, ноён нуруутай байх ёстой шүү гэдэг чинь явж төвийг сахих бодлого байж л дээ. Та бүхэн өвөг дээдсийнхээ бичсэн, үлдээсэн өв хөрөнгө, ном зохиолоос уншаад үзээрэй. Бидний ээж, аав ч хоорондоо ярьж байдаг. “Эхийг нь эцээлгүй, тугалыг нь тураалгүй байх юмсан” гэж. Явуулж байгаа голч бодлогоо энгийн амьдрал дээр аваад ирэхээр саяын үгээр хэлдэг байсан юм.

Тэгэхээр миний хэлж байгаа байнга төвийг сахих бодлого гэдэг нь ямар бодлого вэ? Ямар бодлогын тухай саяхан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл хэлэлцэж зөвлөмж болгосон бэ? Энэ бодлогыг цаашаа хэрэгжүүлж явах шаардлагатай гэж ямар бодлогыг хэлсэн бэ гэдэг талаар хэдэн зүйл хэлье. Байнга төвийг сахина гэдэг бол эхлээд, зарлаад хаячихгүй ээ л гэсэн үг. Энэ бодлогоо тууштай, идэвхтэй хэрэгжүүлнэ л гэсэн үг. Үүнийг бид ингээд орхихгүй ээ гэж хэлж байгаа юм. Энд би таван нөхцөл байдлыг дурдаж хэлье.

Нэгдүгээрт, сүүлийн 25 жил Монгол Улсын хэрэгжүүлсэн бодлого бол бүхэлдээ сая миний хэлдэг бодлогын агуулга болж хэрэгжиж иржээ. Зарим хүн асууж байгаа. Монгол Улс ийм бодлого зарлаад эхэллээ, юу өөрчлөгдөв? Ямар юм солигдов гэж. Тэгвэл юу ч өөрчлөгдөөгүй. Бид нэртэй юмыг нэрээр нь нэрлэж байгаа юм. Бид агуулгыг нь 25 жилд бүтээсэн, хэрэгжүүлсэн. Одоо нэрийг нь өгч байгаа юм. Бид нар сүмээ барьсан бол нэрийг нь бичиж байгаа юм. Бид нар сонинд юм бичсэн бол нэрийг нь өгч байгаа юм. Бид нар хүүхдээ төрүүлсэн бол нэрийг нь өгч байгаа юм. Ямар нэг гэнэтийн болсон зүйл байхгүй. Бид нэртэй юмны нэрийг нь зарлаж байгаа юм.

Бид олон тулгуурт бодлого хэрэгжүүлнэ гэсэн. Бид энхийг эрхэмлэх бодлого хэрэгжүүлнэ гэсэн. Энэ бол төвийг сахих бодлогын амин сүнс нь байдаг. Бид Гадаад бодлогынхоо үзэл

баримтлалд бичсэн, Цэргийн бодлогынхоо үзэл баримтлалд бичсэн. Үндсэн хуульдаа бичсэн. Бид Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа бичсэн. Хэрэв манай улсын эрх ашигт халдахгүй бол бид бусдын эрх ашигт халдахгүй. Хэрэв манай улсад цэрэглэн халдахгүй бол бусдын эрх ашигт цэрэглэн халдахгүй. Бид өөрийнхөө эрх ашгийг хамгаална. Энэ бол төвийг сахих бодлогын үндсэн зарчим.

Бид цөмийн зэвсэггүй бүс нутаг гэж зарлаж байна. Энэ бол төвийг сахих бодлогын үндсэн зарчим. Бид социализмын үеэс Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний идэвхтэй гишүүн байж ирсэн. Энэ бол төвийг сахих бодлогыг олон улсын хэмжээнд Монгол явуулж байсан байдал. Үнэхээр бид нутаг дэвсгэрийнхээ бүрэн бүтэн байдлыг хадгалж үлдэх ёстой гэж бид байнга зарладаг. Үүнийгээ хадгалж үлдэх бодлого бол энэ төвийг сахих бодлогын үндсэн зарчим. Тийм учраас ямар шалтгаанаар, ямар учраас ийм бодлого ярьж эхлэв гэдэг эхний нэгдүгээр шалтгаан энэ байгаа юм.

Хоёрт, миний харж байгаагаар төвийг сахих бодлого бол хамгийн тогтвортой бодлого юм байна. Хамгийн олон жил төвийг сахиж яваа улсын түүх бараг 400 жилээр тоологдож байна. Дэлхийн дэг журам янз бүрээр л өөрчлөгдсөн байх. Олон улсын дэг журам янз бүрээр өөрчлөгддөг. Одоо ч өөрчлөлтийн үйл ажиллагаа явагдаж байна. Цаашдаа ч өөрчлөгдөх болно. Харин төвийг сахисан бодлого хамгийн тогтвортой явж ирсэн байх юм.

Дээрээс нь энэ бодлогын бас нэг сайн чанар бол бид өөрсдөө л зарлаж байгаа. Монгол Улс зарлаж байгаа шүү, өөр хэн ч биднийг шахаагүй. Бидний өвөг дээдэс 1910 онд Монгол Улсын эрх чөлөө, тусгаар тогтнолоо зарлаж байхдаа Төвийг сахисан бодлоготой болох тухай ярьж байсан.

1920 онд Ардын хувьсгал хийж байхдаа төвийг сахисан бодлогын тухай ярьж байсан. 1990 онд бид шинэ Үндсэн хуулийн тухай ярьж байхдаа төвийг сахисан бодлогын тухай ярьж хоорондоо энэ тухай хэлэлцдэг л байсан. Бид нар өнгөрсөн 25 жил энэ бодлогоо бүтээж хийсэн. Үүнийгээ гаргаж ирж байна.

Тэгээд хамгийн сайн зүйл нь энэ бодлогыг зарлаж байгаа улс орон энэ бодлогынхоо тухай өөрөө л тайлбарладаг. Монгол Улс л тайлбарлана, өөр хэн ч бидний өмнөөс тайлбарлаж байгаа тайлбар бодит зүйлд нийцдэггүй. Тэгэхээр Монгол Улс тайлбарладаг. Тэгээд олон улсын эрх зүйгээр төвийг сахисан бодлого гэдэг бол давхар баталгааждаг зүйл юм. Энэ бол бусадтай тэнцвэртэй харилцах, маргаантай асуудал дээр бид нар маш тодорхой байр суурьтай байх энэ боломжийг бидэнд олгож байгаа юм. Ийм учраас Монгол Улс төвийг сахисан бодлого гэдэг нэртэй юмыг нэрээр нь нэрлээд явъя.

Гуравдугаарт, энэ төвийг сахисан бодлогоор монголчууд өөрийн хүчинд найдаж бусадтай нээлттэй харилцаж хөгжих боломжид тулгуурлаж цаашаа явъя. Нэг үе бид Марксизм - ленинизм гэж явсан. Дараа нь ардчилал, зах зээл гэж явсан. Ерөнхийд нь авч үзвэл энэ бол тодорхойгүй, үзэл баримтлалын түвшний зүйлүүд шүү дээ. Хэрэгждэг тодорхой зарчимтай, гэхдээ улс орнууд өөр өөрийн онцлогоор авч явдаг ийм зүйл. Тийм учраас бид тодорхой бодлоготой болж байгаа хэрэг. Тэгээд төвийг сахисан бодлого гэдэг бол тодорхой чадавх шаарддаг. Монголчууд юуг тойрч нэгдэх вэ гэж ярьцгаадаг байсан шүү дээ. Би энэ тухай зарим намын дарга нар, бүлгийн дарга нартайтай зөвлөлдсөн. Энд ажиллаж байсан олон хүмүүстэй, мөн судлаачидтай зөвлөлдөж ярилцсан. Тэгэхэд Монголын эрх ашигт болохгүй байна ийм зүйл нэг ч гарч ирээгүй. Үнэхээр хэлэх цаг нь болсон, ярих цаг нь болсон ийм бодлого юм. Монгол хүн монгол хүндээ найдъя, монгол хүн монгол хүнээ дэмжиж ажиллая.

Өнөөдөр Монголд Ардын намын Монгол гэж байхгүй, Ардчилсан намын Монгол гэж байхгүй. Монгол бол нэг л байгаа. Тийм учраас нэг Монгол, нэг монголчууд нэгдмэл зорилгынхоо төлөө улс орноо хөгжүүлэхийн төлөө, ард түмнээ сайн сайхан амьдруулахын төлөө, ерөөсөө газар нутагтаа бүрэн эрхээ эдэлж, сайн сайхан хөгжихийн төлөө зүтгэе. Төвийг сахисан



бодлого гэдэг бол явж хөгжлийн бодлоготой уялдаж байгаа юм. Эдийн засгийн бодлоготой уялдаж байгаа юм. Зөвхөн гадаад бодлоготой биш, улс төрийн бодлого, цэргийн бодлого, нийгэм, олон улсын харилцаатай уялдаж байгаа юм.

Дөрөвдүгээрт миний хэлэх гэсэн нэг зүйл бол төвийг сахих бодлоготой холбоотойгоор арми, зэвсэгт хүчний асуудал нэлээн гарч ирж яригддаг. Төвийг сахисан бодлоготой улс орнууд өөрийн гэсэн армитай, өөрийн гэсэн зэвсэгт хүчинтэй байгаа. Гадны халдлагаас өөрийгөө хамгаалах чадавхтай байх хэрэгтэй. Энэ чадавхаа бид нар бий болгох хэрэгтэй. Бид өнөөдөр арми, цэрэг, зэвсэгт хүчнээ ийм чадавхтай гэж үздэг. Дээрээс нь НҮБ болон бусад улсаас тусламж хүсэх эрхтэй. Тэгэхээр энэ бүхэн бол манай цэргийн бодлогын үндэстэй нийцдэг юм.

Ер нь манай батлан хамгаалах салбар гурван бодлогыг хэрэгжүүлэх ёстой гэж би боддог. Улс орноо батлан хамгаалах бодлогоо хэрэгжүүлэх ёстой. Ард иргэдээ энэ үйлст зориулж бэлдэх ёстой. Дэлхий нийтэд энхийг сахиулах үйл ажиллагаанд идэвхтэй оролцох ёстой. Тэгэхээр энэ гурван бодлого бол манай батлан хамгаалах болон цэргийн бодлогын үндэс болж явдаг. Энэ нь эргээд түрүүчийн хэлсэн төвийг сахих бодлогын суурь болж байгаа юм. Гол агуулга нь эндээс гарч байгаа юм. Тэгэхээр үүнийг би өнөөдөр Монголын парламентын 25 жилийн ойн дээр бид нар 25 жил явж ирсэн зүйлээ улс төр сайн муу, алдаа оноогоо цаашаа яаж засах вэ, ямар бодлогоо яаж хэрэгжүүлэх вэ гэдгээ зарлаж байгаа энэ үед би түрүүчийн хоёр бодлоготойгоор үүнийг дамжуулж оруулж зарлаж байгаа юм.

Тавдугаарт, төвийг сахих бодлого гэдэг бол гадаад бодлогын үндсэн чиглэл байдаг. Гадаад бодлого гэдэг бол дотоод бодлогогүйгээр байхгүй. Тийм учраас энэ бол Монголын бодлогын хоёр тал юм. Төвийг сахисан бодлогыг бусад нь дэмжвэл бид баярлах болно, дэмжихгүй байлаа гээд эндээс болохгүй юм ерөөсөө гардаггүй. Тухайн улс орон л тухайн бодлогодоо засвар оруулах, тухайн бодлогоо зогсоох, тухайн бодлогоо үргэлжлүүлэх, тухайн бодлогоо тайлбарлах эрхтэй байдаг. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс зөвлөмж гарсан. Ойрын өдрүүдэд манай Засгийн газрын зүгээс төвийг сахих бодлогыг дэлхий нийтэд, олон улсын хэмжээнд зарлах байх.

Дараа нь Монгол Улс байнга төвийг сахих бодлогын тухай хуулийг Улсын Их Хуралд оруулж ирж батлуулна. Ингээд олон улсын түвшинд бид бусад оронтой хамтарч идэвхитэй ажиллах болно гэдгийг энд би хэлье гэж бодож байгаа юм. Энэ төвийг сахих бодлогыг явуулснаар Монгол Улс олон зүйлд өмнө нь явуулж байсан зуучлалын үйл ажиллагаа, эдийн засаг, санхүү, бусад зүйлүүд Монголыг анхаардаг, Монголд ажиллая гэсэн олон бодлогыг идэвхжүүлэхэд энэ бодлого хэрэг болно. Энэ хэрэгтэй юм гэж үзэж байгаа гэдгийг энд хэлье гэж бодож байна. Өнөөдөр энэ түүхэн гэж хэлж болохоор ойг тэмдэглэж байгаа энэ өдөр би гурван зүйлийн тухай маш тодорхой ярилаа. Хариуцлагатай, ёс зүйтэй улс төрийг хэрхэн бүрдүүлэх вэ? Гүйцэтгэх засаглалын бүтээлч, тогтвортой үйл ажиллагааг хэрхэн явуулах вэ? гэдгийг ярилаа. Монгол Улсын гадаад бодлогын үндсэн нэг зарчим болж хэрэгжиж ирсэн зүйлийг албан ёсоор статус нэрийг нь өгч тайлбарлаж хэллээ.

Эдгээр бодлогыг хэрэгжүүлэх нь манай ард түмний эрх ашигт бүрнээ нийцэх зүйл гэж би бодож байна. Тийм учраас эдгээр зүйлүүдийг зөвхөн яриад өнгөрөх биш, энэ бүхнийг хийж хэрэгжүүлэхийн төлөө бид идэвхтэй ажиллах хэрэгтэй. Ер нь Монголын ард түмний хөгжил дэвшил биднээс л шалтгаална. Монголын ард түмнээс, монгол хүнээс өөрөөс нь хамгийн их шалтгаалах болно гэдгийг би энд хэлэх нь зөв байх. Тийм учраас бүгдээрээ сая ярьсан зүйлүүдийг, олон зүйл хэлсэнгүй. Саяын ярьсан тоймтой гурван асуудлыг хэрэгжүүлэхийн төлөө идэвхтэй хамтарч ажиллацгаая. Баярлалаа.

\*\*\*

**УИХ -ын Хүндэтгэлийн хуралдаан дээр  
Улсын Их Хурлын дэд дарга Р.Гончигдоржийн хэлсэн үг**

(2015.09.13)

Монгол Улсын Ерөнхийлөгч өө,  
Монгол Улсын Их Хурлын дарга аа,  
Монгол Улсын Ерөнхий сайд аа,

Үндсэн хуулийн эцэг болсон Ардын Их Хурлын удирдлага болон үе үеийн Улсын Их Хурлын удирдлагууд, Улсын Бага Хурлын гишүүд, Улсын Их Хурлын гишүүд, эрхэм зочид та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлж, Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойн баярын мэндийг дэвшүүлье.

25 жилийн өмнө яг энэ өдөр 1990 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр Улсын Бага Хурал үйл ажиллагаагаа эхлүүлж, Улсын Бага Хурлын гишүүд андгай тангаргаа өргөн Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент үйл ажиллагаагаа эхэлсэн юм. Энэхүү ойг тохиолдуулан хүндэтгэлийн хуралдаан зохион байгуулж, Улсын Бага Хурлын гишүүд биднийг урин оролцуулж байгаад Улсын Улсын Их Хурлын дарга Танд талархаж байгаагаа Бага Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс илэрхийлье.

Улсын Бага Хурал нь 1990 оны ардчилсан хувьсгалын гол үр дүн болж, БНМАУ-ын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу хууль тогтоох, хянан шалгах, зохион байгуулах эрх бүхий төрийн эрх барих дээд байгууллага гэсэн статустайгаар бий болсон ийм түүхтэй. Тиймээс Улсын Бага Хурал өөрийнхөө үйл ажиллагааны нэг чиглэл бол энэ ард түмний сонголт болсон 1990 оны ардчилсан хувьсгалын ололтыг хууль эрх зүйн хувьд нэн тэргүүнд ханган биелүүлэхийн төлөө ажилласан юм. Энэ нь хувь хүний эрх, эрх чөлөөг ханган баталгаажуулах, нийгэм, эдийн засгийн зах зээлийн харилцааны анхлах зохицуулалтуудыг хийх, улс төрийн харилцааны шинэ төлөвлөлийг бий болгох ийм эрх зүйн зохицуулалтууд бидний чиг үүрэг байсан. Энэ дагуу бидний үйл ажиллагаа ирээдүйд гарч ирэх Монголын ардчилсан Үндсэн хуулийн үзэл санааны угтвар болгон хийгдэж байсан ийм түүхтэй юм.

Хоёрдугаарт, Улсын Бага Хурлын үндсэн үүрэг бол Монгол Улсын шинэ, ардчилсан Үндсэн хуулийг боловсруулан, ард нийтээр хэлэлцүүлж, Ардын Их Хурлаар батлуулах чиг үүрэгтэй. Ийм үүргийг Улсын Бага Хурлын гишүүд бидний үүрэг гэж хүлээн авч, энэ үүргээ хэрэгжүүлэхийн төлөө ажиллаж ирсэн юм. Өнөөдөр бидний дунд байхгүй ч гэсэн алд биеэ алжаан байж энэ их ажлаа хийж явсан тэр нөхдөө бид мартахгүй, тэр нөхдийг маань түүх мартахгүй юм.

Улсын Бага Хурал чухамхүү ийм л үүрэгтэй байсан учраас, ийм дуудлагыг хүлээж авсан учраас, ийм даалгаварыг хүлээн авсан учраас бидний ажиллагаа бас өвөрмөц байсан гэдгийг онцолж хэлмээр байна.

Яг энэ өдөр бид дэгийнхээ хуулийг баталж, дэгийнхээ хуулийн дагуу ажилласан. Гэхдээ бидний ажиллагааг дэг жолоодоогүй, бидний ажиллагааг бидний сэтгэл жолоодсон. Аливаа асуудал дээр зөвшилцлийг бий болгох тэр зүйлийг тухайн хуралдаан дээрээ дэг журмаараа тогтоож байсан. Энэ бол чухамхүү дэгээр тогтоохоос гадна чухам өөрсдийнхөө тухайн асуудал, тухайн нөхцөл байдалдаа тохируулан зөвшилцөл, ойлголцлыг бий болгох механизмыг бидний гол дэг хэмээн ингэж ажиллаж ирсэн гэдгийг онцлог болгож дурдаж хэлмээр байна.

Улсын Бага Хурал 1992 оны 01 дүгээр сарын 13-нд Ардчилсан шинэ Үндсэн хуулиа батлагдсаны дараагаар Үндсэн хуулийн хавсралтын тухай хуулийг оруулан батлуулж

үүгээрээ Улсын Их Хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлж эхэлсэн юм. Тийм учраас Улсын Бага Хурал бол Улсын Их Хурлын бүрэн эрхийг шилжүүлэн уламжлуулан хэрэглэж ирсэн гэдэг онцлогийг хэлмээр байгаа юм. Ингээд Улсын Бага Хурал 5 жилийн бүрэн эрхийн хугацаагаар сонгогдсон юм. Бид нар бүрэн эрх гэдэг бол үүргээ биелүүлэх, үүргээ биелүүлэхийн тулд зайлшгүй хангагдах эрхтэйгээр ажиллах гэдэг тийм ойлголттой байсан учраас бид үүргээ биелүүллээ.



**Улсын Их Хурлын дэд дарга Р. Гончигдорж**

Анхны ардчилал, зах зээлийн харилцааны сууриудыг тавилаа. Үндсэн хуулиа батлууллаа. Бид үүргээ хэрэгжүүллээ. Тийм учраас бид 5 жилийн эрхээ эдлэх гэж зүтгэхгүй ээ гэж. Яагаад гэвэл ийм эрх үүргийг ногдуулахад бидэнд өгсөн учраас бид энэ эрхээ дараагийн Их Хуралд нь шилжүүлэх ёстой. Ингэж эцэг парламентын хувьд дараагийн Их Хурлын хуулийг баталж, дараагийн Их Хурлын сонгуулийг баталж, дараагийн Их Хурлын үйл ажиллагаа явуулах зохион байгуулалтын бэлтгэлийг хангаж өгсөн ийм түүхтэй юм. Би энэ болгоныг хэлэхдээ Бага Хурлыг онцолж хэлж байгаа зүйл биш. Үе үеийн парламент ийм л зарчимтай, ийм л сэтгэлтэй, ийм л мандат буюу үүрэгтэйгээр ажиллаж ирсэн цаашдаа ч ажиллах болно гэж боддогийнхоо хувьд жишээ болгож хэлж байгаа гэдгийг онцолж хэлмээр байна.

Нэг зүйлийг бас онцолж хэлье гэж бодсон юм. Бага Хурлаас мал хувьчлах тухай шийдвэрийг гаргаж, иргэд өөрийн гэсэн малтай болсон. Үндсэн хуульд мал сүрэг бол Монгол Улсын баялаг бөгөөд төрийн хамгаалалтад байна гэсэн заалт орсон. Үүнийг би өнөөдөр яаж дурдаж байна вэ гэхээр Улсын Бага Хурал төрт ёсныхоо түүхэн уламжлалыг салган авч хэрэгжүүлсэн төдийгүй Монголынхоо соёл иргэншлийг хадгалж үлдэх, алдагдаж болзошгүй ирмэг дээр байсан тэр соёл иргэншлийг цааш нь баталгаажуулах суурийг бий болгосон гэж боддог юм. Өөрөөр хэлбэл, нүүдэлчин Монголын нүүдэлчин соёл иргэншлийг хадгалж явсан тэр уламжлал бол мал нь эзэнтэй болж, малчид нь малтай болж Монгол Улс нүүдэлчин орныхоо тэр шинэ соёлыг шинэ үедээ авч гарсан нь энэ өнөөдөр бидний бахархал, энэ өнөөдөр бидний энэ түүхэндээ бас бахархаж хэлж болох зүйл байсан юм гэдгийг онцолж хэлэх гэж байгаа юм. Үндсэн хуулийн тэр заалт бол үнэндээ бид нар малыг төрийн хамгаалалтад авсан тухай асуудал биш, нүүдэлчин Монголын соёл бидний соёл үеийн үед хадгалагдах ёстой гэсэн тэр том үзэл санаа гэдгийг өнөөдөр би энд онцолж хэлэхийг хүссэн зүйл байгаа юм.

Би монгол заншлаараа өнөө өглөө босоод бурхандаа зулаа өргөөд өндөр Гэгээний их эв эеийн тухай сургасан Жанлавцогзолыг уншаад тэгээд дотроо ерөөл бодсон. Энэ маань Монгол хүн бүрийнхээ сайн сайхны төлөө, Монгол Улсын хөгжлийн төлөө, үе үеийн парламент, парламентчид сэтгэлийнхээ, итгэлийнхээ нэгдлээр ухаанаа уралдуулж, үгүйсгэлийн биш үргэлжлэлийн бодлогоор авч яваасай, авч явах болно гэсэн ийм ерөөлийг би дотроо бодож ерөөсөн юм. Ингээд энэ ерөөл бат сайхан оршиг.

Монголын үе үеийн парламент монгол түмнийхээ бүрэн эрхийн төлөөлөн байж, тэднийхээ төлөө сайн сайхан бүхнийг бүтээж явах ерөөл орших болтугай гэж ерөөе. Та бүхэнд баярлалаа.

\* \* \*







**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2012 - 2016 ОНЫ БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦААНД ХЯНАН ШАЛГАХ ЧИГЛЭЛЭЭР  
ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТУХАЙ ТОВЧ ТООН ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын 2012 - 2016 оны бүрэн эрхийн хугацаанд хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэх хүрээнд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах болон хяналт шалгах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж ажиллах, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын удирдлагад тодорхой асуудлаар хандаж асуулга, бичгэн асуулт тавьж, хариуг авах, Ерөнхий сайдын мэдээллийг сонсох, холбогдох байгууллага, албан тушаалтны тайлан, мэдээлэл, илтгэлийг сонсох, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлээ.

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах ажлын талаар

2012 - 2016 онд Улсын Их Хурлын даргын захирамж, Байнгын хороодын тогтоолоор хянан шалгах болон хуулийн хэрэгжилттэй танилцах чиглэлээр 43 ажлын хэсэг байгуулагдаж, давхардсан тоогоор Улсын Их Хурлын 258 гишүүн ажилласан байна. Ажлын хэсгүүд нийт давхардсан тоогоор 54 аймаг, нийслэл, сум, дүүрэг, 131 яам, агентлаг, байгууллагын үйл ажиллагааны хүрээнд нийт 172 хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцсан байна. Ажлын хэсгүүдийн гаргасан 13 шалгалтын дүнг холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хурлын 1 тогтоол, Байнгын хорооны 8 тогтоол болон хуралдааны тэмдэглэлээр Засгийн газарт чиглэл өгч ажилласан байна.

Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан хянан шалгах 3 ажлын хэсэгт давхардсан тоогоор Улсын Их Хурлын 38 гишүүн ажилласан бөгөөд 3 яам, агентлагийн үйл ажиллагааны хүрээнд 4 хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгасан байна. Тухайлбал, Улсын Их Хурлын даргын 2012 оны 103 дугаар захирамжаар байгуулагдсан “Барилгын болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиуд, тэдгээртэй холбоотой бусад хууль тогтоомжийн биелэлтийг шалгаж, санал, дүгнэлт гаргах” үүрэг бүхий ажлын хэсэг нь санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороо, Нийгмийн бодлого, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны хамтарсан хурлаар хэлэлцүүлж, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2013 оны 20 дугаар тогтоолыг гаргуулж ажилласан байна.

Байнгын хороодын тогтоолоор хуулийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах чиглэлээр байгуулагдсан 40 ажлын хэсэгт давхардсан тоогоор Улсын Их Хурлын 220 гишүүн ажилласан байна.

Ажлын хэсгүүдийг Байнгын хороодоор нь авч үзвэл, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос 3, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос 6, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос 9, Өргөдлийн байнгын хорооноос 2, Төрийн байгуулалтын байнгын хорооноос 3, Төсвийн байнгын хорооноос 3, Хууль зүйн байнгын хорооноос 6, Эдийн засгийн байнгын хорооноос 5, Эдийн засгийн байнгын хороо болон Төсвийн байнгын хорооны хамтарсан 1, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос 2, Хүний эрхийн дэд хорооноос 1 ажлын хэсэг тус тус байгуулагдсан байна.

Тухайлбал, “Валютын ханш, бензин шатахууны үнийн өсөлтийн шалтгааныг судалж, цаашид авах арга хэмжээний талаар санал, дүгнэлт боловсруулах”, “Хууль зүйн

яам, түүний агентлагуудын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа болон хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг хэрхэн зохион байгуулж байгаатай танилцах”, “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай болон Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх явцад болон холбогдох хууль тогтоомжоор Засгийн газрын эрх бүхий байгууллагуудад олгогдсон эрх, үүргийн хэрэгжилттэй танилцаж санал, дүгнэлт боловсруулах” зэрэг 40 ажлын хэсэг ажиллаж, Байнгын хорооны 8 тогтоол болон хуралдааны тэмдэглэлээр шийдвэр гаргуулсан байна.

Мөн Эдийн засгийн байнгын хороо болон Төсвийн байнгын хорооны 2015 оны хамтарсан 01/02 дугаар тогтоолоор байгуулагдсан “Олон улсын зах зээлд гаргасан Засгийн газрын үнэт цаасны арилжаагаар төвлөрсөн хөрөнгийн зарцуулалт, эргэн төлөлт болон санхүүжүүлсэн хөтөлбөрийн сонголт, хэрэгжилтийн явц байдалтай танилцаж санал, дүгнэлт гаргах”, Төсвийн байнгын хорооны 2015 оны 07 дугаар тогтоолоор байгуулагдсан “Хөрөнгийн зах зээл дэх мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаанд ашиглагдаж буй программ хангамжийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, Лондонгийн хөрөнгийн бирж болон Сангийн яамны хооронд байгуулсан “Стратеги түншлэлийн хамтын ажиллагааны гэрээ”-ний хэрэгжилтийн явц байдлыг шалгаж Засгийн газарт чиглэл өгөх”, Хууль зүйн байнгын хорооны 2015 оны 30 дугаар тогтоолоор байгуулагдсан “Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх”, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны 2015 оны 01 дүгээр тогтоолоор байгуулагдсан “Нийслэлийн 2015 - 2016 оны төсвийн төлөвлөлт, 2015 оны төсвийн урсгал зардал, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хяналт шалгалт хийх” үүрэг бүхий 4 ажлын хэсэг нь явц байдалтай танилцах, санал, дүгнэлтээ нэгтгэн боловсруулах шатандаа ажиллаж байна.

## 2. Улсын Их Хурлын гишүүдээс тавьсан асуулга, асуултын талаар

Парламентын хянан шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлэх нэг гол хэлбэр болох Улсын Их Хурлын гишүүдээс асуулга, бичгэн асуулт тавих, хариуг нэгдсэн болон Байнгын хороодын хуралдаанаар сонсох үйл ажиллагаа нь Улсын Их Хурлын 2012 - 2016 оны бүрэн эрхийн хугацаанд идэвхжсэн байна.

2012 - 2016 онд давхардсан тоогоор Улсын Их Хурлын 214 гишүүн 488 асуудлыг хамруулсан 132 удаагийн асуулгыг Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдээс гадна Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны болон Сонгуулийн ерөнхий хорооны дарга нарт тавьсан байна. Нэгдсэн хуралдаанаар 37 асуулгын хариуг сонссон бөгөөд энэ үеэр давхардсан тоогоор Улсын Их Хурлын 266 гишүүн 742 орчим аман асуулт тавьж, хариулт авсан байна.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт 19, Л.Энх-Амгалан 13, Г.Уянга 9, Ж.Батзандан 7 удаа Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын удирдлагад хандан эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлаар асуулга тавьж, хариуг нэгдсэн хуралдаанаар сонссон байна. 2012 - 2016 онд давхардсан тоогоор Улсын Их Хурлын 33 гишүүн 82 асуудлыг хамруулсан 27 удаагийн бичгэн асуултыг тавьж, 3 асуултын хариуг холбогдох Байнгын хорооны хуралдаанаар сонссон байна.



### 3. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийн хийсэн мэдээллийн талаар

Улсын Их Хурлын 2012-2016 оны бүрэн эрхийн хугацаанд Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийн нийт 43 удаагийн мэдээллийг сонсож, мэдээлэлтэй холбогдуулан давхардсан тоогоор Улсын Их Хурлын 387 гишүүн 1079 аман асуулт асууж, хариулт авсан байна.

Улсын Их Хурлын Байнгын болон дэд хороод өөрсдийн эрхлэх асуудлын хүрээний яам, агентлаг, газруудын үйл ажиллагааны талаарх мэдээллийг тусгайлан авч хэлэлцэж, тодорхой үүрэг чиглэл өгөх ажлын хүрээнд Байнгын болон дэд хороодын хуралдаанаар нийт 81 удаа мэдээлэл сонсож, мэдээлэлтэй холбогдуулан давхардсан тоогоор Улсын Их Хурлын 463 гишүүн 1186 аман асуулт асууж, хариулт авсан байна.

### 4. Хууль тогтоомжоор Засгийн газарт өгөгдсөн үүргийн хэрэгжилтийн талаар

Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хороодын тогтоолоор Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд хууль хэрэгжүүлэхтэй нийцүүлэн холбогдох дүрэм, журам, жагсаалтыг батлан гаргах тусгайлан эрх олгож, үүрэг, чиглэл өгдөг. Ийнхүү эрх олгосон, үүрэг, чиглэл өгсөн хууль тогтоомжийн мэдээллийн санг 2013 оноос шинэчлэн бүртгэж, тэдгээрийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан байна.

2013 онд 40 хуулийн 189 заалтыг, Улсын Их Хурлын 8 тогтоолын 61 заалтыг, Байнгын хорооны 43 тогтоолын 274 заалтыг мэдээллийн санд бүртгэж хяналтанд авч эхэлснээс хойш тогтмол баяжуулснаар 2015 оны байдлаар 128 хуулийн 334 заалтыг, Улсын Их Хурлын 85 тогтоолын 270 заалтыг, Байнгын хорооны 76 тогтоолын 373 заалтыг хяналтад аваад байна.

Улсын Их Хурлын 2012-2016 оны бүрэн эрхийн хугацаанд хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар хагас жил тутам мэдээлэл сонсож, хэлэлцүүлэг хийсэн байна. 2015 оны байдлаар Улсын Их Хурлаас батлагдсан хууль тогтоомжоор Засгийн газарт үүрэг, чиглэл өгөгдсөн заалтын хэрэгжилтийг авч үзвэл, давхардсан тоогоор 64 хуулийн 143 заалт, Улсын Их Хурлын 58 тогтоолын 139 заалт, Байнгын хорооны 31 тогтоолын 119 заалт бүрэн хэрэгжсэн байна.

Улсын Их Хурлын 2012 - 2016 оны бүрэн эрхийн хугацаанд Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудын үйл ажиллагааны тайлан, илтгэлийг холбогдох Байнгын хорооны хуралдаанаар давхардсан тоогоор 71 удаа сонссон байна.

Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 05 дугаар тогтоолын дагуу Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагууд үйл ажиллагааны тайландаа системчилсэн үнэлгээ хийж ирүүлсэн эсэхэд Хяналт үнэлгээний хэлтэс хяналт тавьж, санал, дүгнэлтээ холбогдох Байнгын хороодод хүргүүлж ажилласан.

### 5. Төсвийн хяналт, шинжилгээний талаар

Монгол Улсын Их Хурлын 2012 - 2016 оны бүрэн эрхийн хугацаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт үнэлгээний хэлтсийн Төсвийн шинжилгээний хэсэг нь эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, мөнгөний бодлого болон төсвийн төсөл хэлэлцэх, төсвийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, үр нөлөөг дээшлүүлэхэд

туслах, судалгаа, дүн шинжилгээ хийх, танилцуулга бэлтгэж бодлогын зөвлөмж, санал, дүгнэлт боловсруулах ажлыг гүйцэтгэж байна.

6. Дүн шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэх хүрээнд:

2012-2016 онд төсвийн хүрээний мэдэгдэлд 9, улсын төсвийн төсөлд 4, төсвийн тодотголд 6, төсвийн гүйцэтгэлд 5, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт болон төсөлд 8, төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн төсөлд 4 удаа тус тус дүн шинжилгээ хийж танилцуулга бэлтгэн холбогдох Байнгын хороодод хүргүүлсэн байна. Үүнд:

- Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл нь Монгол Улсын “Төсвийн тогтвортой байдлын тухай” хуульд заасан төсвийн тусгай шаардлагыг хангасан эсэх талаар зөвлөмж;
- Тухайн жилийн төсвийн төсөл нь төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлтэй хэрхэн уялдаж байгаа талаар санал, дүгнэлт;
- Монгол Улсын нэгдсэн төсвийн төсөл, тодотгол болон төсвийн гүйцэтгэлд хийсэн тооцоо судалгаа, танилцуулга;
- Байнгын хороодын эрхлэх асуудлын хүрээн дэх төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн төсөл, тодотгол болон төсвийн гүйцэтгэлд хийсэн тооцоо судалгаа, танилцуулга;
- Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн талаарх дэлгэрэнгүй судалгаа, танилцуулга;
- Төсвийн орлого, зарлага, тэнцэл, санхүүжилтийн эх үүсвэр болон төсвийн өр төлбөр, тэдгээрийн талаар судалгаа, дүгнэлт;
- Голлох эрдсийн бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнэ, төсвийн орлогын талаарх судалгаа;
- Дэлхийн болон хөрш орнуудын эдийн засгийн байдал, Монгол Улсын макро эдийн засгийн өнөөгийн байдал, ирэх жилүүдийн хандлага, макро эдийн засгийн тогтвортой байдалд төсвийн бодлогын нөлөөллийн талаарх дүн шинжилгээ;
- Улсын Их Хуралд өргөн мэдүүлэгдсэн хууль тогтоомжийн төсөлд хавсаргасан зардлын тооцоонд хийсэн дүн шинжилгээ, танилцуулга.

\* \* \*



**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2012 - 2016 ОНЫ БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦААНД  
ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЛААРХ СТАТИСТИК МЭДЭЭ**

Д/д	Чиглэлүүд	2012	2013	2014	2015	2016	Дүн
1	Төсвийн хүрээний мэдэгдэл, төсөөлөл	-	2	3	3	1	9
2	Төсвийн төсөл	1	1	1	1	-	4
3	Төсвийн тодотгол	-	2	2	2	-	6
4	Төсвийн гүйцэтгэл	1	1	1	1	1	5
5	Үндсэн чиглэлийн хэрэгжилт	-	1	1	1	1	4
6	Үндсэн чиглэлийн төсөл	-	1	1	1	1	4
7	Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл	1	1	1	1	-	4
8	Өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төсөлд хавсаргасан зардлын тооцоонд хийсэн дүн шинжилгээ	-	7	13	6		26

\* \* \*

Сангийн яамнаас Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг сар бүр хүлээн авч дүн шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэн дотоод сүлжээ болон [www.parliament.mn](http://www.parliament.mn) цахим хуудсанд байршуулж, төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн гүйцэтгэлийг Байнгын хороодод хүргүүлж Улсын Их Хурлын гишүүдийг мэдээллээр хангаж ажилласан байна.

Улсын төсөвт тухайн төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагын төвлөрүүлэх орлого болон батлагдсан төсвийн зарцуулалт, төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайлангийн талаарх мэдээллийг шилэн дансны нэгдсэн систем /цахим хуудас/ -ээс авч Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна.

\* \* \*

УЛСЫН ИХ ХУРЛЫН 2012 - 2016 ОНЫ БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦААНД УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ, БАЙНГЫН ХОРООДЫН ТОГТООЛООР БАЙГУУЛАГДАЖ, ХЯНАН ШАЛГАХ БОЛОН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ТАНИЛЦСАН АЖЛЫН ХЭСГИЙН ТАЛААРХ СТАТИСТИК МЭДЭЭ

(2012.10.01 - 2016.05.24)

Д/д	Ээлжит чуулган	Зохион байгуулсан хяналт шалгалт	Оролцсон Улсын Их Хурлын гишүүд	Хэрэгжилтийг шалгасан		Шалгалтад хамрагдсан байгууллага				Шалгалтын дүнг хэлэлцсэн байдал		Гаргасан тогтоол, шийдвэр	
				Хууль	Тогтоол	Аймаг, нийслэл	Сум, дүүрэг	Яам	Агентлаг, байгууллага	Нэгдсэн хуралдаанаар	Байнгын ба дэд хорооны хуралдаанаар	Улсын Их Хурлын	Байнгын хорооны
1	Улсын Их Хурлын 2012 оны намрын чуулган	8	44	29	-	3	-	5	13	-	1	1	2
2	Улсын Их Хурлын 2013 оны хаврын чуулган	10	66	18	2	17	24	17	13	-	2	-	-

3	Улсын Их Хурлын 2013 оны намрын чуулган	5	51	26	9	4	6	6	21	-	-	-	1
4	Улсын Их Хурлын 2014 оны хаврын чуулган	4	25	12	6	-	-	2	6	-	1	-	1
5	Улсын Их Хурлын 2014 оны намрын чуулган	7	36	27	3	-	-	7	15	-	2	-	2
6	Улсын Их Хурлын 2015 оны хаврын чуулган	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
7	Улсын Их Хурлын 2015 оны намрын чуулган	9	36	22	18	-	-	5	21	-	7	-	2
8	Улсын Их Хурлын 2016 оны хаврын чуулган	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн		43	258	134	38	24	30	42	89	-	13	1	8

\*\*\*

**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2012 - 2016 ОНЫ БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦААНД  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДЭЭС ТАВЬСАН АСУУЛГЫН ТАЛААРХ СТАТИСТИК МЭДЭЭ**

(2012.10.01 - 2016.05.24)

Д/д	Ээлжит чуулган	Нийт асуулга (давхардсан тоогоор)	Асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүд	Асуулгад хамрагдсан асуудал	Бичгээр ирүүлсэн асуулгын хариу	Хариуг нэгдсэн хуралдаанаар сонссон байдал (тоогоор)	Нэгдсэн хуралдаан дээр асуусан аман асуулг (гишүүн/асуулг)
1	Улсын Их Хурлын 2012 оны намрын чуулган	17	31	78	12	5	42/123
2	Улсын Их Хурлын 2013 оны хаврын чуулган	17	27	102	15	5	46/134
3	Улсын Их Хурлын 2013 оны намрын чуулган	23	25	68	16	7	49/134
4	Улсын Их Хурлын 2014 оны хаврын чуулган	13	17	48	12	4	19/60
5	Улсын Их Хурлын 2014 оны намрын чуулган	15	32	37	11	2	11/27
6	Улсын Их Хурлын 2015 оны хаврын чуулган	17	32	55	11	3	31/67
7	Улсын Их Хурлын 2015 оны намрын чуулган	21	41	66	19	5	31/85
8	Улсын Их Хурлын 2016 оны хаврын чуулган	9	9	34	9	6	37/112
Нийт дүн		132	214	488	105	37	266/742

\*\*\*



**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2012 - 2016 ОНЫ БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦААНД  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДЭЭС БИЧГЭЭР ТАВЬСАН АСУУЛТЫН ТАЛААРХ СТАТИСТИК МЭДЭЭ**

(2012.10.01 - 2016.05.24)

Д/д	Ээлжит чуулган	Нийт асуулт (давхардсан тоогоор)	Асуулт тавьсан Улсын Их Хурлын гишүүд	Асуултад хамрагдсан асуудал	Бичгээр ирүүлсэн асуултын хариу	Хариуг Байнгын хорооны хуралдаанаар сонссон байдал (тоогоор)	Тайлбар
1	Улсын Их Хурлын 2012 оны намрын чуулган	11	11	30	9	1	НББСШУБХ /2012.12.19/
2	Улсын Их Хурлын 2013 оны хаврын чуулган	1	1	3	1	1	АБГББХ /2013.04.10/
3	Улсын Их Хурлын 2013 оны намрын чуулган	5	7	20	3	1	НББСШУБХ /2014.01.22/
4	Улсын Их Хурлын 2014 оны хаврын чуулган	3	3	10	3	-	-
5	Улсын Их Хурлын 2014 оны намрын чуулган	2	4	5	1	-	-
6	Улсын Их Хурлын 2015 оны хаврын чуулган	2	2	6	2	-	-
7	Улсын Их Хурлын 2015 оны намрын чуулган	1	1	3	1	-	-
8	Улсын Их Хурлын 2016 оны хаврын чуулган	2	4	5	2	-	-
Нийт дүн		27	33	82	22	3	

\* \* \*

**УЛСЫН ИХ ХУРЛЫН НЭГДСЭН ХУРАЛДААНД СОНССОН ЕРӨНХИЙ САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН  
ГИШҮҮНИЙ МЭДЭЭЛЭЛ, АМАН АСУУЛТЫН ТАЛААРХ СТАТИСТИК МЭДЭЭ**

(2012.10.01 - 2016.05.24)

Д/д	Мэдээллийн сэдэв	Мэдээлэл хийсэн		Асуулт, санал тавьсан гишүүд	Асуулт, саналын тоо
		Албан тушаалтан	Огноо		
1	Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг	2012.10.05	10	31
2	Гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах талаар Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, үйл ажиллагааны талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг	2012.11.02	9	19
3	Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийг ашиглах талаар Засгийн газраас баримталж байгаа бодлогын талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг	2012.11.02	4	11
4	Олон улсын зах зээл дээр арилжаалсан 1.5 тэрбум америк долларын үнэт цаасны талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг	2012.12.07	12	26
5	Жижиг, дунд үйлдвэрийн талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаашид дэвшүүлж буй зорилтын талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг	2012.12.21	9	28
6	Цаг үеийн асуудал, хаврын бүтээн байгуулалтын бэлтгэл ажлын талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг	2013.01.04	8	25
7	Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн байдлын талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг	2013.01.18	18	60
8.	Оюутолгой” төслийн талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг	2013.02.01	12	54
9	Монгол Улсын эдийн засгийн төлөв байдлын талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг	2013.04.19	6	17
10	Засгийн газрын 1.5 тэрбум америк долларын үнэт цаасны зарцуулалтын талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг	2013.05.17	7	20
11	Барилга, хот байгуулалтын салбарын бүтээн байгуулалтын талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг	2013.05.31	6	20
12	Цаг үеийн асуудлаар	Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг	2013.06.07	7	19
13	Цаг үеийн асуудлаар	Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг	2013.07.05	6	28

14	Цаг үеийн асуудлаар	Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг	2013.10.04	9	24
15	Үнэ тогтворжуулах дэд хөтөлбөрүүдийн талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг	2013.10.18	3	12
16	Чингис бондын зарцуулалт, Монгол Улсын гадаад өр, төлбөрийн талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг	2013.11.01	5	16
17	“Гудамж” төсөл болон улсын чанартай автозамын талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг	2013.11.15	11	32
18	“Нээлттэй ухаалаг төр лүү” хийгдэж буй ажлуудын талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг	2013.11.29	8	17
19	Цаг үеийн асуудлаар	Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг	2013.12.06	13	38
20	“Хөдөлмөр эрхлэлт-2013”	Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг	2013.12.20	-	-
21	Шинэчлэлийн Засгийн газрын 2013 оны үйл ажиллагаа болон 2014 оны төлөвлөгөөний талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг	2014.01.17	1	1
22	Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлын талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг	2014.04.18	14	28
23	Чингис бондын эх үүсвэрээр санхүүжиж буй төслүүдийн талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг	2014.05.02	10	36
24	Эдийн засгийг эрчимжүүлэх 100 хоногийн ажлын талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг	2014.05.16	3	5
25	2013 оны улсын төсвөөс Ерөнхий сайдын багцад хуваарилагдсан 50 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зарцуулалт, ажлын гүйцэтгэлийн талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг	2014.06.06	12	18
26	“Эзэн-100” хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг	2014.06.20	13	24
27	Эдийн засгийг эрчимжүүлэх 100 хоногийн хүрээнд хийсэн ажлуудын талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг	2014.10.03	11	43
28	Монгол Улсын макро эдийн засгийн байдал 2014 оны эхний 9 сарын байдлаар	Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг	2014.10.17	8	28
29	Цаг үеийн асуудлаар	Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг	2014.12.19	30	90

30	Нийгэм, эдийн засгийн голлох тоон үзүүлэлтийн талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг	2015.02.06	12	18
31	Татварын эрх зүйн орчин, цаашид авах арга хэмжээний талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг	2015.05.01	10	45
32	Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн хэлэлцүүлгийн явцын талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг	2015.05.15	7	21
33	Монгол Улсын Засгийн газраас иргэдийг орон сууцжуулах бодлогын хүрээнд авч хэрэгжүүлж байгаа зарим арга хэмжээний талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг	2015.06.05	9	18
34	Өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг	2015.10.02	15	31
35	Цацраг идэвхт ашигт малтмалыг эдийн засгийн эргэлтэд оруулах талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг	2015.10.16	Хаалттай	
36	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг	2015.11.06	8	17
37	Цаг үеийн асуудлаар	Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг	2015.11.20	2	4
38	Засгийн газрын нийгмийн даатгалын салбарт авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг	2015.12.04	7	19
39	Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн явцын талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг	2015.12.18	8	21
40	Монгол Улсын Засгийн газраас 2015 онд эрчим хүчний салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг	2016.01.15	10	32
41	Цаг үеийн асуудлаар	Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг	2016.02.05	2	3
42	Монгол Улсын нийт гадаад өр, Засгийн газрын өрийн талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг	2016.04.15	8	23
43	Засгийн Газраас малчдын талаар авсан арга хэмжээ болон малчны зээлийн хүүг бууруулж буй ажлын талаар	Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг	2016.05.13	3	6
Нийт 43 удаа				387	1079

\*\*\*



**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2012 - 2016 ОНЫ БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦААНД  
УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН БОЛОН ДЭД, ТҮР ХОРООДОД СОНССОН МЭДЭЭЛЛИЙН ТАЛААРХ  
СТАТИСТИК МЭДЭЭ**

(2012.10.01 - 2016.05.24)

№	Мэдээлэл хийсэн албан тушаалтан	Мэдээллийн сэдэв	Хорооны нэр, мэдээлэл сонссон огноо	Асуулт, санал тавьсан гишүүд	Асуулт, саналын тоо
1	Монголбанкны Ерөнхийлөгч Л.Пүрэвдорж	Монголбанкны мэдээлэл	ЭЗБХ 2012.10.03	9	9
2	“Эрдэнэс Таван толгой” ХК-ний гүйцэтгэх захирал Б.Энэбиш	“Эрдэнэс Таван толгой” ХК-ний мэдээлэл	ЭЗБХ 2012.10.10	6	6
3	Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан	Санхүүгийн зохицуулах хорооны мэдээлэл	ЭЗБХ 2012.10.31	4	4
4	МИАТ ХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Орхон	МИАТ ХК-ийн үйл ажиллагааны явц байдал, 2013 онд баримтлах үндсэн чиглэлийн талаар	ЭЗБХ 2012.10.31	6	6
5	Гадаад харилцааны сайд Л.Болд	Монгол Улсын гадаад бодлого, хилийн чанад дахь монгол иргэдийн эрхийг хамгаалах тухай	АБГББХ 2012.11.20	9	11
6	Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан	Хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааны явц байдлын талаар	ЭЗБХ 2012.12.05	5	5
7	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга	Мал хамгаалах сан болон тариалалтыг дэмжих сангийн үйл ажиллагааны талаар	БОХХААБХ 2013.01.09	7	12
8	Уул уурхайн сайд Д.Ганхуяг	“Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай” Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаар	ЭЗБХ 2013.01.09	6	6
9	Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Бямбадорж	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаар Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэл	ХЗБХ 2013.01.09	7	12
10	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга	Мал хамгаалах сан болон Тариаланг дэмжих сангийн үйл ажиллагааны талаар	БОХХААБХ 2013.01.09	10	22
11	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун	Байгаль хамгаалах сан болон Цэвэр агаар сангийн талаарх танилцуулга, тэдгээрийн хөрөнгийн зарцуулалт, цаашид авах арга хэмжээний талаар	БОХХААБХ 2013.01.15	6	14
12	Зам, тээврийн сайд А.Гансүх	“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолын хэрэгжилтийн явц, байдлын талаар	ЭЗБХ 2013.01.16 /хаалттай/	12	24
13	Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг	Зарим аймгийн Засаг даргын томилгооны талаар	ТББХ 2013.01.06	9	25
14	Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл	Улаанбаатар хотын газар өмчлөлийн өнөөгийн байдал, хотын дэд бүтэц, дахин төлөвлөлтийн талаар	БОХХААБХ, ЭЗБХ 2013.01.29	11	22

15	Уул уурхайн сайд Д.Ганхуяг	Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийн өнөөгийн байдлын талаар	ЭЗБХ 2013.01.30	9	9
16	Зам, тээврийн сайд Х.Ержан, Нийслэлийн Засаг даргын экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч Т.Бат-Эрдэнэ	Авто тээврийн хэрэгслээс ялгарах нүүрс хүчлийн хийг багасгах талаар	БОХХААБХ 2013.02.05	2	6
17	Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн дарга Р.Жигжид	Нийслэлд нийлүүлэгдэж байгаа утаагүй түлшний хангалт, стандарт болон түлшний үйлдвэрийн ажлын явц, шинээр баригдах түлшний төсөл, технологийн туршилтын талаар	БОХХААБХ 2013.02.05	2	6
18	Монголбанкны Ерөнхийлөгч Н.Золжаргал	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2012 онд баримтлах үндсэн чиглэлийн биелэлт болон Монголбанкнаас зарим яамдтай хамтран хэрэгжүүлэхээр тохиролцсон дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц байдлын талаар	ЭЗБХ 2013.04.09	4	6
19	Үндэсний аудитын газрын дарга А.Зангад	Үндэсний аудитын газрын 2012 оны үйл ажиллагааны тайлан	ТБХ 2013.04.16	14	21
20	Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөр	Сургалтын төрийн сангийн төсвийн хөрөнгийн зарцуулалт, гадаадад суралцагсдын зээл, түүний эргэн төлөлтийн талаар	НББСШУБХ, ТБХ 2013.04.16	16	28
21	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга	Мал аж ахуйн салбарын өнөөгийн байдлын талаар	БОХХААБХ 2013.04.16	4	13
22	Зам, тээврийн сайд Л.Гансүх	Улсын төсвийн болон Хөгжлийн банкны санхүүжилтээр 2013 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний бэлтгэл ажлын явц байдлын талаар	ЭЗБХ 2013.04.22	10	22
23	Уул уурхайн сайд Д.Ганхуяг	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ний үйл ажиллагаа, тулгамдаж байгаа асуудлын талаар	ЭЗБХ 2013.05.01	7	12
24	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга	Тариалалтын бэлтгэл ажил, мал төлөвлөлтийн өнөөгийн байдлын талаар	БОХХААБХ 2013.05.01	4	14
25	Эрүүл мэндийн сайд Н.Удвал	Эмнэлгийн барилгын өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай	НББСШУБХ 2013.05.01	12	12
26	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун, Уул уурхайн сайд Д.Ганхуяг	Уул уурхайн яамнаас нөхөн сэргээлтийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай	БОХХААБХ 2013.05.08	5	26
27	Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг	Дорноговь аймагт ажилласан ажлын хэсгийн тайлан	БОХХААБХ 2013.05.08	6	22
28	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Гүнбазар	Баянхонгор аймгийн Баянхонгор, Баян-Овоо зэрэг сумын нутаг дэвсгэрт мөнгөн ус илэрсэн талаар	БОХХААБХ 2013.05.08	5	16
29	Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан	Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны үйл ажиллагааны тайлан	ЭЗБХ 2013.05.14	3	4

30	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун	Импортын мод, модон материалын талаар баримталж байгаа бодлого, арга хэмжээ нь Монгол Улсын ойн нөөцийг хамгаалахад үзүүлэх нөлөөллийн талаар	БОХХААБХ 2013.05.15	9	33
31	Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан	Импортын барилгын модон материалыг нийлүүлэх талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай	БОХХААБХ 2013.05.15	1	1
32	Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Батболд, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Дэлгэрцогт	Тав дугаар цахилгаан станц барих газар сонголтын талаар	БОХХААБХ 2013.05.22	6	22
33	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэ	Нийгмийн хамгааллын салбарын шинэчлэлийн хөтөлбөрийн талаар	НББСШУБХ 2013.05.28	6	22
34	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга	Хүнд, хөнгөн аж үйлдвэрийн талаар	ЭЗБХ 2013.11.15 4	4	4
35	Соёл, спорт, аялал жуулчлалын сайд Ц.Оюунгэрэл	Хүүхэд, залуучуудыг хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар	НББСШУБХ 2013.12.17	9	17
36	Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөр	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын шинэ дүрэмт хувцасны үйлдвэрлэлийн явц, чанар, үнэ, борлуулалтын талаар	НББСШУБХ 2013.12.23	6	3
37	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун	Ус болон уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны 2013 оны төсөв, үндсэн чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан	БОХХААБХ 2013.12.25	6	19
38	Хөдөлмөрийн сайд Я.Санжмятав	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудлаар дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилтийн өнөөгийн байдал, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй үндэсний болон олон улсын төсөл, хөтөлбөрүүдийн үр дүн, санхүүжилт, тулгамдсан асуудлуудыг хэрхэн шийдвэрлэж байгаа болон цаашид авах арга хэмжээний талаар	НББСШУБХ 2014.01.06	4	2
39	Гадаад харилцааны сайд Л.Болд	Цөмийн зэвсгээс ангид байх тухай Монгол Улсын хууль тогтоомжийн талаар	АБГББХ 2014.01.08	1	2
40	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны 2013 оны жилийн төсөв, үндсэн чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг /"Монгол мал" үндэсний хөтөлбөр/-ийн хэрэгжилтийн тайлан	БОХХААБХ 2014.01.14	8	21
41	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга	Хөгжлийн бодлого төлөвлөлтийг боловсронгуй болгох тухай тогтоолын төсөл. Төрөөс үйлдвэр, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын талаар	БОХХААБХ 2014.01.14	6	19

42	Монгол Улсаас Япон улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд С.Хүрэлбаатар	Монгол-Японы эдийн засгийн хамтын ажиллагааны өнөөгийн байдал, тулгамдсан асуудлын талаар	ЭЗБХ 2014.04.09	4	13
43	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Я.Батсуурь	“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн талаар	ЭЗБХ 2014.04.15	8	23
44	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэ	Нийгмийн даатгалын орлого, зарлагын дүн, хүн амын бүтцийн насжилтын нөлөөлөл, санхүүгийн ачааллын тооцоо, ирээдүйн төсөөллийн талаар	ӨБХ 2014.04.30	5	16
45	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга	Хаврын тариалалтын бэлтгэл ажлын талаар	БОХХААБХ 2014.04.16	7	30
46	Үйлдвэр, хөдөө аж ахуйн дэд сайд Ц.Туваан	Ноолуурын салбарын бодлогын хэрэгжилтийн талаар	БОХХААБХ 2014.05.14	4	14
47	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар	Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх, төрийн албыг шуурхай, ил тод болгох чиглэлээр хийсэн ажлын талаар	ТББХ 2014.06.03	12	22
48	Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр	Засгийн газраас Үнэт цаасны арилжаагаар төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт, төслийн сонголт, хэрэгжилтийн талаар	ЭЗБХ 2014.05.14	2	11
49	Эрүүл мэндийн сайд Н.Удвал	Эрүүл мэндийн салбарын асуудлаар ирүүлсэн иргэдийн өргөдөлтэй холбогдуулан хийсэн мэдээлэл	ӨБХ 2014.06.17	6	16
50	Гадаад харилцааны сайд Л.Болд	Монгол Улсаас Зүүн хойд Азийн орнуудад суугаа элчин сайд нарын зөвлөгөөний талаар	АБГББХ 2014.06.17		
51	Үйлдвэр, хөдөө аж ахуйн дэд сайд Б.Цогтгэрэл	Намрын ургац хураалтын талаар	БОХХААБХ 2014.10.08	16	49
52	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун	“Монгол орны ойн цэвэрлэгээний талаар авах арга хэмжээний тухай” БОХХААБХ-ны 2014 оны 04 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаар	БОХХААБХ 2014.10.08	4	10
53	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун	Туул голын бохирдлын эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар	БОХХААБХ 2014.10.08	7	19
54	Эрүүл мэндийн сайд Н.Удвал	Эбола вирус, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж байгаа талаар	НББСШУБХ 2014.10.22	5	20
55	Гадаад харилцааны яам, Батлан хамгаалах яам	Бүтцийн талаар	АБГББХ 2015.01.28	-	-
56	Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа	Тариаланчид, гурил үйлдвэрлэгчид, Хүнс, хөдөө аж ахуйн яамыг оролцуулан цаг үеийн асуудлаар	БОХХААБХ 2015.02.03	6	18
57	Хөдөлмөрийн сайд С.Чинзориг	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар	ӨБХ 2015.04.08	3	10
58	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт	Төрийн өмч хувьчлалын үйл явц, үр дүн, цаашдын зорилтын талаар	ӨБХ 2015.04.08	4	9

59	Эрүүл мэнд, спортын сайд Г.Шийлэгдамба	“Эмнэлгийн барилга, эзэмшил газрын талаар цаашид авах арга хэмжээний тухай” НББСШУБХ-ны 2014 оны 09 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаар	НББСШУБХ 2015.04.15	9	25
60	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол	Байгаль орчны төлөв байдлын 2013, 2014 оны тайлан	БОХХААБХ 2015.04.29	6	41
61	Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх	Зарим аймагт тохиолдсон байгалийн гамшигт үзэгдэл, цасан шуурга болон хээрийн түймэртэй тэмцэх, хор хохирлыг барагдуулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар	БОХХААБХ 2015.04.29	9	33
62	Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа	Хаврын тариалалтын бэлтгэл ажлын талаар	БОХХААБХ 2015.04.29	5	29
63	Эрүүл мэнд, спортын яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн талаар	НББСШУБХ 2015.06.15	5	11
64	Гадаад харилцааны сайд Л.Пүрэвсүрэн	Гадаад хэргийн яамны 2015 оны хагас жилийн тайлан	АБГББХ 2015.07.01	5	13
65	Барилга, хот байгуулалтын сайд Д.Цогтбаатар, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа	Газар ашиглалт, хамгаалалтын өнөөгийн байдлын талаар	БОХХААБХ 2015.07.08	2	13
66	Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа	Намрын ургац хураалтын талаар	БОХХААБХ 2015.10.07	3	15
67	Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа	Үнэ тогтворжуулах дэд хөтөлбөрийн хүрээнд гурил үйлдвэрлэгчдэд үзүүлсэн зээл тусламжийн эргэн төлөлт, ОХУ-аас буудай импортлох, хивэг экспортлох талаар	БОХХААБХ 2015.10.20	2	3
68	Барилга, хот байгуулалтын яамны Барилга нийтийн аж ахуйн газрын орлогч дарга Р.Эрдэнэцэцэг	Цэвэрлэх байгууламжийн өнөөгийн байдлын талаар	БОХХААБХ 2015.10.30	3	12
69	Монгол Улсын Ерөнхийлөгч	Монгол Улс байнга төвийг сахих байр суурийн талаар	АБГББХ 2015.11.04	Хаалттай	
70	Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн Усны секторын эрхлэгч Г.Даваа	Говийн бүсийн усан хангамжийг сайжруулах, цөлжилтийг сааруулах “Ногоон говь” хөгжлийн төслийн талаар	БОХХААБХ 2015.11.05	5	13
71	Мал эмнэлэг, үржлийн газрын дарга М.Галбадрах	Бүгд Найрамдах Унгар улсын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд “Биокомбинат” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг шинэчлэх төслийн талаар	БОХХААБХ 2015.11.24	6	19

72	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Н.Батцэрэг	Өмнөговь аймгийн Тост, Тосон бумбын нурууг улсын тусгай хамгаалалтад авах талаар 1059 иргэнээс ирүүлсэн өргөдлийн талаар	ӨБХ 2015.12.01	10	22
73	Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа	“Хөдөө аж ахуйн “Халх гол” чөлөөт бүс байгуулах тухай” Улсын Их Хурлын 2015 оны 75 дугаар тогтоолын талаар ирүүлсэн 3000 иргэний өргөдлийн талаар	ӨБХ 2015.12.01		
74	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Н.Батцэрэг	2012-2015 оны Улаанбаатар хотын агаарын чанарын үзүүлэлт, 2015 онд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр Засгийн газрын хийсэн ажлын тайлан, 2016 онд хийх ажлын төлөвлөгөөний талаар	БОХХААБХ 2015.12.02	4	11
75	Монгол Улсын Шадар сайд Ц.Оюунбаатар	2015-2016 оны өвөлжилтийн нөхцөл байдлын талаар	БОХХААБХ 2015.12.02	6	34
76	Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа	Намрын ургац хураалтын дүнгийн талаар	БОХХААБХ 2015.12.02	3	13
77	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Н.Батцэрэг	Парис хотод 2015 оны 11 дүгээр сард болсон Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэсний Байгууллагын суурь конвенцийн талуудын 21 дүгээр бага хуралдааны талаар	БОХХААБХ 2016.02.02	4	9
78	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Н.Батцэрэг	Монгол Улсын Засгийн газар болон Нийслэлээс агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр 2016 онд хийгдэж байгаа болон хийхээр төлөвлөгдөж буй ажлуудын талаар	Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо 2016.02.02	2	11
79	Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн захирал Б.Цогтбаатар	“Хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын үзүүлэх нөлөө, шийдвэрлэх арга зам” Олон улсын зөвлөлгөөнөөс гарсан үр дүнгийн талаар	Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо 2016.02.02	2	9
80	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэ	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2015 оны үйл ажиллагааны тайлан	НББСШУБХ 2016.04.12	2	9
81	Үндэсний Аудитын газрын дарга А.Зангад	Үндэсний аудитын газрын 2015 оны үйл ажиллагааны тайлан	ТБХ 2016.05.19	1	1
Нийт 81 удаа				463	1186

\* \* \*

**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2012 - 2016 ОНЫ БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦААНД  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖААР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ**

(Нэрийн жагсаалт, 2012.10.01 - 2016.05.24)

Д/д	Захирамжийн			Ажлын хэсгийн ахлагч	Ажлын хэсгийн гишүүн / ахлагчтай/
	Огноо	№	Товч утга		
1	2012.08.28	90	Улсын Их Хурлын Ордны шинэ барилга барих газрын байршил, санхүүжилтийг судалж тогтоох үүрэг бүхий ажлын хэсэг	С.Баярцогт	9
2	2012.08.30	92	Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн болон хууль хэрэгжүүлэхтэй холбогдсон Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Р.Гончигдорж	11
3	2012.09.14	101	Монголбанкны Ерөнхийлөгч шинээр томилогдсонтой холбогдуулан ажил хүлээлцүүлэх ажлын хэсэг	Б.Гарамгайбаатар	4
4	2012.09.18	103	Барилгын тухай болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиуд, эдгээртэй холбоотой бусад хууль тогтоомжийн биелэлтийг шалгаж, санал, дүгнэлт гаргах ажлын хэсэг	Ж.Батзандан	7
5	2012.09.18	106	Монгол Улсын Их Хурлын тухай болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	С.Баярцогт	9
6	2012.12.03	149	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Р.Бурмаа	8
7	2012.12.18	157	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хэрэгжилтийг хангах, аюулгүй байдал, хууль зүйн салбарын шинэчлэлийн бодлогыг уялдуулах, аюулгүй байдлын салбарт тавих парламентын хяналтыг боловсронгуй болгох бодлого боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах чиг үүрэг бүхий ажлын хэсэг	М.Батчимэг	5
8	2013.01.28	17	Нийслэл хотын хүн амын хэт төвлөрөлтэй холбогдуулан төр захиргааны төв байгууллагуудыг дагуул хотуудад нүүлгэн шилжүүлэх, дагуул хот байгуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх, дэд бүтэц, хөрөнгө оруулалтын тооцоо хийх үүрэг бүхий ажлын хэсэг	Д.Гарамгайбаатар	9
9	2013.02.08	26	Монгол Улсын сонгуулийн нэгдсэн /Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулиудыг нэгтгэх/ хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Р.Бурмаа	11

10	2013.02.08	27	Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг судлах үүрэг бүхий ажлын хэсэг	Л.Цог	11
11	2013.02.08	28	Улс төрийн намын тухай, Улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулиудын төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	С.Баярцогт	15
12	2013.03.13	53	Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн Сайд нарын VII Бага хурлын хүрээнд зохион байгуулагдах Ардчиллын төлөөх парламентчдын чуулга уулзалтын бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсэг	М.Батчимэг	2
13	2013.03.13	54	2013 оны 27 дугаар захирамжид өөрчлөлт оруулах тухай Ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс Улсын Их Хурлын Г.Батхүүг чөлөөлж, Улсын Их Хурлын С.Дэмбэрэлийг, 2013 оны 28 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын Г.Батхүүг нэмж оруулах тухай		
14	2013.04.22	73	Улс орнуудын эдийн засгийн байдал, манай улсын эдийн засагт үзүүлэх нөлөө, үр дагавар, түүнийг даван туулах арга зам, гадаадын хөрөнгө оруулалтын нөхцөл байдлыг судалж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг	Б.Гарамгайбаатар	15
15	2013.05.13	85	2012 оны 157 дугаар захирамжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		
16	2013.07.09	114	2013 оны 26 дугаар захирамжид гишүүн нэмж оруулах тухай		
17	2013.07.10	115	Мөрдөх албаны тухай хуулийн төсөл, Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Прокурорын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Д.Батцогт	13
18	2013.07.10	116	“Төрөөс эрдэс баялагийн салбарт баримтлах бодлого батлах тухай” тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	С.Одонтуяа	12
19	2013.07.10	117	Газрын тосны тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ төсөл, Газрын тосны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл, Газрын тосны тухай хуулийг хүчингүй болгох тухай хуулийн төсөл болон зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Х.Болорчулуун	12



20	2013.07.10	119	Монгол Улсын газар зүйн байрлалын давуу талыг ашиглан төмөр зам, авто тээвэр, агаарын тээврийн дамжин өнгөрөх зорчигч, ачаа тээвэрлэлтийг нэмэгдүүлэх, нэгдсэн ложистикийн сүлжээг бий болгох, нефть, хийн хоолой, холбооны болон цахилгаан дамжуулах шугамын талаар нэгдсэн бодлого боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Г.Батхүү	11
21	2013.08.29	143	Улсын Их Хурлын Ордны шинэ барилга барих газрын байршил, санхүүжилтийг судалж тогтоох үүрэг бүхий ажлын хэсэг	Р.Гончигдорж	12
22	2013.10.24	192	Зүүн хойд Азийн бүс нутгийн эмэгтэй парламентчдын чуулга уулзалтыг 2013 оны 11 дүгээр сарын 23-наас 26-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулах бүхий ажлын хэсэг	М.Батчимэг	4
23	2013.10.10	183	2013 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 119 дүгээр захирамжид өөрчлөлт оруулах тухай		
24	2013.10.21	188	2013 оны 26 дугаар захирамжид өөрчлөлт оруулах тухай		
25	2013.12.20	235	2013 оны 26 дугаар захирамжид Улсын Их Хурлын гишүүн О.Содбилэгийг нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		1
26	2014.01.22	16	2013 оны 119 дүгээр захирамжаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтыг чөлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Ц.Нямдоржийг нэмж оруулах тухай		
27	2014.04.15	60	Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичгийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг	Д.Эрдэнэбат, С.Бямбацогт, Н.Батцэрэг	15
28	2014.05.14	71	Хяналтын тухай болон холбогдох бусад хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг	А.Бакей	12
29	2014.05.20	74	Татварын хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг	С.Баярцогт	11
30	2014.05.22	78	Улсын Их Хурлын 2014 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн "Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай" 30 дугаар тогтоолын 12 дахь заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг судалж, нэгдсэн дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг	Ш.Түвдэндорж	1
31	2014.06.24	102	Хяналтын тухай болон холбогдох бусад хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг	Г.Батхүү	8
32	2014.07.09	108	Гэмт хэргийн тухай, Зөрчлийн тухай хуулийн төслүүд болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг	Д.Ганбат	11
33	2014.10.15	157	Эрүүл мэндийн албан журмын даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг	С.Одонтуяа	9

34	2014.11.03	162	Улсын Их Хурлын даргын БНХАУ-д хийсэн айлчлалын үед яригдсан цахилгаан эрчим хүчний ерөнхий хэлэлцээр байгуулах, эрчим хүч экспортлох асуудлаар бодлого боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Х.Баттулга	5
35	2014.11.04	164	Улсын Их Хурлын даргын БНХАУ-д хийсэн айлчлалын үед яригдсан нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх, экспортлох асуудлаар бодлого боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Д.Ганхуяг	5
36	2014.11.04	165	Улсын Их Хурлын даргын БНХАУ-д хийсэн айлчлалын үед яригдсан Монгол Улсаас БНХАУ-д мах экспортлох асуудлаар бодлого боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Д.Батцогт	5
37	2014.11.04	166	Улсын Их Хурлын даргын БНХАУ-д хийсэн айлчлалын үед яригдсан гангийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүтээгдэхүүн экспортлох асуудлаар бодлого боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Д.Сумъяабазар	5
38	2014.11.26	181	Монгол, Япон улсын хооронд байгуулахаар төлөвлөж байгаа Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг байгуулах бэлтгэл ажлыг хангах, Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулсны дараа хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаар санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Д.Ганхуяг	7
39	2014.12.15	194	2013 оны 28 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс Д.Одхүүг чөлөөлж, Улсын Их Хурлын даргын зөвлөх А.Гансүхийг томилох тухай		
40	2014.12.15	195	2013 оны 26 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс Улсын Их Хурлын даргын зөвлөх З.Нарантуяаг чөлөөлж, Улсын Их Хурлын даргын зөвлөх А.Гансүхийг томилох тухай		
41	2014.12.16	199	2014 оны 60 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсгийн дэд бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын даргын зөвлөх А.Гансүхийг томилох тухай		
42	2014.12.23	207	2014 оны 166 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс С.Баярцогтыг чөлөөлөх тухай		
43	2015.01.09	03	2014 оны 166 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн Ц.Баярсайханыг нэмж томилох тухай		1
44	2015.01.13	08	Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Н.Батбаяр	9
45	2015.01.15	13	2013.02.08-ны өдрийн 26 захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Р.Бурмааг чөлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзанданг томилох тухай	Ж.Батзандан	
46	2015.01.15	14	2013 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 28 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогтыг чөлөөлж, Ш.Түвдэндоржийг томилох тухай		

47	2015.03.04	53	Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/, Зөрчлийн тухай хуулийн төслүүд болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Д.Ганбат	10
48	2015.03.11	60	Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтын дөрөв, тав, зургаадугаар зорилтын хэрэгжилтийг үзүүлэлт бүрээр дүгнэж, зөвлөмж боловруулах үүрэг бүхий ажлын хэсэг	С.Ламбаа	
49	2015.03.11	61	“Иргэдэд насан туршийн нээлттэй боловсрол олгох талаар төрөөс баримтлах бодлого” боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Д.Энхбат	
50	2015.04.16	91	2013 оны 26 дугаар захирамжийн дагуу байгуулсан ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзанданг чөлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Р.Бурмааг ахлагчаар томилох тухай	Р.Бурмаа	
51	2015.04.17	93	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг	Р.Амаржаргал	7
52	2015.04.29	101	Засгийн газрын өргөн мэдүүлсэн “Таван толгойн нүүрсний ордыг хөгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын төсөл, Таван толгойн ордыг хөгжүүлэхтэй холбоотой хөрөнгө оруулалтын гэрээ болон хавсралт гэрээнүүдийг Улсын Их Хурлаар хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг	Л.Эрдэнэчимэг	10
53	2015.05.04	109	2014 оны 74 дүгээр захирамжаар байгуулсан ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогтыг чөлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Р.Амаржаргалыг ахлагчаар томилох тухай	Р.Амаржаргал	
54	2015.06.02	128	2013 оны 28 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Г.Батхүү, Б.Гарамгайбаатар, Х.Тэмүүжин нарыг нэмэх тухай		3
55	2015.06.05	131	2015 оны 101 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт Монголын Төмөр зам ТӨХК-ийн дэд захирал П.Бат-Эрдэнэ, Эрдэс баялагийн салбарын ахмадын нэгдсэн хорооны тэргүүн Ч.Хурц нарыг дэд ажлын ажлын хэсгийн гишүүнээр томилох тухай		
56	2015.06.12	137	Монголын Улсын Их Хурлын даргын 2014 оны 4 сарын 15-ны өдрийн 60 дугаар захирамжаар батлагдсан Монгол Улсын Хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичгийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагчийг өөрчлөн Улсын Их Хурлын гишүүн Б.Гарамгайбаатарыг томилох тухай	Б.Гарамгайбаатар	

57	2015.06.18	141	Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын парламентын Ассамблейн намрын хурлыг 2015 оны 09 дүгээр сарын 15-наас 19-ний өдрүүдэд Монгол Улсад зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд ажлын хэсэг	Б.Болдбаатар /Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга/	
58	2015.08.11	162	Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын парламентын Ассамблейн намрын хурлыг 2015 оны 09 дүгээр сарын 15-наас 19-ний өдрүүдэд Монгол Улсад зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай	Б.Болдбаатар /Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга/	
59	2015.08.21	167	Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын парламентын Ассамблейн намрын хурлыг 2015 оны 09 дүгээр сарын 15-наас 19-ний өдрүүдэд Монгол Улсад зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай	Б.Болдбаатар /Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга/	
60	2015.08.25	170	Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг	Г.Батхүү	11
61	2015.10.02	203	Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 357 дугаар тогтоолтой танилцаж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ц.Нямдорж	3
62	2015.10.14	213	Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, хүний хөгжлийн сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2016 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2016 оны төсвийн тухай, Хүний хөгжлийн сангийн 2016 оны төсвийн тухай болон дагалдан хуулийн төсөл өргөн мэдүүлсэнтэй холбогдуулан ойрын болон дунд хугацааны төсвийн бодлогыг тодорхойлох, үр дүнгийн үзүүлэлтүүдийн оновчтой тэнцвэрийг хангах саналыг боловсруулж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг	Ч.Улаан	7
63	2015.11.02	228	Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох, шаардлагатай хөрөнгө оруулалт, зардлын тооцоог гаргах үүрэг бүхий ажлын хэсэг	Ц.Оюунбаатар	9

64	2015.11.26	248	Улсын Их Хурлын гишүүн Р.Бурмаа нарын 16 гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Су.Батболд нарын 7 гишүүн 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр өргөн мэдүүлсэн, Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү нарын 10 гишүүн 2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн Сонгуулийн хуулийн төсөл болон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг нэгтгэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	А.Бакей	10
65	2015.12.22	258	Монгол Улсын Их Хурлын даргын 2015 оны 248 дугаар захирамжаар байгуулсан сонгуулийн хуулийн төсөл болон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг нэгтгэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс Улсын Их Хурлын гишүүн Н.Батцэрэгийг чөлөөлж, Улсын Их Хурлын дэд дарга Л.Цогийг ажлын хэсгийн гишүүнээр томилох тухай	А.Бакей	
66	2016.05.04	58	Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтыг зөрчсөн гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 05 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн авсантай холбогдуулан Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, холбогдох бусад хууль, Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	А.Бакей	7
Нийт 44 ажлын хэсэг				51	193

\* \* \*









**УЛСЫН ИХ ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧООН**

(Он цагийн дарааллаар, 2012 - 2016)

**2012 үйл явдлууд**

2012.07.06

Монгол Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн үр дүнд бүрдсэн Улсын Их Хурлын Анхдугаар чуулганы хуралдааныг Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж нээж, даргалав. Монгол Улсын Ерөнхийлөгчид нэрийг нь өргөн мэдүүлсэн 72 гишүүнээс 69 гишүүн хуралдаанд оролцлоо. Харин МАХН - МҮАН -ын “Шударга ёс” эвслээс нэр дэвшиж Улсын Их Хурлын гишүүний түр үнэмлэхээ гардан авсан Ц.Цолмон, О.Баасанхүү, Ц.Оюунбаатар нар танхимд ирсэнгүй.

Сонгуулийн ерөнхий хорооны дарга Н.Лувсанжав сонгуулийн дүнгийн талаарх танилцуулгадаа, Улсын Их Хурлын энэ удаагийн сонгуулийг хууль эрх зүйн шинэ орчинд сонгуулийн хосолсон тогтолцоогоор анх удаа зохион байгуулав. Улсын Их Хурлын сонгуулийг улс орон даяар зохион байгуулж явуулах үүрэг бүхий сонгуулийн 26 тойргийн хороо, 333 салбар хороо, 1905 хэсгийн хороо байгуулагдаж, тэдгээрт төрийн жинхэнэ болон үйлчилгээний 15549 албан хаагч ажиллаж, сонгуулийг зохион байгууллаа.

Монгол Улсын сонгуулийн эрх бүхий 1836548 иргэн саналаа өгөхөөр нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн байна. Сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх, нягтлан шалгах, давхардлыг арилгах ажлыг улсын хэмжээнд анх удаа Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бие даан зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллалаа. Монгол Улс түүхэндээ анх удаа гадаад орондоо байгаа сонгогчдынхоо саналыг авлаа.

Монгол Улсын Их Хурлын сонгуульд улс төрийн 11 нам, 2 эвсэл оролцохоо илэрхийлж, Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлэн батламж авсан болно. Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчээр 544 хүн бүртгүүлсэн бөгөөд үүнээс 26 тойрогт 354 нэр дэвшигч, нам эвслийн жагсаалтаар 190 нэр дэвшигч бүртгүүлснээс бие даан нэр дэвшигч 26, эмэгтэй нэр дэвшигч 174 байлаа. Сонгуулийн санал авах, тоолох, дүн гаргах болон сонгогчийн бүртгэл хяналтын үйл ажиллагааг Монгол Улс анх удаа автоматжуулсан системээр амжилттай зохион байгуулж явууллаа.

Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Ардын Намаас 25, Ардчилсан намаас 31, “Иргэний зориг-Ногоон нам” -аас 2, МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслээс 11, бие даан нэр дэвшсэн 3 хүн тус тус сонгогдсоныг Монгол Улсын Ерөнхийлөгчид айлтган нийтэд мэдээлсэн болно.

Улсын Их Хурлын сонгуулийн 10 дугаар тойргоос Улсын Их Хурлын гишүүний түр үнэмлэх авсан 2 нэр дэвшигчийн талаар шүүхийн шийдвэр гарсан тул тойргийн хороо хуулийн дагуу хэлэлцэн шийдвэрлэх шаардлагатай болсон. Мөн Улсын Их Хурлын сонгуулийн 22, 26 дугаар тойргийн тус бүр нэг мандатын төлөө дахин санал хураалт явуулахаар болж байна. Улсын Их Хурлын 2012 оны ээлжит сонгууль хуулийн хүрээнд амжилттай явагдсан болохыг Сонгуулийн ерөнхий хороо тэмдэглэж байна гэлээ. Дараа нь Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд заасны дагуу тангараг өргөх ёслолын ажиллагаа эхэлж, энэ удаагийн парламентын насаар хамгийн ахмад гишүүн Д.Дэмбэрэл индэр дээрээс тангарагийг уншихад бусад гишүүд босч, дагаж уншив.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Улсын Их Хурлын гишүүдийн нэрсийг үсгийн дарааллаар, хоёр хоёроор нь дуудахад Улсын Их Хуралд шинээр сонгогдсон гишүүд төрийн сүлдэнд мэхийн ёсолж, тангарагийн хуудсанд гарын үсэг зурж, Улсын Их Хурлын гишүүний энгэрийн тэмдгээ гардаж авлаа.

Улсын Их Хурлын 69 гишүүн тангарагаа өргөж дууссаны дараа Зэвсэгт хүчний Жанжин штабын Бүх цэргийн үлгэр жишээ үлээвэр найрал хөгжимчид Монгол Улсын Төрийн дууллыг танхимд эгшиглүүлэхэд хуралдаанд оролцогсад босч хүндэтгэв.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж шинээр сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрх нь хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан баяр хүргээд Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд заасны дагуу насаар хамгийн ахмад гишүүн Д.Дэмбэрэлийг хуралдаан даргалахыг урив.

Улсын Их Хурлын гишүүн Д.Дэмбэрэл Улсын Их Хурлын даргын суудалд сууж, Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулж, батлуулаад шинээр сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдийн цаашдын ажилд амжилт хүсч, баяр хүргэв. Улсын Их Хуралд шинээр сонгогдож, тангараг өргөсөн гишүүд дурсгалын зураг авахуулав.

2012.07.20

Улсын Их Хурлын Анхдугаар чуулганы хуралдаанаар Улсын Их Хурлын даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсөн байв. Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд Улсын Их Хурлын даргыг сонгох асуудлаар Монголын ардын намтай зөвшилцөөгүй тул Монгол ардын намын гишүүд хуралдаанд оролцох боломжгүй байгаа тухай мэдэгдэж, нэгдсэн хуралдааны танхимаас гарав. Улсын Их Хурлын гишүүн Д. Дэмбэрэл хуралдаан хаасныг мэдэгдэн алх цохиж, чуулганы нэгдсэн хуралдааны танхимаас гарав.

2012.07.24

Улсын Их Хурал дахь Ардчилсан нам, Иргэний зориг ногоон нам, МАХН-МУАН-ын “Шударга ёс” эвслийн гишүүд болон бие даагч гишүүд Анхдугаар чуулганыг үргэлжлүүлэхээр нэгдсэн хуралдааны танхимд ирсэн байв. Гэвч Улсын Их Хурал дахь Монгол ардын намын гишүүд Бага хуралтай гэсэн шалтгаанаар чуулганы хуралдаанд хүрэлцэн ирсэнгүй. Иймээс хуралдаанд оролцож буй Улсын Их Хурлын гишүүдийн хамгийн ахмад гишүүн болох Улсын Их Хурлын гишүүн Л.Цог хуралдааныг удирдан явуулахаар тогтов.

Улсын Их Хурлын Анхдугаар чуулганы энэ өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын даргыг сонгох тухай асуудал хэлэлцэж, Улсын Их Хурлын гишүүн, Ардчилсан намын дарга Н.Алтанхуяг Улсын Их Хурлын даргаар Улсын Их Хурлын гишүүн Зандаахүүгийн Энхболдыг томилуулахаар нэр дэвшүүлж буйгаа мэдэгдэж, нэр дэвшигчийн талаар танилцуулга хийлээ.

Ингээд Улсын Их Хурлын гишүүн Зандаахүүгийн Энхболдыг Улсын Их Хурлын даргаар сонгох санал хураалт явуулж, Улсын Их Хурлын тогтоол батлав. Дараа нь Улсын Их Хурлын тамгыг залах ёслол болж, хуралдаан даргалагч Улсын Их Хурлын гишүүн Л.Цог шинээр томилогдсон Улсын Их Хурлын дарга З.Энхболдод Улсын Их Хурлын тамгыг гардуулж өгөв.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж шинээр сонгогдсон Улсын Их Хурлын



дарга З.Энхболдыг хүлээн авч уулзан, баяр хүргэлээ. Ерөнхийлөгч ард түмэн, улс үндэстнийхээ болон хууль, шударга ёсны эрх ашгийг тэргүүн зэрэгт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын даргаас хүсэв.

Улсын Их Хурлын Анхдугаар чуулганы үдээс хойших хуралдааныг шинээр сонгогдсон Улсын Их Хурлын дарга З.Энхболд даргалан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг, МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслийн бүлэг албан ёсоор байгуулагдаж, Ардчилсан намын бүлгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат, МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Н.Батцэрэг нар сонгогдсоныг танилцуулж, баяр хүргэв.

2012.07.25

Улсын Их Хурлын Анхдугаар чуулганы хуралдаанаар Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж, Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороог 18 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулав.

2012.08.01

Улсын Их Хурлын Анхдугаар чуулганы хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай асуудал хэлэлцэж, шинээр сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн Ц.Цолмон, О.Баасанхүү нар гишүүний тангараг өргөж, Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Агипарын Бакейг сонгож батлав.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж баталлаа.

2012.08.07

Улсын Их Хурлын Анхдугаар чуулганы хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын Байнгын хороодын бүрэлдэхүүний тухай, Төрийн байгуулалтын байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлав.

Байнгын хороодын дарга нарыг томилох тухай асуудал хэлэлцэж, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Цэрэндашийн Цолмон, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Гарьдхүүгийн Баярсайхан, Төсвийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн, Эдийн засгийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Батхүүгийн Гарамгайбаатарыг тус тус сонгож батлав.

2012.08.07

Шинэ парламент анхныхаа хуулийн төслийг хэлэлцэн батлав. Энэ өдрийн хуралдаанаар УИХ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцлээ. Нэмэлт өөрчлөлтөд УИХ-ын Өргөдлийн байнгын хороог шинээр байгуулах, байнгын хорооны тоо нэмэгдсэнээр нэг гишүүн гурваас дээшгүй байнгын хороонд харьяалагдах зэрэг өөрчлөлтүүд тусгагдсан байв.

2012.08.08

Улсын Их Хурлын Анхдугаар чуулганы хуралдаанаар Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай асуудал хэлэлцэж, Улсын Их Хурал дахь МАХН, МҮАН-ын “Шударга ёс” эвслийн бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Чүлтэмийн Улааныг Улсын Их Хурлын дэд даргаар сонгож батлав. Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох тухай асуудал хэлэлцэж, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Зангадын Баянсэлэнгэ, Хууль зүйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Шаравдоржийн Түвдэндорж нарыг сонгож баталлаа.

2012.08.09

Улсын Их Хурлын Анхдугаар чуулганы хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай асуудал хэлэлцэж, Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуягийг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталлаа. Улсын Их Хурлын дарга З.Энхболд Монгол Улсын 27 дахь Ерөнхий сайдаар томилогдсон Норовын Алтанхуягийг хүлээн авч уулзан, шинээр эмхлэн байгуулах Засгийн газрын тэргүүнээр томилогдсонд нь баяр хүргэж ажлын амжилт хүслээ.

Монгол Улсын Их Хурлын 6 дахь удаагийн сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд хамгийн олон суудал авсан Ардчилсан нам нь МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвсэл, ИЗНН-ын хамтарсан Засгийн газар байгуулахаар тохирч Норовын Алтанхуягийг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилуулахаар нэр дэвшүүлэн Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцөхөөр өргөн мэдүүлсэн.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын даргын дэргэдэх Зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай захирамж гаргалаа. Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлэг байгуулах асуудал шийдэгдсэний дараа Зөвлөлийн бүрэлдэхүүнд зарим өөрчлөлт оруулна. Улсын Их Хурлын даргын дэргэдэх Зөвлөл анхны хуралдаанаа хийж, Улсын Их Хурлын 2013 оны төсвийн төсөл, Улсын Их Хурлын ордон барих асуудлыг тус тус хэлэлцлээ.

2012.08.10

Улсын Их Хурлын дарга З.Энхболд “Статистик-2012” үндэсний зөвлөгөөний нээлтэд оролцож, үг хэлэв.

2012.08.14

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын дарга З.Энхболдод өргөн мэдүүлэв. Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газрын бүрэлдэхүүнд Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын Шадар сайд болон Монгол Улсын сайд-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, яамдын асуудал эрхэлсэн сайд зэрэг 19 гишүүнтэй ажиллахаар уг хуулийн төсөлд тусгажээ.

2012.08.16

Улсын Их Хурлын Анхдугаар чуулганы хуралдаанаар Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэж батлав. Уг хуулиуд батлагдсанаар

Монгол Улсын Засгийн газар нь 16 яамтай ажиллах бөгөөд үүнээс дөрөв нь ерөнхий чиг үүргийн, арван хоёр нь чиглэлийн яам байхаар болж байгаа юм. Засгийн газрын бүрэлдэхүүнд Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын Шадар сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, яамдын асуудал эрхэлсэн сайд нарын 18 гишүүн ажиллуулахаар тусгажээ.

Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг Засгийн газрын зорилттой уялдуулж шинэчлэхдээ агентлагийн зохион байгуулалт, бүтцийн зохистой байдлыг хангах, яам, агентлагийн хариуцах асуудал, чиг үүргийн давхардлыг арилгах, шат дамжлагыг бууруулах зарчим, шалгуурыг баримтлан Засгийн газрын тохируулагч агентлаг 11, хэрэгжүүлэгч агентлаг 17, нийт 28 агентлаг байхаар төслөө боловсруулсан байна.

2012.08.17

Улсын Их Хурлын Анхдугаар чуулганы энэ өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай асуудал хэлэлцэж, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Сангажавын Баярцогтыг Улсын Их Хурлын дэд даргаар сонгож батлав.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн болон дагалдах бусад хуулийн төслүүд, Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж баталлаа.

Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг томилох тухай асуудал хэлэлцэж,

- Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар Чимэдийн Сайханбилэг,
- Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайдаар Лувсанвандангийн Болд,
- Засгийн газрын гишүүн, Хууль зүйн сайдаар Хишигдэмбэрэлийн Тэмүүжин,
- Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайдаар Цэвэлмаагийн Баярсайхан,
- Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайдаар Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ,
- Засгийн газрын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайдаар Лувсаннъямын Гантөмөр,
- Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн сайдаар Амаржаргалын Гансүх,
- Засгийн газрын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлалын сайдаар Цэдэвдамбын Оюунгэрэл,
- Засгийн газрын гишүүн, Уул уурхайн сайдаар Даваажавын Ганхуяг,
- Засгийн газрын гишүүн, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдаар Халтмаагийн Баттулга,
- Засгийн газрын гишүүн, Хөдөлмөрийн сайдаар Ядамсүрэнгийн Санжмятав,
- Засгийн газрын гишүүн, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдаар Содномзундуйн Эрдэнэ,
- Засгийн газрын гишүүн, Эдийн засгийн хөгжлийн сайдаар Нямжавын Батбаяр нарыг томилов.

Мөн өмнө нь ажиллаж байсан Засгийн газрын гишүүн, сайд нарыг үүрэгт ажлаас нь чөлөөлөв.

2012.08.20

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг Засгийн газрын зарим гишүүдийг томилох тухай тогтоолын төслийг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэв.

Улсын Их Хурлын Анхдугаар чуулганаар Улсын Их Хурлын дэд даргыг чөлөөлөх тухай асуудал хэлэлцэж, Улсын Их Хурал дахь МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслийн бүлгийн саналын дагуу Улсын Их Хурлын гишүүн Чүлтэмийн Улааныг Монгол Улсын Их Хурлын дэд даргын үүрэгт ажлаас чөлөөлөв.

Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг томилох тухай асуудал хэлэлцэж, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайдаар Дэндэвийн Тэрбишдагва, Засгийн газрын гишүүн, Байгаль, орчин ногоон хөгжлийн сайдаар Санжаасүрэнгийн Оюун, Засгийн газрын гишүүн, Сангийн сайдаар Чүлтэмийн Улаан, Засгийн газрын гишүүн, Эрчим хүчний сайдаар Мишигийн Сономпил, Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайдаар Нацагийн Удвал нарыг томилов.

Засгийн газрын гишүүд бүрэн бүрэлдэхүүнээрээ томилогдож дууссантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Норовын Алтанхуяг үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын дэд даргаар МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслийн бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Логийн Цогийг сонгож батлав.

2012.08.21

Улсын Их Хурлын Анхдугаар чуулганаар Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай, Улсын Их Хурлын дэд хороодын бүрэлдэхүүний тухай асуудал хэлэлцэж Улсын Их Хурлын тогтоол батлав.

Монгол Улсын Их Хурлын 2012 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан Улсын Их Хурлын Анхдугаар чуулганы үйл ажиллагааг хааж Улсын Их Хурлын дарга З.Энхболд үг хэлэв. Тэрбээр хэлсэн үгэндээ “2012 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар Ардчилсан намаас 31, МАН -аас 25, ИЗНН-аас 2, МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслээс 10, бие даан нэр дэвшсэн 3 хүн тус тус сонгогдож төрийн сүлдэндээ тангаргаа өргөсөн 71 гишүүнтэйгээр Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлж байна” гэлээ.

Улсын Их Хурлын сонгуулийн дараа Монголын парламентын бүлгэмийг шинээр байгуулах анхдугаар хуралдаан болж, Монголын парламентын бүлгэмийн Гүйцэтгэх хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга С.Баярцогт, Гүйцэтгэх хорооны дэд даргаар Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэг, Н.Батцэрэг, гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн Сү.Батболд, О.Баасанхүү, Б.Болор, С.Ганбаатар, С.Дэмбэрэл, Н.Энхболд нарыг сонголоо.

2012.08.23

Улсын Их Хурлын дарга З.Энхболд “КНААН QUEST-2012” энхийг дэмжих ажиллагааны олон улсын сургуулийн хаалтад оролцон үг хэлж, энхийг дэмжих ажиллагааны олон улсын сургуульд оролцогчид 12 өдрийн турш санаа зорилго нэгдэн ажиллаж, өмнөө тавьсан зорилтоо амжилттай биелүүлсэнд баяр хүргэлээ.

Улсын Их Хурлын дарга З.Энхболдод манай улсад албан ёсны айлчлал хийж байгаа БНХАУ-ын Төрийн зөвлөлийн гишүүн Дай Бингуо бараалхав.



2012.08.24

Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Р.Бурмаа, Д.Ганхуяг, Н.Батбаяр, С.Баярцогт, Д.Батцогт, М.Зоригт, С.Оюун нар Аймаг, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл санаачлан боловсруулснаа Улсын Их Хурлын даргад өргөн барив.

Уг төслөөр аймаг, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг Улсын Их Хурал болон Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2012 оны ээлжит сонгуультай нэгэн адил холимог хувилбараар явуулах, аймаг, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын нийт төлөөлөгчдийн гуравны хоёроос доошгүй нь сум, баг, хорооноос шууд, харин гуравны нэг хүртэлхийг нь улс төрийн нам буюу намуудын сонгуулийн эвслийн жагсаалтаас сонгохоор тусгажээ.

2012.08.27

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын ээлжит бус чуулганыг 2012 оны 8 дугаар сарын 29-ний өдрөөс 9 дүгээр сарын 19-ний өдрүүдэд зарлан хуралдуулж, 13 асуудал хэлэлцэх тухай захирамж гаргав.

2012.08.29

Улсын Их Хурлын ээлжит бус чуулган гишүүдийн 66,2 хувийн ирцтэй эхэлж, ээлжит бус чуулганыг нээж Улсын Их Хурлын дарга З.Энхболд үг хэлэв. Тэрбээр хэлсэн үгэндээ, хоёр сарын дараа болох аймаг, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэн батлах, Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон цаг хугацааны хувьд яаралтай шийдвэрлэх зарим хуулиудыг хэлэлцэх зорилгоор энэ удаагийн ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулж байгааг онцлов.

2012.09.01

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Нийслэлийн тэргүүний 84 дүгээр сургуулийн хичээлийн шинэ жилийн нээлтийн ажиллагаанд оролцож, Монголын анхны цахим сургууль гэдгээр нь онцолж тус сургуулийн багш, сурагч, эцэг эхчүүдэд хандаж үг хэлэв.

2012.09.03

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2012-2013 оны хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагаанд оролцон үг хэлж, тус сургуулийн эрдэмтэн багш нар, оюутнуудад сурлагын амжилт хүслээ.

2012.09.04

Улсын Их Хурлын ээлжит бус чуулганаар Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн төслийг хэлэлцэж батлав. Уг хууль батлагдсанаар 1990-1995 он болон 1995-2000 онд ажилгүй байсан иргэд нийгмийн даатгалын шимтгэлээ нөхөн төлж тэтгэвэр тогтоолгох, ажилласан жилээ нөхөн тооцуулах эрх зүйн боломж бүрдэж байгаа юм.

2012.09.05

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, С.Ганбаатар, Ц.Даваасүрэн, Д.Батцогт, Г.Уянга,

Х.Болорчулуун нар Оюутолгойн ордыг ашиглах тухай Улсын Их Хурлын 57 дугаар тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангаж, үр дүнг Улсын Их Хуралд 10 дугаар сарын 05-ны дотор ирүүлэх шаардлагыг Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлж байгаагаа мэдэгдэв. Уг шаардлагыг дэмжиж Улсын Их Хурлын 23 гишүүн гарын үсгээ зуржээ.

2012.09.06

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Монгол Улсын Ерөнхийлөгчийн урилгаар манай оронд төрийн айлчлал хийж буй Бүгд Найрамдах Индонез Улс /БНИУ/-ын Ерөнхийлөгч Сусило Бамбанг Юдоёнод бараалхав.

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос томилогдсон ажлын хэсгийн гишүүд Нийслэлийн соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцав.

2012.09.07

Улсын Их Хурлын ээлжит бус чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Шүүхийн захиргааны тухай хуулийн 13 дугаар зүйлд хэсэгчлэн тавьсан хоригийг хүлээж авсантай холбоотойгоор холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэж батлав.

Ингэснээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг анхан шатны шүүхийн шүүгчдийн болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс тус бүр нэг, Хуульчдын холбооноос нэг, Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нэг хүний нэрийг тус тус санал болгосноор Монгол Улсын Ерөнхийлөгч томилох, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргыг Ерөнхий зөвлөлийн гишүүд дотроосоо нэр дэвшүүлэн хуралдаанаараа хэлэлцэж, гишүүдийн олонхын санал авсан хүнийг санал болгосноор Монгол Улсын Ерөнхийлөгч томилж байх зохицуулалт хийгдлээ.

2012.09.10

Улсын Их Хурлын дарга З.Энхболд, Улсын Их Хурлын дэд дарга Л.Цог, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг болон улс төрийн намуудын зарим удирдлага, Улсын Их Хурлын гишүүд, Нийслэлийн төр, захиргааны байгууллагууд, иргэдийн төлөөлөл улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэж, хэлмэгдэгсдийн дурсгалын хөшөөнд цэцэг өргөлөө.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд Ч.Сайханбилэг нар Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэв.

Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргаар Улсын Их Хурлын дэд дарга Л.Цог томилогдов. Тус комисс нь 1930-1940-өөд он, 1950 -иад оны эхэн үе, мөн 1960-аад онд тухайн үеийн нам, төрийн хэлмэгдүүлэлтэд өртөж, улс төрийн хилс хэрэгт баривчлагдсан, мөрдөгдсөн, шийтгүүлсэн, ажил, албан тушаалаасаа халагдаж, хуулийн байгууллагуудын хараа хяналтын доор газар нутаг заагдан цөлөгдсөн, хэлмэгдсэн иргэдийн асуудлыг үргэлжлүүлэн шалгаж, судлах, цагаатгах ажлыг эрхлэн гүйцэтгэх үүрэг зорилготойгоор 1990 онд байгуулагджээ.





2012.09.11

Улсын Их Хурлын ээлжит бус чуулганы нэгдсэн хуралдаанаар Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд, Тогтоолд нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэж шийдвэрлэв.

2012.09.12

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар Ургац хураалтын бэлтгэл ажил, үр тарианы агуулах савны хүрэлцээ хангамж, цаг үеийн байдлын талаар Засгийн газрын гишүүн, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулгын мэдээллийг сонсов.

2012.09.14

- Улсын Их Хурлын ээлжит бус чуулганы нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийж батлав.
- Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангийн 2012 оны төсвийн тухай хууль, Хүний хөгжил сангийн 2012 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн дөрөв дэх хэлэлцүүлгийг хийж эцэслэн баталлаа.
- Аймаг, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Иргэний бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн болон холбогдох Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг батлав.
- Монголбанкны ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөх, томилох тухай асуудлыг хэлэлцэж, Л.Пүрэвдоржийг Монголбанкны ерөнхийлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлөн, Монголбанкны шинэ ерөнхийлөгчөөр Н.Золжаргалыг томилов.

2012.09.15

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар Төрийн ордонд зохион байгуулагдсан “Шууд ардчилал” иргэдийн оролцоотой төсвийн менежментийн үндэсний сургалтын нээлтэд оролцож үг хэллээ. Төсвийн тухай шинэ хууль өнгөрсөн оны сүүлчээр батлагдан гарсантай холбогдуулан төвлөрлийг сааруулах, орон нутгийн төсвийн эрхийг нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад өгөх, төсвийг төлөвлөх, зарцуулах, хяналт тавихад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх үүднээс уг сургалтыг зохион байгуулжээ.

2012.09.17

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар Орхон аймгийн Баян-Өндөр сум, Архангайн Цэнхэр, Өвөрхангайн Бат-Өлзий, Уянга сумдад Орхон, Хангал голын бохирдол, усны нөөцийн ашиглалт, хамгаалалтын байдалд Байгаль орчныг хамгаалах тухай, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай

хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалтай танилцах ажлын хэсэг байгуулав.

Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүдийн албан бус бүлгийн ахлагч Л.Эрдэнэчимэг, Улсын Их Хурлын гишүүн Р.Бурмаа, С.Одонтуяа, Ц.Оюунгэрэл нар Эрүүл мэндийн яам болон Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар, Нийслэлийн эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүдийг хүлээн авч уулзаж, тус салбарт тулгарч буй асуудлууд, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх талаар санал солилцов.

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар “Эрдэнэс-Тавантолгой” ХК -ийн үйл ажиллагааны явц, байдлын талаар тус компанийн гүйцэтгэх захирал Б.Энэбишийн мэдээллийг сонсов.

2012.09.18

Улсын Их Хурлын ээлжит бус чуулганы нэгдсэн хуралдаан “Виз олгох нөхцөлийг хөнгөвчлөх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” -ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэж батлав.

“Аймаг, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2012 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай”, “Сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг батлав.

“Улсын Их Хурлын 2012 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдав.

2012.09.18

Улсын Их Хурлын ээлжит бус чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Засгийн газрын 2012 - 2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг батлав.

Аймаг, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлав.

Улсын Их Хурлын ээлжит бус чуулганыг хааж Улсын Их Хурлын дарга З.Энхболд хэлсэн үгэндээ, Улсын Их Хурлын энэ удаагийн ээлжит бус чуулган төлөвлөсөн асуудлаа цаг хугацаанд нь хэлэлцэн шийдвэрлэлээ. Ээлжит бус чуулган ажлын 21 хоног үргэлжилж, нэгдсэн хуралдааныг 7 удаа хуралдуулсан байна. Чуулганаар хоёр шинэ хууль болон шинэчилсэн найруулга, 17 хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль нэг, Улсын Их Хурлын 15 тогтоолыг тус тус хэлэлцэн баталлаа гэдгийг онцлов

2012.09.19-20

Улсын Их Хурлын дарга З.Энхболд газар тариалангийн гол бүс нутаг Булган, Орхон, Сэлэнгэ аймгуудад ажиллаж намрын ургац хураалт, өвөлжилтийн бэлтгэл ажилтай танилцав. Улсын Их Хурлын дарга З.Энхболд орон нутаг дахь анхны томилолтоо ийнхүү анхдагчдын өлгий нутаг гэгддэг Булган аймгаас эхэллээ.

2012.09.19

Сүүлийн үед нийслэлд баригдаж буй барилгын ажлын явцад хүний амь нас эрсдэх, гэмтэх ноцтой хэрэг зөрчил удаа дараа гарч байгааг харгалзан Улсын Их Хурлын дарга



З.Энхболд захирамжаар байгуулагдсан Барилын тухай болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиуд, тэдгээртэй холбоотой бусад хууль тогтоомжийн биелэлтийг шалгаж, санал дүгнэлт гаргах ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү, С.Ганбаатар нар энэ талаар сэтгүүлчдэд мэдээлэл хийв. Улсын Их Хурлын 7 гишүүнээс бүрдсэн уг ажлын хэсэг хяналт шалгалтын ажлаа 9 сарын 18-наас 10 дугаар сарын 1-ний дотор гүйцэтгэж, санал, дүгнэлтээ 10 дугаар сарын 5-ны дотор Улсын Их Хуралд танилцуулах юм.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, С.Ганбаатар, Д.Батцогт, Х.Болорчулуун, О.Баасанхүү нар хэвлэлийн бага хурал хийж, Оюутолгойн гэрээний талаар байр сууриа илэрхийлэв. Улсын Их Хурлын 25 гишүүн Оюутолгойн гэрээнд өөрчлөлт оруулах асуудлын талаарх шаардах бичгийг 9 дүгээр сарын 05-нд Ерөнхий сайд Н.Алтанхуягт хүргүүлсэн. Гэвч өнөөг хүртэл уг асуудалд хариу өгөөгүй, улмаар Оюутолгойн гэрээнд өөрчлөлт оруулах асуудлыг Улсын Их Хурлын ээлжит бус чуулганд оруулж хэлэлцүүлэхээс татгалзсаныг эсэргүүцэж байгаагаа мэдэгдэв.

2012.09.20

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга Б.Гарамгайбаатар Улсын Их Хурлын ээлжит бус чуулганы хугацаанд тус Байнгын хорооноос зохион байгуулсан ажлын талаар сэтгүүлчдэд мэдээлэл өгөв. Ээлжит бус чуулганы хугацаанд тус Байнгын хороо дөрвөн удаа хуралдаж, таван асуудал хэлэлцэн шийдвэрлэжээ.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга А.Бакей Улсын Их Хурлын ээлжит бус чуулганы хугацаанд тус Байнгын хорооноос хийсэн ажлын талаар сэтгүүлчдэд мэдээлэл хийв. Байнгын хороо 9 удаа хуралдаж, 16 хууль, Улсын Их Хурлын 6 тогтоол батлуулж, байнгын хорооны санал, дүгнэлт 15-г гаргажээ.

2012.09.24

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо Улсын Их Хурлын ээлжит бус чуулганы хугацаанд хийсэн ажлаа сэтгүүлчдэд танилцуулав. Байнгын хороо энэ хугацаанд 8 хууль тогтоомжийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулжээ.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд “Улсын Их Хурлын 2012 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай” захирамж гаргаж, Улсын Их Хурлын 2012 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоосон байна.

2012.09.25

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд харьяалагддаг Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооноос эрхлэн “Сонгогчийн бүртгэл, хяналтын тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдвээр нээлттэй сонгогч зохион байгуулав.

Нээлттэй сонгогчд Сонгуулийн ерөнхий хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газар, улс төрийн нам, иргэд сонгогчдын төлөөлөл, нийслэлийн дүүргүүдийн бүртгэлийн газрын дарга нар оролцож, сонгогчдын нэрсийн жагсаалттай холбоотой тулгамдсан асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх арга замын талаар санал бодлоо солилцов.

2012.09.26

Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүдийн албан бус бүлэг, Жендэрийн үндэсний хороо, төрийн бус байгууллагуудын МОНФЕМНЕТ үндэсний сүлжээ хамтран НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр “Жендэрийн тэгш эрхийг хангах үр дүнтэй үндэсний механизм бүрдүүлэх нь” сэдэвт олон талт зөвлөгөөн зохион байгуулав. Зөвлөгөөнд Улсын Их Хурлын гишүүд, зохион байгуулагч байгууллагууд, шүүх, холбогдох яамны мэргэжилтнүүд, агентлагийн төлөөлөгчид, олон улсын зөвлөхүүд оролцсон юм.

2012.10.01

Улсын Их Хурлын 2012 оны намрын ээлжит чуулган нээгдлээ. Ээлжит чуулганыг нээж Улсын Их Хурлын дарга З.Энхболд үг хэлэв.

2012.10.01

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын шинэчлэгдсэн цахим хуудасны нээлтэд оролцож хэлсэн үгэндээ, “Хууль тогтоох үйл ажиллагааг иргэд, сонгогчдод ил тод, нээлттэй болгоход мэдээллийн технологийн ололтуудыг ашиглах, олон нийтийн сайтуудаар дамжуулан мэдээллийг шуурхай түгээх боломжийг бүрдүүлэх зорилгоор Улсын Их Хурлын албан ёсны <http://www.parliament.mn> цахим хуудсыг шинэчлэн нийтийн хүртээл болгож байна.

Үндсэн энэ сайтаас гадна Улсын Их Хурлын бүх гишүүний нэрээр 76 вэб сайт ажиллаж, парламентын үйл ажиллагааг иргэдэд сурталчлан цахим засаглал, цаахим парламентын хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулах боломж бүрдэж байна. Ингэснээр Улсын Их Хурал төрийн бусад байгууллагаас хамгийн нээлттэй нь байх болно” гэлээ.

2012.10.02

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэгээр, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагаар ахлуулан байгуулав.

2012.10.03

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хүнстэй холбоотой хоёр хуулийн төсөл дэх давхардал, зөрчил, хийдлийг арилган боловсруулж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулав.

2012.10.04

Улсын Их Хурлын 2012 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсаас Бутаны Вант Улс, Бүгд Найрамдах Панам Улстай дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж батлав.

2012.10.05

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч Х.Сонинбаяр, Х.Батсүрэн нарыг танилцуулж, энэ



талаар Улсын Их Хурлын дарга Монгол Улсын Ерөнхийлөгчид танилцуулахаар болов.

Сонгуулийн ерөнхий хорооны удирдлагыг чөлөөлөх, томилох тухай асуудал хэлэлцэж, Н.Лувсанжавыг Сонгуулийн ерөнхий хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлж, тус хорооны даргаар Ч.Содномцэрэнг томилов. Мөн Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн даргаар Б.Алтанжаргалыг, тус хорооны гишүүнээр Д.Дэлгэрцогтыг томиллоо. Монголбанкны Дэд ерөнхийлөгчөөр Э.Батшугарыг томилов.

Улсын Их Хурлын чуулганы үдээс хойших нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг гишүүдийн сонирхсон асуултад хариулт өгөв.

2012.10.13

Улсын Их Хурлын дарга З.Энхболд МУИС-ийн харъяа Экологийн боловсролын төвд болсон “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” арга хэмжээнд оролцож, мод тарилаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “Мод тарих үндэсний өдөр”-ийг жил бүрийн 10 дугаар сарын хоёр дахь долоо хоногийн Бямба гарагт тэмдэглэж, нийслэл болон бүх аймаг, сумдын байгууллага, иргэд мод тарьдаг уламжлалтай.

2012.10.13-15

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Г.Баярсайхан, Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэг, Б.Наранхүү нар Өвөрхангай аймгийн Уянга, Бат-Өлзий, Архангай аймгийн Цэнхэр суманд ажиллаж, Байгаль орчныг хамгаалах тухай, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн хэрэгжилтийн байдалтай танилцав.

2012.10.15

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Б.Бат-Эрдэнэ, Г.Уянга, О.Баасанхүү нар Оюутолгойн гэрээний асуудлаар Төрийн ордны Г танхимд хэвлэлийн бага хурал хийлээ. Оюутолгойн гэрээг өөрчлөх тухай шаардах бичигт гарын үсэг зурсан 27 гишүүнээс 19 нь ажлын хэсэгт орж ажиллаж байгаа бөгөөд бүх нам, эвслийн төлөөлөл багтжээ.

2012.10.16

Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн Улсын Их Хурлын сонгуулийн 10 дугаар тойрог (Өвөрхангай аймаг) -т явагдсан сонгогчдын санал хураалтын дүн (Сонгуулийн ерөнхий хорооны 148 тоот тогтоол) -г Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэв. Уг тогтоолоор Улсын Их Хурлын сонгуулийн 10 дугаар тойрогт сонгуульд оролцсон нийт сонгогчдын 40,39 хувийн санал авсан нэр дэвшигч Г.Батхүү, 34,02 хувийн санал авсан Д.Зоригт нарыг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцож буйгаа танилцуулав.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос байгуулагдсан Хууль зүйн яамны харъяа байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах хэсгийн гишүүд болох тус Байнгын хорооны дарга Ш.Түвдэндорж, Улсын Их Хурлын гишүүн Р.Бурмаа, Ж.Батзандан, Д.Ганбат нар Цагдаагийн ерөнхий газар болон Замын цагдаагийн газрын ажилтай танилцав.

2012.10.17

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухаан, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороод Монгол Улсын Засгийн газар, НҮБ -ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Даян дэлхийн байгаль орчны сантай хамтран “Хүнсний шим тэжээллэг чанар, биоаюулгүй байдал” сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулав.

2012.10.18

УИХ –ын чуулганы нэгдсэн хуралдаан (2012.10.19 –ний өдрийн) –аар хэлэлцэх асуудлын хуваарь гарав. Уг хуваарьт,

- Улсын Их Хурлын зарим гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай асуудал,
- Монгол Улсын 2011 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2011 оны санхүүгийн нэгдсэн тайлан /хоёр дахь хэлэлцүүлэг/ ... гээд нийт 11 асуудал оржээ.

2012.10.19

- УИХ -ын чуулганы нэгдсэн хуралдаан 10.00 цагт эхлэх ёстой байсан ч үүсээд буй нөхцөл байдлын улмаас хуралдаан цагтаа эхлээгүйгээр барахгүй хэзээ эхлэх нь тодорхойгүй байдалд оров. Өмнөх өдөр нь Төрийн ордны гадна МАН-ын гишүүд, дэмжигчид СЕХ-ны шийдвэрийг эсэргүүцэн жагсаж, Төрийн ордон руу гишүүдийг нэвтрүүлэхгүй, орж, гарах гарцыг хэсэг зуур хаасан бол энэ өдөр Төрийн ордон дотор ч МАН -аас УИХ-д сонгогдсон гишүүд чуулганы нэгдсэн хуралдааны танхимын ар, өвөр хаалгыг таглан суулт хийснээр УИХ -ын чуулган бүтэн өдөржингөө хуралдаж чадсангүй.

УИХ –ын чуулганы нэгдсэн хуралдаанаар нэр бүхий УИХ-ын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх асуудал болон Монгол Улсын 2011 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2011 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн хоёрдугаар хэлэлцүүлгийг эхлүүлэх ёстой байв. Түүнчлэн хэлэлцэх асуудлын дараалалд Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх зэрэг .. чухал асуудлууд орсон байв. Тухайлбал, хүүхдийн мөнгө, ахмадын тэтгэвэр, тэтгэмж, төсвийн байгууллагынхны цалин, иргэдийн эрүүл мэндийн даатгалтай холбоотой асуудал .. гэх мэт.

- УИХ-ын дарга З.Энхболд жагсагчдаас УИХ-ын үйл ажиллагаанд саад хийхгүй байх, гишүүдийг Төрийн ордонд нэвтрүүлэхийг хүссэн бөгөөд тэдгээр гишүүдийн тавьсан асуудлыг чуулганы хуралдаанаар хэлэлцэж, улмаар санал хурааж шийднэ гэдгээ хэлэв. Гэвч МАН -ын гишүүд асуудлыг хуралдааны танхимд орж хуулийн дагуу шийдвэрлэхээсээ илүү суулт, эсэргүүцлийг урьгал болгож байгаагаас олон асуудал шийдлээ хүлээсэн энэ эгзэгтэй үед улс орны ажил цалгардаж эхлэв.
- МАН-ын жагсаал цуглааны улмаас УИХ-ын чуулганы үдээс өмнөх нэгдсэн хуралдаан хоёр дахиа ийнхүү тасарч, улс орны төсөв санхүү, эдийн засгийн асуудлууд тэр хэмжээгээр гацаанд ороод байна гэж УИХ-ын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсээс мэдээлэв.

2012.10.22

Сүүлийн үед үүсээд буй улс төрийн нөхцөл байдалтай холбогдуулан УИХ-ын Тамгын



газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Шаравдорж өнөөдөр хэвлэл мэдээллийн ажилтнуудад хандан хууль эрх зүйн тайлбар хийв.

УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Шаравдорж, Өвөрхангайн тойрог буюу УИХ-ын сонгуулийн 10-р тойргийн мандатын асуудлаас болж, УИХ-ын чуулганы хуралдаан хоёр өдөр тасалдлаа. Өнгөрөгч долоо хоногт болж өрнөсөн үйл явдал улс төрийн шинжтэй учир УИХ-ын Тамгын газрын зүгээс оролцох боломжгүй юм.

Намууд аль аль талаасаа хуулийн дагуу асуудалд хандах хэрэгтэй. УИХ-ын Тамгын газар мэргэшсэн байгууллагын хувьд мэргэжлийн туслалцаа, техникийн бүрэн байдлыг хангах л үүрэгтэй.

Монгол Улсын Төрийн ордны тухай хуулийн 11.1.4-т “Төрийн ордон, түүний нутаг дэвсгэрт жагсаал, цуглаан, өлсгөлөн, суулт хийх зэргээр шаардлагаа илэрхийлэх, Төрийн ордонд нэвтрэгчид саад хийхийг хориглоно” хэмээн заасан байдаг. Харин хариуцлагын тухайд уг хуулийн 13.1.3. “Энэ хуулийн 11.1.4-д заасныг зөрчиж Төрийн ордон, түүний нутаг дэвсгэрт жагсаал, цуглаан, өлсгөлөн, суулт хийх зэргээр шаардлагаа илэрхийлсэн, Төрийн ордонд нэвтрэгчид саад хийсэн иргэнийг 20000 - 50000 төгрөг, албан тушаалтныг 20000 - 60000 төгрөг, байгууллагыг 50000 - 250000 төгрөгөөр торгоно” гэсэн байдаг. Тиймээс МАН-ын гишүүдийн энэ үйлдэл хууль зөрчиж байна гэв.

УИХ дахь МАН-ын гишүүд энэ өдрийн хуралдаанаараа эсэргүүцлийн суултаа үргэлжлүүлэхээр шийдвэрлэсэн байна. Энэ талаар УИХ-ын гишүүн Н.Энхболд, С.Бямбацогт, Д.Оюунхорол нар сэтгүүлчдэд мэдээлэл хийв.

УИХ-ын нэгдсэн чуулганд шинэ гишүүдийн тангараг өргөх асуудлыг хойшлуулсан тохиолдолд суултаа зогсоож, чуулгандаа суух ажээ. МАН-ын гишүүдийн хэлж байгаагаар тэд төрийн ажлыг гацаагагүй, хуулийн дагуу ажиллахыг л шаардаж байгаа юм байна.

УИХ-ын гишүүн Д.Оюунхорол, “Сонгуулийн ардчилал байх ёстой. МАН-ын гишүүд илт давуу ялалт байгуулсан байхад үр дүнг уландаа гишгэж байгаа нь зүйд нийцэхгүй. Жагсаал цуглаан хийж буй хөдөө орон нутгийн иргэдээ хүндлэх ёстой. Улс төрийн соёлтойгоор асуудалд хандаж, зөвшилцөж, хамтран ажиллах хэрэгтэй байна. Ийм үүргийг ч ард түмэн өгсөн байгаа” хэмээн байр сууриа илэрхийлэв.

УИХ-ын гишүүн Н.Энхболд, “УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэх асуудлын дараалалд өөрчлөлт оруулбал ирэх оны төсвөөс эхлээд бусад зүйлийг ярилцахад асуудалгүй. Төрийн ордонд суулт хийх нь хууль зөрчсөн хэрэг биш. Өлсгөлөндөө хараахан хүрээгүй байна. Хуулинд төрийн ордонд гэсэн заалт байхгүй” гэсэн бол УИХ-ын гишүүн С.Бямбацогт “Хуулийг буруу тайлбарлаж болохгүй” хэмээн мэдэгдэв.

2012.10.22

Улсын Их Хурлын дэд дарга Л.Цог, Улсын Их Хурлын гишүүн Д.Батцогт, Р.Бурмаа, З.Баянсэлэнгэ нар Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагаатай танилцлаа.

2012.10.23

Улсын Их Хурлын дэд дарга С.Баярцогт Канад Улсын Квебек хотноо болсон Олон улсын Парламентын Холбоо (ОУПХ)-ны 127 дугаар чуулганд оролцох үеэрээ “Даяаршлагдсан дэлхий ертөнц дэх иргэний харьяалал, шинж байдал болон хэл, соёлын олон янз байдал” сэдэвт тусгай хэлэлцүүлэгт үг хэлэв.

2012.10.25

Улсын Их Хурлын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулийг дагалдан өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2013 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2014 - 2015 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Концессын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2013 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэж батлав.

Концессын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Үнэт цаас гаргах зөвшөөрөл олгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж батлав. Ингэснээр Засгийн газраас 2012, 2013 онд таван тэрбум ам.долларын үнэт цаасыг олон улсын зах зээлд арилжаалах эрхтэй болж байгаа бөгөөд эхний ээлжинд 1.5 тэрбум ам.долларын бонд гаргаж урт болон дунд хугацааны бүтээн байгуулалтын ажилд зарцуулах юм. Улсын Их Хурлаас Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэг, Г.Уянга, Эрүүл мэндийн сайд Н.Удвал нар хэвлэлийн бага хурал хийлээ.

2012.10.26

Улсын Их Хурлын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар “Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2012 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын 2011 оны 53 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгаас Сангийн сайдад тавьсан асуулгын хариуг сонсов.

2012.10.26

“Амьдрал бэлэглэе” хүмүүнлэгийн сайн үйлсийн аяныг дэмжин, Төрийн ордонд ажиллаж буй явуулын цусны төвд УИХ -ын дарга З. Энхболд цусаа хандивлав.

2012.10.29

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлаас томилогддог байгууллагуудын удирдлагад хандаж шинэ жил, бусад тэмдэглэлт баярыг тохиолдуулан төрийн байгууллагууд харилцан илгээдэг ил захидал, баярын цаасан мэндчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх санаачлага гаргав. Цаашид төсвийн байгууллагуудын хувьд тэмдэглэлт үйл явдал, баярыг ёслол өнгөрүүлэхдээ аль болох бага зардлаар энгийн тэмдэглэх нь зүйтэй гэсэн чиглэл өгөв. Шинэ жил, бусад тэмдэглэлт баярыг тохиолдуулан төрийн байгууллагууд харилцан илгээдэг ил захидал, баярын цаасан мэндчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхийг Улсын Их Хурлын дарга З.Энхболд уриалгыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар талархан дэмжиж, уг уриалгыг хэрэгжүүлж ажиллахыг харьяаны байгууллагуудын төсвийн ерөнхийлөн захирагчдад үүрэг болголоо.



2012.10.30

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны хуралдаанаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байр, биеийн тамирын заалны барилга хангамжийн талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоол батлав.

2012.10.31

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Ардчилал, сонгуулийн туслалцааны олон улсын хүрээлэн хамтран “Бодлогын шинэчлэл ба улс төрийн үйл ажиллагааны санхүүжилт” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав.

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны гишүүн З.Баянсэлэнгэ, Л.Эрдэнэчимэг нар Төв аймгийн Батсүмбэр сумын гуравдугаар багийн нутаг, Баянголын аманд байрлах Улсын асрамжийн газрын үйл ажиллагаатай танилцлаа.

2012.11.02

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах талаар Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, үйл ажиллагаа болон Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийг ашиглах талаар Засгийн газраас баримталж байгаа бодлогын талаар Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг мэдээлэл хийв.

2012.11.06

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Парламентын сэтгүүлчдийн холбоо, Монголын хэвлэлийн хүрээлэн хамтран хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлчдийн дунд “Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль”-ийн төслийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулав.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулахаар тогтов.

2012.11.07

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны хуралдаанаар Эдийн засгийн байнгын хорооны гишүүдтэй хамтран Барилгын тухай болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн биелэлтийг шалгаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг сонслоо.

Улсын Их Хурлын бүтцэд шинээр байгуулагдсан Өргөдлийн байнгын хороо анхны хуралдаанаа хийж, Газрын тухай хуулийн зарим заалтын биелэлтийг хянан шалгаж, энэ чиглэлээр дүгнэлт гаргах, хэлэлцүүлэг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандангаар, Дархан-Уул аймгийн Хонгор сумын иргэдээс ирүүлсэн өргөдлийг судалж шийдвэрлэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их

Хурлын гишүүн С.Ганбаатар ахлуулан байгуулахаар тогтов.

2012.11.08

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хүсэлтийг нь үндэслэн У.Хүрэлсүхийг Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлж, энэ тухай Улсын Их Хурлын тогтоол батлав.

Улсын Их Хурлын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Шаравдоржийг үүрэгт ажлаас нь чөлөөлж, Б.Болдбаатарыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргаар томилов.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийж баталлаа. Уг хуулиар “Монгол бахархлын өдөр: арваннэгдүгээр сарын 14” гэснийг “Чингис хааны өдөр: Их эзэн Чингис хааны мэндэлсэн өвлийн тэргүүн сарын шинийн нэгэн” хэмээн нэрлэхээр болж, Их эзэн “Чингис хааны өдөр”-өөр бүх нийтээр амарч, тэмдэглэхээр зохицуулав.

“Чингис хаан” одон бий болгох тухай Улсын Их Хурлын 2002 оны 21 дүгээр тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлав.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдав. Монгол Улсын 2013 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг эцэслэн батлав.

2012.11.09

Улсын Их Хурлын дарга З.Энхболд 132 тоот захирамж гаргаж, 2014-2016 онуудад улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтыг төлөвлөх асуудлаар иргэдтэй санал солилцох зорилгоор Улсын Их Хурлын 2012 оны намрын ээлжит чуулганыг 2012 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс 2012 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл түр завсарлуулав.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн ахлагч Д.Эрдэнэбат, “МАХН-МҮАН-ын Шударга ёс эвсэл”-ийн бүлгийн ахлагч Н.Батцэрэг, Улсын Их Хурал дахь Монгол ардын намын гишүүдийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нар Аймаг, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын сонгуулиар зарим аймаг, тойрог, хэсгийн хороодод сонгуулийн хуулийг зөрчин иргэдийн сонгох, сонгогдох эрхийг боогдуулсан гэх маргаан гарч байгаатай холбогдуулан хамтарсан мэдэгдэл гаргаснаа хэвлэлийнхэнд мэдэгдэв.

Уг мэдэгдэлд нэр дэвшигчдийн сонгох сонгогдох эрхийг хязгаарлаж, хууль бус үйлдэл, үйл ажиллагаа явуулахгүй байх, нэр дэвшигчдийг бүртгэх ажиллагааг хуулийн дагуу шийдвэрлэх, орон нутгийн төсөв хөрөнгийг хуульд зааснаас бусад тохиолдолд сонгуулийн холбогдолтой үйл ажиллагаанд зарцуулахгүй байх, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд иргэдэд мэдээллийг тэнцвэртэй хүргэх бололцоог хангах, улс төрийн нам, эвсэл холбоод улс төрийн тогтвортой байдлыг хадгалан олон түмнийг хэтэрхий талцуулж, хагаралдуулахгүй соёлтой оролцохыг уриалав.

2012.11.12

Бүгд Найрамдах Чех Улсын Прага хотноо зохиогдож байгаа НАТО-гийн Парламентын



Ассамблейн 58 дугаар хуралд Монгол Улсын Их Хурал анх удаа ажиглагчаар оролцов.

Ассамблейн хурлын хүрээнд зохиогддог байнгын хороодын хуралдаанд Монгол Улсын Их Хурлыг төлөөлөн оролцож байгаа Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэг НАТО-гийн Парламентын Ассамблейн Ерөнхийлөгч Др.Карл Ламмерстай уулзав

2012.11.12-14

Улсын Их Хурлын дарга З.Энхболд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2014 - 2016 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтыг төлөвлөх, иргэдтэй санал солилцох зорилгоор Сэлэнгэ, Дархан-Уул аймагт томилолтоор ажиллаж, орон нутгийн ажил байдалтай танилцав.

2012.11.14

Улсын Их Хурал Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж жил бүрийн өвлийн тэргүүн сарын шинийн нэгнийг “Монгол бахархлын өдөр” хэмээн зарлаж Их эзэн Чингис хааны мэндэлсэн өдрийг тэмдэглэж байхаар хуульчилсан. Энэ дагуу Их эзэн Чингис хааны мэндэлсний 850 жилийн ойн хүндэтгэлийн хурал Төрийн ордонд болж, Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Улсын Их Хурлын дарга З. Энхболд, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг болон төрийн түшээд нийгэм, соёлын зүтгэлтнүүд оролцов.

2012.11.15-16

Улсын Их Хурлын дарга З.Энхболд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2014-2016 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтыг төлөвлөх, иргэдтэй санал солилцох зорилгоор Өвөрхангай аймагт ажиллаж, иргэд сонгогчидтой уулзаж орон нутгийн ажил байдалтай танилцав.

2012.11.18-22

Улсын Их Хурлын даргын урилгаар БНАСАУ-ын Ардын Дээд Хурлын дарга Чой Тэ Бок тэргүүтэй төлөөлөгчид манай улсад албан ёсны айлчлал хийв.

2012.11.20

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын гадаад бодлого, хилийн чанад дахь монгол иргэдийн эрхийг хамгаалах тухай асуудлаар Гадаад харилцааны сайдын мэдээллийг сонсов.

2012.11.20

Урал дахь Монгол Улсын Өргөмжит консул Владимир Воротников Улсын Их Хурлын дарга З.Энхболдод Б.Н.Ельциний нэрэмжит Уралын их сургуулийн хүндэт төгсөгчийн анхны дипломыг гардуулав.

2012.11.21

Аймаг, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль орон даяар явагдаж УИХ-ын дарга З.Энхболд харьяалагдах дүүрэгтээ буюу Сүхбаатар дүүргийн дөрөвдүгээр хороо, сонгуулийн зургаадугаар хэсэг дээр ирж саналаа өгөв.

2012.11.23

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэг, Р.Бурмаа, С.Одонтуяа, Л.Эрдэнэчимэг нараас “Төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн эрчим хүчний асуудлаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийн талаар Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг сонслоо.

2012.11.26

Улсын Их Хурлын сонгуулийн 22 дугаар тойрог буюу Баянзүрх дүүрэгт явагдсан дахин санал хураалтад оролцсон 44923 сонгогчийн буюу 43,1 хувийн санал авсан нэр дэвшигч Дашжамцын Арвинг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай тогтоолын төслийг Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэв.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Бүгд Найрамдах Улс тунхагласны 88 жилийн ойн баярын өдрийг тохиолдуулан нийт ард түмэндээ мэндчилгээ дэвшүүлээ.

2012.11.27

Монгол Улсын цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссоос “Хэлмэгдэгчид, тэдгээрийн үр хүүхдэд тэтгэмж үзүүлэх тухай хуулийн хэлэлцүүлэг” зохион байгуулав. Уг арга хэмжээнд Улсын Их Хурлын дэд дарга, Монгол Улсын цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын дарга Л.Цог, Улс төрийн хэлмэгдэгсдийн холбоо болон их хэлмэгдүүлэлтэд хохирогчдын үр хүүхдүүд оролцож, хэлмэгдэгсэд, тэдний үр хүүхдэд үзүүлэх нийгмийн халамжийн эрх зүйн зохицуулалтын асуудлаар санал бодлоо солилцов.

2012.12.05

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улс Авлигын эсрэг олон улсын академийг олон улсын байгууллага болгон үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт нэгдэн орох тухай хуулийн төслийг батлав.

Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллага Интерпол, Европын залилангийн гэмт хэрэгтэй тэмцэх алба зэрэг байгууллагын дэмжлэгтэйгээр НҮБ -ын Мансууруулах бодис, гэмт хэргийн алба болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар Авлигын эсрэг олон улсын академийг 2010 оны 9 дүгээр сард албан ёсоор нээжээ. Одоогоор нийт 53 улс тус академид олон улсын байгууллагын статус олгох тухай хэлэлцээрт гарын үсэг зурж, тэдгээрээс 29 улс нэгдэн ороод байгаа аж.

2012.12.06

Улсын Их Хурлын дарга З.Энхболд “Баялаг бүтээгчдэд талархъя” уулзалтын арга хэмжээг нээж үг хэлэв.

2012.12.07

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсаас гадаад улсад суух зарим Элчин сайдыг томилох, эгүүлэн татах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг зөвшилцөж Монгол Улсаас Австри Улсад суух Элчин сайдаар Г.Батжаргалыг, АНУ-д суух Элчин сайдаар Б.Алтангэрэлийг, Бүгд Найрамдах Казахстан Улсад суух Элчин сайдаар Ж.Сүхээг, Лалын Бүгд Найрамдах Афганистан Улсад суух Элчин сайдаар О.Дамбийнямыг, Бельгийн Вант улс болон Европын Холбоонд суух Элчин сайдаар



Х.Даваадоржийг, Кувейт Улсад суух Элчин сайдаар С.Энхбатыг, БНСУ-д суух Элчин сайдаар Б.Ганболдыг, Бүгд Найрамдах Турк Улсад суух Элчин сайдаар Б.Батхишигийг тус тус томилохыг дэмжив.

Чуулганы үдээс хойших нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг “Олон улсын зах зээл дээр арилжаалсан 1,5 тэрбум ам. долларын үнэт цаасны тухай” мэдээлэл хийв. Ерөнхий сайд мэдээлэлдээ “Улсын Их Хурлын 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 52 дугаар тогтоолоор Засгийн газрын үнэт цаасыг анх удаа олон улсын зах зээл дээр гаргах асуудлыг баталсан.

Өнөөдрийн байдлаар нийтдээ 5 тэрбум ам.долларын үнэт цаас гаргах энэ хөтөлбөрийн хүрээнд эхний үе шат болгож 1,5 тэрбум ам.долларын “Чингис” бондыг Засгийн газар эхний 100 хоногт багтааж амжилттай арилжааллаа. Арилжаалсан бондын мөнгө орж ирсэн. Энэ мөнгөөр нэн даруй барьж байгуулах шаардлагатай байгаа уул уурхай, авто зам, эрчим хүч, орон сууцны дэд бүтэц, төмөр замын томоохон төслүүдийг хэрэгжүүлнэ гэдгийг мэдэгдэв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул хийх болон ураны олборлолтын үйл ажиллагааны эсрэг Улсын Их Хурлын албан бус бүлэг байгуулж байгаагаа сэтгүүлчдэд мэдэгдэв. Одоогоор уг албан бус бүлэгт Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Х.Болорчулуун, С.Бямбацогт, С.Ганбаатар нар нэгдээд бол Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлалын сайд Ц.Оюунгэрэл дэмжиж ажиллахаа илэрхийлжээ.

2012.12.10

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаатай танилцав. Улсын Их Хурлын даргыг Улсын Их Хурлын дэд дарга Л.Цог, Хууль зүйн байнгын хорооны ажлын хэсгийн гишүүд болох Хууль зүйн байнгын хорооны дарга Ш.Түвдэндорж, Өргөдлийн байнгын хорооны дарга Р.Бурмаа, УИХ-ын гишүүн Д.Ганбат, Д.Батцогт, О.Баасанхүү нар дагалдан ажиллав.

2012.12.11

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны хуралдаанаар Сэтгэцийн эрүүл мэндийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Г.Баярсайханаар ахлуулан байгуулав.

2012.12.12

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Хууль зүйн байнгын хороо, “Глоб интернэшнл” төрийн бус байгууллага, АНУ-ын Элчин сайдын яам болон “Олон улсын чөлөөт илэрхийллийн сүлжээ” зэрэг байгууллагууд хамтран “Гүтгэлэг, доромжлол гэмт хэрэг мөн үү?” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлгийн үеэр Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцэх гэж буйтай холбогдуулан уг хуулийн төслийг дагалдан нэмэлт, өөрчлөлт оруулахаар өргөн мэдүүлсэн Монгол Улсын эрүүгийн тухай хуулийн гүтгэлэг, доромжлолтой холбоотой 110, 111 дүгээр заалт болон ийм төрлийн гомдлыг Иргэний хуулиар шийдвэрлэдэг болох талаар санал бодлоо солилцов.

2012.12.13

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай асуудад хэлэлцэж, Улсын Их Хурлын сонгуулийн 10 дугаар тойрогт нэр дэвшин өрсөлдсөн Г.Батхүү, 22 дугаар тойрогт явуулсан дахин санал хураалтаар ялалт байгуулсан Д.Арвин, өөрийн хүсэлтээр Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөгдсөн У.Хүрэлсүхийн оронд жагсаалтаар нэр дэвшигчдийн дарааллын дагуу сонгогдсон Д.Сарангэрэл нарын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн тогтоол баталж, шинээр сонгогдсон гишүүд тангараг өргөв.

Хүний хөгжил сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэж батлав.

Чуулганы үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүүгээс тавьсан Монгол Улсын түүх, соёлын дурсгалт газрын харуул хамгаалалт, засвар үйлчилгээ ямар түвшинд байгаа болон Эрдэнэзуу хийдийн өнөөгийн байдлын талаарх асуулгын хариуг Соёл, спорт, аялал жуулчлалын сайд Ц.Оюунгэрэл өгч дэлгэрэнгүй мэдээлэл хийв.

Улсын Их Хурлын гишүүн, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дарга З.Баянсэлэнгэ тэргүүтэй ажлын хэсэг ШШГЕГ-ын харьяа 407 дугаар анги буюу Эмэгтэйчүүдийн хорих анги, 411 дүгээр анги буюу Хүүхдийн хорих анги, Хүүхэд асран хүмүүжүүлэх төвийн ажил байдалтай танилцав.

2012.12.18

Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүдийн албан бус бүлгийн ахлагч Л.Эрдэнэчимэг, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянга, С.Одонтуяа нар нийслэлийн Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Хархорин захын үйл ажиллагаатай танилцаж, түрээслэгчидтэй уулзав.

2012.12.19

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэгээс Уул уурхайн сайдад тавьсан “Монгол Улсад хариуцлагатай уул уурхай бий болгох, хөгжүүлэхээр төлөвлөж буй ажлын талаар болон Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт 2012 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр 4 хүний амийг хохироосон хэрэг гарсантай холбогдуулан тавьсан асуултын хариуг сонсов.

2012.12.20

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтын зарим хэсэг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн Хуулийн цэцийн 2012 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 05 дугаар дүгнэлтийг хэлэлцэв.

“Төрийн албаны зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх тухай” болон “Төрийн албаны зөвлөлийн гишүүнийг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэв.

Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүн Б.Өнөбаатар тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн тул 2012 оны 12 дугаар 31-ний өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас чөлөөлж,



Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнээр Даваанямын Даваа-Очирыг томилов.

Хүнсний тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн төсөл, Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Давс йоджуулж йод дутлаас сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг батлав.

Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооноос Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, Иргэний нийгмийн байгууллагуудын 5 дахь удаагийн уулзалтыг зохион байгуулж, НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлийн “Хүний эрхийн төлөв байдлын талаарх ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг”-ийн зөвлөмжүүд, түүний хэрэгжилтийн талаарх асуудлыг хэлэлцэв. НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлөөс хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор 2008 оноос улс орнуудын хүний эрхийн төлөв байдлыг хэлэлцэж байх шинэ механизм хэрэгжүүлж эхэлжээ.

2012.12.21

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэж баталлаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, уг хуулийг дагалдан гарах хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийж батлав.

Уг хуулийн төсөлд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулиар гадаадад байгаа иргэдийн санал авах өдрийг гурав хүртэл байх; сонгууль зохион байгуулахад улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын гаргах зардлыг тодруулан тусгах; нэр дэвшигчид өгөх хандивын хэмжээг хуулийн этгээдээс тавин сая төгрөгөөс илүүгүй байх; сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогчийн 50 хувь нь сонгуульд оролцоогүй бол ирц хүрээгүй тухайн хэсэгт нэмэлт санал хураалт явуулах тухай шийдвэрийг Сонгуулийн ерөнхий хороо гаргах, уг нэмэлт санал хураалтад эхний санал хураалтад оролцоогүй, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогч оролцож саналаа өгөх, сонгогчдын ирц, саналын тоог эхний санал хураалтад оролцсон сонгогчдын ирц, саналын тоон дээр нэмж тооцох зэрэг саналуудыг төсөлд тусгаж, зохих өөрчлөлтүүдийг оруулан хуулийн төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр зөвхөн найруулга, үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй завсар хийжээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг баталлаа.

Чуулганы үдээс хойших нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг Жижиг, дунд үйлдвэрийн талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаашид дэвшүүлж буй зорилтын талаар гишүүдэд мэдээлэл хийв. Мэдээлэлтэй холбогдуулан гишүүд Ерөнхий сайд болон Хөдөлмөрийн сайдаас асуулт асууж, саналаа хэллээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын

Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан Монгол ардын намын төлөөллийн гишүүдийн хувьд Улсын Их Хуралд бүлэг байгуулах боломж бүрдсэн тул Улсын Их Хурлын гишүүн, Монгол ардын намын дарга Ө.Энхтүвшин Монгол ардын намын бүлэг хуралдаж Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдоор ахлуулсан нийт 25 гишүүн бүхий Монгол ардын намын бүлэг албан ёсоор байгуулагдаж байгааг танилцуулж, шийдвэрээ Улсын Их Хурлын даргад гардуулж өгөв.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Монгол ардын намын бүлгийн гишүүдийн нэрс бүхий танилцуулгыг хүлээн аваад Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлэг албан ёсоор байгуулагдсаныг мэдэгдэж баяр хүргээд ирэх долоо хоногоос Байнгын хороод хуралдаж, байнгын хорооны гишүүдийн талаар шийдвэр гаргах болно гэдгийг мэдэгдлээ.

2012.12.25

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Монгол Улсад уул уурхайн салбар үүсч хөгжсөний 90 жилийн ойг тохиолдуулан үе, үеийн уурхайчид, салбарын ажилтан, ажиллагсдад баярын мэндчилгээ дэвшүүлэв.

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгүүдийг Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэг, С.Ганбаатар нараар ахлуулан байгуулав.

2012.12.26

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Сонгуулийн ерөнхий хороо байгуулагдсаны 20 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсад сонгуулийн ардчиллыг хөгжүүлэх үйл хэрэгт үнэтэй хувь нэмэр оруулж ирсэн тус хамт олонд баярын мэндчилгээ дэвшүүлээ.

Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны хуралдаанаар Хүний эрхийн Үндэсний Комиссын “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 11 дэх илтгэл”-ийг хэлэлцэв.

2012.12.27

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай асуудал хэлэлцэж, Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгээс Улсын Их Хурлын дэд даргаар Миеэгомбын Энхболдыг сонгож батлав.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Ганбатын Эрдэнэбатыг Улсын ерөнхий прокурорын орлогчоор томилох асуудлыг зөвшилцөхөөр Улсын Их Хуралд санал ирүүлснийг хэлэлцэж дэмжив.

2012.12.28

Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунбаатар Улсын Их Хурлын 74 дэх гишүүн болж тангараг өргөснөөр МАХН, МҮАН-ын “Шударга ёс” эвсэл Улсын Их Хуралд 11 суудалтай болов.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Гаалийн тухай хуульд өөрчлөлт





оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиуд батлагдав.

Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохыг хориглох тухай хуулийн хугацааг 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн дахин сунгахаар болов. Мөн Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай, “Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолууд батлагдав.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчдийн газрын тэргүүн нартай уулзав. Улсын Их Хурал хилийн чанадад ажиллаж, амьдарч байгаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах асуудалд онцгой ач холбогдол өгч байгаа. Тиймээс суугаа орондоо эх орныхоо нүд чих болж эх орон, иргэдийнхээ эрх ашгийг эрхэмлэн хамгаалж, иргэдтэйгээ байнга холбоотой, тэдэндээ түргэн шуурхай үйлчилж, тусалж дэмжиж ажиллах шаардлагатайг Улсын Их Хурлын дарга дипломат төлөөлөгчдөд зөвлөв.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл байгуулагдсаны 20 жилийн ойд зориулсан баярын хуралд оролцогчдод илгээлт хүргүүлж, баярын мэндчилгээ дэвшүүлэв.

2012.12.29

Монгол Улс үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 101 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Улсын Их Хурлын дарга З.Энхболд, Ерөнхий сайд Н.Алтанхуяг нар Төрийн тамганы хөшөөнд цэцэг өргөв. Цэцэг өргөх ёслолд Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд оролцов.

2012.12.30

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Монголын хүүхдийн ордноос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Харшийн сүлд мод”-ны наадамд гэр бүлийн хамт оролцож, авъяаслаг хүүхдүүдийн тоглолтыг үзэж сонирхон тэргүүний хүүхдүүдэд бэлэг гардуулж, шинэ жилийн мэндчилгээ дэвшүүлэв.

\*\*\*

## 2013

2013.01.03

Улсын Их Хурлын 2012 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын болон Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийг батлав.

2013.01.04

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг улс орны цаг үеийн ажил, хаврын бүтээн байгуулалтын ажлын бэлтгэлийн талаар мэдээлэл хийв.

2013.01.10

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Хадгаламжийн даатгалын тухай хууль болон бусад дагалдах хуулийн төслүүд, “Улсын Их Хурлын даргын ажлын хэсгийн орон тоог батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай” тогтоолын төслийг хэлэлцэн батлав.

Төрийн албаны зөвлөлийн даргыг чөлөөлөх, томилох тухай асуудлыг хэлэлцэж, Төрийн албаны зөвлөлийн дарга Д.Зүмбэрэллхамыг үүрэгт ажлаас нь чөлөөлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болгосны дагуу Төрийн албаны зөвлөлийн даргаар Б.Цогоог томилов.

2013.01.11

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар “Байнгын хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоол батлав.

Чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж оролцож, улс орны үндэсний аюулгүй байдлын чиглэлээр Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүдийг оролцуулан хаалттай мэдээлэл хийлээ.

Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсаны 21 жилийн ойд зориулсан үзэсгэлэн Төрийн ордон дахь Төрийн түүхийн музейд нээгдэв.

2013.01.13

Улсын Их Хурлын дарга З.Энхболд ардчилсан шинэ Үндсэн хууль баталсны 21 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан Монгол Улсын хөдөлмөрийн баатар, гавьяат хуульч, шинэ Үндсэн хуулийн эхийг баригч Б.Чимэдэд хүндэтгэл үзүүлэв.

2013.01.13

Монгол Улсын ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсаны 21 жилийн ойг тохиолдуулан Улсын Их Хурлын даргын ивээл дор зохион байгуулагдаж буй сонирхогчдын шатрын нийслэлийн аварга шалгаруулах анхдугаар нээлттэй тэмцээн Төрийн ордонд болов.

2013.01.14

Авлигын эсрэг парламентчдын дэлхийн байгууллага (ГОРАС)-ын Монгол дахь салбар бүлэг Улсын Их Хуралд суудалтай бүх нам, эвслийн төлөөлөл бүхий 12 гишүүний



бүрэлдэхүүнтэйгээр Улсын Их Хуралд шинэчлэгдэн байгуулагдсан талаар тус бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Р.Бурмаа, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, М.Батчимэг, Я.Содбаатар, С.Дэмбэрэл нарын хэвлэлийн бага хурал хийв.

2013.01.16

Улсын Их Хурлын дарга З.Энхболд төрийн байгууллагуудад хандаж оюуны өмчийн зөрчилгүй программ хангамжийн бүтээгдэхүүн хэрэглэхийг уриалсан Уриалга гаргав.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Монгол Улсын Их Хурлын дарга З.Энхболд, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг нар гадаад орнуудаас Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчдийн газрын тэргүүн нарыг Төрийн ордны Ёслол хүндэтгэлийн их танхимд хүлээн авч уулзаж, шинэ оны мэндчилгээ дэвшүүллээ.

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар “Уул уурхайн хөгжил” түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дэмжив.

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон дагалдах бусад хуулийн төслийн талаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулав.

2013.01.16

УИХ-ын дарга З.Энхболд монгол хэлээ “Google translate”-д оруулах санаачлага гаргаж, өөрийн твиттер хуудсаараа дамжуулан иргэдээс санал аваад байсан билээ. Уг санаачлагын хүрээнд парламентын тэргүүн мэдээлэл, технологийн чиглэлийн мэргэжилтнүүдтэй уулзаж “Google translate”-д эх хэлээ хэрхэн богино хугацаанд оруулж болох талаар санал солилцов.

2013.01.17

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Шүүхийн тухай багц хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, зарим хуулиудад өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудыг батлав.

2013.01.18

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Д.Батбаярыг Төрийн албаны зөвлөлийн гишүүнээс чөлөөлж, Тогмидын Хадхүүг Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнээр томилов.

2013.01.21

Улсын Их Хурлын дарга З.Энхболд “Нээлттэй эхийн программ хангамжийг нэвтрүүлэх, хөгжлүүлэх боломж” сэдэвт хэлэлцүүлгийг нээж үг хэлэв.

2013.01.22

Улсын Их Хурлын бүтцийн шинэ байгууллага болох Өргөдлийн байнгын хороо анхны хуралдаанаа хийж, “Өргөдлийн байнгын хорооны дүрэм батлах тухай” байнгын хорооны тогтоол батлав.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Авлигатай тэмцэх газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран “НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн хэрэгжилт Монголд” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав.

2013.01.30-02.01

Улсын Их Хурлын дарга З.Энхболдын урилгаар Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хорооны дарга У Бангуо манай улсад албан ёсны айлчлал хийлээ. Айлчлалын үеэр Монгол Улсын Их Хурлын дарга З.Энхболд, БНХАУ-ын Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хорооны дарга У Бангуо нар хэлэлцээ хийж, Монгол Улсын Их Хурал, БНХАУ-ын Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал хоорондын хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурав.

2013.01.31

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай /шинэчилсэн найруулга/, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудыг батлав.

Монгол Улсаас гадаадын зарим улсад суух Элчин сайдыг томилох, эгүүлэн татах тухай асуудал хэлэлцэж, Ш.Алтангэрэлийг Монгол Улсаас ОХУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Н.Тулгыг Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, З.Алтайг Шведийн Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Л.Дүгэржавыг Бүгд Найрамдах Болгар Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Д.Зүмбэрэлхамыг Бүгд Найрамдах Чех Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар тус тус томилох Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг зөвшилцөж дэмжив.

“Уул уурхайн хөгжил” түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдав.

2013.02.01

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг Оюутолгойн ордын асуудлаар мэдээлэл хийж, Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж оролцов.

2013.02.06

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос “Ардчилсан нийгэм дэх аюулгүй байдлын салбарын шинэчлэл” сэдэвт дугуй ширээний ярилцлагыг Төрийн ордонд хаалттай горимоор зохион байгуулав.

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хороо Улсы Их Хурлын 2012 оны намрын чуулганы хугацаанд хийсэн ажлаа тайлагнав.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо Улсын Их Хурлын 2012 оны намрын чуулганы хугацаанд хийсэн ажлаа тайлагнав.

2013.02.07

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоол батлав.



Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хаягжуулалтын тухай, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудыг батлав.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Бага, дунд боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиуд батлагдав.

2013.02.07

Улсын Их Хурлын дарга З.Энхболд ард түмэндээ сар шинийн баярын мэндчилгээ дэвшүүлэв. Улсын Их Хурлын 2012 оны намрын ээлжит чуулган өндөрлөв. Ээлжит чуулганыг хааж Улсын Их Хурлын дарга З.Энхболд үг хэлэв.

2013.02.07

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Билгийн тооллын XVII жарны “Тийн ялгуусан” хэмээх усан могой жилийн хаврын тэргүүн сарын шинийн нэгний өглөө Төрийн есөн хөлт цагаан туганд хүндэтгэл үзүүлж, төрийн золголтод оролцов.

2013.02.14

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын 2012 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэж баталсан хууль тогтоомж болон улс орны цаг үеийн асуудлаар өдөр тутмын зарим сонин, МҮОНТ, Ийгл, NTV, Блүүмберг, ETV зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага өгөв.

2013.02.15

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо Улсын Их Хурлын 2012 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийсэн ажлаа тайлагнаж, хэвлэлийн бага хурал хийв.

2013.02.18

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо 2012 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийсэн ажлаа тайлагнав. Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо 2012 оны намрын чуулганы хугацаанд хийсэн ажлаа тайлагнаж, хэвлэлийн бага хурал хийлээ.

2013.02.20

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо Улсын Их Хурлын 2012 оны намрын чуулганы хугацаанд хийсэн ажлаа тайлагнаж, сэтгүүлчдэд мэдээлэл хийв.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгт ажиллав.

2013.02.25

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар зохион

байгуулсан “Шууд ардчилал” иргэдийн оролцоотой төсвийн менежментийн үндэсний сургалт, зөвлөгөөнд оролцож илтгэл тавилаа. Тэрбээр энэ Улсын Их Хурал орон нутагт төсвөө бүрэн мэдэж зарцуулах эрх мэдлийг анх удаа өгсөн гэдгийг онцлов.

2013.02.27

Улсын Их Хурлын дарга З.Энхболд “Эмэгтэйчүүдийн хөгжлийн бодлого-шинэчлэл” сэдэвт үндэсний чуулганд оролцогчдод мэндчилгээ дэвшүүлэв.

2013.02.28

Улсын Их Хурлын дарга З.Энхболд, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга Б.Гарамгайбаатар нар Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөнд оролцов.

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2012 оны намрын чуулганы хугацаанд хийсэн ажлын тайлагнаж, сэтгүүлчдэд мэдээлэл хийв.

2013.03.01

Улсын Их Хурлын даргын 26 тоот захирамжийн дагуу байгуулагдсан Монгол Улсын сонгуулийн нэгдсэн хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг анхны хуралдаанаа хийв.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга А.Бакей, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар нар НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн суурин төлөөлөгч хатагтай Сезин Синаноглу, Орлогч суурин төлөөлөгч ноён Томас Эриксон болон Швейцарийн хөгжлийн агентлагийн дэд суурин төлөөлөгч ноён Дийпак Элмер нарыг хүлээн авч уулзлаа.

2013.03.06-09

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Монголын үндэсний сэтгүүл зүйн 100 жилийн ойг тохиолдуулан нийт сэтгүүлчид, хэвлэл, мэдээллийн ажилтнуудад баяр хүргэж, мэндчилгээ дэвшүүлэв. Улсын Их Хурлын дарга З.Энхболд Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймагт томилолтоор ажиллаж, орон нутгийн ажил амьдрал, бүтээн байгуулалтын ажилтай танилцан Улсын Их Хурлын 2012 оны намрын чуулганы үйл ажиллагааны талаар иргэд сонгогчдод мэдээлэл хийлээ.

2013.03.07

Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүдийн албан бус бүлэг хүүхэд, эмэгтэйчүүдийн асуудлаар НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран ажиллахаар болж, харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав.

2013.03.13

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Парламентын Ассамблейн Ерөнхийлөгч Рикардо Миглиори тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.

2013.03.13

Улсын Их Хурлын дарга З.Энхболд, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн суурин төлөөлөгч,



хатагтай Сезин Синаноглу нар “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төсөл, Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн баримт бичигт гарын үсэг зурав.

2013.03.14

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Ц.Цолмон, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Л.Болд, Ё.Отгонбаяр нар Онцгой байдлын ерөнхий газрын үйл ажиллагаатай танилцав.

2013.03.20

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хороо Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр хэлэлцүүлэг зохион байгуулав.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос байгуулагдсан Ерөнхийлөгчийн сонгуулийн бэлтгэл ажлын явцтай танилцах ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга М.Энхболд, Улсын Их Хурлын гишүүн Д.Батцогт нар Улсын бүртгэлийн ерөнхий газар, Сонгуулийн ерөнхий хорооны удирдлагуудтай уулзав.

2013.03.20-26

Улсын Их Хурлын дарга З.Энхболд АНУ-д албан ёсны айлчлал хийлээ. Улсын Их Хурлын дарга айлчлалынхаа үеэр АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргын нэгдүгээр орлогч У.Бёрнз, АНУ-ын Конгрессын Төлөөлөгчдийн танхимын спикер Жон Бэйнер, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мүүн нартай уулзаж, хоёр талын хамтын ажиллагааны талаар санал солилцов.

2013.03.22

Улсын Их Хурлын дарга З.Энхболд казах түмэнд нарны баяр (наурыз) -ын мэндчилгээ дэвшүүлэв.

2013.03.25

Улсын Их Хурлын Хууль зүйн болон Аюулгүй байдлын байнгын хороодын хамтарсан тогтоолоор байгуулагдсан Хилийн боомтын тухай хуулийн төслийг чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэг, Д.Батцогт нар Дорноговь аймгийн Замын-Үүд боомтын үйл ажиллагаатай танилцаж, Хилийн боомтын тухай хуулийн төслийн талаар мэргэжлийн байгууллагуудын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг зохиов.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Цог, Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Б.Гарамгайбаатар, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Г.Баярсайхан, Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан нар Хөтөлийн “Цемент-Шохой” ХК-ийн үйл ажиллагаатай танилцав.

2013.03.26-28

Улсын Их Хурлын дарга З.Энхболд тэргүүтэй Монголын парламентын төлөөлөгчид Канад Улсад албан ёсны айлчлал хийв. Улсын Их Хурлын дарга айлчлалынхаа үеэр Канад Улсын Нийтийн танхимын спикер А.Шийр, Парламентын сенатор П.К.Нолин,

Хүнс, хөдөө аж ахуйн сайд Жерри Ритц, Гадаад хэргийн сайд Жон Бэйрд, Олон улсын худалдааны сайд Э.Фаст нар болон Канадын экспортын хөгжлийн агентлагийн удирдлагууд, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа Канадын компаниудын төлөөлөгчидтэй уулзаж, санал солилцов.

2013.03.31

Улсын Их Хурлын дарга З.Энхболд манай улсад албаны ёсны айлчлал хийж байгаа Япон Улсын Ерөнхий сайд Шинзо Абэг хүлээн авч уулзав.

2013.04.01

Улсын Их Хурлын дарга захирамж гаргаж, Улсын Их Хурлын 2013 оны хаврын чуулганы нэгдсэн хуралдааныг долоо хоногийн Пүрэв, Баасан гарагт өглөө 09 цагаас эхэлж, үдээс хойш 14 цагаас үргэлжлүүлж байхаар шийдвэрлэв.

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Ц.Цолмон, Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр нар Цөмийн энергийн газрын үйл ажиллагаатай танилцав.

2013.04.02

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо Газрын тухай хуулийн төслийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулав.

2013.04.05

Улсын Их Хурлын 2013 оны хаврын ээлжит чуулган нээлтээ хийв. Ээлжит чуулганыг нээж Улсын Их Хурлын дарга З.Энхболд үг хэлэв.

2013.04.06-10

Улсын Их Хурлын дарга З.Энхболд БНХАУ-ын Хайнань мужийн Боао хотод болсон “Азийн төлөөх Боаогийн чуулга уулзалт”-ын нээлтэд оролцож үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга уулзалтын үеэр БНХАУ-ын дарга Си Зиньпин уулзсаны зэрэгцээ Бээжин хотноо БНХАУ-ын Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хорооны шинэ дарга Жан Дөзянтай уулзаж парламент хоорондын хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.

2013.04.11

Улсын Их Хурлын 2013 оны хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг товлон зарлах тухай Улсын Их Хурлын тогтоол батлав.

Уг тогтоолоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг 2013 оны 4 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн товлон зарлах, Монгол Улсын Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуулийн санал хураалтыг 2013 оны 6 дугаар сарын 26 -ны өдөр явуулах, Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар байрладаг гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэдийн саналыг 2013 оны 6 дугаар сарын 14-16 -ны өдрүүдэд авахаар болов.

“Дахин санал хураалтын зардал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоол баталж, Улсын Их Хурлын сонгуулийн 26 дугаар тойрог буюу нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгт





явуулах дахин санал хураалтын зардлын дээд хэмжээг 397.4 сая төгрөгөөр батлав.

Улсын Их Хурлын дарга З.Энхболдод манай улсад албан ёсны айлчлал хийж байгаа Бүгд Найрамдах Турк Улсын Ерөнхий сайд Рэжэп Тайип Эрдоан тэргүүтэй зочид бараалхав.

2013.04.16

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны болон Төсвийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар Сургалтын төрийн сангийн төсвийн хөрөнгийн зарцуулалт, гадаадад суралцагчдын зээл, түүний эргэн төлөлтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөрийн мэдээллийг сонсов.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах эсэх тухай асуудлыг хэлэлцээд огцруулахыг дэмжих боломжгүй гэж үзэв.

2013.04.17

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан Хөдөө аж ахуйн газрын эрх зүйн зохицуулалтын талаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулав.

2013.04.22

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо ШУА-ийн Биологийн салбарын Бага чуулгантай хамтран “Мазаалай баавгайг хамгаалах асуудал” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав.

2013.04.23

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо “Иргэний эрүүл мэндийн даатгалын эрх зүйн шинэчлэл” сэдвийн хүрээнд холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулав.

2013.04.24

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар хийж байгаа ажилтай зарим байгууллагад танилцсан дүнг сонсов.

2013.04.25

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогтыг Улсын Их Хурлын дэд даргын үүрэгт ажлаас чөлөөлөв. Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах тухай асуудлыг хэлэлцээд чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн 66,7 хувийн саналаар Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах шаардлагагүй гэж үзэв.

2013.04.27

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улаанбаатар хотноо эхэлсэн Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн Сайд нарын 7 дугаар бага хурлын хүрээнд болох Ардчиллын төлөөх парламентчдын чуулга уулзалтын нээлтэд оролцож үг хэлэв.

2013.04.28

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэг (АОХН)-ийн Сайд нарын VII Бага хуралд оролцож буй НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга / ЕНБД/-ын орлогч, НҮБ-ын Женев дэх төвийн Ерөнхий захирал Кассим Жомарт Токаев, Тайландын Вант Улсын Ерөнхий сайд Ийнглак Чинават, Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэнгийн Ерөнхийлөгч Лорн Крейнер, Холбооны Бүгд Найрамдах Нигери Улс/ХБННУ/-ын Дэд ерөнхийлөгч Мохаммед Номади Самбо, Канад улсын Гадаад хэргийн сайдын парламентын асуудал хариуцсан нарийн бичгийн дарга Дийпэк Обрайт нарыг хүлээн авч уулзав.

2013.04.28-30

Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэг /АОХН/-ийн Сайд нарын YII бага хурал Төрийн ордны Их танхимд болов. Тус хуралд дэлхийн 104 орны зочид төлөөлөгчид оролцлоо. Бага хуралд оролцогчид Иргэний нийгмийн төлөөллийн, Парламентчдын, Эмэгтэйчүүдийн, Бизнесийн, Залуучуудын чуулга уулзалт гэсэн таван чиглэлээр салбар хуралдаан хийж, хэлэлцүүлэг өрнүүлэн Улаанбаатарын тунхаглал гэсэн баримт бичиг батлав.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн Сайд нарын YIII Бага хуралд оролцож буй Бүгд Найрамдах Латви Улсын Гадаад хэргийн яамны Парламентын нарийн бичгийн дарга Викторс Макаровс, Нобелийн шагналт, сэтгүүлч, улстөрч, хүний эрхийн төлөө тэмцэгч, Йемений иргэн, хатагтай Таваккол Карман, Япон Улсын Гадаад хэргийн дэд сайд Шюничи Сүзүки, Норвегийн Гадаад хэргийн сайд Эспен Барт Эйдэ нарыг хүлээн авч уулзав.

2013.05.01

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудлын талаар Уул, уурхайн сайд Д.Ганхуягийн мэдээллийг сонсов.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн биелэлтийн тухай хэлэлцэж, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаярын танилцуулгыг сонслоо.

Улсын Их Хурлын Байгаль орчин хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар хаврын тариалалтын бэлтгэл ажил, мал аж ахуйн салбарын хаваржилтын байдлын талаар Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулгын мэдээллийг сонсов.

2013.05.03

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийг тохиолдуулан Монголын хэвлэл мэдээллийн салбарын хамт олон, нийт сэтгүүлчдэд мэндчилгээ дэвшүүлэв. Улсын Их Хурлын дарга З.Энхболд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаарх үндэсний чуулганд оролцож, үг хэлэв.

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар “Олон Улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс хоорондын хэлэлцээр”-ийн төслийг зөвшилцөв.



2013.05.07

Улсын Их Хурлын дарга З.Энхболд “Эврика-2013” эрдэм шинжилгээний бага хурлыг нээж үг хэлэв.

2013.05.08

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар Уул уурхайн яамнаас нөхөн сэргээлтийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Уул уурхайн сайд Д.Ганхуягийн мэдээллийг сонслоо.

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Засгийн газар, Японы Олон улсын хамтын ажиллагааны банк хооронд байгуулах экспортын зээлийн ерөнхий хэлэлцээрийн төслийг зөвшилцөж, энэ тухай санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр тогтов.

2013.05.09

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлав. Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрийг манай улс хүлээн зөвшөөрснөөр 2000 оны 7 дугаар сарын 26-нд тус банкны 61 дэх гишүүн орноор элсчээ .

2013.05.10

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Р.Гончигдоржийг Улсын Их Хурлын дэд даргаар сонгож батлав.

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-4 төсөл: Нэмэлт санхүүжилт”-ийн болон “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлав.

Улсын Их Хурлын сонгуулийн 10 дугаар тойрогт явагдсан санал хураалтын дүнгийн тухай болон Улсын Их Хурлын сонгуулийн 26 дугаар тойрогт явуулсан дахин санал хураалтын дүн, гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай асуудал хэлэлцэж, Улсын Их Хуралд шинээр сонгогдсон Д.Зоригт, Д.Сумьяабазар нар гишүүний тангараг өргөлөө. Ингэснээр Улсын Их Хурал 76 гишүүнтэй боллоо.

2013.05.12

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн бүтээн байгуулалтын үйл явцтай танилцаж, бүх нийтээр мод тарих үндэсний өдрийг тохиолдуулан мод тарив.

2013.05.13

Улсын Их Хурлын дарга З.Энхболд “Үндэсний уламжлалаа дээдлье” сэдэвт манлайлагчдын чуулганд оролцож үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Бүгд Найрамдах Турк Улсын Үндэсний Их Хурлын Дэд дарга Садик Якут тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисс хамтран Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 12 дахь илтгэлийг нээлттэй хэлэлцлээ.

2013.05.14

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэв.

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хамтран Газрын тухай хуулийн төслөөр хэлэлцүүлэг зохион байгуулж, газар өмчлөх, түүнд хяналт тавих, хамгаалах чиглэлээр бусад орны туршлагыг сонсов.

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны банк хооронд байгуулах экспортын зээлийн ерөнхий хэлэлцээрийн төсөл, Гадаадын зарим улсад Монгол Улсын Элчин сайдын яам, Ерөнхий консулын болон Консулын газар нээж ажиллуулах тухай саналыг зөвшилцөв.

2013.05.15

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар Монгол орны ойг гал түймрээс сэргийлэх, цэвэрлэх асуудлыг судлах ажлын хэсэг байгуулахаар тогтож, мод, модон материалын импортыг дэмжих чиглэлээр бодлогын баримт бичиг боловсруулах чиглэлийг Засгийн газарт өгөхөөр шийдвэрлэв.

2013.05.16

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Прокурорын байгууллагын тухай, Авлигын эсрэг хууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2013 оны 02 дугаар дүгнэлтийг хэлэлцэв.

2013.05.17

Улсын Их Хурлын дарга З.Энхболд “Хуулийн засаглал ба шударга ёс” үндэсний чуулганд оролцож үг хэлэв.

2013.05.20-22

Улсын Их Хурлын дарга З.Энхболдын урилгаар Бүгд Найрамдах Польш Улсын Сенатын Маршал Богдан Борусевич манай улсад албан ёсны айлчлал хийв. .

Улсын Их Хурлын дарга З.Энхболд “Залуучуудын хөгжил-шинэчлэлийн бодлого, зорилт” үндэсний чуулганд оролцогчдод илгээлт хүргүүлэв.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга А.Бакей тэргүүтэй гишүүд Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаатай танилцлаа.

2013.05.21

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга Б.Гарамгайбаатар, Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр нар Өмнөговь аймагт ажиллаж, орон нутгийн бүтээн байгуулалтын ажилтай танилцав.

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын



хорооны хуралдаанаар Иргэний эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалангаар ахлуулан байгуулав.

2013.05.22

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар 5 дугаар цахилгаан станц барих газрын сонголтын талаар Байгаль орчин, ногоон хөгжлийн болон Эрчим хүчний яамны мэдээллийг сонсов.

2013.05.24

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай”, “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолууд батлав.

Монгол Улсын 2014-2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулиуд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдав.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдуулан өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг баталлаа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Гарамгайбаатараас Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдад тавьсан Монголбанк, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамтай хамтран 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдөр баталсан Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдал, Улсын Их Хурлын 2011 оны “Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоолын хэрэгжилт, үр дүнгийн талаарх асуулгын хариуг сонслоо.

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Ж.Батсуурь, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны төлөөлөл болон бусад холбогдох албаны хүмүүс нийслэлийн Баянгол дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл, Шастины нэрэмжит нэгдсэн гуравдугаар эмнэлгийн үйл ажиллагаатай танилцаж, эмч, эмнэлгийн ажилтнууд, үйлчлүүлэгчидтэй уулзав.

2013.05.27

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Олон улсын энхийг сахиулагчдын өдөрт зориулж үг хэлэв.

2013-05-28

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын

хорооны хуралдаанаар “Нийгмийн хамгааллын салбарын шинэчлэлийн хөтөлбөр” сэдвээр Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэ мэдээлэл хийлээ.

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны гишүүд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газрын тендер шалгаруулалтын ажлын явц байдал, Засгийн газрын худалдан авах ажиллагааны 2013 оны эхний 4 сарын гүйцэтгэлийн байдалтай танилцав.

2013.05.31

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль батлав.

2013.06.05

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос байгуулагдсан Эмнэлгийн барилгын өнөөгийн байдалтай танилцах, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид авах арга хэмжээний талаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүд Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, Улсын II төв эмнэлэг, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Улсын III төвэмнэлгийн эзэмшил газрын байдалтай танилцав.

2013.06.06

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоол батлав.

Улсын Их Хурлын дарга З.Энхболдод Мэргэжлийн сүмо бөхийн тавдугаар сарын Нацу башёд нэг ч уналгүй түрүүлсэн Монгол Улсын гавьяат тамирчин, 69 дэх Их аварга Хакухо М.Даваажаргал бараалхав.

2013.06.07

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар “Монгол Улсын Элчин сайдын яам, Ерөнхий консулын газар, Консулын газрыг гадаадын зарим улсад нээн ажиллуулах тухай” Улсын Их Хурлын тогтоол батлав.

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл болон “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоол /24-өөс дээш суудалтай, 45-аас дээш зорчигчийн багтаамжтай автобус, троллейбусыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай/ батлагдав.

Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиуд батлав.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг цаг үеийн асуудлаар мэдээлэл хийж, гишүүдийн асуултад хариулав.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд захирамж гаргаж, Улсын Их Хурлын 2013 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сарын 13, 14, 20, 21 -ний өдрүүдийн нэгдсэн хуралдааныг түр завсарлуулахаар шийдвэрлэв.



2013.06.08

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюуны хамт мод үржүүлгийн олон улсын байгууллага болох “Трий глобал” ХХК-ийн үйл ажиллагаатай танилцав.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд “Эрин” хотхоны шав тавих ёслод оролцов. Ипотекийн зээл хэрэгжиж эхэлснээс хойш анх удаа орон сууцны шав тавих ёслолд оролцож байгаа нь ажилтай, орлоготой иргэн бүр шинэ, хуучин гэлгүй орон сууцтай болох боломж бүрдсэнтэй холбоотойг Улсын Их Хурлын дарга хэлсэн үгэндээ онцоллоо.

2013.06.10-12

Улсын Их Хурлын дарга З.Энхболдын урилгаар Бүгд Найрамдах Финланд Улсын Парламентын дарга Эеро Хейнэлуома манай улсад хийх албан ёсны айлчлал хийлээ.

2013.06.12

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Сэлэнгэ аймгийн Мандал, Орхон, Дархан-Уул аймгийн Шарын гол, Хонгор суманд ажиллаж иргэд сонгогчидтой уулзан Улсын Их Хураар баталсан хууль тогтоомжуудын талаар мэдээлж, орон нутгийн цаг үеийн ажлын явц байдал, зарим аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаатай танилцлаа.

2013.06.17-20

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Завхан, Өвөрхангай аймаг, Төв аймгийн Зуунмод хотод ажиллан батлагдсан хууль тогтоомжуудыг иргэд сонгогчдод мэдээлж тайлбарлан таниулж, иргэд сонгогчдын санал бодлыг сонсохын зэрэгцээ орон нутгийн цаг үеийн ажлын явц байдал, зарим аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаатай танилцав.

2013.03.18

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороо болон ХБНГУ-ын Бундестагийн Өргөдлийн байнгын хорооны хамтарсан уулзалт ярилцлага зохион байгуулав.

2013.06.21

Улсын Их Хурлын дарга З.Энхболд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 67 дугаар чуулганы дарга, ноён Вук Еремичийг хүлээн авч уулзлаа. Улсын Их Хурлын дарга Монголд анх удаа НҮБ-ын Ерөнхий Ассамблейн дарга айлчилж байгаад талархал илэрхийлээд 67 дугаар Ерөнхий Ассамблейг амжилттай даргалж, дэлхийн энх тайван, аюулгүй байдал, хөгжил дэвшилд тустай олон чухал тогтоол шийдвэр гаргаж байгаад баяр хүргэлээ.

2013.06.26

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн энэ өдөр Улсын Их Хурлын дарга З.Энхболд гэр бүлийн хамт нийслэлийн Сүхбаатар дүүргийн дөрөвдүгээр хороонд байрлах сонгуулийн зургадугаар хэсэгт саналаа өгөв.

2013.06.28

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Б.Гарамгайбаатараас Уул уурхайн сайдад тавьсан “Газрын тосны бүтээгдэхүүний үнийн

хэлбэлзлийг тогтворжуулах ажлын хүрээнд Монголбанк, Уул уурхайн яамтай хамтран 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдөр баталсан Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн явц байдлын талаарх” асуулгын хариуг сонслоо.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд захирамж гаргаж, Улсын Их Хурлын 2013 оны хаврын ээлжит чуулганы хугацааг 2013 оны 7 дугаар сарын 10-ны өдрийг дуустал сунгахаар шийдвэрлэв.

2013.07.01

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газар, Монголын төсвийн мэргэжилтнүүдийн холбоотой хамтран “Монгол Улсын төсвийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага” сэдэвт судалгааны хэлэлцүүлэг зохион байгуулав.

Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дүнг Улсын Их Хурлын дарга З.Энхболдод өргөн мэдүүлэв.

2013.08.01

Улсын Их Хурлын гишүүн, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэ Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох хуулийн хэрэгжилтийн хугацаа дуусч байгаатай холбогдуулан сэтгүүлчдэд мэдээлэл хийв.

2013.08.13

Улсын Их Хурлын гишүүн, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэ, НҮБ-ын Залуучуудын асуудлаарх ажлын хэсгийн ахлагч, НҮБ-ын Хүүхдийн сангийн Суурийн төлөөлөгч Мохамед Фолл, Монголын залуучуудын холбооны ерөнхийлөгч А.Мөнхбат нар хэвлэлийн бага хурал хийлгэж, жил бүрийн 8 дугаар сарын 12-ны өдрийг Олон улсын залуучуудын өдөр болгон тэмдэглэж байхаар НҮБ-ын Ерөнхий Ассамблей тогтоосон талаар мэдээлэв.

2013.08.19

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Тайландын Вант Улсын Үндэсний Ассамблей дэх Тайланд-Монголын найрамдлын бүлгийн дарга Сомбуун Утайвианкул тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.

2013.08.20

Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судлах үүрэг бүхий ажлын хэсэг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн судалгааны багийн хамтарсан уулзалт, ярилцлага болов. Уулзалт, ярилцлагад Ажлын хэсгийн зарим гишүүд болон Судалгааны багийн судлаачид, мөн АНУ-ын Калифорнийн их сургууль, Хуулийн сургуулийн судлаач профессор Томас Гинсберг оролцож, Монгол Улсын ашинэ Үндсэн хуулийн үзэл санаа, суурь зарчмын үр нөлөө, нийгмийн өнөөгийн нөхцөл байдалд хэрхэн нийцэж байгаа талаар саналаа солилцов.

2013.08.21

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Г.Баярсайхан, Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Б.Гарамгайбаатар, З.Баянсэлэнгэ,





С.Одонтуяа, Л.Эрдэнэчимэг, Ц.Цолмон, Д.Ганбат нар “Чингис бонд”-ын хөрөнгөөс Үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлж байгаа төслүүдийн явц байдалтай танилцав.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд нийслэл хотод өрнөж буй бүтээн байгуулалтын ажил болон “Эрэл” ХХК-ийн Асфальт, төмөр бетон эдлэл, тоосгоны үйлдвэрүүдтэй танилцлаа.

2013.08.22

Улсын Их Хурлын дарга З.Энхболд нийслэлийн Сүхбаатар, Баянзүрх, Хан-Уул дүүрэг дэх гэр хорооллын дахин төлөвлөлт, шинээр баригдаж байгаа орон сууцны зарим хорооллын барилгажуулалт, автозам, дэд бүтцийн ажлын явц байдал, мөн зарим аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай танилцав.

2013.08.23

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Монголын залуучуудын эв нэгдлийн баяр-“Залуучуудын өдөр” тохиож буйтай холбогдуулан Монголын залуучуудын ролбооны удирдлага, гишүүн дэмжигчид, Монголын нийт залуучуудад баярын мэндчилгээ дэвшүүлэв.

2013.08.26

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Япон Улсын Парламент дахь эрх баригч Либерал ардчилсан намын Япон-Монголын найрамдлын бүлгийн дарга М.Хаяаши тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.

2013.09.01

Улсын Их Хурлын дарга З.Энхболд 84 дүгээр сургуулийн хичээлийн шинэ жилийн нээлтийн ажиллагаанд оролцлоо. Тус сургууль нь нийслэлийн тэргүүний сургууль бөгөөд анхны цахим сургууль гэдгээрээ онцлогтой учраас УИХ-ын Тамгын газраас тус сургуульд ИМАС компьютерийг багш нарын ном, сурах бичиг бэлтгэдэг программын хамт бэлэглэв.

2013.09.02

Улсын Их Хурлын дарга З.Энхболд МУИС-ийн хичээлийн шинэ жилийн нээлтийн ажиллагаанд оролцож, эрдэмтэн профессор, багш, оюутан залууст хандаж үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Европын сэргээн босголт хөгжлийн банкны Ерөнхийлөгч Сэр Сума Чакрабарти тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.

2013.09.04

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Бүгд Найрамдах Белорусс Улсын Ерөнхий сайд Михаил Владимирович Мясникович тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа.

Олон улс орны Төрийн албаны төв байгууллагын удирдлага, түүний төлөөлөгчдийн туршлага солилцдог бага хурал “Төрийн албаны Мерит тогтолцоо-туршлага сургамж, сорилт боломж” сэдвийн дор Монголд төдийгүй Азид анх удаа болж, тус Бага хуралд оролцож байгаа 14 орны төлөөлөгчдийг УИХ -ын дарга З. Энхболд хүлээн авч уулзан санал бодлоо солилцов.

2013.09.09

Улсын Их Хурлын дарга З.Энхболд банк бус санхүүгийн байгууллагуудаас мөрдвөл зохих дүрэм журмаа зөрчин валютын ханшны өсөлтөд нөлөөлөх зүй бус үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд Санхүүгийн зохицуулах хороо хэрхэн хяналт тавьж байгаа талаар холбогдох албан тушаалтнуудыг байлцуулан тайлбар мэдээлэл сонсов.

2013.09.10

Улсын Их Хурлын дарга З.Энхболд захирамж гаргаж, Улсын Их Хурлын ээлжит бус чуулганыг 2013 оны 9 дүгээр сарын 16-ны өдрөөс 9 дүгээр сарын 27-ны өдрүүдэд зарлан хуралдуулж, хэлэлцэх асуудлуудыг тогтоов.

2013.09.11

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос “Замын хөдөлгөөний аюулгүй байдал” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав.

2013.09.12-15

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын ээлжит бус чуулганаар хөрөнгө оруулалт, ашигт малтмалын салбарын эрх зүйн орчинг сайжруулах хуулийн төслүүд хэлэлцэх гэж буйтай холбогдуулан Өмнөговь аймагт ажиллаж, уул уурхайн үндэсний компаниудын үйл ажиллагаатай танилцав.

2013.09.16

Улсын Их Хурлын ээлжит бус чуулган ажлаа эхлэв. Ээлжит бус чуулганыг нээж Улсын Их Хурлын дарга З.Энхболд үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Франц Улсын Үндэсний Ассамблейн гишүүн, Үндэсний Ассамблей дахь Франц-Монголын найрамдлын бүлгийн дарга Жером Шартъег хүлээн авч уулзав.

2013.09.19

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар “Зэвсгийн худалдааг зохицуулах тухай” олон улсын гэрээнд гарын үсэг зурах тухай, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг НҮБ-ын конвенцын нэмэлт Протоколд нэгдэн орох тухай асуудлыг зөвшилцөв.

2013.09.20

Улсын Их Хурлын дарга З.Энхболд захирамж гарган “Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурвалжлах, мэдээлэх журам” батлав. Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Д.Батцогт, С.Ганбаатар, Г.Уянга нар хэвлэлийн бага хурал зарлаж, “Оюутолгой” төслийн нэмэлт санхүүжилтийн асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуягт шаардлага хүргүүлж байгаагаа мэдэгдэв.

2013.09.23

УИХ-ын дарга З.Энхболд Францын Сенат дахь Франц, Монголын найрамдлын бүлгийн дарга Ф.Пилье тэргүүтэй гишүүдийг Төрийн ордонд хүлээн авч уулзав.



2013.09.24

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын эдийн засгийн гадаад, дотоод орчин, хөгжлийн явц байдалд судалгаа дүгнэлт хийх, цаашид баримтлах чиг хандлага, даруй авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох үүрэг бүхий Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн мэдээллийг сонслоо.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Цог болон Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, З.Баянсэлэнгэ, Д.Ганбат, Ц.Оюунбаатар нар Өршөөлийн тухай хуулийн төслийн талаар хэвлэлийн бага хурал хийлгэж, сэтгүүлчдэд мэдээлэл өгөв.

2013.09.25

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос байгуулагдсан Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хороонд зарим хууль, тогтоомжийн хэрэгжилттэй шалгаж танилцах ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэлээр ахлуулан байгуулав.

2013-09-27

Улсын Их Хурлын ээлжит бус чуулган өндөрлөв. Ээлжит бус чуулганыг хааж Улсын Их Хурлын дарга З.Энхболд үг хэлэв.

2013.09.30

Улсын Их Хурлын дарга З.Энхболдын урилгаар Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Ассамблейн дарга Кан Чан Хий тэргүүбэй төлөөлөгчид манай улсад албан ёсны айлчлал хийв.

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, НҮБ-ын Хүн амын сан хамтран “Хүн ам ба хөгжлийн асуудал” сэдвээр үндэсний дээд хэмжээний уулзалт зохион байгуулав.

2013.10.01

Улсын Их Хурлын 2013 оны намрын ээлжит чуулган үйл ажиллагаагаа эхлэв. Ээлжит чуулганыг Улсын Их Хурлын дарга З.Энхболд нээж үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар нар Монгол Улсын 2014 оны төсвийн төслийг хэрхэн боловсруулсан талаар Улсын Их Хуралд ажлаа шууд тайлагнадаг байгууллагуудын удирдлагуудыг хүлээн авч санал солилцов.

2013.10.03

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Хөрөнгө оруулалтын тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай, уг хуулийг дагалдан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Инновацийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудыг баталлаа.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын

газрын Хяналт үнэлгээний хэлтсээс “Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлалын талаар” сургалт зохион байгуулав.

2013.10.06-09

Улсын Их Хурлын дарга З.Энхболд тэргүүтэй Монголын парламентын төлөөлөгчид Олон улсын парламентын Холбооны 129 дүгээр Ассамблейд оролцов. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд УИХ-ын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга А.Бакей, УИХ-ын гишүүн Д.Сарангэрэл, Д.Батцогт нар багтжээ. Мөн УИХ -ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар энэ үеэр болсон Олон улсын парламентын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга нарын уулзалтад оролцлоо.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд тэргүүтэй төлөөлөгчид Олон Улсын Парламентын Холбооны 129 дүгээр Ассемблейд оролцсоны дараа энэ сарын 9-13-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Турк Улсад албан ёсны айлчлал хийв.

2013.10.07

Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Г.Баярсайхан, Улсын Их Хурлын гишүүн Ц.Цолмон, А.Бакей, Д.Ганбат, Л.Эрдэнэчимэг нар Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны удирдлагуудтай уулзаж, тус яамнаас хийж хэрэгжүүлж байгаа цаг үеийн ажлын явц байдалтай танилцав.

2013.10.08

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо Канад Улсын Элчин сайдын яамтай хамтран “Сонгуулийн санхүүжилт- шинэчлэлийн асуудал” сэдвээр семинар зохион байгуулав.

2013.10.09

Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан дамжин өнгөрөх тээвэр, логистикийн талаар бодлого боловсруулах ажлын хэсэг, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, Худалдаа, аж үйлдвэрийн танхим, Монголын төмөр замын инженерүүдийн холбоо, “Монгол нүүрс” ассоциаци, Монголын логистикийн холбоо хамтран “Монголын тээврийн логистик: Өнөөгийн байдал, цаашдын хөгжил” онол практикийн бага хурал зохион байгуулав.

2013.10.09

Улсын Их Хурлын дарга З.Энхболд тэргүүтэй төлөөлөгчид Олон Улсын Парламентын Холбооны 129 дүгээр Ассемблейд оролцсоны дараа энэ сарын 9-13-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Турк Улсад албан ёсны айлчлал хийв.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Бүгд Найрамдах Турк Улсын Үндэсний Их Хурлын дарга Жэмил Чичекийн урилгаар болсон энэхүү айлчлалын үеэр Улсын Их Хурлын дарга З.Энхболд Бүгд Найрамдах Турк Улсын Ерөнхий сайд Р.Т.Эрдоантай уулзаж, хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.

2013.10.11

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн С.Бямба-



цогт, Л.Энх-Амгалан нараас Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдад тавьсан “Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2011 оны 30 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх” асуулгын хариуг сонслоо.

Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох тухай асуудал хэлэлцэж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Франц Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Мундагбаатарын Батсайхан, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цолмонгийн Болор, Канад Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Раднаабазарын Алтангэрэл, Швейцарийн Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Ваанчигийн Пүрэвдорж нарыг томилуулах Ерөнхийлөгчийн саналыг зөвшилцөж дэмжив.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтоос Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдад тавьсан “Махны нөөц бүрдүүлэх, хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх” асуулгын хариуг сонслоо.

2013.10.15

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын Тамгын газрын 2012 оны үйл ажиллагааны тайланг сонслоо. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагааны тайланг Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Төрийн байгуулалтын байнгын хороонд жил бүр танилцуулахаар заасан байдаг.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Бүгд Найрамдах Чех Улсын Сенатын дэд дарга хатагтай Алена Гаядушковаг дагалдан яваа хүмүүсийн хамт хүлээн авч уулзав.

2013.10.18

Улсын Их Хурлын чуулганы өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн 2013 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 03 дугаар дүгнэлтийг бүхэлд нь хүлээн зөвшөөрөх боломжгүй хэмээн үзэж, Улсын Их Хурлын тогтоол батлав.

“Бүгд Найрамдах Солонгос Улс болон Бүгд Найрамдах Турк Улсаас Монгол Улсад тус тус суугаа Элчин сайдын яаманд олгосон газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдав.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг “Үнэ тогтворжуулах дэд хөтөлбөр”-үүдийн талаар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж, гишүүдийн асуултад хариулт өгөв.

2013.10.21

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Монгол Улсын Ерөнхийлөгчийн урилгаар Монгол Улсад төрийн айлчлал хийж байгаа Канад Улсын Амбан захирагч Дэвид Жонстон Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд үг хэлэхтэй холбогдуулан 2013 оны 10 дугаар сарын 25-ны Баасан гарагийн 12.30 цагаас Улсын Их Хурлын Хүндэтгэлийн хуралдааныг зарлан хуралдуулах захирамж гаргав.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд манай улсад албан ёсны айлчлал хийж байгаа Бүгд Найрамдах Польш Улсын Ерөнхийлөгч Бронислав Коморовскид бараалхлаа.

2013.10.23

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Эм хангажийн алба үүсч хөгжсөний 90 жилийн ойг тохиолдуулан мэндчилгээ дэвшүүлэв.

2013.10.25

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар “Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай” Улсын Их Хурлын тогтоол батлав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн урилгаар манай улсад төрийн айлчлал хийж байгаа Канад Улсын Амбан захирагч Дэвид Жонстон Монгол Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаан дээр үг хэллээ.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд манай улсад төрийн айлчлал хийж байгаа Канад Улсын Амбан захирагч Дэвид Жонстонд бараалхав.

Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиуд батлагдав.

2013.10.28

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Бүгд Найрамдах Казахстан Улсын парламентын гишүүн, Казахстан-Монголын парламентын найрамдлын бүлгийн дарга Шавхат Анесович Утемисовыг хүлээн авч уулзав.

2013-10-30

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны харьяа Мянганы хөгжлийн зорилтууд болон ядуурлыг бууруулах асуудлын дэд хорооны хуралдаанаар “Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн талаарх” үндэсний тав дахь илтгэлийг хэлэлцлээ.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Нутгийн удирдлагын дэд хороо, Монголын нутгийн удирдлагын холбоотой хамтран Конрад-Аденауэрийн сангийн дэмжлэгтэйгээр “Иргэддээ тулгуурласан, чадвартай, хариуцлагатай иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг төлөвшүүлэх арга зам” сэдэвт зөвлөгөөнийг Төрийн ордны Их танхимд зохион байгуулав.

2013.10.31

Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хороо, Хууль зүйн яам, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний Комисс хамтран НҮБ -ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хамтын ажиллагаа” сэдэвт уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Р.Гончигдорж Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын дэд Ерөнхийлөгч Кгалема Мотлантег хүлээн авч уулзлаа.

2013.11.01

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Дипломат албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах



тухай хуулиудыг баталлаа. Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд “Чингис” бондын зарцуулалт, Монгол Улсын гадаад өр, төлбөрийн талаар мэдээлэл хийж, гишүүдийн асуултад хариулт өгөв.

2013.11.02

Улсын Их Хурлын дарга З.Энхболд орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нар болон аймгуудын Засаг дарга нартай уулзаж, санал бодлыг нь сонсов.

2013.11.04

Эзэн богд Чингис хааны мэндэлсний 851 жилийн ойн баяр, “Монгол бахархлын өдөр” буюу өвлийн тэргүүн сарын шинийн нэгний өдөр УИХ-ын дарга З.Энхболд Эзэн богд Чингис хааны хөшөөнд хүндэтгэл үзүүлэх болон Монгол Улсын төрийн дээд шагнал, тэргүүн зэргийн “Чингис хаан” одон гардуулах ёслол, Төрийн тулганы гал бадраах арга хэмжээнд оролцов.

2013.11.05

Улсын Их Хурлын дарга З.Энхболд “Евро-Азийн тээвэр:-Бүс нутгийн оролцоо” сэдэвт олон улсын бага хурлыг нээж үг хэлэв.

2013.11.07

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, “Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, цалингийн санг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоол баталлаа. Төсвийн тухай хуулийн зарим хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хууль, Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2014 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдав.

2013.11.08

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо Газрын шинэтгэлийн үндэсний хороо, Швейцарын хөгжлийн агентлагтай хамтран “Газрын ашиглалт ба хамгаалалт-салбар дундын зохицуулалт” сэдэвт уулзалт, зөвлөгөөн зохион байгуулав. Улсын Их Хурлын бие даагч гишүүн Х.Болорчулуун, С.Ганбаатар, Ц.Даваасүрэн нар сэтгүүлчдэд мэдээлэл хийж, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуягт мэдэгдэл хүргүүлэх болсноо дуулгалаа.

2013.11.11

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагаатай танилцав. Төрийн албаны зөвлөл нь НҮБ-аас хэрэгжүүлсэн “Монгол Улсад шударга ёс, ил тод байдлыг бэхжүүлэхийг дэмжих” төслийн хүрээнд төрийн албанд анх орох иргэний сонгон шалгаруулалтын шалгалтыг цахим хэлбэрээр авах системийг програм хангамжийн түвшинд боловсруулан 2011 оны 11 дүгээр сараас нэвтрүүлжээ.

2013.11.13

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Дээд боловсролын санхүүжилт,

суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлав.

2013.11.14

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоол батлав. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2014 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2015-2016 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиуд батлагдав.

2013.11.15

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2014 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн дөрөв дэх хэлэлцүүлгийг хийж батлав.

“Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоол баталлаа.

Монгол Улсын Ерөнхий сайдын Н.Алтанхуяг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын чанартай авто замын болон “Гудамж” төслийн талаар мэдээлэл хийж, гишүүдийн асуултад хариулт өгөв.

2013.11.18

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо Женев дэх Зэвсэгт хүчний ардчилсан хяналтын төвтэй хамтран “Аюулгүй байдлын салбарын хяналт ба аюулгүй байдлын салбарын засаглал: Парламентын байнгын хороодын үүрэг, хариуцлага” сэдэвт хоёр өдрийн сургалт зохион байгуулав.

2013.11.20

ОХУ-ын Холбооны Хурлын Холбооны Зөвлөлийн урилгаар тус улсад айлчилж байгаа Монгол Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурал дахь Монгол-Оросын парламентын бүлгийн дарга Л.Цог тэргүүтэй Монголын парламентын төлөөлөгчид ОХУ -ын Төрийн Думын депутат, Төрийн Дум дахь Монголын парламенттай харилцах бүлгийн зохицуулагч С.М.Мироновтой уулзав.

2013.11.22

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандангаас Эрүүл мэндийн сайдад тавьсан “Хордлогын яаралтай үндэсний төвийн үйл ажиллагаа болон хор судлал, хордлогын мэдээллийн талаар”, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдад тавьсан “Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн хэрэгжилтийн талаар”, Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан “Цөмийн энергийн тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулиудын хэрэгжилтийн талаар” тавьсан асуулгын хариуг тус тус сонслоо.

Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүд Улаанбаатар хотноо 11 дүгээр сарын 24-25-ны өдрүүдэд зохиогдох Зүүн хойд Азийн бүс нутгийн эмэгтэй парламентчдын чуулга уулзалтын талаар сэтгүүлчдэд мэдээлэл хийв.





2013.11.23

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Америкт төгсөгч монголчуудын холбооноос зохион байгуулсан үндэсний хоёр дахь чуулга уулзалтад оролцож үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 30 дугаар хорооны нутаг дэвсгэрт гэр хорооллыг дэд бүтэцтэй болгож, засмал зам тавьж байгаа ажлын явц байдалтай танилцлаа.

2013.11.24

“Боловсролоор дамжуулан энх тайван, хөгжлийг урагшлуулахад эмэгтэй парламентчдын гүйцэтгэх үүрэг” сэдвийн дор зохион байгуулагдаж байгаа Зүүн хойд Азийн эмэгтэй парламентчдын чуулга уулзалт Төрийн ордонд эхлэв. Чуулга уулзалтыг Улсын Их Хурлын дарга З.Энхболд нээж үг хэлэв.

2013.11.25

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Зүүн хойд Азийн парламентын эмэгтэй парламентчдын чуулга уулзалтад оролцсон улс орнуудын төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.

2013.11.26

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Гаалийн ерөнхий газрын харьяа Улаанбаатар хот дахь гаалийн газрын үйл ажиллагаатай танилцаж, гаальчдын саналыг сонсов.

2013.11.28

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2013 оны 04 дүгээр дүгнэлтийг хэлэлцээд, цэцийн дүгнэлтийг хүлээн авах боломжгүй гэж үзэв.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудыг баталлаа.

2013.11.29

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг нээлттэй, ухаалаг төрийг төлөвшүүлэх чиглэлээр хийж байгаа ажлын талаар гишүүдэд мэдээлэл өгөв.

2013.11.30

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Бүгд Найрамдах Өмнөд Судан Улс дахь НҮБ-ын энхийг сахиулах “UNMISS” ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн Монгол Улсын Зэвсэгт хүчний 11 дүгээр ээлжийн цэргийн багийн бүрэлдэхүүнд төрийн одон, медаль гардуулах арга хэмжээнд оролцож, дайчдад шагнал гардуулж баяр хүргэлээ.

2013.12.03

Улсын Их Хурлын гишүүн, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дарга З.Баянсэлэнгэ, Улсын Их Хурлын гишүүн Ё.Отгонбаяр,

С.Ганбаатар нар нийслэлийн зарим ерөнхий боловсролын болон их, дээд сургуулиудын үйл ажиллагаатай танилцлаа.

2013.12.06

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг болон Засгийн газрын гишүүн, салбарын сайд нар оролцон цаг үеийн асуудлаар мэдээлэл хийж, гишүүдийн асуултад хариулав.

2013.12.11

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Олон Улсын Парламентын Холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Андрес Жонсонд захидал илгээв.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Үндэсний статистикийн хорооны үйл ажиллагаатай танилцав.

2013.12.12

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Р.Амаржаргалын Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтийг хэлэлцээд дэмжих боломжгүй гэж үзэв.

Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлав.

Шүүхийн захиргааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуулиуд, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Архивын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиуд болон “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

2013.12.13

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Д.Сумьяабазараас Боловсрол, шинжлэх ухааны сайдад тавьсан асуулгад хариуг сонсов.

2013.12.16

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Монголын чөлөөт хэвлэл, сэтгүүл зүйн салбарын нийт ажилтан, ажиллагсдад Монгол Улсад чөлөөт хэвлэл үүсч, хөгжсөний 25 жил, Монголын сонины холбоо байгуулагдсаны 15 жилийн ойн баярын мэндчилгээ дэвшүүлэв.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд “Таван богд” компанийн хэрэгжүүлж байгаа дулааны алдагдалгүй гэр буюу “Пассив гэр” төсөлтэй танилцлаа.

2013.12.18

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо Эрүүл мэндийн, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын, Хөдөлмөрийн яамтай хамтран “Ядуурал ба эрүүл мэнд” сэдэвт нээлттэй сонгог зохион байгуулав.



2013.12.19

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2013 оны 05 дугаар дүгнэлтийг хэлэлцэж шийдвэрлэв.

2013.12.20

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлаар мэдээлэл хийж, гишүүдийн асуултад хариулт өгөв.

Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга А.Бакей Шинжлэх ухааны Академийн удирдлагуудтай уулзаж, орон нутагт агаарын бохирдлын хэмжээг хэрхэн багасгах талаар санал солилцлоо.

2013.12.21

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Олон улсын хүүхдийн “Найрамдал” төвийн 35 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдаж байгаа арга хэмжээнүүдийн нэг болох Харшийн сүлд модны наадамд оролцов.

2013.12.23

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дарга З.Баянсэлэнгэ, Улсын Их Хурлын гишүүн Ё.Отгонбаяр, С.Ганбаатар, Г.Уянга, Л.Эрдэнэчимэг нар Боловсрол, шинжлэх ухааны яамнаас баримталж буй шинэчлэлийн бодлого, төлөвлөлтийн явц байдалтай танилцав.

2013.12.24

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Засгийн газрын гишүүн, Эдийн засгийн хөгжлийн сайд, Сангийн сайд нарыг огцруулах эсэх хэлэлцээд нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар Засгийн газрын хоёр гишүүнийг огцруулах шаардлагагүй гэж үзлээ.

2013.12.26

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх, цэцийн гишүүнээс чөлөөлөх, мөн Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүдийг томилох, чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоол батлав.

2013.12.26

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Хилийн боомтын тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиуд, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоол батлав.

2013.12.30

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Монголын хүүхдийн ордноос зохион байгуулж буй “Харшийн сүлд мод”-ны баярт оролцож, хүүхэд багачуудад хандан үг хэлж шинэ жилийн мэндчилгээ дэвшүүлэн шилдэг хүүхдүүдэд бэлэг гардуулав.

## 2014

2014.01.07

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны хуралдаанаар Төрийн аудитын байгууллагын бүтцийн ерөнхий бүдүүвч, орон тооны дээд хязгаарыг батлах тухай Байнгын хорооны тогтоол батлав. Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл шинжлэх ухааны байнгын хорооны дарга Д.Батцогт, Улсын Их Хурлын гишүүн Д.Арвин, З.Баянсэлэнгэ нар Хөдөлмөрийн яам болон түүний харьяа байгууллагуудын үйл ажиллагаатай танилцав.

2014.01.09

Улсын Их Хурлын дарга З.Энхболд аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарын семинарт оролцож, Улсын Их Хурлаас баталсан зарим хууль тогтоомжийн талаар тайлбарлан таниулж, санал солилцов.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудыг баталлаа.

Монгол Улсаас гадаадын зарим улстай дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж, Монгол Улс Антигуа Барбуда Улс, Бүгд найрамдах Бурунди Улс, Бүгд найрамдах Вануату Улс, Бүгд найрамдах Палау Улс, Бүгд найрамдах Суринам Улс, Бүгд найрамдах Сьерра Леон Улс, Бүгд найрамдах Того Улс, Эритри Улс, Ямайка Улстай дипломат харилцаа тогтоов.

2014.01.10

Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Ц.Оюунбаатар Гадаад харилцааны яамны удирдлагуудтай уулзаж, санал солилцов.

2014.01.11

Улсын Их Хурлын даргын ивээл дор уламжлал болж зохиогддог Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн өдөрт зориулсан шатар сонирхогчдын 2014 оны улсын аварга шалгаруулах тэмцээн Төрийн ордонд эхлэв. Нийслэл хот, 21 аймгаас шалгаран ирсэн 120 шатарчин оролцсон тэмцээнийг Улсын Их Хурлын дарга З.Энхболд нээж үг хэлэв. Үндсэн хуулийн өдөрт зориулсан шатар сонирхогчдын 2014 оны улсын аварга шалгаруулах тэмцээн Улсын Их Хурлын дарга З.Энхболд, Соёл, спорт, аялал жуулчлалын сайд Ц.Оюунгэрэл нар анхны нүүдэл хийснээр эхэллээ.

2014.01.13

Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсаны 22 жилийн ойг тохиолдуулан Улсын Их



Хурлын дарга З.Энхболд, Ерөнхий сайд Н.Алтанхуяг болон Улсын Их Хурал, Улсын Бага Хурлын гишүүд, Ардын Их Хурлын депутатууд Эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл үзүүлэв.

Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн 22 жилийн ойд зориулсан “Төрийн бэлгэдэл” үзэсгэлэнгийн нээлт 12 цагт Төрийн ордон дахь Төрийн түүхийн музейд болж, Улсын Их Хурлын дарга З.Энхболд нээж үг хэллээ.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд НҮБ-ын Хүн амын сангийн Монгол дахь суурин төлөөлөгч Наоми Китахара нар харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав.

2014.01.14

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, Хууль зүйн байнгын хороо, Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүдийн албан бус бүлэг, Хууль зүйн яам, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвтэй хамтран “Хохирогч хамгаалал, хуулийн шинэчлэл” сэдэвт зөвлөлдөх уулзалт зохион байгуулав. Уулзалтаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн хэрэгжилтийн байдал, уг хуулийн шинэчилсэн найруулгын талаар санал солилцов.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос байгуулсан Цагдаагийн ерөнхий газар, нийслэлийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн Арван дөрөвдүгээр бүлэг /хүсэлт, гомдол гаргах/, Арван тавдугаар бүлэг /эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь иргэний нэхэмжлэл/-ийн заалтуудын хэрэгжилттэй танилцах болон хяналт, шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүн Ж.Батзандан, З.Баянсэлэнгэ, Д.Лүндээжанцан, Б.Чойжилсүэрн, О.Баасанхүү нар Цагдаагийн ерөнхий газар, Нийслэлийн цагдаагийн газар, Дотоодын цэргийн бие бүрэлдэхүүнтэй уулзаж, хуулийн хэрэгжилттэй танилцав.

2014.01.15

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Улсын Их Хурлын дарга З.Энхболд, Ерөнхий сайд Н.Алтанхуяг нар Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайдуудад шинэ оны мэндчилгээ дэвшүүлж, баяр хүргэлээ.

УИХ-ын дарга З.Энхболд БНХАУ-ын өдөр тутмын томоохон сонинуудын нэг болох “Чайна Дэйли” /China Daily/ сонинд ярилцлага өгөв. Тус сонин нь БНХАУ-д англи хэл дээр, гаралт бүрдээ 500 000 гаруй хувь хэвлэгдэн гардаг томоохон сонин нэг юм.

2014.01.16

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнг Төсвийн байнгын хорооны даргаар сонгож батлав.

“Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоол, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиуд /Хүнсний улирлын нөөц бүрдүүлэхэд шаардагдах 100.0 мянга хүртэл тонн улаан буудайг импортоор оруулахад/-ыг батлав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Бадамдоржийн Батбаярыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх, Үндэсний статистикийн хорооны Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах, “Монгол судлалыг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолыг тус тус батлав.

2014.01.21

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны Ажлын алба, Эрүүл мэндийн яам, Азийн хөгжлийн банкнаас хамтран “Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын шинэчлэл” сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулав.

2014.01.23

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342 дугаар зүйлийн 342.1 дэх хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 01 дүгээр дүгнэлтийг хэлэлцэн уг дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан байнгын хорооноос санаачлан боловсруулсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг баталлаа. Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүдийн албан бус бүлэг, Монголын сурагчдын холбоо, Монголын залуучуудын холбоо хамтран нийт ард түмэндээ хандан уриалга гаргаж, “Архи, тамхигүй бэлэг барьцгаая” аян өрнүүлж байгаа талаар сэтгүүлчдэд мэдээлэл өгөв.

2014.01.24

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын сайн малчин, тэргүүний тариаланчидтай уулзаж, малынхаа тоо толгойг өсгөж, тариалан эрхлэлтээрээ нутагтаа тэргүүлсэн малчин, тариаланчдад баяр хүргэв.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг баталлаа. Ашигт малтмалын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар Монголбанкинд алт тушаасан нөхцөлд рояльтийн татвар 2.5 хувь болож буурч байгаа юм.

“Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдав. Эдгээр хууль, тогтоолоор Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албыг Авлигатай тэмцэх газарт шилжүүлэхээр боллоо.

2014.01.28

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх “Иргэний танхим” хамтран Ерөнхийлөгчийн санаачилсан Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн төслийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулав.

Хэлэлцүүлэгт Улсын Их Хурлын эмэгтэй гишүүд, Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны гишүүд, Боловсрол, шинжлэх ухааны яамны газрын дарга нар, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын байцаагч, НҮБ-ын “Хүүхдийн сан” Бага насны хүүхдийн хөгжлийн мэргэжилтэн, “Бага насны



хүүхдийн хөгжлийг дэмжих төв” төрийн бус байгууллага, “Өүлэн эх” төв, нийслэлийн дүүргүүдийн холбогдох хэлтсийн мэргэжилтэн, эцэг, эхчүүдийн төлөөлөл оролцож санал, бодлоо солилцов.

2014.01.30

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Засгийн газар, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага хооронд байгуулсан Улаанбаатар хотын 4 дүгээр цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төслийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлав. “Улсын Их Хурлын 2014 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолыг батлав. Улсын Их Хурлын 2013 оны намрын ээлжит чуулганы ажиллагаа өндөрлөв. Ээлжит чуулганы ажиллагааг хааж Улсын Их Хурлын дарга З.Энхболд үг хэллээ.

2014.01.31

Билгийн тооллын XVII жарны “Ялгуусан” хэмээх модон морин жилийн Хаврын тэргүүн сарын шинийн нэгний ерөөл, хүндлэл дүүрэн энэ өглөө Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нар Төрийн есөн хөлт цагаан туганд хүндэтгэл үзүүлсний дараа Төрийн ёслол хүндэтгэлийн өргөөнөө морилон хамгийн өндөр насыг насалж яваа есөн ахмадад хүндэтгэл үзүүлэн амар мэндийг нь айлтган золгож гарын бэлэг гардуулав.

2014.02.03

Улсын Их Хурлын дэд дарга, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга Л.Цог ХҮИ жарны “Ялгуусан” хэмээх хөх модон морин жилийн цагаан сарыг тохиолдуулан улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн төлөөлөл зарим ахмадуудтай золгож, хүндэтгэл үзүүллээ.

2014.02.06

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны зарим гишүүд ШУА-ийн Физик-технологийн хүрээлэн, Хими-технологийн хүрээлэн, Биологийн хүрээлэнгүүдийн үйл ажиллагаатай танилцаж, эрдэмтэн судлаачид, эрдэм шинжилгээний ажилтнуудтай санал солилцов.

2014.02.11

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо Улсын Их Хурлын 2013 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийсэн ажлаа тайлагнаж сэтгүүлчдэд мэдээлэл өгөв.

2014.02.12

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос 2013 оны намрын чуулганы хугацаанд хийсэн ажлын талаар тус байнгын хорооны дарга Ц.Оюунбаатар хэвлэлийн бага хийлгэж, сэтгүүлчдэд мэдээлэл өгөв.

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Ц.Оюунбаатар Цөмийн энергийн газрын үйл ажиллагаатай танилцав.

2014.02.13

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга Ш.Түвдэндорж хэвлэлийн бага хурал хийлгэж тус байнгын хорооноос намрын ээлжит чуулгаын хугацаанд ажлаа тайлагнав. Тус байнгын хороо 2013 оны хавар, намрын ээлжит чуулганы хугацаанд 39 удаа хуралдаж, 176 хуулийн төсөл, Улсын Их Хурлын 15 тогтоолын төслийг хэлэлцжээ.

2014.02.17

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос хэвлэлийн бага хурал хийлгэж, 2013 оны намрын чуулганы хугацаанд хийсэн ажлынхаа талаар сэтгүүлчдэд мэдээлэл өгөв. Тус байнгын хороо намрын ээлжит чуулганы хугацаанд 12 удаа хуралдаж, 40 асуудал хэлэлцэн шийдвэрлэжээ.

2014.02.21

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн тус байнгын хорооноос Улсын Их Хурлын 2013 оны намрын ээлжит чуулганы хугацаанд гүйцэтгэсэн ажлаа тайлагнаж, сэтгүүлчдэд мэдээлэл хийв. Төсвийн байнгын хороо тайлангийн хугацаанд 60.2 хувийн дундаж ирцтэйгээр 23 удаа хуралдаж, 55 асуудал /давхардсан тоогоор/ хэлэлцжээ.

2014.02.24

Монгол Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын 2013 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэж баталсан хууль тогтоомжууд болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Том төрөөс - Ухаалаг төр рүү” санаачилгын хүрээнд хийхээр төлөвлөж буй ажлуудаа сэтгүүлчдэд танилцуулж, сонирхсон асуултад нь хариулт өгөв.

Намрын ээлжит чуулганаар 100 хууль, 52 тогтоол баталснаас 12 нь бие даасан хууль байгаа бол 81 нь нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 6 нь хууль хүчингүй болгох, 1 нь зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хууль байсныг тэрээр дурдав.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны цагийг өөрчлөх тухай захирамжийг гаргаж, Улсын Их Хурлын 2014 оны хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдааныг долоо хоногийн Пүрэв, Баасан гарагт өглөө 09 цагаас эхэлж, үдээс хойш 14 цагаас үргэлжлүүлж байхаар шийдвэрлэв.

2014.02.25

Монгол Улсын Их Хурлын дарга З.Энхболд АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд хатагтай Пайпэр Э.Кэмбэллийг хүлээн авч уулзав. Элчин сайд хэлэхдээ Монгол Улс, АНУ-ын хоорондын харилцаа улам гүнзгийрч, улс төр, эдийн засгийн салбарт баттай суурилсан хамтын ажиллагаанд хүрснийг онцлон тэмдэглэв.

2014.02.27

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Г.Баярсайхан, Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Ц.Цолмон нар Үйлдвэр, хөдөө аж ахуйн дэд сайд Ц.Туваан, тус яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Ганибал, Мал эмнэлэг, үржлийн газрын дарга М.Галбадрах, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Т.Дуламдорж нартай уулзаж, малын шүлхий өвчний нөхцөл байдлын талаар мэдээлэл сонсов.





2014.02.28

Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэг, Г.Баярсайхан нар МХЕГ-ын Эрүүл мэнд, боловсрол, соёл, шинжлэх ухааны хяналтын газар, Эрүүл мэндийн хэлтсийн дарга, НМХЕГ -ын Эрүүл мэнд, боловсрол, соёл, шинжлэх ухааны хяналтын хэлтсийн дарга нарыг байлцуулан Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийн талаар сэтгүүлчдэд мэдээлэл хийлээ.

2014.02.28

Монгол Улсын Ерөнхий аудитор А.Зангад “Хөрөнгө оруулалтын зарим арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдсэн, гүйцэтгэл удааширсан шалтгаанд хийсэн дүн шинжилгээний тайлан”-г Улсын Их Хурлын дарга З.Энхболдод гардуулан өгөв. “Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2013 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 63 дугаар тогтоолоор өгөгдсөн үүрэг, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд энэхүү дүн шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэжээ.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтран Улсын Их Хурлын Тамгын газраас хэрэгжүүлж буй “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Швейцарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр хангайн бүсийн аймгуудын нутгийн өөрөө удирдах байгууллагуудын хамтарсан онол практикийн бага хурлыг Орхон аймагт зохион байгуулав.

“Ухаалаг төр рүү шилжих санаачлагын хүрээнд нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох нь” сэдэвт энэ ага хуралд Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл аймгийн ИТХ-ын төлөөлөгч, хурлын байгууллагын ажлын албаны ажилтнууд зэрэг 170 гаруй хүн оролцлоо.

2014.03.01

Улсын Их Хурлын дарга З.Энхболд “Эх орончдын өдөр”-ийг тохиолдуулан Монголын нийт ард түмэнд баярын мэндчилгээ дэвшүүлэв.

2014.03.06

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, Д.Сумъяабазар, С.Ганбаатар Шинжлэх ухааны академийн харьяаны 5 хүрээлэнгийн үйл ажиллагаатай танилцав.

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд “О.О” дүнтэй тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдсэн, гүйцэтгэл удааширсан шалтгааныг тогтоох, гүйцэтгэл хэрэгжилтийн явц байдалд Үндэсний аудитын газраас хийсэн дүгнэлт, тайланг сонсов. Улсын Их Хурлын дарга З.Энхболд Үндэсний аудитын газар, Монголбанкны үйл ажиллагаатай танилцлаа.

2014.03.11

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны гишүүн С.Ганбаатар, Д.Сарангэрэл нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг

“IVCO” тарилгын шингэний үйлдвэр, МХЕГ-ын Үндэсний лавлагаа лабораторийн эм, биобэлдмэлийн лаборатори, “Цомбо” эмийн үйлвэр, “Монос” эм ханган нийлүүлэх байгууллагын үйл ажиллагаатай танилцав.

2014.03.12-15

Улсын Их Хурлын дарга З.Энхболд БНСУ-ын Үндэсний Ассамблейн дарга Кан Чан Хийгийн урилгаар тус улсад хийх албан ёсны айлчлал хийлээ.

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Хууль зүйн үндэсний хүрээлэн болон Парламентын сэтгүүлчдийн холбоотой хамтран “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төслийн үзэл баримтлал, жендэрт суурилсан хүчирхийллийг мэдээлэхэд анхаарах зүйлс” сэдэвт сургалт зохион байгуулав.

2014.03.18

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Монгол цэргийн өдрийг тохиолдуулан мэндчилгээ дэвшүүлэв. Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэг, Г.Уянга, Р.Бурмаа нар эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн чиглэлээр төрөөс баримталж буй бодлого, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдал, тулгамдаж буй асуудал, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, цаашдын зорилтын талаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулав.

2014.03.24

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны цагийг өөрчлөх тухай захирамжийг гаргав. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг үндэслэн Улсын Их Хурлын 2014 оны хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдааныг долоо хоногийн Пүрэв, Баасан гарагт өглөө 09 цагаас эхэлж, үдээс хойш 14 цагаас үргэлжлүүлж байхаар уг захирамжид заасан.

2014.03.21-24

Улсын Их Хурлын дарга З. Энхболд Баян-Өлгий аймагт ажиллаж, орон нутгийн ажил амьдрал, бүтээн байгуулалтын ажилтай танилцав.

2014.03.24

Улсын Их Хурлын гишүүн, “Хустайн байгалийн цогцолборт газар” төвийн Удирдах зөвлөлийн дарга Н.Энхболд, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун нар Хустайн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны үүргийг “Хустайн цогцолборт газар” төвөөр гүйцэтгүүлэх тухай гэрээнд гарын үсэг зурлаа.

2014.03.26

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Усны үндэсний хороо, Хот, суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл хамтран “Ус ба тогтвортой хөгжил” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлэгт Улсын Их Хурлын гишүүд, салбарын мэргэжилтэн, эрдэм шинжилгээний ажилтнууд, Төрийн бус байгууллагын төлөөлөл оролцлоо.



2014.03.27

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамтай хамтран “Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэж буй бодлого, үйл ажиллагаа” сэдэвт дугуй ширээний ярилцлага зохион байгуулав.

2014.03.28-31

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Өвөрхангай, Баянхонгор аймагт ажиллаж, орон нутгийн ажил амьдрал, бүтээн байгуулалтын ажилтай танилцан Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийн талаар иргэдэд мэдээлэл хийв.

2014.04.02

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Фан Данг Дуонгийг Итгэмжлэх жуух бичгээ барьсантай нь холбогдуулан Төрийн ордонд хүлээн авч уулзав.

2014.04.02

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Азийн бүтээмжийн байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Марио Аmano, Монголын бүтээмжийн байгууллагын ТУЗ-ийн дарга Я.Эрхэмбаяр болон бусад төлөөлөгчдийг Төрийн ордонд хүлээн авч уулзав.

2014.04.03

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Санхүү эдийн засгийн дээд сургуульд зочилж, оюутан залуустай уулзан чөлөөт ярилцлага өрнүүлэв. Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Ц.Оюунбаатар, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нар Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штаб, Батлан хамгаалах их сургуулийн үйл ажиллагаатай танилцлаа.

2014.04.07

Улсын Их Хурлын 2014 оны хаврын ээлжит чуулган гишүүдийн 71.4 хувь нь хүрэлцэн ирснээр үйл ажиллагаагаа эхлэв. Хаврын чуулганы ажиллагааг нээж Улсын Их Хурлын дарга З.Энхболд үг хэллээ.

2014.04.08

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар “Улсын Их Хурлын 2014 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” тогтоол батлав.

Улсын Их Хурлын дарга З.Энхболдын ивээл дор “Эврика-2014” эрдэм шинжилгээний бага хурлыг Монголын залуучуудын холбоо, Улсын Их Хурлын даргын ажлын алба хамтран зохион байгуулав. Өмнөх жилүүдэд найман салбарт зохион байгуулдаг байсан бол энэ жил судалгааны чиглэл, оролцогчдын тоог харгалзан эдийн засаг, бизнесийн, техник технологийн зэрэг арван салбарыг хамруулжээ. Улсын Их Хурлын дарга З.Энхболд 57 тоот захирамж гаргаж, Улсын Их Хурлын 2014 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоов.

2014.04.09

Улсын Их Хурлын гишүүдийн уламжлалт онлайн уулзалт буюу цахим ярилцлагын энэ

оны анхны ярилцлага Төрийн ордон дахь Нутгийн удирдлагын танхимд боллоо. Сар бүр хоёр удаа зохион байгуулах цуврал ярилцлагыг Баян-Өлгий аймгаас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга А.Бакей, Улсын Их Хурлын гишүүн А.Тлейхан нарын тойрогтойгоо хийсэн ярилцлагаар эхлүүлэв.

2014.04.12-15

Улсын Их Хурлын дарга З.Энхболдын урилгаар Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсын Холбооны парламентын дарга бөгөөд Төлөөлөгчдийн танхимын дарга Тура У Швэ Манн Монгол Улсад хийх албан ёсны айлчлал хийлээ.

2014.04.15

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөрийн сайд Я.Санжмятав, Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны ерөнхийлөгч Х.Амгаланбаатар, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны тэргүүн Х.Ганбаатар нарыг хүлээн авч уулзав.

2014.04.16

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар Хаврын тариалалтын бэлтгэл ажлын талаарх мэдээллийг сонсов. Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Эрүүл мэндийн яам хамтран “Хүнсний аюулгүй байдлын хүрээнд: Пестицидын зохистой хэрэглээ, түүний тулгамдсан асуудал” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Улсын Их Хурлын гишүүн Г.Батхүү, М.Батчимэг нарын санаачлан боловсруулсан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлэг болов.

2014.04.17

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсаас Бүгд Найрамдах Индонези Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Шагдарын Батцэцэгийг, Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Чулуунбаатарын Сосормааг томилло.

“Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдав.

2014.04.18

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлын талаар мэдээлэл хийлээ.

2014.04.22

Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүдийн албан бус бүлэг, Канад Улсын Элчин сайдын яамтай хамтран “Тэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн шинэчлэл” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав.



2014.04.23

Улсын Их Хурлын дарга З.Энхболд “Экологбус” компанид зочилж, Монгол Улс дотооддоо автобус хэрхэн үйлдвэрлэж байгаатай танилцав. “

“Эколог бус” ХХК-ийн үйлдвэрлэж буй 41 хүний суудалтай Экобус J-800T автобус нь Монгол орны уур амьсгалын онцлогт тохирсон, агаарын бохирдлыг бууруулах, Евро-4 стандартын, хэрэглээнд бүрэн нийцсэн, тохилог, Солонгосын “Daewoo BS 106” автобуснаас давуу талтай тээврийн хэрэгсэл бөгөөд уг үйлдвэр нь жилдээ 120 гаруй ийм автобус үйлдвэрлэх хүчин чадалтай юм.

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дарга Д.Батцогт, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, С.Одонтуяа, Д.Сарангэрэл, О.Содбилэг, Д.Сумьяабазар, Ё.Отгонбаяр нар Эрүүл мэндийн яам болон эмнэлгүүдийн удирдлагуудыг хүлээн авч уулзаж, эрүүл мэндийн салбарын өнөөгийн байдал, тулгамдаж байгаа асуудлын талаар санал солилцлоо.

2014.04.24

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг баталлаа. Мөн Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг устгах тухай протоколыг соёрхон батлах тухай хуулийг батлав.

2014.04.25

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Д.Оюунхорол, Ж.Эрдэнэбат нараас “2013 оны төсвийн гүйцэтгэлийг хэрэгжүүлэхэд үүссэн нөхцөл байдал, төсвийн урьдчилсан гүйцэтгэл болон Монгол Улсын Засгийн газраас Япон Улсын санхүүгийн зах зээл дээр арилжаалагдсан “Самурай” бондын хөрөнгийн эх үүсвэр, түүний зарцуулалтын талаар” Сангийн сайдад тавьсан асуулгын хариуг сонсов.

2014.04.26

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Дэлхийн оюуны өмчийн өдрийг тохиолдуулан Чингисийн талбайд зохион байгуулсан “Оюуны өмч-Төрийн алтан сан” үзэсгэлэн яармагт оролцов.

2014.04.30

Улсын Их Хурлын гишүүдийн уламжлалт цахим ярилцлагад Төв аймгаас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн М.Энхболд, Су.Батболд нар оролцож, орон нутгийн удирдлагуудтай санал солилцов.

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Монголын ноос, ноолуурын холбоо хамтран “Ноос, ноолуурын салбарт тулгарч буй хүндрэл, бэрхшээл түүнийг даван туулах арга зам” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав.

2014.05.02

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг “Чингис” бондын эх үүсвэрээр санхүүжиж буй төслүүдийн талаар мэдээлэл хийж, гишүүдийн асуултад хариулт өгөв.

2014.05.05

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос байгуулагдсан “Иргэдийн амьжиргааны түвшин, үнийн инфляцийн өөрчлөлттэй уялдуулан цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх асуудлыг судлан санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий” ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Я.Содбаатар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, С.Ганбаатар нар Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөрийн яаманд ажиллав.

2014.05.06

Галт зэвсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэлийг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү, уг ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын дэд хэсгийн гишүүд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Батлан хамгаалахад туслах нийгэмлэгийн Техникийн спортын төвийн үйл ажиллагаанд болон Цагдаагийн албанд хэрэглэгдэж буй галт зэвсэг, сум хэрэгслийн хадгалалт хамгаалалтын байдалтай танилцав.

2014.05.08

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар “Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоол батлав.

2014.05.09

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиудыг баталлаа. Мөн, Улсын Их Хурлаас “Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдсантай холбогдуулан Эдийн засгийн байнгын хорооны дарга Б.Гарамгайбаатар, Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригт, Монголбанкны Ерөнхийлөгч Н.Золжаргал нар сэтгүүлчдэд мэдээлэл хийв.

2014.05.10

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Төв аймгийн Эрдэнэ сумын нэгдүгээр багийн нутаг “Элстэй” хэмээх газар мод тарив. Энэ удаагийн мод тарих арга хэмжээнд Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун болон бусад албаны хүмүүс, “Эко Ази” дээд сургуулийн 20 гаруй оюутан, ШУТИС-ийн 140 гаруй оюутан, “Ногоон Ази” төрийн бус байгууллагын төлөөллүүд оролцов.

2014.05.13

Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүдийн албан бус бүлэг Хөдөлмөрийн яамтай хамтран “Танд ямар бэрхшээл байна вэ?” сэдэвт жижиг бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн чуулга уулзалт зохион байгуулав.



2014.05.14

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын хэсэг, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Төв аймгийн Засаг даргын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран Хяналтын тухай хуулийн төслийн талаар Төв аймгийн Зуунмод суманд хэлэлцүүлэг зохион байгуулав.

2014.05.15

Улсын Их Хурлын чуулганы үдээс өмнөх нэгдсэн хуралдаанаар Засгийн газрын гишүүн, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга Засгийн газрын гишүүн, сайдын албан тушаалаасаа чөлөөлөгдөхөөр гаргасан хүсэлтийг хэлэлцэн дэмжиж, тогтоол батлав. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга болон дагалдан өргөн мэдүүлсэн 15 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, мөн Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудыг баталлаа.

2014.05.16

Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Д.Ганбат, Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Ц.Оюунбаатар нар хүний эрхийн асуудлаар сэтгүүлчдэд мэдээлэл хийж, “Хорих 461 дүгээр ангид хоригдож байгаад амь насаа алдсан иргэн А нь эмнэлгийн тусламж авч чадаагүй.

Одоогийн байдлаар холбогдох хууль, хяналтын байгууллага шалгаж байна. Ер нь хорих байгууллагад хүний эрх зөрчигдсөөр байгаа. 2014 он гарсаар 5 хүн хорих байранд амь насаа алдсан тохиолдол гарсан. Цаашид Гэмт хэргийн тухай хууль, Гэмт хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулиудыг батлуулж хүний эрхийн асуудлыг цэгцэлнэ” гэдгийг мэдэгдлээ.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг эдийн засгийг эрчимжүүлэх 100 хоногийн ажлын талаар мэдээлэл хийлээ. Улсын Их Хурлаар өнгөрсөн долоо хоногт “Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдсантай холбогдуулан эдийн засгийг эрчимжүүлэх 100 хоногт 70 гаруй ажил хийхээр төлөвлөөд байгааг мэдэгдэв.

2014.05.20

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны хуралдаанаар Боловсролын тухай хуулийн зарим заалтын хэрэгжилт болон уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар зарим иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийг хэлэлцээд Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.4 дэх заалт, 43.3 дахь хэсгүүд хоорондын зөрчлийг арилгах, мөн хуулийн заалтад их, дээд сургуульд ажилласан иргэнийг хамруулах, хуулийн шаардлагыг хангасан боловч тэтгэврийн насанд хүрэхээсээ өмнө нас барсан иргэн, түүний гэр бүлийн гишүүнд дээрх мөнгөн тэтгэмжийг олгох боломжтой эсэх талаар судлан эрх зүйн зохицуулалт хийх саналаа боловсруулан танилцуулахыг Засгийн газарт чиглэл болгохоор шийдвэрлэв.

Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны хуралдаанаар Цагдан хорих болон хорих байгууллага дахь хүний эрхийн нөхцөл байдлын талаар Хууль зүйн сайд Х.Тэмүүжин, Хүний эрхийн үндэсний комиссын дарга Ж.Бямбадорж нарын мэдээллийг сонслоо.

2014.05.21

Улсын Их Хурлын гишүүдийн уламжлалт цахим ярилцлагад Баянхонгор аймгаас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн Х.Баттулга, Д.Ганбат нар оролцож, цаг үеийн ажлын талаар орон нутгийн удирдлагуудын мэдээллийг сонсож, санал солилцов.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Монгол Улсын Боловсролын их сургуульд зочлон үйл ажиллагаатай нь танилцаж, оюутнуудад боловсролын шинэчлэлийн талаар лекц уншив.

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсантай холбогдуулан тус байнгын хорооны зарим гишүүд Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдуудтай цахим ярилцлага хийж санал солилцов.

2014.05.23

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2014 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2015-2016 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудыг батлав.

Монгол Улсын Засгийн газар, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага хооронд байгуулсан “Инженер, технологийн дээд боловсрол төсөл”-ийн зээлийн хэлэлцээр, Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр, Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Хүнс, тэжээл, нийгмийн халамжийн төсөл:Нэмэлт санхүүжилт”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулиудыг соёрхон баталлаа.

2014.05.26

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, Эрүүл мэндийн яам, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв хамтран “Татварыг нэмэгдүүлэх замаар тамхины хэрэглээг бууруулах боломж” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав. Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос байгуулагдсан “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий” ажлын хэсгийн гишүүд нийслэлийн Баянгол дүүргийн нэгдсэн эмнэлгийн эмийн сан, П.Н.Шастины нэрэмжит Улсын гуравдугаар төв эмнэлгийн эм зүйн алба болон зарим хувийн эмийн сангуудын үйл ажиллагаатай танилцав.

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны гишүүд Уул уурхайн яам болон Монголын уул уурхайн үндэсний ассоциаци, зарим уул уурхайн компанийн төлөөлөлтэй Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал солилцов.

2014.05.28

Улсын Их Хурлын дарга З.Энхболд нүүрсийг “цэвэр нүүрс” болгох тал дээр ажилладаг дэлхийн тэргүүлэгчдийн “World clean coal conference” хурлыг нээж үг хэлэв. Монгол





Улсын эдийн засагт уул уурхайн салбар томоохон жин эзэлж байна. Тухайлбал, 2013 оны статистикаас үзвэл Монгол Улсын ДНБ-ний 18.5 хувийг уул уурхайн салбар үйлдвэрлэж, нийт экспортын 82 хувийг эрдэс бүтээгдэхүүн эзэлж байна. Үүний дотор нүүрсний экспорт нийт экспортын 26 хувийг бүрдүүлжээ. Иймээс энэ салбарыг тогтвортой хөгжүүлэх нь манай улсын эдийн засагт тэргүүлэх ач холбогдолтой юм гэдгийг Улсын Их Хурлын дарга онцлов.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо “Ардчилсан засаглалын институцийн хөгжилд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг: Үр дүн, сургамж” сэдэвт судалгааны хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Улсын Их Хурлын гишүүд, улс төрийн намуудын удирдлагууд, их, дээд сургуулийн эрдэмтэн багш, судлаачид, ардчилсан Үндсэн хууль тогтоогчдын холбооны төлөөллүүд оролцлоо.

2014.05.29

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос Газрын тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийн хүрээнд “Бэлчээрийн газрын тулгамдсан асуудал” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлэгт Улсын Их Хурлын гишүүд, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, ҮАБЗ, их сургуулиудын багш эрдэмтэн, судлаачид, Хэнтий, Дархан-Уул аймгийн малчид, фермерийн төлөөлөл оролцож бэлчээр ашиглалт, тулгамдаж буй асуудлаар санал солилцлоо.

2014.05.30

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Хууль зүйн яам, Хууль зүйн үндэсний хүрээлэн хамтран “Монгол Улсын эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулав.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Монгол Улсад банкны тогтолцоо үүсч, бэхжсэний 90 жилийг тохиолдуулан баярын мэндчилгээ дэвшүүлэв.

2014.05.30

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хууль, “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоол батлав.

Татварын хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Төсвийн байнгын хорооны ажлын хэсэг, Улсын Их Хурлын Тамгын газар, Сангийн яам, Татварын ерөнхий газар хамтран “Нэмэгдсэн өртгийн албан татвар болон Худалдааны албан татвар” сэдвээр нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулав.

2014.06.01

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан нийт хүүхэд багачууддаа мэндчилгээ дэвшүүлэв. Улсын Их Хурлын дарга З.Энхболд Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Viva” хотхонд зохиогдсон хүүхдийн баярын нэгдсэн арга хэмжээнд оролцов.

2014.06.02

Монгол Улсын Их Хурлын дарга З.Энхболд АНУ -ын Денверийн Их сургуулийн Удирдах

ажилтнуудад зориулсан Бизнесийн удирдлагын мастерын сургалтын багш, оюутнуудын төлөөллийг хүлээн авч уулзав.

2014.06.03

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам хамтран “Тэтгэврийн тогтолцооны шинэчлэл” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав.

2014.06.04

Улсын Их Хурлын гишүүдийн уламжлалт цахим ярилцлагад Ховд аймгаас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дарга Д.Батцогт, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дарга С.Бямбацогт нар оролцон аймгийн удирдлагуудын мэдээлэл, иргэдийн төлөөллийн санал хүсэлтийг сонсож санал солилцов.

2014.06.05

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг нэгдсэн хэлэлцэж, Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслүүдийг батлав.

2014-06-06

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиудыг батлав.

Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж ажлын байрыг нэмэгдүүлэх, импортыг орлох, экспортыг дэмжсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор импортоор оруулж байгаа жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөхөөр дээрх хуульд тусгажээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг 2013 оны улсын төсвөөс Ерөнхий сайдын багцад хуваарилагдсан 50 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зарцуулалт, ажлын гүйцэтгэлийн талаар мэдээлэл хийв. Ерөнхий сайд өөрийн багцад хуваарилагдсан 50 тэрбум төгрөгөөс 47.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар долоон төрлийн ажлыг гүйцэтгэсэн тухайгаа мэдээлэлдээ дурдав.

2014.06.10

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны хуралдаанаар Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тайланг сонсов.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагаа болон стратегийн чухал ач холбогдол бүхий орд газарт түшиглэн төрийн өмчийн оролцоот хувьцаат компани байгуулж үйл ажиллагааг нь үр ашигтай удирдан зохион байгуулах, түүний өгөөжөөс ард иргэдэд хишиг хувь хүртээх чиглэлээр батлагдсан хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийн байдлыг шалгах зорилгоор Эдийн засгийн байнгын хорооноос байгуулагдсан ажлын хэсэг Өмнөговь аймгийн Цогтцэций суманд ажиллав.



2014.06.11

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, Соёл, спорт, аялал жуулчлалын яам хамтран “Монголын кино урлагийн тулгамдсан асуудлууд, шийдвэрлэх арга замууд” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав. Энэхүү хэлэлцүүлэгт Улсын Их Хурлын гишүүд, Монголын кино урлагийн ахмад, залуу үеийн төлөөлүүд зэрэг 100 гаруй хүн оролцож, Монгол Улсын төрөөс кино урлагийн талаар цаашид баримтлах бодлого чиглэл, кино урлагийн тулгамдсан асуудлын талаар санал солилцлоо.

2014.06.12

Улсын Их Хурлын дарга З.Энхболд, Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогт нар Монгол Улсын газар тариалангийн гол бүс нутаг Сэлэнгэ аймагт ажиллав.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд, Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогт нар Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотын Бумцэндийн нэрэмжит 1 дүгээр дунд сургуулийн 30 жилийн ойн арга хэмжээнд оролцож, Ардын хувьсгалын партизан, Улсын Бага Хурлын анхны дарга Гончигийн Бумцэндийн хөшөөнд цэцэг өргөж хүндэтгэл үзүүлэв.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Ш.Түвдэндоржийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдаар томилов.

2014.06.13

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Үндэсний их баяр наалмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлав. Уг хуулиар далай аварга цолыг хасч байгаа бөгөөд үндэсний бөхийн цол чимэгийн агуулга сайжирч, олон түмний дунд нэр хүнд улам өсөхийн сацуу бөхчүүдийн шударга өрсөлдөөн, барилдааны чанарт өөрчлөлт гарна гэж төсөл санаачлагчид үзсэнийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжив.

“Ногоон хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоол, Малын индексжүүлсэн даатгалын тухай болон холбогдох бусад хуулиудыг баталлаа.

2014.06.16

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос томилогдсон сэжигтнийг баривчлах, сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих, хорьж мөрдөх хугацааг сунгах, цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ нь хүний эрх, эрх чөлөөг зөрчиж байгаа эсэхэд хяналт шалгалт хийж, үр дүнг нь байнгын хорооны хуралдаанд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүд ШШГЕГ болон тус байгууллагын харьяа Цагдан хорих 461 дүгээр ангийн үйл ажиллагаатай танилцав.

2014.06.17

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар “Алтанбулаг” худалдааны болон “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсүүдийн өнөөгийн байдал, цаашдын үйл ажиллагааны талаар Эдийн засгийн хөгжлийн дэд сайд О.Чулуунбатын танилцуулга, мэдээллийг сонсов.

2014.06.17

Улсын Их Хурлын дарга З.Энхболд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн захирагчийн орлогч бөгөөд Ази, Номхон далайн бүсийн товчооны захирал Хаолянь Шу болон албаны бусад төлөөлөгчдийг Төрийн ордонд хүлээн авч уулзав.

2014.06.18

Улсын Их Хурлын дарга З.Энхболд АНУ-ын Денверийн Их сургуулийн MBA программын захирал, доктор Дуглас Ален, "Spring" институтийн Ерөнхийлөгч Мирна Анн Адкинс болон багш, оюутнуудын төлөөллийг Төрийн ордонд хүлээн авч уулзав.

2014.06.19

Улсын Их Хурлын гишүүдийн уламжлалт цахим ярилцлагад Дорноговь аймгаас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь оролцож аймгийн Засаг даргын орлогч Б.Төмөрхуяг, аймгийн ИТХ-ын дарга Г.Ганбаатар нараас орон нутгийн цаг үеийн асуудлын талаар мэдээлэл сонсож, иргэдийн төлөөллийн сонирхсон асуултад хариулт өгөв.

Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Ц.Оюунбаатар Дархан-Уул, Сэлэнгэ аймагт ажиллаж, зэвсэгт хүчний болон хилийн цэргийн анги салбаруудын үйл ажиллагаатай танилцан тулгамдаж байгаа асуудлын талаар санал солилцов.

2014.06.20

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Монгол Улсад Онцгой байдлын алба үүсэн байгуулагдсаны 10 жилийн ойг тохиолдуулан мэндчилгээ дэвшүүлэв.

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын баримт бичиг батлахтай гэж байгаатай холбогдуулан "Дээд болон мэргэжлийн боловсролын хөгжлийн гарц, шийдэл" сэдэвт хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг "Эзэн-100 хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн талаар гишүүдэд мэдээлэл хийлээ.

2014.06.21-22

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Орхон аймагт ажиллаж, "Эрдэнэт" үйлдвэр, цахилгааны зэс утас үйлдвэрлэх "Эрдмин" ХХК, өдөртөө 8000-10000 ширхэг маск үйлдвэрлэх хүчин чадалтай "Мөнхийн цагаан жим" ХХК, "Эрдэнэт Эко" жишиг хорооллын үйл ажиллагаатай танилцав.

2014.06.22-23

Улсын Их Хурлын дарга З.Энхболдын урилгаар Оросын Холбооны Улсын Холбооны Хурлын Холбооны Зөвлөлийн дарга Валентина Ивановна Матвиенко Монгол Улсад албан ёсны айлчлал хийлээ.

2014.06.23

Монгол Улсын Их Хурлын дарга З.Энхболд, манай улсад албан ёсны айлчлал хийж буй



ОХУ-ын Холбооны Хурлын Холбооны Зөвлөлийн дарга хатагтай Валентина Ивановна Матвиенко нар хэлэлцээний үеэр яригдсан асуудлаар хоёр орны сэтгүүлчдэд мэдээлэл хийв.

2014.06.23

Улсын Их Хурлын дарга З.Энхболдын урилгаар Бүгд Найрамдах Турк Улсын Үндэсний Их Хурлын дарга Жемил Чичек Монгол Улсад албан ёсны айлчлал хийв.

2014.06.24

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос томилогдсон “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогыг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий” ажлын хэсэг “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын хөгжлийн гарц, шийдэл” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав.

Улсын Их Хурлын Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хорооны хуралдаанаар 2014 оны эхний хагас жилд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хийж гүйцэтгэсэн болон цаашид хийх ажлын талаар холбогдох төрийн байгууллагуудын тайлан мэдээллийг сонсов.

Хуралдааны эхэнд Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны нарийн бичгийн дарга, ажлын албаны дарга Ж.Эрдэнэцогт тус хорооны 2014 оны үйл ажиллагааны эхний хагас жилийн тайланг танилцуулав.

2014.06.25

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо Сонгуулийн нэгдсэн хууль, Улс төрийн намын тухай, Улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүдийн уулзалт, ярилцлага зохион байгуулав. Уулзалт, ярилцлагад ажлын хэсгийн гишүүд болон Төрийн байгуулалтын байнгын хорооны урилгаар манай улсад хүрэлцэн ирсэн Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт, хүний эрхийн албаны Ардчилсан засаглал, жендэрийн нэгжийн дарга, доктор Марчин Валецки, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны ажилтнууд оролцлоо.

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны хуралдаанаар “ДЦС-2” түшиглэн байгуулсан утаагүй түлшний үйлдвэрийн төсвийн зарцуулалт үр дүн”-д хийсэн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор А.Зангад танилцууллаа. Байнгын хорооноос Засгийн газрын 161 дүгээр тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах, намрын чуулганаар энэ асуудлаар эргэж танилцуулах заалт бүхий тогтоол гаргахаар шийдвэрлэв.

2014.06.26

Улсын Их Хурлын гишүүдийн уламжлалт цахим ярилцлагад Сэлэнгэ аймгаас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбат оролцож аймгийн Засаг дарга С.Бүрэнбат, ЗДТГ-ын дарга Ө.Сувдаа, ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга А.Сарантуяа нараас орон нутгийн цаг үеийн асуудлын талаар мэдээлэл сонсож, санал солилцов.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний их баяр наадмын

тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Дипломат албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудыг баталлаа.

Мөн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль баталснаар Засгийн газар “Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх 100 хоног”-ийн хүрээнд банкны салбарын хүндрэлийг шийдвэрлэх зорилгоор Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17.2 -т “Монгол Улсын арилжааны банкны гадаад, дотоодын хөрөнгийн биржид гаргасан бондыг худалдан авсан Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн бондын хүүгийн орлогод 10 хувиар татвар ногдуулах” гэснийг нэмэхээр болж байгаа юм.

2014.06.27

Хууль тогтоох үйл ажиллагаанд иргэдийн оролцоог дэмжих, хууль тогтоомжийг боловсронгуй болгох зорилгоор Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороо, Монголын хуульчдын холбооны Шүүгчдийн хороотой хамтран ажиллах санамж бичигт гарын үзэг зурлаа. Уг арга хэмжээнд Улсын Их Хурлын гишүүн, Өргөдлийн байнгын хорооны дарга Р.Бурмаа, Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан, С.Ганбаатар болон Монголын хуульчдын холбооны Шүүгчдийн хорооны тэргүүн Ц.Цогт, Монголын хуульчдын холбооны Тамгын газрын дарга Б.Энх-Амгалан нар оролцов.

2014.06.27

УИХ-ын дарга З.Энхболд Олон Улсын Валютын Сангийн /ОУВС/ Удирдах захирлын орлогч ноён Наюуки Шинохара, Ази, Номхон Далайн Газрын орлогч захирал Маркус Родлаувер болон бусад төлөөлөгчдийг хүлээн авч уулзаж, Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал болон цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаар санал солилцов.

2014.06.30

Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэгээр ахлуулсан Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэг цахим сайтуудын эрхлэгч нарын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулж, хуулийн төслийн үндсэн зохицуулалтын талаар санал солилцов.

2014.07.01

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2013 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоол, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг батлав.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль баталж, Үндэсний их баяр наадмаар 14,15-ны өдрүүдэд амрахаар болов.

Шилэн дансны тухай болон холбогдох бусад хууль, “Цагаан суваргын ордын төрийн эзэмшлийн хувь тогтоор тухай”, “Улсын Их Хурлын 2014 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдав.

Улсын Их Хурлын 2014 оны хаврын ээлжит чуулган өндөрлөв. Ээлжит чуулганыг хааж Улсын Их Хурлын дарга З.Энхболд үг хэллээ.



2014.07.02

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны дарга Р. Бурмаа Улсын Их Хурлын 2014 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд тус байнгын хорооноос хийсэн ажлын талаар сэтгүүлчдэд мэдээлэл өгөв.

2014.07.07

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга А.Бакей 2014 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлаа тайлагнаж сэтгүүлчдэд мэдээлэл хийлээ. Тус байнгын хороо ээлжит чуулганы хугацаанд нийт 11 удаа хуралдаж, давхардсан тоогоор 17 асуудал хэлэлцэн шийдвэрлэжээ.

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дарга Д.Батцогт Улсын Их Хурлын 2014 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлынхаа талаар сэтгүүлчдэд мэдээлэл өгөв.

Тус байнгын хороо хаврын чуулганы хугацаанд 11 удаа хуралдаж, 43 хуулийн төсөл, Улсын Их Хурлын тогтоолын төсөл 7, хяналт шалгалтын тайлан нэг, эрхлэх асуудлын хүрээнд хамаарах яам, агентлаг, харьяа байгууллагуудын тайлан мэдээлэл 4, нийт 55 асуудал хэлэлцэн шийдвэрлэжээ.

2014.07.07

Монгол Улсад албан ёсны айлчлал хийж байгаа Бүгд Найрамдах Чех Улсын Парламентын Доод танхимын Дэд дарга ноён Пётр Газдык тэргүүтэй төлөөлөгчдийг Улсын Их Хурлын дарга З.Энхболд Төрийн ордонд хүлээн авч уулзав.

2014.07.08

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Г.Баярсайхан хаврын ээлжит чуулганы хугацаанд хийсэн ажлынхаа талаар сэтгүүлчдэд мэдээлэл хийлээ. Тайлангийн хугацаанд тус байнгын хороо 63,11 хувийн дундаж ирцтэйгээр 16 удаа хуралдаж, давхардсан тоогоор 28 асуудал хэлэлцжээ.

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Ц.Оюунбаатар, Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэг нар тус байнгын хорооноос Улсын Их Хурлын 2014 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийсэн ажлын талаар хэвлэлийн бага хурал хийлгэв. Байнгын хороо хаврын чуулганы хугацаанд 12 удаа хуралдаж 20 асуудал хэлэлцэж шийдвэрлүүлсний зэрэгцээ Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан 4 ажлын хэсэг 10 удаа хуралджээ.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд БНКиру-ын Ерөнхий сайд Д.К.Оторбаев тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав. Улсын Их Хурлын дарга Монгол Улс Киргиз Улсыг Төв Азийн бүс нутаг дахь Монгол Улсын чухал түншүүдийн нэг хэмээн үзэж цаашид харилцаа хамтын ажиллагаа, түүний дотор хоёр орны парламентын хамтын ажиллагааг идэвхжүүлэхийн төлөө байгаага дурдаад хоёр орны парламентын хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд парламентын бүлгүүдийн харилцаа, харилцан айлчлал чухал үүрэгтэйг хэллээ.

УИХ-ын дарга З.Энхболд Бүгд Найрамдах Франц Улсын Үндэсний Ассамблейн гишүүн, Үндэсний Ассамблей дахь Франц, Монголын найрамдлын бүлгийн дарга Жером Шартье тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа. Бүгд Найрамдах Франц Улсын Үндэсний

Ассамблейн гишүүн, Үндэсний Ассамблей дахь Франц, Монголын найрамдлын бүлгийн дарга Жером Шартъег хоёр улсын нийгэм эдийн засгийн харилцаанд оруулсан хувь нэмрийг өндрөөр үнэлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар алтан гадас одонгоор шагнасныг Монгол Улсын Их Хурлын дарга Зандаахүүгийн Энхболд гардуулж өгөв.

2014.07.08-12

Улсын Их Хурал дахь “МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслийн бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол-Францын парламентын бүлгийн дарга Н.Батцэрэгийн урилгаар Бүгд Найрамдах Франц Улсын Үндэсний Ассамблейн гишүүн, Франц-Монголын найрамдлын бүлгийн дарга Ж.Шартъе тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад албан ёсны айлчлал хийв.

2014.07.09

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Ганбат, Улсын Их Хурлын гишүүн Ш.Түвдэндорж нар Улсын Их Хурлын 2014 оны хаврын чуулганы хугацаанд тус байнгын хорооны хийсэн ажлын талаар сэтгүүлчдэд мэдээлэл хийлээ. Тус байнгын хороо хаврын чуулганы хугацаанд 15 удаа хуралдаж, хуулийн төсөл 42, Улсын Их Хурлын тогтоолын төсөл 4-ийг хэлэлцэж, санал, дүгнэлт 26, танилцуулга 6, зарчмын зөрүүтэй 33 саналын томъёолол бэлтгэн чуулганы нэгдсэн хуралдаанаар шийдвэрлүүлсэн байна.

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн хэвлэлийн бага хурал хийлгэж, хаврын чуулганы хугацаанд тус байнгын хорооноос хийсэн ажлын талаар сэтгүүлчдэд мэдээлэл өгөв. Тус байнгын хороо хаврын чуулганы хугацаанд 63 хувийн дундаж ирцтэйгээр 19удаа хуралдаж, 101 асуудал /давхардсан тоогоор/ хэлэлцжээ.

Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэг, Г.Уянга нар хэвлэлийн бага хурал хийлгэж, Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүдийн албан бус бүлгийн хоёр жилийн үйл ажиллагааны талаар сэтгүүлчдэд мэдээлэл өгөв.

2014.07.22-28

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Ц.Оюунбаатар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Цолмон нар ОХУ-ын Эрхүү, Улаан-Үд дахь Монгол Улсын Ерөнхий консулын газруудын үйл ажиллагаа болон консулын газрын байр, ажиллах нөхцөл, ажилчдын орон сууцны асуудалтай газар дээр нь танилцаж, шийдвэрлэх арга замын талаар санал солилцов.

2014.08.20

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Монгол Улсад айлчилж байгаа Япон Улсын Парламент дахь Либерал Ардчилсан намын Япон-Монголын найрамдлын бүлгийн дарга Мотоо Хаяаши тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа.

2014.08.22

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Монгол Улсын Ерөнхийлөгчийн урилгаар манай улсад төрийн айлчлал хийж байгаа БНХАУ-ын дарга Си Зиньпинд бараалхав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн урилгаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын дарга Си





Зиньпин Монгол Улсад төрийн айлчлал хийж байгаатай холбогдуулан зарласан Улсын Их Хурлын Хүндэтгэлийн хуралдаан болов. Хүндэтгэлийн хуралдаанд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Ерөнхий сайд Н.Алтанхуяг нар байлцав.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын дарга Си Зиньпинийг чуулганы хуралдааны танхимд орж ирэхэд Улсын Их Хурлын гишүүд, хүндэт зочид босч хүндэтгэл үзүүлэв. Хүндэтгэлийн хуралдааныг Улсын Их Хурлын дарга З.Энхболд нээж, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын дарга Си Зиньпин Хүндэтгэлийн хуралдаанд үг хэллээ.

2014.08.27

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны гишүүд “Цэцэрлэгийн хүртээмж, өнөөгийн байдал, хэрэгцээ шаардлага, барилга байгууламж”-ийн талаар мэдээлэл сонсож, холбогдох албаныхантай тулгамдаж буй асуудлуудын талаар санал солилцов.

2014.08.28

Улсын Их Хурлын дарга З.Энхболд “Энэрэл нигүүсэл оюун билгийн төв” ТББ-ын тэргүүн Ажиа гэгээн Лувсантүвданы санаачлагаар бүтээн босгосон Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн дэргэдэх Хүүхдийн цусны эмгэг, хавдрын эмнэлгийн барилгын нээлтэд оролцож үг хэлэв.

2014.09.01

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Барилгын политехник коллежийн хичээлийн шинэ жилийн нээлтэд оролцож багш, оюутнуудад мэндчилгээ дэвшүүлэв.

2014.09.05-06

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Орхон аймаг дахь “Шим-Технологи” ХХК-ийн Молибдены баяжмал боловсруулах үйлдвэрийн нээлтэд оролцож үг хэллээ. Улсын Их Хурлын дарга 4600 гаруй хүн амтай Булган аймгийн Хутаг-Өндөр суманд ажиллаж, махны чиглэлийн үхрийн фермерийн аж ахуй эрхэлдэг Канадын иргэн Жереми Тиссений фермерийн аж ахуйтай танилцав.

2014.09.10

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг тохиолдуулан Улсын Их Хурлын дарга З.Энхболд, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг, Улсын Их Хурлын дэд дарга Л.Цог, М.Энхболд, Улсын Их Хурлын гишүүд, нийслэлийн иргэдийн Хурлын Төлөөлөгчид болон хэлмэгдэгсдийн ар гэрийнхэн “Хэлмэгдэгсдийн хөшөө”-нд цэцэг өргөж, хүндэтгэл үзүүлэв.

Улсын Их Хурлын дэд дарга, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга Л.Цог Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг тохиолдуулан Гандантэгчинлэн хийдийн дэргэдэх Дашчоймпол дацангийн Гавж, Дархан-унзад 100 настай Лочин овогтой Ишжамцынд зочилж, хүндэтгэл үзүүлэв.

2014.09.18

Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Ганбат, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга

Г.Баярсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн сайд Х.Тэмүүжин, Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү нар болон Улсын Их Хурлын Хууль зүй, Аюулгүй байдал, гадаад бодлого, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ажилтнууд Иргэний харьяалал шилжилт хөдөлгөөний ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газарт ажиллаж, хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцав.

2014.09.22

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны цагийг еөрчлөх тухай 146 дугаар захирамж гаргаж, Улсын Их Хурлын 2014 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдааныг долоо хоногийн Пүрэв, Баасан гарагт өглөө 09 цагаас эхэлж, үдээс хойш 14 цагаас үргэлжлүүлж байхаар шийдвэрлэлээ.

2014.09.23

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын 2014 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай захирамж гаргав.

2014.09.24

Улсын Их Хурлын дарга З.Энхболд “Амгалангийн дулааны станц”, “Дулааны цахилгаан станц-3” ТӨХК, “Дулааны цахилгаан станц-4” ТӨХК-иудад ажиллаж, эрчим хүчний салбарын бүтээн байгуулалтын ажилтай танилцлаа.

2014.09.26

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын 90 жилийн ойг тохиолдуулан мэндчилгээ дэвшүүллээ.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Монголын нутгийн удирдлагын холбоотой хамтран “Нутгийн удирдлагын цаашдын хандлагыг зөв тодорхойлох нь” сэдэвт хэлэлцүүлгийг Төрийн ордны Их танхимд зохион байгуулав.

2014.09.29

Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Г.Батхүү, Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга А.Бакей нар Хяналтын тухай хуулийн төслийн талаар нийслэлийн Иргэний танхимд хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлэгт нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Д.Баттулга болон холбогдох албаны удирдах ажилтан, мэргэжилтнүүд, аж ахуйн нэгж, иргэдийн төлөөлөл оролцов.

Улсын Их Хурлын Тамгын газар, БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлсэн “Цахим парламент” төсөл, Улсын Их Хурлын хуралдааны цахим системийн нээлтийн арга хэмжээ Төрийн ордонд болов.

Нээлтийн арга хэмжээнд Улсын Их Хурлын дэд дарга Л.Цог, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, БНСУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ли Тэ Ру, БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /Койка/-ын Суурин төлөөлөгч Чой Хын Ёл, КТНЕТ компанийн Ерөнхийлөгч Сео Кванг Хён болон албаны бусад хүмүүс оролцов.



2014.10.01

Улсын Их Хурлын 2014 оны намрын ээлжит чуулган 11.40 цагт гишүүдийн 86,8 хувийн ирцтэйгээр нээлтээ хийлээ. Хуралдаанд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Ерөнхий сайд Н.Алтанхуяг болон гадаад орнуудаас Монгол Улсад суугаа Элчин сайд нар, олон улсын байгууллага, гадаад, дотоодын зочид, төлөөлөгчид оролцов.

2014.10.03

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Нээлттэй нийгэм форум, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран “Нийтийн сонсголын тухай” хуулийн төслийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулав.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Монгол Улсад орчин үеийн тоо бүртгэл, статистик мэдээллийн мэргэжлийн алба үүсч хөгжсөний түүхт 90 жилийн ойг тохиолдуулан мэндчилгээ дэвшүүлэв.

Улсын Их Хурлын 2014 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг Эдийн засгийг эрчимжүүлэх 100 хоногийн хүрээнд хийсэн ажлуудын талаар мэдээлэл хийв.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Дэлхийн болон Монголын багш нарын өдрийг тохиолдуулан мэндчилгээ дэвшүүлэв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан, С.Ганбаатар, Д.Батцогт, З.Баянсэлэнгэ нар хэвлэлийн бага хурал хийж, ахмад настнуудын тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх талаар Ерөнхий сайдад шаардлага хүргүүлж байгаагаа мэдэгдлээ.

2014.10.07

Улсын Их Хурлын 2014 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын бүтцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиуд, “Төрөөс захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай” Улсын Их Хурлын 2012 оны 14 дүгээр тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоол батлав.

2014.10.08

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Хууль зүйн яам, Хууль сахиулахын их сургууль, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сан, Нээлттэй нийгэм форум хамтран “Хууль сахиулахуйн инноваци” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг Төрийн ордны Их танхимд зохион байгуулж, эрдэмтэд илтгэл тавьж, хэлэлцүүлэг өрнүүлэв.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Хойд Америк, Монголын бизнесийн зөвлөлийн хөрөнгө оруулагчдын 17 дахь удаагийн зөвлөгөөнд оролцлоо.

Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Г.Батхүү, Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Ц.Оюунбаатар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь нар Хяналтын тухай хуулийн төслийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулав.

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар Намрын ургац хураалтын явц болон Мал аж ахуйн салбарын 2014-2015 оны

өвөлжилтийн бэлтгэл ажлын явц байдлын талаар Үйлдвэр, хөдөө аж ахуйн дэд сайд Б.Цогтгэрэлийн мэдээллийг сонсов.

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар Туул голын бохирдлын эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээ болон “Монгол орны ойн цэвэрлэгээний талаар авах арга хэмжээний тухай” Байнгын хорооны 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 04 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээллийг сонслоо.

2014.10.09

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 05 дугаар дүгнэлтийг хэлэлцээд хүлээн авах боломжгүй гэж үзэв.

“Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенц”-ийг соёрхон батлах тухай хууль батлагдав.

2014.10.11

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Бүх нийтээр мод тарих өдрөөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд мод тарив. Энэ удаагийн мод тарих арга хэмжээнд Улсын Их Хурлын гишүүн, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дарга Д.Батцогт, Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Д.Арвин, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар нар оролцлоо.

2014.10.15

Улсын Их Хурлын 2014 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуулийг хэлэлцэж батлав.

Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Ганбат Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагаа, өнөөгийн нөхцөл байдалтай танилцлаа. Энэ үеэр Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Амарсанаа, цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэг нартай уулзаж эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хийгдэж буй ажлууд, тэр дундаа Үндсэн хуулийн цэцийн тухай болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслүүдийн талаар санал солилцов.

2014.10.16

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Засгийн газрын зарим гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж, Чүлтэмийн Улааныг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайдын; Лувсанвандангийн Болдыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайдын; Цэвэлмаагийн Баярсайханыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайдын; Амаржаргалын Гансүхийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн сайдын; Даваажавын Ганхуягийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Уул уурхайн сайдын; Нямжавын Батбаярыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эдийн засгийн хөгжлийн сайдын; Мишигийн Сономпилийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрчим хүчний сайдын үүрэгт ажлаас тус тус чөлөөлөв.



Засгийн газрын бүтцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд нийцүүлэн холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг хэлэлцэж баталлаа.

Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Ганбат Улсын дээд шүүхийн үйл ажиллагаатай танилцлаа. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Зориг тулгамдаж буй асуудлууд, Улсын Их Хуралд өргөн бариад байгаа зарим хуулийн төслүүдийн хэлэлцүүлгийг эхлүүлэх, батлуулах асуудлыг шуурхайлах асуудлаар Хууль зүйн байнгын хороо анхаарал хандуулж ажиллах шаардлагатай байгааг байнгын хорооны даргад танилцуулав.

2014.10.17

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг Монгол Улсын макро эдийн засгийн 2014 оны эхний есөн сарын байдлын талаар мэдээлэл хийж, гишүүдийн асуултад хариулт өгөв.

2014.10.20

Улсын Их Хурлын Төсвийн болон Төрийн байгуулалтын байнгын хороо Швейцарийн хөгжлийн агентлаг, Дэлхийн банкны Монгол дахь Суурин төлөөлөгчийн газрын дэмжлэгтэйгээр “Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт, түүнд тулгарч буй сорилтууд” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав.

2014.10.22

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны хуралдаанаар “Эбола” вирусын талаар Эрүүл мэндийн сайдын болон Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын мэдээллийг сонсов.

2014.10.23

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороо “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав.

2014.10.24

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоол батлав. Уг тогтоолын дагуу Тавантолгой-Гашуунсухайт, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын шинэ шугамыг 1435 мм-ийн өргөн царигтай, Арц суурь-Эрдэнэт, Тавантолгой-Сайншанд-Баруун-Урт-Хөөт-Чойбалсан, Хөөт-Нөмрөг чиглэлийн төмөр замын шинэ шугамыг 1520 мм-ийн өргөн царигтай барихаар болов.

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо НҮБ-ын Хүн амын сантай хамтран “Хүн амын хөгжлийн бодлого ба эрүүл мэндийн даатгал” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэгээс Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдад тавьсан “Дотоодын фермерийн аж ахуйн нэгжүүдийг хивгээр хангах үүднээс экспортыг улирлын чанартайгаар зогсоож

болох эсэх талаарх” асуулга, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгээс “Монгол мал” хөтөлбөрийг батлах тухай Улсын Их Хурлын 2010 оны 23 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх асуулгын хариуг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд, Улсын Их Хурлын гишүүн Ш.Түвдэндорж танилцуулав.

2014.10.27-28

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын БХАТИХ-ын Байнгын хорооны дарга Жан Дөзяны урилгаар тус улсад албан ёсны айлчлал хийлээ.

Монгол Улсын Их Хурлын дарга Зандаахүүгийн Энхболд БНХАУ-ын БХАТИХ-ын Байнгын хорооны даргын урилгаар БНХАУ-д албан ёсны айлчлал хийв. Айлчлалын үеэр УИХ-ын дарга З.Энхболд БНХАУ-ын БХАТИХ-ын Байнгын хорооны дарга Жан Дөзянтай уулзалт хийж, санамж бичигт гарын үсэг зурав.

2014.10.28

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүдийн албан бус бүлгийн дарга Л.Эрдэнэчимэг болон тус бүлгийн эмэгтэй гишүүдийн төлөөлөл Хүчирхийллийн эсрэг төвд байрлаж байгаа хохирогч эмэгтэйчүүдтэй Төрийн ордонд уулзав.

2014.11.01

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Сүхбаатар аймагт ажиллаж, орон нутгийн ажил амьдрал, бүтээн байгуулалтын ажилтай танилцав.

2014.11.03

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Монголын хотуудын холбоо хамтран “Хотын захирагч - 2014” хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлэгт Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга А.Бакей, нийслэлийн Засаг даргын Хот байгуулалт, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан орлогч, Монголын хотуудын холбооны дэд ерөнхийлөгч С.Очирбат, нийслэлийн Баянгол дүүргийн Засаг дарга Д.Оросоо, Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотын захирагч М.Идэрбат, Хэнтий аймгийн Бэрх хотын захирагч Х.Баасанжав, Дархан-Уул аймгийн Дархан хотын орлогч дарга Б.Азжаргал, Өмнөговь аймгийн Даланзадгад хотын захирагч Ц.Баттулга нар оролцлоо.

2014.11.05

Улсын Их Хурлын эмэгтэй гишүүд 2014-2015 оны хичээлийн жилд гурван ээлжээр хичээллэж байгаа нийслэлийн зарим дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар хэлэлцүүлэг зохион байгуулав.

2014.11.05

Улсын Их Хурлын 2014 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Д.Хаянхярваа нарын 28 гишүүн 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах тухай асуудлыг хэлэлцлээ. Ерөнхий сайдыг огцруулахыг дэмжих нь зүйтэй гэсэн Байнгын хорооны саналын томъёоллоор санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон 66 гишүүнээс 36 нь зөвшөөрч 54,5 хувийн саналаар Ерөнхий сайдыг огцруулах санал дэмжигдлээ.



2014.11.06

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, АНУ-ын Азийн сан, Авлигатай тэмцэх газар, Эмэгтэй удирдагч сантай хамтран “Авлига үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх нь” сэдэвт онол практикийн бага хурлыг Төрийн ордонд зохион байгуулав.

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороо “Иргэдээс өргөдөл, гомдол хүлээн авах, шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт” сэдвээр зохион байгуулав. Хэлэлцүүлэгт яам, агентлагийн Төрийн захиргаа удирдлагын газрын дарга нар, Хууль зүйн яам, Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар, Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгаа шинжилгээний хэлтсийн төлөөлөл болон Швейцарийн хөгжлийн агентлагийн Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хөтөлбөрийн менежер Жак Мира нар оролцож саналаа солилцов.

2014.11.07

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Европын Холбоо, Европын Холбооны гишүүн орнуудаас Монгол Улсад суугаа болон хавсран суугаа Элчин сайд нарыг хүлээн авч уулзлаа.

Улсын Их хурлын дарга уулзалтыг нээж хэлсэн үгэндээ, Европын Холбоо болон Европын Холбооны гишүүн орнуудаас Монгол Улсад суугаа болон хавсран суугаа Элчин сайд нартай уулзаж харилцаа, хамтын ажиллагааны талаар санал солилцож байгаадаа баяртай байгаагаа илэрхийлэв.

2014.11.13

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг батлав.

2014.11.14

Улсын Их Хурлын 2014 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2015 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуулиудыг хэлэлцэж баталлаа.

Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг хуулийн хугацаанд нь хэлэлцэж баталсантай холбогдуулан Улсын Их Хурлын дарга З.Энхболд, Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Д.Эрдэнэбат, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь “Шударга ёс” эвслийн бүлгийн дарга Н.Батцэрэг нар хамтран сэтгүүлчдэд мэдээлэл хийлээ.

2014.11.20

Улсын Их Хурлын дарга З.Энхболд манай улсад айлчилж байгаа Бүгд Найрамдах Польш Улсын Сеймийн дэд маршал Ежи Вендерлих тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав. Ноён Ежи Вендерлих хоёр улсын парламентын Тамгын газар хоорондын хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурахад бэлэн болсон талаар танилцуулж, Монгол Улсын Их Хурлын даргыг Польш Улсад айлчлах үеэр гарын үсэг зурахаар хоёр тал тохиролцсон гэдгийг уламжлав.

2014.11.21

Улсын Их Хурлын 2014 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох асуудлыг хэлэлцээд хуралдаанд оролцсон гишүүдийн 95.5 хувийн саналаар Чимэдийн Сайханбилэгийг Монгол Улсын Ерөнхий сайдаар томиллоо.

Олон талын хөрөнгө оруулалтыг баталгажуулах байгууллагын конвенцид орсон нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай, Далайн хөдөлмөрийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 2066 оны конвенцид нэгдэн орох тухай, Аврах ажиллагааны тухай 1989 оны Лондонгийн конвенцид нэгдэн орох тухай хуулиудыг соёрхон батлав.

2014.11.23

Эзэн богд Чингис хааны мэндэлсний 852 жилийн ойн баяр, “Монгол бахархалын өдөр” буюу өвлийн тэргүүн сарын шинийн нэгний түүхэн өдрийг тохиолдуулан УИХ-ын дарга З.Энхболд Монгол Улсын төрийн дээд шагнал, тэргүүн зэргийн “Чингис хаан” одон гардуулах ёслолын ажиллагаанд оролцлоо.

Монгол Улсын төрийн дээд шагнал, тэргүүн зэргийн “Чингис хаан” одон гардуулах ёслолын ажиллагаа Төрийн ордны Ёслол хүндэтгэлийн өргөөнөө болж, Академич, дэлхийд нэртэй физикч Хавтгайн Намсрай энэхүү нэр хүндтэй шагналыг хүртлээ. Эрдэмтэн Х.Намсрай ийнхүү Төрийн дээд шагнал “Чингис хаан” одонгоор шагнуулсан найм дахь хүн болсон юм.

2014.11.26

Улсын Их Хурлын дарга З.Энхболд ОХУ -ын Бүгд Найрамдах Буриад Улсын Ардын Хурлын дарга М.М.Гершевич тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.

Улсын Их Хурлын дарга хоёр орон стратегийн түншлэлийн түвшинд хөгжүүлж буй харилцаа, хамтын ажиллагаа өргөн хөгжиж байгаад сэтгэл хангалуун байгааг дуулгаад энэ онд хоёр улсын хооронд дээд, өндөр түвшний айлчлалууд хэрэгжсэнийг онцлов.

Анхдугаар Үндсэн хууль батлагдсан, Бүгд Найрамдах улсаа тунхагласны 90 жилийн ойн өдөр Улсын Их Хурлын дарга З.Энхболд болон Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд, нийслэлийн удирдлагууд, иргэдийн төлөөлөл Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөж, Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл үзүүллээ.

2014.11.28

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороо “Дорноговь аймгийн Цагаан дэлийн агуй, Хутаг уул, Чандмань хар уулын бүс нутаг дахь байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилт” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав.

2014.12.01

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Дэлхийн банкны Монгол дахь суурин төлөөлөгч Жим Андерсоныг хүлээн авч уулзав. Энэхүү уулзалтаар Монгол Улсын төсвийн өнөөгийн байдал, Дэлхийн банкнаас цаашид Монгол Улсад хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийн талаар харилцан санал солилцсон.





2014.12.02

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын даргаас тус байнгын хороонд чиглэл болгосны дагуу Татварын ажилтнуудын үр дүнгийн урамшуулал авсан талаарх асуудлаар ажлын хэсэг гаргаж шалгахаар тогтов.

2014.12.04

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн төслийг хэлэлцэж батлав.

Эдгээр хууль батлагдсанаар шинэ Засгийн газар Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын Шадар сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга болон дор дурдсан асуудал эрхэлсэн нийт 19 гишүүнтэйгээр ажиллахаар боллоо. Үүнд:

- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд;
- Гадаад хэргийн сайд;
- Сангийн сайд;
- Хууль зүйн сайд;
- Аж үйлдвэрийн сайд;
- Батлан хамгаалахын сайд;
- Барилга, хот байгуулалтын сайд;
- Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд;
- Зам, тээврийн сайд;
- Уул уурхайн сайд;
- Хөдөлмөрийн сайд;
- Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд;
- Хүнс, хөдөө аж ахуйн сайд;
- Эрчим хүчний сайд;
- Эрүүл мэнд, спортын сайд;
- Монгол Улсын сайд.

Хуралдааны төгсгөлд Улсын Их Хурлын дарга З.Энхболд Засгийн газрын бүтцийн тухай хууль батлагдсанаар Ерөнхий сайд Засгийн газрын гишүүнээр ажиллах хүмүүсийг томилуулах саналаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх боломжтой болсныг дуулгаад 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн ажлын цаг дуусахаас өмнө саналаа өргөн мэдүүлэхийг санууллаа.

2014.12.05

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар “Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай” Монгол Улс, АНУ хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг батлав.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиуд батлагдав.

2014.12.05

“Монголын ардчилсан хувьсгал-25” эрдэм шинжилгээний бага хурал төрийн ордонд болж, Улсын Их Хурлын дарга, Ардчилсан намын дарга З.Энхболд оролцож үг хэллээ.

2014.12.05

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн “Том төрөөс-Ухаалаг төр” санаачилгын хүрээнд Монгол Улсын Их Хурлын Тамгын газарт хийж хэрэгжүүлсэн Мэдээлэл, үйлчилгээ, удирдлагын төвийн нээлтийн үйл ажиллагаа боллоо. Улсын Их Хурлын дарга З.Энхболд энэ үеэр хэлсэн үгэндээ, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Ухаалаг төр санаачилгыг хэрэгжүүлж байна. Аливаа байгууллагын үйл ажиллагааны бизнес модель, процесст нарийвчилсан анализ хийж, оновчтой болгож чадвал ажилбар бүрийн явц, хугацаа зэргийг хэмжиж болдог, удирдахад төвөггүй болдог арга бий.

Төрийн байгууллага бүрийн үйл ажиллагаанд анализ хийж, дахин инженерчлэл хийхээс ухаалаг төрийг бүтээх ажил эхэлнэ гэж үзэж байна гэлээ.

Улсын Их Хурлын гишүүн Г.Батхүү, М.Батчимэг нарын санаачилан боловсруулсан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлэг боллоо. Хэлэлцүүлэгт Улсын Их Хурлын гишүүн Г.Батхүү болон Улаанбаатар хотын Цагдаагийн газрын Замын цагдаагийн асуудал эрхэлсэн дэд дарга Ч.Жаргалсайхан, Хөдөлмөрийн яамны мэргэжилтэн Р.Дүүрэнбаяр, Зам тээврийн яамны мэргэжилтэн А.Энхболд, Хууль зүйн яамны мэргэжилтэн Ч.Бат-Эрдэнэ, ШУТИС-ийн Механик инженерийн сургуулийн багш А.Эрдэнэтуяа, Замын хөдөлгөөн судлалын хүрээлэнгийн хуульч Я.Мөнхжаргал нар болон холбогдох албаны бусад хүмүүс оролцож хэлэлцүүлэг өрнүүлэв.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Засгийн газрын зарим гишүүдийг томилох, үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайдаар У.Хүрэлсүхийг хуралдаанд оролцсон гишүүдийн 98,3 хувийн саналаар томилов.

2014.12.06

Монгол Улсын Их Хурлын дарга, Ардчилсан намын дарга Зандаахүүгийн Энхболд болон Улсын Их Хурлын гишүүд, Ардчилсан намын гишүүд, олон нийтийн төлөөлөл Ардчилсан хувьсгалын 25 жилийн ойг тохиолдуулан Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл үзүүлэв.

2014.12.08

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Өсвөрийн зохион бүтээгчдийн ерөнхий боловсролын лаборатори ахлах сургуулийн нээлтийн ажиллагаанд оролцож үг хэлэв. Тэрээр хэлсэн үгэндээ, инноваци, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, шинийг эрэлхийлэхийг улс бодлогоор дэмжих ёстой. Монгол Улсын өнөө, ирээдүйн хөгжил цэцэглэлтийг зохион бүтээгчид бүтээн байгуулна гэдэгт би итгэдэг. Тиймээс инженерийн мэргэжлийг сонгон суралцах хүүхдүүдийг багаас нь бэлтгэх, тэдний техникийн боловсрол, сэтгэлгээг хөгжүүлэх орчныг бүрдүүлэх шаардлагатайг онцлов.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Ардчилсан хувьсгалын 25 жилийн ойд зориулан гаргасан “Монголын Ардчилал Японы хэвлэлд” гэрэл зургийн үзэсгэлэнгийн нээлтэд оролцлоо.

2014.12.09

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Засгийн газрын гишүүдийг томилох



асуудлыг хэлэлцэж Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогтыг, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдаар Улсын Их Хурлын гишүүн Д.Оюунхоролыг, Гадаад хэргийн сайдаар Л.Пүрэвсүрэнг тус тус томилов.

Засгийн газрын гишүүдийг томилох асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэж, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайдаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбатыг, Засгийн газрын гишүүн, Хууль зүйн сайдаар Д.Дорлигжавыг, Засгийн газрын гишүүн, Аж үйлдвэрийн сайдаар Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбатыг, Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайдаар Д.Цогтбаатарыг, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайдаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Цолмонг, Засгийн газрын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдаар Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөрийг, Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн сайдаар Н.Төмөрхүүг, Засгийн газрын гишүүн, Уул уурхайн сайдаар Р.Жигжидийг, Засгийн газрын гишүүн, Хөдөлмөрийн сайдаар С.Чинзоригийг, Засгийн газрын гишүүн, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдаар Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнийг, Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуйн сайдаар Улсын Их Хурлын гишүүн Р.Бурмааг, Засгийн газрын гишүүн, Эрүүл мэнд, спортын сайдаар Г.Шийлэгдамбыг, Засгийн газрын гишүүн, Эрчим хүчний сайдаар Улсын Их Хурлын гишүүн Д.Зоригтыг, Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайдаар М.Энхсайханыг тус тус томиллоо.

2014.12.10

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Дэлхийн банкны Зүүн Ази, Номхон далайн бүсийн дэд ерөнхийлөгч ноён Аксел ван Тротсенбург тэргүүтэй төлөөлөгчдийг Төрийн ордонд хүлээн авч уулзав.

2014.12.11

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцийн нэмэлт Протокол”-ыг соёрхон батлах хуулийг батлав.

2014.12.16

Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийн зарлигаар Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын найрамдалт харилцаа, боловсролын салбарын хамтын ажиллагаанд оруулж буй хувь нэмрийг нь өндрөөр үнэлж, Оросын Холбооны Улсын иргэн, Оросын Холбооны Улсын Б.Н.Ельциний нэрэмжит Уралын Холбооны Их сургуулийн орлогч захирал Анатолий Иванович Матерныг «Алтан гадас» одонгоор шагнасныг Монгол Улсын Их Хурлын дарга Зандаахүүгийн Энхболд гардуулав.

2014.12.17

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос байгуулагдсан “Түлш эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2010 оны 72 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгах ажлын хэсгийн удирдамжийн хүрээнд “Түлш эрчим хүчний салбарын төрийн өмчит болон хувьцаат компаниудын үйл ажиллагаа болон тулгамдаж буй асуудал” сэдэвт хэлэлцүүлгийг Байнгын хорооны дэд ажлын хэсэг Эрчим хүчний яамтай хамтран зохион байгуулав.

Хэлэлцүүлэгт ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн А.Тлейхан, Д.Сумъяабазар, Эрчим хүчний сайд Д.Зоригт, дэд сайд Д.Доржпүрэв, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга О.Магнай, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга С.Отгонбаяр болон Эрчим хүчний салбарын сайдын зөвлөл, Төрийн өмчийн хороо, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Төрийн өмчийн хороо, төрийн өмчит хувьцаат компаниудын захирлууд, дэд ажлын хэсгийн гишүүд оролцлоо.

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо “Соёлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн зохицуулалт, хэрэгжилт” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав.

2014.12.18

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг хэлэлцэж батлав.

2014.12.19

УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Номын сангийн тухай хуулийн төслийг баталлаа.

2014.12.22

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны гишүүд Зам тээврийн яамны байрлаж буй Засгийн газрын XIII байрны барилга болон Төрийн албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн барилгын ажлын явцтай танилцав.

2014.12.23

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай” Хууль зүйн байнгын хорооны 05 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоол батлав.

2014.12.25

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, тус хорооны орон тооны гишүүн Г.Хэрлэн, Б.Даажамба, орон тооны бус гишүүн Б.Лхагвасүрэн, Б.Батбаяр нарыг хүсэлтийн нь дагуу үүрэгт ажлаас чөлөөлөв.

Санхүүгийн зохицуулах хорооны даргаар З.Нарантуяаг, Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүнээр Х.Бум-Эрдэнэ, Э.Батболд нарыг, тус хорооны орон тооны бус гишүүнээр Д.Ганбат, Ж.Цэдэнрагчаа нарыг томилов.

Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн зарим гишүүнийг томилох тухай асуудал хэлэлцэж, Б.Батбаяр, Б.Золбаяр, Д.Нямсамбуу, Д.Оюун-Эрдэнэ, Д.Цэндсүрэн, Б.Энхмандах, З.Энхболд нарыг тус зөвлөлийн гишүүнээр томиллоо.

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал хэлэлцэж, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Ж.Энхбаяр, Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн



байнгын хорооны даргаар Су.Батболд, Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар А.Бакей, Төсвийн байнгын хорооны даргаар Б.Болор, Эдийн засгийн байнгын хорооны даргаар Ж.Батсуурь, Нийгмийн бодлого, боловсрол шинжлэх ухааны байнгын хорооны даргаар Д.Батцогт нарыг сонгож батлав.

2014.12.26

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороог төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Ё.Отгонбаяр, Д.Сарангэрэл нар ХӨСҮТ-ийн үйл ажиллагаатай танилцав. Нийслэлийн хэмжээнд хоёрдугаар шатлалын тусламж үйлчилгээ үзүүлэх хүүхдийн эмнэлэг дутагдалтай байгаатай холбогдуулан Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос уг асуудлыг шийдвэрлэх боломжийг судалж байгаа юм.

Улсын Их Хурлын чуулганы үдээс хойших нэгдсэн хуралдаан хаалттай горимоор болж, Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж улс орны нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын талаар мэдээлэл хийлээ. Мөн Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг, Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд М.Энхсайхан, Монголбанкны ерөнхийлөгч Н.Золжаргал нар гишүүдэд мэдээлэл өгсөн байна.

2014.12.29

Үндэсний эрх чөлөөний хувьсгалын 103 жилийн ойн өдрийн хүрээнд Монгол Улсын Дээд Хурлын дарга, Сайн ноён хан, Ерөнхий сайд Намнансүрэнгийн хөргийг Төрийн ордонд залах ёслол болов. Ёслолын ажиллагааг нээж Улсын Их Хурлын дарга З.Энхболд үг хэллээ.

Үндэсний эрх чөлөөний хувьсгалын 103 жилийн ойн өдрийг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Улсын Их Хурлын дарга З.Энхболд, Ерөнхий сайд Ч.Сайханбилэг нар Төрийн ордны хойно байрлах Монгол төрийн тамганы хөшөөнд цэцэг өргөв.

2014.12.29

Улсын Их Хурлын дарга З.Энхболд тусгаар тогтнолын товчоон хэмээн онцолсон “Талд ассан түймэр” цахим номын нээлтэд оролцож үг хэлэв.

2015.01.06

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар Хүний эрхийн дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Ё.Отгонбаярыг сонгов.

Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Ж.Батсуурь Барилга хот байгуулалтын яам, Зам тээврийн яам болон Уул уурхайн яамны удирдлагуудтай уулзаж, салбарын ажил байдалтай танилцлаа.

\* \* \*

## 2015

2015.01.10

Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Су.Батболд Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагаатай танилцаж, цаашид тус салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох асуудлаар яамны удирдлагуудтай санал солилцов.

2015.01.13

Монгол Улсад Ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсаны 23 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын дарга З.Энхболдын мэндчилгээ дэвшүүлж Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл илэрхийлэв.

2015.01.13

Монгол Улсын Үндсэн хуулийн 23 жилийн ойн өдрийг тохиолдуулан төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, Үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч Б.Чимидийн нэрэмжит Монгол Улсын Их Хурлын шагналын анхны эзнээр Монгол Улсын гавьяат хуульч, Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан тодорлоо.

Монгол Улсын Үндсэн хуулийн 23 жилийн ойн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд Үндсэн хууль тогтоогчдын холбооны анхдугаар чуулган Төрийн ордны Их танхимд болов.

2015.01.15

Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүд “Согтуу жолооч-Хүүхдийн амь нас” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав.

2015.01.16

Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэг, З.Баянсэлэнгэ, Д.Сарангэрэл нар Монгол Улс гурван сая дахь иргэнээ хүлээн авах гэж буйтай холбогдуулан нийслэлийн II, III дугаар төрөх эмнэлгийн үйл ажиллагаатай танилцлаа.

Улсын Их Хурлын 2014 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурал дахь МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслийн бүлгийн саналын дагуу Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны даргаар О.Баасанхүүг сонгож батлав.

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороо Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарын санаачилгаар “Үлийн цагаан оготны тархалт, үр дагавар, шийдвэрлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлэг боллоо.

2015.01.20

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлав.

2015.01.21

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо



Хөдөлмөрийн яам хамтран Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр хэлэлцүүлэг зохион байгуулав.

Улсын Их Хурлын даргын 2015 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 08 тоот захирамжаар байгуулагдсан Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн анхны хуралдаан болов. Хуралдааныг Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Батбаяр даргаллаа.

#### 2015.01.23

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Онцгой албан татварын тухай болон Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийж батлав.

Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2015 төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд батлагдав.

#### 2015.01.27

Монгол Улсын эдийн засгийн бодлого боловсруулалтыг сайжруулах зорилгоор НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Мянганы хөгжлийн институтийн шинжээчдийн багтай хамтран боловсруулсан “Макро эдийн засгийн T21 загвар”-ыг танилцуулах семинар боллоо.

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос “Эрүүл элэг - эрүүл чийрэг монгол хүн” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулав. Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороо 2014 онд хийсэн ажлаа тайлагнаж, 2015 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталлаа.

#### 2015.01.29

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулийн төслүүд, “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ыг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Эрүүл мэндийн албан журмын даатгалын тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулийн төслүүд, Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /утаат тамхи татах цэгийг тодорхойлж, байгуулах тухай/ хуулиудын төслийг хэлэлцэж батлав.

Монгол Улсаас гадаадын зарим улсад суугаа Элчин сайдыг эгүүлэн татсантай холбогдуулан Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Лодойдамбын Галбадрах, Бүгд Найрамдах Сингапур Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Төмөрийн Лхагвадорж, Бүгд Найрамдах Куба Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цэдэндамбын Батбаяр, Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гончигийн Ганболд Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Чулууны Баярмөнх, Австрали Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Батлайн Чулуунхүү, Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Нэмэхийн Батаа, Тайландын Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Төмөрхүлгийн Төгсбилгүүн, мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын

дэргэд суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Сүхээгийн Сүхболд нарыг тус тус томилох Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг зөвшилцөж дэмжлээ.

2015.01.30

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улс НҮБ-ын гишүүн-Бүгд Найрамдах Уганда Улс, Бүгд Найрамдах Руанда Улс, Холбооны Микронез Улс, Бүгд Найрамдах Гаити Улс, Бүгд Найрамдах Кирибати Улс, Экваторын Гвиней Улс, Бүгд Найрамдах Чад Улс, Бүгд Найрамдах Маврики Улстай тус тус дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоол батлав.

Монгол Улсын Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын “Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тухай” 88 дугаар конвенци, “Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын тухай” Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 181 дүгээр конвенци, “Антарктидийн тухай гэрээнд нэгдэн орох тухай” хуулийн төслүүдийг соёрхон баталлаа.

Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлгээр нь батлав.

2015.01.31

Улсын Их Хурлын дарга З.Энхболд нийслэлийн Налайх дүүрэгт байрладаг Монгол-Германы Ашигт малтмал, технологийн их сургуулийн үйл ажиллагаатай танилцаж, тус сургуулийн багш, оюутнуудтай уулзан сонирхсон асуултад нь хариулт өглөө.

2015.02.02

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хамтран зохион байгуулсан Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарын уулзалтад Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Улсын Их Хурлын дарга З.Энхболд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт нар оролцлоо.

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооноос хууль тогтоох үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, иргэдээс хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих асуудлаар Улсын Их Хуралд өргөдөл гаргах боломж бүрдүүлэх, энэ үйл явцыг хөнгөвчлөх ажлын хүрээнд иргэдийн өргөдлийг хүлээн авах саналын хайрцаг, түүнийг ажиллуулах журмыг тус байнгын хорооны дарга О.Баасанхүү аймгуудын Засаг дарга нарт хүлээлгэж өгөв.

2015.02.03

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамтай хамтран Тэтгэврийн даатгалын шинэчлэлийн асуудлаар уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулав.

2015.02.05

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай





хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 01 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй хэмээн үзэж тогтоол батлав.

2015.02.11

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Үндэсний статистикийн хорооны даргаар С.Мэндсайханыг улируулан томилов.

Авлигатай тэмцэх газрын дэд даргыг томилох тухай асуудал хэлэлцэж, Цээсүрэнгийн Нямдоржийг Авлигатай тэмцэх газрын дэд даргаар томилохыг дэмжив.

2015.02.12

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Чөлөөт бүсийн тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хууль, тогтоолын төслүүд, Монгол хэлний тухай хуулийн төслийг хэлэлцэж баталлаа.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус баталлаа.

Монгол Улсын ерөнхий прокуророор Магванноровын Энх-Амгаланг томилох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг зөвшилцөж дэмжив.

2015.02.15-16

ОХУ -ын Холбооны Хурлын Төрийн Думын дарга Е.С.Нарышкин тэргүүтэй төлөөлөгчид УИХ -ын даргын урилгаар Монгол Улсад албан ёсоор айлчлав.

2015.02.17

Улсын Их Хурлын дарга З.Энхболд манай улсад албан ёсны айлчлал хийж байгаа Оросын Холбооны Улсын Холбооны Хурлын Төрийн Думын дарга Сергей Евгеньевич Нарышкин нар уулзалт хэлэлцээ хийлээ.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг хэлэлцэж батлав. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдав.

2015.02.18

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны хуралдаанаар “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг буцааж эзэмших хүсэлт гаргасан 3375 иргэний өргөдлийн талаар хэлэлцэж, Засгийн газарт чиглэл өгөх тухай Байнгын хорооны тогтоол батлав.

Улсын Их Хурлын чуулганы эгдсэн хуралдаанаар “Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай тогтоолд өөрчлөлт оруулах тухай”, “Эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоол батлав.

Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын

тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай болон холбогдох бусад хуулийн төслүүд, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж баталлаа.

Сонгуулийн ерөнхий хорооны даргаар Чойнзонгийн Содномцэрэнг улираан томилох, Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн даргаар Цэдэн-Ишийн Болдсайханыг томилох асуудлыг дэмжиж, Улсын Их Хурлын тогтоол батлав.

2015.02.23-27

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Япон Улсын парламентын Төлөөлөгчдийн танхимын дарга Н.Мачимурагийн урилгаар тус улсад албан ёсны айлчлал хийлээ.

2015.02.24

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо 2014 оны намрын ээлжит чуулганы хугацаанд зохион байгуулсан ажлаа тайлагнав.

2015.02.25

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, ажлын хэсгийн ахлагч Б.Болор, Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэг болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ажилтнууд “Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудал барих төсөл”-ийн үйл ажиллагаатай танилцав.

2015.02.27

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо Улсын Их Хурлын 2014 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийсэн ажлаа тайлагнав.

2015.03.03

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо Улсын Их Хурлын 2014 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийсэн ажлаа тайлагнав.

2015.03.04

Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн, Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга Ц.Болдсайхан, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн Р.Содхүү нар Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу тангараг өргөлөө.

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл шинжлэх ухааны байнгын хороо Монголын Улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулав. Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо хороо 2014 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийсэн ажлаа тайлагнав.

2015.03.05-07

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Дундговь, Өмнөговь аймагт ажиллаж, Улсын Их Хурлын 2014 оны намрын ээлжит чуулганы үйл ажиллагааны талаар иргэд сонгогчдод мэдээлж, орон нутгийн ажил амьдрал, бүтээн байгуулалтын ажилтай танилцав.



2015.03.06

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2014 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийсэн ажлаа тайлагнав.

2015.03.10

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хороо 2014 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлаа тайлагнав.

2015.03.11

“Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журмын тухай” хуулийн төслийн хэлэлцүүлэг болов.

2015.03.12

Монгол Улсын хууль тогтоомжийн хэрэгжилтийн өнөөгийн байдал хэлэлцүүлгийг нээж УИХ-ын дарга З.Энхболд үг хэлэв.

2015.03.14-21

Улсын Их Хурлын дарга З.Энхболд ХБНГУ-ын Бундестагийн Ерөнхийлөгч Н.Ламмертын урилгаар 2015 оны 3 дугаар сарын 14-18-ны өдрүүдэд ХБНГУ-д, БНПУ-ын Сенатын Маршал Богдан Борусевичийн урилгаар 3 дугаар сарын 18-21-ний өдрүүдэд БНПУ-д тус тус албан ёсны айлчлал хийв.

2015.03.17

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооноос 2014 оны намрын чуулганы хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлаа тайлагнаж хэвлэлийн бага хурал хийлгэв.

2015.03.25

Улсын Их Хурлын дарга З.Энхболд захирамж гаргаж, Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдааныг долоо хоногийн Пүрэв, Баасан гарагт өглөө 09 цагаас эхэлж, үдээс хойш 14 цагаас үргэлжлүүлж байхаар тогтоов.

2015.04.01

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос “Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого-2015-2040” тогтоолын төслийн хэлэлцүүлэг зохион байгуулав.

2015.04.03

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо Баянхонгор аймагт “Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, ослыг бууруулах, урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, бүс нутгийн хамтын ажиллагаа” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав.

2015.04.06

Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганы нээлт болж, Улсын Их Хурлын дарга З.Энхболд чуулганы ажиллагааг нээж үг хэлэв.

2015.04.15

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хорооны 2014 оны тайланг сонслоо.

2015.04.16

Улсын Их Хурлын дарга З.Энхболдын ивээл дор зохион байгуулагддаг “Эврика” эрдэм шинжилгээний их хурал Төрийн ордны Их танхимд болов. Улсын Их Хурлын гишүүн Д.Дэмбэрэл, З.Баянсэлэнгэ, Ж.Батзандан, Н.Энхболд, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар нар Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад болсон Олон Улсын Парламентын Холбооны 132 дугаар ээлжит Ассамблейд оролцов.

2015.04.20

Улсын Их Хурлын дарга З.Энхболд “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Оюутолгой” ХХК-ийн хамтран ажиллах санаж бичигт гарын үсэг зурах ёслолын ажиллагаанд оролцов.

2015.04.21

Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Ганбат, Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл, Ц.Оюунбаатар, Ц.Оюунгэрэл нар болон Хүний эрхийн үндэсний комиссын зарим гишүүд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа цагдан хорих 461 дүгээр ангийн үйл ажиллагаатай танилцав.

2015.04.22

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журмын тухай” хуулийн төслийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулав.

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороо Хүнс, хөдөө, аж ахуйн яам хамтран “Бэлчээрийн талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь” сэдэвт хэлэлцүүлэг зохиов.

2015.04.28

Улсын Их Хурлын эмэгтэй гишүүд Монголын эмэгтэйчүүдийн сантай хамтран 21 аймаг, 9 дүүргийн эмэгтэйчүүдийн төлөөлөлтэй Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төслийн талаар цахим хэлэлцүүлэг зохион байгуулав.

2015.04.29

Улсын Их Хурлын дарга захирамж гаргаж, Таван толгойн ордыг хөгжүүлэхтэй холбоотой хөрөнгө оруулалтын гэрээ болон хавсралт гэрээнүүдийг Улсын Их Хурлаар хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсэг байгууллаа.

2015.04.30

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо МУИС-ийн Хууль зүйн сургуультай хамтран “Үндсэн хууль тайлбарлах онол, арга зүй” эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулав.



2015.05.03

“Үндсэн хууль ба зөвлөлдөх ардчилал” сэдэвт онол, практикийн бага хурлыг нээж УИХ-ын дарга З.Энхболд үг хэлэв.

2015.05.05

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Монголын амьтан, ургамлын мэргэжлийн байгууллагуудын нэгдсэн холбоо ТББ хамтран “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн хэрэгжилт” сэдэвт уулзалт-хэлэлцүүлэг зохион байгуулав.

2015.05.05

УИХ-ын дарга З.Энхболд “Онлайн эрх чөлөө” эвслийн Сайд нарын 5 дугаар бага хуралд оролцож үг хэлэв.

Монгол Улс “Онлайн эрх чөлөө” олон улсын эвслийг тэргүүлж байгаа бөгөөд 5 дугаар бага хурлыг Улаанбаатар хотноо зохион байгуулсан. Төрийн ордонд хоёр өдөр үргэлжилсэн уг хуралд 60 гаруй орны төлөөлөл, түүнчлэн ЮНЕСКО, ЮНИСЕФ болон Азийн сан, Эмнести интернэйшл, “Human Rights Watch”, “Дижитал Партнерс глобал” зэрэг иргэний нийгмийн болон судалгааны байгууллага, “Google”, “Mozilla”, “Twitter” зэрэг мэдээлэл холбооны салбарын тэргүүлэгч компаниудын төлөөлөл оролцсон юм.

2015.05.07

Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 05 дугаар дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоол батлав.

2015.05.09

Улсын Их Хурлын гишүүд бүх нийтээр мод тарих үндэсний өдрөөр Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жил, Ялалтын 70 жилийн ойд зориулан Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд мод тарьж «Парламентын төгөл» байгуулав.

2015.05.13

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой санал солилцох хэлэлцүүлэг зохион байгуулав.

2015.05.14

Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар Төрөөс ойн талаар баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоол батлав.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн захиргааны тухай болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулиудад өөрчлөлт оруулах тухай хуулиуд батлагдав.

2015.05.17

Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Ерөнхий сайд Нарендра Модри -ийн айлчлалд зориулсан Монгол Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаан болов. Хүндэтгэлийн хуралдаанд Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Ерөнхий сайд Нарендра Модри үг хэлэв.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос эрхлэн төвийн бүсийн аймгуудын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажилтнуудын ээлжит чуулга уулзалтыг Дархан-Уул аймагт зохион байгуулав.

2015.05.19

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороо “Боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдал, сайжруулах арга зам” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгууллаа.

2015.05.20

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо Авлигатай тэмцэх газар, “Сонгогчдын боловсрол” төвтэй хамтран “Сонгуулийн санхүүжилт-шинэчлэлийн асуудал” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудыг батлав.

2015.05.22

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Хууль зүйн яам, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангаас хамтран “Эрх зүйт төр-Эрхэм зорилго” сэдэвт олон улсын онол-практикийн бага хурал зохион байгуулав.

2015.05.27

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын хэсэг Төв аймгийн нутаг дэвсгэрт байрлах Зэвсэгт хүчний 016, 311 дүгээр ангиудад ажиллаж, “Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын үндэс” баримт бичиг, “Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилт, Зэвсэгт хүчний зарим ангиудын зэвсэглэл, техникийн хадгалалт, хамгаалалтын байдалтай танилцлаа.

2015.05.28

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороо Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хууль эрх зүйн зохицуулалт, ажлын явц, тулгамдаж буй хүндрэл, бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэх талаар хэлэлцүүлэг зохион байгуулав.

2015.05.30

Улсын Их Хурлын дарга З.Энхболд нийслэлийн Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт хэрэгжиж байгаа “Шинэ яармаг” орон сууцны цогцолбор хороолол төслийн явцтай танилцлаа.

2015.06.05

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Засгийн газар, Японы



Олон улсын хамтын ажиллагааны байгууллага хооронд байгуулсан “Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх онгоцны буудал барих төсөл”-ийн нэмэлт зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хууль батлагдав.

2015.06.07-08

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Сэлэнгэ, Дархан-Уул аймагт томилолтоор ажиллаж, «Нутгийн өөрөө удирдах байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх төсөл» -ийн хэрэгжилт, орон нутгийн ажил байдал, үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай танилцлаа.

2015.06.09

Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэг, Н.Энхболд нар Монгол хэлний тухай хууль 2015 оны 07 дугаар сарын 01-нээс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн үйл ажиллагаатай танилцав.

2015.06.10

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо Ерөнхийлөгчийн Тамгын газар хамтран Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төслийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулав.

2015.06.11

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэж батлав.

2015.06.13

УИХ-ын дарга З.Энхболд Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагаатай танилцав.

2016.06.18

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдав.

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо “2015 оноос хойших хөгжлийн хөтөлбөрт ногоон зорилтыг тусгах нь: Монгол Улсад хэрэгжүүлэх боломж, сорилт” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав.

2015.06.19

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Шүүх байгуулах тухай /шинэчилсэн найруулга/ Монгол Улсын Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүх байгуулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд, Шүүгчийн орон тоо батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүд, Аудитын тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулийн төслүүд, Захиргааны ерөнхий хууль болон холбогдох бусад хуулийн төслүүдийг хэлэлцэж батлав.

Нийслэл хотын албан татварын тухай хуулийн төсөл, “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай”, “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд, Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуулийн төслүүд батлагдав.

“Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

2015.06.22-23

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Говь-Алтай, Завхан аймгуудад ажиллаж, «Нутгийн өөрөө удирдах байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх төсөл» -ийн хэрэгжилт, орон нутгийн ажил байдал, бүтээн байгуулалттай танилцав.

2015.06.25

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Төлбөрийн системийн шинэчлэл төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг баталлаа.

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо “Элэгний хорт хавдартай тэмцэх талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, цаашдын зорилт” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав.

2015.06.26

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Хотыг дахин хөгжүүлэх тухай болон холбогдох бусад хуулиуд, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль баталлаа. Улсын Их Хурлын дарга З.Энхболд Монгол Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганы хугацааг 2015 оны 07 дугаар сарын 10-ны өдрийг дуустал сунгах захирамж гаргав.

2015.06.27

Монгол Улсын Их Хурлын дарга З.Энхболд “Эм Си Лог хаус” ХХК-ийн Мод боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцсаны дараа “Долоон болдог” группын тавилгын үйлдвэр, Ган хийцийн үйлдвэртэй танилцлаа.

2015.07.02

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар “Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн батлах тухай”, Монгол Улсын Их Хурлын 2015 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай, Монгол Улсын 2014 оны төсвийн гүйцэтгэл батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолууд батлагдав.

Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай болон холбогдох бусад хуулийн төслүүд, Галын аюулгүй байдлын тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулийн төслүүд, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай болон холбогдох бусад хуулийн төслүүд, Хүүхэд харах үйлчилгээний тухай болон холбогдох бусад хуулийн төслүүдийг батлав.





ОХУ-ын Урчуудын холбооны гишүүн, ОХУ-ын иргэн Даш Намдаковын “Чингис хаан” уран бүтээлийг Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслүүд батлагдав.

2015.07.03

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоол, “Уурхай дахь аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 176 дугаар конвенцид нэгдэн орох тухай хууль батлав.

2015.07.05

Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэг, Л.Болд, Д.Тэрбишдагва нар Финландын нийслэл Хельсинки хотноо болсон Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага /ЕАБХАБ/ -ын Парламентын Ассамблейн ээлжит 24 дүгээр жилийн хуралдаанд оролцов.

2015.07.06

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороо Улсын Их Хурлын 2015 оны хаврын чуулганы хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлаа тайлагнав.

2015.07.07

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Монгол Улсад суугаа гадаад орнуудын Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүнүүдийг хүлээн авч уулзав.

2015.07.08

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 03 дугаар дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоол батлав.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай тухай болон холбогдох бусад хуулийн төслүүд, Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг баталлаа.

2015.07.09

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Үйлдвэрлэлийг дэмжих тухай болон холбогдох бусад хуулийн төслүүд, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон холбогдох бусад хуулийн төслүүд, Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуулийн төслүүд, Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг дагаж өргөн мэдүүлэгдсэн “Халх гол” чөлөөт бүс байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлав.

“Боловсролын чанарын шинэчлэл төслийн санхүүжилтийн хэлэлцээр”, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Цахим эрүүл мэнд төслийн санхүүжилтийн хэлэлцээр”, “Ухаалаг засаг төслийн санхүүжилтийн хэлэлцээр”, Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Мянганы сорилтын корпорацын хооронд байгуулсан “Мянганы сорилтын компакт гэрээг боловсруулахад дэмжлэг үзүүлэх буцалтгүй тусламжийн тухай хэлэлцээр”, Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг

дээшлүүлэх төслийн зээлийн хэлэлцээр”, Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төсөл”-ийн хэлэлцээрүүдийг соёрхон батлах тухай хуулиуд батлагдав.

“Хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, гамшгийн үр дагаврыг арилгах болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах ажиллагааны чиглэлээр сургалт хэрэгжүүлэхэд хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төсөл болон Хараагүй, харааны бэрхшээлтэй болон хэвлэмэл бүтээл унших хязгаарлагдмал чадвартай хүмүүст зориулан хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хүртээмжтэй болгохыг хөнгөвчлөх тухай Марракешийн гэрээг соёрхон баталлаа.

2015.07.10

Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулган өндөрлөлөө. Ээлжит чуулганыг хааж Улсын Их Хурлын дарга З.Энхболд үг хэлэв.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийсэн ажлаа тайлагнав.

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийсэн ажлаа тайлагнав. Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийсэн ажлаа тайлагнав. Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2015 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийсэн ажлаа тайлагнав.

2015.07.17

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо 2015 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийсэн ажлаа тайлагнав.

2015.07.28

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын ээлжит бус чуулган товлон зарлах тухай 156 тоот захирамж гаргалаа.

2015.07.29

Улсын Их Хурлын дарга З.Энхболдын урилгаар Бүгд Найрамдах Чех Улсын Парламентын Төлөөлөгчдийн Танхимын дарга Ян Хамачек тэргүүтэй төлөөлөгчид 2015 оны 07 дугаар сарын 29-нөөс 08 дугаар сарын 02 -ны өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийв.

2015.08.03

Улсын Их Хурлын 2015 оны ээлжит бус чуулган нээлтээ хийлээ. Ээлжит бус чуулганыг нээж Улсын Их Хурлын дарга З.Энхболд үг хэлэв.

2015.08.06

Улсын Их Хурлын 2015 оны ээлжит бус чуулганы нэгдсэн хуралдаанаар “Монгол Улсын Засгийн газрын зарим гишүүдийг огцруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж, Ухнаагийн Хүрэлсүхийг Монгол Улсын Засгийн газрын



гишүүн-Монгол Улсын Шадар сайдын; Дуламсүрэнгийн Оюунхоролыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын; Жаргалтулгын Эрдэнэбатыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Сангийн сайдын; Дамдины Цогтбаатарыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Барилга, хот байгуулалтын сайдын; Намхайн Төмөрхүүг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн сайдын; Содномын Чинзоригийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хөдөлмөрийн сайдын үүрэгт ажлаас огцруулав.

2015.08.07

Улсын Их Хурлын 2015 оны ээлжит бус чуулганы нэгдсэн хуралдаанаар Галт зэвсгийн тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулийн төслүүд, Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн төслийг хэлэлцэж батлав.

2015.08.11

Улсын Их Хурлын 2015 оны ээлжит бус чуулганы нэгдсэн хуралдаанаар Засгийн газраас өргөн мэдүүлсэн Өршөөлийн тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хаалттай дэгээр хэлэлцэж баталлаа.

2015.08.12

Улсын Их Хурлын дарга З.Энхболд ОХУ-ын “Россия-24” телевизэд ярилцлага өгөв. ОХУ-ын “Россия-24” телевизийн сэтгүүлч Монгол Улсын Их Хурлын дарга З.Энхболдоос хоёр орны хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт болон бусад асуудлаар асуулт асууж, ярилцсан. Монгол Улсын Их Хурлын дарга З.Энхболд олон зуун жилийн түүхтэй хоёр орны хамтын ажиллагааны өнөөдөр хүрсэн түвшинд сэтгэл хангалуун явдгаа илэрхийлж, сэтгүүлчийн асуусан асуултад хариулт өгсөв.

2015.08.14

Улсын Их Хурлын ээлжит бус чуулганы нэгдсэн хуралдаанаар Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан Өршөөл үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах Комисс байгуулах тухай тогтоол батлав. Улсын Их Хурлын 2015 оны ээлжит бус чуулган өндөрлөлөө.

2015.08.28

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойд зориулан 2015 оны 9 дүгээр сарын 13-ны Ням гарагийн 11 цаг 40 минутаас Улсын Их Хурлын Хүндэтгэлийн хуралдаан зарлан хуралдуулах тухай 173 тоот захирамж гаргав.

2015.08.31

Улсын Их Хурлын дарга З.Энхболд АНУ-ын Нью-Йорк хотноо болсон парламентын спикерүүдийн дэлхийн IV бага хуралд оролцов.

2015.09.07

Улсын Их Хурлын 2015 оны ээлжит бус чуулган нээлтээ хийлээ. Ээлжит бус чуулганы хуралдааны нээлтэд Улсын Их Хурлын 42 гишүүн хүрэлцэн ирж, 55,3 хувийн ирцтэйгээр эхлэв.

2015.09.08

Улсын Их Хурлын ээлжит бус чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунбаатарыг Монгол Улсын Шадар сайдаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Батцэрэгийг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Болорыг Сангийн сайдаар, Улсын Их Хурлын гишүүн З.Баянсэлэнгийг Барилга, хот байгуулалтын сайдаар, Улсын Их Хурлын гишүүн М.Зоригтыг Зам, тээврийн сайдаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Баярсайханыг Хөдөлмөрийн сайдаар тус тус томилов.

2015.09.11

Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойд зориулсан “Байнгын ажиллагаатай парламент-25 жил” сэдэвт эрдэм шинжилгээний хурал Төрийн ордонд болов.

2015.09.11-12

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Өвөрхангай, Архангай аймагт ажиллаж, орон нутгийн ажил амьдрал, бүтээн байгуулалтын ажилтай танилцав.

2015.09.13

Монгол Улсад Байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын Хүндэтгэлийн хуралдаан болов. Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Их Хурлын дарга Зандаахүүгийн Энхболд Улсын Бага Хурлын нийт 62 гишүүнд “Улсын Бага Хурлын гишүүн” тэмдэг, үнэмлэхийг гардуулан өглөө.

2015.09.16

Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллагын Парламентын Ассамблейн 2015 оны намрын хурал Улаанбаатар хотноо ажлаа эхлэв. ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн 2015 оны намрын хурлыг нээж Монгол Улсын Их Хурлын дарга З.Энхболдын үг хэллээ.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн 2015 оны намрын хуралдаанд оролцохоор хүрэлцэн ирсэн Оросын Холбооны Улсын Холбооны Хурлын Төрийн Думын дарга С.Е.Нарышкиныг хүлээн авч уулзав.

ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн 2015 оны намрын хурлын салбар хуралдаанууд болов.

2015.09.17

ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн Байнгын хорооны хуралдаан болж өндөрлөв. Тус байгууллагын Парламентын Ассамблейн Ерөнхийлөгч Илкка Канерва мэдээлэл хийв. ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн III салбар хуралдаан болов. Улсын Их Хурлын дарга З.Энхболд ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн 2015 оны намрын хурлын талаар мэдээлэл хийв.

2015.09.18


Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Парламентын Ассамблейн 2015 оны намрын хуралдаан өндөрлөв. Улсын Их Хурлын 2015 оны ээлжит



бус чуулган хаалтаа хийв. Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын 2015 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай 189 дүгээр захирамж гаргав.

2015.09.20-23

Улсын Их Хурлын дарга З.Энхболд ОХУ-ын Холбооны Хурлын Холбооны Зөвлөлийн даргын урилгаар ОХУ-д албан ёсны айлчлал хийв.



Монгол Улсын Их Хурлын дарга З. Энхболд ОХУ -ын Төрийн Думын дарга С.Е. Нарышкины хамт

2015.9.20-23

Монгол Улсын Их Хурлын дарга Зандаахүүгийн Энхболд Оросын Холбооны Улсад 2015 оны 9-р сарын 20-23 -нд албан ёсны айлчлал хийв.

УИХ -ын дарга З.Энхболд айлчлалынхаа эхэнд Москвагийн Улаан талбай дахь Александровын цэцэрлэгт хүрээлэн дэх «Нэр нь үл мэдэгдэх цэргийн булш» -нд цэцэг өргөв. УИХ -ын дарга З.Энхболд ОХУ -ын Төрийн Думын дарга С.Е.Нарышкинтай уулзаж, ОХУ-ын Холбооны Хурлын Холбооны Зөвлөлийн дарга В.И.Матвиенкотой хэлэлцээ хийв.

2015.9.25

Монгол Улсын Их Хурлын дарга З.Энхболд ОХУ-ын Уралын Холбооны Их Сургуулийн эрдмийн зөвлөлийн шийдвэрээр тус сургуулийн Хүндэт доктор болов.

Монгол Улсын Их Хурлын дарга З. Энхболдод Уралын Холбооны Их Сургуулийн хүндэт

доктор цол олгох ёслолын арга хэмжээнд чөлөөлөх дайнд оролцож явсан ОХУ -ын ахмад дайчин Е.И.Верхотурцева, Т.М.Воробьева, В.И.Горбунов, Н.М.Лаптев, С.С.Козьмин нар болон тус сургуулийн багш, оюутнууд оролцлоо. Ёслолын үеэр УИХ-ын дарга З.Энхболд ахмад дайчдад чөлөөлөх дайны ойн медаль, дурсгалын зүйлс гардуулав.

УИХ-ын дарга З.Энхболд Уралын Холбооны Их Сургуулийн Хүндэт доктор болсны дараа тус сургуулийн эрдэмтэн багш нар, оюутнуудад “Монголын ардчиллын үнэт зүйл ба хөгжил дэвшил” сэдвээр лекц уншив.

2015.09.24

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороо “Хууль тогтоох үйл ажиллагаанд иргэдийн оролцоог дэмжиж ажиллахад баг, хороодын үүрэг” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгууллаа.2015.09.28

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын 2015 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдааны цагийг тогтоох тухай 197 дугаар захирамж гаргав.

2015.09.29

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Хэнтий аймагт ажиллаж, орон нутгийн ажил амьдрал, бүтээн байгуулалтын ажилтай танилцав.

2015.10.01

Улсын Их Хурлын 2015 оны намрын ээлжит чуулган нээгдэв. Ээлжит чуулганыг нээж Улсын Их Хурлын дарга З.Энхболд үг хэлэв.

2015.10.06

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Монгол Улсын 2015 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг нэн яаралтай дэгээр хэлэлцүүлэх тухай захирамж гаргав.

2015.10.08

Улсын Их Хурлын 2015 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын үндсийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хаалттай горимоор хэлэлцэж баталлаа.

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Ч.Улааныг сонгож батлав.

Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк үүсгэн байгуулах хэлэлцээр, Ялтан шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газар хоорондын гэрээг соёрхон батлав.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Газар хөдлөлтийн гамшгийн асуудлаар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийлээ.



2015.10.09

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхимын тодорхой хэсэгт Улсын Их Хурлын гишүүн-Засгийн газрын гишүүдэд зориулсан тусгайлсан суудал /блок/ гаргахаар Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэв.

2015.10.10

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Б.Бат-Эрдэнэ, Х.Болорчулуун, С.Ганбаатар, Г.Уянга, Л.Цог нараас Оюутолгой төслийн хэрэгжилтийн өнөөгийн явц, татвар төлөлтийн байдал болон “Эвлэрлийн гэрээ”-ний талаар Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэгт тавьсан асуулгын хариуг сонсов.

2015.10.13

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, С.Одонтуяа, Д.Сарангэрэл, А.Тлейхан, Д.Тэрбишдагва нар Хавдар судлалын үндэсний төвд ажиллав.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатыг тус байнгын хорооны даргаар улираан сонгохыг дэмжлээ.

2015.10.14

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо Эрчим хүчний яам хамтран Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн төслийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулав.

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороо 2015 оны намрын чуулганы хугацаанд байнгын хорооноос хийх ажлын төлөвлөгөөг батлав.

2015.10.15

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатыг Хууль зүйн байнгын хорооны даргаар сонгож батлав.

2015.10.16

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Хүнс хөдөө аж ахуйн яамтай хамтран Дорнод аймгийн газар ашиглалтын байдал, хөдөө аж ахуйн “Халх гол” чөлөөт бүсийн талаар уулзалт, ярилцлага зохион байгууллаа.

2015.10.19

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Хүнс, хөдөө аж ахуйн яамтай хамтран “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулав.

2015.10.21

Улсын Их Хурлын дэд дарга Л.Цог, Улсын Их Хурлын гишүүн Л.Болд, Ч.Хүрэлбаатар нар Олон Улсын Парламентын Холбооны 133 дугаар Ассамблейн нэгдсэн хуралдаанд оролцов.

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хороо, “Монголын усны түншлэл” төрийн бус байгууллагатай хамтран “Усны засаглал, институцийг бэхжүүлэх замаар төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломж” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав.

2015.10.22

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол-Оросын “Эрдэнэт үйлдвэр” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газрын хоорондын 2003 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын протокол, Монгол-Оросын “Монголросцветмет” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2007 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын протоколыг соёрхон батлав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн урилгаар Монгол Улсад ажлын айлчлал хийж буй Япон Улсын Ерөнхий сайд Шинзо Абэ Улсын Их Хурлын дарга З.Энхболдод бараалхаж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны үйл ажиллагаатай танилцав.

2015.10.23

Улсын Их Хурлын даргын Ажлын алба, НҮБ-ын Хүн амын сан, Эрүүл мэнд, спортын яам хамтран “Эх, хүүхдийн эсэн мэнд амаржихуйн яаралтай тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар” сэдэвт төвийн болон баруун бүсийн зөвлөгөөнийг Төрийн ордонд зохион байгуулав.

Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга А.Бакей, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Төслийн үндэсний захирал Б.Болдбаатар нар “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн дунд хугацааны үнэлгээний тайланг сонсов.

2015.10.26

Хууль тогтоомжийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Нийтийн сонсголын тухай хуулийн хэрэгжилтийн бэлтгэл ажлыг хангах талаарх зөвлөгөөн Төрийн ордонд болов.

2015.10.28

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганы үеэр Нью-Йорк хотноо болсон НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн гишүүдийг сонгох сонгуульд манай улс НҮБ-ын гишүүн 172 орны саналыг авч, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн гишүүнээр сонгогдсоныг Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын гишүүдэд дуулгав.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан Өршөөл үзүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав.

2015.10.30

Улсын Төрийн байгуулалтын байнгын хороо, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Төрийн албаны зөвлөл, “Иргэдийн оролцоотой





хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төсөл хамтран “Монгол Улсын Төрийн албаны эрх зүйн шинэтгэл” сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулав.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон дагалдан өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэж баталлаа.

2015.11.02

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Оросын Холбооны Улсын “Когалымавиа” компанийн зорчигч тээврийн онгоц осолдсонтой холбогдуулан Монгол Улс дахь тус улсын Элчин сайдын яаманд хүрэлцэн очиж эмгэнэл илэрхийлэв.

2015.11.05

Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан Өршөөл үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах Комиссын гишүүд Дархан-Уул аймагт ажиллав.

2015.11.06

Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан Өршөөл үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах Комиссын гишүүд Эмэгтэйчүүдийн 407 дугаар болон Зайсан дахь 401 дүгээр хорих ангиудад ажиллав.

Улсын Их Хурлын 2015 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар мэдээлэл хийлээ.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батбаяр нарын нэр бүхий гишүүд Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг Улсын Их Хурлын даргад өргөн барив.

2015.11.10

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулах “Нийгмийн халамжийг дэмжих хөтөлбөр”-ийн зээлийн хэлэлцээр, Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулах “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн нэмэлт санхүүжилт” -ийн зээлийн хэлэлцээрүүдийг соёрхон батлах тухай хуулийг батлав.

2015.11.11

Монголын программ хангамж үйлдвэрлэлийн салбарын III чуулганы нээлтэд УИХ-ын дарга З.Энхболд үг хэлэв.

“Шинжлэх ухаан ба үйлдвэрлэл” Монголын залуу эрдэмтэн, судлаачдын үндэсний V чуулганд УИХ-ын дарга З.Энхболд мэндчилгээ дэвшүүлэв.

2015.11.13

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2016 оны төсвийн тухай хуулиуд, дагалдан өөрчлөлт оруулахаар өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд болон 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017 - 2018 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд батлагдав.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоол, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017 - 2018 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2016 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2016 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2016 оны төсвийн тухай хуулиудыг батлав.

2015.11.16

Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, Монгол Улсын гавьяат хуульч Д.Лүндээжанцан “Монгол Улс дахь Үндсэн хуульт ёсны төлөвшил, Үндсэн хууль дахь парламентын эрх мэдэл” сэдвээр Төрийн ордны их танхимд хүндэтгэлийн лекц уншив.

2015.11.19

УИХ-ын дарга З.Энхболд “Авлигын эсрэг санаачилга”-ын 13 дахь удаагийн бүс нутгийн семинарын нээлтэд оролцож үг хэлэв.

2015.11.20

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Олон улсын цахилгаан холбооны байгууллагын Үндсэн дүрэм, конвенцид оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах, Ялтан шилжүүлэх тухай Европын зөвлөлийн конвенцид нэгдэн орох тухай хуулийг тус тус соёрхон батлав.

УИХ-ын дарга З.Энхболд МУИС-ийн Хууль зүйн сургуулийн 55 жилийн ойн арга хэмжээний нээлтэд оролцов.

2015.11.23-25

Улсын Их Хурлын дэд дарга М.Энхболдын урилгаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хорооны дэд дарга хатагтай Янь Зюньчи тэргүүтэй төлөөлөгчид манай улсад албан ёсны айллчлал хийж, Монгол-Хятадын парламент хоорондын байнгын уулзалтын механизмын хамтарсан хуралд оролцов.

Монгол Улсын Их Хурал, БНХАУ-ын Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал хоорондын байнгын уулзалтын механизмын анхдугаар уулзалт Төрийн ордонд болов.

2015.11.26

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын сонгуулийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Экспорт Импорт банк хооронд байгуулах 1.0 тэрбум ам. долларын зээлийн



ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулиуд, “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоол батлав.

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, Эрүүл мэнд, спортын яам хамтран “Сүрьеэгүй Монгол” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав.

2015.11.26

УИХ-ын дарга З.Энхболд Анхдугаар Үндсэн хуулиа баталж, Бүгд Найрамдах улс тунхагласны 91 жилийн ойг тохиолдуулан мэндчилгээ дэвшүүлэв.

2015.11.27

Улсын Их Хурлын дарга З.Энхболд, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Эрчим хүчний сайд Д.Зоригт, Улсын Их Хурлын гишүүн М.Сономпил, А.Тлейхан нар “Амгалан” дулааны станцын нээлтийн ажиллагаанд оролцов.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо “Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал /2016-2030 он/” сэдэвт нээлттэй сонсгол зохион байгуулав.

2015.12.03

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар “Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 14 дүгээр дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолд тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авлаа.

Хамтын тэтгэврийн тухай, Гаалийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, “Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоол батлав. Мөн Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн нийт 14 хууль, 2 тогтоолын төслийг хэлэлцэж батлав.

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл шинжлэх ухааны байнгын хороо “Хүнсний сав, баглаа боодлын аюулгүй байдал, тулгамдаж буй асуудал, хүний эрүүл мэндэд нөлөөлж буй нөлөөлөл, шийдвэрлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав.

2015.12.04

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо “Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал /2016-2030 он/” сэдэвт хоёр дахь удаагийн нээлттэй сонсголыг төрийн захиргааны байгууллагууд, манай улсад суугаа гадаад орнуудын Дипломат төлөөлөгчдийн газрууд болон олон улсын байгууллагуудын төлөөллийг оролцуулан Төрийн ордонд зохион байгуулав. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Зөрчлийн тухай болон холбогдох бусад хуулийн төслийг эцэслэн баталлаа.

2015.12.04

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Увс аймагт ажиллаж, орон нутгийн ажил амьдрал, бүтээн байгуулалтын ажилтай танилцав.

2015.12.08

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Европын Холбоо болон түүний гишүүн орнуудаас Монгол Улсад суугаа, хавсран суугаа Элчин сайдуудыг хүлээн авч уулзав.

2015.12.09

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо Эрүүл мэнд, спортын яамтай хамтран Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр “Эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулах нь” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгууллаа.

2015.12.10

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 15 дугаар дүгнэлтийг хэлэлцэж, уг дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй хэмээн үзэж тогтоол батлав.

2015.12.11

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо “Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал /2016-2030 он/” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав.

2015.12.14

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Монгол дахь Их Британийн Элчин сайдын яам, Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн хамтран “Улс төрийн санхүүжилт: Сонгуулийн санхүүжилтийн шинэчлэлийн асуудал” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав.

2015.12.16

Монгол Улсад албан ёсны айлчлал хийж байгаа Бүгд Найрамдах Солонгос Улсын Ерөнхий сайд Хван Гё Ан Улсын Их Хурлын дарга З.Энхболдод бараалхаж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхимтай танилцав.

2015.12.17

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсаас ОХУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шүхэрийн Алтангэрэлийг эгүүлэн татаж, Монгол Улсаас ОХУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Банзрагчийн Дэлгэрмааг томилон.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлав.

2015.12.18

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудыг батлав.

Гааль, татварын ерөнхий газрын эрх зүйн байдлын тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах



тухай, Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиуд батлагдав.

Улсын Их Хурал, НҮБ -ын Хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн хүрээнд орон нутгийн удирдах ажилтнуудад зориулсан сургалт, хэлэлцүүлэг Төрийн ордонд болов.

2015.12.22

Оюуны спорт болох шатрыг сурталчлах үйлсэд онцгой хувь нэмэр оруулсныг үнэлж Улсын Их Хурлын дарга З.Энхболдод Монголын шатрын холбооны хүндэт өргөмжлөл гардуулав.

2015.12.23

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооноос “Хот, суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” сэдэвт цуврал хэлэлцүүлэг зохион байгуулав.

2015.12.24

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэгийг, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Д.Батцогтыг, Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн А.Бакейг, Эдийн засгийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Баярсайханыг тус тус сонгож батлав.

Үндэсний статистикийн хорооны дарга С.Мэндсайхан, Монголбанкны тэргүүн дэд ерөнхийлөгч Б.Жавхлан нарыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоол батлав. Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн үйлчлэх хугацааг 2016 оны 2 дугаар сарын 20 хүртэл сунгалаа.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо “Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал /2016-2030 он/ сэдэвт цуврал, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулав.

2015.12.25

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр Б.Галаарид, Ж.Соёл-Эрдэнэ, С.Санасэр нарыг томилж, Д.Ганбат, Д.Сосорбарам, Б.Цэнддоо нарыг зөвлөлийн гишүүнээс чөлөөлөв.

Сонгуулийн тухай хууль, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиудыг баталлаа. Улсын Их Хурлын дарга З.Энхболд нийслэлийн Хан-Уул дүүргийн 10 дугаар хороонд байрлах “Буянт Ухаа 2” орон сууцны цогцолбор хорооллын нээлтэд оролцов.

\*\*\*

## 2016

2016.01.06

Улсын Их Хурлын дарга З.Энхболд “Нийгмийн давхаргыг тэлж, хуримтлалыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн урт хугацааны хөгжилд хүрэх нь” сэдвээр танилцуулга хийж, Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээр хүчингүй болсон Иргэний хууль болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн зарим зүйл, заалтыг сэргээхээр холбогдох хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүд боловсруулж байгааг дуулгав.

2016.01.07

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монголын Улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төслийг хэлэлцэж батлав.

2016.01.09

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын даргын ивээл дор жил бүр уламжлан зохиогддог Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн өдөрт зориулсан шатар сонирхогчдын улсын аварга шалгаруулах дөрөв дэх удаагийн тэмцээнийг нээж үг хэлэв. Дараа нь Улсын Их Хурлын дарга З.Энхболд, Нийслэлийн ргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Д.Баттулга нар 2016 оны шатар сонирхогчдын улсын аварга шалгаруулах тэмцээний эхний нүүдлийг хийж, тэмцээнийг албан ёсоор эхлүүллээ.

2016.01.10

Улсын Их Хурлын даргын ивээл дор жил бүр уламжлан зохиогддог шинэ Үндсэн хуулийн өдөрт зориулсан шатар сонирхогчдын улсын аварга шалгаруулах дөрөв дэх удаагийн шигшээ тэмцээн Төрийн ордонд хоёр өдөр үргэлжилж өндөрлөв.

Шигшээ тэмцээнд нийт 95 эрэгтэй шатарч өрсөлдсөнөөс нийслэлийн шатар сонирхогч Б.Цэцэнбаатар, 34 эмэгтэй шатарчдаас Хан-Уул дүүргийн оролцогч Ж.Даваасүрэн нар тэргүүн байрт шалгарав.

2016.01.11

Улсын Их Хурлын дарга З.Энхболд “Барилгын салбарын хөгжил ба ипотекийн зээлийн үүрэг” сэдвээр Барилгын политехникийн коллежийн багш, оюутнуудад танилцуулга хийв.

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамтай хамтран “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулав.

Хэлэлцүүлэгт Улсын Их Хурлын гишүүд, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, ШУА-ийн Газар зүй-геоэкологийн хүрээлэн, Түүх, археологийн хүрээлэн, Цагдаагийн ерөнхий газрын төлөөлөл оролцож санал солилцлоо.

2016.01.12

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны хуралдаанаар Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,



Дээд боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн А.Бакейгаар ахлуулан байгуулав.

Улсын Их Хурлын гишүүн, Өргөдлийн байнгын хорооны дарга О.Баасанхүү Улсын ерөнхий прокурорын газарт ажиллаж, иргэдээс тус Байнгын хороонд ирүүлсэн зарим өргөдөлтэй холбоотой санал, хүсэлтийг хүлээлгэн өгөв.

Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Е.Сагсай эдгээр санал, хүсэлтийг хүлээн авлаа.

2016.01.13

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Монгол Улсад ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсаны 24 жилийн ойн өдрийг тохиолдуулан ард түмэндээ мэндчилгээ дэвшүүлэв.

Монгол Улсын ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсаны 24 жилийн ойн өдрийг тохиолдуулан Улсын Бага Хурал, үе үеийн Улсын Их Хурлын гишүүдийн гэрэл зургийн цомгийг Төрийн ордонд хүндэтгэн залж байрлуулав.

Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, Үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Бяраагийн Чимидийн нэрэмжит шагнал гардуулах ёслол Төрийн ёслол хүндэтгэлийн их танхимд болов. Улсын Их Хурлын дарга З.Энхболд Б.Чимидийн нэрэмжит шагналыг Монгол Улсын гавьяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор И.Дашнямд гардуулж баяр хүргэлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 24 жилийн ойн өдрийг тохиолдуулан Улсын Их Хурлын дарга З.Энхболд, Улсын Их Хурлын дэд дарга Р.Гончигдорж, Улсын Их Хурлын гишүүд, Ардын Их Хурлын депутатууд, иргэдийн төлөөлөл Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл илэрхийлэв.

Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсаны 24 жилийн ойн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд Үндсэн хууль тогтоогчдын холбооны уулзалт ярилцлага болж, Улсын Их Хурлын дэд дарга, Ардын Их Хурлын депутат Л.Цог, Улсын Их Хурлын гишүүн, Ардын Их Хурлын депутат Н.Батбаяр болон Ардын Их Хурлын депутатууд оролцов.

Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү Өргөдлийн байнгын хорооны 2015 оны үйл ажиллагааны талаар хэвлэлийн бага хурал хийж, сэтгүүлчдэд мэдээлэл өгөв. Өнгөрсөн хугацаанд Өргөдлийн байнгын хороо 13 удаа хуралдан 31 асуудал хэлэлцэж, 5 удаа салбарын сайдын мэдээлэл сонсож, Байнгын хорооны хуралдаанаас 15 тогтоол гарган 7 хуралдааны тэмдэглэлээр хуулийн хэрэгжилтийг хангах, зөрчлийг арилгах асуудлаар Засгийн газарт чиглэл өгсөн байна.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд үе үеийн Улсын Их Хурлын дарга нарыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэв. Уулзалтад Улсын Бага Хурал, Улсын Их Хурлын дарга Р.Гончигдорж, Улсын Их Хурлын дарга Н.Багабанди, С.Төмөр-Очир, Ц.Нямдорж, Д.Лүндээжанцан, Д.Дэмбэрэл нар оролцов. Дараа нь Улсын Их Хурлын дарга нар дурсгалын зураг татуулав. Үе, үеийн Монгол Улсын Их Хурлын дарга нарт хүндэтгэл үзүүлэх тус арга хэмжээний үеэр Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар байлцав.



Зурагт, зүүн гар талаас:

С. Төмөр-Очир, Д. Дэмбэрэл, Н. Багабанди, З. Энхболд, Р. Гончигдорж, Д. Лүндээжанцан, Ц. Нямдорж

2016.01.14

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурал дахь Ардчилсан





намын бүлгээс нэр дэвшүүлсэн Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзанданг Өргөдлийн байнгын хорооны даргаар, Улсын Их Хурал дахь МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслээс нэр дэвшүүлсэн Улсын Их Хурлын гишүүн М.Сономпилийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар сонгож батлав.

2016.01.15

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг Монгол Улсын Засгийн газраас 2015 онд эрчим хүчний салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар мэдээлэл хийж, гишүүдийн асуултад хариулт өгөв.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд “Санхүүгийн зах зээлийн хөгжил” үндэсний форумд оролцогчдод илгээлт хүргүүлж, амжилт хүсэв.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Улсын Их Хурлын дарга З.Энхболд, Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг, Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэн нар Улаанбаатар дахь Дипломат корпусын төлөөлөгчдийн газрын тэргүүн нарт шинэ жилийн мэндчилгээ дэвшүүллээ.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд барилга угсралт, барилгын материал үйлдвэрлэлийн төлөөлөл болон тус салбартай холбоотой үйл ажиллагаа явуулдаг тавилгын үйлдвэрлэл, үл хөдлөх хөрөнгийн компаниудын төлөөлөлтэй уулзаж санал солилцов.

2016.01.18

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооноос баталсан Эрүүл мэндийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих удирдамжийн дагуу Улсын Их Хурлын гишүүн, Өргөдлийн байнгын хорооны дарга Ж.Батзандан, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл нар нийслэлийн Баянзүрх дүүргийн эмнэлгийн үйл ажиллагаатай танилцав.

2016.01.19

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Иргэний хуульд нэмэлт оруулах тухай болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг баталлаа. Хуулийн төслүүд батлагдсанаар зээлийн эргэн төлөлт хэвийн найдвартай хийгдэж, олгосон зээлүүд эрсдэлд орохгүй байх бодит нөхцөл бүрдэж байгаа юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэж баталлаа.

Улсын Их Хурлын гишүүн Г.Уянга, Х.Болорчулуун нарын 19 гишүүн Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэгийг огцруулах тухай саналыг өргөн мэдүүлэв.

Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг АНЭУ-д айлчлах үеэрээ Оюутолгойн орд газрыг ашиглах гэрээний нэг тал Туркойз Хилл Ресурс болон Рио Тинто компанитай “Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтын төлөвлөгөө”-нд гарын үсэг зурахдаа Улсын Их Хуралд мэдээлэлгүйгээр “далд уурхайн санхүүжилт” нэрээр Оюутолгойн ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ, ТЭЗҮ -ээр баталгаажсан далд уурхайн

санхжүүжилт 1.5 тэрбум долларын анхны хөрөнгө оруулалтын дүн дээр нэмж 4.7 тэрбум долларын зардлыг хүлээн зөвшөөрсөн нь түүнийг огцруулах үндэслэл гэж үзэж буйгаа нэр бүхий гишүүд дурдсан байна.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс хуралдаж, 2015 оны ажлын тайлан болон 2016 онд хийх ажлын төлөвлөгөөг хэлэлцэв.

Улсын Их Хурлын гишүүн, Өргөдлийн байнгын хорооны дарга Ж.Батзандан, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл нар нийслэлийн зарим дүүргийн өрхийн эмнэлгийн дарга нарыг хүлээн авч уулзаж, санал хүсэлтийг нь сонсов.

#### 2016.01.20

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар Засгийн газраас өргөн мэдүүлсэн “Санхүүгийн хамтын ажиллагааны Ерөнхий хөтөлбөрийн тухай” Монгол Улсын Засгийн газар, Унгар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, Хөгжлийн хамтын ажиллагааны тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг тус тус зөвшилцөв.

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны харьяаны Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэлийг сонгов.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны харьяаны Хүний эрхийн дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Л.Болдыг сонгов.

#### 2016.01.21

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Г.Уянга нарын нэр бүхий 19 гишүүний өргөн мэдүүлсэн Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах тухай саналыг хэлэлцэж эхлэх явцад Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлэг 5 хоногийн завсарлага авав.

Мөн Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг тус байнгын хорооны энэ өдрийн хуралдаанаар хэлэлцэх байсан Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуультай холбогдсон Улсын Их Хурлын тогтоолын төслүүдөөс 5 хоногийн завсарлага авлаа.

#### 2016.01.22

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай болон холбогдох бусад хуулийн төслүүдийг батлав.

Чуулганы үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ж.Энхбаяр нараас “Дэлхийн зах зээлийн өнөөгийн ханштай уялдуулан дотоодын шатахууны үнийг бууруулах талаар” Уул уурхайн сайдад тавьсан асуулгын хариуг сонсов.

#### 2016.01.23

Улсын Их Хурлын дарга З.Энхболд “Буянт-Ухаа 2” хороолол, “Талст трейд” ХХК-ийн металл хийцийн үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцав. Тэрээр энэ үеэр Сүхбаатар дүүргийн 16 дугаар хороо буюу Дарь-Эхэд 14 жил амьдарч байгаад “Буянт-Ухаа 2” хороололд шинэ байранд ороод байгаа О.Гэрэлсайханыд зочилсон юм.



2016.01.25

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын даргын ивээл дор НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр Эрүүл мэнд, спортын яам, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Хүүхдийн төлөө үндэсний газар, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн хамтран зохион байгуулж буй “Хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын үзүүлэх нөлөө, шийдвэрлэх арга зам” сэдэвт олон улсын зөвлөгөөнд оролцогчдод мэндчилгээ дэвшүүлэв.

Улсын Их Хурлын дарга З.Энхболдод манай улсад албан ёсны айлчлал хийж байгаа Унгар Улсын Ерөнхий сайд Виктор Орбан бараалхав.

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос байгуулагдсан “Тост, Тосон бумбын нурууг улсын тусгай хамгаалалтад авах эсэх талаарх асуудлыг судлах” ажлын хэсэг Өмнөговь аймгийн Гурван тэс суманд ажиллав.

2016.01.27

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Монголын баг, сумдын үндэсний холбооноос хамтран зохион байгуулж байгаа “Хамтын хүч-Нутгийн хөгжил” үндэсний чуулганд оролцож үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Санхүүгийн зохицуулах хороо үүсч байгуулагдсаны 10 жилийн ойн арга хэмжээнд оролцогчдод илгээлт хүргүүлж, мэндчилгээ дэвшүүлэв..

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны хуралдаанаар Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн, тус байнгын хорооны дарга Ч.Улаанаар ахлуулан байгуулав.

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороо иргэдийн өргөдлийн дагуу иргэд, холбогдох албан тушаалтнуудаас тайлбар авах уулзалт зохион байгуулав.

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Инфляцийн түвшин буурч байгаатай холбогдуулан тэтгэврийн, цалингийн, малчны болон жижиг, дунд үйлдвэрлэлийн зориулалттай зээлийн хүүг бууруулах асуудлын талаар Монголбанкны мэдээллийг сонслоо.

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны хуралдаанаас Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагаар, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлээр ахлуулан байгуулав.

2016.01.28

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг эгүүлэн татах талаарх Улсын дээд шүүхийн саналыг хэлэлцэх байсан ч Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлэг 5 хоногийн завсарлага авав.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Г.Уянга нарын 19 гишүүний өргөн мэдүүлсэн Монгол Улсын Ерөнхий

сайдыг огцруулах тухай саналыг хэлэлцээд дэмжих боломжгүй гэж үзэв.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах тухай Улсын Их Хурлын гишүүн Г.Уянга нарын 19 гишүүний саналыг хэлэлцээд Ерөнхий сайдыг огцруулах шаардлагагүй гэж үзсэн Төрийн байгуулалтын байнгын хорооны саналыг дэмжив.

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамтай хамтран Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших “Тост, Тосон Бумбын нурууг улсын тусгай хамгаалалтад авах талаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулав.

2016.01.29

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дамбын Ганхуяг, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Сүрэнгийн Цоггэрэл, Унгар Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Зэнээмьядарын Батбаяр, Бүгд Найрамдах Итали Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цэрэндоржийн Жамбалдорж нарыг тус тус томилох саналыг зөвшилцөж дэмжив.

Хүний хөгжил сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тариалангийн тухай болон холбогдох бусад хуулийн төслүүдийг хэлэлцэж баталлаа.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар З.Нарантуяаг хүсэлтийн нь дагуу Санхүүгийн зохицуулах хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлөв.

2016.02.01

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Хүний эрхийн үндэсний Комисс байгуулагдсаны 15 жилийн ойд зориулсан онол практикийн бага хуралд оролцогчдод илгээлт хүргүүлж, амжилт хүсэв.

2016.02.02

Улсын Их Хурлын дарга З.Энхболд 22 тоот захирамж гаргаж, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг, Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн хүсэлтийг үндэслэн Төрийн ордны Байнгын хорооны хуралдааны “А” танхимыг “Их Эзэн Чингис хаан танхим”, “Б” танхимыг “Жанжин Д.Сүхбаатар танхим” гэж тус тус нэрлэхээр шийдвэрлэв.

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар Парис хотод 2015 оны 11 дүгээр сард болсон НҮБ-ын уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенцийн талуудын 21 дүгээр бага хуралдааны талаар Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын мэдээллийг сонсов.

Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хорооны хуралдаанаар Монгол Улсын Засгийн газар болон Нийслэлээс агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр 2016 онд хийгдэж байгаа болон хийхээр төлөвлөгдөж буй ажлуудын талаар Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Н.Батцэрэгийн мэдээлэлтэй танилцав.

“Хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын үзүүлэх нөлөө, шийдвэрлэх арга зам” сэдэвт олон улсын зөвлөгөөний үр дүнгийн талаар Нийгмийн эрүүл мэндийн



хүрээлэнгийн захирал Б.Цогтбаатарын мэдээллийг сонсов.

Улсын Их Хурлын гишүүн, Өргөдлийн байнгын хорооны дарга Ж.Батзандан, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Сарангэрэл нар нийслэлийн Сүхбаатар, Баянзүрх, Хан-Уул дүүрэгт ажиллаж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг боловсронгуй болгох асуудлаар иргэдийн саналыг сонсон Улсын Их Хурал, түүний Өргөдлийн байнгын хороонд хандан гаргасан өргөдлийг саналын хайрцгаар дамжуулан хүлээн авахаар болсныг дуулгаж, саналын хайрцгийг холбогдох албаны хүмүүст хүлээлгэж өгөв.

2016.02.03

“Цахим засаглалаар дамжуулан хууль боловсруулах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь” төслийн хүрээнд цахим хэлэлцүүлгийн платформын нээлт болов.

Нээлтийн ажиллагаанд Улсын Их Хурлын дарга З.Энхболд оролцож үг хэлэв. Энэ арга хэмжээ, төсөл нь Улсын Их Хурлын Тамгын газар, “Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн” ТББ хамтран НҮБ -ын Ардчилал сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж байгаа юм.

2016.02.04

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг эгүүлэн татах талаарх Улсын дээд шүүхийн саналыг үргэлжлүүлэн хэлэлцэх явцад Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлэг 3 хоногийн нэмэлт завсарлага авав.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай” Улсын Их Хурлын тогтоол, “Гацууртын ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдав.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай /шинэчилсэн найруулга/ болон Захиргааны ерөнхий хууль батлагдсантай холбогдуулан бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл ахуйн тухай болон холбогдох бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийж батлав.

2016.02.04

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулж, Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дэргэдэх Мянганы хөгжлийн зорилтууд болон ядуурлыг бууруулах асуудлын дэд хороог “Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо” болгож өөрчиллөө.

Хууль тогтоомжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон бусад хуулийн төслүүд, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуулийн төслүүдийг хэлэлцэж батлав.

2016.02.05

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн

албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, Онцгой албан татвараас чөлөөлөх тухай, Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг батлах тухай” Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд батлагдав.

Ирээдүйн өв сангийн тухай болон холбогдох бусад хуулийн төслүүд, Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал /2016 - 2030 он/ батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталлаа.

Монгол Улс урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг 2016-2020, 2021-2025, 2026-2030 он гэсэн 3 үндсэн үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд үзэл баримтлалд эдийн засгийн бодлогын, нийгмийн тогтвортой хөгжлийн, байгаль орчны тогтвортой хөгжлийн, тогтвортой хөгжлийн засаглалын гэсэн үндсэн 4 бүлгийн хүрээнд нийт 45 зорилт, 18 үндсэн үзүүлэлтийг тодорхойлж хэрэгжүүлэхээр тусгажээ.

Чуулганы үдээс хойших нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг улс орны цаг үеийн асуудлаар мэдээлэл хийж, Улсын Их Хурлын гишүүдийн сонирхсон асуултад хариулт өгөв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар Ард нийтийн санал асуулгын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төсөл, Хүүхдийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүд, Хүүхэд хамгааллын тухай болон холбогдох бусад хуулийн төслүүд, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай болон холбогдох бусад хуулийн төслүүд, Барилгын тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулийн төслүүдийг батлав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсантай холбогдуулан Улсын Их Хурлын 2015 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 94 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулав.

“Монгол Улсаас гадаадын зарим улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж, Бүгд Найрамдах Габон Улс, Сент Люси Улс, Бүгд Найрамдах Нигер Улс, Бүгд Найрамдах Камерун Улс, Маршаллын Арлуудын Бүгд Найрамдах Улстай дипломат харилцаа тогтоохоо болов.

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл, Тээврийн салбарт хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай, “Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэж баталлаа.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлыг баталснаар Улсын Их Хурлын 2015 оны намрын ээлжит чуулган өндөрлөв.

Улсын Их Хурлын 2015 оны намрын ээлжит чуулганыг хааж Улсын Их Хурлын дарга З.Энхболд үг хэлэв. Улсын Их Хурлын дарга хэлсэн үгэндээ “Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацааны отгон намрын чуулган өндөрлөж байна.

Энэ чуулган ажлын 90 өдөр үргэлжилж, нэгдсэн хуралдаан 38 удаа, Байнгын болон дэд хороод давхардсан тоогоор 131 удаа хуралдаж, нийт 412 хууль, 65 тогтоол хэлэлцэн баталлаа. Эдгээрийн дотор бие даасан хууль 26, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 347, хууль хүчингүй болгох тухай хууль 28, олон улсын гэрээ, конвенц соёрхон батлах, нэгдэн орох тухай хууль 11 байна” гэлээ.

2016.02.08

Улсын Их Хурлын дарга З.Энхболд ард түмэндээ XVII дугаар жарны гал бичин жилийн хаврын Тэргүүн сарын шинийн нэгний мэнд дэвшүүлж, айл хотлоороо амар амгалан, сайхан шинэлэхийг ерөөв.

2016.02.09

Билгийн тооллын XVII жарны гал бичин жилийн хаврын тэргүүн сарын шинийн нэгний ерөөл билэгт сайхан энэ өглөө Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Улсын Их Хурлын дарга З.Энхболд, Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг нар Төрийн ёслол хүндэтгэлийн өргөөнөө морилон цагаан сарын золголт хийж, монгол түмний заншил ёсоор азай буурлууддаа хүндэтгэл үзүүлж золгов.

2012.02.12

Улсын Их Хурлын дарга З.Энхболд 25 тоот захирамж гаргаж, Улсын Их Хурлын ээлжит бус чуулганыг 2016 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 02 дугаар сарын 26-ны өдрүүдэд зарлан хуралдуулж, нийт 24 асуудал хэлэлцэн шийдвэрлэхээр товлон зарлав.

2016.02.18

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дарга Д.Батцогт Улсын Их Хурлын 2015 оны намрын ээлжит чуулганы хугацаанд тус Байнгын хорооноос хэрэгжүүлсэн ажлын талаар сэтгүүлчдэд мэдээлэл хийлээ. Тус Байнгын хороо 2015 оны намрын ээлжит чуулганы хугацаанд 12 удаа, 60 хувийн дундаж ирцтэйгээр хуралдаж, 38 асуудал хэлэлцэж, 10 хууль, /хамт өргөн мэдүүлсэн 28 хууль/ 4 тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулжээ.

Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл Улсын Их Хурлын ээлжит бус чуулганы нээлтийг хойшлуулан 2 дугаар сарын 18-ны өдрийн 09.00 цагт нээхээр товлосон ч чуулганы хуралдааны танхимд Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн 34 гишүүн, МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслийн бүлгээс МҮАН-ын хоёр гишүүн, Иргэний Зориг Ногоон намын нэг гишүүн буюу нийт 37 гишүүн ирж, Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн гишүүд, “Шударга ёс” бүлгээс МАХН-ын гишүүдийн нэг ч гишүүн танхимд орж ирээгүй учир ээлжит бус чуулганы нээлтийг хийх боломжгүй болсон юм. Иймд Улсын Их Хурлын ээлжит бус чуулганы нээлтийг үдээс хойш 14 цаг хүртэл хойшлуулсан боловч хуралдааны ирц мөн бүрдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүдийн ирц бүрдээгүйн улмаас ээлжит бус чуулган хуралдсангүй. Харин хүрэлцэн ирсэн гишүүд семинарын горимд шилжиж Улсын Их Хурлын ээлжит бус чуулганыг хуралдуулах шаардлага, үндэслэлийн талаар үг хэлэв.

2016.02.19

Улсын Их Хурлын 2016 оны ээлжит бус чуулган ажлаа эхлэв. Ээлжит бус чуулганыг нээж УИХ-ын дарга З.Энхболд үг хэлэв. Тэрбээр ээлжит бус чуулганаар хэлэлцэх асуудлуудын талаар үг хэлэхдээ, юуны өмнө татварын шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд онцгой анхаарал хандуулах болно гэдгийг онцлов.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо Улсын Их Хурлын 2015 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийсэн ажлаа тайлагнаж, хэвлэлийн бага хурал

зохион байгуулан сэтгүүлчдэд мэдээлэл өгөв. Тус байнгын энэ хугацаанд 20 удаа хуралдаж, хуулийн төсөл 209, Улсын Их Хурлын тогтоолын төсөл 14, Байнгын хорооны тогтоол 5, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт 2-ыг хэлэлцэж, 38 санал, дүгнэлт, 4 төслийн эцсийн хэлэлцүүлгийн танилцуулга гаргажээ.

Улсын Их Хурлын 2016 оны ээлжит бус чуулганы нэгдсэн хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг эгүүлэн татах талаарх Улсын дээд шүүхийн саналыг үргэлжлүүлэн хэлэлцэж, Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Амарсанааг эгүүлэн татах тухай Улсын Их Хурлын тогтоол батлав.

“Санхүүгийн хамтын ажиллагааны Ерөнхий хөтөлбөрийн тухай” Монгол Улсын Засгийн газар, Унгар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, Монгол Улсын Засгийн газар Азийн хөгжлийн банк хооронд байгуулах “Зээлийн батлан даалтын системийг дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх ажлын байр бий болгох” төслийн зээлийн хэлэлцээр, Монгол Улсын Засгийн газар Азийн хөгжлийн банк хооронд байгуулах “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг шинэчлэн сайжруулах” төслийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэж батлав.

Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ -ийн төсөл, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төсөл, Хувь хүний орлогын албан татварын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төсөл, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж, хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр шилжүүлэв.

Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулийн төслүүд; Хууль сахиулах тухай болон холбогдох бусад хуулийн төслүүд; Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцээд анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.

Улсын Их Хурлын 2016 оны ээлжит бус чуулган өндөрлөлөө. Ээлжит бус чуулганыг хааж Улсын Их Хурлын дарга З.Энхболд үг хэлэв.

2016.02.23

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Монгол Улсын Их Хурал, Бүгд Найрамдах Индонез Улсын Төлөөлөгчдийн танхим хоорондын хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурав.

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороо иргэдийн өргөдлийн дагуу иргэд, холбогдох албан тушаалтнуудаас тайлбар авах уулзалтыг Нээлттэй сонсголын танхимд зохион байгуулав.

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга М.Сономпил, Улсын Их Хурлын гишүүн Л.Болд, С.Оюун нар Батлан хамгаалах яаманд ажиллан тус салбарын бодлого, үйл ажиллагаатай танилцаж, салбарын хэмжээнд тулгамдсан асуудлуудын талаар сайдын мэдээллийг сонсов.

2016.02.24

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Ганбат Улсын Их Хурлын 2015



оны намрын ээлжит чуулган болон ээлжит бус чуулганы хугацаанд байнгын хорооноос хийсэн ажлын талаар хэвлэлийн бага хурал хийж, сэтгүүлчдэд мэдээлэл өгөв.

Намрын чуулганы хугацаанд тус байнгын хороо 19 удаа хуралдаж, хуулийн төсөл 257, Улсын Их Хурлын тогтоолын төсөл 12-ыг хэлэлцэн санал, дүгнэлт 29, танилцуулга 5, зарчмын зөрүүтэй 324 саналын томъёолол бэлтгэн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлжээ.

#### 2016.03.02

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооноос “Орон сууцны ипотекийн, малчны, өндөр насны тэтгэвэр барьцаалсан зээлийн хүүгийн талаарх зарим асуудал” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав.

Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг зохион байгуулах ажлын бэлтгэл хангах үүрэг бүхий Үндэсний хороо анхны хуралдаанаа хийж, хурлын зохион байгуулалт, бэлтгэл ажлын явц байдлын талаар хэлэлцэв.

Үндэсний хорооны дарга, Улсын Их Хурлын дэд дарга Р.Гончигдорж Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг гадаад харилцаа, улс төрийн агуулга, бэлтгэл зохион байгуулалтын өндөр түвшинд зохион байгуулахад анхаарч, бэлтгэл ажлыг сайтар хангахыг үүрэг болгов.

#### 2016.03.03

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос хэвлэлийн бага хурал зохион байгуулж, Улсын Их Хурлын 2015 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийсэн ажлаа тайлагнав. Тус байнгын хороо энэ хугацаанд нийт 25 удаа хуралдаж, 96 хууль, 10 тогтоолын төсөл болон бусад асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо зөвлөлдөх уулзалт зохион байгуулж, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал солилцов.

#### 2016.03.06-08

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Өмнөговь, Дундговь аймагт томилолтоор ажиллаж, Улсын Их Хурлын 2015 оны намрын чуулганы хугацаанд батлагдсан хууль, тогтоолуудын талаар аймгийн иргэдэд танилцуулга хийж, орон нутгийн бүтээн байгуулалтын ажилтай танилцав.

#### 2016.03.06

Монгол Улсын Их Хурлын дарга Зандаахүүгийн Энхболд Өмнөговь аймагт ажиллах үеэрээ энэ өдөр “Монгол тэмээ 999” арга хэмжээний хүрээнд болж буй “Тэмээчдийн зөвлөгөөн”-д оролцож байгаа БНХАУ-ын Өвөрмонголын өөртөө засах орны Хөх хотын Хөдөө аж ахуйн их сургуулийн профессор Н.Журамтыг хүлээн авч уулзав. Тэд уулзалтын үеэр ингэний сүүг тогтмол хэрэглэж заншвал чихрийн шижин өвчнийг анагаах боломжийн талаар ярилцлаа.

Өвөрмонголын өөртөө засах орны эрдэмтэн, судлаачид ингэний сүү нь чихрийн шижин өвчнийг анагаах боломжтойг тогтоосон бөгөөд Япон улсад ингэний сүүний

бэлдэц бүтээгдэхүүнийг экспортлож эхэлсэн байна. Өнөөгийн байдлаар Өвөрмонголын тэмээчид 1 литр ингэний сүүг 100 юаниар худалдаалж байгаа бол боловсруулсан ингэний сүүн бүтээгдэхүүн зах зээл дээр 200 юань байгаа талаар дуулгаад, зарим мэдээллийг танилцуулав.

Уулзалтын үеэр Улсын Их Хурлын дарга З.Энхболд ингэний сүүг дэлхийн брэнд болгох боломжийн талаар сонирхож, уг асуудлаар харилцан санал солилцсон юм. Уулзалтад Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Хүнс хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа, Улсын Их Хурлын гишүүн Д.Бат-Эрдэнэ нар байлцав.

2016.03.07

Улсын Их Хурал Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалт (АСЕМ) -ын хүрээнд Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг Улаанбаатар хотноо 2016 оны 04 дүгээр сарын 21-нээс 23-ны өдрүүдэд зохион байгуулах гэж байгаатай холбогдуулан уг уулзалтыг зохион байгуулах Үндэсний хорооны гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар нар Монгол Улсад байнга суугаа гадаад улсын дипломат болон консулын төлөөлөгчийн газрын тэргүүнүүдтэй уулзаж мэдээлэл хийлээ.

2016.03.10

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар Монгол Улс Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенци, Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай 1997 оны конвенцид тус тус нэгдэн орох, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцийн 2005 оны нэмэлт, өөрчлөлтийн тухай протокол, Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг тус тус соёрхон батлах тухай асуудлыг зөвшилцөв.

2016.03.11

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Монгол Улсад Барилгын цэрэг байгуулагдсаны 80 жилийн ойн арга хэмжээнд оролцож, баярын мэндчилгээ дэвшүүлэв

2016.03.14

Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг зохион байгуулах ажлын бэлтгэл хангах үүрэг бүхий Үндэсний хороо хуралдаж, уулзалтын бэлтгэл хэрхэн хангагдаж байгаа талаар мэдээлэл сонсоож, санал солилцов.

2016.03.16

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо Хууль зүйн яамтай хамтран Хууль сахиулах тухай хуулийн төслийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлгийг Байнгын хорооны дарга Д.Ганбат нээж, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин удирдаж явуулав.

2016.03.17

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Уул уурхайн яам, Япон Улсын Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яамнаас хамтран зохион байгуулсан “Цэвэр нүүрсний технологи” семинарт оролцож, үг хэлэв.



Уг арга хэмжээнд энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, их сургууль, судалгаа шинжилгээ явуулдаг компаниуд болон уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөлөл оролцов. Улсын Их Хурлын дарга З.Энхболд Засгийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Швейцарийн хөгжлийн агентлагтай хамтран зохион байгуулсан “Тэргүүний малчдын улсын зөвлөгөөн”-д оролцож үг хэлэв.

2016.03.18-23

Улсын Их Хурлын дарга, Ардчилсан намын дарга З.Энхболд “Монгол цэргийн өдөр” -ийг тохиолдуулан мэндчилгээ дэвшүүлэв.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Архангай аймгуудад ажиллан Улсын Их Хурлын 2015 оны намрын ээлжит чуулганы үйл ажиллагааны талаар иргэд сонгогчдод мэдээлэл хийж, орон нутгийн ажил байдал, бүтээн байгуулалтын ажилтай танилцав.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд эх орны дөрвөн зүг, найман зовхист ажилллаж, амьдарч байгаа казах ард иргэддээ Наурызын баярын мэндчилгээ дэвшүүлэв.

2016.03.23

Монгол Улсын Их Хурал Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг зохион байгуулах ажлын хэсэг хуралдаж, уулзалтын зохион байгуулалт, бэлтгэл ажлын талаар санал солилцов.

2016.03.25

Улсын Их Хурлын дарга З.Энхболд захирамж гаргаж, Улсын Их Хурлын ээлжит бус чуулганыг 2016 оны 03 дугаар сарын 29-ний өдрөөс 04 дүгээр сарын 01 -ний өдрүүдэд зарлан хуралдуулахаар товдон зарлаж, хэлэлцэх асуудлыг тогтоов.

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Хүнс, хөдөө аж ахуйн яамтай хамтран Малын генетик нөөцийн тухай хуулийн төслийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлэгт Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэг, Ё.Отгонбаяр, С.Оюун нар болон холбогдох байгууллагуудын төлөөллүүд оролцож, Малын генетик нөөцийн тухай хуулийн төслийн талаар дэлгэрэнгүй танилцуулга, Хүнс, хөдөө аж ахуйн генетик нөөцийн олон улсын болон үндэсний зохицуулалтын талаарх илтгэл сонсож санал солилцов.

2016.3.28

Улсын Их Хурлын дарга З.Энхболд 41 дүгээр захирамж гаргаж, Улсын Их Хурлын 2016 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоов. Улсын Их Хурлын даргын захирамжаар Улсын Их Хурлын 2016 оны хаврын ээлжит чуулганаар асуудлын асуудлын дарааллыг доор дурдсанаар тогтоосон байна. Үүнд:

1. “Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийг товлон зарлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;
2. “Нийтийн сонголыг зохион байгуулах журам батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;
3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн тухай;
4. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай”

- Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;
5. Монгол Улсын 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл;
  6. “Монгол Улсын 2015 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны санхүүгийн нэгдсэн тайлан;
  7. “Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн зардлын хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;
  8. “Авлигатай тэмцэх, хариуцлага, шударга ёсыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөрийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;
  9. Гэр бүлийн тухай хуулийн төсөл; Гэр бүлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
  10. Төрийн шагналын тухай хуулийн төсөл;
  11. Худалдааны тухай хуулийн төсөл;
  12. бусад.

Энэ захирамжид зааснаас бусад хэлэлцүүлгийн шатанд байгаа болон Засгийн газраас санал авахаар Улсын Их Хурлын гишүүдээс хүргүүлсэн хууль, тогтоолын төсөл, хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бусад хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг хаврын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх асуудлыг тухай бүрт нь Зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлэж байхаар тогтоосон байна.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын 2016 оны хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдааны цагийг тогтоох тухай захирамж гаргаж, Улсын Их Хурлын 2016 оны хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдааныг долоо хоногийн Пүрэв, Баасан гарагт өглөө 9-00 цагаас эхэлж, үдээс хойш 14 цагаас үргэлжлүүлж байхаар тогтоов.

2016.03.29

Монгол Улсын Их Хурал Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг зохион байгуулах ажлын бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийн хуралдаанаар өмнөх хуралдаанаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийн талаар мэдээлэл сонсож, зохион байгуулалтын бэлтгэл ажлын явц байдлын талаар санал солилцлоо.

2016.03.30

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Дэлхийн эмч нарын өдрийг тохиолдуулан Монгол Улсын эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа эмч, эмнэлгийн ажилтнуудад баярын мэндчилгээ дэвшүүлэв.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд “Улсын Их Хурлын ээлжит бус чуулган товлон зарлах тухай” Улсын Их Хурлын даргын 2016 оны 40 дүгээр захирамжид нэмэлт оруулах тухай захирамж гаргаж, хэлэлцэх асуудлын дараалалд “6/Ашигласан түлш, цөмийн болон цацраг идэвхт хаягдлыг Монгол Улсын хилээр оруулахыг хориглох тухай хуулийн төсөл.” гэж нэмэхээр шийдвэрлэв.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд ажиллаж, тус төвийн Оношлогоо-эмчилгээний иж бүрэн шинэчлэгдсэн тоног төхөөрөмжийг ашиглалтад хүлээн авах арга хэмжээнд оролцов.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд “Камминс Монголиа инвестмент” ХХК -ийн үйл ажиллагаатай танилцаж, Төмөрлөг, машин үйлдвэрлэл, инженерингийн холбооны төлөөлөлтэй уулзав.



2016.03.31

Улсын Их Хурлын дарга З.Энхболд хүнсний ногоо тариалагчид, малчидтай хамтран ажиллаж, импортыг бууруулж, эрүүл, аюулгүй хүнсээр дотоодын зах зээлийг бүрэн хангах зорилгоор “Дельта холдинг” ХХК-ийн хэрэгжүүлж байгаа “Монгол фермер” ложистик худалдааны төвийн төслийн явцтай танилцав.

2016.03.31

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын ээлжит бус чуулган гишүүдийн ирц хүрэлцэхгүйгээс шалтгаалж хуралдах боломжгүй болсныг мэдэгдэж, ээлжит бус чуулганыг цуцлав.

2016.04.01

Түрээсийн харилцааг зохицуулах судалгааны үр дүн, түрээсийн хуулийн төслийг танилцуулж, санал авах хэлэлцүүлэг болж, хэлэлцүүлгийг УИХ-ын гишүүн Г.Уянга хөтлөн явуулсан бөгөөд хэлэлцүүлэгт түрээслүүлэгч, түрээслэгчдийн төлөөлөл, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл оролцсон юм.

2016.04.01

Улсын Их Хурлын гишүүн, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дарга Д.Батцогт Эрүүл мэнд, спортын яам, Сангийн яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар, зарим эмнэлгийн удирдлага, эмч, мэргэжилтэн, Төрийн бус байгууллагын төлөөлөлтэй уулзаж, эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй асуудлаар санал солилцлоо.

2016.04.01-03

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Булган, Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул аймгуудад томилолтоор ажиллан орон нутгийн бүтээн байгуулалт, үйлдвэр, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай танилцаж, иргэд сонгогчилтой уулзалт хийлээ.

2016.04.03

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газар, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал хамтран Баянхонгор аймагт Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төслийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулав.

2016.04.04

Улсын Их Хурлын дарга З.Энхболд “Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо” үндэсний чуулганы нээлтэд оролцон үг хэлж, уг чуулганыг санаачлан зохион байгуулсан Улсын Их Хурлын эмэгтэй гишүүд, Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хамт олонд талархал илэрхийлэв.

2016-04-04

УИХ -ын гишүүн Н.Алтанхуяг Төрийн ордонд хэвлэлийн бага хурал зарлан мэдэгдэл хийлээ. Тэрбээр мэдэгдлийнхээ эхэнд, Манай ард түмэн хоёрхон сарын дараа сонголттой хийх гэж байна. Маргааш энд УИХ -ын хаврын чуулган эхэлнэ. Ийм хариуцлагатай цаг

үед би ард түмэндээ тодорхой зүйлсийг анхааруулж, мэдэгдэхээс өөр аргагүй байдалд хүрлээ хэмээсэн юм. Тэрбээр улс төр, эдийн засгийн өнөөгийн байдлын талаар өөрийн байр суурийг илэрхийлж, шударга ёсны төлөөх тэмцэлд Ардчилсан намынхаа гишүүд, дэмжигчид, монголынхоо ард түмнийг уриалж буйгаа мэдэгдлээ

2016-04-05

Энэ удаагийн Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацааны сүүлчийн ээлжит чуулган болох Улсын Их Хурлын 2016 оны хаврын ээлжит чуулган 9 цаг 25 минутад гишүүдийн 52.6 хувийн ирцтэйгээр үйл ажиллагаагаа эхэллээ. УИХ -ын дарга З.Энхболдын Улсын Их Хурлын 2016 оны хаврын ээлжит чуулганыг нээж үг хэлэв.

Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы нээлтэд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж болон Засгийн газрын гишүүд, Улсын Их Хурлаас томилогддог болон ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудын удирдлагууд, мөн улс төрийн намуудын төлөөлөл, гадаад орнуудаас Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчдийн байгууллагын тэргүүн нар оролцов.

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг УИХ-ын гишүүн А.Тлейханаар, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсгийг УИХ-ын гишүүн С.Дэмбэрэлээр ахлуулан байгуулж ажиллуулахаар боллоо.

2016-04-06

УИХ -ын Төрийн байгуулалтын байнгын хорооны энэ өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын 2015 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, энэ талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар хийв.

Улсын Их Хурлын Тамгын газар 2015 онд реинженерчлэлийн ажлын үр дүнд үндэслэн ажилтнуудын ажлын чиг үүрэг, ажлын байрын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, ажил үүргийн давхардал, хийдлийг арилгах, “Улсын Их Хурлын Тамгын газрын Мэдээлэл, үйлчилгээ, удирдлагын төв” -ийн үйл ажиллагааг жигдрүүлэх зорилго тавин ажиллаж, бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийж, Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Тамгын газрын дүрэм болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулан ажилласныг Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга танилцуулгынхаа эхэнд онцлоод Улсын Их Хурлын Тамгын газраас 2015 онд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааг үндсэн 8 чиглэлээр тайлагнаж танилцуулав.

2016-04-06

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга А.Бакей Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Хүний эрх, ардчиллын институтийн ахлах зөвлөх Стивен Мартин, зөвлөх Улви Акундлу нарыг хүлээн авч уулзав.



2016-04-06

УИХ -ын дарга З.Энхболдын “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний долдугаар форум”-д оролцож үг хэлэв.

2016-04-07

Органик хүнсний тухай хуулийн төслийн /Засгийн газар 2015.06.10-ны өдөр өргөн мэдүүлсэн/ эцсийн хэлэлцүүлгийг хийж, хуулийн төслийг батлах санал хураалт явуулсныг хуралдаанд оролцсон гишүүд 75.8 хувийн саналаар дэмжсэнээр Органик хүнсний тухай хууль батлагдлаа.

Мөн чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын дарга З.Энхболд УИХ дахь МАХН-МҮАН-ын “Шударга ёс эвсэл” -ийн бүлгээс “Улсын Их Хурлын гишүүн Л.Цог, Г.Уянга нар 2016 оны 3 дугаар сарын 21-ний өдөр УИХ дахь МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслийн бүлгээс гарсанаа мэдэгдсэн албан бичиг ирүүлсэн тул УИХ дахь “Шударга ёс” эвслийн бүлгээс гарсан болохыг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.12 -т заасны дагуу үүгээр мэдэгдэж байна.

Улсын Их Хурлын гишүүн Л.Цог, Г.Уянга нараас бүлэгтээ ирүүлсэн албан бичгийг хавсаргав. Бүлгийн дарга Н.Батцэрэг” гэсэн албан бичиг ирүүлснийг уншиж сонсгов. Энэхүү албан бичгийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд уншиж сонсгосноор эдгээр гишүүд УИХ дахь “Шударга ёс” эвслийн бүлгээс гарсныг хуралдаан даргалагч мэдэгдлээ.

2016-04-08

Улсын Их Хурлын дэд дарга, Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга Л.Цог, тус комиссын гишүүд Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын үе үеийн даргаар ажиллаж байсан төр, нийгмийн зүтгэлтнүүдийг Төрийн ордонд хүлээн авч уулзаж, хүндэтгэл үзүүлэв

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс байгуулагдсаны 25 жилийн ойн хүрээнд зохион байгуулж буй уг хүндэтгэлийн арга хэмжээг Улсын Их Хурлын дэд дарга, Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга Л.Цог нээж хэлсэн үгэндээ,

- Одоогоос 25 жилийн өмнө тэр үеийн БНМАУ-ын Ерөнхийлөгч П.Очирбат 56 дугаар зарлиг гарган Монгол Улсын түүхэнд хар толбо болж үлдсэн Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссыг байгуулж, мөрдөж ажиллах дүрэм журмыг нь баталж байсныг онцлоод тус комиссын үе үеийн даргаар ажиллаж байсан төр, нийгмийн зүтгэлтнүүдийн хамтын хүчин чармайлт, комиссын гишүүд, салбар комиссууд, ажлын албаны ажилтнуудын нөр их хөдөлмөр зүтгэлийн ачаар чамгүй олон ажил хийгдэж, тодорхой үр дүнд хүрснийг баримт дурдаж тэмдэглэлээ.

2016-04-08

Улсын Их Хурлын 2016 оны хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын зарим гишүүдээс Монгол Улсын Ерөнхий сайд болон салбарын сайд нарт тавьсан дөрвөн асуулгын хариуг сонслоо. Үүнд:

- Улсын Их Хурлын гишүүн С.Оюун нарын 8 гишүүнээс Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор Шийдлийн Засгийн газраас 2015 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ,

түүний хэрэгжилт болон 2016 онд төлөвлөж буй арга хэмжээ, хүрэх үр дүнгийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Н.Батцэрэг танилцуулав.

- Улсын Их Хурлын гишүүн Д.Сумъяабазараас Цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа доголдож, хүний эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж байгаа болон иргэдийг орчны бохирдлоос хамгаалахтай холбоотой авч буй арга хэмжээний талаар Эрүүл мэнд, спортын сайдад тавьсан асуулгын хариуг Эрүүл мэнд, спортын сайдын үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа Монгол Улсын шадар сайд Ц.Оюунбаатар танилцуулав. Мөн тэрээр Д.Сумъяабазар гишүүнээс Нийслэлийн иргэдийг агаар, хөрс, усны бохирдлоос хамгаалах, бий болсон хор хөнөөлийг бууруулах талаар авч буй арга хэмжээний талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг хамтад нь танилцуулсан юм.
- Улсын Их Хурлын гишүүн Д.Сумъяабазараас Нийслэлийн агаарын болон Туул голын бохирдол, цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа доголдож байгаатай холбоотойгоор иргэдийг орчны болон агаарын бохирдлоос хамгаалах талаар Байгаль орчин, ногоон хөгжил аялал жуулчлалын сайдад тавьсан асуулгын хариуг Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Н.Батцэрэг танилцуулав.

2016-04-08

Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулиас санаачлан Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Хууль зүйн яам, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монголын Хуульчдын холбоо, Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэн хамтран Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн дэмжлэгтэйгээр “Хууль зүйн нэр томъёоны судалгаа, хэрэглээ” сэдэвт улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлыг зохион байгууллаа.

2016-04-08

Монгол Улсын Их Хурлын дарга Зандаахүүгийн Энхболдод Монгол Улсын Гадаад харилцааны тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэг, С.Оюун, Н.Энхболд, Д.Дэмбэрэл нар өргөн мэдүүллээ.

2016-04-11

Улсын Их Хурлаас баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлогын баримт бичгийн нээлтийн ёслол 14-00 цагт Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд болж, Улсын Их Хурлын дарга З.Энхболд, Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг болон Улсын Их Хурал, Засгийн газрын зарим гишүүд, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн дарга нар, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд болон олон улсын банк санхүүгийн байгууллагын төлөөлөгчид оролцов.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ыг Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэгт гардуулж өгөв.

Ёслолын ажиллагааны дараа Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга А.Бакей, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн дарга нар хэвлэлийн бага хурал хийж, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлого баримт бичгийн талаар сэтгүүлчдэд мэдээлэл өглөө.





“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030”-ын нээлтийн ёслолын ажиллагааг нээж УИХ-ын дарга З.Энхболд үг хэлэв.

2016-04-12

Монгол Улсын Их Хурлын дарга Зандаахүүгийн Энхболдод Засгийн газрын гишүүн, Хууль зүйн сайд Д.Дорлигжав Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн төслийг өргөн мэдүүлээ.

2016.04.12

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга М.Сономпил, Улсын Их Хурлын гишүүн Д.Дэмбэрэл, Ж.Энхбаяр, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Ц.Цолмон нар Зэвсэгт хүчний Жанжин штабт ажиллав.

2016-04-12

Монгол Улсын Их Хурлын дарга Зандаахүүгийн Энхболдод “Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” болон “Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын гишүүн, Хуульзүйн сайд Д.Дорлигжав өргөн мэдүүлэв.

2016.04.13

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороонд ирүүлсэн өргөдөл гомдлын дагуу хоёр асуудлаар холбогдох албан тушаалтнуудаас тайлбар авах уулзалтыг Төрийн ордон дахь Нээлттэй сонсголын танхимд зохион байгуулав.

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар Засгийн газраас өргөн мэдүүлсэн Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ -ын суурь конвенцийн Парисын хэлэлцээрийн төслийг зөвшилцөв.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2016 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн тогтоолоор байгуулсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүн Улсын Их Хурлын гишүүн Л.Болд, Ц.Оюунгэрэл, Ё.Отгонбаяр, Х.Тэмүүжин нар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, түүний харьяа Цагдан хорих 461 дүгээр анги, Төв аймаг дахь Цагдан хорих байр болон Тахарын ерөнхий газарт ажиллалаа.

2016.04.14

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Ерөнхийлөгчөөс Улсын Их Хуралд ирүүлсэн санал, Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцээд өөрийнх нь хүсэлтийн дагуу Н.Ганболдыг Авлигатай тэмцэх газрын даргын үүрэг ажлаас чөлөөлөв.

Боловсролын тухай, Дээд боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Н.Батбаярын санаачилж өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж батлав.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунбаатар нарын нэр бүхий 10 гишүүний өргөн мэдүүлсэн

“Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж баталлаа.

“Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлав. Дээрх тогтоол батлагдсанаар байгаль орчны тэнцвэрт байдал, байгалийн унаган төрх, түүх, соёлын үнэт өвийг тогтвортой хадгалах, устах аюулд орсон амьтан, ургамлыг хамгаалах зорилгоор байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд онцгой ач холбогдол бүхий Өмнөговь аймгийн Гурван тэс сумын нутагт орших Тост, Тосон бумын нурууг байгалийн нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авахаар болов.

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга Ч.Улаан Гааль, татварын ерөнхий газарт ажиллаж, 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж байгаа Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулийн хэрэгжилтийн явц, ажил байдалтай танилцав. Гааль, татварын ерөнхий газрын дарга С.Пүрэв дээрх хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор нэг цэгийн үйлчилгээний төв ажиллуулж байгаагаа танилцууллаа.

2016.04.15

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Л.Эрдэнэчимэг, Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунгэрэл нар “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсантай холбоотойгоор сэтгүүлчдэд мэдээлэл хийлээ.

Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг зохион байгуулах ажлын бэлтгэл хангах үүрэг бүхий Үндэсний хорооны хуралдаан болж, Үндэсний хорооны дарга, Улсын Их Хурлын дэд дарга Р.Гончигдорж хуралдааны эхэнд мэдээлэл хийв.

Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтад өнөөдрийн байдлаар 30 гаран орон болон Европын парламентаас нийт 170 орчим төлөөлөгч бүртгүүлснээс парламентын дарга 3 /Энэтхэг, Итали, Тайланд/, дэд дарга 11 /Австрали, Итали, Индонези, Финланд, Унгар, Польш, Вьетнам, Испани/ оролцохоор байгааг Үндэсний хорооны дарга мэдээлэв.

Хурлын үеэр Үндэсний хорооны гишүүд Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтаар батлах Тунхаглалын төсөл, манай улсаас оруулж хэлэлцүүлэх илтгэл болон зохион байгуулалтын бусад асуудлын талаар санал солилцлоо.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг Монгол Улсын гадаад өр, Засгийн газрын өрийн талаар мэдээлэл хийлээ. Мөн Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгын гаргасан асуулгын дагуу Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэнд, спортын сайдын үүрэг гүйцэтгэгч Ц.Оюунбаатар улаанбурхан өвчний талаар мэдээлэл хийв.

2016-04-15

Монгол Улсын Их Хурлын дэд дарга, Цагаатгалын комиссын дарга Л.Цог Конрад-Аденауэр сангийн Суурин төлөөлөгч Даниель Шмюкингийг Төрийн ордонд хүлээн авч уулзав.

2016.04.18

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга А.Бакей НҮБ-ын



Хөгжлийн хөтөлбөрийн шадар суурин төлөөлөгч хатагтай Даниела Гаспарикова тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав. Улсын Их Хурлаас Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлогын баримт бичгийг батлан гаргахад хамтран ажиллаж, дэмжлэг туслалцаа үзүүлж ирсэнд нь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хамт олонд Байнгын хорооны дарга талархал илэрхийллээ.

2016.04.18-22

Монгол Улсын Их Хурлын даргын урилгаар Бүгд Найрамдах Энэтхэг Улсын парламентын Доод танхим /Лок Сабха/-ын дарга хатагтай Сумитра Махажан 2016 оны 04 дүгээр сарын 18-22-ны өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийж, Улаанбаатар хотноо 04 дүгээр сарын 21-23-ны өдрүүдэд зохион байгуулагдах Ази-Европын Парламентын Түншлэлийн 9 дүгээр уулзалтын зарим арга хэмжээнд оролцов.

Айлчлалын үеэр Монгол Улсын Их Хурлын дарга З.Энхболд, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын парламентын Доод танхим /Лок Сабха/-ын дарга хатагтай Сумитра Махажан нар Монгол Улсын Их Хурал, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын парламентын Доод танхим /Лок Сабха/-ын хоорондын хамтын ажиллагааны протоколд гарын үсэг зурлаа.

2016.04.19

Улсын Их Хурлын дэд дарга Р.Гончигдорж Оросын Холбооны Улсын Төрийн Думын дарга С.Е.Нарышкин, Бүгд Найрамдах Солонгос Улсын парламентын дарга Чон Ый Хва нарын санаачлагаар Москва хотноо зохион байгуулсан Евразийн бүс нутгийн орнуудын парламентын дарга нарын анхдугаар зөвлөгөөнд оролцов. Тус зөвлөгөөнд Монгол, Орос, Солонгос, Афганистан, Армен, Азербайжан, Беларусь, Вьетнам, Индонез, Иран, Казахстан, Киргиз, Хятад, Камбож, Пакистан, Тажикистан, Тайланд, Филиппин, Энэтхэг зэрэг 19 орны парламентын төлөөлөгчид оролцсон байна.

2016-04-20

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг зохион байгуулах Үндэсний хорооны Ажлын хэсгийн дарга Б.Болдбаатар сэтгүүлчдэд мэдээлэл хийлээ.

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороо иргэдийн өргөдлийн дагуу иргэд, холбогдох албан тушаалтнуудаас тайлбар авах уулзалтыг Төрийн ордон дахь Нээлттэй сонсголын танхимд зохион байгуулав. Уулзалтад Улсын Их Хурлын гишүүн, тус байнгын хорооны дарга Ж.Батзандан, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, Ө.Энхтүвшин нар оролцлоо.

2016.04.20-23

Улсын Их Хурлын даргын урилгаар Бүгд Найрамдах Итали Улсын парламентын Сенатын танхимын Ерөнхийлөгч Пьетро Грассо 2016 оны 04 дүгээр сарын 20-23-ны өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийлээ. Сенатын танхимын Ерөнхийлөгч Пьетро Грассо айлчлалынхаа хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржид бараалхаж, Монгол Улсын Их Хурлын дарга З.Энхболдтой албан ёсны уулзалт хэлэлцээ хийсэн юм.

2016.04.21

Монгол Улсын Их Хурал Ази, Европын дээд түвшний 11 дүгээр чуулга уулзалт /АСЕМ/-ын хүрээнд Улаанбаатар хотод зохиогдох Ази-Европын парламентын түншлэлийн 9

дүгээр уулзалтыг Бэлтгэл хурал Төрийн ордны хуралдааны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд болов. Хуралдааныг Улсын Их Хурлын гишүүн С.Оюун даргалж, Ази-Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтад хүрэлцэн ирсэн улс орнуудын парламентын төлөөлөгчид оролцлоо.

2016.04.22

Ази, Европын дээд түвшний 11 дүгээр чуулга уулзалтын хүрээнд Улаанбаатар хотноо зохиогдож буй Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтын нээлтийн ажиллагаа Төрийн ордны Их Танхимд боллоо. Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтад түнш 32 орон болон Европын парламентаас 170 төлөөлөгч оролцож байна.

Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг нээж УИХ-ын дарга З.Энхболд үг хэлж, Ази, Европын парламентчдын энэ удаагийн уулзалт нь Ази, Европын парламентын түншлэлийн өнгөрсөн 20 жилийн үйл ажиллагааг дүгнэн цэгнэж, дараагийн 10 жилийн ирээдүйгээ тодорхойлон, хамтын ашиг сонирхол, нийтлэг зорилтуудад тулгуурлан өргөн хүрээнд, цогц, гүнзгий агуулга, үр дүнтэй хэлэлцүүлэг өрнүүлнэ гэдэгт итгэж буйгаа илэрхийлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг нээж хэлсэн үгэндээ, Ази, Европын парламентыг төлөөлсөн нэр хүндтэй, хариуцлагатай элч төлөөлөгчид манай оронд айлчлан ирсэнд тун их баяртай байгаагаа илэрхийлээд Ази, Европ хоёр тивийн хувьд бие биенээсээ суралцах, ярилцах, хуваалцах зүйл асар их бий. АСЕМ бол манай хоёр тивийг холбосон яриа хэлцлийн хамгийн чухал механизм гэдгийг онцлов.

Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг нээлтийн арга хэмжээнд Ази, Европын парламентын түншлэлийн 8 дугаар уулзалтыг зохион байгуулсан БНИУ-ын Парламентын Сенатын танхимын дарга Пьетро Грассо үг хэлэв. Ром хотноо 2014 оны 02 дугаар сард зохион байгуулагдсан Ази, Европын парламентын түншлэлийн 8 дугаар уулзалтын буухиаг дамжуулж, ирэх 7 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулагдах Засгийн газар хоорондын чуулга уулзалтын хүрээнд 2014 оны 10 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд болсон чуулганы үр дүнг парламентын түвшинд ярилцах, хэлэлцүүлэгт оролцохыг зорьсон гэдгээ тэрбээр онцлоод Ром хотно батлагдсан Тунхаглал нь хамтын ажиллагааны үндсэн хоёр салбарыг онцлон авч үзсэн талаар дурдав.

Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтын хоёрдугаар салбар хуралдааныг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Унгар Улсын Парламентын дэд дарга Иштван Хиллер нар даргалж, Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтад хүрэлцэн ирсэн улс орнуудын парламентын төлөөлөгчид оролцлоо.

Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтын салбар хуралдаан Төрийн ордны Их танхимд “Үр дүнтэй олон талт харилцаа, хамтын ажиллагаа” сэдвээр үргэлжилж, хуралдааныг Улсын Их Хурлын гишүүн С.Оюун, Бүгд Найрамдах Польш Улсын Сенатын дэд маршал хатагтай Мария Коц нар даргалав.

Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтын Нэгдсэн хоёрдугаар хуралдаан Төрийн ордны хуралдааны Их танхимд эхлэв. Нэгдсэн хоёрдугаар хуралдааныг Ази, Европын парламентын түншлэлийн хуралдааны дэгийн дагуу Монгол Улсын Их Хурлын дарга З.Энхболд даргалав. Нэгдсэн хоёрдугаар хуралдаанаар

“Ази, Европын парламентын түншлэлийн АСЕМ дахь үүрэг оролцоо” гэсэн ерөнхий сэдвийн хүрээнд явагдаж байгаа Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтын хоёр салбар хуралдааны тайланг сонслоо.

“АСЕМ дахь Ази, Европын парламентын түншлэлийн үүрэг оролцоо” сэдвийн дор зохион байгуулагдсан Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалт өндөрлөлөө. Энэ удаагийн уулзалтад Ази, Европын 32 орны болон Европын парламентын 170 төлөөлөгч оролцов. Уулзалтын хүрээнд “Үр дүнтэй олон талт харилцаа, хамтын ажиллагаа”, “Ирээдүйн төлөөх түншлэл” сэдэвт салбар хуралдаанууд болж, парламентын төлөөлөгчид илтгэл танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлэн, санал бодлоо солилцсон юм. Уулзалтаас нийт 44 зүйл бүхий Тунхаглал баталлаа.

Хоёр өдөр үргэлжилсэн уулзалтын арга хэмжээ өндөрлөж, уулзалтыг хааж Монгол Улсын Их Хурлын дарга З.Энхболд үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыгн үр дүнгийн талаар сэтгүүлчдэд дэлгэрэнгүй мэдээлэл хийв. Монгол Улсын Их Хурал Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг эх орондоо анх удаа амжилттай зохион байгуулав. Уулзалтын үр дүнгээр хоёр тивийн хууль тогтоогчид Тунхаглал баталлаа. Энэ удаагийн уулзалтад Ази, Европын 32 орны болон Европын парламентын 170 төлөөлөгч оролцлоо. Парламентын төлөөлөгчид уулзалтын үеэрх нэгдсэн болон салбар хуралдаанууд, хороодын хурлын ажиллагаанд идэвхи, санаачлагатай оролцсоныг Улсын Их Хурлын дарга тэмдэглээд дурдаад дээрх уулзалтууд найрсаг, хамтын ажиллагааны уур амьсгалд болсныг онцлов.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төслийг хэлэлцэж батлав.

2016-04-22

Монгол Улсын Их Хурлын дарга Зандаахүүгийн Энхболдод Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Ерөнхийлөгчийн Хүний эрх, хуулийн бодлогын зөвлөх Ч.Өнөрбаяр өргөн мэдүүлээ.

2016.04.23

Монгол Улсын Их Хурлын дарга Зандаахүүгийн Энхболдын урилгаар Бүгд Найрамдах Итали Улсын парламентын Сенатын танхимын Ерөнхийлөгч Пьетро Грассо 2016 оны 04 дүгээр сарын 21-23-ны өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийв.

2016-04-25

Монгол Улсын Их Хурал Ази, Европын Дээд түвшний 11 дүгээр уулзалт (АСЕМ)-ын хүрээнд Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалт Улаанбаатар хотноо 2016 оны 04 дүгээр сарын 21-нээс 23-ны өдрүүдэд зохион байгуулагдаж амжилттай өндөрлөлөө. Үүнтэй холбогдуулан Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг зохион байгуулах ажлын бэлтгэл хангах үүрэг бүхий Ажлын хэсэг хуралдав.

Хуралдааны эхэнд Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг зохион байгуулах Үндэсний хорооны Ажлын хэсгийн дарга Б.Болдбаатар “Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтын үр дүнгийн талаар танилцууллаа.

Ажлын хэсгийн хуралд Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Үндэсний хорооны Нарийн бичгийн дарга, УИХ-ын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтсийн дарга Ц.Нарантунгалаг болон ажлын хэсгийн гишүүд, бусад албаны хүмүүс оролцов.

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг зохион байгуулах Үндэсний хорооны Ажлын хэсгийн дарга Б.Болдбаатар танилцуулгадаа, “ Энэ оны 4 дүгээр сарын 21-23 -ны өдрүүдэд Монгол Улсад зохион байгуулах АСЕМ -ын дээд хэмжээний уулзалтын хамгийн эхний арга хэмжээ Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалт амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө.

Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан Үндэсний хорооны хуралдаанаар Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтын зохион байгуулалтын талаар ярилцана. Энэ үеэр уулзалтыг зохион байгуулахад гарсан алдаа оноо, сургамж юу байсан талаар тайлан тавих хүсэлт гаргасан. Энэ дагуу хүн болгон хариуцсан чиглэлээрээ дүгнэлт хийж, Үндэсний хорооны Нарийн бичгийн дарга, УИХ-ын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтсийн дарга Ц.Нарантунгалагт өгөх нь зүйтэй.

АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтын хамгийн эхний уулзалт болох Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалт Төрийн ордонд зохион байгуулагдлаа.

Төрийн ордны зарим хэсэгт сүүлийн үед хийгдээгүй байсан засвар үйлчилгээг хийсэн Төр, засгийн үйлчилгээ эрхлэх газар, Төр, засгийн амралт үйлчилгээний цогцолбор газар, Төрийн тусгай хамгаалалтын газар, Улсын Мэргэжлийн хяналтын газар, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ компани, Эрчим хүчний яам зэрэг байгууллагууд идэвхтэй ажиллалаа. Мөн арга хэмжээний бүх интерьер, дизайны ажлуудыг хариуцан зохион байгуулсан “Саунд оф Монголиа” ХХК-ний хамт олон засал чимэглэлийн чиглэлээр сайн ажиллаж, өөрсдийн санаачлагаар нэлээд олон газар “Пресс центр” болон гадаах үйлчилгээ зэрэг төлөвлөгдөөгүй байсан олон зүйлүүдээр туслалцаа үзүүлсэнд талархалтай байна.

Мөн анх удаа уулзалтын арга хэмжээг зохион байгуулахад аюулгүй байдал талаас шинэлэг олон арга хэмжээ авч ажиллалаа. Хамгийн түрүүнд “badge” буюу мандатын шинэлэг технологийн шийдлийг туршсан бөгөөд үүнд Төрийн тусгай хамгаалалтынхан зөв зохион байгуулалттай, шийдлээ олж ажилласан. Мөн гадуур, дотуур хамгаалалт болон нисэх онгоцны буудлаас төлөөлөгчдийг хүлээн авч зочид буудалд байрлуулах үйлчилгээ үзүүлэхэд Гадаад хэргийн яам өндөр зохион байгуулалттай оролцлоо.

Түүнчлэн унаа, автобусны үйлчилгээнд ажилласан Төрийн тусгай хамгаалалтын газар, Цагдаагийн бие бүрэлдэхүүн, Замын цагдаагийн хамт олон, Иргэний харьяа, шилжилт хөдөлгөөний газар, Мэргэжлийн хяналтын газрын хамт олон өндөр зохион байгуулалттай ажиллалаа.

Мөн хурлын үйл ажиллагааг дамжуулж, мэдээлэхэд хэвлэл мэдээллийн байгууллагын 62 сэтгүүлч, зураглаач, гэрэлзурагчид ажилласны зэрэгцээ уулзалтын талаарх мэдээ, мэдээлэл дамжуулах интернэт холболтыг хийж гүйцэтгэхэд Үндэсний Дата төв, Төрийн холбоо, Кибер аюулгүй байдлын газар хүчин чармайлт тавьж ажилласныг энд дурдах нь зүйтэй. Түүнчлэн Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг зохион байгуулахад идэвхтэй оролцож сайн ажилласан

Төрийн ёслолын алба, УИХ-ын Тамгын газар түүний дотор Гадаад харилцааны хэлтэс, Мэдээлэл технологийн хэлтэс, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс

талархал илэрхийлье. Арга хэмжээний хүрээнд сайн зохион байгуулалттай хамтран ажилласан бүх байгууллагад талархал илэрхийлж байна” гэв.

2016.04.26

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импортын банк хооронд байгуулах Зээлийн хэлэлцээрийг зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцэн дэмжиж, энэ талаарх санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр тогтов.

2016-04-28

Монгол Улсын Их Хурлын дарга Зандаахүүгийн Энхболдод Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт Монгол Улсын 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 20018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг өргөн мэдүүллээ.

2016-04-28

Монгол Улсын Их Хурлын дарга Зандаахүүгийн Энхболд Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас гаргасан GMP (Good Manufacturing Practice) стандартад нийцсэн орчин үеийн дэвшилтэт техник, технологиор тоноглогдсон, иж бүрэн цогцолбор эмийн үйлдвэрийн нээлтэд оролцов.

2016-04-28

Монгол Улсын Их Хурлын дарга Зандаахүүгийн Энхболдод Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Н.Батцэрэг Хог хаягдлын тухай /шинэчилсэн найруулга/ болон Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг өргөн мэдүүллээ.

2016-04-28

Монгол Улсын Их Хурлын дарга Зандаахүүгийн Энхболдод Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүллээ.

2016-04-28

Монгол Улсын Их Хурлын дарга Зандаахүүгийн Энхболдод Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин өргөн мэдүүллээ.

2016-04-28

Монгол Улсын Их Хурлын дарга Зандаахүүгийн Энхболдод Киноны тухай болон Хөгжлийн хамтын ажиллагааны тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа өргөн мэдүүлэв.

2016.04.29

Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг зохион байгуулах ажлын

бэлтгэл хангах үүрэг бүхий Үндэсний хороо Монгол Улсад анх удаа зохион байгуулагдсан энэхүү 9 дүгээр уулзалтын зохион байгуулалтын талаар хуралдаж, уулзалтын үр дүнгийн талаарх танилцуулгыг Үндэсний хорооны дарга, Улсын Их Хурлын дэд дарга Р.Гончигдорж хийлээ.

2016-05-02

Улсын Их Хурлын дарга З.Энхболдод манай улсад айлчилж байгаа Япон Улсын парламентын Төлөөлөгчдийн танхимын гишүүн Казунори Танака тэргүүтэй төлөөлөгчидтэй бараалхав.

2016-05-02

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол-Японы парламентын бүлгийн дарга Д.Ганхуягийн урилгаар Япон Улсын парламентын Төлөөлөгчдийн танхимын гишүүн, эрх баригч Либерал ардчилсан намын Гадаад харилцааны газрын дарга Казунори Танака тэргүүтэй төлөөлөгчид манай улсад 2016 оны 4 дүгээр сарын 29 -нөөс 5 дугаар сарын 03-ны өдрүүдэд айлчлав.

2016.05.03

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороо Хог хаягдлын тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд хог хаягдлын төвлөрсөн байгууламж, эсхүл тогтоосон тусгай цэг байгуулах асуудлаар иргэдээс ирүүлсэн өргөдлийн дагуу хэлэлцүүлэг зохион байгуулж, иргэдээс тавьж байгаа гомдол, албан тушаалтнуудаас өгсөн мэдээлэл, Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан саналуудыг үндэслэн Засгийн газарт албан тоот хүргүүлэхээр болов.

2016.05.04

Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 05 дугаар дүгнэлт /Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/ -ийг үргэлжлүүлэн хэлэлцлээ. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг 2016 оны 04 дүгээр сарын 27-ны нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эхэлсэн ч УИХ дахь МАХН – МҮАН -ын “Шударга ёс” эвслийн бүлгээс завсарлага авсан учир хэлэлцүүлгийг хойшлуулаад байсан юм.

Тодруулга

*Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 05 дугаар дүгнэлт буюу сонгуульд жагсаалтаар нэр дэвшихийг хууль зөрчсөн гэсэн цэцийн дүгнэлтийг УИХ-ын чуулганы хуралдаанаар хэлэлцэх үед ТББХорооны санал дүгнэлтийг А.Бакей гишүүн танилцуулсны дараа З.Баянсэлэнгэ гишүүн “Шударга ёс” эвслийн бүлэг энэ асуудлаар тав хоногийн завсарлага авах хүсэлтэй байгаагаа УИХ-ын даргад танилцуулав.*

*“Шударга ёс”-ынхон бүлгийн хуралдаанаараа уг асуудлыг хэлэлцэн нэгдмэл байр суурьтай болох шаардлагатай байгаа тул завсарлага авна гэсэн тайлбарыг З.Баянсэлэнгэ гишүүн хэлсэн.*

*УИХ-ын дарга З.Энхболд “Намууд Сонгуулийн хуулийн дагуу тавдугаар сарын 9-нд нэр дэвшигчдээ тодруулна. Тав хоногийн завсарлага авч болохгүй байна” гэв.*

*УИХ -ын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга А.Бакей “УИХ-ын Дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулсан. Нам, эвслийн бүлэг хуулиар тогтоосон хугацаатай*





*асуудлыг харгалзан завсарлага авна” гэлээ. Гэхдээ УИХ-ын Дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулсан хууль Төрийн мэдээлэл сэтгүүлд хэвлэгдээгүй байгаа аж. Тиймээс одоогоор мөрдөгдөх эхлээгүй байгаа тул УИХ-ын дарга “Завсарлага өглөө. Гэхдээ 5 хоногийн хугацаатай биш. “Шударга ёс” эвсэл бүлгийн хуралдаанаа шуурхай хуралдуулаад үдээс хойш ч хамаагүй асуудлаа оруулж ирэх” –ийг зөвлөв.*

Тухайн асуудлаар гишүүд байр сууриа илэрхийлсний дараа Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 04 дүгээр сарын 22 -ны өдрийн дунд суудлын хуралдаанаас гаргасан Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25 -ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтад “хувь тэнцүүлсэн /пропорциональ/”, 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын 48 -аас илүүгүй гишүүнийг олонхийн сонгуулиар, 28-аас илүүгүй гишүүнийг хувь тэнцүүлэх сонгуулиар тус тус сонгоно.” гэж заасны “... 28 -аас илүүгүй гишүүнийг хувь тэнцүүлэх сонгуулиар ...” гэж заасан нь Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд ... шууд ... сонгоно.”, Хорин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно.” гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн дүгнэлтийн заалт тус бүрээр санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзэж Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 05 дугаар дүгнэлтийн тухай УИХ-ын тогтоолын төслийг баталлаа.

2016-05-04

Улсын Их Хурлын гишүүн Г.Уянга сэтгүүлчдэд мэдээлэл хийв. (2016.5.03 –нд хуралдсан Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэхээр төлөвлөөд байсан зарим асуудлаар Улсын Их Хурал дахь МАН -ын бүлэг 5 хоногийн завсарлага авсан. Хэлэлцэхээр төлөвлөсөн асуудлын жагсаалтад Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгын санал тусгагдсан байв)

Улсын Их Хурлын гишүүн Г.Уянга мэдээлэлдээ, татвар төлөхөөс зайлсхийсэн хэргээр ял шийтгэгдсэн Жастин Каплад Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гарган уучлал үзүүлсэн. Тухайн үед нь би хоёр орны гадаад харилцаатай холбоотой асуудал хэмээн хүндэтгэлтэй хандсан. Жастин Капла нь уучлал үзүүлсний дараа Монгол Улсад учруулсан өрийг төлөх ёстой байсан ч ямар нэгэн байдлаар зувчуулж эхэлсэн.

Саяхнаас энэ өрийг төлөхгүй гэсэн асуудал яригдаж эхэллээ. Монгол Улсын Ерөнхийлөгчийн гаргасан зарлигийг хүчингүй болгох, Монгол Улсын Ерөнхийлөгч Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар Үндсэн хуулийн Цэцэд хандсан асуудлыг Хууль зүйн байнгын хороогоор хэлэлцэх байсан ч МАН-ын бүлэг завсарлага аваад байна. АНУ-ын иргэн Жастин Каплад уучлал үзүүлсэн ч татвар төлөхгүй гэж байгаа нь харамсалтай байна.

Энэ нь Монгол Улсыг доромжилсон, дорд үзсэн явдал юм. Түүнчлэн татварын асуудалтай олон хүмүүс өршөөгдөж болох нь гэсэн ойлголтыг төрүүлж байна. Энэ бол шударга ёсыг үнэгүй болгож байгаа үйлдэл. Иймээс татвараа төлөхгүй гэж үзэж байгаа бол Ерөнхийлөгчийн зарлигийг хүчингүй болгох хэрэгтэй. Иймд энэ асуудлаар авсан завсарлагын хугацаа дуусгавар болмогц үргэлжлүүлэн хэлэлцэж, улмаар чуулганы нэгдсэн хуралдаанаар яаралтай хэлэлцэх шаардлагатай гэлээ. Дараа нь, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянга сэтгүүлчдийн сонирхсон асуултад хариулт өгөв.

2016-05-04

Улсын Их Хурлын гишүүн Д.Тэрбишдагва, Ч.Улаан нар цаг үеийн асуудалтай холбогдуулан хэвлэлийн бага хурал хийж, сэтгүүлчдэд мэдээлэл өгөв.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Улаан хэвлэлийн бага хурлын үеэр хэлэхдээ, Сонгуулийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн талаарх Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 05 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзлээ гээд бидний хувьд цэцийн энэ дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх ёстой гэдэг байр суурийг анхнаас нь хатуу барьж байсан.

Улсын Их Хурал нэгэнт цэцийн дүгнэлтийг хүлээн авсан учраас одоо Үндсэн хуульдаа нийцүүлж, мөнгөнөөс ангид шударга сонгууль явуулах хуулийн зохицуулалтыг яаралтай хийх шаардлагатай болж байна гээд хуулийн шинэ зохицуулалтын талаар өөрийн байр суурийг илэрхийлэв. Хэвлэлийн Бага хурлын үеэр, сонгуулийн холимог тогтолцоог хэвээр хадгалах хуулийн боломж байгааг онцлон дурдав.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Улаан, Д.Тэрбишдагва нар МАХН-ын гишүүнээс, мөн Улсын Их Хурал дахь МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслийн бүлгээс гарах өргөдлөө намын даргадаа өнөөдөр өгч буйгаа мэдэгдэв.

2016-05-04

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Авлигатай тэмцэх газрын даргаар Хүрэлсүхийн Энхжаргалыг томилуулахаар Монгол Улсын Их Хуралд санал хүргүүлжээ.

2016-05-05

Улсын Их Хурлын 2016 оны хаврын ээлжит чуулганы үдээс хойших нэгдсэн хуралдааны эхэнд Улсын Их Хурлын гишүүн Д.Тэрбишдагва, Ч.Улаан нар Улсын Их Хурал дахь МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслийн бүлгээс албан ёсоор гарч буйгаа бичгээр мэдэгдсэнийг Улсын Их Хурлын дарга З.Энхболд гишүүдэд уншиж танилцуулав.

Мөн тэрээр бүлгийн гишүүдийн тоо нь хуульд заасан шаардлагыг хангахгүй болсон тул Улсын Их Хурал дахь МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслийн бүлгийн үйл ажиллагаа өнөөдрөөр албан ёсоор дуусгавар болж буйг мэдэгдлээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэв.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд Сонгуулийн тухай хуулийн 128 дугаар зүйлд “сонгуулийн мөрийн хөтөлбөрийн эдийн засгийн тооцоонд энэ хуулийн 125.2-т заасан хугацаанаас 10 хоногийн өмнө хийсэн төрийн аудитын байгууллагын дүгнэлт” гэсэн агуулгатай 128.3.10 дахь заалт нэмэх, 2 дугаар зүйлд Сонгуулийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.2 дахь хэсгийн “гишүүн” гэсний дараа “тус бүр нэг мандаттай 76 тойргоос” гэж, 128 дугаар зүйлийн 128.8 дахь хэсгийн “нэр дэвшигчдийн” гэсний өмнө “нам, эвслээс” гэж, мөн хэсгийн “бүртгэх” гэсний өмнө “бие даан нэр дэвшигчийн талаарх баримт бичгийг хүлээн авснаас хойш тав хоногийн дотор” гэж нэмэхээр тусгажээ.

Мөн Сонгуулийн тухай хуулийн Сонгуулийн тогтолцоо гэсэн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг “7.1.Сонгууль нь олонхийн /мажоритар/ тогтолцоотой байна” гэж өөрчлөн найруулахаар тусгасан байна. Түүнчлэн хуулийн 85.1.1 дэх заалтыг “85.1.1.намыг Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн он, сар, өдрийг баримтлан, эвслийг түүний бүрэлдэхүүнд



орсон намуудын Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн дарааллын дагуу тэдгээрийн нэр дэвшигчийг” гэж, 126.5.3 дахь заалтыг “126.5.3.энэ хуулийн 126.1-д заасан нэрийн жагсаалтыг гаргахдаа энэ хуулийн 122.1, 126.4-т заасан хуралдаанаар нэр дэвшигч бүрийн авсан саналын тоо, хувиар нь эрэмбэлэн, тойргийн дарааллын дагуу үйлдэх” гэж тус тус өөрчлөн найруулахаар зохицуулжээ. Мөн хуулийн зарим зүйл, заалт, хэсгийг өөрчлөх, хүчингүй болгохоор тусгасан байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү, Д.Тэрбишдагва, З.Баянсэлэнгэ, Л.Эрдэнэчимэг, Г.Уянга, Ч.Улаан, Д.Сарангэрэл нар байнгын хорооны даргаас асуулт тодруулан байр сууриа илэрхийлэв. Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бүхэлд нь батлах санал хураалт явуулахад чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн 72.4 хувь нь дэмжлээ.

Мөн Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн санал авах өдрийг тогтоох тухай Улсын Их Хурлын 2016 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 09 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг батлахыг гишүүдийн 75.9 хувь нь, Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тойрог байгуулах, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай Улсын Их Хурлын 2016 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 11 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай тогтоолын төслийг батлахыг гишүүдийн 75.4 хувь нь дэмжив. Эдгээр хууль тогтоомжийн төслүүдийг батлагдсан өдрөөс нь дагаж мөрдөнө.

2016-05-06

Монгол Улсын Их Хурлын гишүүн, Өргөдлийн байнгын хорооны дарга Ж.Батзандан Зам, тээврийн яам болон Худалдан авах ажиллагааны газрын холбогдох албан тушаалтнуудтай уулзаж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж буй бүтээн байгуулалтын явцтай танилцаж, мэдээлэл авав.

2016-05-06

Улсын Их Хурлын чуулганы үдээс хойшхи хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгээс Хилийн цэргийн 0311-р ангид алба хааж байгаа албан хаагчдаас ирсэн санал, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар Хууль зүйн сайдад тавьсан асуулгын хариуг сонсохоор төлөвлөсөн байв.

Хуралдааны эхэнд УИХ-ын гишүүн Ц.Даваасүрэнгийн асуулгын хариуг өгөх Хууль зүйн сайд Д.Дорлигжав дээрх асуудлыг хаалттай горимоор хэлэлцэх саналтай байгаагаа илэрхийлэв. Тэрбээр, УИХ-ын гишүүний асуулгын хариунд дурдагдах баримтууд Төрийн нууцийн тухай хууль болоод Засгийн газрын нууц тогтоолд хамаарч буйгаас гадна хэлэлцүүлгийн үеэр хувь хүний нууцтай холбоотой асуудал яригдах учир хаалттай горимоор хэлэлцэх шаардлагатай хэмээн тайлбарласан. Ингээд хуралдааныг хаалттай горимд шилжүүлжээ.

2016-05-06

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн өнөөдөр /2016.05.06/ сэтгүүлчдэд мэдээлэл хийв. Тэрээр “Би Хууль зүйн сайдад хандан, Увс аймгийн Баруунтуруун сумын Хилийн цэргийн 0311 дүгээр ангид амь эрсдсэн цэргүүдийн талаар асуулга тавьсан. Энэ дагуу Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Засгийн газрын мэдээллийн

сонсохоор хаалттай хуралдаж байна. Асуулгын зорилго бол тус анги нэгтгэлд Хөвсгөл аймгийн цэргүүдийг алба хаах явдлыг зогсоох биш харин цэргүүдийн нас барсан шалтгааныг тодруулж, цаашид гарч болох эрсдлээс урьдчилан сэргийлэх талаар ярилцах юм. Тиймээс уг асуудлыг хаалттай хэлэлцэх шаардлагагүй гэж би үзэж байна” хэмээн мэдээлэл хийх үеэрээ онцлон тэмдэглэв.

2016-05-11

Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгын оруулсан саналыг хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэнтэй холбогдуулан тэрээр сэтгүүлчдэд мэдээлэл хийв.

Иргэнийхээ хувиар бус Улсын Их Хурлын гишүүний хувиар асуудлыг тавьсан гэдгээ Улсын Их Хурлын гишүүн Г.Уянга мэдээллийн эхэнд онцоллоо. Мөн Улсын Их Хурлын гишүүнийхээ хувиар асуудлыг тавих хангалттай үндэслэл бий. Үндсэн хуулийн 66 дугаар зүйлд “Үндсэн хуулийн Цэц нь Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг Улсын Их Хурлын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ” гэж заасан байдаг. Хоёрдугаарт, Цэц Улсын Их Хурлын хүсэлтээр маргаан хянан шийдвэрлэхдээ дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна гэж заасан.

Иймээс Улсын Их Хурлаас энэ асуудлыг Цэцэд тавиулахаар хандаж, хуулийн дагуу оруулсан. Энэ бол Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд халдаж байгаа зүйл огт биш. Энэ процесс нь Үндсэн хууль зөрчсөн үү үгүй юу гэдгийг тодруулж өгөх асуудлаар Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн Цэцэд хандана уу гэсэн хүсэлт юм. Гэвч Ерөнхийлөгчийн зарлигийг хүчингүй болгох тухай асуудлыг хэлэлцэх нь нээлттэй үлдэж байгаа учраас энэ асуудлыг хэлэлцүүлэхийг шаардана гэлээ.

2016-05-11

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны хуралдаанаар эхлээд Засгийн газрын гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэнд, спортын сайдын үүрэг гүйцэтгэгч Ц.Оюунбаатар Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн Ганхуягийн Шийлэгдамбыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэнд, спортын сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх, Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37.7 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэнд, спортын сайдаар Цэрэнхүүгийн Лхагвасүрэнг томилуулах саналыг тус тус танилцуулсан.

Хуралдааны явцад “.. Ц.Лхагвасүрэн нь эвслийн бүлгээс орж ирсэн нэр дэвшигч. Гэтэл “Шударга ёс” эвслийн бүлэг бүрэлдэхүүнгүй болсон байхад нэр дэвшигчийг ямар субъектээс оруулж ирж байгаа болон эцсийн хариуцлагыг хэн хүлээх вэ” гэсэн асуудал хөндөгдөв.

Гишүүд асуулт асууж, хариулт авсны дараа Ганхуягийн Шийлэгдамбыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэнд, спортын сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх санал хураалт явуулахад 81.8 хувийн саналаар дэмжлээ. Үүний дараа Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэнд, спортын сайдаар Цэрэнхүүгийн Лхагвасүрэнг томилуулах саналыг дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулсныг хуралдаанд оролцсон гишүүдийн 72.1 хувь нь дэмжих боломжгүй гэж үзжээ.

2016-05-11

Монгол Улсын Их Хурлын гишүүн, Өргөдлийн байнгын хорооны дарга Ж.Батзандан Олон улсын эрэн сурвалжлах сэтгүүл зүйн нийгэмлэгийн цахим хуудаст Панамын баримт бичиг хэмээх мэдээллийг олон нийтэд байрлуулсантай холбогдуулан хэвлэлийн мэдээлэл хийлээ. Тэрээр, Панам Улсын Моссак Фонсека хуулийн фирмийн уг баримт бичигт Монгол Улсын улс төрийн болон төрийн захиргааны удирдах албан тушаалтнууд, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эзэмшдэг оффшор дансны талаарх мэдээлэл үнэн зөв эсэхийг шалгуулах, бодит мэдээлэл өгөх, хариуцлага тооцоолуулах талаар иргэдээс санал, хүсэлт ирүүлж байна гэж мэдээллийн эхэнд тэмдэглэсэн юм.

Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь хэсэгт Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах этгээдүүд хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах бөгөөд өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй гэж заасан байдаг. Түүнчлэн, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Албан тушаалын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт”-ын 3.2.6 -д хадгаламж, бэлэн мөнгө, хувийн харилцах болон төлбөрийн данс, картын үлдэгдэл /гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллагад байгаа бүх төрлийн данс, картын үлдэгдэл/-ийг мэдүүлэхээр заасан байгаа тул нийт төрийн албан хаагчид, тэдгээрийн хамаарал бүхий этгээдүүдийн оффшор дансны мэдээлэл, түүнд хадгалагдаж байгаа хөрөнгийн хэмжээг хөрөнгө, орлогын мэдүүлэгт тусгасан байх шаардлагатай юм гэлээ.

Иймд, Авлигын эсрэг хуульд заасан бүрэн эрх, чиг үүргийн хүрээнд Панамын баримт бичигт оффшор данс эзэмшдэг хэмээн дурдагдсан Монгол Улсын улс төрийн болон төрийн захиргааны удирдах албан тушаалтнууд, тэдгээрийн гэр бүлийн гишүүд, хамаарал бүхий этгээдүүдийн мэдээлэл албан тушаалтнуудын гаргасан хөрөнгө орлогын мэдүүлэгтэй нийцэж байгаа эсэхийг шалгаж, шаардлагатай тохиолдолд хэрэг үүсгэж мөрдөн шалгах, хариуцлага тооцох арга хэмжээг шуурхай авч ажиллах албан тоотыг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж буйгаа мэдэгдэв.

2016-05-12

Улсын Их Хурлын 2016 оны хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаан 17 цаг 28 минутад 51.3 хувийн ирцтэй эхлэв. Чуулганы нэгдсэн хуралдааны эхэнд Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс албан бичиг ирүүлж Улсын Их Хурлын гишүүн Н.Батцэрэг, М.Сономпил нар тус намын бүлэгт нэгдэж орохоо илэрхийлснийг гишүүдэд танилцуулаад ингэснээр Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг 37 гишүүнтэй болж буйг мэдэгдлээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэв.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дарга

С.Бямбацогт уг тогтоолын төслийг байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх явцад сонгуулийн зарим тойрог байгуулах, тойргийн нутаг дэвсгэрийг хуваарилахдаа хүн амын тоо, нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгжийг харгалзах хуулийн зарчмыг үл тоомсорлон сонгогчдын эрх ашгийг зөрчихөд хүргэсэн гэж үзэж буйгаа хэлээд энэ асуудлыг эргэн харах боломж олгохыг хүсэв.

Харин хуралдаан даргалагч сонгууль болохоос 45 хоногийн өмнө сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, нутаг дэвсгэр, төвийг тогтоосон байх хуулийн хугацаа дуусах гэж байгаа учраас тогтоолыг яаралтай хэлэлцэж шийдвэрлэх шаардлагатайг сануулаад Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэ зохицуулалтын дагуу хуулиар шийдвэрлэх хугацааг тусгайлан заасан асуудлаар нам, эвслийн бүлэг завсарлага авах бол хуралдаан даргалагч тухайн асуудлыг хуулиар тогтоосон хугацаанд нь шийдвэрлэхэд саад болохгүй байхаар завсарлагын хугацааг тогтоохоор заасныг үндэслэн 18 цаг хүртэл завсарлага өгч буйгаа мэдэгдсэн юм. 18 цаг 13 минутаас чуулганы нэгдсэн хуралдаан үргэлжилж, тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Бакей танилцуулав.

Хэлэлцүүлгийн явцад Улсын Их Хурлын гишүүн Ч.Улаан, С.Бямбацогт нар Сүхбаатар аймгийн 2 тойргийг 1 тойрог болгох асуудлаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан Хөвсгөл аймгийн тойргийн нутаг дэвсгэрийн хуваарилалттай холбоотой асуудлаар цөөнх болсон байна. Мөн хэлэлцэж буй асуудлаар Улсын Их Хурал дахь МАН-ын бүлэг завсарлага авах хүсэлт гаргасан боловч Сонгуулийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4.6 дахь хэсгийг баримтлан хуралдаан даргалагч завсарлага өгөх боломжгүйг мэдэгджээ.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Дашдорж, Д.Хаянхярваа, Л.Энх-Амгалан, Ж.Энхбаяр, Ё.Отгонбаяр, Су.Батболд, О.Баасанхүү, Ж.Батсуурь, Ц.Нямдорж, Ч.Улаан, Д.Тэрбишдагва, Ө.Энхтүвшин, Н.Номтойбаяр, Я.Содбаатар, О.Содбилэг, Д.Лүндээжанцан, Н.Батбаяр, Д.Оюунхорол, Б.Гарамгайбаатар, М.Энхболд, С.Бямбацогт, Х.Тэмүүжин, С.Дэмбэрэл, Л.Болд, Н.Энхболд, З.Баянсэлэнгэ, Ч.Хүрэлбаатар, Б.Бат-Эрдэнэ, Р.Гончигдорж, Ц.Оюунбаатар нар асуулт асууж тодруулан үг хэлж байр сууриа илэрхийлэв.

Ингээд байнгын хорооны саналаар “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулахад чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон 63 гишүүний 39 нь буюу 61.9 хувь нь дэмжсэнээр тогтоолын төсөл батлагдлаа. Уг тогтоолын төслийг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө. Ингэснээр Улсын Их Хурал “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай” асуудлыг хуулийн хугацаанд нь багтаан хэлэлцэж шийдвэрлэлээ.

Тогтоолын төсөл батлагдсанаар Улсын Их Хурлын сонгуулийн 76 мандатын 48-ыг нь аймгуудад, 28-ыг нь нийслэлд хуваарилахаар болж байна. Ингэхдээ Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Сүхбаатар аймгууд тус бүр 1, Дорнод, Завхан, Өмнөговь аймгууд тус бүр 2, Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Дархан-Уул, Орхон аймгууд тус бүр 3 мандаттай. Харин нийслэлийн тойргуудын тухайд Багануур дүүргийг Сүхбаатар дүүргийн сонгуулийн тойрогтой нэгтгэж мандатын тоог 1-ээр нэмж 4 болгох, Багахангай дүүргийг Хан-

Уул дүүргийн сонгуулийн 56 дугаар тойрогт нэгтгэж тойргийн мандатын тоог 4 байсан хэвээр нь үлдээх, Налайх дүүргийг Чингэлтэй дүүргийн сонгуулийн 63 дугаар тойрогтой нэгтгэж тойргийн мандатын тоог 4 байсан хэвээр нь үлдээхээр болов. Харин нийслэлийн Баянгол дүүргийн сонгуулийн тойрог 4 мандаттай, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн сонгуулийн тойргууд тус бүр 6 мандаттай байхаар болж байгаа юм. Мөн Завхан, Ховд, Хөвсгөл зэрэг аймгийн сонгуулийн тойргуудын нутаг дэвсгэрийн хуваарилалтад зарим өөрчлөлт оруулсан байна.

2016-05-12

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунгэрэл Америкийн Нэгдсэн Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд хатагтай Женифер Зимдал Галтыг хүсэлтийнх нь дагуу хүлээн авч уулзав.

Уулзалтын эхэнд Элчин сайд хатагтай Женифер Зимдал Галт Сонгуулийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулсан талаар мэдээлэл авах, мөн цаг үеийн бусад асуудлаар сонирхож буйгаа дуулгав. Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунгэрэл Сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулсан талаар танилцуулж, шинэчилсэн найруулгаар намын жагсаалтыг хасч, жижиг 76 тойргоор сонгуулиа явуулахаар болоод байгаа төдийгүй уг хуульд өөрчлөлт орсноор эмэгтэйчүүдэд халтай тусч, квотыг 20 хүртэл хувь болгож бууруулсан болохыг мэдээлэв.

Мөн ирэх 9 дүгээр сарын 01-нээс хүчин төгөлдөр болох Эрүүгийн хууль болон холбогдох бусад хуулиуд, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар ярилцаж, санал солилцлоо. Үүний дараа Элчин сайд хатагтай Женифер Зимдал Галт Урьдчилан хорих ангид саатуулагдаж буй иргэн Б.Булганы талаар асууж, иргэний эрх Монгол Улсад хэрхэн хэрэгжиж буй тухай тодруулсан юм. Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунгэрэл хэлэхдээ, өнгөрсөн 4 дүгээр сарын 13-ны өдөр Улсын Их Хурлын гишүүн Л.Болдын хамт Төв аймаг дахь Урьдчилан хорих ангид очиж, иргэн Б.Булгантай биечлэн уулзсан талаар болон энэ хэрэг маш нууц зэрэглэлд шалгагдаж байгааг мэдэгдэв.

2016.05.13

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Засгийн газраас малчдын талаар авсан арга хэмжээ болон малчны зээлийн хүүг бууруулж байгаа ажлын талаархи Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг сонслоо.

Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуулийн төслүүд, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийж баталлаа.

Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл, Хууль сахиулах ажиллагааны тухай болон холбогдох бусад хуулийн төслүүд, “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт”-ийн тухай тогтоолын төслийг хэлэлцэж батлав. Мөн “Хөгжлийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг батлав.

Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дарга Д.Батцогт Эрүүл мэнд, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Ламбаа, Сангийн яамны төсвийн зарлагын хэлтсийн дарга О.Хуягцогт, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын газрын дарга Л.Мөнхзул, Эрүүл мэндийн бодлогын

хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Энхболд болон эмч, мэргэжилтнүүдтэй уулзаж ажлын хэсгээс өнгөрсөн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажлын явц байдал, үр дүнгийн талаар сонсч харилцан ярилцав.

2016-05-13

Монгол Улсын Их Хурлын дэд дарга Л.Цог хэвлэлийн бага хурал хийж, цаг үеийн асуудлаар сэтгүүлчдэд мэдээлэл өгөв. Хэвлэлийн хурлын эхэнд Улсын Их Хурлын дэд дарга Л.Цог хэлэхдээ, сүүлийн үед хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдан олон нийтийг түгшээж буй оффшор дансны асуудлаар, тэр дунд Улсын Их Хурлын гишүүд, сайд нарын нэр холбогдож байна.

Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогтын оффшор бүсийн дансан дахь 1 сая ам.долларын эх үүсвэрийг шалгуулах албан ёсны хүсэлтээ Монгол Улсын Ерөнхий прокурор, Хууль зүйн сайд, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар зэрэг хуулийн байгууллагуудад хүргүүлнэ гэв. Түүнчлэн уг асуудлыг шалгах явцад өөрийн биеэр хяналт тавьж ажиллахаа дуулгасан юм. Тэрээр “Уг асуудлыг шалгах явцад би хяналт тавина, шаардана. Хэрэв шалгахгүй, хааж, хаацайлах юм бол хүрэх газар хаа байна, тэр хүртэл тэмцэнэ гэж бодож байна. Тун тодорхой асуудал учраас үүнийг хуулийн байгууллагаас шударгаар шалгах нь зүйтэй” гэв.

2016-05-13

Монгол Улсын Их Хурлын дэд дарга Р.Гончигдоржид Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батбаяр өргөн мэдүүлэв.

Монгол Улсын хувьд олон улсын түвшинд зээлжих зэрэглэл ахин арилжааны нөхцөлтэй зээл болон санхүүгийн бүх хэрэгслийг ашиглах боломжтой болсон ч өр, зээлийн талаар нэгдсэн цогц бодлого, зохицуулалтгүй, хууль, эрх зүйн орчны хувьд зөвхөн буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийн зохицуулалтаар хязгаарлагдаж байсан тул Засгийн газрын зүгээс өрийн удирдлагын нэгдсэн бодлого, зохицуулалтыг хангасан бие даасан хууль гаргах шаардлага үүссэн. Иймд Улсын Их Хурлаас 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдөр Өрийн удирдлагын тухай хуулийг баталсан болохыг Улсын Их Хурлын гишүүн Н.Батбаяр тэмдэглэв.

Сүүлийн үед өрийн асуудлаар улс төржих болж, цахим сүлжээ, мэдээллийн хэрэгслээр иргэд олон нийтийн дунд Засгийн газар, улсын нийт гадаад өртэй холбоотой буруу, сөрөг ойлголтыг төрүүлж, олон нийтийг төөрөгдүүлж байгаатай холбогдуулж өрийн тухай асуудлаар нэгдсэн ойлголтод хүрэх нь цаг үеийн тулгамдсан асуудал болж байна хэмээн үзэж, уг хуулийн төслийг боловсруулжээ. Түүнчлэн нийгэмд хурцадмал болсон өр зээлийн асуудлын талаар эдийн засгийн болон улс төрийн хувьд ялгаж салгах, нийгэмд зөв ойлголттой болох хэрэгтэй хэмээн үзсэн байна.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батбаяр хэлэхдээ, “Өр” гэдэг ойлголтыг “өглөг” гэдгээр сольж, Өрийн удирдлагын тухай хуулийг “Өглөгийн удирдлагын тухай” хууль гэж өөрчлөлт оруулах нь зүйтэй. Учир нь “Өр” гэж хугацаандаа төлж чадахгүй байгаа өглөгийг хэлдэг. “Өглөг” гэж гэрээнд заасны дагуу тодорхой хугацаанд төлөгдөж байгаа хүү, үндсэн төлбөр болон холбогдох бусад төлбөрийн үүрэг юм гэлээ. Иймд, хуулийн нэр томъёонд өөрчлөлт оруулж, өглөг гэсэн шинэ нэр томъёог хэрэглэх, холбогдох хууль тогтоомжуудад өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гараад байна хэмээн Улсын Их Хурлын дэд дарга Р.Гончигдоржид танилцууллаа.



2016-05-13

УИХ-ын чуулганы үдээс хойшхи нэгдсэн хуралдаанаар Засгийн газраас малчдын талаар авсан арга хэмжээ болон малчны зээлийн хүүг бууруулж байгаа ажлын талаархи Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг сонслоо.

Ерөнхий сайдын мэдээллийг дараа Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийлээ. Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Д.Ганбат танилцуулав. Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан асуулт асуух гишүүн гараагүй бөгөөд Байнгын хороогоор дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудаар санал хураалт явуулан хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон холбогдох хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн баталлаа.

2016-05-14

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар жил бүрийн тав, аравдугаар сарын хоёр дахь долоо хоногийн Бямба гарагийг “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” хэмээн зарласан бөгөөд энэ өдөр бүх нийтээр байгаль эхээ дээдлэх үзлийг түгээн дэлгэрүүлж, мод тарих, ногоожуулах хөдөлгөөнийг олон нийтийн үйлс болгон сурталчилдаг билээ. Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр тохиож байгаа бөгөөд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнууд мод тарьж төгөл байгуулав. Улсын Их Хурлын дарга З.Энхболд, УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б. Болдбаатар нар энэхүү арга хэмжээнд оролцов.

2016-05-16

Монгол Улсын Их Хурлын гишүүн, Өргөдлийн байнгын хорооны дарга Ж.Батзандан Нийслэлийн Баянзүрх дүүргийн 14 дүгээр сургуулийн барилгын асуудал гурван жил саатаж буйтай холбогдуулан ажил хариуцаж буй албаны хүмүүс болон тус сургуулийн удирдлагыг хүлээн авч уулзав.

2016-05-16

УИХ-ын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Ганбат, УИХ-ын гишүүн Л.Болд, Ц.Оюунгэрэл, Х.Тэмүүжин, Хууль зүйн сайд Д.Дорлигжав нар өнөөдөр хэвлэлийн бага хурал хийн, шинээр батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хуулийн талаар сэтгүүлчдэд мэдээлэл хийлээ.

2016-05-17

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар Прокурорын байгууллагын тухай / шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ. Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Ганбат танилцуулав.

Хууль зүйн байнгын хороо 2016 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар Прокурорын байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгийг хийж хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, зарим өөрчлөлт оруулах саналыг нэгдсэн хуралдаанд оруулж байна хэмээн Байнгын хорооны дарга танилцуулгадаа дурдсан. Тухайлбал,

Прокурорын байгууллагын дэргэдэх прокурорын чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх алба Улсын ерөнхий прокурорын газрын дэргэд байх, прокурорын аюулгүй байдлыг Тахарын алба хангах, прокурорын нийгмийн баталгаатай холбогдох зарим заалтыг Төрийн албаны тухай хуулиар зохицуулахаар өөрчлөх, хуулийн төсөлд заасан нэр томъёог Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Хууль сахиулах ажиллагааны тухай хуульд нийцүүлэн өөрчлөх зэрэг саналыг төсөлд тусгажээ.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан УИХ-ын гишүүн Д.Тэрбишдагва асуулт асуусан. Тэрбээр, прокурор өөрийн гаргасан шийдвэрээ оролцогч талд тайлбарлахгүй гэдэг. Хохирогч ямар үндэслэлээр шийдвэр гаргасан талаар тайлбар авахыг хүсдэг. Хуульд энэ талаар хэрхэн тусгасан бэ хэмээн лавласан.

Хууль зүйн сайд Д.Дорлигжав, Прокурор гаргасан шийдвэрээ тайлбарлахгүй гэж хуульд байхгүй. Гарсан шийдвэрээ оролцогчдод өгнө, оролцогч хүсвэл тайлбар өгнө. Харин прокурор гаргасан шийдвэрийнхээ талаар хэн нэгэн албан тушаалтны өмнө тайлбарлах албагүй юм хэмээн хариулсан юм. Үүний дараа Хууль зүйн байнгын хороогоор дэмжигдсэн зарчмын зөрүүтэй болон найруулгын шинжтэй саналын томъёоллуудаар санал хураалт явуулж дуусан, хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв. Мөн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай болон холбогдох бусад хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ. Дараа нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийв.

Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн өмнөх “Монгол Улсын эдийн засаг, санхүү, төсвийн төлөв байдлын талаарх мэдээлэл”-ийг энэ өдрийн хуралдаанаар сонслоо. Мэдээллийг Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Б.Болор хийв. Тэрбээр, Монгол Улсын эдийн засаг 2012-2015 онд дунджаар 8.6 хувь өслөө. Энэхүү өсөлтөд уул уурхайн салбар, хөдөө аж ахуйн салбарт гарсан өсөлт голлон нөлөөлсөн бөгөөд Оюутолгойн ил уурхайн олборлолт тогтворжсон, газрын тосны олборлолт жил тутам 40 орчим хувиар өссөн, мал сүргийн тоо 56 сая толгойд хүрсэн зэрэг нь нөлөөлсөн байна. Сүүлийн жилүүдэд дэлхийн эдийн засгийн өсөлт удааширч, манай улсын худалдааны гол түнш БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарсан, эрдэс бүтээгдэхүүний үнэ буурсан тул макро эдийн засагт учирч болох эрсдлээс сэргийлж, төсвийн бодлогод шинэчлэл хийж, 2014 оноос төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлсэн.

Энэ хүрээнд үр ашиг багатай, тэвчиж болох бараа, үйлчилгээний зардлыг 5-30 хувь хүртэл бууруулах, захиргааны удирдах тушаалын дэд сайд, орлогч буюу дэд дарга нарын орон тоог цомхотгох, чиг үүргийн давхардлыг арилгаж, төрийн байгууллагуудад бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгоход чиглэсэн төсвийн бодлогыг хэрэгжүүлснээр төсвийн зарлагын огцом өсөлтийг хязгаарлаад байна гэлээ.

2016-05-17

Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү хэвлэлийн бага хурал хийж, сэтгүүлчдэд мэдээлэл өгөв. Тэрээр Улсын Их Хурлын гишүүнээр болон Өргөдлийн байнгын хорооны даргаар ажиллах хугацаандаа хийж, хэрэгжүүлсэн ажлаа иргэдэд тайлагнаж байгаа хэмээн мэдээллээ.

Энэ ажлын хүрээнд тэрээр Орхон аймагт ажилласан байна. Мөн Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү хэвлэлийн хурлын үеэр зарим хэвлэл мэдээллийн хэрэгслээр түүнтэй холбоотой мэдээ, мэдээлэл гарч, нэр төрд нь халдаж байгааг тогтоолгох зорилгоор хууль хяналтын байгууллагуудад хандана гэдгээ сэтгүүлчдэд мэдэгдлээ.

хэмээн Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсээс мэдээлэв.

2016-05-17

Монгол Улсын Их Хурлын дарга Зандаахүүгийн Энхболдод “Таван толгойн нүүрсний ордыг ашиглах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын нэр бүхий 40 гишүүн санаачлан боловсруулсныг Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэг өргөн мэдүүлэв. Тогтоолын төсөл батлагдснаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн дараах үр дагавар бий болно. Үүнд:

- Тавантолгойн нүүрсний ордыг ашиглахаар уралдаант шалгаруулалтанд ялсан Консорциумтай байгуулахаар төлөвлөсөн Хамтын ажиллагааны гэрээ, Хөрөнгө оруулалтын гэрээ, Төмөр замын концессийн гэрээнүүдийг үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхолд харш заалтуудыг өөрчилж, гэрээний талуудын эрх тэгш байдлыг хангах, Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжид нийцүүлэх боломж бүрдэнэ.
- “Эрдэнэс Тавантолгой” ХК-д 2,558,175,510 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа Монгол улсын 2,475,201 иргэн болон 8,497,671 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа Монгол улсын 553 аж ахуйн нэгжийн хувьцааг эдийн засгийн эргэлтэд оруулах, тэдний ашиг сонирхол, эрх ашгийг хангасан арга хэмжээ авах боломж бүрдэнэ.
- Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах Улсын Их Хурлын 2010 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 39 дүгээр тогтоолд заасан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 20 хүртлэх хувийг дотоодын болон гадаадын хөрөнгийн биржээр худалдаж шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах арга хэмжээг авах боломж бүрдэнэ.
- Засгийн газрын Ажлын хэсэг Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах хэлэлцээр хийж Хөрөнгө оруулалтын гэрээ болон дагалдах гэрээний төслийг бэлтгэхдээ баримтлах үндсэн зарчим, удирдамжтай болно.
- Тавантолгойн нүүрсний ордыг ашиглахдаа Монгол улсын гадаад бодлогод баримтлаж буй Гуравдагч хөршийн бодит оролцоо, хөрөнгө оруулалтыг хангах нөхцөл бүрдэнэ.
- Цанхийн хэсгийг хөгжүүлэх, Ухаа худаг-Гашуунсухайт чиглэл болон Тавантолгой-Сайншанд-Хөөт-Чойбалсан-Эрэнцав зэрэг бусад чиглэлийн төмөр замын суурь бүтэц барих асуудлыг шийдвэрлэнэ. Мөн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн тусгай зөвшөөрөл бүхий Бортолгой, Бортээг, Оорцог, Онч-Хараат зэрэг талбайг ашиглах асуудал цогцоор шийдэгдэнэ.
- Хөрөнгө оруулалтын гэрээ болон бусад дагалдах гэрээг Монгол улсын эрх ашгийг хангасан нөхцлөөр амжилттай байгуулах, Тавантолгойн нүүрсний ордыг хөрөнгө оруулагчтай хамтран ашиглах төслөөс Монгол Улсын хүртэх үр ашгийг дээшлүүлэх, улмаар улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах нөхцөл бүрдэнэ; гэж үзжээ.

2016-05-18

Уулзалтын эхэнд Улсын Их Хурлын дарга, Арабын Нэгдсэн Эмират Улсаас Монгол Улсад суух анхны суурин Элчин сайдаар томилогдсонд эрхэмсэг ноён Абдуллад баяр хүргэв.

Монгол Улсад Элчин сайдын яам нээх Эмират Улсын Засгийн газрын шийдвэрийг талархан хүлээн авсан болохыг дурдаад, энэхүү шийдвэр нь тус улсаас хоёр талын

харилцаа, хамтын ажиллагаанд ач холбогдол өгч буйн илрэл хэмээн үзэж буйгаа илэрхийлсэн юм.

Улсын Их Хурлын дарга Монгол Улс Эмират Улстай улс төрийн найрсаг сайн харилцааг хөгжүүлж ирснийг дурдаад, шинээр байгуулагдсан Элчин сайдын яам хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа, түүний дотор хууль тогтоох байгууллагуудын хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулна гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлсэн юм. Түүнчлэн Монгол, Эмиратын харилцаа хамтын ажиллагаа улс төр, эдийн засгийн салбарт төдийгүй бусад олон салбарт хөгжих боломжтой хэмээн үзэж буйгаа тэмдэглэн хэлэв.

2016-05-18

УИХ-ын гишүүн Ц.Оюунгэрэл ХБНГУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Герхард Тийдеманныг хүлээн авч уулзав.

2016.05.19

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар “Тогтоолуудад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлав. Уг тогтоолын төсөл батлагдсанаар “Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2011 оны 30 дугаар тогтоол болон “Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2012 оны 74 дүгээр тогтоолд тусгасан “... хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд...” гэсэн томъёоллоос “...хоршооны гишүүн...” гэснийг хасахаар болж байгаа юм.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн “Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүс байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулийн төслүүдийг хэлэлцэж батлав.

2016-05-19

Монгол Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Ганбат, Улсын Их Хурлын гишүүн, Өргөдлийн байнгын хорооны дарга Ж.Батзандан нар Дэлхийн банк, Олон улсын санхүүгийн корпорацийн Санхүү ба зах зээл хөтөлбөрийн Ази, Номхон далайн бүс хариуцсан захирал Женнифер Исерн, Монгол дахь Дэлхийн банк, Олон улсын санхүүгийн корпорацийн Улаанбаатар хотод суугаа суурин төлөөлөгч Туен Нгуен нарыг хүлээн авч уулзав.

2016.05.20

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны эхэнд Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэж, Г.Шийлэгдамбыг Засгийн газрын гишүүн-Эрүүл мэнд, спортын сайдын үүрэгт ажлаас чөлөөлөв.

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулах “Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл”-ийн зээлийн хэлэлцээр, Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулах “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт”-



ийн зээлийн хэлэлцээрийг тус тус соёрхон батлах тухай хуулийн төслийг баталлаа.

“Ялтан шилжүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлав.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, Прокурорын байгууллагын тухай /Шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийж баталлаа.

Улсын Их Хурлын чуулганы үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Н.Батбаяраас Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг сонсов.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар Засгийн газрын гишүүнийг томилох тухай асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэж С.Ламбааг Засгийн газрын гишүүн-Эрүүл мэнд, спортын сайдаар томилов.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батбаярын санаачилсан Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлаас Улсын Их Хурал дахь МАН-ын бүлэг 5 хоногийн завсарлага авлаа.

Прокурорын байгууллагын тухай /Шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийв.

Хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураахад, тухайлбал, Улсын ерөнхий прокурор, түүний тусгайлан эрх олгосон прокурор эрэн сурвалжлах нууц ажиллагаа, мөрдөн шалгах нууц ажиллагаа, гүйцэтгэх ажилд ямар байдлаар хяналт тавих, Прокурор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Хууль сахиулах ажиллагааны тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасан бүрэн эрхээс гадна ямар бүрэн эрхтэй байх зэрэг асуудлыг зохицуулсан “Эрэн сурвалжлах нууц ажиллагаа, мөрдөн шалгах нууц ажиллагаа, гүйцэтгэх ажилд хяналт тавих прокурорын бүрэн эрх” гэсэн зүйлийг, мөн хуулийг 2016 оны 09 дүгээр сарын 01 -ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тогтоох зэрэг саналууд гишүүдийн олонхийн дэмжлэг авав.

“Прокурорын байгууллагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ баталсантай холбогдуулан прокурорын албан тушаалын цалингийн сүлжээ, нэмэгдлийн хэмжээг тогтоохтой холбогдсон хууль тогтоомжийн төслийг хуульд заасан журмын дагуу боловсруулж, 2016 оны 06 дугаар сарын 01 -ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг ”Прокурорын байгууллагын тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тогтоолоор Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/, Улсын ерөнхий прокурор /М.Энх-Амгалан/-г даалгах” гэсэн саналын томъёолол дэмжигдлээ.

Прокурорын байгууллагын тухай /Шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг баталснаар 4 жилийн өмнө эхэлсэн хуулийн системийн өөрчлөлт шинэчлэл үндсэндээ дуусаж байна; гэж Улсын Их Хурлын дарга З.Энхболд онцлон тэмдэглэв.

2016-05-23

Монгол Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооноос Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулахаар Засгийн газарт өгсөн чиглэлийн хэрэгжилтийн талаарх асуудлаар холбогдох албан тушаалтнууд, иргэдтэй

хийх уулзалт-хэлэлцүүлгийг Төрийн ордон дахь Нээлттэй сонголын танхимд зохион байгуулав.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Улсын Их Хурлын чуулганыг түр завсарлуулах тухай 62 тоот захирамж гаргав. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 29 дүгээр зүйлийн 29.14 дэх хэсэг, Улсын Их Хурлын даргын дэргэдэх Зөвлөлийн саналыг харгалзан Монгол Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагаатай холбогдуулан Улсын Их Хурлын чуулганыг 2016 оны 6 дугаар сарын 23-ны өдрийг хүртэл түр завсарлуулахаар уг захирамжид дурджээ.

УИХ –ын чуулганы 2016.5.24 –ны өдрийн нэгдсэн хуралдаанаар доорхи асуудлуудыг хэлэлцэхээр төлөвлөсөн байв. Үүнд:

- “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2016.04.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/;
- Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2016.04.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд / Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин 2016.04.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/;
- Малын генетик нөөцийн тухай /шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулийн төслүүд /Засгийн газар 2015.07.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/;
- Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт оруулах тухай болон холбогдох бусад хуулийн төслүүд /Засгийн газар 2016.01.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2016.04.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/;
- Дэмпингийн тухай болон холбогдох бусад хуулийн төслүүд /Засгийн газар 2016.05.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/;
- Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2016.04.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/.

2016-05-24

Монгол Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороо Усны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаарх иргэдийн өргөдлийг судлан тус байнгын хороогоор хэлэлцүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийн тайланг сонсов.

2016-05-26

Улсын Их Хурлын дарга Зандаахүүгийн Энхболд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бундестагийн гишүүн, Бундестаг дахь Христосын Ардчилсан Холбоо намын бүлгийн дарга Герда Хассельфелдт, Бундестагийн гишүүн, Бундестаг дахь Христосын Ардчилсан Холбоо намын бүлгийн дэд дарга Макс Штраубингер нарыг хүлээн авч уулзав.



2016-05-26

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороо бага, дунд ангийн багш нарын нийгмийн баталгааны талаар уулзалт - хэлэлцүүлэг зохион байгуулав.

2016-05-29

Монгол Улсын Их Хурлын дарга Зандаахүүгийн Энхболдод өнөөдөр /2016.05.29/ Америкийн Нэгдсэн Улсын Конгрессын төлөөлөгчдийн танхимын Ардчиллын түншлэлийн хөтөлбөрийн дарга, төлөөлөгчдийн танхимын гишүүн Питр Роскам тэргүүтэй Конгрессын гишүүд бараалхав.

2016-05-30

Монгол Улсын Их Хурал, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр хамтран “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь”, “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх “ төслүүдийг 2013 оны 3 дугаар сараас эхлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд эдгээр төслүүдийн удирдах зөвлөлийн 2016 оны эхний хагас жилийн хурал боллоо.

2016-05-31

Улсын Их Хурлын дарга Зандаахүүгийн Энхболдод УИХ-ын гишүүн, Сангийн сайд Б.Болор Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын нэг тэрбум ам.долларын экспортын зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг, мөн, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн барив. Мөн, Улсын Их Хурлын дарга Зандаахүүгийн Энхболдод Засгийн газрын гишүүн, Эрүүл мэнд, спортын сайд С.Ламбаа Эмнэлгийн мэргэжилтний хариуцлагын даатгалын тухай хуулийн төслийг, мөн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг, “Прокурорын албан тушаалын цалингийн хэмжээ, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг тогтоох тухай” УИХ -ын тогтоолын төслийг мэдүүлэв.

2016-06-01

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Монголынхоо нийт хүүхэд, багачуудад баярын мэндчилгээ дэвшүүлж үг хэлэв.

2016.06.01-03

УИХ-ын дарга З.Энхболд тэргүүтэй Монголын парламентын төлөөлөгчид 2016 оны 06 дугаар сарын 01-03-ны өдрүүдэд Япон Улсад ажлын айлчлал хийв. Ажлын айлчлалын үеэр УИХ-ын дарга З.Энхболд Япон Улсын Парламентын Төлөөлөгчдийн танхимын дарга Т.Ошима, Зөвлөхүүдийн Танхимын дарга М.Ямазаки, Ерөнхий сайд Шинзо Абе нартай уулзаж санал солилцов. Мөн Монгол Улсын Хөдөлмөрийн яам, Япон Улсын Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн халамжийн яам хоорондын “Хөдөлмөрийн салбар дахь хамтын ажиллагааны санамж бичиг”-т гарын үсэг зурах ёслолд оролцлоо. Улсын Их Хурлын дарга З.Энхболдын Япон Улсад хийсэн ажлын айлчлалын бүрэлдэхүүнд УИХ-ын гишүүн, Монгол-Японы парламентын бүлгийн дэд дарга Д.Ганбат, УИХ-ын гишүүн, Хөдөлмөрийн сайд Г.Баярсайхан, Засгийн газрын гишүүн, Уул уурхайн сайд Р.Жигжид, УИХ-ын даргын зөвлөх Ц.Буянцогтоо, Б.Баярсайхан болон албаны бусад хүмүүс оржээ.

2016.6.03

Улсын Их Хурлын дарга Чингис хаан олон улсын нисэх буудалд газардмагцаа айлчлалын бүрэлдэхүүнд багтсан Улсын Их Хурлын гишүүн, Монгол-Японы парламентын бүлгийн дэд дарга Д.Ганбат, Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөрийн сайд Г.Баярсайхан, Уул уурхайн сайд Р.Жигжид болон Дадлагажигч ажилтны шилжилт хөдөлгөөний төвийн дарга Ш.Батдэлгэр нарын хамтаар мэдээлэл хийв.

2016.06.04

УИХ-ын дарга З.Энхболд “Хааны эрэлд-2016” олон улсын энхийг дэмжих ажиллагааны хээрийн сургалт, дадлагын хаалтын ажиллагаанд оролцож үг хэлэв. Тэрээр, Монгол Улс энхийг эрхэмлэсэн олон тулгуурт нээлттэй гадаад бодлогын хүрээнд Монгол Улсын Зэвсэгт хүчин, Номхон далай дахь АНУ-ын цэргийн командлал, “Дэлхийн энхийн төлөө санаачилга” хөтөлбөртэй хамтран “Хааны эрэлд” олон улсын энхийг сахиулах ажиллагааны сургалт, дадлагыг уламжлал болгон зохион явуулж ирсэн болохыг онцлоод “Хааны эрэлд-2016” олон улсын энхийг сахиулах ажиллагааны хээрийн сургалт, дадлагад оролцогчдод талархал дэвшүүлээ.

2016.06.06

УИХ-аар Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль батлагдаж, 2016 оны 06 дугаар сарын 03 -ны өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, Эрүүл мэнд, спортын яам хамтарч уг хуулийг хүлээн авах хүндэтгэлийн арга хэмжээг Төрийн ордонд зохион байгуулав. Уг арга хэмжээг нээж УИХ-ын дарга З.Энхболд хэлсэн үг хэллээ.

Өргөдлийн байнгын хорооны дарга Ж.Батзандан, УИХ-ын гишүүн Д.Сарангэрэл нар Зэвсэгт хүчний 326 дугаар ангид ажиллаж, уулзалт хэлэлцүүлэг хийв. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн холбогдох заалтыг боловсронгуй болгох талаар судалж, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр хэлэлцэн Байнгын хороонд танилцуулах чиглэлийг Засгийн газарт өгснийг Байнгын хорооны дарга энэ үеэр танилцуулаад УИХ-аар хэлэлцэж буй батлан хамгаалах салбарын багц хуулиудын төслийн хүрээнд хийгдэж буй шинэчлэлийн талаар мэдээлэл өгөв.

2016-06-08

Улсын Их Хурлын дарга З. Энхболд “Сайн хашаа” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч компаниудын үзэсгэлэнг сонирхов.

2016-06-09

Улсын Их Хурлын дарга Зандаахүүгийн Энхболд “Бондын бүтээн байгуулалт” сэдэвт хэлэлцүүлгийн нээлтэд оролцов.

2016-06-09

УИХ -ын гишүүн Д.Дэмбэрэл, Су.Батболд, Ж.Батсуурь, Ё.Отгонбаяр нар “Эрдэнэс Таван толгой” хувьцаат компанийн иргэдэд үнэ төлбөргүй эзэмшүүлсэн 1072 хувьцааг мөнгөжүүлэх асуудлаар УИХ -ын тогтоолын төсөл боловсруулснаа Засгийн газарт хүргүүлээ.Иргэдэд эзэмшүүлсэн 1072 хувьцааг нэг ширхгийн нэрлэсэн үнэ 933 төгрөгөөр үнэлэн 1 сая төгрөгөөр худалдан авах ажлыг зохион байгуулах даалгаврыг Засгийн газарт үүрэг болгохыг тогтоол санаачлагчид санал болгожээ.





Иргэн бүрт олгосон 1072 ширхэг хувьцаа буюу нийт 3 тэрбум хувьцааг мөнгөжүүлэх арга хэмжээ авснаар хувьцаа эзэмшигч нийт 1.5 сая иргэд, түүний дотор цалин, тэтгэвэр, арилжааны зээлтэй байгаа 971 мянган иргэний тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд тус нэмэр болно гэж тогтоол санаачлагчид үзсэн байна. Тогтоолын төслийг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар яаралтай хэлэлцүүлэхийг нэр бүхий хууль санаачлагч нар хүссэн байна.

2016.06.10

УИХ-ын дарга З.Энхболд манай улсад зохиогдож байгаа Ази, Евродын Сангийн сайд нарын уулзалтад оролцож буй Дэлхийн банкны дэд ерөнхийлөгч Викториа Кваква тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.

Монгол Улсын иргэдэд эзэмшүүлсэн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 1072 ширхэг хувьцааны 30 хувийг худалдаж авах шийдвэрийг Засгийн газраас гаргасантай холбогдуулан УИХ -ын гишүүн, “Сайн хувьцаа” арга хэмжээг хэрэгжүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулах ажлын хэсгийн ахлагч Н.Батбаяр сэтгүүлчдэд мэдээлэл өгөв.

2016-06-10

УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэг, М.Батчимэг, З.Баянсэлэнгэ, Ц.Оюунгэрэл, Г.Уянга, Д.Сарангэрэл нар хэвлэлийн бага хурал хийн, УИХ дахь эмэгтэй гишүүдийн өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд хамтран хийсэн ажлын талаар сэтгүүлчдэд мэдээлэв<sup>4</sup>.

УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэг, 2012 оны УИХ-ын сонгуулиар парламентад улс төрийн таван намын төлөөлөл бүхий 11 эмэгтэй гишүүн сонгогдож, эмэгтэйчүүд хууль тогтоох, бодлого тодорхойлох, шийдвэр гаргах түвшинд үзэл бодлоо хүргэх, нийгэмд тулгамдсан олон эмзэг асуудлыг шийдвэрлэх боломжтой болсон хэмээн мэдээллийн эхэнд онцолсон. Тэрбээр, парламентад эмэгтэйчүүдийн тоо 11 болж нэмэгдсэн нь сайн үзүүлэлт боловч 76 дотор 11 гэдэг бол дэндүү цөөхөн гээд хэдий тийм ч эмэгтэй гишүүд хамтран болон хувь гишүүнийхээ хувиар олон хууль тогтоолын төслүүдийг өргөн барьж, ажлын хэсгийг ахлан ажиллаж, хууль, тогтоолуудаа батлуулж чадлаа гэж хэлсэн юм.

Өнгөрсөн 4 жилийн хугацаанд эмэгтэй гишүүд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай, Тамхины хяналтын тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Соёлын тухай, Хог хаягдлын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Монгол хэлний тухай, Түрээсийн тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай, Тосон бумбын нурууг тусгай хамгаалалтад авах тухай, Органик хүнсний тухай зэрэг хууль, тогтоолын төслүүд дээр хамтран ажилласан талаар УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэг мэдээлэлдээ дурдсан.

Түүнчлэн эмэгтэй гишүүд дөрвөн жилийн хугацаанд Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамтай нягт хамтран ажиллаж, улсын төсөв болон гадаадын урт хугацааны зээл, тусламжаар сургууль, дотуур байрны хөрөнгө оруулалтыг эрс нэмэгдүүлэхэд онцгой

<sup>4</sup> Парламентын эмэгтэй гишүүд 2012 - 2016 онд их төлөв нийгмийн чиглэлтэй олон талт асуудлаар УИХ дотор албан бус бүтэц үүсгэнлобби бүлэг хэлбэрээр идэвхтэй ажиллаж ирсэн юм. Хэвлэлийн хурлаар парламентын эмэгтэй гишүүд хийсэн ажлаа олон нийтэд “тайлагнасан” тул холбогдох мэдээллийг энд зориуд дэлгэрэнгүй тусгав. (Эмхтгэгч)

анхаарал тавьж ажилласнаар урд жилүүдээс хамаагүй олон тооны сургууль, цэцэрлэг, дотуур байр, хүүхдийн эмнэлгийн асуудлыг шийдсэн гэж тэрбээр хэлсэн. Улсын хэмжээнд нийт 152 цэцэрлэг, цэцэрлэгийн өргөтгөл баригдсан байна.

Бүх хүүхдээ цэцэрлэгт хамруулахын тулд шинээр барих шаардлагатай 800 цэцэрлэгийн хөрөнгө оруулалтад нэг их наяд төгрөг шаардлагатай байгаа бөгөөд энэ нь Монгол Улсын нийт төсвийн 30 гаруй хувийг эзлэх хэмжээний хөрөнгө. Нэгэнт төсвийн хөрөнгөөр нэг дор бүгдийг шийдэх боломжгүй учраас эмэгтэй гишүүд асуудлыг шийдвэрлэх өөр арга зам хайж Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийг санаачлан боловсруулж, УИХ-ын чуулганаар батлуулан өнөөдөр хэрэгжээд явж байгааг мөн дуулгасан.

УИХ дахь эмэгтэй гишүүд нам харгалзалгүй эв нэгдэлтэй ажиллаж чадсан хэмээн дуу нэгтэй хэвлэлийн бага хуралд оролцсон гишүүд мэдэгдсэн бөгөөд санаачилсан хууль, тогтоолын төслүүдийг батлуулахад амар байгаагүй ч хариуцлагатай улс төрийн төлөө, хүн рүү чиглэсэн асуудлыг шийдвэрлэхийн төлөө дуу хоолойгоо нэгтгэсний дүнд амжилтад хүрч чадсан гэж мэдэгдсэн юм.

Тухайлбал, ахмадын тэтгэвэр нэмэх, одонтой эхчүүдийн мөнгө, малчдын тэтгэврийн нас зэрэг ахмад настны нийгмийн хамгааллын чиглэлээр шийдвэр гаргах түвшинд эмэгтэй гишүүд ахмадын нэрийн өмнөөс байнга дуу хоолой болж Хамтын тэтгэврийн тухай хуулийн гол санаачлагчаар ажиллаж батлуулсан. 2015 оны УИХ-ын намрын чуулганаар Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай мөн Хүүхдийн эрхийн тухай хуулийг батлуулсан хэмээлээ.

2012 оноос эхлэн Гэр бүлийн хүчирхийллийн асуудлыг нийгэмд гаргаж тавин онцгой анхаарал хандуулж, НҮБ болон олон улсын байгууллагуудтай хамтран нийтийн анхаарлыг хандуулж, арав гаруй жил нэг ч удаа хэрэгжиж чадаагүй Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлуулсан талаар гишүүд онцолж байлаа.

2012-2016 оны УИХ-ын бүрэн эрхийн хугацаанд Соёл, спорт, аялал жуулчлалын сайдаар Ц.Оюунгэрэл, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдаар С.Оюун, Д.Оюунхорол, Эрүүл мэндийн сайдаар Н.Удвал, Барилга, хот байгуулалтын сайдаар З.Баянсэлэнгэ, Хүнс, хөдөө аж ахуйн сайдаар Р.Бурмаа, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Л.Эрдэнэчимэг нар ажиллан, УИХ дахь эмэгтэй гишүүд энэ салбаруудын хууль эрхзүй болон хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах чиглэлд дэмжлэг үзүүлж хамтран ажиллаж байгааг мөн дурджээ.

2016-06-10

УИХ-ын гишүүн Д.Ганхуяг хэвлэлийн бага хурал хийж, малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх тухай хуулийн төслийг боловсруулан Засгийн газартай зөвшилцөөд санал авахаар хүргүүлээ хэмээн сэтгүүлчдэд мэдээлэв. УИХ-ын гишүүн Д.Ганхуягийн санаачилсан хуулийн төсөл батлагдвал 2001-2016 онд нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй байгаа 260 мянга орчим малчин иргэд нийгмийн даатгалын шимтгэлээ нөхөн төлөх арга хэмжээнд хамрагдаж, ирээдүйд тэтгэвэр авах боломжтой болох юм.

\*\*\*

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТОЙМ**

Монгол Улсын байнгын ажиллагаатай анхны парлам ент болох Улсын Бага Хурал байгуулагдахад хууль тогтоох байгууллагын гадаад харилцааны асуудлыг Улсын Бага Хурлын гадаад харилцааны асуудал эрхэлсэн нэг зөвлөгч хариуцан ажиллах болсноор Тамгын газрын энэ чиг үүргийг хариуцсан бүтцийн нэгжийн үүсэл тавигджээ. Улмаар 1992 оноос Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын зохион байгуулалтын бүтцэд Улсын Их Хурал, түүний Тамгын газрын гадаад харилцаа, хамтын ажиллагааны асуудлыг дагнан хариуцаж ажилладаг бие даасан хэлтэс ажиллаж ирсэн.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтэс нь Улсын Их Хурал, түүний Тамгын газар, Монголын Парламентын Бүлгэм /МПБ/-ээс гадаад орнуудын хууль тогтоох дээд байгууллага, тэдгээрийн Тамгын газар, парламентын бүлгүүд, Олон Улсын Парламентын Холбоо /ОУПХ/, тус холбооны дэргэдэх Ерөнхий нарийн бичгийн дарга нарын холбоо, олон улсын болон бүс нутгийн парламентын байгууллагуудтай харилцах, хамтран ажиллах асуудлыг холбогдох хууль тогтоомж, гэрээ, хэлэлцээрийн үндсэн дээр зохион байгуулах бүхий л үйл ажиллагааг хэрэгжүүлэх үндсэн чиг үүргийг гүйцэтгэдэг.

Улсын Их Хурлын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтэс нь Улсын Их Хурал, Монголын парламентын Бүлгэмийн гадаад арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж холбогдох айлчлал, арга хэмжээг бүхэлд нь хариуцаж зохион байгуулдаг.

Улсын Их Хурлын гишүүн Монгол Улсын Их Хурал, Монголын Парламентын Бүлгэмийн шугамаар гадаадад айлчлал хийх, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын хийх төрийн болон албан ёсны айлчлалын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орж айлчлах, олон улсын хурал, зөвлөгөөн болон бусад арга хэмжээнд оролцох, өөрийн сонгогдсон тойргийн болон хувийн ажлаар явах, амрах, эмчлүүлэх зорилгоор гадаадад явахад Улсын Их Хурлын даргын захирамжаар батлагдсан “Монгол Улсын Их Хурлын гишүүн гадаадад явахад мөрдөх журам”-ыг мөрддөг.

Монголын Парламентын Бүлгэмийн үйл ажиллагаа

Монголын парламентын Бүлгэм (МПБ) нь Олон улсын парламентын холбоо (ОУПХ)-ны дүрмийг хүлээн зөвшөөрч, түүний дагуу Монгол Улсын Их Хуралд байгуулагдсан үндэсний бүлгэм бөгөөд Улсын Их Хурлын гишүүдийн сайн дурын олон нийтийн байгууллага юм. Монголын парламентын Бүлгэмийн дүрмийг зөвшөөрч, МПБ-ийн гишүүн болох саналаа илэрхийлсэн Монгол Улсын Их Хурлын гишүүн МПБ-ийн гишүүн болдог.

МПБ нь бусад орны хууль тогтоох байгууллагууд болон хоёр талын парламент хоорондын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, ОУПХ болон олон улсын бусад парламентын байгууллагуудаас парламентын ардчиллыг хөгжүүлэх, үйл ажиллагааны арга хэрэгслийг бэхжүүлэх, боловсронгуй болгох, түүнчлэн дэлхийн энх тайван, аюулгүй байдлын төлөө олон улсын хамтын хүчин чармайлтыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаанд оролцох үндсэн чиг үүрэгтэй.

МПБ-ийн өдөр тутмын үйл ажиллагааг Улсын Их Хурлын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтэс эрхлэн явуулж, МПБ-ийн Гүйцэтгэх хороо хяналт тавьдаг. МПБ-ийн дүрэмд заасны дагуу Гүйцэтгэх хороо нь дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга болон гишүүдээс бүрдэнэ. Гүйцэтгэх хороо нь МПБ-ийн ажлын төлөвлөгөөг батлах, ОУПХ-ны ээлжит бага хурал, тус холбооны Зөвлөлийн хурлуудад оролцох төлөөлөгчдийн бэлтгэлийг хангах, тэднийг томилоход саналаа оруулах, МПБ-ийн шугамаар бусад орноос ирэх төлөөлөгчдийн

айлчлалыг хэрэгжүүлэх, ОУПХ-ны тогтоол, шийдвэрийг гишүүдэд танилцуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, шаардлагатай асуудал болон тогтоолын талаар холбогдох байгууллагуудад санал тавих, ОУПХ болон бусад орны парламентын бүлгэм, олон улсын парламентын бусад байгууллагатай харилцаа тогтоож хамтран ажиллах, олон улсын цаг үеийн шаардлагатай зарим асуудлаар МПБ-ийн байр суурийг илэрхийлж байх зэрэг үндсэн үүрэг гүйцэтгэдэг. МПБ -ийн Гүйцэтгэх хорооны даргаар,

- 1990 - 1992 онд Улсын Бага Хурлын гишүүн агсан С.Зориг
- 1992 - 1996 онд Улсын Их Хурлын дарга Н.Багабанди
- 1996 - 2000 онд Улсын Их Хурлын дэд дарга Ц.Элбэгдорж
- 2000 - 2004 онд Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бямбадорж
- 2004 - 2008 онд Улсын Их Хурлын гишүүн К.Сайраан
- 2008 - 2012 онд Улсын Их Хурлын дэд дарга Н.Энхболд, Г.Батхүү нар (хоёр жилээр ээлжлэн)
- 2012 - 2013 онд Улсын Их Хурлын дэд дарга С.Баярцогт
- 2013 - 2016 онд Улсын Их Хурлын дэд дарга Р.Гончигдорж нар тус тус ажиллажээ.

Монгол Улсын Их Хурлын 2012 оны сонгуулийн дараа Улсын Их Хуралд шинээр байгуулагдсан МПБ-ийн Гүйцэтгэх хорооны дэд даргаар Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэг, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Улсын Их Хурал дахь МАХН-МАН-ын “Шударга ёс” эвслийн бүлгийн дарга Н.Батцэрэг нар сонгогдон ажилласан.

#### Улсын Их Хурлын олон талт хамтын ажиллагаа

Монгол Улсын Их Хурал нь олон талт хамтын ажиллагааны хүрээнд Олон Улсын Парламентын Холбоо, Ази-Номхон далайн парламентын чуулган, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Парламентын чуулганд, НАТО-гийн парламентын чуулган зэрэг бүс нутгий болон олон улсын парламентын байгууллагад гишүүнээр элсэж, үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцож иржээ.

#### Олон Улсын Парламентын Холбоо

Тус холбоо нь тусгаар тогтносон улс орнуудын парламентуудыг нэгтгэсэн олон улсын байгууллага бөгөөд 1889 онд Парис хотноо байгуулагдсан. Олон Улсын Парламентын Холбоо нь 163 гишүүнтэй бөгөөд бүс нутгийн парламентын 10 байгууллага хавсарга гишүүнээр ажилладаг.

Олон Улсын Парламентын Холбооны Ассамблей нь улс төрийн асуудлаар тус холбооны байр суурийг илэрхийлдэг гол чуулган юм. Ассамблей нь жилд хоёр удаа хавар, намар хуралддаг. Ассамблейн гол ажиллагаа Энх тайван, олон улсын аюулгүй байдлын асуудлаарх нэгдүгээр хороо, Тогтвортой хөгжил, санхүү, худалдааны асуудлаарх хоёрдугаар хороо, Ардчилал, хүний эрхийн асуудлаарх гуравдугаар хороодод явагдаж, эдгээр хороодын саналын дагуу тогтоол баталдаг.

Монгол Улсын Их Хурал 1962 онд тус байгууллагын гишүүнээр элссэнээс хойш ОУПХ-ны үйл ажиллагаанд идэвхтэй оролцож хавар, намрын нийт 78 удаагийн Ассамблейд оролцсон байна. Улсын Их Хурлын гишүүдээс Л.Болд, Н.Энхболд нар ОУПХ-ны Гүйцэтгэх хорооны гишүүнээр, Д.Алтай, Д.Туяа нар ОУПХ-ны Эмэгтэй парламентчдын зохицуулах хорооны гишүүнээр, К.Сайраан ОУПХ-ны Ойрхи Дорнодын асуудал эрхэлсэн хорооны гишүүнээр тус тус сонгогдон ажиллаж байжээ. Эмэгтэй парламентчдын уулзалт нь 1999 оноос албан ёсоор

тус холбооны нэг нэгж болжээ. Тус холбоо нь Парламентчдын Хүний эрхийн хороо, Ойрхи Дорнодын асуудлын хороо, Киприйн асуудлыг зохицуулах хэсэг, Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг хүндэтгэх явдлыг хөхиүлэн дэмжих хороо, ОУПХ-НҮБ-ын хамтын ажиллагааны бүлэг, ХДВХ/ДОХ-ын асуудлаарх бүлэг, Жендерийн түншлэлийн бүлэг зэрэг бүрэлдэхүүн хэсгүүдтэй.

#### Ази-Номхон далайн парламентын чуулган

Япон Улсын Ерөнхий сайд Ясухиро Накасонэгийн санаачилгаар Ази-Номхон далайн бүс нутгийн 15 орны парламентын 57 төлөөлөгч 1993 оны 1 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд Токио хотноо цуглаж тус бүс нутгийн улс орнуудыг “нэгэн томоохон гэр бүл” болгох зорилгоор Ази-Номхон далайн парламентын чуулган /АНДПЧ/ гэдэг байгууллагыг анх байгуулжээ.

Монгол Улсын Их Хурлын төлөөлөгчид анх 1994 онд Ази-Номхон далайн парламентын чуулганд оролцсоноос хойш байнгын хамтын ажиллагаатай болжээ. АНДПЧ нь аль нэг гишүүн оронд жилд нэг удаа хуралдаж парламентчдад Ази-Номхон далайн бүс нутагт тулгарч буй сорилтууд, нийтлэг ашиг сонирхол, дэлхий дахины тулгамдсан асуудлын талаар хэлэлцэх, бодлого боловсруулах талаар харилцан туршлага солилцох, бүс нутгийн интеграц, эдийн засгийн өсөлтөөс улбаалан гарч буй улс төр, нийгэм, соёлын хөгжлийн өөрчлөлтийг шүүн хэлэлцдэг.

Ази-Номхон далайн парламентын 19 дүгээр чуулган Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо 2011 оны 1 дүгээр сарын 23-наас 27-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, 17 гишүүн орны 223 төлөөлөгч, ажиглагч хоёр орны төлөөлөгч оролцсон. Өдгөө Австрали, АНУ, БНХАУ, БНСУ, БНАЛАУ, БНСВУ, Камбож, Канад, Коста Рика, Колумб, Индонез, Малайз, Маршалын арлууд, Мексик, Микронез, Монгол Улс, ОХУ, Сингапур, Тайланд, Папуа Шинэ Гвиней, Перу, Филиппин, Фижи, Чили, Шинэ Зеланд, Эквадор, Япон зэрэг 27 орон энэ байгууллагын гишүүн юм.

#### Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Парламентын чуулган

Монгол Улс 2012 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага /ЕАБХАБ/-ын бүрэн эрхт гишүүнээр элссэнээр тус байгууллагын Парламентын чуулганы гишүүн болсон.

ЕАБХАБ-ын Парламентын чуулган нь тус байгууллагын гишүүн 57 улсын парламент хоорондын яриа хэлэлцээний гол механизм бөгөөд эдгээр улсын парламентуудын төлөөлөл болсон 323 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулдаг байна. Жил бүр гишүүн орнуудад ээлжлэн зохион байгуулагддаг Парламентын ээлжит чуулганы үеэр цаг үеийн тулгамдсан асуудал болон ЕАБХАБ-ын үйл ажиллагааны талаар тунхаг бичиг гаргадаг. Чуулганы төв байр Данийн Вант Улсын нийслэл Копенгаген хотноо байрладаг.

ЕАБХАБ-ын Парламентын чуулганы ээлжит хурал жил бүрийн долдугаар сарын эхээр хуралддаг. Чуулганы холбогдох байнгын хорооны шийдвэрт үндэслэн гишүүн орнуудад ногдох гишүүдийн тоог тогтоодог агаад дүрэмд заасны дагуу Монгол Улсын Их Хурлаас 3 гишүүн тус чуулганы гишүүн болж, үйл ажиллагаанд оролцдог.

Монгол Улсын Их Хуралд ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейтай харилцах бүлэг байгуулагдаж, идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. Тус бүлгийн даргаар Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэг ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурал ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн үйл ажиллагаанд идэвхтэй

оролцож, хувь нэмэр оруулах үүднээс ЕАБХАБ ын Парламентын Ассамблейн 2015 оны намрын хурлыг 2015 оны 9 дүгээр сарын 15-наас 19-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулсан.

#### НАТО -гийн Парламентын чуулган

НАТО-гийн Умард Атлантын зөвлөл “Монгол Улс-НАТО хоорондын түншлэл, хамтын ажиллагааны тусгай хөтөлбөр”-ийг 2012 оны 3 дугаар сарын 19-ний өдөр баталснаар Монгол Улс НАТО-гийн түнш орны статустай болсон.

Умард Атлантын эвслийн орнуудын парламент хоорондын зөвлөлдөх механизм болох НАТО-гийн Парламентын чуулган нь 1955 онд байгуулагджээ. Парламентын чуулган НАТО-гийн гишүүн болон түншлэгч орнуудын хууль тогтоогчдын харилцан яриа, зөвшилцөлийн индэр болж, НАТО-гийн бодлого, хувьсан өөрчлөгдөж буй аюулгүй байдлын ойлголтыг гишүүн орнуудын парламент болон олон нийтэд танилцуулах, дэмжлэг авахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

НАТО-гийн Парламентын чуулган жилд хоёр удаа хуралдаж, салбар хороодын тайланг хэлэлцэн бодлогын асуудлаар зөвлөмж гаргаж, санал хураан Умард Атлантын зөвлөлд хүргүүлдэг юм. НАТО-гийн гишүүн 28 улс нь тус байгууллагын бүрэн эрхт гишүүн юм. Парламентын чуулган нь парламентын 257 гишүүнээс бүрддэг бөгөөд эдгээр нь гишүүн орны үндэсний парламентын гишүүд байдаг.

#### АЕПТ-ийн 9 дүгээр уулзалт

Ази-Европын Парламентын Түншлэл /АЕПТ/-ийн уулзалт нь Ази болон Европын орнуудын хууль тогтоох байгууллагуудын хамтын ажиллагааны чухал бүтэц юм. АЕПТ-ийн уулзалт нь 2 жил тутамд АСЕМ-ын Дээд түвшний уулзалтын өмнө Ази-Европын гишүүн орнуудад ээлжлэн зохион байгуулагддаг.

Энэхүү уулзалт нь өөрийн дэгтэй бөгөөд уулзалт бүр гишүүн орнууд зөвшилцөн тогтсон тодорхой сэдвийн хүрээнд явагддаг. Нэгдсэн хуралдаанаас гадна салбар хуралдаанууд эдийн засаг, улс төр, нийгэм-соёл гэсэн АСЕМ-ын үндсэн гурван тулгуур чиглэлээр илтгэл, хэлэлцүүлэг хэлбэрээр явагддаг.

АЕПТ-ийн 9 дүгээр уулзалт 2016 оны 4 дүгээр сарын 21-нээс 23-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж, нэгдсэн хуралдаан “Ази-Европын Парламентын Түншлэлийн АСЕМ дахь үүрэг оролцоо”, салбар хоёр хуралдаан “Үр дүнтэй олон талт харилцаа, хамтын ажиллагаа”, “Ирээдүйн төлөөх түншлэл” сэдвээр явагдаж, гишүүн 32 орон болон Европын Парламентаас нийт 156 төлөөлөгч оролцсон.

Дэгийн дагуу АЕПТ-ийн 9 дүгээр уулзалтын төгсгөлд АСЕМ-ын Дээд түвшний 11 дүгээр уулзалтад танилцуулагдах, АЕПТ-ийн үүрэг болон хоёр тивийн цаашдын хамтын ажиллагаанд гүйцэтгэх парламентчдын үүрэг, оролцоог тусгасан Тунхаг бичиг батлагдсан.

#### Улсын Их Хурлын гадаад хамтын ажиллагааны тухай зарим тоон үзүүлэлт

Парламентын тэргүүний айлчлал			Парламентын дэд даргын айлчлал		
Он	Дотоодод	Гадаадад	Он	Дотоодод	Гадаадад
1992	2	9	1992	1	7
1993	-	2			

1994	2	4		1994	2	-
1996	1	5		1996	-	-
1997	4	4				
2000	2	3		2000	-	2
2001	2	2		2001	1	2
2002	2	7		2002	2	3
2003	4	7		2003	1	2
2004	4	6		2004	4	3
2005	4	6		2005	-	3
2006	4	6		2006	3	2
2007	3	3		2007	1	1
2008	7	2		2008	-	1
2009	2	1		2009	3	4
2010	4	4		2010	1	1
2011	3	2		2011	1	2
2012	4	1		2012	-	3
2013	9	4		2013	3	10
2014	5	2		2014	3	3
2015	1	3		2015	-	-
2016	2	1		2016	-	1
Нийт:	71	83		Нийт:	26	50

\*\*\*

Парламентын бүлгэмийн айлчлалууд			Парламентын Тамгын газрын даргын айлчлал		
Он	Дотоодод	Гадаадад	Он	Дотоодод	Гадаадад
2000	1	3	1996	-	1
2001	2	5	2001	1	2
2002	5	4	2002	4	3
2003	3	6			
2004	4	3	2004	5	3
2005	4	7	2005	1	7
2006	5	8	2006	3	3
2007	8	6	2007	3	4
2008	2	3	2008	2	1
2009	5	6	2009	3	4

2010	2	9		2010	1	5
2011	4	7		2011	2	5
2012	1	3		2012	1	3
2013	5	3		2013	-	3
2014	3	6		2014	4	6
2015	1	6		2015	-	1
2016	1	1		2016		
Нийт:	56	86		Нийт:	30	51

Улсын Их Хурлын гишүүдийн гадаадад явсан тухай мэдээллийг долоо хоног тутам шинэчилж гаргадаг. Баримт жагсаалтаас үзэхэд давхардсан тоогоор Улсын Их Хурлын гишүүд давхардсан тоогоор 2008 онд 73, 2009 онд 177, 2010 онд 220, 2011 онд 173, 2012 онд 115, 2013 онд 256, 2014 онд 156, 2015 онд 91, 2016 оны 6 дугаар сарын байдлаар 17 удаа гадаад арга хэмжээнд оролцсон байна.

#### Улсын Их Хурлын Тамгын газрын гадаад харилцаа

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар нь Улсын Их Хурлын гишүүдэд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх, Улсын Их Хурлын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгох, Тамгын газрын ажилтнуудын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх, парламентын тогтолцооны удаан жилийн түүхтэй орнуудаас туршлага судлан үйл ажиллагаандаа тусгах зорилгын хүрээнд гадаад орнуудын парламентын Тамгын газрууд, олон улсын байгууллагуудтай харилцаа, хамтын ажиллагаа тогтоон хөгжүүлж ирсэн билээ.

Сүүлийн арав гаруй жилийн хугацаанд Улсын Их Хурлын Тамгын газар нь 20 гаруй орны парламентын Тамгын газрын 40 гаруй удаагийн төлөөлөгчдийг хүлээн авч айлчлалыг амжилттай зохион байгуулан харилцаа, хамтын ажиллагаагаа идэвхтэй хөгжүүлж байна.

Улсын Их Хурлын Тамгын газрын төлөөлөгчид гадаад орнуудын парламент, олон улсын байгууллагад туршлага судлах, солилцох, парламентын үйл ажиллагааг боловсронгуй болгох, Тамгын газрын чадавхийг дээшлүүлэх хүрээнд гадаад орны парламентын Тамгын газарт дадлага хийх, англи хэлний сургалтад хамрагдах чиглэлээр 30 орчим улсад 60 гаруй удаа туршлага судлах, танилцах аялалд оролцжээ. Түүнчлэн Тамгын газрын ажилтнууд гадаадын парламентын Тамгын газар, олон улсын байгууллагуудаас зохион байгуулсан 30 гаруй удаагийн сургалт, семинарт оролцож мэргэжил, мэдлэгээ дээшлүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар нь ОХУ, БНХАУ, БНЭУ, ХБНГУ, БНАЛАУ, БНСВУ, БНСУ, БНЧУ, БНПУ, БНТУ, ДВУ, ОХУ-ын БНБУ зэрэг орнуудын хууль тогтоох байгууллагуудын Тамгын газруудтай хамтран ажиллах протоколыг 24 удаа байгуулж, төлөөлөгчид солилцох, хууль эрх зүйн мэдээллээ солилцох, техникийн туслалцаа харилцан үзүүлэх зэрэг хэлбэрээр идэвхтэй хамтран ажилладаг.

Улсын Их Хурлын Тамгын газар НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, АНУ-ын Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, Азийн сан, АНУ-ын Конгрессын дэргэдэх Ардчиллын түншлэлийн байгууллага, Швейцарийн Хөгжлийн агентлаг, ХБНГУ-ын Ханс Зайделийн сан, Фридрих Эбертийн сан, БНСУ-ын КОИКА олон улсын хамтын ажиллагааны агентлаг, БНТУ-ын Засгийн газрын дэргэдэх Олон улсын хамтын ажиллагааны зохицуулагч агентлаг /ТИКА/ зэрэг олон



улсын байгууллага болон Дэлхийн банк, Олон улсын валютын сангийн Улаанбаатар хот дахь Төлөөлөгчийн газруудтай нягт хамтран ажиллаж, Улсын Их Хурлын үйл ажиллагааг боловсронгуй болгох, Тамгын газрын чадавхийг бэхжүүлэх чиглэлээр хамтарсан төсөл хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал, БНСУ-ын КОИКА олон улсын хамтын ажиллагааны агентлагтай хамтран Улсын Их Хурлын архивыг цахим хэлбэрт оруулах, орчин үеийн техник төхөөрөмжөөр хангах болон “Цахим парламент” төсөл, ТИКА-гийн тусламжаар “Монгол Улсын Их Хурлын Цахим номын сан” болон “Хэвлэх цехийн тоног төхөөрөмжийн шинэчлэл” төслийг амжилттай хэрэгжүүлсэн.

Мөн Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь”, “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслүүдийг амжилттай хэрэгжүүлж байна.

\* \* \*

## УЛСЫН ИХ ХУРЛЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ ҮЙЛ ЯВДЛЫН ТОЙМ

(2012-2016)

2012-2016 онд хэрэгжүүлсэн гадаад, дотоод айлчлал, арга хэмжээнүүд нь Улсын Их Хурлын гадаад орнуудын хууль тогтоох дээд байгууллагуудтай харилцах харилцаа, хамтын ажиллагааг бүх түвшинд өргөжүүлэх, уламжлалт тогтсон хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн тодорхой түвшинд ахиулах, парламентын Байнгын хороо, Монголын Парламентын Бүлгэм, Тамгын газрууд хоорондын харилцааг өргөжүүлэхэд чиглэгдсэн төдийгүй Монгол Улсын гадаад харилцаа, хамтын ажиллагаанд чухал ач холбогдолтой болсон юм.

Улсын Их Хурлын даргын захирамжаар 2012 онд 40, 2013 онд 256, 2014 онд 156, 2015 онд 91 гадаад айлчлал, олон улсын хурал, семинар, танилцах аялал зэрэг арга хэмжээнд Улсын Их Хурлын гишүүд оролцсон байна.

Улсын Их Хурлын Тамгын газраас давхардсан тоогоор 2012 онд 60, 2013 онд 43, 2014 онд 63, 2015 онд 81 ажилтан тус тус Улсын Их Хурал болон олон улсын байгууллагын зардлаар айлчлал, олон улсын хурал, семинар, сургалт, туршлага судлах, танилцах аялалд оролцсон. Тус хэлтсээс Улсын Их Хурлын гадаад харилцааг идэвхжүүлэн хөгжүүлэхэд анхаарахын зэрэгцээ гадаад орны хөгжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж Улсын Их Хурал болон Тамгын газрын техникийн чадавхийг бэхжүүлэх албадтай хамтран ажилласан. Тухайлбал,

Монгол Улсын Их Хурлын Тамгын газарт Туркийн Хамтын ажиллагааны зохицуулагч агентлаг (ТИКА) -ийн тусламжтайгаар Цахим номын сан болон хэвлэх цехийн тоног төхөөрөмжийг иж бүрнээр нь шинэчлэх төсөл, БНСУ -ын Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (КОЙКА) -ын “Цахим парламент” төслийг хэрэгжүүлэх ажилд оролцож холбогдох гэрээ, баримт бичгүүдийг орчуулах, захидал, хүсэлт, албан бичгийг боловсруулах, орчуулан илгээх зэргээр ажилласан нь Тамгын газрын техникийн чадавхийг дээшлүүлэхэд ач холбогдолтой ажил болсон.

Монгол Улсын Их Хурлын урилгаар 2013 онд 6 орны /БНХАУ, ДВУ, ЕАБХАБ, БНПУ, БНФУ, БНСУ/ парламентын дарга, 2 орны /БНЧУ, ХБНГУ/ парламентын дэд дарга нар, 2014 онд 4 орны парламентын дарга /Мьянмар, ОХУ, Турк, ОХУ-ын БН Буриад Улс/, 2 орны /Чех, Польш/ парламентын дэд дарга нар, 2015 онд 2 орны парламентын дарга / ОХУ - 2 удаа, Чех /, 3 орны парламентын дэд дарга /БНСВУ, БНПУ, БНХАУ/ нар тус тус Монгол Улсад албан ёсны болон ажлын айлчлал хийв.

2013 онд Улсын Их Хурлын дарга З.Энхболд тэргүүтэй парламентын төлөөлөгчид АНУ, Канад, БНТУ -д тус тус албан ёсны айлчлал хийж, БНХАУ -д зохион байгуулагдсан Азийн төлөөх Боао -гийн чуулга уулзалт, ШХУ -ын Женев хотноо зохион байгуулагдсан ОУПХ -ны 129 дүгээр Ассамблейд оролцов.

2014 онд УИХ-ын дарга тэргүүтэй төлөөлөгчид БНСУ, БНХАУ-д, 2015 онд Япон, ХБНГУ, БНПУ, ОХУ-д тус тус албан ёсны айлчлал хийж, АНУ-ын Нью-Йорк хотноо зохион байгуулагдсан Дэлхийн Спикерүүдийн 4 дүгээр бага хурал, БНХАУ -ын Бээжин хотноо зохион байгуулагдсан “Торгоны Зам” сэдэвт Азийн улстөрийн намуудын олон улсын бага хуралд тус тус оролцсон нь Монгол Улсын Их Хурал бусад орнуудын парламенттай харилцаа, хамтын ажиллагаа идэвхтэй хөгжиж байгааг харуулж байна.

Дээрх айлчлалууд өндөр дээд хэмжээний харилцан айлчлалуудын давтамжийг хадгалах,



айлчлалын мөрөөр харилцан ашигтай хамтын ажиллагааг хэрэгжүүлэх замаар улс орны хөгжилд тодорхой ач холбогдолтой болсон.

2013 онд Монгол Улсын Их Хурал, БНХАУ -ын БХАТИХ -ын хооронд хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан. 2014 онд Монгол Улсын Их Хурал, БНХАУ -ын БХАТИХ -ын Байнгын хороо хооронд хамтын ажиллагааны байнгын механизм байгуулах тухай харилцан ойлголцлын санамж бичиг, Монгол Улсын Их Хурал, Бүгд Найрамдах Турк Улсын Үндэсний Их Хурал хооронд хамтын ажиллагааны протокол, Монгол Улсын Их Хурлын Тамгын газар Чех, Лаос Улсын Парламентын Тамгын газартай тус тус хамтын ажиллагааны санамж бичиг, Данийн Парламентын Тамгын газар тай хамтын ажиллагааны протокол байгуулсан.

2013.03 дугаар сарын эхээр Улсын Их Хурлын дарга З.Энхболдын урилгаар Данийн Вант Улсын Парламентын дарга Могенс Ликкеттофт тэргүүтэй төлөөлөгчид манай улсад албан ёсны айлчлал хийсэн.

Мөн 2015 онд Монгол Улсын Их Хурлын Тамгын газар БНПУ, БНСВУ -ын парламентын Тамгын газартай тус тус хамтын ажиллагааны протокол байгуулсан нь талуудын хамтран ажиллах эрхзүйн орчинг бататгасан юм.

2013 онд Улаанбаатар хотноо Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн Сайд нарын 7 дугаар бага хурал, уг хурлын хүрээнд Ардчиллын төлөөх парламентчдын чуулга уулзалт, “Евро - Азийн тээвэр: Бүс нутгийн оролцоо” сэдэвт олон улсын бага хурал, Зүүн хойд Азийн эмэгтэй парламентчдын чуулга уулзалт “Боловсролоор дамжуулан энхтайван, хөгжлийг урагшлуулахад эмэгтэй парламентчдын гүйцэтгэх үүрэг” сэдвийн дор тус тус зохион байгуулсан.

2015 онд ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн намрын чуулган Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулагдсан нь Монгол Улсын нэр хүнд бүс нутгийн хэмжээнд төдийгүй олон улсын тавцанд өсч, бүс нутаг, олон улсын чанартай аливаа асуудлыг шийдвэрлэхэд манай улсын үүрэг, оролцоо нэмэгдэх чухал ач холбогдолтой болсон юм. Чуулганд ЕАБХАБ -ын гишүүн 45 орон, түнш 2 орон, олон улсын 14 байгууллагын нийт 310 төлөөлөгч, үүний дотор ОХУ -ын Төрийн Думын дарга, Румын Улсын Парламентын Сенатын танхимын дэд дарга, Азербайжан Улсын Парламентын дэд дарга, БНПУ -ын Сеймын Дэд Маршал зэрэг өндөр дээд хэмжээний төлөөлөгчид оролцсон.

2016 оны 4 дүгээр сарын 21-23 -ны өдрүүдэд зохиогдсон Ази, Европын Парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтад 30 гаран орны 170 гаруй төлөөлөгчид оролцов. Уулзалт “Ази-Европын Парламентын Түншлэлийн АСЕМ дахь үүрэг оролцоо” ерөнхий сэдвийн хүрээнд “Үрдүнтэй олон талт харилцаа, хамтын ажиллагаа”, “Ирээдүйн төлөөх түншлэл” гэсэн сэдвээр хоёр салбар хуралдаан явагдав. Дээрх олон улсын хурлуудыг Улсын Их Хурлын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтэс зохион байгуулав.

\* \* \*

Монгол Улсын Их Хурал Ази, Европын Дээд түвшний 11 дүгээр уулзалт (АСЕМ)-ын хүрээнд Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг Улаанбаатар хотноо 2016 оны 04 дүгээр сарын 21-нээс 23-ны өдрүүдэд зохион байгуулав. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын даргын 28 тоот захирамжийг үндэслэн Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг зохион байгуулах ажлын бэлтгэл хангах үүрэг бүхий Үндэсний хороо Монгол Улсад анх удаа зохион байгуулагдсан энэхүү 9 дүгээр уулзалтын

зохион байгуулалтын талаар хуралдаж, үр дүнг албан ёсоор танилцуулсан.

Үр дүнгийн талаарх танилцуулгыг Үндэсний хорооны дарга, Улсын Их Хурлын дэд дарга Р.Гончигдорж хийв. Тэрээр, Парламентын түншлэлийн 9-р уулзалтад 30 гаран орны нийт 170 гаран зочид төлөөлөгч оролцсоныг дурдав. Уулзалтын үеэр Энэтхэгийн парламентын Доод танхимын дарга Сумитра Махажан, Италийн Сенатын танхимын Ерөнхийлөгч Пьетро Грассо нар албан ёсны айлчлал хийв.

Уулзалтын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын дэд дарга нар болон Улсын Их Хурлын зарим гишүүдтэй нийт 41 хоёр талын уулзалт хийгдсэн. Уулзалтуудын үеэр парламент хоорондын харилцааг улам өргөжүүлэх, улс төрийн яриа хэлэлцээг гүнзгийрүүлж, хоёр талын болон олон талт хамтын ажиллагааг бэхжүүлэхэд идэвхтэй хамтран ажиллах зэрэг асуудлуудыг ярилцав.

2016 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр Бэлтгэл хурал болон Төслийн хорооны хурал болж, салбар хуралдааныг даргалагчдаа тохирч, уулзалтаас гарах Тунхаглалын төслийг хэлэлцсэн. Уг хурлуудыг Улсын Их Хурлын гишүүн С.Оюун амжилттай даргалж явуулсан.

2016 оны 04 сарын 22-ны өдөр Нэгдсэн хуралдаан болон хоёр салбар хуралдаан хуралдсан: Нэгдүгээр салбар хуралдааныг УИХ-ын гишүүн С.Оюун, Польшийн Парламентын дэд дарга нар хамтран даргалсан. Хоёрдугаар салбар хуралдааныг УИХ-ын гишүүн Н.Энхболд, Унгарын Парламентын дэд дарга нар хамтран даргалсан.

Уулзалтын үеэр УИХ-ын гишүүн Л.Болд, Г.Батхүү, Д.Тэрбишдагва нар илтгэл тавьсан. Мөн 2-р салбар хуралдааны илтгэгчээр УИХ-ын гишүүн М.Батчимэг ажиллаж, тайлангаа нэгдсэн хуралдаанд танилцуулсан. Уулзалтын төгсөглд 3 бүлэг, 44 заалт бүхий Тунхаглал батлагдсан. Уг Тунхаглалд терроризмтай тэмцэх, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлж, илрүүлэх, Солонгосын хойгийг цөмийн зэвсгээс ангид байлгах, Зургаан талт яриа хэлэлцээг үр нөлөөтэйгээр сэргээх, Зүүн Хойд Ази дахь энх тайван, аюулгүй байдал, хамтын ажиллагааны санаачлагууд, Улаанбаатарын яриа хэлэлцээ санаачлагын чухал ач холбогдол, дэлхий нийтийг хамарсан өнөөгийн болон шинээр гарч буй сорилтуудыг олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээний дагуу үр дүнтэй шийдвэрлэхэд олон талт үйл ажиллагаа болон олон улсын хамтын ажиллагааг улам бэхжүүлэх, энх тайван, далайн тээврийн намжмал, тогтвортой, аюулгүй байдлыг хангах, задгай тэнгис болон харалдаа агаарын орон зайд чөлөөтэй болон аюулгүй зорчих, дүрвэгсэд болон цагаачдын асуудал, шударга, эрх тэгш, ардчилсан болон нээлттэй нийгмийг бэхжүүлэхэд хүний эрх, эрх чөлөөг сахин дээдлэх, авлигатай тэмцэх, хоёр бүс нутгийн хооронд бараа, үйлчилгээ, хөрөнгийн чөлөөт урсгалыг нэмэгдүүлэх, ард иргэдийн хэлхээ холбоог бэхжүүлэх, соёл, боловсрол, шинжлэх ухаан, технологи, эрдэм шинжилгээний чиглэлийн болон залуучуудын солилцоог идэвхжүүлэх, харилцан ашигтай технологи дамжуулахыг хөхиүлэх дэмжих зэрэг олон чухал асуудлуудыг хоёр тивийн парламентын гишүүд харилцан зөвшилцөж тусгасан байна хэмээн танилцуулав.

Ийнхүү Үндэсний хорооны дарга, Улсын Их Хурлын дэд дарга Р.Гончигдорж Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг амжилттай зохион байгуулахад хүчин чармайлт гаргаж ажилласан Үндэсний хорооны гишүүд болох УИХ-ын болон Засгийн газрын гишүүд, ялангуяа, УИХ-ын гишүүн С.Оюун, Н.Энхболд, Гадаад хэргийн яам, УИХ-ын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтэс болон холбогдох бүх байгууллагуудын удирдлага, хамт олонд талархал илэрхийлье гэлээ.

Үндэсний хорооны хуралд Үндэсний хорооны гишүүд болох УИХ-ын гишүүн Г.Батхүү, УИХ-ын гишүүн Л.Болд, УИХ-ын гишүүн Н.Энхболд мөн энэхүү 9 дүгээр уулзалтыг зохион

байгуулах Ажлын хэсгийн ахлагч, УИХ -ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, АСЕМ-ын Ахлах албан тушаалтан, Бэлтгэл ажлын албаны орлогч дарга Л.Оргил, Үндэсний хорооны Нарийн бичгийн дарга, УИХ-ын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтсийн дарга Ц.Нарантунгалаг болон бусад албаны хүмүүс оролцлоо.

АСЕМ-ын дээд түвшний XI уулзалтын хүрээнд зохион байгуулагдах хамгийн эхний арга хэмжээ болох Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалт нь тухайн орны парламент байрладаг ордонд зохион байгуулагддаг уламжлалтай. Энэ дагуу Төрийн ордонд энэ сарын 21-22 -ны өдрүүдэд зохион байгуулагдлаа.

Энэ удаагийн АСЕМ-ын дээд түвшний уулзалт 20 дахь жилдээ зохион байгуулагдаж буйгаараа онцлогтой. Иймд энэ ойг тохиолдуулан парламентын түншлэл энэ уулзалтад ямар үүрэг гүйцэтгэдэг талаар ярилцахаар Ази, Европын парламентын түншлэлийн IX уулзалтыг “Ази, Европын парламентын түншлэлийн АСЕМ дахь үүрэг” сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан юм. Дараагийн хурал 2016 оны 05 сарын 12-13-нд АСЕМ-ын Ахлах албан тушаалтнуудын уулзалт бол ирэх зургадугаар сард АСЕМ-ын Сангийн сайд нарын 12 дугаар уулзалт, Ази, Европын хүнсний аюулгүй байдал, фермерийн сургалт болно. Харин долдугаар сард Ази-Европын иргэний 11 дүгээр чуулга уулзалт, АСЕМ-ын Загвар чуулган, Редакторуудын дугуй ширээний 8 дугаар уулзалт, АСЕМ-ын Ахлах албан тушаалтнуудын уулзалт, Ази, Европын Бизнесийн 15 дугаар чуулга уулзалт тус тус болно.

\* \* \*



# 6

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР (ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ, 2012 - 2016)





**УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР (2012 - 2016) -ЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Парламентын ажлын албаны чиг үүрэг, удирдлага зохион байгуулалтын зарим онцлог

Улсын Их Хурлын Тамгын газрын алсын хараа

Төрийн эрх барих дээд байгууллага - Улсын Их Хурлаас хууль тогтоох, хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь иж бүрэн зөвлөгөө, туслалцаа, үйлчилгээ үзүүлэх чадавхитай бие даасан өндөр мэргэшсэн төрийн захиргааны байгууллага болон төлөвших нь УИХ -ын Тамгын газрын алсын хараа мөн.

Улсын Их Хурлын Тамгын газрын эрхэм зорилго, эрхэмлэх үндсэн зарчим

Улсын Их Хурлын Тамгын газрын эрхэм зорилго нь эх орондоо хүмүүнлэг, ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх, монголын ард түмний засаглах эрхийг хангах чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь УИХ -д үзүүлэх мэргэжил, арга зүй, техник - зохион байгуулалтын туслалцаа, санхүү, аж ахуйн үйлчилгээ нь УИХ -ын хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн байхад оршино. Энэхүү эрхэм зорилгыг хангаж ажиллахын тулд дараахь үндсэн зарчмыг үйл ажиллагаандаа эрхэмлэнэ. Үүнд:

Эрхэмлэх үндсэн зарчим

- Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуулийг дээдлэн сахиж, бүхий л үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд хэрэгжүүлэх
- Төрийн албаны ёс зүйг сахин мөрдөж, улс төрөөс ангид байж, хариуцлага хүлээх чадвартай байх
- Тамгын газрын үйл ажиллагаа нь мэргэшсэн, шуурхай, соёлтой, найдвартай, тасралтгүй байх

Үйл ажиллагааны үндсэн чиглэл

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурал нь өөрийн гишүүд, Байнгын болон бусад хорооны үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх болон ажиллах нөхцөлөөр хангах үүрэг бүхий Тамгын газартай байна” гэж заасан.

Тамгын газар нь дараахь ажлыг эрхлэн гүйцэтгэнэ:

- Улсын Их Хурал, түүний гишүүд, Байнгын болон бусад хороодын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн туслалцаа болон бусад ажиллах нөхцөлөөр хангах;
- Улсын Их Хурлын аж ахуй, санхүүг хөтлөн явуулах, түүний төсвийг зохих журмын дагуу зарцуулах;
- Улсын Их Хурлын чуулганы бэлтгэл, хуралдааны хэвийн ажиллах нөхцөлийг хангах;
- Чуулганы болон хороо, ажлын хэсгийн хуралдааны танхим, шаардлагатай техник хэрэгслийг бэлэн байлгах, танхимд журам сахиулах;
- Хууль, улсын Их Хурлын бусад шийдвэр, баримт бичгийг нийтлүүлэх, тараах ажлыг зохион байгуулах. Улсын Их Хурлын гишүүдийг шаардлагатай мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;
- Улсын Их Хуралд иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;
- Улсын Их Хурлын бичиг хэрэг, архивын үйл ажиллагааг хөтлөн явуулах;


- Улсын Их Хурал, Тамгын газар, түүний харьяа байгууллагын гадаад харилцааны асуудлыг хариуцан шаардлагатай баримт бичиг бэлтгэх, Улсын Их Хурлын шугамаар гадаад оронд айлчлах болон гадаадаас ирэх төлөөлөгчдийг хүлээн авах, бэлтгэл хангах, гадаадын зочин төлөөлөгчдөд үйлчлэх;
- Хууль болон Улсын Их Хурлын бусад шийдвэрээр даалгасан бусад үүргийг биелүүлэх.
- Улсын төсвийн төсөл боловсруулах, батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих, Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг Тамгын газарт байна. Түүнчлэн Улсын Их Хурлын даргад туслах ажлын хэсэг Тамгын газарт багтах бөгөөд Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын шууд харьяанд байж Улсын Их Хурлын даргад үйлчилнэ.

#### Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагааны эрх зүйн үндэс

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хурал нь гишүүд, Байнгын, дэд, түр хорооны үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах үүрэг бүхий Тамгын газартай байна” гэж заасан. Мөн хуулийн 39 дүгээр зүйлд Улсын Их Хурлын Тамгын газар, түүний эрхлэх ажлыг нарийвчлан зааж өгсөн байдаг. Улсын Их Хурлын Тамгын газар /цаашид “Тамгын газар” гэх/ нь дараахь ажлыг эрхлэн гүйцэтгэнэ. Үүнд:

- Улсын Их Хурал, Байнгын, дэд, түр хороод, ажлын хэсэг, гишүүдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх;
- Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх төслийг хянаж, зохих журмын дагуу өргөн мэдүүлэх бэлтгэлийг хангах;
- хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл өргөн мэдүүлэх, хэлэлцүүлэх, батлах үйл ажиллагааны зохион байгуулалтын бэлтгэлийг хангах;
- Улсын Их Хурал, түүний Тамгын газар Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн аж ахуй, санхүүг хөтлөн явуулах, төсвийгхууль тогтоомжийн дагуу зарцуулах;
- нэгдсэн, Байнгын, дэд, түр хороод, нам, эвслийн бүлгийн хуралдааны техникийн бэлтгэлийг хангах;
- батлагдсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн эцсийн найруулга хийх, хэлбэржүүлэн гаргах, нийтлэх, мэдээлэх;
- чуулганы явцыг дэс дараалан албан ёсоор тэмдэглэн хөтөлж, уг тэмдэглэлийг ашиглах, хадгалах ажлыг эрхлэн явуулах;
- Улсын Их Хурал, түүний Тамгын газрын бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагааг эрхэлж чуулганаар хэлэлцэх асуудалтай холбоотой баримт бичгийг олшруулан тараах ажлыг зохион байгуулах;
- Улсын Их Хурлаас олон нийттэй харилцах ажиллагааг зохион байгуулах;
- гишүүдэд иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, санал, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг нэгтгэн дүгнэж Улсын Их Хурлын дарга, Өргөдлийн байнгын хороо, гишүүдэд мэдээлэх;
- Улсын Их Хурал, Тамгын газрын гадаад харилцааны асуудлыг хариуцан шаардлагатай баримт бичиг бэлтгэх, Улсын Их Хурлын шугамаар гадаад оронд айлчлах болон гадаадаас ирэх зочин, төлөөлөгчдийг хүлээн авах бэлтгэл хангах, тэдгээрт үйлчлэх;
- хянан шалгах чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь Байнгын, дэд, түр хороо, ажлын хэсэгт арга зүйн туслалцаа үзүүлэх;
- чуулганаар хэлэлцэх хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар

УИХ -ын Тамгын газрын зохион байгуулалтын бүтцийн бүүдүүвч



болон гишүүдийн хүссэнээр тодорхой хуулийн хэрэгжилтээр мэдээллийн эх үүсвэрийг бүрдүүлэх;

- Монгол Улсын хууль тогтоомжийн мэдээллийн сан бүрдүүлж гишүүдэд үйлчлэх;
- хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрээр даалгасан бусад үүргийг биелүүлэх.

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дэргэд Улсын Их Хурлаар төсвийн төсөл хэлэлцэх, төсвийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, үр нөлөөг дээшлүүлэхэд туслах, бодлогын зөвлөмж гаргах, дүн шинжилгээ хийх бие даасан нэгжийг ажиллуулах бөгөөд уг нэгж нь Улсын Их Хурлын Тамгын газрын бүтцэд байна гэж заасан байна. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Тамгын газар нь хуулийн этгээд мөн бөгөөд түүний дүрмийг Улсын Их Хурал батална” гэж заасан. Энэ үндсэн дээр Монгол Улсын Их Хурлын 2006 оны 06 дугаар сарын 22 -ны өдрийн 62 дугаар тогтоолоор “Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын дүрэм” -ийг баталсан. Уг дүрэмд зааснаар Улсын Их Хурлын Тамгын газар нь Монгол Улсын Их Хурлаас хууль тогтоох, төрийн бодлого тодорхойлох, хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зөвлөгөө, туслалцаа, үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий бие даасан, мэргэшсэн, төрийн захиргааны байгууллага юм.

УИХ -ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга нь Улсын Их Хурлын чуулган бэлтгэн явуулах, түүний өдөр тутмын ажлыг зохицуулахад Улсын Их Хурлын даргад туслах, Улсын Их Хурлын Тамгын газрыг удирдах үндсэн үүрэгтэй. УИХ -ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргыг Улсын Их Хурлаас томилно. Ерөнхий нарийн бичгийн дарга нам бус байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Тамгын газрыг хууль зүй, улс төрийн өндөр мэргэшил бүхий Ерөнхий нарийн бичгийн дарга удирдах бөгөөд түүнийг Улсын Их Хурлын даргын санал болгосны дагуу Улсын Их Хурал томилж, чөлөөлнө” гэж заасан байдаг.

Энэ үндсэн дээр Монгол Улсын Их Хурлын 2012 оны 11 дүгээр сарын 25 -ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар өөрийнх нь хүсэлтийг үндэслэн Цэрэнхүүгийн Шаравдоржийг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөхөөр шийдвэрлэж, энэ тухай Улсын Их Хурлын 54 тоот тогтоол гарчээ. Улсын Их Хурлын чуулганы мөн өдрийн нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын даргаас санал болгож, Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаас дэмжлэг авсан Бямбадоржийн Болдбаатарыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргаар томилохоор хэлэлцэн шийдвэрлэж, Улсын Их Хурлын 55 тоот тогтоолыг баталсан юм.

#### Улсын Их Хурлын Тамгын газрын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт (2012 - 2016)

Монгол Улсын Их Хурлын зургаа дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд Улсын Их Хурлын Тамгын газар нь Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиуд, Монгол Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсан Монгол Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөө, Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын дүрэм болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдлөг болгон хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Энэ хугацаанд Тамгын газрын үйл ажиллагааны чанар, хүртээмж, шуурхай байдлыг хангах, хүний нөөцийн чадавхийг бүрэн дүүрэн ашиглах, бүтцийн нэгжүүдийн зохион байгуулалтыг оновчтой болгох чиглэлээр зохион байгуулалтын зарим арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн

даргын 2012 оны 12 дугаар сарын 06 -ны өдрийн 587 тоот захирамжаар Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын бүтэц, зохион байгуулалтын нэгжийн ажлын ачааллын тэнцвэртэй байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулах, дүн шинжилгээ хийх ажлын хэсгийг Эрх зүй, хууль тогтоомжийн хэлтсийн даргаар ахлуулан 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2006 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын дүрэмд заасан эрх, үүргийн хүрээнд Тамгын газрын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж, Улсын Их Хурал, түүний гишүүд, Байнгын болон бусад хороодод шуурхай үйлчлэх чадварлаг, мэргэшсэн баг, хамт олон бүрдүүлэх чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулах ажлыг батлагдсан удирдамжийн дагуу гүйцэтгэж, 14 хоногийн хугацаанд Ерөнхий нарийн бичгийн даргын дэргэдэх Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг үүрэг болгосон байна.

Ажлын хэсэг нь удирдамжид заасны дагуу Тамгын газрын бүтэц, зохион байгуулалтын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, хэлтэс, алба, төвийн чиг үүрэг, хоорондын ажлын уялдаа холбоо, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг судлан үзэх, зэрэгцүүлэн дүгнэлт хийж болохуйц ижил албан тушаалд ажиллагсдын ажлын нягтралтай харьцуулан дүгнэх, ажилтнуудын илүү цагаар ажиллуулах бодит шалтгаан байгаа эсэх, илүү цагаар байнга ажилладаг ажилтнуудын ажлын үр дүнг тооцох, төрийн үйлчилгээний албан тушаалд ажиллагсдын ажлын ачааллыг судлах, цаг ашиглалтын программын ашиглалтад тулгуурлан ажилтнуудын ирцийн байдалд дүгнэлт хийх, ажилтнуудын ажлын цаг ашиглалтын байдалд зураг авалтаар дүгнэлт гаргах чиглэлээр ажилласан байна.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын зохион байгуулалтын бүтэц, хэлтэс, алба, төвийн чиг үүргийг шинэчлэх талаар санал боловсруулах үүрэг бүхий ажлыг хэсгийг Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөхөөр ахлуулан 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулсан Ерөнхий нарийн бичгийн даргын 2013 оны 29 тоот захирамж гаргав.

Тамгын газрын зохион байгуулалтын бүтэц, хэлтэс, алба, төвийн чиг үүргийг шинэчлэн боловсруулахдаа хэлтэс, алба, төвийн чиг үүрэг, ажлын давхардал, хийдэгдэл, ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг нарийвчлан судалж, Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын бүтэц, зохион байгуулалтын нэгжийн ажлын ачааллын тэнцвэртэй байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулах, дүн шинжилгээ хийх үүрэг бүхий ажлын хэсгээс гаргасан дүгнэлт, Улсын Их Хурлын Байнгын хорооны удирдлагаас ирүүлсэн саналыг үндэслэн санал боловсруулж танилцуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосон байна. Энэ бүхний үндсэн дээр Улсын Их Хурлын Тамгын газар зохион байгуулалтынхаа бүтцэд дүн шинжилгээ хийж, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч, нэгжүүдийн үйл ажиллагааны чиг үүрэг, ажлын уялдаа холбоог сайжруулах, албан тушаалын ажлын байрны тодорхойлолтыг боловсронгуй болгох гол зорилго тавин ажиллаж, Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Тамгын газрын дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, Улсын Их Хурлын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх үүргээ хэрэгжүүлж иржээ.

Өнгөрсөн хугацаанд Тамгын газрын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх чиглэлээр Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга хоёр удаа захирамж гаргаж, зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.

Эхний удаад Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2006 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын Их Хурлын Тамгын

газрын дүрэм” -ийн 3.3 -т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын зохион байгуулалтын бүтцийг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2013 оны 3 дугаар сарын 6 -ны өдрийн захирамжийн хавсралтаар баталжээ.<sup>5</sup>

#### УИХ -ын Тамгын газрын нарийн бичгийн даргын чиг үүрэг

Тамгын газрын хууль зүйн үйлчилгээ хариуцсан нарийн бичгийн дарга нь Улсын Их Хурал, Байнгын, түр, дэд хороод, Улсын Их Хурлын удирдлага, гишүүд, Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргаас чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх хүрээнд Ерөнхий нарийн бичгийн даргыг орлож, Хууль зүйн үйлчилгээний хэлтэс, Хуралдаан зохион байгуулах хэлтэс, Судалгаа шинжилгээний хэлтэс, Хяналт үнэлгээний хэлтсийн үйл ажиллагааг ерөнхий зохицуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллах чиг үүрэгтэй.

Тамгын газрын захиргаа, нийтлэг үйлчилгээ хариуцсан нарийн бичгийн дарга нь Улсын Их Хурал, Байнгын, түр, дэд хороод, Улсын Их Хурлын удирдлага, гишүүд, Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргаас чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх хүрээнд Ерөнхий нарийн бичгийн даргыг орлож, Захиргаа, нийтлэг үйлчилгээний хэлтэс, Мэдээллийн технологийн хэлтэс, Хэвлэл, мэдээлэл олон нийттэй харилцах хэлтсийн үйл ажиллагааг ерөнхий зохицуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллахаар заасан байна.

Энэхүү бүтэц, зохион байгуулалтын үндсэн дээр Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2013 оны 4 дүгээр сарын 15 -ны өдрийн 224 дүгээр захирамжаар Б.Цэвээнпүрэвийг Улсын Их Хурлын Тамгын газрын захиргаа, нийтлэг үйлчилгээ хариуцсан нарийн бичгийн даргаар, 2013 оны 4 дүгээр сарын 26 -ны өдрийн 256 дугаар захирамжаар Н.Отгончимэгийг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль зүйн үйлчилгээ хариуцсан нарийн бичгийн даргаар тус тус томилжээ.

2016 оноос тус Тамгын газарт зөвхөн Хууль зүйн үйлчилгээ хариуцсан нэг Нарийн бичгийн дарга ажиллахаар бүтцийн зохицуулалт хийгдсэн болно. Энэ үндсэн дээр эдүгэ УИХ -ын Тамгын газрын Хууль зүйн үйлчилгээ хариуцсан Нарийн бичгийн даргаар П.Амаржаргал ажиллаж байна. Мөн,

УИХ -ын Тамгын газрын дотоод зохион байгуулалтын хэлтэс, нэгжийн даргаар дор дурдсан нэр бүхий хүмүүс ажиллаж байна. Үүнд,

- Мэдээлэл үйлчилгээ удирдлагын төв - Б. Төгөлдөр
- Хууль зүйн үйлчилгээний хэлтэс - Ж. Дашдорж
- Хуралдаан зохион байгуулах хэлтэс - Н. Цогтсайхан
- Гадаад харилцааны хэлтэс - Ц. Нарантунгалаг
- Судалгааны хэлтэс - Ц. Норовдондог
- Хяналт, үнэлгээний хэлтэс - Л. Энхтуяа
- Захиргаа, нийтлэг үйлчилгээний хэлтэс - Н. Ширэндэв
- Мэдээллийн технологийн хэлтэс - Ж. Элбэгзаяа
- Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс - Б. Мандухайсэцэн

#### УИХ -ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын дэргэдэх Зөвлөл

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2014 оны 9 дүгээр сарын 17 -ны өдрийн 476 тоот захирамжаар “Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий

<sup>5</sup> “Тамгын газрын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай” УИХ -ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2013 оны 3 дугаар сарын 06 -ны өдрийн 111 тоот захирамж;

нарийн бичгийн даргын дэргэдэх Зөвлөлийн ажиллах журам"-ыг шинэчлэн баталсан.

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын дэргэдэх Зөвлөл нь Тамгын газрын үйл ажиллагааг удирдан зохион байгуулахад Ерөнхий нарийн бичгийн даргад зөвлөх үүрэгтэй.

Зөвлөлийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын 2006 оны 62 дугаар тогтоолоор баталсан Улсын Их Хурлын Тамгын газрын дүрмийн 3 дугаар зүйлийн 3.8 дахь хэсэгт заасан Тамгын газрын эрхэм зорилго, зорилт, стратегийн болон бизнесийн төлөвлөгөө, тэдгээрийн биелэлт, Тамгын газрын ажлын тайлан, Тамгын газрын төсвийн төсөл, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан тэнцлийн үр дүн, эд хөрөнгийн тооллого, тооцоо, ашиглалт, хамгаалалтын асуудал, Тамгын газрын хэлтэс, албадын чиг үүргийн хуваарь, Тамгын газрын үйл ажиллагаатай холбогдсон журам, зааврын төсөл, төрийн захиргааны албан тушаалын ажлын байрны тодорхойлолт, Улсын Их Хурлын компьютерийн сүлжээ, бусад техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, техникийн шинэчлэлийн бодлого, чиглэл, Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааны үр дүн, тодорхой ажилтны ажлын талаархи мэдээлэл, сонсгол, Тамгын газрын ажилтнуудад шагнал, урамшил олгох, сахилгын шийтгэл ногдуулах, гарсан зөрчлийг арилгуулах тухай асуудал, Тамгын газрын ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг шийдвэрлэхтэй холбогдсон болон цалин хөлс, тусламж дэмжлэг үзүүлэх зэрэг асуудал, мөн дотоод хяналт шалгалттай холбогдсон асуудал, бусад асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхээр заасан байна.

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын дэргэдэх Зөвлөлийн бүрэлдэхүүнд, Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргаас гадна,

- Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль зүйн үйлчилгээ хариуцсан нарийн бичгийн дарга
- Хууль зүйн үйлчилгээний хэлтсийн дарга
- Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга
- Судалгааны хэлтсийн дарга
- Хяналт үнэлгээний хэлтсийн дарга
- Гадаад харилцааны хэлтсийн дарга
- Захиргаа, нийтлэг үйлчилгээний хэлтсийн дарга
- Мэдээллийн технологийн хэлтсийн дарга
- Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга
- Дотоод аудитор
- Хууль зүйн үйлчилгээний хэлтсийн орлогч дарга
- Ахлах нягтлан бодогч
- Мэдээлэл үйлчилгээ удирдлагын төвийн дарга

нар эрхэлсэн чиг үүргийнхээ дагуу орж ажилладаг.

#### Тамгын газрын үйл ажиллагааг эрчимжүүлэхэд чиглэсэн ажил, холбогдох зарим шийдвэрүүд

Энэ удаагийн Улсын Их Хурлын Тамгын газар өөрийн үндсэн чиг үүргийн хүрээнд мөрдөгдөж байгаа дүрэм, журам, заавруудыг шинэчлэн боловсруулж, боловсронгуй болгоход анхаарч, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2014 оны 78 тоот захирамжаар тусгай ажлын хэсэг гаргаж ажиллуулсан байна. Энэ үндсэн дээр Улсын Их Хурлын Тамгын газрын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт хийгдэж, улмаар орон тоо шинэчлэн батлагдсантай холбогдуулан Тамгын газрын үйл ажиллагаанд мөрдөгдөх дүрэм, журмыг боловсронгуй болгох ажлын хүрээнд зарим заавар, журмуудыг шинэчилжээ. Үүнд:

- Монгол Улсын Их Хурал, түүний Тамгын газрын албан хэрэг хөтлөх заавар,
- Монгол Улсын Их Хурал, түүний Тамгын газрын тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх, хадгалах журам,
- УИХ-ын Тамгын газрын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх нийтлэг журам,
- УИХ -ын Тамгын газрын төсөв хуваарилах, үндсэн чиг үүргийг хангах, үр дүнг нь тооцох тогтмол үйл ажиллагааны хөтөлбөр, арга хэмжээг боловсруулж баталжээ.
- УИХ -ын Тамгын газрын Хөдөлмөрийн дотоод журам, Тамгын газрын хүний нөөцийг бэхжүүлэх сургалтын хөтөлбөр, ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр зэрэг бусад эрх зүйн актыг шинэчлэн боловсруулсан байна.
- Улмаар Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2014 оны 78 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2014 оны 03 дугаар сарын 20 -ны өдрийн 138 тоот захирамжийн хавсралтаар Улсын Их Хурлын Тамгын газарт мөрдөгдөж байгаа Нийт 22 дүрэм, журам, зааврыг хүчингүй болсонд тооцжээ.

Улсын Их Хурлын хууль тогтоох чиг үүргийг хэрэгжүүлэхэд Тамгын газраас үзүүлэх мэргэшсэн туслалцаа, үйлчилгээг боловсронгуй болгох үүднээс зохион байгуулалтын цогц арга хэмжээ авч хэрэгжүүлээд байна. Энэхүү зорилтын хүрээнд Улсын Их Хурлын даргын захирамжаар “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн эцсийн найруулга бэлтгэх, хянах журам”, “Хууль, Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгын хяналтын хуудас”, “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн ёсчлох эхийг бэлтгэх, ёсчлох журам”, “Хууль, Улсын Их Хурлын тогтоолын ёсчлох хяналтын хуудас” зэргийг батлуулан мөрдөж байна.

Түүнчлэн Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжаар “Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар хууль зүйн зөвлөмж гаргах журам”, “Хууль зүйн зөвлөмж гаргуулах тухай Байнгын хорооны саналын хуудасны загвар” -ыг батлан мөрдөж эхэлсэн нь хууль тогтоомжийн төслийн үндэслэлийг бодитой болгох, энэ чиглэлээр хууль санаачлагчид үзүүлэх мэргэшсэн туслалцаа, үйлчилгээг дээшлүүлэхэд ач холбогдолтой болжээ.

Мөн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг өргөн мэдүүлэх, хэлэлцэн батлах үе шатанд холбогдох албан тушаалтны хариуцан гүйцэтгэх ажил, үүргийг хэлэлцүүлгийн үе шатны дарааллаар тусгай хуваарь гарган хариуцуулж өгсөн нь Тамгын газрын бүтцийн үндсэн нэгжүүд, тэдгээрийн холбогдох албан тушаалтнуудын чиг үүргийг оновчтой болгох, ажлын давхардал, эзэнгүйдлийг арилгах, хариуцлагыг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн чухал зохицуулалт юм.

Энэ хүрээнд Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2013 оны 662 тоот захирамжаар “Улсын Их Хурлын чуулганы хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтыг хангах журам”, чуулганы нэгдсэн хуралдааны болон Байнгын, дэд, түр хороодын хуралдааны ирцийн мэдээ гаргах хүснэгт, хуралдааны танхимуудын зохион байгуулалтын зураглалыг баталсан байна. Энэчлэн Тамгын газарт мөрдөгдөж байгаа дүрэм, журам, заавруудыг шинэчлэн боловсруулж батлуулж хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах журам, зааврыг шинэчлэн баталсан байна. Үүнд:

- Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2013 оны 01 дүгээр сарын 30 -ны өдрийн 60 дугаар захирамжаар Улсын Их Хурлын Тамгын газарт ашиглагдаж буй хэрэглээний программ хангамжуудыг 2013 оны 3 дугаар сарын 1 -ээс, үйлдлийн системийг 2013 оны 8 дугаар сарын 1-ээс эхлэн нээлттэй эхийн программ хангамж руу шилжүүлэхээр шийдвэрлэжээ.



- Үүнтэй холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газарт нээлттэй эхийн программ хангамж нэвтрүүлэх төлөвлөгөөг хавсралтаар баталж, нийт ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод нээлттэй эхийн программ хангамж ашиглах чадварын тухай заалт нэмж оруулж, сургалт зохион байгуулан шаардлагатай мэдлэг чадвар олгохыг Захиргаа, боловсон хүчний хэлтэст үүрэг болгожээ.
- Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2013 оны 03 дугаар сарын 25 -ны өдрийн 154 дүгээр захирамжаар Улсын Их Хурлын Тамгын газарт мөрдөгдөх төрийн захиргааны албан тушаалын ажлын байрны тодорхойлолтыг хавсралтаар баталжээ.

Уг захирамжаар ажлын байранд гүйцэтгэх ажил, тавигдах шаардлагыг мөрдөж ажиллахыг хэлтсийн дарга нарт үүрэг болгожээ. Мөн энэ захирамж гарсантай холбогдуулан Ерөнхий нарийн бичгийн даргын 2009 оны 190 тоот, 2010 оны 39, 155, 185, 417, 426 тоот, 2011 оны 480 тоот, 2012 оны 221, 651 тоот захирамжуудыг хүчингүйд тооцсон байна.

“Улсын Их Хурлын Тамгын газрын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх нийтлэг журам” журмыг хэрэгжүүлэхэд хөтлөх маягтуудыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2013 оны 5 дугаар сарын 31 -ний өдрийн 364 дүгээр захирамжаар баталсан.

Энэхүү журмын зорилго нь Улсын Их Хурлын Тамгын газрын төсөв, санхүүгийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн үр дүнтэй, шуурхай, харилцан уялдаатайгаар зохион байгуулах, хэрэгжүүлэх, төсвийн төсөл, санхүүгийн тайлан мэдээг цаг хугацаанд нь үнэн зөв гаргах, санхүүгийн баримт бүрдүүлэлтийн стандартыг хангах, төсвийн зарцуулалт, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын үр нөлөөг дээшлүүлэх, дотоод хяналт, дотоод аудитыг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино. Мөн Улсын Их Хурлын Тамгын газрын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд оролцогч бүр энэхүү журмыг дагаж мөрдөхөөр заажээ.

“Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагаанд дотоод аудит хийх дүрэм”-ийг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2013 оны 6 дугаар сарын 27 -ны өрийн 407 дугаар захирамжаар баталсан байна. Уг дүрэм нь Улсын Их Хурлын Тамгын газрын дотоод аудитын үйл ажиллагааны зорилго, хүрээ, зарчим, зохион байгуулалт болон дотоод аудиторын эрх, үүргийг тодорхойлж, дотоод аудитын үйл ажиллагааг явуулах, хөндлөнгийн аудитын байгууллагатай хамтарч ажиллах зэрэг харилцааг зохицуулахаар заажээ.

Улсын Их Хурлын Тамгын газрын дотоод аудитын үйл ажиллагааны зорилго нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршиж байгаа болно.

Дотоод аудитын үйл ажиллагаа нь ил тод, бие даасан, хараат бус байж, аудитын дүнг бодитой, үнэн зөв шударгаар тайлагнахаар тусгажээ.

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2013 оны 07 дугаар сарын 02 -ны өдрийн 412 дугаар захирамжаар Төрийн захиргааны албан хаагчийн баримтлах ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг хүлээн авч, түүний үндэслэлийг шалган тогтоож, дүгнэлт гаргах эрх бүхий байнгын, орон тооны бус Ёс зүйн хороог 9 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан.

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2013 оны 8 дугаар сарын 30 -ны өдрийн 486 тоот захирамжаар Улсын Их Хурлын Тамгын газрын Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн батлав. Дээрх журам батлагдсантай холбогдуулан 2009 оны 130 дугаар захирамжаар батлагдсан “Тамгын газрын Хөдөлмөрийн дотоод журам” -ыг хүчингүй болгожээ. Харин Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2013 оны 9 дүгээр сарын 17 -ны өдрийн 531, 2014 оны 665, мөн оны 12 дугаар сарын 18 -ны өдрийн 701, 2015 оны 2 дугаар сарын 25 -ны 159 тоот захирамжаар Улсын Их Хурлын Тамгын газрын Хөдөлмөрийн дотоод журамд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Улсын Их Хурлын Тамгын газрын хөдөлмөрийн дотоод журмын зорилго нь Тамгын газрын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах, хөдөлмөр, зохион байгуулалтыг оновчтой болгох, хөдөлмөрийн сахилгыг бэхжүүлэх, ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах, ажлын үр дүнг дээшлүүлэх, ажилтны эрх, үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, шагнаж урамшуулах, хариуцлага хүлээлгэх, тусламж тэтгэмж огох болон түүнтэй холбоотой хөдөлмөрийн харилцааг зохицуулахад оршиж байгаа болно.

Тамгын газар, ажилтны хөдөлмөрийн харилцааны хүрээнд үүссэн аливаа асуудлыг Монгол Улсын Их Хурлын тухай, Төрийн албаны тухай, Төсвийн тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм болон Тамгын газрын үйл ажиллагааны онцлог хүчин зүйлсийг харгалзан тэдгээрт нийцүүлэн гаргасан бодлого, дүрэм, журам, заавар, энэ журмаар зохицуулагдахаар тусгасан байна.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх бодлогын хүрээнд ажилтнуудыг мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх, сургалтад оролцуулах, үүнээс үүдэн гарах харилцааг зохицуулах үүднээс Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2013 оны 8 дугаар сарын 30 -ны өдрийн 491 тоот захирамжаар “Сургалтын журам” -ыг шинэчлэн баталжээ. Уг журамд Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2015 оны 5 дугаар сарын 19 -ний өдрийн 385 тоот захирамжаар нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Энэхүү журмын зорилго нь ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод заасан мэргэжлийн мэдлэг, чадварыг дээшлүүлж мэргэшүүлэх, давтан сургах, мэргэжлийн боловсрол, дээд боловсролын зэрэг олгох сургалтад оролцуулах болон сургалттай холбоотой гарах асуудлыг зохицуулахад оршиж байгаа болно.

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2013 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 492 тоот захирамжаар “Ажил хүлээлцэх журам шинэчлэн батлах тухай” баталсан байна. Уг захирамжийн 1 дүгээр хавсралтаар Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнуудын ажил хүлээлцэх журмыг, 2, 3 дугаар хавсралтаар ажил хүлээлгэн өгөгчийн “Хариуцсан эд хөрөнгө, холбогдох бичиг баримтыг хүлээлгэн өгөх хуудас” -ыг тус тус баталж, мөрдөж ажиллахыг хэлтсийн дарга нарт даалгажээ.

Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнуудын үүрэгт ажлыг хүлээлцэхдээ Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад акт болон энэхүү журмыг удирдлага болгохоор заажээ. Мөн ажилтан нь Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон Тамгын газрын хөдөлмөрийн дотоод журам зэрэг эрх зүйн баримт бичигт заасны дагуу холбогдох шийдвэр гарч ажлаас өөрчлөгдөх, түр чөлөөлөгдөх, чөлөөлөгдөх, халагдах, хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусгавар болох, хөдөлмөрийн гэрээ цуцлагдах тохиолдолд үүрэгт ажлаа энэхүү журамд заасны дагуу хүлээлгэн өгнө.

Улсын Их Хурлын Тамгын газрын нарийн бичгийн дарга, хэлтсийн дарга нар болон нууцын асуудал хариуцсан ажилтан, мөнгөн, эд хөрөнгө хариуцагч няравын ажил хүлээлцэх комиссыг Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжаар томилохоор,

ажилтны ажлыг хүлээлцэхдээ харьяалагдах нэгжийн удирдлага буюу түүний томилсон ажилтан, Захиргаа, нийтлэг үйлчилгээний хэлтэс болон Мэдээллийн технологийн хэлтсийн холбогдох албан тушаалтан байлцахаар, Захиргаа, нийтлэг үйлчилгээний хэлтсийн хүний нөөцийн алба нь ажилтны ажил хүлээлцэх тухай шийдвэр болон хүлээлцэх цагийг Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын эд хөрөнгө хариуцсан нярав болон Төрийн ордны хамгаалалтын албанд тухай бүрд нь мэдэгдэж, ажил хүлээлцэх ажлыг зохион байгуулна.

Улсын Их Хурлын 2002 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөө” -ний “Парламентын ажлын мэргэшсэн алба болох Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагааны зохион байгуулалт, үйлчилгээний арга хэлбэр, чанарыг сайжруулах” стратеги зорилтын хүрээнд хүний нөөцийн мэдлэг, чадварыг байнга дээшлүүлж, цаашид шаардагдах мэдлэг чадварыг бий болгох, ажилтнуудын сургалтын хэрэгцээг тодорхойлж, Тамгын газрын сургалтын бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөх шаардлага бий болсон байна. Энэ үүднээс Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2013 оны 12 дугаар сарын 03 -ны өдрийн 687 тоот захирамжаар “Улсын Их Хурлын Тамгын газрын хүний нөөцийг бэхжүүлэх сургалтын хөтөлбөр”-ийг баталсан байна.

Тамгын газрын хүний нөөцийг бэхжүүлэх сургалтын бодлого, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний зорилт, шаардагдах санхүүжилтийн эх үүсвэр, хэрэгжүүлэх арга механизм, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлсон бодлогын баримт бичиг болох “Улсын Их Хурлын Тамгын газрын хүний нөөцийг бэхжүүлэх сургалтын хөтөлбөр” -ийг боловсруулан гаргажээ.

Тамгын газрын хүний нөөцийг бэхжүүлэх сургалтын бодлого нь Улсын Их Хурлын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн Тамгын газрын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтад орсон өөрчлөлт, түүнийг дагалдан бий болсон ажил үйлчилгээг эрхлэхэд шаардагдах мэргэжлийн ур чадварыг бий болгох, мэргэшсэн, чадварлаг боловсон хүчнийг бэлтгэх, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, дадлагажуулах ажлыг системтэй зохион байгуулахад чиглэгдэнэ.

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2013 оны 11 дүгээр сарын 21 -ний өдрийн 662 дугаар захирамжаар Улсын Их Хурлын чуулганы хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтыг хангах журам, Хуралдаан зохион байгуулах хэлтсийн шинжээч ирцийн мэдээ гаргах хүснэгт, Байнгын хорооны нарийн бичгийн дарга нар ирцийн мэдээ гаргах хүснэгт, чуулганы нэгдсэн хуралдааны болон Байнгын хороо хуралдах Төрийн ордны танхимуудын зохион байгуулалтын зураглалыг хавсралтаар тус тус шинэчлэн баталжээ.

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2013 оны 12 дугаар сарын 11 -ний өдрийн 707 тоот захирамжаар Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хавсралтаар баталсан.

Энэхүү хөтөлбөр нь Монгол Улсад мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах зорилтыг хэрэгжүүлэх харилцааг зохицуулах юм.

Хөтөлбөрийн зорилго нь Тамгын газрын ажилтнуудын хэвийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, ажлын үр дүнд тохирсон цалин хөлс олгох, бүтээлч, эвсэг хамт олныг төлөвшүүлэх, тогтвор суурьшил, идэвх санаачилга, үр бүрээмжтэй, шударга ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд ажилтнуудын хэрэгцээ, шаардлагыг нь үндэслэн ахуйн нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, ажилтнуудын ажлын байрны ая тухтай,

эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангасан нөхцөлийг бүрдүүлэх, ажилтнуудын саначилга, ур чадвар, мэргэжлийн түвшингийн үнэлгээ, ажлын гүйцэтгэл, үр дүнг харгалзан цалин хөлс, урамшуулал тогтоох, ажилтнуудын мэдлэг мэргэшил, ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, ажилтнуудад эрүүл мэндээ хамгаалахад нь дэмжлэг үзүүлэх, нийгмийн бусад тусламж, тэтгэмж, дэмжлэг үзүүлэх зэрэг ажлыг авч хэрэгжүүлэхээр заажээ.

#### Тамгын газарт техник технологи нэвтрүүлэх зарим ажил үйлчилгээний талаар

Дэлхийн аль ч улс орны парламентын хууль тогтоох, төрийн бодлого тодорхойлох үйл ажиллагаанд мэргэшсэн үйлчилгээ үзүүлдэг ажлын албадын зохион байгуулалтын бүтцэд мэдээллийн технологийн нэгж онцгой байр суурь эзэлдэг байна. Ер нь орчин үед парламентын Тамгын газарт тулгамдаж байгаа нэг чухал асуудал нь парламентын үйл ажиллагаанд мэдээллийн автоматжуулалтыг нэвтрүүлэх ажил болоод байна.

Дэлхийн улс орнуудын парламентын Тамгын газрын бүтцээс харахад парламентын үйл ажиллагаанд мэдээллийн автоматжуулалт нь нэгд, мэдээллийн технологи (парламентын болон спикер, гишүүдийн вэб сайт, Тамгын газрын сүлжээний программ хангамж зэрэг), хоёрт, техник хангамж (компьютер, техник хэрэгсэл, дотоод болон интернетийн сүлжээ, хуралдаанд ашиглах техник хэрэгсэл зэрэг), гуравт, парламентын мэдээллийг электрон хэлбэрээр түгээх (парламентаас гарч буй шийдвэрийг электрон хэлбэрээр олон нийтэд шуурхай түгээх) гэсэн гурван цогц асуудлаас бүрддэг байна.

Энэ жишгээр Монгол Улсын байнгын ажиллагаатай парламентын ажлын албаны бүтцэд ч техник ашиглалт, мэдээллийн технологийн ажил хариуцсан үндсэн чиг үүрэгтэй нэгж байнга хадгалагдсаар иржээ.

Улсын Их Хурлын Тамгын газрын мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах бүтцийн нэгж нь эхэндээ Судалгаа, мэдээлэл, лавламжийн албанд Сүлжээ, программын хэсэг, Санхүү, зохион байгуулалтын хэлтэст Олшруулах хэсэг нэртэйгээр байгуулагдаж байсан бол үйл ажиллагааны нь цар хүрээ жил ирэх тусам өргөжиж 2000 - 2001 онд Техникийн алба, 2001-2003 онд Техник ашиглалтын алба, 2003-2008 онд Санхүү, үйлчилгээний хэлтсийн Техник ашиглалтын алба хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байжээ. Харин 2008-2012 онд Мэдээллийн технологи, техник ашиглалтын хэлтэс, 2013 оноос Программ хангамжийн алба, Техник хангамжийн алба гэсэн дотроо үндсэн хоёр албатай Мэдээллийн технологийн хэлтэс болж өргөжсөн байна. Энэ нь дэлхийн бусад орны парламентын ажлын албаны бүтцийн жишигт дөхүү, тэр дундаа орчин үед чухлаар тавигдаж байгаа парламентын үйл ажиллагаанд мэдээллийн автоматжуулалтыг нэвтрүүлэх шаардлагад нийцэж байгаа зохион байгуулалтын хэлбэр болсон.

Энэ үндсэн дээр Улсын Их Хурлын Тамгын газрын газрын Мэдээллийн технологийн хэлтэс нь Улсын Их Хурал, түүний гишүүд, Байнгын, дэд, түр хорооны үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах Тамгын газрын хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж иржээ.

2012 он;

- Бүгд Найрамдах Турк Улсын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг /ТИКА/-тай хамтран “Монгол Улсын Их Хурлын цахим номын сан /нэгдүгээр шат/” төслийг тус улсын Засгийн газрын буцалтгүй тусламж болох 596.200 ам.долларын санхүүжилтээр хэрэгжүүлж Улсын Их Хурлын номын сан, Судалгааны төвийн мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх, ангилан хадгалах, улмаар мэдээллийг цахим хэлбэрээр хэрэглэгчдийн

хүртээл болгох суурь нөхцөлийг бүрдүүлэх, Улсын Их Хурлын хэвлэх хэсгийн зарим тоног төхөөрөмжийг шинэчлэх, сайжруулах ажлууд хийгдсэн.

- Улсын Их Хурлын Тамгын газрын 2020 он хүртэл баримтлах Мэдээллийн технологийн бодлого болон Мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг боловсруулж батлуулсан.
- Улсын Их Хурлын цахим хуудсыг шинэчлэн Цахим офисийн системийг нэвтрүүлсэн. Энэхүү шинэчлэлтийн үр дүнд олон дэд цахим хуудас ажиллуулах технологийн боломж бүрдсэн бөгөөд одоогоор үндсэн цахим хуудас, цахим оффисийн систем, удирдлагын систем, Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороод, Тамгын газрын хэлтсүүдийн дэд цахим хуудсууд болох нийт 100 орчим цахим хуудас ажиллаж байна.
- Улсын Их Хурлын [www.parliament.mn](http://www.parliament.mn) цахим хуудасны ухаалаг утас, хөдөлгөөнт төхөөрөмжүүдэд зориулагдсан хувилбар болох ParliamentMN аппликейшн бүтээгдсэн.
- [www.parliament.mn](http://www.parliament.mn) цахим хуудсаар чуулганы нэгдсэн хуралдааныг онлайнаар шууд дамжуулах шийдлийг боловсруулан хэрэгжүүлж, хуралдааны бичлэг болон сурталчилгааны видео материалуудыг интернетээр шууд дамжуулах боломжийг бүрдүүлсэн.
- Хууль тогтоох үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох, парламентын мэдээллийг шуурхай түгээх үүднээс Facebook, Twitter гэх мэт олон нийтийн /social/ цахим хуудсуудад байгууллагын эрхийг нээн ашиглаж эхэлсэн.
- Цахим шуудангийн албан ёсны лицензтэй Microsoft Exchange программ хангамжийг худалдан авч ашиглаж эхэлсэн.
- Дотоод сүлжээний мессенжер программ нэвтрүүлснээр сервер компьютер нь өөрийн сүлжээнд байрлаж, интернет орчноос хамааралгүйгээр дотоод сүлжээний орчинд ажиллах, мэдээллийн аюулгүй байдал хангагдах, файл дамжуулах хурд нэмэгдэх, серверт хэрэглэгчийн бүртгэлийг нэмэх, бүлэглэх, шилжилт хөдөлгөөнийг оруулах зэрэг боломж, давуу талууд бий болсон.
- Улсын Их Хурлын Тамгын газрын эд хөрөнгийн тооллого бүртгэлийн зураасан код уншигчтай системийг шинээр бүтээж нэвтрүүлсэн.
- Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурталчлах, олон нийтэд хүргэх зорилгоор чуулганы нэгдсэн хуралдааныг зөвхөн Сансар кабелийн телевизээр шууд дамжуулдаг байсныг өөрчлөн хүсэлт ирүүлж, шаардлагатай техникийн нөхцөлийг бүрдүүлсэн телевизүүдээр 2015 оны 8 дугаар сарын 01-ний байдлаар Юнивишн, Сансар, Скаймедиа кабелийн телевиз, МҮОНТ -ийн 2 -р суваг, ТМ телевиз, Төрийн ордны дотоод сүлжээ, Улсын Их Хурлын [www.parliament.mn](http://www.parliament.mn) цахим хуудсаар чуулганы нэгдсэн хуралдааныг шууд дамжуулж байна.
- Улсын Их Хурлын даргын гаргасан оюуны өмчийн зөрчилгүй программ хангамж ашиглах талаарх уриалгыг дэмжин программ хангамж хөгжүүлэгчдийн дунд “Нээлттэй эхийн программ хангамжийг нэвтрүүлэх, хөгжүүлэх боломж” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжид үндэслэн Улсын Их Хурлын Тамгын газарт нээлттэй эхийн систем нэвтрүүлсэн.
- Албан хэрэгцээнд ашиглагдаж буй хэрэглээний программ хангамжуудыг нээлттэй эхийн програмуудаар бүрэн сольж, санхүү бүртгэл, цахим номын сан, бичиг хэрэг зэрэг системүүдийг нээлттэй эхтэй зохицон ажилладаг болгож хөгжүүлснээр Улсын Их Хурлын Тамгын газар оюуны өмчийн зөрчилгүй программ хангамж ашигладаг байгууллага болсон.

- Компьютерийн сүлжээний серверийн өрөөг нүүлгэн шилжүүлж хяналтын системийг суурилуулан стандартад нийцүүлэн нийт 40 гаруй сервер компьютер бүхий цахим мэдээллийн төв /Datacenter/ байдлаар ажиллуулдаг болов
- Компьютерийн сүлжээний орц, гарц дээр халдлага илрүүлэх firewall төхөөрөмж суурилуулж мэдээллийн аюулгүй байдлын түвшинг дээшлүүлсэн.
- Улсын Их Хурлын гишүүд, Тамгын газрын удирдлагуудын албан хэрэгцээний MyParliament хөдөлгөөнт оффисийн системийг шинэчлэн сайжруулахын зэрэгцээ iOS, Android системийн хөдөлгөөнт төхөөрөмж, ухаалаг утсанд зориулсан ТМ эмхэтгэл, laws.mn аппликейшн програмуудыг ашиглан хууль тогтоох үйл ажиллагааны мэдээ мэдээлэл, хууль эрх зүйн актыг үнэ төлбөргүйгээр цахим хэлбэрээр шуурхай түгээх болсон. Мөн Улсын Их Хурлын даргын ивээл доор зохион байгуулагддаг багш, оюутны эрдэм шинжилгээний бага хурлын “Эврика” аппликейшн, сургалтын ном, гарын авлагыг үнэ төлбөргүй түгээх “ШУТИС контент” аппликейшныг хэрэглээнд нэвтрүүлсэн.
- 2013 онд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхимд 4 ширхэг дижитал камер бүхий системийг шинээр суурилуулж системийн бүрэн шинэчлэлт хийснээр Монгол Улс 2014 оны 7 дугаар сард тоон системд шилжих бэлтгэл хангагдаж чанарын өндөр түвшинд бичлэг хийх, чуулганы нэгдсэн хуралдааныг шууд дамжуулах боломжтой болсон.
- Улсын Их Хурлын гишүүд, Тамгын газрын удирдлагууд болон бусад шаардлагатай хэрэглэгчдийн албан өрөөнд Юнивишн IPTV холбож ашиглах боломжийг бүрдүүлсэн. Одоогоор нийт 100 орчим хэрэглэгч ашиглаж байна.
- Компьютер, техник хангамжийн шинэчлэлт өмнөх жилүүдтэй харьцуулахад хэд дахин илүү хийгдсэн. Тухайлбал, Тамгын газар, намын бүлгийн ажлын албаны ажилтнуудад өндөр үзүүлэлт бүхий нийт 110 гаруй компьютер хуваарилж олгосон.
- БНСУ-ын Засгийн газрын 3,5 сая ам.долларын буцалтгүй тусламжаар Солонгосын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /КОИКА/ -тай хамтран “Цахим парламент” төсөл хэрэгжүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан болон Байнгын хороодын хуралдааны цахим систем /программ хангамж/ нэвтрүүлсэн. Мөн парламентын сэтгүүлчдийн өрөө, техникийн удирдлагын өрөө, мэдээллийн төв зэрэг өрөө тасалгаануудыг шинээр байгуулан орчин үеийн өндөр үзүүлэлт бүхий тоон системийн тоног төхөөрөмжөөр иж бүрэн тоногдсон. Төслийн хүрээнд нийт 100 гаруй нэр төрлийн техник хэрэгслийг суурилуулж, 3.2км сувагчлалыг шинээр байгуулж, 5 төрлийн /дуу, дүрс, сүлжээ, шилэн, тэжээл/ нийт 10 км. орчим кабель шинээр татсан.
  - Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог болон ажпаа тайлагнадаг байгууллагуудын мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийн мэдээлэл туршлага солилцох уулзалтыг санаачлан 5 удаа зохион байгуулсан.
  - Улсын Их Хурлын цахим хуудсуудын кирилл /\*.мон/ домайн нэр ашиглах боломжтой болсон.
  - Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан болон байнгын хороодын хуралдааны дүрс бичлэгийг мөн дотоод сүлжээний дундын төхөөрөмжид шуурхай байрлуулан сүлжээгээр дамжуулан ашиглах техникийн нөхцлийг бүрдүүлсэн.
  - Сэтгүүлчдийн өрөө, техникийн удирдлагын өрөө, серверийн өрөөнүүдэд нийт 9 хяналтын камер нэмж байрлуулснаар тусгай зориулалтын тоног төхөөрөмжүүд байрладаг нийт 16 цэгт техникийн хяналтыг хэрэгжүүлэх боломжтой болсон.
  - Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ -ын Хөгжлийн хөтөлбөрийн хамтран

хэрэгжүүлж буй “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” болон “Иргэдийн оролцоотой хууль тогтоох үйл ажиллагааг дэмжих нь” төслийн хүрээнд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нэгдсэн портал [www.khural.mn](http://www.khural.mn) цахим хуудас бүтээх, хуулийн төслийн цахим хувийн хэргийн болон хэлэлцүүлгийн цахим систем байгуулах, аймаг, нийслэлийн дүүргийн Засаг даргын Тамгын газарт байрлах Иргэний танхимыг Байнгын хороод, ажлын хэсгийн хуралдааны танхим, Улсын Их Хурлын удирдлагын өрөөтэй холбох дүрст хурлын систем байгуулах ажлууд хийгдсэн. Төслийн хүрээнд бүтээгдсэн [www.khural.mn](http://www.khural.mn) портал цахим хуудасны “khuralMN” аппликейшн бүтээгдэн хэрэглээнд нэвтэрсэн.

2015 он:

- Скаймедиа IPTV -ийн дотоод сувгийн үйлчилгээг нэвтрүүлж, Улсын Их Хурлын гишүүдийн албан өрөөнд чуулганы нэгдсэн хуралдаан төдийгүй Байнгын хороодын хуралдаан, нээлттэй сонсголыг шууд дамжуулах боломжтой болсон.
- Улсын Их Хурлын Тамгын газар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь” болон “Иргэдийн оролцоотой хууль тогтоох үйл ажиллагааг дэмжих нь” төслийн хүрээнд Улсын Их Хурлын байнгын хороод, ажлын хэсгийн хуралдааны танхим, Улсын Их Хурлын удирдлагын өрөө, аймгуудын Засаг даргын Тамгын газарт байрлах Иргэний танхимууд зэрэг нийт 27 цэгийг холбосон, цаашид өргөтгөх боломжтой тоон технологийн дүрст хурлын иж бүрэн системийг шинээр суурилуулсан.
- Төрийн ордонд хуурайшилтаас үүдэн хуримтлагддаг статик цэнэгийн улмаас техник хэрэгсэлд гардаг гэмтлийг бууруулах зорилгоор хуралдааны танхимууд, техникийн удирдлагын өрөөнүүдэд газардуулгын нэмэлт систем байгуулсан.
- Улсын Их Хурлын Тамгын газар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй “Иргэдийн оролцоотой хууль тогтоох үйл ажиллагааг дэмжих нь” төслийн хүрээнд хэрэгжсэн “Хуулийн хувийн хэргийн болон хэлэлцүүлгийн цахим систем байгуулах” зөвлөх үйлчилгээний явцад цахим систем бүтээгдэн бэлэн болж суурилуулалт, тохиргоо, зүгшрүүлэлтийн ажлууд хийгдсэн.
- Мэдээллийн технологийндэд бүтэц, программ болон техник хангамж: Улсын Их Хурал, түүний Тамгын газар нь мэдээллийн технологийн бие даасан дэд бүтэцтэй, хууль тогтоох үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай программ төхөөрөмжүүдээр бүрэн хангагдсан. Зарим нэгэн тоо баримтуудаас дурдвал,
- Сүлжээний хэрэглэгчид 1500 /LAN 750, WiFi 750/, ширээний компьютер 450, зөөврийн компьютер 250, хөдөлгөөнт төхөөрөмж iPad 195, сервер компьютер 40, принтер 410, зурагт 230, тог баригч 220, хувилагч машин 30 гаруй, факсын аппарат 34, сканнер 30, компьютерийн дотоод сүлжээний нийт урт 20 гаруй км, хуралдааны тусгаарлагдсан сүлжээний кабелийн нийт урт 10 км гэх мэт.
- Программ хангамжийн хувьд хэрэглэгчийн тоо 450, үндсэн болон дэд цахим хуудас 100, өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдаж буй систем 7, ухаалаг утас, хөдөлгөөнт төхөөрөмжид зориулсан апликайшн 7 байна.

\*\*\*

Тамгын газарт бүтээмжийг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийг эрчимжүүлэхээр хийсэн зарим шинэлэг ажил үйлчилгээ

Мэдээлэл үйлчилгээ удирдлагын төв

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Том төрөөс ухаалаг төр рүү” санаачилгыг дэмжиж, судалгаанд суурилсан, үйлчилгээнд чиглэсэн, хууль дээдэлсэн ухаалаг төрийн зарчмыг хэрэгжүүлэхийг уриалсан зөвлөмжийн дагуу Монгол Улсын Их Хурлын дарга З.Энхболдын санаачлагаар Улсын Их Хурлын Тамгын газар үйл ажиллагаандаа “дахин инженерчлэл” (реинженеринг) хийж, үйл ажиллагааг оновчлох, өөрийгөө сайжруулдаг системийг бий болгохоор Мэдээлэл, үйлчилгээ, удирдлагын төвийг байгуулан ажиллуулж байна.

УИХ -ын Тамгын газарт хийгдэж буй дахин инженерчлэлийн ажлын үр дүн, судалгаа дүгнэлтийг үндэслэн ажилтнуудын ажлын чиг үүрэг, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, ажил үүргийн давхардал, хийдлийг арилгах, цомхон, чадварлаг бүтэц бүрдүүлэхээр МҮҮТөвийг УИХ -ын Тамгын газрын бүтэцэд шинээр оруулан зохион байгуулав.

Мэдээлэл, үйлчилгээ, удирдлагын төв нь Монгол Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаанд Тамгын газрын хэлтэс, албадаас үзүүлж буй мэргэшсэн болон нийтлэг ажил, үйлчилгээний ялгааг тогтоох, мэргэшсэн ажлын гүйцэтгэлийг хангуулах, нийтлэг ажил, үйлчилгээг нэг цонхоор төвлөрүүлэн явуулах, Тамгын газрын хэлтэс, албаны үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, төвийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, удирдлага - хяналтын оновчтой тогтолцоог бий болгох зорилготой.

Мэдээлэл үйлчилгээ удирдлагын төв нь Тамгын газрын дотоод үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулахдаа ажил, үйлчилгээнд гүйцэтгэлийн хяналт тавих, УИХ -ын дарга, Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргыг үйл ажиллагааны статистик мэдээгээр хангах үндсэн чиг үүрэгтэй.

Мэдээлэл, үйлчилгээ, удирдлагын төв нь 2014 оны 12 дугаар сарын 04 -ний өдрөөс үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд энэ хугацаанд УИХ-ын Тамгын газраас үзүүлдэг ажил, үйлчилгээнд судалгаа хийж, нийт ажил, үйлчилгээний процессийг тогтоож, процессийн гүйцэтгэлийг захиалга, хяналтын маягтаар боловсруулан, ажилтнуудын код, бүрдлийн маягтуудыг боловсруулан хэрэгжүүлж, дотоод шуудангийн үйл ажиллагааг нэвтрүүлэн ажиллаж байна.

2015 оны 01 дүгээр сарын 15 -наас тоон үзүүлэлтээр хэлтэс, алба тус бүрээр мэдээ гарган, УИХ-ын Тамгын газраас үзүүлдэг нийт ажил, үйлчилгээний захиалга, хяналтын маягтуудыг оновчлон, заавар загвар, хяналтын журнал, нэгтгэл гүйцэтгэлийн мэдээний маягтуудыг боловсруулж, 2016 оны 01 дүгээр сарын 4-нөөс эхлэн УИХ -ын Тамгын газрын хэлтэс, алба, нэгж тус бүрээр ажлын гүйцэтгэлийг тоон ба хугацааны үзүүлэлтээр 7 хоног тутам гаргаж, үндсэн чиг үүргийнхээ дагуу УИХ-ын дарга болон Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргыг үйл ажиллагааны нэгтгэсэн мэдээллээр хангадаг.

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2015 оны 01 дүгээр сарын 23 -ны өдрийн №74, 75 тоот захирамжаар төвийн ажиллах түр журам болон төвийн ахлагч, хяналтын хорооны бүтэц бүрэлдэхүүнийг баталсан ба Төвийн даргаар тус Тамгын газрын ажилтан удирдахуйн ухааны магистр, математикч Б. Төгөлдөр ийг томилжээ.

\*\*\*





Судалгааны албанаас хэрэгжүүлсэн зарим ажил үйлчилгээ

2012-2016 оны Монгол Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд Судалгааны хэлтсээс Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын гишүүд, Улсын Их Хурлын Байнгын хороо, хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсгээс нийт 269 судалгааны захиалга ирүүлсэнийг гүйцэтгэн тайланг захиалагчид хүргүүлэв.

Эдгээр судалгааны тайлангуудыг Улсын Их Хурлын гишүүд болон Тамгын газрын ажилтнуудын ажлын хэрэгцээнд зориулан Улсын Их Хурлын [intra.parliament.mn](http://intra.parliament.mn) дотоод сүлжээ, хөдөлгөөнт оффисын сүлжээний MyParliament цэст цахим хэлбэрээр, мөн Улсын Их Хурлын Номын сан, Архивт хэвлэмэл хэлбэрээр байршуулав. Мөн Улсын Их Хурлын [www.parliament.mn](http://www.parliament.mn) цахим хуудсанд судалгааны ажлын жагсаалт болон тойм аннотацийг тогтмол байршуулсан.

Тайлант хугацаанд нийт 35 ном товхимолыг эмхэтгэн хэвлүүлжээ. Мөн Үндсэн хуулийн 20 жилийн ойн хүрээнд “Ардчилсан Үндсэн хууль-20”, Байнгын ажиллагаатай Парламент байгуулагдсаны 25 жилийн ойд зориулсан “Байнгын ажиллагаатай парламент - 25 жил”, “Бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд судалгааны байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх нь” зэрэг эрдэм шинжилгээний хурлуудыг зохион байгуулж ажиллав.

\*\*\*

## УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

(Он цагийн дарааллаар, 2012 - 2016)

2012.08.30

АНУ-ын Бүгд Найрамдахчуудын олон улсын хүрээлэн (IRI)-гийн Монгол Улс дахь хөтөлбөрийн захирлаар шинээр томилогдсон Рафаэл Бэжар Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Шаравдоржтой уулзаж Улсын Их Хурлын Тамгын газартай хамтран ажиллаж ирсэн уламжлалт харилцаагаа өргөжүүлэн хөгжүүлэх талаар санал солилцлоо. АНУ-ын Ардчиллын түншлэлийн байгууллага (HDP)-ийн санаачлагаар АНУ-ын Конгрессын Судалгааны албаны сургагч багш нар Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны төвийн судлаач, шинжээч нарт зориулан 5 хоногийн сургалт семинар зохион байгуулахаар төлөвлөж байгааг хөтөлбөрийн шинэ захирал дуулгав.

Улсын Их Хурлын Тамгын газрын Нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн манай улсад албаны ёсны айлчлал хийж буй Бүгд Найрамдах Социалист Вьетнам улсын Үндэсний Ассамблейн Хууль зүйн байнгын хорооны дэд дарга ноён Данг Динх Лиен тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав. Манай улсын парламентын үйл ажиллагаанаас туршлага судлахаар ирсэн төлөөлөгчид Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг сонирхон хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийлэв.

2012.09.10

АНУ-ын Ардчиллын түншлэлийн байгууллага, Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэнгийн урилгаар ирсэн АНУ-ын Конгрессын Судалгааны албаны сургагч багш Фрэнсис Мико, Билл Робинсон нар Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны төвийн судлаач, шинжээч нарт зориулан сургалт зохион байгуулав. Хууль тогтоох байгууллагын судалгааны албаны ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх үүднээс зохион байгуулагдаж буй уг сургалт 5 хоног үргэлжлэв.

2012.09.14

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Шаравдорж Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны төвийн ажилтнуудад сургалт явуулж, туршлагаа хуваалцсан АНУ-ын Конгрессын Судалгааны албаны сургагч багш нарыг хүлээн авч уулзлаа. АНУ-ын Конгрессын Судалгааны албаны сургагч багш Фрэнсис Мико, Билл Робинсон нар Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны төвийн судлаач, шинжээчдэд зориулан 5 хоногийн сургалт зохион байгуулсан юм.

2012.09.18

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Шаравдорж “Жи-Мобайл” ХХК-ийн Хамтын ажиллагааны газрын захирал Н.Заяа, Маркетингийн хэлтсийн дарга Б.Наранхүү нарыг хүлээн авч уулзав.

Энэ үеэр тус компаниас Улсын Их Хурлын Тамгын газарт 32 ширхэг таблет төхөөрөмж U-TAB-ыг бэлэглэлээ. Энэхүү төхөөрөмжийг ашигласнаар Жи-Мобайлын сүлжээгээр дамжин утасгүй интернетийн сүлжээнд холбогдохоос гадна албан ёсны андройд үйлдлийн систем, байрлал тодорхойлох GPS үйлчилгээтэй бөгөөд орон нутаг дахь Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурталчлах танхимын ажилтнууд Улсын Их Хурлын



Тамгын газрын аппликейшнийг /хэрэглээний программ, мэдээлэл/ татаж авч мэдээ, мэдээллээр шуурхай хангагдах боломжтой болох юм.

2012.10.01

Улсын Их Хурлын шинэчлэгдсэн цахим хуудсын нээлтэд Улсын Их Хурлын дарга З.Энхболд оролцож үг хэлэв. “Хууль тогтоох үйл ажиллагааг иргэд, сонгогчдод ил тод, нээлттэй болгоход мэдээллийн технологийн ололтуудыг ашиглах, олон нийтийн сайтуудаар дамжуулан мэдээллийг шуурхай түгээх боломжийг бүрдүүлэх зорилгоор Улсын Их Хурлын албан ёсны <http://www.parliament.mn> цахим хуудсыг шинэчлэн нийтийн хүртээл болгож байна. Үндсэн энэ сайтаас гадна Улсын Их Хурлын бүх гишүүний нэрээр 76 вэб сайт ажиллаж, парламентын үйл ажиллагааг иргэдэд сурталчлан цахим засаглал, цахим парламентын хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулах боломж нээгдэж байна. Ингэснээр Улсын Их Хурал төрийн бусад байгууллагаас хамгийн нээлттэй нь байх болно” гэдгийг Улсын Их Хурлын дарга онцоллоо.

2012.10.11-23

Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнууд Арабын Бүгд Найрамдах Египет Улсын нийслэл Кайр хотноо Египетийн сангаас зохион байгуулж буй 14 хоногийн сургалтад хамрагдав. Сургалтад хамрагдагсад Египетийн Хууль зүйн Үндэсний хүрээлэнд хичээллэж, Арабын Бүгд Найрамдах Египет Улсын парламент болон хууль, эрх зүйн зарим байгууллагын үйл ажиллагаатай танилцан туршлага судалсан юм.

2012.10.12

Улсын Их Хурлын Тамгын газар, АНУ-ын Бүгд Найрамдахчуудын олон улсын хүрээлэнтэй хамтран “Улсын Их Хурлын гишүүний туслахууд, нийслэлээс сонгогдсон Улсын Их Хурлын гишүүний бие төлөөлөгч-туслахуудад зориулсан сургалт” зохион байгуулав.

2012.10.24

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос эрхлэн “Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагаа, цаашид боловсронгуй болгох арга зам” сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлэгт Улсын Их Хурлын Байнгын хороодын дарга нар, Улсын Их Хурлын зарим гишүүд, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудын удирдлага, Тамгын газрын хэлтэс албадын дарга, ажилтнууд, их дээд сургуулийн эрдэмтэн судлаачид оролцож хууль тогтоох байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад ажлын алба буюу Тамгын газар хэрхэн ажиллах талаар санал солилцов.

2012.10.26

Улсын Их Хурлын Тамгын газар, БНСУ -ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /КОИКА/-тай хамтран БНСУ-ын Засгийн газрын 3,5 сая ам. долларын буцалтгүй тусламжаар “Цахим парламент” багц төслийг 2013-2015 онд үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тохиролцож, хэлэлцээрийн протоколд гарын үсэг зурлаа. Гарын үсэг зурах ёслолын ажиллагаанд БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын Суурин төлөөлөгч Чой Хын Ёл болон БНСУ-ын мэргэжилтнүүд, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Шаравдорж болон албаны бусад

хүмүүс оролцов. Нийтдээ 3,5 сая ам. долларын өртөгтэй энэ төсөл нь Улсын Их Хурал болон Байнгын хороодын үйл ажиллагааг боловсронгуй, олон нийтэд нээлттэй, ил тод болгоход чухал ач холбогдолтой юм.

2012.11.08

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Шаравдоржийг үүрэгт ажлаас нь чөлөөлж, Улсын Их Хурлын даргын санал болгосны дагуу Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргаар Б.Болдбаатарыг томилов.

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргыг чөлөөлөх, томилох асуудлыг чуулганаар хэлэлцэж шийдвэрлэгдсэний дараа Тамгын газрын шинэ хуучин дарга нар ажлаа хүлээлцэв. Энэ арга хэмжээнд Улсын Их Хурлын дэд дарга С.Баярцогт, УИХ -ын гишүүн Г. Батхүү нар оролцов.

2013.01.21

Улсын Их Хурлын даргын ивээл дор Улсын Их Хурлын Тамгын газраас Монголын залуу программистуудын холбоо, Линукс хэрэглэгчдийн бүлгэмтэй хамтран “Нээлттэй эхийн программ хангамжийг нэвтрүүлэх, хөгжүүлэх боломж” сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулав.

2013.02.06

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Цогтсайхан нар Албан хаагчдыг сэлгэн ажиллуулах журам батлах тухай хамтарсан шийдвэрт гарын үсэг зурлаа.

2013.02.07

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбооноос Төрийн ордонд зохион байгуулж байгаа уулзалт семинарт оролцон хууль сурталчлах, хуулийг хэрэгжүүлэхэд хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах боломж, шаардлагын талаар мэдээлэл хийж, орон нутгийн сэтгүүлчидтэй санал солилцов.

2013.03.25

Улсын Их Хурлын Тамгын газар болон Батлан хамгаалах яамны албан хаагчдыг сэлгэн ажиллуулах журам батлах тухай хоёр байгууллагын хамтарсан шийдвэрт Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, хошууч генерал З.Болдбаатар нар гарын үсэг зурав.

2013.05.13

Улсын Их Хурлын Тамгын газраас ажилтнуудын мэдлэг чадварыг дээшлүүлэх, чадавхийг бэхжүүлэх зорилгоор зохион байгуулж байгаа цуврал сургалтын хүрээнд Үндэсний статистикийн хорооноос “Статистик мэдээллийн нэгдсэн сан [www.1212.mn](http://www.1212.mn) EzStat, Monstat ann-аас статистикийн тоон мэдээллийг ашиглах” сэдэвт сургалт зохион



байгуулав. Сургалтад Тамгын газрын ажилтнууд болон Улсын Их Хурлын гишүүдийн туслахууд оролцож 1212.мн цахим хуудсан дахь статистик мэдээллийг хэрхэн ашиглах талаар мэдээлэл авав.

2013.05.15

Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргадаг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн тусгай дугааруудыг хүлээлгэн өгөх ёслолын арга хэмжээ Төрийн ордонд болов. Арга хэмжээг нээж Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн Зөвлөлийн дарга Б.Болдбаатар хэлсэн үгэндээ, Улсын Их Хурлын Тамгын газраас төрийн байгууллагуудад төдийгүй аймаг, нийслэл дэх Иргэний танхим, Парламентын үйл ажиллагааг сурталчлах төвүүд болон төрийн өмчийн болон төрийн бус өмчийн их, дээд сургууль, төрийн бус байгууллагууд, нийтийн номын сан зэрэг нийт 70 орчим байгууллагад “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн тусгай дугааруудыг үнэ төлбөргүй хүлээлгэн өгөхөөр шийдвэрлэсэнээ мэдэгдэв.

2013.06.03

Улсын Их Хурлын Тамгын газар хууль тогтоох дээд байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод хүргэх ажлын хүрээнд Парламентын сэтгүүлчдийн шуурхай ажиллах боломжийг бүрдүүлэх зорилгоор сэтгүүлчдийн өрөөг өндөр үзүүлэлт бүхий компьютерээр шинэчлэн тохижуулав. Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар энэ үеэр хэлэхдээ интернэтийн хурд нэмэгдсэнээс гадна цаашид сэтгүүлчдийн ашиглах компьютерт нээлттэй эхийн программ суулгана гэдгээ мэдэгдэв.

2013.09.18

Монголын ахмадын холбооны ерөнхийлөгч Ц.Сүхбаатар “Ахмадад ээлтэй байгууллага” хүндэт өргөмжлөлийг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатарт гардуулав.

Улсын Их Хурлын Тамгын газраас Улсын Их Хурлын гишүүний туслахуудад зориулсан ажлын байран дахь сургалт зохион байгуулж, сургалтыг Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар нээж үг хэллээ.

2013.09.19

Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Швейцарын хөгжлийн агентлагаас хамтран хэрэгжүүлж байгаа “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн нээлтийн хэлэлцүүлэг НҮБ-ын төв байранд болж, хэлэлцүүлгийн нээлтэд Улсын Их Хурлын дарга З.Энхболд оролцож үг хэлэв. Тэрээр Үндсэн хуульд заасан эрх мэдлээ бодитоор хэрэгжүүлэхэд нутгийн өөрөө удирдах байгууллагуудын санхүүгийн бие даасан байдал, чадамж сул байгаа нь ихээхэн саад болж байгаа талаар олон жил шүүмжлэн ярьж ирснийг дурдаад, шинээр батлагдаж энэ оны 1 дүгээр сарын 1 -нээс хэрэгжиж эхэлсэн Төсвийн тухай хуулиар орон нутгийн өөрөө мэдэж зарцуулах хөрөнгө 2010 онтой харьцуулахад 2.3 дахин нэмэгдсэнийг дуулгалаа.

2013.10.08

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар

Швейцарийн Женев хотноо болсон Олон Улсын Парламентын Холбооны 129 дүгээр Ассамблейн хүрээнд Парламентын Ерөнхий нарийн бичгийн дарга нарын холбооны ээлжит хуралдаанд оролцов.

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс, Парламентын сэтгүүлчдийн холбоо хамтран парламентын сэтгүүлчдэд зориулан “Улсын Их Хурлын үйл ажиллагааны ил тод байдал, парламентын сэтгүүл зүй” нэртэй сургалтыг “Бага баян” амралт, үйлчилгээний цогцолборт зохион байгууллаа.

2013.10.23-26

Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгаа, шинжилгээний хэлтсээс санаачлан судлаачид болон Тамгын газрын ажилтнуудад зориулсан нийгмийн судалгааны SPSS программ ашиглах, судалгааны мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх, тайлан мэдээлэл боловсруулах, ашиглах арга зүйн сургалт зохион байгуулав.

2013.11.01

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны “Койка” байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын орлогч дарга Вүдон Ван нар Улсын Их Хурлын Тамгын газарт хэрэгжүүлэх “Цахим парламент” төслийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж гарын үсэг зурлаа.

2013.11.12

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар Олон улсын “Revenue Watch institute” байгууллагын Евроазийн бүсийн зохицуулагч Галиб Эфендиевтэй уулзаж, байгалийн нөөц баялгийн ашиглалтын ил тод байдлыг хангах чиглэлээр хамтран хэрэгжүүлэх хөтөлбөрийн талаар саналаа солилцов.

2013.11.13

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар БНХАУ-ын Түвдийн Өөртөө засах орны Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хорооны Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч Дуньжуданзэн тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.

2013.11.15

Төрийн үйлчилгээний цахим машин буюу ТҮЦ машинаар дамжуулан Улсын Их Хурлын Тамгын газрын үйлчилгээг иргэдэд хүргэх ажлын явцын талаар Мэдээлэл технологи, шуудан, харилцаа холбооны газраас Улсын Их Хурлын гишүүдэд танилцуулав.

2013.12.19

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар хурууны хээгээр бүртгэх системийн техникийн шийдлийн талаар сэтгүүлчдэд мэдээлэл хийлээ. Улсын Их Хурлын гишүүдийн ирцийг хурууны хээгээр бүртгэж эхэлсэнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын Тамгын газраас хэвлэл мэдээллийн ажилтнуудыг чуулганы нэгдсэн хуралдааны танхимд оруулж, санал хураалтын систем хэрхэн ажиллаж байгаатай танилцуулав.



## 2014.01.03

2014 оны 01 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийг төр, захиргаа, шүүх, эрх мэдэл, хууль сахиулах байгууллагууд, их, дээд, дунд сургууль, нийтийн номын сангуудад үнэ төлбөргүй тараах шийдвэр гаргасан билээ.

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, «Төрийн мэдээлэл» эмхэтгэлийн зөвлөлийн дарга Б.Болдбаатар “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийг үнэ төлбөргүй тараах зарим байгууллагуудын төлөөлөлд эмхэтгэлийн 2014 оны анхны дугаарыг гардуулан өгөв.

Энэ арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Шүүхийн Ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, шинжлэх ухааны яам, нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын төлөөлөлөгч хүрэлцэн ирж “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2014 оны анхны дугаарыг гардан авлаа.

## 2014.01.11

Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнуудын онолын мэдлэгийг дээшлүүлж, чадавхижуулах сургалтыг эрх зүй, эдийн засаг болон бусад шаардлагатай чиглэлээр бүтэн жилийн туршид явуулахаар төлөвлөсний дагуу ахисан түвшний эхний сургалтыг “Эрх зүйн зохистой орчныг бий болгоход эрх зүйн эх сурвалжийн онолын гүйцэтгэх үүрэг: Нийтлэг жишгийн болон Үндэсний загвар, хандлага”, “Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага: Онол, үзэл баримтлал, хандлага” сэдвээр явуулав. Сургалтад Улсын Их Хурлын Байнгын хороодын ажлын алба, Тамгын газрын Хууль зүйн үйлчилгээний хэлтсийн Эрх зүйн экспертний алба, Судалгаа, шинжилгээний хэлтсийн Судалгааны алба, Хяналт, үнэлгээний хэлтсийн Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих албаны эрх зүйч мэргэжилтэй 60 -аад ажилтан оролцов.

## 2014.01.13

Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсаны 22 жилийн ойн өдрийг тохиолдуулан шинэ Үндсэн хуулийн уг эхийг Төрийн түүхийн музейд залав. Төрийн хамгаалалтад байдаг Үндсэн хуулийн эхийг залах хүндэтгэлийн ёслолд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга П.Цагаан, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, Төрийн ёслолын албаны дарга Ж.Сэрээжав, Төрийн ордны хамгаалалтын албаны дарга, дэд хурандаа Ц.Мөнхтүвшин нар оролцлоо.

Улсын Их Хурлын даргын Ажлын алба, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс, НҮБ-ын Хүн амын сангаас хамтран хүн амын хөгжил, жендэрийн тэгш байдал, гэр бүлийн хүчирхийлэл, нөхөн үржихүйн эрүүл мэнд, ХДХВ/ДОХ -ын асуудлаар нийт сэтгүүлчдийн дунд зарласан шилдэг нийтлэл, нэвтрүүлгийн уралдааныг дүгнэлээ. Уралдаанд нийт 13 хэвлэл, мэдээллийн байгууллагын 19 уран бүтээлч материалаа ирүүлсэн байна.

## 2014.01.24

Улсын Их Хурлын Тамгын газрын санаачлагаар Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог болон ажлаа тайлагнадаг байгууллагуудын мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийн мэдээлэл, туршлага солилцох уулзалт зохион байгуулав.

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар Улсын Их Хурлын даргын уриалгын дагуу Тамгын газар нээлттэй эхийн програм хангамжийг нэвтрүүлэх ажлыг 2013 онд бүрэн хэрэгжүүлсний зэрэгцээ мэдээллийн технологийн давуу талыг ашиглан Улсын Их Хурлын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах арга хэмжээ авч, ухаалаг төхөөрөмж хэрэглэдэг бүх хүн хууль тогтоох байгууллагаас батлан гаргасан эрх зүйн актуудыг хүссэн цагтаа нэг дороос олж авч ашиглах боломжтой болсныг уулзалтын үеэр мэдэгдэв.

2014.01.27

Улсын Их Хурлын дарга З.Энхболд болон Улсын Их Хурлын Тамгын газрын удирдлагууд сар шинийн баярыг тохиолдуулан Тамгын газарт олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудаа хүлээн авч уулзан санал хүсэлтийг нь сонсов.

Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурал болон Улсын Их Хурлын гишүүд, мөн Тамгын газарт ажиллаж байсан 57 ахмадын 40 гаруй нь уулзалтад хүрэлцэн ирэв.

2014.02.07

Монгол Улсын Их Хурал, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж байгаа “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн хүрээнд “Ардчилсан засаглалын институцийн хөгжил: (1992-2013) сургамж ба шинэтгэлийн санал” сэдэвт судалгааны тайлан, зөвлөмжийн талаар Удирдлагын академид хэлэлцүүлэг зохион байгуулав. Уг арга хэмжээнд эрдэмтэн судлаачид, холбогдох төрийн байгууллагуудын төлөөлөл оролцлоо.

2014.02.15

Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарын Хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хамтарсан “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд нийслэлийн Налайх, Багануур дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг чадавхижуулах сургалт зохион байгуулав.

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, төслийн үндэсний захирал Б.Болдбаатар энэхүү төслийн хүрээнд орон нутгийн сонгуульт төлөөлөгчдөд зориулсан сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх механизмыг бий болгож байна.

Мөн шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хөхиүлэн дэмжих замаар сонгуульт төлөөлөгчдийн хариуцлага болон хурлын хяналтын үүргийг нэмэгдүүлж, нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн орчныг сайжруулахад чиглэгдэж байгааг онцлов.

2014.02.17

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, төслийн үндэсний захирал Б.Болдбаатар Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарын Хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хамтарсан “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Булган аймагт зохион байгуулагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг чадавхижуулах сургалтын нээлтэд оролцож, орон нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаатай танилцав.





2014.02.20

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Засаглалын багийн ахлагч Ц.Даваадулам Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнуудад “Ухаалаг төрийн талаарх үзэл баримтлал” сэдвээр мэдээлэл хийж, санал солилцов.

Мэдээллийн эхэнд Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар “Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн “Том төрөөс ухаалаг төр лүү” санаачилгыг дэмжин төрийн байгууллагууд хэлэлцүүлэг явуулж, энэ чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээгээ төлөвлөн ажиллаж байгааг мэдээлэв.

2014.03.01

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, төслийн үндэсний захирал Б.Болдбаатар Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарын Хөгжлийн агентлаг, НҮБ -ын Хөгжлийн хөтөлбөрийн хамтарсан “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Өвөрхангай аймагт зохион байгуулсан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг чадавхижуулах сургалтыг нээж үг хэлэв.

2013 оны 6 дугаар сараас хэрэгжиж эхэлсэн уг төслийн хүрээнд нутгийн удирдлагын хариуцлага, орон нутгийн үйлчилгээг сайжруулах, орон нутгийн хурлын төлөөллийн болон хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх, төлөөлөгчдөд зориулсан үндэсний сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх механизм бий болгох, иргэдийн оролцоог хангаж байгаа сайн туршлагыг дэлгэрүүлэх, нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн орчныг сайжруулах зэрэг цогц арга хэмжээг хэрэгжүүлэхээр юм.

2014.03.03

Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх зорилгоор Завхан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөд зориулсан сургалтыг Улиастай хотод зохион байгуулав.

Сургалтын нээлтэд Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, Улсын Их Хурлын даргын зөвлөх З.Нарантуяа, Завхан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Б.Отгонбаатар нар оролцов.

2014.03.21

Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарын Хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран хэрэгжүүлж байгаа “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг чадавхижуулах сургалт зохион байгуулав.

2014.03.24

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар БНАЛАУ-ын Үндэсний Ассамблейн гишүүн, Тамгын газрын дарга Унгээв Вутилад тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа.

2014.03.28

Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарын Хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн

хөтөлбөр хамтран хэрэгжүүлж байгаа “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг чадавхижуулах сургалт зохион байгуулав.

2014.04.02

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар Бүгд Найрамдах Турк Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Мурат Карагөзийг хүлээн авч уулзаж, хоёр орны парламент хоорондын хамтын ажиллагааны талаар санал солилцов.

2014.04.03

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар Латви Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ингрида Лэврэнсэг хүлээн авч уулзлаа.

2014.04.23

Улсын Их Хурлын дарга З.Энхболд “Дэлхийн номын өдөр”-ийг тохиолдуулан Улсын Их Хурлын Тамгын газраас уншигч, хэвлэн нийтлэгчид, номын үйлдвэрлэл, худалдаа эрхлэгчидтэй хамтран Төрийн ордонд зохион байгуулж буй номын үзэсгэлэнд зочлов.

2014.05.10

Улсын Их Хурын Тамгын газрын ажилтнууд Мод тарих үндэсний өдрөөрр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд мод тарилаа.

2014.05.20

Улсын Их Хурлын Тамгын газрын удирдах ажилтнууд “Байгууллагын өрсөлдөх чадварыг сайжруулах нь” сэдэвт сургалтад хамрагдлаа. “Өөрчлөлтийг чиглүүлэгч” төв, “Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв” хамтран анх удаа энэхүү сургалтыг зохион байгуулав.

2014.05.27

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, Швейцарийн хамтын ажиллагааны дэд захирал Дийпак Элмер болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн суурин төлөөлөгч, хатагтай Сезин Синагоглу нар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг чадавхижуулах үндэсний хэмжээний сургалт удирдах эрх бүхий хүмүүст сертификат гардуулав.

Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарийн хамтын ажиллагаа, НҮБ -ийн Хөгжлийн хөтөлбөр хамтран хэрэгжүүлж буй “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд бүх шатны сургалтыг 8 сарын хугацаанд зохион байгуулж, 62 хүнд сургагч багшийн эрх олгосон байна.

2014.05.29

Монголд анх удаа цахим хаягийг эх хэлээрээ буюу кирилл үсгээр ашиглах үйлчилгээг “Датаком” ХХК нэвтрүүлснээр Улсын Их Хурлын цахим хаягийг эх хэлээрээ ашиглах боломжтой боллоо. Тус компани нь УЛСЫН-ИХ-ХУРАЛ.МОН, УИХ.МОН, МОНГОЛ-УЛСЫН-ИХ-ХУРАЛ.МОН, МУИХ.



МОН, ПАРЛАМЕНТ.МОН, НЭЭЛТТЭЙ-ПАРЛАМЕНТ.МОН, ИХ-ХУРАЛ.МОН, ХУРАЛ.МОН гэсэн найман домэйн нэрийг ашиглалтад оруулсныг “Датаком” ХХК-ийн ерөнхий захирал Г.Энхболд Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатарт хүлээлгэж өгөв.

2014.06.09

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар Бүгд найрамдахчуудын Олон улсын хүрээлэнгийн Суурин төлөөлөгч хатагтай Гречин Күнзийг хүлээн авч уулзаж, хоёр талын цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцов.

2014.06.24

Туркийн хамтын ажиллагаа, зохицуулах агентлаг /ТИКА/-ийн санхүүжилтээр Улсын Их Хурлын номын санг цахим хэлбэрт шилжүүлэх, хэвлэх цехийн тоног төхөөрөмжийг шинэчлэх төслийн нээлтийн ёслол Улсын Их Хурлын номын санд болов.

Улсын Их Хурлын даргын урилгаар манай улсад албан ёсоор айлчилж байгаа Бүгд Найрамдах Турк Улсын Үндэсний Их Хурлын даргын айлчлалын хүрээнд болж буй энэхүү ёслолын ажиллагаанд Монгол Улсын Их Хурлын дарга З.Энхболд, Туркийн Үндэсний Их Хурлын дарга Жемил Чичек, албаны бусад хүмүүс оролцлоо.

2014.06.29-07.02

Бүгд Найрамдах Чех Улсын Парламентын Доод танхимын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Петр Кинштетр тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад айлчлав. Айлчлалын хүрээнд Бүгд Найрамдах Чех Улсын Парламентын Доод танхимын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Петр Кинштетр тэргүүтэй төлөөлөгчдийг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар хүлээн авч уулзаж, Хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурав.

2014.07.09

Улсын Их Хурлын Тамгын газрын удирдлагууд Их Монгол Улс байгуулагдсаны 808 жил, Ардын хувьсгалын 93 жилийн ойг угтаж төр, засгийн хариуцлагатай албанд олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадууддаа хүндэтгэл үзүүлж, санал хүсэлтийг нь сонсов.

2014.08.14

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн урилгаар БНХАУ-ын дарга Си Жин Пин манай улсад айлчлах гэж байгаатай холбогдуулан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдааныг 8 дугаар сарын 22-нд хийхээр товлосон болохыг сэтгүүлчдэд албан ёсоор мэдэгдэв.

2014.08.18

Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарийн хөгжлийн агентлаг, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр хамтран хэрэгжүүлж буй “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Khural.mn иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нэгдсэн цахим хуудсыг бий болгосон. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаанд

иргэдийн оролцоог хангахад чиглэгдсэн энэхүү цахим хуудсыг ашиглах сургалтыг аймаг, дүүрэг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны ажилтнуудыг оролцуулан зохион байгуулав.

2014.09.26

Олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан Улсын Их Хурлын дарга З.Энхболд болон Тамгын газрын удирдлагууд Тамгын газарт олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудаа хүлээн авч уулзан, санал бодлыг нь сонслоо.

Улсын Их Хурлын Тамгын газрын санаачлагаар “Бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд судалгааны байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав.

Энэхүү хэлэлцүүлэгт Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, Улсын Их Хурлын Тамгын газрын Нарийн бичгийн дарга Н.Отгончимэг, Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга Ц.Норовдондог нар болон Улсын Их Хурлын харьяа судалгааны чиг үүрэгтэй байгууллагын төлөөлөгчид, эрдэмтэн, судлаачид оролцов.

2014.10.24

Улсын Их Хурлын зарим гишүүдийн гар утасны дугаарыг ашиглан Газрын тухай хууль, “Bank of China”, төмөр замын царигтай холбоотой мессежийг “Мобиком” корпораци, “Юнител” группийн үүрэн телефоны сүлжээгээр тойргийн сонгогчдод болон нийтэд тараасан үйлдэл гарсантай холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар сэтгүүлчдэд мэдээлэл хийлээ.

Энэхүү үйлдэл нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсэгт иргэний халдашгүй байх эрх, мөн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хуулиар хамгаалагдсан Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хөндсөн гэж үзэж байна. Мөн Улсын Их Хурлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.6 дахь хэсэгт “Гишүүний харилцуур утас болон бусад тусгай хэрэглээний холбооны хэрэгсэл төрийн хамгаалалтад байх бөгөөд бүрэн эрхээ хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа явуулахтай холбогдсон шуудан, захидал харилцааны болон мэдээллийн нууцыг задруулахыг хориглоно”, Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасан “Иргэний нэрийг хууль бусаар ашиглахыг хориглоно” гэж заасныг тус тус зөрчжээ.

Иймд Улсын Их Хурлын зарим гишүүний утасны дугаарыг ашиглаж мэдээ тараасан үйлдлийг шалгуулах болон зохих залруулга хийлгэх талаар холбогдох байгууллагад хандсан болохыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар албан ёсоор мэдэгдэв.

2014.11.18

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх С.Ламбаа, Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга О.Батханд нар сэтгүүлчдэд мэдээлэл хийж, Улсын Их Хурлын дарга З.Энхболд “Б.Чимидийн нэрэмжит шагнал олгох журам батлах тухай” захирамж гаргасан талаар танилцуулав.

Хууль тогтоох дээд байгууллагын нэрийг ашиглаж мэдээ мэдээлэл тараах, санал асуулга явуулах зэрэг ёс зүйгүй үйлдлүүд гарч байгаатай холбогдуулан Улсын Их Хурлын



Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга О.Батханд сэтгүүлчдэд мэдээлэл хийв.

2014.11.24

Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарийн хамтын ажиллагаа, НҮБ -ийн Хөгжлийн хөтөлбөр хамтран хэрэгжүүлж байгаа “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд бүх шатны сургалтыг найман сарын хугацаанд зохион байгуулсан юм. Төслийн хүрээнд 16 тэтгэлгийн хэрэгжилт, үр дүнг хэлэлцэх, сайн туршлага солилцох семинарыг Төрийн ордны Иргэний танхимд зохион байгуулав.

2014.12.06

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар Данийн Вант Улсад айлчилж, Данийн Вант Улсын Парламентын дарга Могенс Ликкеттофт бараалхав. Мөн тус улсын хууль тогтоох дээд байгууллага Фолькетингетийн Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Гарстен У.Ларсентай уулзаж санал солилцон Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Данийн Вант Улсын Фолькетингетийн Тамгын газар хоорондын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж, гарын үсэг зурав.

2014.12.12

Улсын Их Хурлын Тамгын газар, Парламентын сэтгүүлчдийн холбоо хамтран сэтгүүлчдэд зориулж “Парламентын нээлттэй, ил тод байдал, парламентын сэтгүүл зүйн онцлог, сэтгүүлчийн ёс зүй, хариуцлага” эмхэтгэл хэвлэн гаргасан талаар Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга О.Батханд, Парламентын сэтгүүлчдийн холбооны тэргүүн Ж.Алтангэрэл нар сэтгүүлчдэд мэдээлэл хийлээ.

2014.12.24

Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран хэрэгжүүлж байгаа “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн хүрээнд “Мэдээллийн ил тод байдлыг хангах, мэдээлэл авах эрхийг хэрэгжүүлэх чиглэлээрх сайн туршлага, санаачилгууд” сэдэвт зөвлөлдөх уулзалтыг Хууль зүйн үндэсний хүрээлэнд зохион байгуулав.

2015.01.11

Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсаны 23 жилийн ойн өдөрт зориулан Улсын Их Хурлын дарга З.Энхболдын ивээл дор уламжлал болгон зохион явуулдаг шатар сонирхогчдын улсын аварга шалгаруулах тэмцээн Төрийн ордонд хоёр өдөр үргэлжилж өндөрлөлөө. Энэ удаагийн тэмцээнд эрэгтэй шатарчдаас С.Алтангэрэл 7.5 оноогоор, эмэгтэй шатарчдаас Т.Март 7 оноогоор тэргүүн байрт шалгарч алтан медаль хүртэв.

2015.01.12

Монгол Улсын Үндсэн хуулийн 23 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд шинэ Үндсэн хуулийн уг эхийг Төрийн түүхийн музейд хүндэтгэлтэйгээр залах ёслол болов.

Орчин үеийн техник, технологийн дэвшлийг ашиглан бүтээсэн Төрийн ордонтой танилцах цахим аяллын /<http://tour.parliament.mn/> вэб хуудсыг албан ёсоор нээх ёслол болов.

2015.01.13

Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсаны 23 жилийн ойг тохиолдуулан Улсын Их Хурлын Тамгын газраас зохион байгуулсан үндэсний бөхийн барилдаанд Булган аймгийн Бүрэгхангай сумын уугуул, улсын заан Д.Баасандорж түрүүлж, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын уугуул улсын харцага Э.Оюунболд үзүүрлэлээ.

2015.03.03

Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнууд “Эрдэс баялгийн гэрээний шинжилгээ, мониторинг” сэдэвт сургалтад хамрагдав.

2015.03.14-18

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар Бүгд Найрамдах Чех Улсад айлчлал хийв.

2015.04.08

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын Тамгын газрын 2014 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцээд Улсын Их Хурлын Тамгын газар чиг үүргээ хангалттай хэрэгжүүлж байна гэж дүгнэлээ. Улсын Их Хурлын Тамгын газар, Монголын хуульчдын холбоо хамтран ажиллах санамж бичиг байгуулж, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, Монголын хуульчдын холбооны ерөнхийлөгч Д.Батсүх нар гарын үсэг зурав.

2015.04.17

Улсын Их Хурлын Тамгын газар иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг нээлттэй хэлэлцэн шийдвэрлэх зорилгоор Төрийн ордны дөрөвдүгээр давхарт “Нээлттэй сонсголын танхим” байгуулав.

2015.04.18

Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр парламентын сэтгүүлчдэд зориулсан “Парламент ба иргэдийн харилцааг бэхжүүлэхэд сэтгүүлчдийн оролцоо” сэдэвт сургалт зохион байгуулав.

2015.04.23

Улсын Их Хурлын Тамгын газраас Дэлхийн номын өдрийг тохиолдуулан Төрийн ордонд “Номын өдөрлөг” зохион байгуулав.

2015.05.04

Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж байгаа “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн хүрээнд “Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд үндсэн



хуулийн гүйцэтгэсэн үүрэг: Дүн шинжилгээ” судалгааны тайлан номын нээлт болов. Энэхүү арга хэмжээний үеэр ийг хийж, чөлөөт ярилцлага зохион байгууллаа.

2015.05.04

Улсын Их Хурлын Тамгын газраас НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж буй “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн хүрээнд Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр боловсруулсан “Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг: Дүн шинжилгээ” судалгааны тайлан,» номын нээлт болов.



**УИХ -ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн Үндэсний захирал Б. Болдбаатар**

Нээлтийн ажиллагааны үеэр «Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлт» сэдвийн хүрээнд УИХ -ын зарим гишүүд, эрдэмтэн судлаачид, сонирхогч талууд санал солилцож чөлөөт ярилцлага өрнүүлэв. Уг арга хэмжээнд УИХ «ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, төслийн Үндэсний захирал Б. Болдбаатар оролцож үг хэлэв.

Тэрээр хэлсэн үгэндээ, “Монгол Улс Ардчилсан Үндсэн хуулиа батлан мөрдөж эхэлсэнээс хойш 23 жилийн ой тохиож буй энэ цаг хугацаанд бид Үндсэн хуулиа эргэн харж хэлэлцэж байна. Монгол Улсын Их Хурал, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр хамтран “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийг 2013 оны 3 дугаар сараас эхлэн хэрэгжүүлж байна.

Тус төсөл нь хууль тогтоох ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, иргэд ба сонгогчдын харилцаа холбоог улам ойртуулах, энэ дагуу хууль тогтоомжийг шинэчлэхэд судалгаа, хэлэлцүүлгээр дэмжих, УИХ-ын холбогдох байнгын хороодын чадавхийг дэмжин бэхжүүлэх, Авлигатай тэмцэх НҮБ-ын Конвенцын хэрэгжилтийг хангах чадавхийг дэмжихээс гадна Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санааны дагуу Монгол Улсад

ардчиллыг бэхжүүлэх чиглэлээр хийсэн шинэтгэл, төрийн институцийн хөгжлийн 20 жилийн туршлага, сургамжийн талаар дэлгэрэнгүй шинжилгээ хийж, шаардлагатай шинэтгэлийн талаар зөвшилцөл бий болгоход хувь нэмэр оруулахад чиглэгдэж байна.

Энэ зорилгоор нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр бүрдсэн баг болох Удирдлагын Академийн Удирдахуйн ухааны сургуулийн дэд захирал, профессор Ч.Энхбаатар, Үндсэн хуулийн цэцийн гишүүн профессор Д.Солонго, УИХТГ-ын Хууль зүйн үйлчилгээний хэлтсийн ахлах зөвлөх П.Амаржаргал нар болон Олон улсын зөвлөх АНУ-ын Чикагогийн их сургуулийн Хуулийн сургуулийн профессор Томас Гинсбург нар хамтран Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн тодорхой институтуудын гүйцэтгэсэн үүрэг, сургамжийг судлан дүгнэж мөн цаашид шинэчлэн хөгжүүлэх зөвлөмж боловсруулсан” гэлээ.

2015.05.07

Улсын Их Хурлын Тамгын газар нь нийслэлийн Сүхбаатар дүүргийн “Хамгийн олон даатгуулагчтай харилцагч байгууллага”-аар шалгарав.

2015.05.09

Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудын дунд “Улсын Их Хурлын цом-2015” шилжин явах цомын төлөөх урлаг, спортын наадам эхэллээ.

Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнууд Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ой, Ялалтын 70 жилийн ойд зориулсан төгөлд мод тарилаа.

2015.05.14

Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж байгаа “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн манлайлал” сэдэвчилсэн сургалтын сургагч багш нарын 3 дахь сургалтыг “Энхийн төлөө” цогцолборт зохион байгуулав.

2015.05.19

ОХУ-ын Бүгд найрамдах Буриад улсын сэтгүүлчдийн төлөөлөл Төрийн ордонд зочилж, парламентын үйл ажиллагаатай танилцан Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн ажилтнуудтай уулзаж санал солилцон, туршлагаасаа хуваалцав.

2015.05.23

Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан “Улсын Их Хурлын цом-2015” урлаг, спортын наадамд Улсын Их Хурлын Тамгын газар хоёрдугаар байрт шалгарав.

2016.06.17

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар Данийн





Вант Улсын Фолькетингетийн /Парламент/ даргын Хэвлэл, мэдээллийн зөвлөх Финн Соренсен тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.

2015.06.20

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хамтран хэрэгжүүлж байгаа “Нутгийн өөрөө удирдах байгууллагыг чадавхийг бэхжүүлэх нь” төслийн хоёр дахь шатны сургалт Баянхонгор аймагт зохион байгуулагдав.

2015.06.26

АНУ -ын Конгрессын ардчиллын түншлэлээс Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнуудад зориулан цуврал сургалт зохион байгуулав.

2015.06.28

Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Швейцарийн хөгжлийн агентлаг хамтран “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг хөгжүүлж, эрх зүйн орчныг сайжруулах нь” сэдэвт зүүн бүсийн аймгуудын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагуудын онол практикийн бага хурал, туршлага солилцох чуулга уулзалтыг Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд зохион байгуулав.

2015.07.08

Улсын Их Хурлын Тамгын газар жил бүрийн Үндэсний их баяр наадмын үеэр ахмад настнуудаа хүлээн авч, хүндэтгэл үзүүлдэг уламжлалт уулзалтыг Төрийн ордонд зохион байгуулав.

2015.07.22

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар И Жун Хү тэргүүтэй Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Ассамблейн зөвлөх хорооны багийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.

2015.08.19

Монгол Улсын Их Хурал, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ) -ын Парламентын Ассамблейн 2015 оны намрын хурлыг Монгол Улсад зохион байгуулах Үндэсний хорооны гишүүн, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар Монгол Улсад байнга суугаа гадаад улсын дипломат болон консулын төлөөлөгчийн газрын тэргүүнүүдтэй уулзаж, уг арга хэмжээний талаар мэдээлэл хийв.

2015.08.25

Улсын Их Хурлын Тамгын газрын Захиргаа, нийтлэг үйлчилгээний хэлтсийн дарга Н.Ширэндэв ЕАБХАБ -ын Парламентын Ассамблейн 2015 оны намрын хурлыг Улаанбаатар хот дахь Шангри-Ла зочид буудалд зохион байгуулах гэрээнд гарын үсэг зурав.

2015.09.02

Улсын Их Хурлын Тамгын газар Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойд зориулж Улсын Бага Хурал болон үе үеийн Улсын Их Хурлын хууль тогтоох, төрийн бодлого тодорхойлох үйл ажиллагааны талаар «Улсын Бага хурлын түүхэн товчоон, 1990-1992», «Монгол Улсын байнгын ажиллагаатай парламентын Тамгын газар», «Улсын Бага Хурал 1990 - 1992», «Найргийн хуртай Монгол парламент», «Монгол Улсын парламент III, IV боть» ... зэрэг хэд хэдэн номыг УИХ -ын Тамгын газраас эрхлэн хэвлүүлжээ.

2015.09.09

Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойн хүрээнд Улсын Их Хурлын Тамгын газар, Монгол Улсын Үндэсний номын сан, Улаанбаатар хотын төв номын сантай хамтран номын үзэсгэлэн зохион байгуулав.

2015.09.11

Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойд тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Төрийн түүхийн музейн үзэсгэлэнгийн танхимд “Төрийн түшээдийн бүтээл” номын үзэсгэлэн, Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргасан шинэ ном товхимлуудыг танилцуулах арга хэмжээ, Парламентын 25 жилийн түүхийг харуулсан баримтат кино болон гэрэл зургийн үзэсгэлэнгийн нээлтүүд тус тус боллоо.

2015.09.12

Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Улсын Бага Хурал болон Улсын Их Хурлын үе үеийн гишүүд, түүний Тамгын газрын ажилтнуудын дунд шатрын тэмцээн зохион байгуулав.

2015.09.13

Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойд тохиолдуулан Улсын Их Хурлын Тамгын газраас зохион байгуулсан үндэсний бөхийн барилдаан Монгол бөхийн өргөөнд боллоо.

2015.09.23

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар Бүгд Найрамдах Солонгос Улсын КОЙКА-ийн Монгол дахь суурин төлөөлөгчийг хүлээн авч уулзав.

2015.10.07

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, төслийн үндэсний удирдагч Б.Болдбаатар “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Дорноговь аймагт ажиллалаа.

2015.10.08

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, төслийн үндэсний



захирал Б.Болдбаатар “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Говьсүмбэр аймагт ажиллалаа.

2015.10.19

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хамтран хэрэгжүүлж байгаа “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Баянхонгор, Говь-Алтай, Төв, Сүхбаатар аймгуудтай онлайнгаар холбогдож, дүрст хурлыг Баянхонгор аймгаас удирдан явуулав.

2015.10.31

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хэрэгжилтийг хянаж үнэлэх аргачлалын төслүүдэд санал өгөх” хэлэлцүүлэгт оролцлоо.

2015.11.09

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс Улсын Их Хурлын Хууль зүйн болон Төрийн байгуулалтын байнгын хороотой хамтран Парламентын сэтгүүлчдэд зориулж, Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журмын тухай хуулиудын талаар цуврал сургалт зохион байгуулав.

2015.11.10

Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарийн хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран хэрэгжүүлж байгаа “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд “Орон нутгийн сонгуульт төлөөлөгчдөд зориулсан үндэсний сургалтын хөтөлбөрийг институтчлэх: явц ба стратеги” сэдэвт хэлэлцүүлэг болов.

2015.11.25

Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байгаа “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслөөс Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтран Хууль тогтоомжийн тухай болон Захиргааны ерөнхий хуулийг танилцуулах сургалт зохион байгуулав.

2015.12.01

Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарийн хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж байгаа “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн удирдах зөвлөлийн 6 дугаар хурал Төрийн ордонд боллоо.

2015.12.30

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 195 дугаар тогтоолын дагуу 2015 онд улс

орон даяар явагдсан “Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт”-ын улсын үзлэгт Улсын Их Хурлын Тамгын газар төрийн байгууллагуудаас шалгарч Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдав.

2016.01.11

Монгол Улсын ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсаны 24 жилийн ойн өдөр тохиож буйтай холбогдуулан шинэ Үндсэн хуулийн уг эхийг залах ёслол Төрийн түүхийн музейд болов.

Төрийн хамгаалалтад байдаг Үндсэн хуулийн уг эхийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга П.Цагаан, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, Үндсэн хуулийн 24 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах комиссын дарга, Улсын Их Хурлын Тамгын газрын Захиргаа, нийтлэг үйлчилгээний хэлтсийн дарга Н.Ширэндэв нар хүндэтгэлтэйгээр заллаа.

2016.01.13

Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, Үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Бяраагийн Чимидийн нэрэмжит шагнал гардуулах ёслол болж, Б.Чимидийн нэрэмжит шагнал олгох тухай Улсын Их Хурлын даргын захирамж, шагналын Өргөмжлөлийг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар уншиж сонордуулав.

Улсын Их Хурлын дарга З.Энхболд Б.Чимидийн нэрэмжит шагналыг Монгол Улсын гавьяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор И.Дашнямд гардуулж баяр хүргэлээ.

Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсаны 24 жилийн ойг тохиолдуулан Улсын Их Хурлын Тамгын газраас зохион байгуулсан үндэсний бөхийн барилдаан бөхийн өргөөнд болов. Энэ удаагийн барилдаанд Увс аймгийн Ховд сумын харьяат улсын арслан Н.Батсуурь найм даван түрүүлж, Архангай аймгийн Хашаат сумын харьяат улсын заан Ч.Санжаадамба үзүүрлэлээ.

Үндэсний бөхийн барилдааны үеэр шинэ Үндсэн хуулийн өдөрт зориулсан шатар сонирхогчдын улсын аварга шалгаруулах дөрөв дэх удаагийн тэмцээнд түрүүлсэн оролцогч нарт Улсын Их Хурлын дарга З.Энхболд өргөмжлөл, медаль гардуулж баяр хүргэлээ.

2016.01.15

Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсаны 24 жилийн ойн өдрийг тохиолдуулан Төрийн түүхийн музейд залсан шинэ Үндсэн хуулийн уг эхийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн албан өрөөнд хүндэтгэлтэйгээр буцааж залав.

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсаны 24 жилийн ойн өдрийг тохиолдуулан шинэ Үндсэн хуулийн уг эхийг тав хоногийн хугацаатайгаар Төрийн ордонд залж иргэд, олон нийтэд сонирхуулах боломж олгосон Монгол Улсын Ерөнхийлөгчид Улсын Их Хурал, түүний Тамгын газрын нэрийн өмнөөс талархал илэрхийлээд шинэ Үндсэн хуулийн уг эхийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга П.Цагаанд гардуулж өгөв.



2016.01.22

“Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудын 2015 оны авлигын эсрэг үйл ажиллагаанд хийсэн үнэлгээний тайлан” сэдэвт уулзалт болов.

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар уулзалтыг нээж хэлсэн үгэндээ, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагаанд хийсэн хөндлөнгийн байгууллагын үнэлгээний тайлан танилцуулах арга хэмжээ 3 дахь жилдээ болж байна. Үнэлгээний дүнг өнгөрсөн жилүүдийнхтэй харьцуулахад ахиц гарсан нь эдгээр байгууллагууд авлигын эсрэг санаачилгатай ажилласны үр дүн гэж харж байна гэлээ.

Уулзалтад Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар Н.Ганболд, Үндэсний аудитын газрын дарга А.Зангад, Хүний эрхийн үндэсний комиссын дарга Ж.Бямбадорж, Санхүүгийн зохицуулах хорооны дарга З.Нарантуяа болон Монголбанк, Сонгуулийн ерөнхий хороо, Төрийн албаны зөвлөлийн холбогдох албан тушаалтнууд, Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнууд болон “Эм Ди Эс анд Хаан Лекс” хуулийн фирмийн төлөөлөл оролцов.

2016.02.03

Улсын Их Хурлын Тамгын газар, “Нийгмийн дэвшил-эмэгтэйчүүдийн хөдөлгөөн” ТББ хамтран НҮБ-ын Ардчилсан сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Цахим засаглалаар дамжуулан хууль боловсруулах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь” төслийн хүрээнд цахим хэлэлцүүлгийн платформын нээлт болж, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар хууль, тогтоолын төслийг өргөн мэдүүлэхийн өмнө олон нийтээр хэлэлцүүлэхэд зориулагдсан тусгай платформыг нээж буй талаар танилцуулав.

Уг арга хэмжээний нээлтэд Улсын Их Хурлын дарга З.Энхболд оролцож хэлсэн үгэндээ “Хууль тогтоомжийг хэлэлцэж баталдаг, хэрэгжилтэд нь хяналт тавьдаг байгууллага бол Улсын Их Хурал. Энэ эрхээ хэрэгжүүлэхдээ иргэдийн саналыг сонсож, тэдний оролцоог хангах үүрэг хүлээдэг. Хууль тогтоох үйл явцад иргэд шууд оролцож, хуулийн төсөлд онлайнгаар санал өгөх боломж бүрдүүлсэн вэб сайтын нээлт өнөөдөр болж байна. Иргэд энэ платформыг ашиглан парламенттай шууд харилцаж, мэдээлэл солилцох замаар “амьд харилцаа” үүснэ гэсэн үг. Мөн хууль санаачлагчдын зүгээс иргэд, сонгогчидтой харилцах шинэ суваг нээгдэж байна” гэлээ.

2016.02.05

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Женифер З.Гаалтыг хүлээн авч уулзав. АНУ-ын Конгрессын Ардчиллыг дэмжих түншлэлийн хөтөлбөр амжилттай хэрэгжиж ирснийг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга дурдаад, энэхүү хөтөлбөр нь манай хоёр орны хууль тогтоох дээд байгууллагуудын хооронд туршлага солилцох гол механизмуудын нэг болохын зэрэгцээ манай улсын хууль, эрх зүйн тогтолцооны шинэчлэлд ихээхэн хувь нэмэр оруулж байгааг онцоллоо.

2016.02.08

Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалтын хүрээнд Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг зохион байгуулах ажлын бэлтгэл хангаж ажиллах

үүрэг бүхий Ажлын хэсэг хуралдаж, уулзалтын зохион байгуулалт, бэлтгэл ажлын талаар санал солилцов. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Гадаад хэргийн яам, Төрийн ёслолын алба, Төрийн тусгай хамгаалалтын газар, Онцгой байдлын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар болон холбогдох яам, газруудын албаны хүмүүс багтжээ.

2016.02.15-21

Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хамтран хэрэгжүүлж байгаа “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Улсын Их Хурлын гишүүн Су.Батболд, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, зарим аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга нар болон албаны бусад хүмүүс БНСУ-д ажиллаж, нутгийн удирдлагын туршлага судлав.

2016.02.22

Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалтын хүрээнд Улаанбаатар хотноо болох Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг зохион байгуулах ажлын бэлтгэл хангах үүрэг бүхий Ажлын хэсэг хуралдаж, уулзалтын бэлтгэл ажлын явцтай танилцан, цаашид хэрэгжүүлэх ажлуудын талаар зөвлөлдөв. 2016 оны 07 дугаар сард Монгол Улсад болох Ази, Европын Дээд түвшний XI уулзалтын хүрээнд энэ оны 04 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалт Улаанбаатар хотод болох юм.

2016.02.24

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар Европын Холбооны Гадаад харилцааны албаны АСЕМ-ын асуудал хариуцсан ахлах зөвлөх Майкл Мэтиссэн тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.

Монгол Улс АСЕМ-ын Дээд түвшний 11 дүгээр уулзалтыг зохион байгуулах гэж байгаад Европын Холбоо баяртай байгаа. Учир нь Монгол Улс ардчиллыг бэхжүүлэх сайн туршлагатай төдийгүй энэ онд АСЕМ-ын 20 жилийн ой тохиож байгаа чухал жил болж буйгаараа онцлог юм. Иймд Европын Холбоо энэхүү дээд түвшний уулзалтыг зохион байгуулах Монгол Улсыг тууштай дэмжинэ гэдгээ Майкл Мэтиссэн мэдэгдлээ.

2016.03.04

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар Бүгд Найрамдах Энэтхэг Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Сомнат Гошийг хүлээн авч уулзав.

Монгол Улсын Их Хурал Ази, Европын Дээд түвшний 11 дүгээр уулзалт (АСЕМ)-ын хүрээнд Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг Улаанбаатар хотноо ирэх 04 дүгээр сарын 21-23-ны өдрүүдэд зохион байгуулах бөгөөд одоогийн байдлаар 20 орны 90 гаруй төлөөлөгч уулзалтад оролцохоор бүртгүүлээд байгааг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар энэ үеэр танилцуулав.



2016.03.07

Ази, Европын Дээд түвшний 11 дүгээр уулзалт (АСЕМ)-ын хүрээнд Улаанбаатар хотод зохиогдох Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг зохион байгуулах Үндэсний хорооны гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд болон Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар нар Монгол Улсад байнга суугаа гадаад улсын дипломат болон консулын төлөөлөгчийн газрын тэргүүнүүдтэй Гадаад хэргийн яаманд уулзаж, уг арга хэмжээний талаар мэдээлэв.

Ази, Европын Дээд түвшний XI уулзалтын хүрээнд зохиогдох эхний томоохон арга хэмжээ нь Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалт юм. Улсын Их Хурлын даргын 2016 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 28 дугаар захирамжийг үндэслэн энэхүү уулзалтыг зохион байгуулах ажлын бэлтгэлийг хангах үүрэг бүхий Үндэсний хороо байгуулагдан ажиллаж байгааг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар энэ үеэр танилцуулав.

2016.03.10

Ази, Европын Дээд түвшний XI уулзалт (АСЕМ)-ын хүрээнд Улаанбаатар хотод зохион байгуулагдах Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг зохион байгуулах ажлын бэлтгэлийг ханган ажиллах үүрэг бүхий Ажлын хэсэг хуралдаж, уг уулзалтын зохион байгуулалт, бэлтгэл ажлын талаар зөвлөлдөв. Уг уулзалтад одоогийн (тухайн үедээ) байдлаар 23 улс болон Европын парламентаас нийтдээ 100 гаруй төлөөлөгч оролцохоо илэрхийлээд байгаа. Үүнээс парламентын дарга гурав, дэд дарга зургаа бүртгүүлээд байгаа гэдгийг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар энэ үеэр мэдэгдэв.

2016.03.14

Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг зохион байгуулах ажлын бэлтгэл хангах үүрэг бүхий Үндэсний хорооны ээлжит хуралдаан болж, уулзалтын бэлтгэл ажлын явц байдлын талаар санал солилцов.

Хуралдаанд тус хорооны дарга, Улсын Их Хурлын дэд дарга Р.Гончигдорж, хорооны гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Улсын Их Хурлын гишүүн С.Оюун, Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэн, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, Улсын Их Хурлын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтсийн дарга, Үндэсний хорооны нарийн бичгийн дарга Ц.Нарантунгалаг болон бусад албаны хүмүүс оролцлоо.

2016.03.23

Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг зохион байгуулах ажлын хэсгийн хуралдаан болж, уулзалтын бэлтгэл ажлын явц болон цаашид хийж хэрэгжүүлэх ажлуудын талаар зөвлөлдөв.

Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, Ази, Европын парламентын түншлэлийн IX уулзалтад оролцох урилгыг АСЕМ-ын гишүүн 51 орны парламентын дээд, доод танхимуудын дарга нар болон олон улсын 2 байгууллагад албан ёсоор хүргүүлээд байгаа. Иймд бусад орны парламентын төлөөлөгчидтэй холбогдож, оролцуулах талаар арга хэмжээ авахыг холбогдох албаны хүмүүст үүрэг өглөө.

2016.03.29

Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг зохион байгуулах ажлын бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсэг хуралдаж, уулзалтын бэлтгэл ажлын явц байдлын талаар санал солилцож зөвлөлдөв.

Энэхүү уулзалтад өнөөдрийн байдлаар Болгар, Литва, Итали, Пакистан, Энэтхэг, Индонези, Финланд, Унгар, Чех, Польш, Бельги, Камбодж, ОХУ, Лаос, Норвеги, Швейцарь, Сингапур, Дани зэрэг 33 орны, мөн Европын парламентаас нийт 130 гаруй төлөөлөгч оролцох саналаа ирүүлээд байна. Үүнээс 5 орны парламентын дарга, 7 орны парламентын дэд дарга нар оролцохоор мэдэгдээд байгаа ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, Улсын Их Хурлын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтсийн дарга Ц.Нарантунгалаг танилцуулав.

2016.04.06

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын 2015 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, энэ талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар хийлээ.

Хуралдааны эцэст байнгын хорооны дарга А.Бакей Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагаа өнгөрсөн 4 жилд жигдэрсэн, олон шинэлэг ажил санаачлан амжилттай хэрэгжүүлсэн нь Улсын Их Хурлын гишүүдэд мэдрэгдэж, үр дүнгээ өгч байгааг тэмдэглээд цаашид Тамгын газрын ажилтнуудын чадавхи, хариуцлагын асуудлыг хамтад нь авч үзэж хариуцлагыг улам жигдрүүлэхэд анхааралыг сануулав.

Улсын Их Хурлын Тамгын газрын 2015 оны үйл ажиллагааны тайланг байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэнтэй холбогдуулан байнгын хорооноос тогтоол гаргаж холбогдох байгууллагуудад чиглэл өгөхөөр тогтов.

2016.04.08

Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулиас санаачлан Улсын Их Хурлын Тамгын газар, Хууль зүйн яам, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монголын хуульчдын холбоо, Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэнтэй хамтран НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн дэмжлэгтэйгээр “Хууль зүйн нэр томъёоны судалгаа, хэрэглээ” сэдэвт улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурал зохион байгууллаа.

2016.04.13

Ази, Европын парламентын түншлэлийн IX уулзалтыг зохион байгуулах ажлын бэлтгэл хангах үүрэг бүхий Ажлын хэсэг уулзалтын зохион байгуулалт, бэлтгэл ажлын талаархи ээлжит хуралдаанаа хийв.

Хуралдааны эхэнд тус уулзалтыг зохион байгуулах Ажлын хэсгийн ахлагч, УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар зохион байгуулалтын бэлтгэл ажлын явц байдлын талаар Ажлын хэсгийн гишүүн бүрээс мэдээлэл сонсч, Ази, Европын парламентын түншлэлийн IX уулзалтыг зохион байгуулж буй байгууллагуудыг нягт холбоотой ажиллахыг анхааруулав.





2016.04.18

Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг зохион байгуулах ажлын бэлтгэл хангах үүрэг бүхий Ажлын хэсгийн хуралдаан болж, Ажлын хэсгийн ахлагч, УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар мэдээлэл хийв.

Өнөөдрийн байдлаар 32 улс болон Европын парламентаас нийт 152 төлөөлөгч уг уулзалтад оролцохоор бүртгүүлснээс парламентын дарга 3 /Энэтхэг (Доод танхим), Итали (Сенат), Тайланд/, дэд дарга 11 /Австрали, Итали (Төлөөлөгчдийн танхим), Индонези, Финланд, Унгар, Польш, Вьетнам, Испани (2 танхимын 4 дэд дарга)/ оролцохоор байна. Мөн ажиглагчаар гадаадын 5, дотоодын 5 байгууллагын төлөөлөгчид оролцоно гэдгийг танилцуулав.

2016.04.20

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг зохион байгуулах Үндэсний хорооны Ажлын хэсгийн дарга Б.Болдбаатар сэтгүүлчдэд мэдээлэл хийлээ. Ази, Европын Дээд түвшний 11 дүгээр уулзалт (АСЕМ) -ын хүрээнд Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалт 2016 оны 04 дүгээр сарын 21-23 -ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдах гэж байна.

Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтын бэлтгэл бүрэн хангагдлаа. Өнөөдрийн байдлаар 32 улс болон Европын парламентаас нийт 152 төлөөлөгч бүртгүүлснээс парламентын дарга 3 /Энэтхэг (Доод танхим), Итали (Сенат), Тайланд/, дэд дарга 11 Австрали, Итали (Төлөөлөгчдийн танхим), Индонези, Финланд, Унгар, Польш, Вьетнам, Испани (2 танхимын 4 дэд дарга) оролцохоор байна.

Мөн хоёр олон улсын байгууллага оролцохоор бүртгүүлсэн. Бүгд Найрамдах Энэтхэг улсын парламентын Доод танхим /Лок Сабха/-ын дарга хатагтай Сумитра Махажан даваа гарагт Монгол Улсад хүрэлцэн ирж, албан ёсны айлчлалаа үргэлжлүүлж байна. Өнөөдөр орой Бүгд Найрамдах Итали Улсын Парламентын Сенатын танхимын Ерөнхийлөгч ноён Пьетро Грассо манай улсад хүрэлцэн ирнэ гэдгийг мэдэгдлээ.

2016.05.14

Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнууд Бүх нийтээр мод тарих үндэсний өдрөөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд мод тарьж, «Парламент - 2» төглийг байгуулав. Энэ удаагийн арга хэмжээнд Улсын Их Хурлын дарга З.Энхболд, Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Д.Сарангэрэл нар оролцов.

Энэ өдөр Улсын Их Хурлын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Хөгжлийн банк, Үндсэн хуулийн цэц зэрэг төрийн байгууллагууд, мөн төрийн бус зарим байгууллага, 100 гаруй аж ахуйн нэгж, их, дээд сургууль болон дунд сургуулиудын төлөөлөл болсон 4000 орчим иргэн 14 нэр төрлийн 3500 орчим мод, бут, сөөг тарилаа.

2016.05.30

Монгол Улсын Их Хурал, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран 2013 оны 3 дугаар сараас эхлэн хэрэгжүүлж байгаа “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн 2016 оны эхний хагас жилийн Удирдах зөвлөлийн хурал боллоо.

Зөвлөлийн хурлыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Төслийн үндэсний захирал Б.Болдбаатар удирдан явуулсан бөгөөд төслийн 2016 оны

эхний хагас жилийн тайланг сонсож, цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудын талаар ярилцаж, санал солилцов. Тайланг төслийн зохицуулагч Н.Отгончимэг танилцуулав.

Уг төсөл нь 2012 - 2016 онд Монгол Улсад хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ардчилсан засаглалын салбар дахь НҮБ -ын Хөгжлийн хөтөлбөр болон Монгол Улсын Засгийн газрын хамтын ажиллагааны нэг хэсэг юм.

2016.06.07

АСЕМ -ийн Дээд түвшний уулзалтын хүрээнд Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг зохион байгуулах ажлын бэлтгэл хангах үүрэг бүхий Үндэсний хорооны зүгээс үүргээ амжилттай гүйцэтгэсэн Ажлын хэсгийн хамт олонд талархал гардуулав.

Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтын бэлтгэлийг ажлын хэсэг өндөр түвшинд гүйцэтгэсэн болохыг Ажлын хэсгийн даргаар ажилласан УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар онцлон тэмдэглээд уралдааны явцад аюулгүй байдал, хамгаалалт гээд олон талын үйл ажиллагаанд идэвхтэй ажиллан, бүх талын арга хэмжээг авч уулзалтыг амжилттай зохион байгуулсан ажлын хэсгийн нийт хамт олонд талархал илэрхийлсэн юм.

2016.6.10-11

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарийн хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн 2013-2016 онд хэрэгжүүлж буй “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал /ИТХ/-уудын уулзалт, семинар 2016 оны 06 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд Хөвсгөл аймгийн Хатгал суманд болов.

Уулзалтыг Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь” төслийн Үндэсний захирал Б.Болдбаатар нээж, үг хэлсэн юм. Тэрээр, “Нутгийн удирдлага: Сорилт ба шийдэл” үндэсний чуулганыг Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр хамтран 2015 оны 12 дугаар сарын 16-нд Улаанбаатар хотноо зохион байгуулсан.

Тус чуулганаар нутгийн удирдлагад тулгамдаад байгаа нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай асуудлууд буюу нутгийн удирдлагад засаглалын эрх мэдлийн тэнцвэрийг хангах, чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах замаар нутгийн удирдлагын хариуцлагыг дээшлүүлэх, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг шинэчлэх, нутгийн удирдлагын өмчлөлийг шийдвэрлэх замаар бие даасан байдлыг нэмэгдүүлэх, эрх зүйн орчныг шинэчлэх хэрэгцээ шаардлагын талаар судлаачдын тавьсан илтгэл, шийдлийн хувилбаруудыг авч хэлэлцсэн юм.

Улмаар “Нутгийн удирдлагын тогтолцоо”, “Чиг үүргийн хуваарилалт”, “Нутгийн удирдлагын эрх зүйн шинэтгэл” гэсэн гурван салбар хуралдааныг хийж, орон нутгийн удирдлагад тулгарч буй асуудлууд, чуулганаас гарах завлөмжийг дэлгэрэнгүй авч хэлэлцлээ. Чингээд тус чуулганд тавигдсан нээлтийн болон үндсэн илтгэлүүд, салбар хуралдааны тэмдэглэл, чуулганаас гарсан зөвлөмжийг нэгтгэн “Нутгийн удирдлага: Сорилт ба шийдэл” хэмээх эмхэтгэлийг бүрэн эхээр нь толилуульж байгаадаа баяртай



байна. Энэхүү эмхэтгэл нь хууль тогтоогчид, бодлого боловсруулагчид, судлаачид ашиглах чухал эх сурвалж болно гэдэгт найдаж байна” гэлээ.

Мөн тэрээр нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн орчныг сайжруулахаар ажиллаж буй ИТХ-уудын төлөөлөгчдөд амжилт хүсч, харилцан туршлага судлахын зэрэгцээ нутгийн удирдлагад иргэний оролцоог нэмэгдүүлж сайн туршлагыг дэлгэрүүлэхэд энэхүү уулзалт, семинар чухал ач холбогдолтой болохыг онцолсон юм.

Швейцарийн хөгжлийн агентлагийн Хамтын ажиллагааны Дэд захирал хатагтай Габриэлла Спирли энэхүү уулзалтад оролцож буй Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудын төлөөлөгчдөд хандаж, “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь” төсөл хэрэгжиж эхлэхээс өмнө ИТХ-ын төлөөлөгчдөд зориулсан системтэй сургалт зохион байгуулагдаггүй байсан.

Үдэсний хэмжээнд 8000 гаруй хурлын төлөөлөгчид суурь сургалтын хүрээнд нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн орчин, хурлын хэлэлцүүлэг, төсөв, төлөвлөлт, ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалт, байгаль орчны менежмент зэрэг чухал асуудлаар мэдлэг, чадвараа дээшлүүлээд байна. Эдгээр сургалтууд хурлын үйл ажиллагааг идэвхжүүлэх, энэ хүрээнд дотоод үйл ажиллагааг нь сайжруулах, иргэдэд илүү нээлттэй, тэдний өмнө хариуцлагатай байх явдлыг сайжруулахад чухал нөлөө үзүүлсэн болохыг тэмдэглэсэн юм.

Төслөөс хэвлэсэн “Нутгийн удирдлага: Сорилт ба шийдэл чуулганы илтгэлийн эмхэтгэл”, “ИТХ-ыг дэмжих тэтгэлгийн сайн туршлага” мөн “ИТХ-ын сайн туршлага” номуудын нээлтийн ажиллагааны дараа “Нутгийн удирдлагад иргэний оролцоо” сургалтын агуулга, хөтөлбөрийн талаарх хэлэлцүүлэг зохион байгуулагдаж, төлөөлөгчид харилцан туршлага судалсан юм.

Ийнхүү хоёр өдөр үргэлжилсэн энэхүү уулзалтаар төлөөлөгчид харилцан туршлага солилцож, нутгийн удирдлагын талаарх иргэний боловсролын сургалтын хөтөлбөрийн танилцуулга хийхийн сацуу Хөвсгөл аймгийн ИТХ-ын туршлагыг судалсан юм.

Энэхүү уулзалт, семинарыг төслийн зохицуулагч П.Лхам зохион байгуулж, УИХ-ын Тамгын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Э.Түвшинжаргал, УИХ-ын Тамгын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны референт Б.Төгсцэнгэл, УИХ-ын Тамгын газрын ерөнхий аудитор Ц.Лхагвагэрэл, УИХ-ын Тамгын газрын ахлах референт С.Тэрбиш, Хөвсгөл аймгийн ИТХ-ын дарга Т.Болдбаатар, Хөвсгөл аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга С.Цогтоо, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорнод, Дундговь, Төв, Өвөрхангай аймгийн ИТХ -уудын төлөөлөгчид, “Тунгаамал төв” ТББ, “Иргэний боловсролын төв” ТББ, Орон нутгийн хөгжлийн хүрээлэн болон албаны бусад хүмүүс оролцжээ.

2016-06-14

“Төлөөллийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн үнэлгээний хорооны хурал Төрийн ордонд боллоо. “Төлөөллийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн баримт бичгийг танилцуулах энэ удаагийн хуралд УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, Нарийн бичгийн дарга П.Амаржаргал, Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Б.Энхболд, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Орлогч суурин төлөөлөгч Даниэла Гаспарикова, Швейцарийн хөгжлийн агентлагийн Хамтын ажиллагааны Дэд захирал Габриэлла Спирли болон Азийн сан, Удирдлагын академи, “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг

бэхжүүлэх нь”, “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн ажилтнууд, “Нутгийн удирдлага” ТББ-ын төлөөлөл оролцов.

Энэ өдрийн хуралдааныг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Орлогч суурин төлөөлөгч Даниэла Гаспарикова удирдан явуулсан бөгөөд төслийн баримт бичгийн талаар НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Засаглалын багийн ахлагч Ц.Даваадулам танилцуулсан юм.

УИХ-ын Тамгын газар Швейцарийн хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн тусламжтайгаар “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь”, “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслүүдийг 2013-2016 онд хэрэгжүүлж байгаа билээ. Дээрх хоёр төслийн хүрээнд бий болгосон үр дүнг бэхжүүлэх, үндэсний тогтвортой механизм бий болгох зорилгоор “Төлөөллийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийг хэрэгжүүлэхээр баримт бичгийг боловсруулаад байгаа юм байна.

Төслийг боловсруулах явцад Олон улсын зөвлөх, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн бүсийн зөвлөх 3 дугаар сард ажиллажээ. Энэ үеэр зүүн 5 аймаг, хотын дүүргүүдийн ИТХ-ын төлөөлөл, 8 аймгийн ИТХ-ын Нарийн бичгийн дарга нар, ТББ-ын төлөөлөлтэй төслийн хэрэгцээ, хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар санал солилцсон байна. Түүнчлэн УИХ-ын Тамгын газраас Швейцарийн хөгжлийн агентлагт ирүүлсэн төсөл, газар, хэлтсүүдээс өгсөн саналуудыг судалж үзсэн гэж танилцуулгын үеэр дурдсан. Төслийн баримт бичгийн төслийг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Суурин төлөөлөгчийн газар эцэслэн боловсруулж, Швейцарийн хөгжлийн агентлагт 5 дугаар сард танилцуулж санал авсан гэлээ. Харин энэ удаагийн хурлын хэлэлцүүлгийн үеэр гарсан саналыг тусган Швейцарийн хөгжлийн агентлагийн Хамтын ажиллагааны газар Швейцарийн Засгийн газарт төслийг батлуулахаар хүргүүлэх аж. Төслийг 2017-2020 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй бөгөөд 4.0 сая ам.долларын санхүүжилт шаардагдана гэж тооцож байгаа юм байна.

Төслийн хамрах хүрээ нь үндэсний хэмжээнд буюу бүх аймаг, сум, нийслэл, дүүргийн ИТХ, баг, хорооны Нийтийн хурал, УИХ-ын Тамгын газар бөгөөд хэрэгжүүлэгч байгууллага нь УИХ-ын Тамгын газар байх юм.

Төслийн хүрээнд нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг дээшлүүлэх 3 цогц буюу Хууль эрх зүйн, Институцийн, Хувь төлөөлөгчийн гэсэн стратегийг хэрэгжүүлэхээс гадна УИХ-ын Тамгын газрын Хууль тогтоомжийн тухай шинэ хуулийг хэрэгжүүлэх чадавхийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулахаар тусгажээ.

Төслийн үр дүнд нутгийн удирдлагын эрх зүйн орчин сайжирч, ИТХ-ын зохион байгуулалтын чадавхи нэмэгдэн, сонгогдсон төлөөлөгчдөд зориулсан сургалтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх байнгын механизм бий болсон байна гэж тооцож байгаа аж. Түүнчлэн УИХ-ын Тамгын газрын Хууль тогтоомжийн тухай хуулийг хэрэгжүүлэх чадавхи дээшилнэ гэж үзжээ.

Энэ үеэр төслийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа, санхүүжилтийн талаар дэлгэрэнгүй танилцуулсаны дараа УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар үг хэлсэн. Тэрбээр, өнгөрсөн хугацаанд “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь”, “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслүүд амжилттай хэрэгжсэнийг тэмдэглээд, “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийг хэрэгжүүлэх явцад үндэсний сургалтын системийг бий болгосон гэлээ. Мөн Иргэдийн хуралд сонгогдсон төлөөлөгчдийн үйл ажиллагаанд чанарын өөрчлөлт гаргахад төсөл хувь нэмрээ

оруулсан болохыг онцлоод “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төсөл нь орон нутаг төрийн удирдлагын харилцааг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн хэмээсэн.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар төсөл дуусахаар хэрэгжүүлж байсан ажил зогсдог байдлыг халж, үйл ажиллагаа нь байнга үргэлжлэх чиглэл рүү хандуулахыг зорьж ажилласан хэмээн онцолсон юм. Тэрбээр, “Төлөөллийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн баримт бичгийг боловсруулах явцад өгсөн саналууд тусгагдан, баримт бичгийн үндсэн хана босч, ерөнхий чиг гарсан болохыг дурдсан. УИХ-аар баталсан Хууль тогтоомжийн тухай, Захиргааны ерөнхий хууль, Нийтийн сонсголын тухай хуулиудыг хэрэгжүүлснээр шийдвэр гаргах түвшинд, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хувьсал гарна гээд үүнд “Төлөөллийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн үйл ажиллагаа онцгой үүрэгтэй болохыг тэмдэглэн хэлсэн юм. Түүнчлэн төслийн баримт бичигт тусгах саналуудаа илэрхийлсэн.

“Төлөөллийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн баримт бичгийн танилцуулгатай холбогдуулан хуралдаанд оролцсон төлөөлөл саналаа илэрхийлэн, асуулт асууж, хариулт авлаа.

2016-06-14

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар Дэлхийн банкны Засаглалын хөтөлбөрийн эксперт хатагтай Элин Бэргман тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.

Хатагтай Элин Бэргман, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргыг цаг, зав гарган хүлээн авч уулзсанд баяртай байгаагаа илэрхийлж, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Дэлхийн банкинд албан хүсэлт тавьсны дагуу Монгол Улсын зохицуулалтын бодлого болон түүний хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийх гэж буйгаа уулзалтын эхэнд танилцуулсан юм. Тэрээр, зохицуулалтын бодлого хэрэгжилтийг хангах оношилгооны хэрэгслийг Монголд хэрэглэх болсон шалтгаан бол Монгол Улсад зохицуулалтын бодлого болон хэд хэдэн чухал хуулиуд дээр ахиц, дэвшилт гарсан байгаа. Эдгээр бүх зүйлийг харгалзан үзэж Монгол Улсад оношилгооны хэрэгслийг хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн дүгнэлт гарсан болохыг тэмдэглэсэн юм. Түүнчлэн энэхүү дүн шинжилгээний үр дүнд тайлан гаргаж, цаашдаа хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тодорхой зөвлөмжүүд гаргах юм.

Эхний судалгааны ажлыг Хууль тогтоомжийн тухай хууль болон бусад томоохон хуулиуд, тэдгээрийн хэрэгжилтийн бэлтгэл ажил, хэрэгжилтийн явцад тулгарч болох асуудлууд байгаа эсэх талаар санал солилцохоор уулзаж буйгаа дуулгалаа. Мөн тэрээр, Хууль тогтоомжийн тухай хууль батлагдснаар Монгол Улсын Их Хурлын Тамгын газарт ямар ач холбогдолтой болохыг лавлахад Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар тайлбарлахдаа, Улсын Их Хурлаар батлагдаж буй хуулиудын чанар, хэрэгжилтэд нь тодорхой өөрчлөлт оруулах зорилгоор энэ хууль хэрэгжсэн юм. Мөн хууль тогтоох үйл ажиллагаанд иргэний оролцоог хангах шаардлага байсан гэлээ. Ийнхүү талууд Хууль тогтоомжийн тухай хууль, Нийтийн сонсголын тухай хууль болон Захиргааны ерөнхий хуулийн хүрээнд хууль тогтоомжийн чанар, хэрэгжүүлэлт, Дэлхийн банкаас хийхээр төлөвлөж байгаа Зохицуулалтын чанарын үнэлгээний талаар харилцан санал солилцов.

\*\*\*

**УИХ -ЫН ХЯНАН ШАЛГАХ ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН  
ТАМГЫН ГАЗРЫН ЗАРИМ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ**

(УИХ -ын Тамгын газрын Хяналт үнэлгээ-  
ний хэлтэсээс гаргасан мэдээлэл, 2012-2016)

2012 - 2016 он;

- “Улсын Их Хурлын гишүүний асуулга, Ерөнхий сайдын мэдээлэл, тэдгээртэй холбогдсон аман асуулт, хариулт” товхимолын 13-31 дэх дугаарууд буюу нийт 19 дугаарыг Хяналт үнэлгээний хэлтсээс эрхлэн хэвлүүлэв.
- Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хороодын тогтоолоор Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд эрх олгож, үүрэг, чиглэл өгсөн хууль тогтоомжийн мэдээллийн санг Хяналт үнэлгээний хэлтэс 2013 оноос шинэчлэн бүртгэж, тэдгээрийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан бөгөөд хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар хагас жил тутам мэдээлэл сонсож, хэлэлцүүлэг зохион байгуулав.
- Улсын Их Хурлаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлэлцүүлэх бэлтгэлийг хангах ажлын хүрээнд Төрийн байгуулалтын байнгын хорооноос өгсөн чиглэлийн дагуу Монгол Улсын Засгийн газрын 2012 - 2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 бүлэг, 319 зорилтын хэрэгжилтийн талаарх шинжилгээг Хяналт үнэлгээний хэлтэс нийт 4 удаа хийж, ажлын хэсэгт хүргүүлэв.
- Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг 10 байгууллагын үйл ажиллагааны тайлан, илтгэл, мэдээллийг хуульд заасан хугацаанд ирүүлэх, тайланг холбогдох Байнгын хорооны хуралдаанаар сонсох ажлыг Хяналт үнэлгээний хэлтсээс зохион байгуулж ажилласан.
- Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 05 дугаар тогтоолын дагуу Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагууд үйл ажиллагааны тайландаа системчилсэн үнэлгээ хийж ирүүлсэн эсэхэд Хяналт үнэлгээний хэлтэс хяналт тавьж, санал, дүгнэлтээ холбогдох Байнгын хороодод хүргүүлж ажилласан.
- Хууль тогтоох үйл ажиллагааг иргэдэд хүртээмжтэй хүргэх, хуулийн хэрэгжилтийн талаар олон нийтийн санаа бодлыг тандах зорилгоор хийсэн Улс төрийн барометр 1, 2 судалгааны санал асуулгыг Хяналт үнэлгээний хэлтэс боловсруулж хэрэгжүүлсэн.
- Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, мөнгөний бодлого болон төсвийн төсөл хэлэлцэх, төсвийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, үр нөлөөг дээшлүүлэхэд туслах, судалгаа, дүн шинжилгээ хийх, танилцуулга бэлтгэж бодлогын зөвлөмж, санал, дүгнэлт боловсруулах ажлыг Хяналт үнэлгээний хэлтэс гүйцэтгэсэн байна.
- Нэгдсэн төсвийн дүн шинжилгээ хийж, төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг Хяналт үнэлгээний хэлтэс сар бүр гаргаж байна.
- Монгол Улсын макро эдийн засгийн тойм боловсруулж, бодит эдийн засаг, төсөв ба мөнгөний бодлогын үзүүлэлтүүд, гадаад худалдаа, төлбөрийн тэнцэл зэрэг үзүүлэлтүүдээр улирал бүр Хяналт үнэлгээний хэлтэс мэдээлэл гаргаж байна.
- Улсын Их Хуралд өргөн баригдсан 26 хууль тогтоомжийн төсөлд зардлын тооцоолол, төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх судалгааг Хяналт үнэлгээний хэлтэс хийж, холбогдох Байнгын хороо, ажлын хэсэгт хүргүүлэв.
- “Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудын тухайн оны

авлигын эсрэг үйл ажиллагаанд хийсэн үнэлгээний тайлан” сэдэвт уулзалтыг Авилгатай тэмцэх газартай хамтран Хяналт үнэлгээний хэлтсээс 3 удаа зохион байгуулав.

2013.05 сар

- Хяналт үнэлгээний хэлтсээс <http://sd-monitoring.parliament.mn> цахим хаяг нээж, Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлт, Ерөнхий сайдын мэдээлэл, Улсын Их Хурлын гишүүдээс тавьсан асуулга, асуулт, түүний хариу, хяналт шалгалтын ажлын явц байдал, төсвийн сар, улирлын гүйцэтгэлд хийсэн дүн шинжилгээ, тайлан мэдээ болон Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагаатай холбоотой нийт давхардсан тоогоор 700 гаруй мэдээ мэдээллийг [www.parliament.mn](http://www.parliament.mn), <http://sd-monitoring.parliament.mn>, дотоод сүлжээнд байршуулсан бөгөөд 92343 хүн үзэж танилцсан байна.

- 2013.07.02

Хяналт үнэлгээний хэлтэс “Монгол Улсын төсвийн өнөөгийн байдал, цаашдын хандлага” сэдвээр иж бүрэн судалгааг Монголын төсвийн мэргэжилтнүүдийн холбоотой хамтран хийж, Үндэсний аудитын газар, Сангийн яам болон эдийн засгийн судалгаа, шинжилгээний ажил эрхэлдэг төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулав.

- 2015.03.12

“Монгол Улсын хууль тогтоомжийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, цаашдын хандлага” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлэгт нийт 25 яам, агентлагийн 107 удирдах ажилтнууд оролцож, нийт 4 сэдвийн хүрээнд илтгэл тавьж, хэлэлцүүлэг өрнүүлсэн. Хэлэлцүүлэгт оролцогчдын дунд хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулахтай холбоотой санал асуулга явуулсан.

- 2015.10.31

2015 онд батлагдсан Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан 6 аргачлалын төслийг Засгийн газар /Хууль зүйн яам/ боловсруулж, санал авахаар ирүүлсэн бөгөөд Тамгын газраас саналаа нэгтгэх зорилготой хэлэлцүүлэг зохион байгуулав.

\* \* \*

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ОЛОН НИЙТЭД ХҮРГЭЖ СУРТАЛЧЛАХ ТАЛААР  
ТАМГЫН ГАЗРААС ХЭРЭГЖҮҮЛСЭН ЗАРИМ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ**

(2012 - 2016, Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн гаргасан мэдээнээс ...)

## 2012

- 2008 - 2012 оны УИХ -д гишүүнээр сонгогдоны ажилласан гишүүдийн хөрөг намтар, өнгөрсөн дөрвөн жилийн УИХ, Тамгын газрын үйл ажиллагааны талаарх цогц мэдээллийг багтаасан “Монгол Улсын Их Хурал 2008-2012” ном
- 1100 гаруй текст мэдээ
- 108 дүрстэй мэдээ
- “76/26 Парламент ток шоу” нэвтрүүлэг 36 дугаар, “Парламент энэ цагт” нэвтрүүлэг 3 дугаар, “Парламент энэ долоо хоногт” нэвтрүүлэг 54 дугаарыг бэлтгэв.

Нийт 93 нэвтрүүлэг

## 2013

- “Парламентын сэтгүүлчдийн гарын авлага”
- “Үндсэн хууль - 20” номыг бэлтгэн гаргалаа.
- 2013 оны хаврын ээлжит чуулганы талаарх олон нийтэд зориулсан товхимол бэлтгэн гаргав.
- 1488 текст мэдээ
- 432 дүрстэй мэдээ
- “Парламент энэ долоо хоногт” нэвтрүүлгийн 40 дугаарыг бэлтгэв.

## 2014

- “Парламентын нээлттэй ил тод байдал, парламентын сэтгүүл зүйн онцлог, сэтгүүлчийн ёс зүй, хариуцлага” нэртэй эмхэтгэлийг Парламентын сэтгүүлчдийн холбоотой хамтран бэлтгэж хэвлүүлэв.
- 2013 оны намрын, 2014 оны хаврын ээлжит чуулганы талаарх олон нийтэд зориулсан товхимол бэлтгэн гаргав.
- 1430 текст мэдээ,
- 603 дүрстэй мэдээ
- “Парламент энэ 7 хоногт” нэвтрүүлгийн 40 дугаар,
- “Хуулийн толь” нэвтрүүлгийн 6 дугаар,
- УИХ-ын гишүүнтэй ярилцах цаг” нэвтрүүлгийн 50 дугаар,
- Үндсэн хуулийн талаар 7 нэвтрүүлэг,
- теле хэлэлцүүлэг нэвтрүүлгийн 4 дугаар,
- УИХ-ын даргын орон нутагт ажилласан тухай 3 нэвтрүүлэг,
- Бүгд найрамдах улс тунхагласны 90 жилийн ойд зориулсан 2 нэвтрүүлэг

Нийт 112 нэвтрүүлэг бэлтгэв.





**2015**

- “Байнгын ажиллагаатай парламентын ажлын алба” /1990-2015/ номыг бэлтгэн хэвлүүлсэн.
- “Монгол Улсын анхны байнгын ажиллагаатай парламент-Улсын бага хурал 1990-1992” номыг бэлтгэн хэвлүүлсэн.
- “Найргийн хуртай монгол парламент” ном бэлтгэн гаргасан.
- 2014 оны намрын, 2015 оны хаврын ээлжит чуулганы талаарх олон нийтэд зориулсан товхимол бэлтгэн гаргав.
- 1930 текст мэдээ
- 620 дүрстэй мэдээ
- “УИХ энэ 7 хоногт” нэвтрүүлгийн 36 дугаар,
- “УИХ-ын гишүүнтэй ярилцах цаг” нэвтрүүлгийн 26 дугаар,
- “Хуулийн толь” нэвтрүүлгийн 10 дугаар,
- гадаад, дотоод “томилолт”-ын нэвтрүүлгийн 3 дугаар,
- “Ардчилсан үндсэн хууль” нэвтрүүлгийн 1 дугаар,
- Байнгын ажиллагаатай парламентын 25 жилийн ойд зориулсан нэвтрүүлгийн 2 дугаар,
- “Чингис бонд ба үйлдвэржилт” нэвтрүүлгийн 3 дугаар,
- Орон нутгийн томилолтын тухай нэвтрүүлгийн 1 дугаар,
- “Эх хүүхдийн эсэн мэнд амаржихуй яаралтай түргэн тусламж, үйлчилгээний хүртээмж зөвлөгөөн” нэвтрүүлгийн 1 дугаар,
- Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг өргөн барьсантай холбогдуулан ард иргэдэд мэдээлэл өгөх цуврал нэвтрүүлгийн 2 дугаар

Нийт 85 нэвтрүүлэг

**2016**

- “Улсын Их хурал (2012 - 2016)” ном
- 2016 оны хаврын ээлжит чуулганы талаарх олон нийтэд зориулсан товхимол
- Текст мэдээ-790
- Видео мэдээ - 316
- Нэвтрүүлэг - 34
  - Теле хичээл: 1
  - “УИХ энэ 7 хоногт” тойм: 13
  - “УИХ-ын гишүүнтэй ярилцах цаг”: 4
  - Хуулийн толь: 6
  - Томилолт: 4
  - Бусад: 6

\*\*\*

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН ТАЙЛАН (2016) -Г  
УИХ -ЫН ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН НЬ**

2016-04-06

Улсын Их Хурал өөрийн Ажлын алба (Тамгын газар) -ныхаа үйл ажиллагааны жил бүрийн тайланг тодорхой тогтсон хугацаанд Төрийн байгууллагын байнгын хорооны хуралдаанаар сонсон хэлэлцэж дүгнэдэг уламжлалтай. Энэ уламжлал 2012 - 2016 онд зохих ёсоор хадгалагдаж ирсэн. УИХ -ын Тамгын газрын үйл ажиллагааны өнгөрсөн 4 жилийн тайланг нэгтгэсэн хэлбэрээр дэлгэрэнгүй танилцуулах нь мэдээллийнхээ агуулгын хувьд хангалттай “нуршуу” материал болохоор байв. Жишээ нь, УИХ -ын Тамгын газрын үйл ажиллагааны зөвхөн 2015 оны дэлгэрэнгүй тайлан дангаараа 140 хуудас болж байсан тул бид эмхтгэлийнхээ хэмжээнд захируулан, тэдгээрийг нийтэд нь бус, харин тухайлсан нэг оны (2016) -ийн тайлан хэлэлцүүлгийг жишиг байдлаар авч энд тоймлон тусгав. (Ред.)

\* \* \*

УИХ -ын Төрийн байгуулалтын байнгын хорооны энэ өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын 2015 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, энэ талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар хийв.

Улсын Их Хурлын Тамгын газар 2015 онд реинженерчлэлийн ажлын үр дүнд үндэслэн ажилтнуудын ажлын чиг үүрэг, ажлын байрын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, ажил үүргийн давхардал, хийдлийг арилгах, “Улсын Их Хурлын Тамгын газрын Мэдээлэл, үйлчилгээ, удирдлагын төв”-ийн үйл ажиллагааг жигдрүүлэх зорилго тавин ажиллаж, бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийж, Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Тамгын газрын дүрэм болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулан ажилласныг Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга танилцуулгынхаа эхэнд онцлоод Улсын Их Хурлын Тамгын газраас 2015 онд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааг үндсэн 8 чиглэлээр тайлагнаж танилцуулсан юм.

Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх ажлын хүрээнд Улсын Их Хурлын Тамгын газар 2015 онд Улсын Их Хурлын чуулганы 88 удаагийн нэгдсэн хуралдаан, Байнгын болон дэд хороодын 297 удаагийн хуралдаан, Улсын Их Хурлын даргын захирамж, Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан 94 ажлын хэсгийн 429 удаагийн хуралдаанаар 764 хууль, 128 тогтоолын төслийг хэлэлцүүлэх бэлтгэл, зохион байгуулалтыг хангаж, хуралдаанаас гарсан баримт бичгийн төслийг бэлтгэж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлжээ.

Тайлангийн хугацаанд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан чиг үүргийнхээ дагуу хууль болон Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцүүлэх бэлтгэлийг хангаж, бие даасан 43 хууль, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 448 хууль, хууль хүчингүй болсонд тооцох тухай 50 хууль, зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай 29 хууль, бүгд 570 хууль, Улсын Их Хурлын 120 тогтоолын төслийн эцсийн хувилбар, танилцуулгыг бэлтгэн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, эцсийн найруулга хийж ёсчлуулсан байна.

Энэ хугацаанд Байнгын хороодын ажлын албад Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлын бэлтгэлийг хангаж, хэлэлцсэн асуудлын талаар Байнгын хорооны хэлэлцэх эсэхийн 210, анхны хэлэлцүүлгийн 206 санал, дүгнэлт, эцсийн хэлэлцүүлгийн 82 танилцуулга, 2792 зарчмын зөрүүтэй саналын томъёолол бэлтгэн албажуулж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулан хэлэлцүүлж, Байнгын хорооны 141 тогтоолын төслийг боловсруулж батлуулжээ. Харин Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх

ажлын хүрээнд Төсвийн тухай хуулийн хэрэгжилт, нэгдсэн төсвийн гүйцэтгэл, төсвийн төсөлд хийх хяналт, шинжилгээний чиглэлээр Засгийн газраас өргөн барьсан 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн төсөлд шинжилгээ хийж холбогдох тооцоо, судалгааг гаргаж Төсвийн байнгын хорооноос байгуулагдсан ажлын хэсэгт танилцуулан хэлэлцүүлж батлуулжээ.

Энэ хугацаанд Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолоор хяналт шалгалтын чиглэлээр нийт 16 ажлын хэсэг байгуулагдан ажилласан ба эдгээр ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэ ажилласан байна. Дээрх ажлын хэсгүүд яам, агентлагийн үйл ажиллагаатай 46 удаа танилцаж, 70 гаруй хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцжээ.

Тайлант хугацаанд давхардсан тоогоор Улсын Их Хурлын 64 гишүүн 111 асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд болон Монголбанкны Ерөнхийлөгчид хандан 33 удаагийн асуулга тавьсан бөгөөд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу сонсох саналаа ирүүлсэн 7 асуулгын хариуг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар сонсох ажлыг зохион байгуулжээ. Хуралдаанд Улсын Их Хурлын 44 гишүүн 69 аман асуулт тавьж, асуулга тавьсан гишүүд санал бодлоо илэрхийлсэн байна. Улсын Их Хурлын 3 гишүүн 9 асуудлаар 3 удаагийн бичгэн асуулт тавьсан бөгөөд асуултын хариуг гишүүдэд ирүүлжээ. Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын 8 удаагийн мэдээллийг чуулганы нэгдсэн хуралдаанаар сонсох ажлыг зохион байгуулсан. Мэдээллийн цагаар давхардсан тоогоор 61 гишүүн 170 асуулт тавьж, хариулт авсан байна.

Хуралдааны хэвийн үйл ажиллагааг хангах ажлын хүрээнд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын, дэд хороодын хуралдааныг хэвийн явуулах нөхцөл бүрдүүлэх, хуралдааны тэмдэглэлийг цаг тухайд нь гаргаж албажуулсны зэрэгцээ Улсын Их Хурлын чуулганы 88 удаагийн нэгдсэн хуралдаан, Байнгын хороодын 276, дэд хороодын 21 удаагийн хуралдааныг хэвийн явуулах бэлтгэлийг хангаж хуралдуулжээ. Энэ хугацаанд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны явцын талаар 1207 хуудас гар тэмдэглэл хөтөлж, 6662 хуудас дэлгэрэнгүй тэмдэглэлийг дууны бичлэгээс буулгаж, хянан нийлж, 10152 хуудас хавсралт баримт бичгийн хамт архивт нийт 18021 хуудас баримт материалыг шилжүүлсэн байна.

Судалгаа, мэдээлэл, лавлагаагаар хангах ажлын хүрээнд Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороодыг судалгаа, мэдээллээр шуурхай ханган ажиллаж, тайлант хугацаанд нийт 50 судалгааны ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн боловч 56 судалгааны захиалга ирүүлснийг хүлээн авч гүйцэтгэжээ. Мөн УИХ-ын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудал тус бүрээр сэдэвчилсэн лавлагаа, мэдээлэл бэлтгэх төлөвлөгөө гаргаж, судалгааны мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг 2 удаа зохион байгуулж, нийт 56 судалгааны тайланг тухай бүр нь хэвлэмэл байдлаар захиалагчдад хүргүүлсэн байна.

Улсын Их Хурлыг сурталчлах, олон нийттэй харилцах үйл ажиллагааны хүрээнд Улсын Их Хурлын 2014 оны намрын, 2015 оны хаврын ээлжит болон ээлжит бус чуулганы нэгдсэн болон Байнгын хороодын хуралдаан, Улсын Их Хурлын даргын гадаад улс болон хөдөө орон нутагт ажилласан томилолт, Улсын Их Хурлын гишүүдийн хөдөө, орон нутаг, тойрогтоо ажилласан тухай, Тамгын газрын үйл ажиллагаа, цаг үеийн асуудлаар нийт 1930 текст мэдээлэл, 620 видео мэдээллийг бэлтгэн УИХ-ын [www.parliament.mn](http://www.parliament.mn), [open.parliament.mn](http://open.parliament.mn) болон [intra.parliament.mn](http://intra.parliament.mn) цахим хуудаснуудад байршуулжээ. Мөн Улсын Их Хурлаар батлагдсан хууль тогтоомж, Улсын Их Хурлын ээлжит болон ээлжит бус чуулганы үйл ажиллагааны үр дүн, цаг үеийн бусад асуудлаар нийт 85 удаагийн хэвлэлийн бага хурал зохион байгуулж хэвлэл, мэдээллийн ажилтнуудыг өргөн оролцуулж сурталчлах ажлыг зохион байгуулсан байна. Улсын Их Хурлын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх

асуудлын хүрээнд Улсын Их Хурал, Монголын Парламентын бүлгэм, Улсын Их Хурлын Тамгын газрын гадаад харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, гадаад хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор 2015 оны гадаад арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллажээ. Улсын Их Хурлын 2015 оны гадаад арга хэмжээний төлөвлөгөөнд гадаадад 9, дотоодод 7 арга хэмжээ тусгагдаж батлагдсанаас төлөвлөгөөний дагуу гадаадад 8, дотоодод 2, төлөвлөгөөнөөс гадна гадаадад 4, дотоодод 7, нийт гадаадад 12, дотоодод 9 арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.

Санхүүгийн үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд Улсын Их Хурал, түүний Тамгын газрын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн төсөв, санхүү, аж ахуй, техник хэрэгсэл, материал хангамжийн үйлчилгээг амжилттай үзүүлж ирсэн бол Дотоод аудитын ажлын хүрээнд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөөг боловсруулж, Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2014 оны 738 дугаар захирамжаар батлуулж, төлөвлөгөөний биелэлтэд тухай бүр хяналт тавин хэрэгжилтийг хангуулж ажиллажээ.

Техник технологийн шинэчлэл, хангамжийн үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Парламентын Ассемблейн 2015 оны намрын хурлын техникийн бэлтгэлийг хангахтай холбогдуулан хурлын цахим хуудсын домайн нэрийг зарлан ангилал цэсийг үүсгэж 2 хэл дээр цахим хуудас ажиллуулжээ. Мөн дуу, дүрсийн бичлэг, дамжуулалтын бие даасан зөөврийн систем угсарч ажиллуулан дуу, дүрсийн бичлэг, шууд дамжуулалтыг гүйцэтгэсэн байна. Түүнчлэн Нээлттэй сонсголын танхимыг шинээр байгуулан техник хэрэгсэл суурилуулж дуу, дүрсийн иж бүрэн системийг ашиглалтад оруулсан байна.

Тамгын газарт хийсэн реинженерингийн ажилтай уялдуулан Ерөнхий нарийн бичгийн даргын 2015 оны 768 тоот захирамжаар “Тамгын газрын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай”, 769 тоот захирамжаар “Чиг үүргийг шинэчлэн батлах тухай”, 770 тоот захирамжаар “Тамгын газрын орон тоог шинэчлэн батлах тухай” шийдвэрийг гаргаж, 197 нэгж орон тоотой үйл ажиллагаагаа явуулж ирснийг Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга танилцуулгадаа дурдаад эцэст нь төсвийн талаар гаргасан саналууд улсын төсөвт бүрэн тусгагдахгүй байгаа нь Улсын Их Хурлын хэвийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй байгаад байнгын хорооноос анхаарал тавьж ажиллахыг санал болголоо.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Су.Батболд, С.Дэмбэрэл, Г.Батхүү нар Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргаас асуулт асууж тодруулан Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэг, С.Дэмбэрэл, Г.Батхүү нар үг хэллээ. Үг хэлсэн гишүүд Улсын Их Хурлын Тамгын газар өнгөрсөн 4 жилд хуулиар хүлээсэн чиг үүргээ хангалттай хэрэгжүүлж Улсын Их Хурлын гишүүдэд мэдээлэл, арга зүйн үр дүнтэй тусалцааг шуурхай үзүүлж ирсэнд талархаж буйгаа илэрхийлсэн юм. Тухайлахад, Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл Тамгын газар нь Улсын Их Хурлын зүтгүүр хүчний хувьд хангалттай сайн ажиллаж байгаа. Ялангуяа Тамгын газрын судалгааны бааз, чадавхи их тус болдог, мэдээллийн технологийн сайн хөгжсөн, мэдээллийг түргэн шуурхай олж авах боломж бүрдсэн, хуулийн лавлагаа, тусалцааг сайн үзүүлж байгаа,

Улсын Их Хурлын үйл ажиллагааг олон нийтэд түгээхэд Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс сайн ажиллаж, гишүүн-олон түмнийг холбох гүүр бэхжиж чадсаныг сайшаагаад цаашид судалгаа шинжилгээ, Улсын Их Хурлын үйл ажиллагааг олон түмэнд сурталчилж тайлбарлан таниулах чадавхийг улам бэхжүүлэх, ажилтнуудын нийгмийн асуудлыг сайжруулж орон байраар хангахад анхаарахыг санал болгов. Мөн Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэг Тамгын газар өнгөрсөн 4 жилд сайн ажилласан, цаашид сургалт,

судалгааны бүтцийг улам бэхжүүлж лавлагаа мэдээллээс илүүтэй бодлогын судалгаагаар гишүүдийг хангахад анхаарах, байнгын хороодын зөвлөхүүдийг чадавхижуулах, мэдээллийн аюулгүй байдлыг хангахад анхаарах, түүнчлэн Улсын Их Хурлын шинэ гишүүдэд сургалт явуулж мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах санал гаргалаа. Мөн Улсын Их Хурлын гишүүн Г.Батхүү Тамгын газрын үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан байнгын хорооноос тогтоол гаргаж холбогдох байгууллагуудад чиглэл өгөх нь зүйтэй гэж үзэж буйгаа илэрхийлсэн юм.

Хуралдааны эцэст байнгын хорооны дарга А.Бакей Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагаа өнгөрсөн 4 жилд жигдэрсэн, олон шинэлэг ажил санаачлан амжилттай хэрэгжүүлсэн нь Улсын Их Хурлын гишүүдэд мэдрэгдэж, үр дүнгээ өгч байгааг тэмдэглээд цаашид Тамгын газрын ажилтнуудын чадавхи, хариуцлагын асуудлыг хамтад нь авч үзэж хариуцлагыг улам жигдрүүлэхэд анхаарахыг сануулав. Ингээд Улсын Их Хурлын Тамгын газрын 2015 оны үйл ажиллагааны тайланг байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэнтэй холбогдуулан байнгын хорооноос тогтоол гаргаж холбогдох байгууллагуудад чиглэл өгөхөөр тогтов.

Уг тогтоолын төсөлд парламентын ордон барих талаар урьд нь гаргасан тогтоол шийдвэрүүдэд үнэлэлт дүгнэлт өгч саналаа танилцуулах чиглэлийг Засгийн газарт өгөх, Тамгын газрын ажилтнуудыг чадавхижуулах, сургалтад хамруулах, байр орон сууцаар хангах, цалин урамшууллыг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, мөн судалгаа шинжилгээний чадавхийг бэхжүүлэх, хууль тогтоомжийг иргэд олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр сурталчлан таниулах ажлыг өргөжүүлж чадавхийг бэхжүүлэх, шинээр сонгогдсон гишүүдэд мэдээлэл, арга зүйн зөвлөгөө өгөх сургалт зохион байгуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Тамгын газарт үүрэг болгох, түүнчлэн төсөв, хөрөнгө оруулалтыг хасахгүйгээр төлөвлөсөн хэмжээнд нь баталж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлийг холбогдох байгууллагуудад өгөх зэрэг асуудлыг тусгаж, гишүүдийн саналыг авч эцэслэн боловсруулж батлахаар тогтов.

\*\*\*



6+

**ТАМГЫН ГАЗАР** (БУСАД НЭГЖ, ДОТООД ЗАРИМ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ, 2012 - 2016)





**УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ НАМ, ЭВСЛИЙН БҮЛГИЙН АЖЛЫН АЛБА**

Парламент дахь улстөрийн намын бүлэг, түүний Ажлын албаны эрхзүйн зохицуулалт

(Ерөнхий тойм)

Улсын Их Хурлын зохион байгуулалтын бүтцийн нэг хэсэг нь тухайн сонгуулиар Улсын Их Хуралд суудал авсан нам, эвслийн бүлэг юм. Нам, эвслийн бүлэг байгуулан ажиллуулах талаар 1992 онд батлагдсан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд анх удаа тусгагдсан бөгөөд түүнээс хойш тус хуулийн шинэчилсэн найруулга болон Улс төрийн намын тухай хуульд тусгай бүлэг, зүйл болгон хуульчилжээ.

Улсын Их Хурлаас 2006 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 8 дугаар зүйлд Улсын Их Хурал дахь олонх ба цөөнх, мөн хуулийн 26 дугаар зүйлд Улсын Их Хурал дахь нам /эвсэл/ -ын бүлгийн тухай зааж өгчээ. Уг хуульд “Улсын Их Хурлын сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд 8 -аас доошгүй суудал авсан нам, эвсэл бүлэг /цаашид “бүлэг” гэх/ байгуулж болно” гэсэн байдаг.

Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн үйл ажиллагааг боловсронгуй болгож, ажлын үр дүнг дээшлүүлэхэд түүний Ажлын алба онцгой үүрэг гүйцэтгэдэг. Тиймээс Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлд нам, эвслийн бүлгийн эрх, үүргийг тодорхойлж, “Бүлэг нь бодлогоо боловсруулах, зохион байгуулалтын туслалцаа авах чиг үүрэг бүхий ажлын албатай байх бөгөөд түүний гүйцэтгэх үүргийг нь бүлгийн дүрмээр зохицуулна. Бүлгийн ажлын албаны ажилтны тоо нь тухайн бүлгийн гишүүдийн тооны хоёрны нэгтэй тэнцүү байх бөгөөд хэрэв бүлгийн гишүүдийн тоо нь сондгой байгаа тохиолдолд дараагийн бүхэл тэгш тооноос тооцно” хэмээн заажээ.

Нам, эвслийн бүлгийг ажиллах нөхцөл бололцоогоор хангах асуудлыг Улсын Их Хурлын Тамгын газар хариуцах бөгөөд ажлын албаны цалин, унаа, албан томилолт, холбоо, бичигхэргийн зардлыг Улсын Их Хурлын төсөвт тусгаж санхүүжүүлдэг. Улсын Их Хурлын 1995 оны 63 дугаар тогтоолд зааснаар Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны орон тооны ажилтныг төрийн захиргааны албан тушаалын хүрээнд гүйцэтгэх албан тушаалтантай адилтган үздэг.

Нам, эвслийн бүлэг нь Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль тогтоомж, тухайн нам, эвслийн бүлгийн үйл ажиллагааны дүрэм, бүлгийн даргын шийдвэрийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажилладаг.

Нам, эвслийн бүлгийн Ажлын алба нь тухайн бүлгийн өдөр тутмын хэвийн ажиллагааг хангах, бүлгийн гишүүдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх, хууль тогтоомжийн талаар судалгаа хийх, лавлах материалаар хангах, бусад улс орнуудын туршлагыг судлах, танилцуулга мэдээлэл бэлтгэх, батлан гаргасан хууль тогтоомжийг сурталчлах, Улсын Их Хурлын сонгуульд намаас дэвшүүлж оролцсон мөрийн хөтөлбөр, бодлого шийдвэрийг Улсын Их Хурлын хууль тогтоомжид тусгуулах, тухайн хууль тогтоомжийн төслөөр намын бүлгийнхээ санал, дүгнэлтийг боловсруулах, гишүүдийнхээ үйл ажиллагааг мэдээлж сурталчлах зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг.

\*\*\*

**1. УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ АРДЧИЛСАН НАМЫН НАМЫН БҮЛЭГ, ТҮҮНИЙ АЖЛЫН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ТОЙМ МЭДЭЭ (2012.VII. - 2016.VII.)**Ажлын албаны үүсэл, хөгжил:

Монгол Улс байнгын ажиллагаатай парламенттай болсноос хойш зургаан удаа явагдсан Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнд Ардчилсан нам Улсын Их Хуралд дөрвөн удаа бүлэг байгуулан ажилласан. Үүнд:

- 1996 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулиар Ардчилсан Нам Монгол Улсын Их Хуралд 50 суудал авч, 25 хүний бүрэлдэхүүнтэй бүлгийн ажлын алба байгуулагдсан. Бүлгийн ажлын албаны даргаар А.Батсайхан, Б.Намсрай болон одоогийн Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунгэрэл нар ажиллаж байв.
- 2004 оны Монгол Улсын Их Хурлын сонгуульд “Эх орон-Ардчилал” эвсэл 34 суудал авч, бүлгийн ажлын алба 12 хүнтэй, ажлын албаны даргаар Ё.Гэрэлчулуун томилогдон ажиллаж байв.
- 2005 онд “Эх орон-Ардчилал” эвслийн бүлэг тарсны улмаас Ардчилсан Нам, ИЗБНН, Эх орон намаас нэр дэвшиж сонгогдсон болон бие даагч гишүүд Улсын Их Хурал дахь МАХН-ын бүлэгт нэгдэн орсноор хоёр намын ажлын албыг нэгтгэн 30 ажилтантай, ажлын албаны даргаар МАХН-ын Д.Батбаяр, дэд даргаар Б.Болдбаатар нарыг томилжээ.
- 2005 оны 8 дугаар сарын 09-нд Улсын Их Хурал дахь Ардчилсан Намын бүлэг байгуулагдан 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж, ажлын албаны даргаар Х.Ганчимэгийг томилжээ. Улмаар 2006 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр Монгол Улсын Их Хурал дахь Ардчилсан Намын Зөвлөл байгуулагдаж, ажлын алба 5 ажилтантай, ажлын албаны даргаар Б.Болдбаатарыг томилов.
- 2008 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулиар Ардчилсан Намаас нэр дэвшигчид 27 суудал авч, бүлгийн ажлын албаны даргаар Б.Болдбаатарыг томилон 14 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулсан.
- 2012 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулиар Ардчилсан Нам 34 суудалтай болж, бүлгийн ажлын алба 18 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж, ажлын албаны даргаар Б.Болдбаатарыг томилсон. 2013 онд бүлгийн ажлын албаны даргаар С.Дэмчиг томилогдон ажиллаж байна.

№	Намын бүлгийн ажлын албаны дарга	Ажилласан хугацаа
1	А. Батсайхан	1996.07.01 - 10.01
2	Б. Намсрай	1996.10.01 - 1998.12.05
3	Ц. Оюунгэрэл	1998.12.05 - 2000.07.09
4	Ё. Гэрэлчулуун	2004.12.28 - 2005.02.01
5	Б. Болдбаатар /дэд дарга /	2005.02.01 - 08.04
6	Х. Ганчимэг	2005.08.04 - 10.14
7	Б. Болдбаатар	2006.10.24 - 2012.11.08
8	С. Дэмчиг	2013.02.04 ...

Ажлын албаны бүтэц, бүрэлдэхүүн:

Монгол Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн ажлын алба нь Хуулийн хэсэг, Олон нийттэй харилцах хэсэг, Зохион байгуулалтын хэсэг гэсэн 3 үндсэн чиг үүргийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

Бүлгийн ажлын алба нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай, Төрийн албаны тухай болон холбогдох бусад хууль тогтоомж, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн үйл ажиллагааны дүрэм, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн даргын 2012 оны 10 дугаар сарын 09 -ний өдрийн 20, 21 тоот журам, 2015 оны 01 дүгээр сарын 30 -ны өдрийн 05 тоот журам болон бусад холбогдох дүрэм, журмуудыг тус тус удирдлага болгон Ажлын албаны ахлах зөвлөх, зөвлөх, референт гэсэн бүтцээр ажиллаж байна.

Ардчилсан намын бүлгийн ажлын албаны  
бүтэц, орон тоо

№	Албан тушаал	Орон тоо
1	Ажлын албаны дарга	1
2	Ахлах зөвлөх	2
3	Зөвлөх	3
5	Референт	12
	Бүгд	18

Ажлын албыг дотоод, гадаадын их, дээд сургууль төгссөн өндөр боловсролтой чадварлаг, төрийн болон улс төрийн ажлын дадлага туршлагатай боловсон хүчнээр бүрдүүлж чадсан нь бүлгийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, ажлын үр дүнг дээшлүүлэх, гишүүдэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Мөн Ажлын албаны ажилтнууд чуулганы завсарлагаанаар бүлгийн гишүүдийн хамт хөдөө, орон нутагт томилолтоор ажиллаж иргэд, сонгогчидтой уулзалт хийж, бүлгээс гарсан шийдвэрүүд, бүлгийн үйл ажиллагаа, цаашдын зорилт болон Их Хурлын үйл ажиллагаа, батлагдсан хууль тогтоомжийг сурталчлах ажлуудыг хийж байна.

## 2. МОНГОЛ АРДЫН НАМЫН БҮЛГИЙН АЖЛЫН АЛБА

### Бүлгийн ажлын албаны үүсэл, хөгжил:

Монгол Улсын Их Хурлын таван удаагийн сонгуулийн үр дүнгээр Улсын Их Хурал дахь МАХН /МАН/-ын бүлгийг 5 удаа байгуулан ажиллуулж иржээ.

- 1992 оны Улсын Их Хурлын анх удаагийн сонгуульд МАХН /МАН/ -аас нэр дэвшигчдээс 70 хүн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдож үнэмлэхүй олонх болсноор Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн дагуу анх удаа Бүлгийн ажлын албыг байгуулжээ. Бүлгийн ажлын албаны анхны ажилтнаар өмнө нь МАХН-ын түүхийн институтэд эрдэм шинжилгээний ажилтнаар ажиллаж байсан дэд доктор Ч.Энхбат бүлгийн ахлагчийн туслахаар ажиллаж, ажлын албаны суурийг тавьсан байдаг. Бүлгийн ажлын алба нь 1993 оны намрын чуулганы үеэс өргөжиж, улмаар 1993 - 1996 онд зөвлөх, референт, улс төрийн ажилтан, ажилтан зэрэг 23 хүнтэй ажиллаж байжээ.
- 1996 оны Улсын Их Хурлын сонгуулиар тус намаас нэр дэвшигчид Улсын Их Хуралд

25 суудал авч анх удаа цөөнх болов. Энэ үед бүлгийн ажлын албыг 12 ажилтнаар бүрдүүлэн зохион байгуулж, ажлын албаны даргаар доктор Х.Баатарыг томилсон байна.

- 2000 оны Улсын Их Хурлын гурав дахь удаагийн сонгуулиар тус намаас нэр дэвшигчид Улсын Их Хуралд 72 суудал авсан учир бүлгийн ажлын албанд 36 хүн ажиллах эрх зүйн үндэс бүрджээ. Бүлгийн ажлын албаны даргын үүрэг гүйцэтгэгчээр С.Шааман ажиллаж байсан бөгөөд 2000 оны 10 дугаар сараас доктор Д.Батбаярыг ажлын албаны даргаар томилон ажиллуулжээ.
- 2004 оны Улсын Их Хурлын сонгуульд тус намаас нэр дэвшигчид 36 суудал авсан тул бүлгийн ажлын албыг өөрчлөн зохион байгуулах шаардлагатай болж өмнөх орон тоог тал хувиар цомхотгон 18 ажилтантай ажиллажээ. Бүлгийн ажлын албаны даргаар ажиллаж байсан Д.Батбаяр Ерөнхий сайдын зөвлөхөөр томилогдсон тул 2006 оны 10 дугаар сараас Ш.Бадам ажлын албаны даргаар ажилласан байна. Харин 2005 оны эхээр Улсын Их Хурал дахь МАХН-ын бүлэгт бусад намуудын нэр бүхий 25 гишүүн өөрсдийн хүсэлтээр нэгдэн орж бүлэг 61 гишүүнтэй болсноор бүлгийн ажлын албыг өргөтгөж бусад намуудын төлөөллийг ажлын албанд томилжээ. Ингэснээр Ардчилсан намын төлөөлөл Б.Болдбаатарыг бүлгийн ажлын албаны дэд даргаар, зарим ажилтныг ахлах зөвлөх, зөвлөх, референтээр томилсон байна.
- 2008 оны сонгуульд тус намаас нэр дэвшигчид Улсын Их Хуралд 46 суудал авснаар бүлгийн ажлын албыг 23 хүний бүрэлдэхүүнтэй байгуулах эрх зүйн боломж бүрдэж, өмнө нь ажиллаж байсан ажилтнуудаа үргэлжлүүлэн ажиллуулсан. Харин ажлын албаны ажиллах дүрэм, ажилтнуудын хариуцах ажил үүрэгт зарим өөрчлөлт оруулжээ.
- 2012 оны ээлжит сонгуулиар МАН-аас нэр дэвшигчид Улсын Их Хуралд 26 суудал авч, мөн оны 12 дугаар сарын 21-ний өдөр Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн дагуу Улсын Их Хурал дахь Монгол Ардын Намын бүлэг байгуулагдсанаар бүлгийн ажлын алба 13 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

#### Бүлгийн ажлын албаны дарга нар

№	Бүлгийн дарга	Ажилласан хугацаа
1	А.Цанжид	1992.10.24 - 1993.09.01
2	О.Жамбалдорж	1993.10.08 - 1994.03.15
3	Г.Очирбат	1994.03.15 - 1995.10.02
4	Х.Баатар	1995.10.02 - 2000.08.24
5	Д.Батбаяр	2000.10.30 - 2006.04.20
6	Ш.Бадам	2006.10.02 - 2013.01.02
7	Д.Батбаатар	2013.01.02 - 2014.01.08
8	П.Раднаасэд	2014.01.08 - 2015.02.01
9	Г.Өнөрбаяр	2015.01.02 - ноос

#### Ажлын албаны бүтэц, бүрэлдэхүүн:

Монгол Улсын Их Хурлын 2012 оны ээлжит сонгуулиар МАН -аас нэр дэвшигчид Улсын Их Хуралд 26 суудал авч, мөн оны 12 дугаар сарын 21 -ний өдөр Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн дагуу Улсын Их Хурал дахь Монгол Ардын

Намын бүлэг байгуулагдсан. Ингэснээр Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 21.2 - 1 зааснаар бодлого боловсруулах, зохион байгуулалтын туслалцаа авах чиг үүрэг бүхий бүлгийн Ажлын албыг 13 ажилтантай бүрдүүлж, Ажлын албаны даргаар Б.Батбаатар /2013.01.02 - 2014.01.02/, Ш.Раднаасэд /2014.01.15 - 2015.02.01/, Г.Өнөрбаяр /2015.02.01 -ээс/ нар томилогдон ажиллаж байна. Хэдийгээр Улсын Их Хурлын хоёр гишүүн тутамд нэг ажилтан байхаар тооцож, бүлгийн Ажлын алба 13 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан боловч Улсын Их Хурал дахь тус намын бүлэг идэвхтэй, бүтээлч сөрөг хүчин байх зорилт тавьснаар Ажлын албыг өргөтгөн, жагсаалтаар сонгогдсон бүлгийн гишүүдийнхээ бие төлөөлөгч- туслах ажилтан 5 хүнийг бүлгийн Ажлын албандаа татан ажиллуулж байна.

Ажлын албаны ажилтнууд нь бүлгийн үйл ажиллагааны дүрмийн дагуу батлагдсан Ажлын албаны ажиллах журмыг удирдлага болгон Бүлгийн дарга, Ажлын албаны дарга нарын шууд удирдлага дор Хуулийн, Эдийн засгийн, Хэвлэл мэдээллийн, Нийгмийн, Дотоод ажлын гэсэн таван хэсэгт хуваагдан, баримт бичиг, хууль тогтоомжийн төслийн талаар бүлгийн дүгнэлт, санал боловсруулах, тооцоо судалгаа хийх, лавлагаа гаргах, үйл ажиллагааг сурталчлах, бүлгийн хуралдаан, ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах зэрэг чиг үүрэгтэйгээр ажилладаг. Үүнд:

- Эдийн засгийн хэсэгт зөвлөх Ч.Энхбат, референт Д.Отгонсүрэн, П.Төвсанаа, Б.Хандмаа нар,
- Хуулийн хэсэгт зөвлөх Б.Энхбаяр, Д.Төвшинтөр, референт Г.Золжаргал нар,
- Нийгмийн хэсэгт зөвлөх Ч.Ганчимэг, референт Д.Алтангэрэл, Н.Алтангэрэл нар,
- Хэвлэлийн хэсэгт зөвлөх Н.Хажидсүрэн, И.Буянжаргал, Б.Цогтгэрэл, референт Б.Энхбат нар,
- Дотоод ажлын хэсэгт референт Б.Ариунзаяа, М.Лхагвасүрэн, Ц.Энхжаргал нар тус тус ажиллаж байна.

Мөн Ажлын албаны ажилтнууд чуулганы завсарлагаанаар бүлгийн гишүүдийн хамт хөдөө, орон нутагт иргэд, сонгогчидтой уулзалт хийж, бүлгээс гарсан шийдвэрүүд, бүлгийн үйл ажиллагаа, цаашдын зорилт болон ИхХурлын үйл ажиллагаа, батлагдсан хуультогтоомжийг сурталчлах ажлуудыг хийж гүйцэтгэдэг.

#### Намын бүлгийн Ажлын албаны бүтэц, орон тоо

№	Албан тушаал	Орон тоо
1	Ажлын албаны дарга	1
2	Зөвлөх	7
3	Референт	9
	Бүгд	17

### **3. УИХ ДАХЬ “МАХН-МҮАН -ЫН ШУДАРГА ЁС ЭВСЭЛ” -ИЙН БҮЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

(2012.VII. - 2016.V.)

МАХН болон МҮАН нь үндэсний эрх ашгаар засаглаж, монгол хүн, монголын эрх ашгийг аливаа бүхнээс эрхэмлэн дээдлэх үзэл санаагаар нэгдэн УИХ -ын 2012 оны сонгуульд эвсэж оролцон УИХ -д “МАХН-МҮАН-ын Шударга ёс эвсэл”-ээс 11 гишүүн сонгогдсон.

“МАХН-МҮАН -ын Шударга Ёс” эвслээс сонгогдсон гишүүд 2012 оны 07 дугаар сарын 24 -ны

өдөр анхныхаа хуралдааныг хийсэн. Хуралдаанаар “МАХН - МҮАН-ын Шударга ёс эвсэл”-ийн бүлгийн дүрмээ баталж, бүлгийн ахлагчаа сонгож, бүлэг байгуулсан тухай шийдвэрээ УИХ -д өргөн мэдүүлснээр УИХ дахь “МАХН-МҮАН -ын Шударга ёс эвсэл” -ийн бүлэг албан ёсоор байгуулагдсан.

Эвслийн бүлгийн гишүүдээс хуульч, эрх зүйч -4, инженер -4, эдийн засагч -1, сэтгүүлч -1, багш -1 гэсэн мэргэжлийн хүмүүс байна. Бүлгийн даргаар Н.Батцэрэг, О.Баасанхүү, бүлгийн дэд даргаар Ч.Улаан, З.Баянсэлэнгэ нар ээлжлэн сонгогдож ажиллаа.

“МАХН-МҮАН -ын Шударга Ёс” эвсэл нь нийт ард түмнийхээ язгуур эрх ашигт нийцсэн, улс эх орныхоо хөгжилд нөлөөлөхүйц томоохон хөтөлбөр боловсруулан УИХ -ын 2012 оны сонгуульд оролцсон. Энэхүү хөтөлбөрөө “Монголоо Аврах Таван Хувьсгал” гэж нэрэлсэн ба улс эх орондоо шударга ёсыг тогтоож, эх орныхоо баялгийг иргэн бүрт тэгш хүртээж, баялагтаа эзэн сууж, хангалуун, тайван, аюулгүй амьдрах боломжийг бүрдүүлж, эх оронч үндэснийхээ эрх ашгийг дээдэлсэн төрийг бий болгохоор зорин ажиллав.

Тус эвлээс “Шинэчлэлийн” болон “Шийдлийн” Засгийн Газрыг хамтран байгуулалцаж, Засгийн Газрын гишүүнээр, Шадар сайдад Улсын Их Хурлын гишүүн Д.Тэрбишдагва, Ц.Оюунбаатар нарыг, Сангийн сайдад Улсын Их Хурлын гишүүн Ч.Улаан, Эрчим хүчний сайдад Улсын Их Хурлын гишүүн М.Сономпил, Эрүүл мэндийн сайдаар Н.Удвал, Г.Шийлэгдамба нарыг, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдад Улсын Их Хурлын гишүүн Н.Батцэрэг, Барилга, хот байгуулалтын сайдад Улсын Их Хурлын гишүүн З.Баянсэлэнгэ, Батлан хамгаалах яамны сайдад Улсын Их Хурлын гишүүн Ц.Цолмон, Монгол Улсын сайдад М.Энхсайхан нарыг санал болгон томилуулж ажиллуулсан.

\* \* \*

Улсын Их Хурал дахь “МАХН - МҮАН -ын Шударга Ёс Эвсэл”-ийн бүлэг байгуулагдаж, үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойшхи 3 жил гаруйн хугацаанд бүлэг нийт 140 гаруй удаа хуралдаж, давхардсан тоогоор 300 гаруй асуудлыг хэлэлцэж шаардлагатай гэж үзсэн хууль, тогтоолын төслүүдэд бүлгийн санал, дүгнэлтийг гаргаж байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлж, холбогдох хууль, тогтоолын төслүүдийг санаачлан боловсруулав.

Өмнөх хугацаанд бүлгээс Монгол Улсын Засгийн газрын 2012 - 2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн тухай, Монгол Улсын Үндсэн хуулийн тухай, Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого батлах тухай УИХ -ын тогтоолын төсөл, Сонгуулийн нэгдсэн хуулийн төсөл зэрэг нийтдээ 20 гаруй ажлын хэсэг байгуулан ажилласан байна.

Бүлгийн гишүүдээс дангаар болон хамтаар нийт 70 гаруй хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл өргөн мэдүүлж, 20 гаруй хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг батлуулжээ.

а) Улс төр, нийгэм, эдийн засгийн бодлогын хүрээнд:

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуулийн төслүүдийг санаачлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж ажиллав. Тухайлбал,

- Улс төрийн намууд үйл ажиллагаа явуулахдаа чинээлэг хувь хүн, аж ахуйн нэгж байгууллага, эдийн засаг бизнесийн бүлэглэлээс хараат бус байх эрсдэл өндөр байгааг харгалзаж улс төрийн намуудыг санхүүжилтээр нь дамжуулан чадавхжуулж,

хариуцлагажуулах зорилгоор Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бүлгийн нийт гишүүд санаачлан боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүллээ.

- Сонгуулийн дүнг санал тоолох автоматжуулсан төхөөрөмжөөр хийх нь ихээхэн шүүмжлэл дагуулж байгааг харгалзан хяналтын тооллогыг сонгуулийн бүх хэсэгт гар аргаар явуулах, намын жагсаалтаар нэр дэвшсэн 28 нэр дэвшигчийг сонгогч өөрөө эрэмбэлж намыг бус хүнийг сонгодог журманд шилжих, санал тоолох автомат төхөөрөмжийн программ хангамжийн хянан баталгаажуулалтыг хараат бус хөндлөнгийн байгууллагаар хийлгэх зэрэг зохицуулалтыг бий болгохоор Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бүлгийн гишүүд санаачлан 2015 оны 11 дүгээр сарын 13 -ны өдөр Улсын Их хуралд өргөн мэдүүлэв.
- 2012 оны Аймаг, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн / шинэчилсэн найруулга/ хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх үеэр хуулийн төсөлд нутгийн өөрөө удирдах байгууллагын эрхийг хангах үүднээс ард иргэд төлөөлөө өөрсдөө дундаасаа сонгодог байх зарчимд тулгуурлаж, аль нэг намын санал болгосон нэр дэвшигчийг иргэд сонгодог байдлыг халж, цэвэр иргэдийн төлөөлөл байх ёстой гэж үзэж, улмаар чуулганы нэгдсэн хуралдаанд бүлгийн завсарлага авч, УИХ-ын гишүүн Н.Батцэрэг, Л.Цог, Г.Уянга нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулан ажиллууллаа. Завсарлага авч, ажлын хэсэг байгуулж ажилласны үр дүнд сонгогч саналаа өгөөгүй бол 1 жилийн хугацаанд төрийн албанд орох эрхгүй болох тухай заалтыг хуулийн төслөөс хасуулав.
- Монгол Улсыг 2030 он хүртэл хөгжүүлэх урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын төслийг боловсруулахаар УИХ дахь нам, эвслийн бүлгийн дарга нараар ахлуулсан ажлын хэсгийг байгуулан, төслийг боловсруулалцаж, УИХ -аар батлууллаа. Сонгуулиар аль ч улс төрийн нам хүчин гарсан тус хөгжлийн үзэл баримтлалын дагуу хөгжлийн бодлого, төлөвлөлтийг бүрдүүлсэн нь чухал ач холбогдолтой болов. Энэхүү үзэл баримтлалаар Монгол Улс 2030 он гэхэд нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой өсөж байгаа эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхарга давамгайлсан, экологийн тэнцвэрт байдлыг хадгалсан, тогтвортой ардчилсан засаглалтай улс болох ерөнхий зорилт дэвшүүллээ. Үзэл баримтлалыг 3 (2016 - 2020, 2021 - 2025, 2026 - 2030) үе шаттайгаар хэрэгжүүлж, 2030 он гэхэд нийгэм, эдийн засгийн үзүүлэлтийн хүрэх түвшинг 20 үндсэн үзүүлэлтээр тогтоолоо.

b) Уул уурхай, байгаль орчны салбарын хүрээнд:

- Оюу толгой хөрөнгө оруулалтын гэрээг сайжруулах өөрчлөлт оруулах тухай асуудлыг бүлгийн нийт гишүүд болон нэр бүхий 25 гишүүний хамт Засгийн газар /Н.Алтанхуяг/-т шаардлага хүргүүллээ.
- Оюу толгой ХК-нд санхүүгийн шалгалтыг анх удаагаа оруулж, олон тооны зөрчлийг олж тогтоолоо. санхүүгийн баримтын шалгалтаар 1.8 тэрбум ам долларын зөрчил, анхны хөрөнгө оруулалтыг 1.4 тэрбум ам долларыг зөрчлийг илрүүлж тогтоов.
- Уул уурхайн чиглэлээр гарсан хууль, УИХ -ын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг судалж, санал дүгнэлт боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий “Уул уурхайн хөгжил” түр хороо байгуулах тухай УИХ -ын тогтоолын

төслийг УИХ -ын бусад гишүүдийн хамт санаачлан боловсруулалцаж, Улсын Их Хурлаар батлууллаа.

- Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичгийн төсөлд бүлгээс салбарын эрдэмтэн судлаачдаас бүрдсэн өргөн бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг гаргаж ажиллаж, бүлгээс Эрдэс баялгийн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн төсөл боловсруулж, УИХ -ын тогтоолын төсөлд бодлогын болоод зарчмын шинж чанартай дараах саналуудыг хүргүүлэв.  
Тухайлбал:
  - Ашигт малтмалын тодорхой ордыг хугацаатай болон хугацаагүйгээр төлөвлөн нөөцлөн хадгалах, ашиглалтыг хязгаарлах, хориглох;
  - Орд газрын нөөцийг буруу тогтоосон, технологийг хангалтгүй сонгон, ордын нөөцийг сорчлон олборлож, ордыг сүйтгэсэн бол хариуцлага тооцох эрх зүйн орчинг бүрдүүлэх;
  - Газрын хэвлийн эрдэс баялгийг олборлосон, баяжуулсан бүтээгдэхүүн нь монгол түмний нийтийн өмч байх, баялгийн сангийн хуримтлалыг бий болгох;
  - Эрдэс баялаг нь үнэ үнэлэмжтэй байх, түүнийг Монгол улсын санхүүгийн бус үл хөдлөх хөрөнгөөр бүртгэж, ордын нөөц, нөөцийн хөдөлгөөний нэгдсэн тэнцлийн тайланг Засгийн газар жил бүр үйлдэж, УИХ-ын холбогдох байнгын хороонд танилцуулж байх;
  - Олборлох, баяжуулах үйлдвэрийн цогцолборыг барьж байгуулахдаа орон сууцны барилга, байгууламж, хүн амын нийгэм, соёлын асуудлыг иж бүрнээр төлөвлөн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэй хамт шийдвэрлэх зэрэг саналуудыг гаргасан байна.

Эдгээрээс гадна бүлгийн болон хувь гишүүдийн зүгээс холбогдох хуулийн төслүүдийг санаачлан бусад гишүүдийн хамт УИХ -д өргөн мэдүүлж, холбогдох асуудлуудаар бүлгийн нэгдсэн байр суурь мэдэгдэл, санал, дүгнэлтүүдийг байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж ажилласан байна.

\* \* \*





## УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН АЖЛЫН АЛБА

### Улсын Их Хурлын даргын Ажлын албаны эрх зүйн үндэс:

Улсын Их Хурлын тухай хуулийн 42 дугаар зүйлд “Улсын Их Хурлын дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ зөвлөгөө авах, шуурхай ажил гүйцэтгэх, зөвлөх ажлын хэсэгтэй байна. Улсын Их Хурлын даргын ажлын хэсгийн орон тоо, зардлын төсвийг Улсын Их Хурал тогтооно” гэж заасны дагуу Улсын Их Хурлын 2004 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 36 тоот тогтоолоор “Улсын Их Хурлын даргын ажлын хэсэг” байгуулагдаж, орон тоог 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр анх баталжээ. Харин 2012 оны 12 дугаар сарын 21 -ний өдөр Монгол Улсын Их Хурлын тухай хуульд “Улсын Их Хурлын дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын албатай байна. Ажлын албаны орон тоог Улсын Их Хурлын дарга баталж, ажлын албаны ажилтан Улсын Их Хурлын даргад ажлаа шууд хариуцаж, Тамгын газарт харьяалагдана” гэсэн нэмэлт, өөрчлөлт оруулсан.

### Ажлын албаны бүтэц, бүрэлдэхүүн:

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу Улсын Их Хурлын даргын 2012 оны 12 дугаар сарын 26 -ны өдрийн 168 тоот захирамжаар Ажлын албаны орон тоог дараах бүрэлдэхүүнтэй байхаар баталжээ. Үүнд:

- Улс төрийн бодлогын зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга,
- Хууль зүйн бодлогын зөвлөх,
- Эдийн засгийн бодлогын зөвлөх,
- Нийгмийн бодлогын зөвлөх,
- Улс төрийн бодлогын асуудал хариуцсан ахлах референт,
- Хууль зүйн бодлогын асуудал хариуцсан референт,
- Эдийн засгийн бодлогын асуудал хариуцсан референт,
- Нийгмийн бодлогын асуудал хариуцсан референт гэсэн 8 хүний бүрэлдэхүүнтэй байна.

№	Албан тушаал	Орон тоо
1	УИХ-ын даргын ахлах зөвлөх, Ажлын албаны дарга	С.Ламбаа
2	УИХ-ын даргын Хууль зүйн бодлогын зөвлөх	А.Гансүх
3	УИХ-ын даргын Эдийн засгийн бодлогын зөвлөх	Д.Лхагвасүрэн
4	УИХ-ын даргын Нийгмийн бодлогын зөвлөх	Ц.Буянцогтоо
5	Ажлын албаны ахлах референт	Ч.Хосбаяр
6	Ажлын албаны референт	Х.Ундрах, Ш.Бадамцоо, Б.Төгөлдөр
7	УИХ-ын даргын шадар туслах	Ж.Батсайхан
8	УИХ-ын даргын туслах	Г.Ганбагана
9	УИХ-ын даргын гэрэл зурагчин	Х.Сүх-Очир

\* \* \*

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН ОРОЛЦОО ДЭМЖЛЭГТЭЙГЭЭР ХЭРЭГЖИЖ БАЙГАА ТӨСЛҮҮД**

**А. “ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛЬ ТОГТООХ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ**

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр, Монгол Улсын Их Хурлын Тамгын газар хамтран “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийг 2013 оны 3 дугаар сараас эхлэн хэрэгжүүлж байна. Тус төсөл нь 2012 - 2016 онд Монгол улсад хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ардчилсан засаглалын салбар дахь НҮБХХ ба Монгол улсын Засгийн газрын хамтын ажиллагааны нэг хэсэг юм. НҮБХХ -ийн Хөгжлийн бодлогын товчооны тэргүүлсэн засаглалын баг Монгол улсад 2012 оны 10 дугаар сард ажиллаж шинээр гарч буй хэрэгцээг тодорхойлсон бөгөөд төслийг уг хэрэгцээнд үндэслэн боловсруулсан.

Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь төслийн баримт бичигт УИХ-ын дарга З.Энхболд, НҮБХХ-ийн суурин төлөөлөгч Сезин Синаноглу нар 2013 оны 3 дугаар сарын 13-нд гарын үсэг зурж, мөн оны 8 сараас 2016 оныг дуустал төсөл хэрэгжсэн юм. Энэхүү төслийг хэрэгжүүлэхэд НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрөөс 1 сая ам.долларын санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Төслийн үйл ажиллагаа нь 4 үндсэн үр дүнд чиглэсэн. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санааны дагуу төрийн институцийн шинэчлэлийн Монгол Улсын 20 жилийн туршлага, сургамжийн талаар дэлгэрэнгүй шинжилгээ хийх;
- Төрийн байгуулалттай холбоотой хуулийн төсөл боловсруулахад бодлогын судалгаа хийх, олон нийттэй зөвлөлдөх, хууль боловсруулах үйл ажиллагааг сайжруулах;
- Иргэд ба сонгогдсон төлөөлөгчид хоорондын харилцааг бэхжүүлэх;
- Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн хэрэгжилтийг сайжруулах;

1. Монгол Улс ардчилсан Үндсэн хуулиа 1992 онд тунхаглаж баталснаас хойш 20 жилийн хугацаан дахь төрийн байгуулалт, Үндсэн хуулийн институцийн хөгжлийн явц, туршлага, сургамжийн талаар гадаад, дотоодын бие даасан шинжээч, судлаачдаар судалгаа, дүн шинжилгээ хийлгүүлэх ажлыг 2013 оноос эхлүүлэв.



“Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг: Дүн шинжилгээ”, (Судалгааны тайлан, хамтын бүтээл), УБ., 2015;

Судалгааны явцын тайланг “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг тогтоох” УИХ-ын ажлын хэсгийн гишүүд, төрийн байгууллага, судлаачдаар



хэлэлцүүлэн, 2015 онд энэ судалгаа, шинжилгээний ажлын эцсийн тайланг “Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг: Дүн шинжилгээ” нэртэйгээр хүлээн авч, Монгол, Англи хэлээр хэвлэн нийтэлж, цахим хуудсанд нээлттэй байршуулан олон нийтийн хүртээл болгосон юм.

Судалгааны багийн тайланд, “Монгол Улсын Үндсэн хууль 1992 оноос хойш ардчилсан засаглалын бат бэх суурийг тус улсад бий болгожээ. Гэхдээ энэ нь улс төрийн институци бүрийн гаргасан шийдвэр болгон оновчтой байсан гэсэн үзүүлэлт биш юм. Аливаа Үндсэн хуулийн үүрэг нь зөрчлийг зохицуулах, бодлого батлах, төр засаг эрх мэдлийг урвуулан ашиглахаас сэргийлэх институцийг бий болгоход оршдог. Энэ утгаар авч үзвэл, Үндсэн хууль ерөнхийдөө амжилттай хэрэгжсэн”<sup>6</sup> гэж дүгнэжээ.

2. Төрийн байгуулалттай холбоотой хуулийн төсөл боловсруулахад бодлогын судалгаа хийх, олон нийттэй зөвлөлдөх, хууль боловсруулах үйл ажиллагааг сайжруулах зорилгын хүрээнд, нэгдүгээрт, Хууль тогтоомжийн тухай хуулийн төслийг боловсруулах, хэлэлцүүлэхэд дэмжлэх үзүүлэх, хоёрдугаарт, төрийн байгуулалттай холбоотой тодорхой хуулиудын төслийг боловсруулахад бодлогын судалгаагаар хангах, хэлэлцүүлэгт дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэв.

Хууль тогтоомжийн тухай хуулийн төслийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор дараах 3 төрлийн судалгааг хийлгэн хууль санаачлагчид хүргүүлсний дүнд, хуулийн төслийг өргөн мэдүүлсэн юм:

- Хуулийн төсөл боловсруулах стандарт, журмын талаарх олон улсын харьцуулсан туршлага, сайн практикийг судлах судалгаа;
- Хуулийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэхтэй холбоотой хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, дагалдах хууль боловсруулах зөвлөх үйлчилгээ;
- Хуулийн төсөлд хийсэн үр нөлөөний шинжилгээ.

Төслийн дэмжлэгтэйгээр холбогдох харьцуулсан судалгаа, бодлогын дүн шинжилгээ хийлгэж, зөвлөх үйлчилгээ авсны дүнд Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журмын тухай” хуулийн төслийг өргөн мэдүүлж, хуулийн төслийн хэлэлцүүлгийг өргөн хүрээнд төслийн дэмжлэгтэйгээр зохион байгуулав. УИХ дахь хэлэлцүүлгийн явцад хуулийн төслийн нэр өөрчлөгдөж “Хууль тогтоомжийн тухай хууль” (шинэчилсэн найруулга) нэртэйгээр 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан юм. Хууль тогтоох ажиллагаанд иргэдийн оролцоог хангахад Хууль тогтоомжийн тухай хуулиар эрх зүйн өргөн боломжийг бүрдүүлж өгсөн байна. Тухайлбал,

- Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээс өмнө олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах үүрэгтэй болсон (Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.1 дэх хэсэг);
- Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслөө албан ёсны цахим хуудастаа байршуулж, ирсэн саналыг төсөлдөө тусгасан, тусгаагүйгээр ангилан цахим хуудсаараа мэдээлэх ёстой (мөн хуулийн 38.2, 38.6 дахь хэсэг);
- Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөлд тусгасан, тусгаагүй олон нийтийн саналын товъёгийг өргөн мэдүүлэх баримт бичгийн бүрдүүлбэртээ хавсарган өгөх ёстой (мөн хуулийн 40.1.10).

<sup>6</sup> “Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг: Дүн шинжилгээ”, (Судалгааны тайлан, хамтын бүтээл), УБ., 2015, 102 дахь тал;

Хууль тогтоомжийн тухай хуульд тусгасан эдгээр зохицуулалт нь иргэд, олон нийт, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн этгээд хуулийн төслийг өргөн мэдүүлэхээс өмнө түүнтэй танилцах, улмаар саналаа өгөх, өгсөн санал нь тусгагдсан эсэх талаар мэдээлэл авах боломжийг олгож, хууль санаачлагчид энэ талаар үүрэг хүлээлгэсэн ба энэ нь шинэлэг харилцаа юм.

Хууль тогтоомжийн тухай хууль нь хууль боловсруулах, өргөн мэдүүлэх, хэрэгжилтийг үнэлэх, түүнд иргэдийн оролцоог хангахад 1997 онд батлагдаж 20-оод жил хэрэгжиж байсан эрх зүйн эх сурвалжид томоохон өөрчлөлт оруулсан шинэтгэл болсон ба эрх зүйн шинэ тутам зохицуулалтын зөв, бүрэн дүүрэн хэрэгжилтийг хангахын тулд таниулах, мэдээлэх, тайлбарлах, сурталчлах ажлын ач холбогдол их байна.

Төрийн байгуулалтын салбарын хууль тогтоомжоос сонгуулийн нэгдсэн хууль, улс төрийн нам, түүний санхүүжилтийн хууль, Төрийн албаны багц хууль, УИХ-ын багц хуулийн шинэчлэлтийг онцлон авч үзэж, эдгээр хуулийн төслийг боловсруулах, хэлэлцүүлэхэд дэмжлэг үзүүлэх төслийн үндсэн зорилгын нэг байв:

- a. “Улс төрийн намуудын санхүүжилт, гишүүнчлэл, орон нутгийн сонгууль дахь улс төрийн намын оролцоог боловсронгуй болгох нь” судалгааг хийлгэж Улс төрийн намын хуулийн төсөл хэлэлцүүлэгт бэлтгэх УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын хэсэг, мөн Ерөнхийлөгчийн Тамгын газартхүргүүлж бодлогын судалгааны дэмжлэг үзүүлэв;
- b. Сонгуулийн хуулийн тодорхой сэдэв, асуудлаар “Сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны эрхзүйн орчинг боловсронгуй болгох нь”, “Сонгуулийн маргаан шийдвэрлэх нь: Сонгуулийн маргааныг хянах нэгдсэн системийг бий болгох чиглэлээр” (“OECD”-ын гарын авлага) судалгаа, шинжилгээ хийлгэж, гарын авлагыг орчуулан гаргаж хүргүүлэв. Сонгуулийн хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Р.Бурмаа нарын 16 гишүүн 2015 оны 11 дүгээр сарын 6-нд өргөн мэдүүлж, УИХ 2015 оны 12 дугаар сарын 25-нд Сонгуулийн тухай хуулийг батлав;
- c. Монгол Улсын Ерөнхийлөгч 2015 оны 7 дугаар сарын 1-ний өдөр Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн юм. Хуулийг төслийг УИХ-д хэлэлцэхэд дэмжлэг үзүүлэв.

Тухайлбал, Монгол Улсын төрийн албаны тогтолцоо, эрх зүйн шинэтгэлийн тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга замын тухай хэлэлцэж, олон нийтийн саналыг авах зорилгоор “Төрийн албаны эрх зүйн шинэтгэл” хэлэлцүүлгийг УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо, Төрийн албаны зөвлөлтэй хамтран өргөн хүрээнд зохион байгуулав.

Хэлэлцүүлэгт бодлого боловсруулагчид, төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага, судалгаа, мэргэжлийн байгууллагууд, иргэний нийгмийн төлөөлөл оролцсон бөгөөд хэлэлцүүлгээс гарсан саналыг УИХ-ын ажлын хэсэгт хүргүүлсэн. Төрийн албаны хуулийн шинэчилсэн найруулгын төсөл одоо УИХ-ын анхны хэлэлцүүлгийн шатанд байна;

- d. Улсын Их Хурлаас Нийтийн сонголын тухай, Захиргааны ерөнхий хуулиудыг 2015 онд баталсан ба эдгээр хуульд иргэдийн оролцоотой шийдвэр гаргах механизмыг тусгасан. Хуульд тусгагдсан иргэдийн оролцооны тогтолцоог хэрэгжүүлэхэд төслөөс арга зүйн туслалцаа үзүүлэв.

3. Иргэд ба сонгогдсон төлөөлөгчид хоорондын харилцааг бэхжүүлэх зорилгын хүрээнд

УИХ-ын Өргөдлийн байнгын хорооны иргэдийн гомдлыг хүлээн авч шийдвэрлэх чадавхыг сайжруулах, Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэв.

Төслийн санхүүжилтээр боловсруулсан [www.urgudul.parliament.mn](http://www.urgudul.parliament.mn) цахим системийг ӨБХ-нд бүрэн хэрэглээнд нэвтрүүлж ашиглаж байна. Энэхүү систем нь өргөдөл, гомдлыг бүртгэх, ангилах, хариу өгөх хугацаанд хяналт тавих иж бүрэн хяналтын программ юм. Өргөдлийн байнгын хорооны үйл ажиллагааг сурталчлах, ажлын албаны чадавхыг дээшлүүлэх зорилгоор ӨБХ-ны үйл ажиллагааны танилцуулга, брошур, тус Байнгын хороонд иргэд хэрхэн хандах гарын авлагыг хэвлүүлж иргэдэд түгээв. Байнгын хорооны ажлын албаны ажилтнуудыг ХБНГУ-ын парламентын өргөдлийн асуудал эрхэлсэн байнгын хорооны үйл ажиллагаатай танилцуулах арга хэмжээг төслийн дэмжлэгтэйгээр зохион байгуулж, чадавхыг бэхжүүлэв;

Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагаанд иргэдийн мэдээлэл авах эрх хэрхэн хангагдаж, хэрэгжиж байгааг тандан судалж, хэрэгжилтийг хангуулах, мэдээлэл авах талаарх холбогдох хуулийг сурталчлах ажил чухал ач холбогдолтой. Энэ хүрээнд төслөөс бодлогын болон практик асуудлаар дараах “Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, мэдээллийн ил тод байдал, иргэдийн мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хууль тогтоомж, түүний хэрэгжилтийн байдалд мониторинг судалгаа хийх, эрх зүйн орчинг боловсронгуй болгох саналыг боловсруулах”, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 23, 24 дүгээр зүйлийн хэрэгжилт, мониторинг” зэрэгсудалгааг хийлгэж холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажлыг эрхэлж буй байгууллагад хүргүүлэв.

Парламент ба олон нийтийн харилцааг бэхжүүлэх талаар Төслийн хүрээнд Төрийн ордны хуралдааны 6 танхим, 21 аймгийн иргэний танхим, нийт 27 цэгийг холбосон тоон технологийн дүрст хурлын системийг байгуулж ашиглалтад орууллаа. Тус системийг Улсын Их Хурал төдийгүй Засгийн газар, Ерөнхийлөгчөөс хууль тогтоомж боловсруулах, хэлэлцэх болон тэдгээрийн хэрэгжилтийг хангахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, Улсын Их Хурлын гишүүд, Ерөнхийлөгч, Төрийн захиргааны төв байгууллагаас иргэд, олон нийттэй харилцах харилцааг бэхжүүлэхэд ашиглах боломж олгох зорилгоор хамтарсан журмын төслийг төслийн нэгжээс боловсруулж талуудтай зөвшилцөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Засгийн Газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Тагнуулын ерөнхий газрын даргын хамтарсан тушаал, захирамжийг 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдөр батлан мөрдөж байна.

“Парламент ба иргэдийн харилцааг бэхжүүлэхэд сэтгүүлчдийн оролцоо” сэдэвт парламентын сэтгүүлчдийн сургалтыг зохион байгуулсан нь УИХ-ын үйл ажиллагааг иргэдэд хүргэхэд чухал хувь нэмэр болов. Энэхүү сургалтаар Хууль тогтоомжийн тухай хуулийн төсөлд олон нийтийн оролцоог хэрхэн туссан, Улс төрийн мэдээллийг жендэрийн мэдрэмжтэй боловсруулж хүргэх нь зэрэг сэдвүүдээр мэдээлэл өгсөн юм.

4. Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн хэрэгжилтийг сайжруулах, Авлигатай тэмцэх үндэсний стратегийг сурталчлах, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэх нь Үр дүн 4-ийн хүрээнд хийгдэх үндсэн ажлууд байв.

“Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн орон нутаг дахь хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдлыг судлан цаашид авах арга хэмжээг тодорхойлох” судалгааг хийлгэн

АТГ-т хүргүүлж судалгааны дэмжлэг үзүүлэв. Авлигын эсрэг НҮБ -ын Конвенцийн 2 ба 5 бүлгийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээг хийх хяналтын асуумжийг орчуулж, үнэлгээний тайлан боловсруулах зөвлөхөөр хангаж, үнэлгээ хийх бэлтгэл хангах хүрээнд үнэлгээг хийх олон улсын Омнибус программ хангамжийг тайлан гаргах төрийн байгууллагуудын холбогдох албан хаагчдад танилцуулах, программыг ашиглан хэрхэн тайлан гаргах талаар сургалтыг АТГ-тай хамтран зохион байгуулав.

“Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төсөл нь хууль тогтоох байгууллага ба иргэдийн хооронд мэдээллийн урсгалыг тогтмолжуулах, хууль тогтоох үйл ажиллагаа, хуулийн төслийн талаарх иргэдийн санал, хүсэлтийг тогтмол хүлээн авах механизм бүрдүүлэх, хуулийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох, авилгатай тэмцэх эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийг хангахад оролцогч байгууллагууд, ажилтнуудын чадавхыг бэхжүүлж, техникийн туслалцаа үзүүлсэн нь чухал ач холбогдол арга хэмжээ болсон юм.

\* \* \*

#### Төслийн удирдах зөвлөл

Төслийн удирдах зөвлөл (ТУЗ) нь төслийн үйл ажиллагаа жилийн төлөвлөгөө, төслийн баримт бичигт тусгагдсаны дагуу хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавина. ТУЗ -ыг Хэрэгжүүлэгч байгууллагын удирдлага (Төрийн байгуулалтын Байнгын хорооны дарга) даргалах бөгөөд ТУЗ төслийн үр дүнг хүртэгчид, нийлүүлэгчээс бүрдэнэ. ТУЗ 6 сард нэг удаа хуралдана. ТУЗ нь ажлын төлөвлөгөө, төсөв, төслийн баримт бичигт өөрчлөлт оруулах зэрэг асуудлаар удирдах зөвлөлийн шийдвэр гаргана. ТУЗ нь:

- Засгийн газрын байгууллагууд хоорондын ажлын уялдааг хангах;
- Төслийн үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн тэргүүлэх чиглэл, хөрөнгө нөөцийг тогтвортой ашиглах бодлоготой нийцүүлэх;
- хэрэгжүүлэгч нэгжүүдийн ажил, үр дүнд хяналт тавих, тайланг хүлээн авах;
- санхүүгийн менежмент, санхүүгийн тайланд хяналт тавих;
- Төсөл үр нөлөөтэй хэрэгжиж байгаад хяналт тавих үүрэгтэй.

Төслийн удирдах зөвлөл дараах бүрэлдэхүүнтэй.

Төслийн Удирдах зөвлөлийн дарга нар:

- Б. Болдбаатар, УИХ -ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Төслийн захирал
- Томас Эрикссон, НҮБХХ -ийн Орлогч Суурин төлөөлөгч – ТУЗ -ийн хамтран даргалагч

Төслийн Удирдах зөвлөлийн гишүүд:

- Л. Цог, УИХ -ын дэд дарга
- А. Бакей, УИХ -ын Төрийн байгуулалтын Байнгын хорооны дарга
- Р. Бурмаа, УИХ -ын Өргөдлийн Байнгын хорооны дарга
- Ш. Түвдэндорж, УИХ -ын Хууль зүйн Байнгын хорооны дарга
- Л. Төр-Од, Ерөнхийлөгчийн хуулийн асуудал хариуцсан шадар туслах
- Ж. Баярцэцэг, Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга
- Т. Хадхүү, Төрийн албаны зөвлөлийн гишүүн

- Б. Бат - Отгон, Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх газрын дарга
- Х. Наранжаргал, Глоб Интернэйшнл ТББ -ын захирал
- П. Эрдэнэжаргал, Нээлттэй нийгэм форумын гүйцэтгэх захирал
- Д. Солонго, МУИС -ийн Хууль зүйн сургуулийн захирал

Төслийн зохицуулагчаар Н. Отгончимэг ажилласан.

#### **В. УИХ-ЫН ТАМГЫН ГАЗАР, ШВЕЙЦАРИЙН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ, НҮБ-ЫН “НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ” ТӨСӨЛ**

Улсын Их Хурал, Швейцарийн хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь” төслийн зорилго нь нутгийн удирдлагын хариуцлага, орон нутгийн үйлчилгээг сайжруулахад орон нутгийн хурлын төлөөллийн болон хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэхэд оршино.

Төсөл нь 2013-2016 онд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг чадавхижуулах 4 зорилт, үр дүнгийн хүрээнд хэрэгжсэн.

- Үр дүн 1. Орон нутгийн сонгуульт төлөөлөгчдөд зориулсан сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх механизмыг бий болгох.
- Үр дүн 2. Шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог дэмжих замаар сонгуульт төлөөлөгчдийн иргэдийн өмнө хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх.
- Үр дүн 3. Орон нутгийн хурлын хяналтын чиг үүргийг бэхжүүлэх.
- Үр дүн 4. Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн орчныг сайжруулах, хурлуудын сайн туршлага солилцох, хамтын ажиллагааг дэмжих.

ҮР ДҮН 1 -ИЙН ХҮРЭЭНД:

Аймгуудын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (ИТХ)-тай хамтран ИТХ-ийн нийт 8000 гаруй төлөөлөгчдийн 88 хувь буюу 7200 төлөөлөгчдийн хамруулсан чадавхижуулах сургалтыг 21 аймаг, 9 дүүрэгт, 5 сарын хугацаанд багтаан зохион байгуулсан. ИТХ-ын 7293 Төлөөлөгчийг уг сургалтад хамруулсан нь Монголын нийт ИТХ-ын Төлөөлөгчдийн 88.6 хувь нь юм. Сургалтад оролцсон бараг бүх төлөөлөгч суурь сургалтыг чухал буюу маш чухал гэж үнэлсэн бөгөөд сургалтын сэдвүүд ИТХ-ын төлөөлөгчдөд ач холбогдолтой гэж үзсэн байна.<sup>7</sup>

Суурь сургалтын төгсгөлд оролцогч бүрийн боловсруулсан ажлын төлөвлөгөөнөөс харахад сургалтаар олгосон мэдлэгийг сайн ойлгож, Орон нутгийн хөгжлийн сан, төрийн үйлчилгээний чанарт хяналт тавих, ИТХ-ын хуралдааны дүрэм журмыг шинэчлэх, хорооны хуралдааныг тогтмолжуулах зэргээр практикт хэрэглэх чадвартай болсон бана.

Сургалтаас бий болсон нэг эерэг нөлөө нь зэргэлдээх 6-7 сумын хурлын Төлөөлөгчдийг нэг баг болгон сургах арга барил хэрэглэсний үр дүнд тэд нэг нэгэнтэйгээ ойр танилцаж, мэдээлэл, туршлага солилцон, цаашид хамтран ажиллах суурийг тавьжээ. 2016 онд болон цаашид харилцан суралцах, туршлага солилцох ийм үр дүнтэй үйл ажиллагааг дэмжих талаар авч үзэх нь зүйтэй байж болох юм.

<sup>7</sup>Төслийн дунд хугацааны тайлан, Пол Ван Хуф, 2015 оны 11-р сар

Сургалтаас бий болсон өөр нэг эерэг нөлөө нь сургалтад оролцогчид одоогийн ЗЗНДНТУХ-ийн хийдэл, зөрчлийн талаар болон хэрхэн боловсронгуй болгох талаар олон санал гаргасан явдал бөгөөд эдгээрийг хуулийн шинэчлэлийн санал боловсруулж буй судалгааны багт шилжүүлж өгсөн байна.

#### Хурлын төлөөлөгчдөд зориулсан сэдэвчилсэн сургалтууд

- Бүх шатны 2823 (90,6%) ИТХ-ын Тэргүүлэгч Төлөөлөгч “Төлөөлөгчийн манлайлал”,
- Төлөөлөгчдийн манлайлал (8 цаг);
- Хяналт-шинжилгээ ба үнэлгээ, Хурлын шийдвэрийн хэрэгжилтэд тавих хяналт (2 цаг);
- Судалгааны арга зүй (2 цаг);
- Нутгийн өөрөө удирдах байгууллага болон бусад байгууллагын хоорондын харилцааны гол төрлүүд (4 цаг);

Сургалтын агуулгыг Төрийн албаны зөвлөл (ТАЗ) -ийн экспертүүд, Хурлын тэргүүлэгчдийн ажлын алба, УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо (УИХ-ын ТББХ) -ны зөвлөхүүд, мөн НҮБХХ -ийн Засаглалын баг хамтран боловсруулсан.

Сэдэвчилсэн сургалтыг 2015 оны 5-р сараас 11-р сарын хооронд бүх сум, аймаг, Улаанбаатархотын болон дүүргүүдийн Хурлын тэргүүлэгчдийг хамруулан улс даяар зохион байгуулсан.

#### Нутгийн удирдлагад эмэгтэйчүүдийн манлайлал” сургалт

Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан “Нутгийн удирдлагад эмэгтэйчүүдийн манлайлал” сэдэвт сургалтын хөтөлбөр, гарын авлагыг боловсруулж, 21 аймаг, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчдөөс 30 сургагч багш бэлтгэж, 21 аймаг, нийслэл, дүүрэгт зохион байгуулахад ний 2204 төлөөлөгчөөс 1926 буюу 67.8% нь сургалтад хамрагдсан.

Эмэгтэй төлөөлөгчдийн сургалтаас гарсан гол үр дүнгийн хувьд эмэгтэй төлөөлөгчид дараах арга барил, шинэлэг зүйлийг сурч авсан, үүнд,

- Орон нутгийн хөгжилтэй холбоотой сорилтуудыг хэрхэн тодорхойлох, гол асуудлуудад хэрхэн дүн шинжилгээ хийж боломжит шийдлийг гаргах;
- Хурлын шийдвэр гаргахад дуу хоолой нь тэр болгон сонсогдоод байдаггүй иргэдийн янз бүрийн бүлгийн, тэр дундаа эмзэгбүлгүүдийн ашигсонирхлыг хэрхэн төлөөлөх;
- Улстөрд, эх эмэгтэйчүүдэд тулгардаг нийгэм, соёлын саад бэрхшээлд шинжилгээ хийсний үндсэн дээр нөлөөллийн хүрээгээ хэрхэн өргөжүүлэх; мөн,
- манлайллын өөрөөр хэв маягийг үнэлж улмаар манлайллыг хэрхэн хэрэгжүүлэх, давуу болон сул талаа хэрхэн зөв удирдах.

Эмэгтэй төлөөлөгчдийн сургалтын дараа хэд хэдэн санаачлага гарсан. Тодруулбал, эмэгтэй төлөөлөгчдийн клубыг байгуулсан, хурлын зардлаар Налайх дүүрэг, Дорноговь аймгийн Замын Үүд суманд нэмэлт сургалт зохион байгуулсан, улс төр дэх эмэгтэйчүүдийн талаар олон нийтэд сурталчлан таниулах үүднээс Ховд аймгийн орон нутгийн телевизээр цуврал нэвтрүүлэг гаргасан, мөн ижил аргачлал ашиглан Ховд аймгийн Жаргалант сумын багийн түвшинд сургалтыг зохион байгуулсан зэргийг дурдаж болно<sup>8</sup>.

Хурлын хоёр эмэгтэй төлөөлөгч (Баянзүрх дүүрэг болон Архангай аймгийн Өгий нуур сум)

<sup>8</sup> Монфемнет, Эмэгтэйчүүдийн манлайллын сургалтын эцсийн тайлан, 2015 он.



шийдвэр гаргах түвшинд эх эмэгтэйчүүдийн төлөөллийн асуудлаарх үндэсний хэмжээний хоёр телевизийн ток шоунд УИХ-ын эмэгтэй гишүүд болон бусад илтгэгчидтэй хамтран оролцсон<sup>9</sup>.

ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ ЗАМААР СОНГУУЛЬТ ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ИРГЭДИЙН ӨМНӨ ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, ОРОН НУТГИЙН ХУРЛЫН ХЯНАЛТЫН ЧИГ ҮҮРГИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

2014-2015 онд ИТХ-ын үйл ажиллагааг дэмжих тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлж 41 иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (ИТХ)-ыг хамруулж 200 орчим сая төгрөгийн санхүүжилт олгож, бодлого, арга зүйн дэмжлэг үзүүлсэн. 2014 оны хөтөлбөрт 16 ИТХ хамрагдан үр дүнтэй хэрэгжүүлсэн туршлагад үндэслэн 2015 онд ИТХ-ын тоог нэмэгдүүлж, 25 ИТХ шалгаруулж тэтгэлэг олгосон. Эдгээрийн 5 нь аймгийн ИТХ, 18 нь сум, 1 нь дүүргийн ИТХ байна.

2014 онд иргэний оролцоо, ОНХС-нд тавих хяналт гэсэн 2 сэдэвтэй байсан бол 2015 онд хангалттай төлөөлөлгүй бүлэг болох залуучууд, эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг асуудлыг хамарч,

- иргэдийн оролцоо;
- төрийн үйлчилгээний чанар хүртээмжид хяналт тавих нь;
- орон нутгийн сангийн хэрэгжилтэд хяналт тавих нь;
- эмзэг бүлэгтэй ажиллах нь гэсэн дөрвөн үндсэн чиглэлээр тэтгэлэг хэрэгжсэн.

Төрийн үйлчилгээний чанар хүртээмжид хяналт тавих нь тэтгэлэг хэрэгжүүлсэн аймаг, сумдын 2000 гаруй иргэн судалгаа, санал асуулгад хамрагдан ИТХ-ын үйл ажиллагаа, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, өрхийн болон сум дундын эмнэлгийн үйлчилгээ, сурагчдын “Үдийн цай” хөтөлбөрийг үнэлж, тулгамдаж буй асуудал, бэрхшээлийг шийдвэрлэхэд өөрсдийн санал бодлыг тусгажээ.

Санал асуулгын дүнгээс Сум хөгжүүлэх сангийн талаар иргэдийн дийлэнх хувь нь мэдэхгүй (Хөвсгөл, Чандмань-Өндөр), Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гүйцэтгэх худалдан авалтад иргэдийн оролцоо, хяналт сул (Сүхбаатар), өрхийн эмнэлгийн тусламж үйлчилгээ хангалтгүй (Завхан, Улиастай) гэсэн дүгнэлт хийж, сургалт, нээлттэй хуралдаан, хэлэлцүүлэг зохион байгуулах, гарын авлага боловсруулж тараах зэргээр иргэдэд мэдээллийг ил тод хүргэх, холбогдох асуудлаар мэдлэг олгох, асуудлыг шийдвэрлэхэд иргэдийн саналыг тусгах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна.

ИТХ-ын хяналтын чиг үүргийг сайжруулах нь тэтгэлэг хэрэгжүүлсэн ИТХ-ууд хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулж, цаашид авах арга хэмжээг тодорхойлохоор иргэдээс санал асуулга авсан бөгөөд үүнд Баянхонгор аймгийн ИТХ-ээс баталсан тогтоол, шийдвэр хэрхэн хэрэгжиж байгаа талаар 20 сумын 104 багийн 1000 гаруй иргэн, Хөвсгөл аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар нийт сумдын 2345 иргэн, Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын Тамгын газрын харьяа 6 байгууллагын 70 гаруй ажилтан хамрагджээ. Эдгээр арга хэмжээний үр дүнд:

- Хэрэгжилт удаашралтай байгаа хууль, тогтоол, шийдвэрийн биелэлтийг хангуулах, цаашид авах арга хэмжээг тодорхойлж, хэрэгжих нөхцөл боломжийг тодорхойлсон
- ИТХ, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагаа идэвхжиж, Засаг даргын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн суурь түвшинг тогтоосон

<sup>9</sup> НҮБ-ын ХХ/NCGE, Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүд, DVD Телевизийн ток шоуны бичлэг, 2015 ;

- ИТХ-ын тогтоол, шийдвэр болон төсөвт байгууллагуудын ажлын мэдээллийг багтаасан “Мэдээлэл-2015” хавтас айл өрх, албан байгууллагуудар аялах болсон байна.

Орон нутгийн шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь:

Энэ чиглэлээрх тэтгэлэгт 13 сум, нэг дүүрэг хамрагдаж, тэтгэлгийн хүрээнд зохион байгуулагдсан санал асуулгад 4000, сургалтад 900, чуулган, хэлэлцүүлэгт 1000 орчим иргэн оролцсон байна.

Шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагааг зөвхөн санал авах төдийгөөр хязгаарлах бус тэднийг идэвхтэй, бүтээлч оролцоо, харилцан санал бодлоо солилцож, хамтран ажиллах нөхцлөөр хангасан явдал нь тэтгэлгийн гол ач холбогдол байлаа. Тэтгэлэг хэрэгжсэнээр бий болсон бодит үр дүнгээс дурдвал:

- Иргэдэд мэдээлэл шуурхай, ил тод хүрэх нөхцөл бүрдсэн
- Иргэд тухайн орон нутагтаа тулгамдсан асуудлаа өөрсдөө тодорхойлж, шийдвэрлэх арга замыг хэлэлцэн тогтоож, нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэрт тусгуулан бодит үйл ажиллагааг хэрэгжүүлсэн
- Иргэний танхимын үйл ажиллагааг идэвхжүүлсэн
- Тодорхой урамшуулал бүхий Нийтийн эргүүл ажиллаж эхэлсэн (Чингэлтэй дүүрэг)
- Иргэний танхимыг явуулын хэлбэрээр ажиллуулсан (Баянхонгор Эрдэнэцогт, Увс Тариалан )
- Залуучуудын хөгжлийн хөтөлбөр батлагдсан (Баянхонгор, Гурванбулаг)
- Малчдын хороолол бий болгох замаар бэлчээрийн даац хэтэрсэнээс үүдэлтэй малын ашиг шим, малчин өрхийн амьжиргааны түвшин буурсныг шийдвэрлэсэн (Өвөрхангай, Хархорин)
- Залуу малчдыг дэмжих хөгжлийн хөтөлбөр, бичил уурхай эрхлэгчдийн хоршоотой болсон (Дундговь, Хулд)
- Иргэдийн оролцоотойгоор сумын боловсрол, эрүүл мэндийн дэд хөтөлбөр баталсан(Булган, Хутаг-Өндөр)
- Төрийн байгууллагуудын мэдээлэл солилцох журам” бодлогын баримт бичиг батлагдсан (Говь-Алтай, Шарга)
- Хог хаягдлын цэгт байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж, асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай хөрөнгийг төсөвт тусгуулсан (Говьсүмбэр, Шивээговь)
- Сайн дурын Иргэний зөвлөл байгуулагдсан (Хөвсгөл, Төмөрбулаг)
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх худалдан авалтад иргэдийн оролцоог хангаж, сургалт зохион байгуулсан. (Говь-Алтай, Баян-Уул, Өвөрхангай)

Эмзэг бүлгийнхэнтэй ажиллах нь:

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сум “Нийгмийн эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн оролцоогоор хангах нь”; Төв аймгийн Баянчандмань сум “Өрх толгойлсон эмэгтэйчүүдийг дэмжиж ажиллах нь”; Дундговь аймгийн Адаацаг сум “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь” тэтгэлэг хэрэгжүүлэв.

ИТХ-ын дэмжих тэтгэлэг хэрэгжсэнээр ИТХ-ын хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх ажиллагаа



идэвхжиж, тэдгээрийн ажлын албаны ажилтнуудын ажлын ур чадвар тодорхой хэмжээнд сайжирсан гэж дүгнэж болно. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй, бага орлоготой иргэд, өрх толгойлсон эмэгтэйчүүд, залуу малчид төдийгүй тухайн орон нутгийн нийт иргэд шууд болон шууд замаар тэтгэлгийн үр дүнг хүртэв. Тухайлбал, 9500 гаруй иргэн санал асуулга, судалгаанд хамрагдаж, 10,000 орчим иргэн сургалт, хэлэлцүүлэгт оролцох замаар нутгийн удирдлагын байгууллагуудын үйл ажиллагаа, ажлын үр дүнг үнэлж, шийдвэр гаргах түвшинд өөрсдийн дуу хоолойг хүргэв.

Тэтгэлэг хэрэгжүүлэх хугацаанд сайн туршлага солилцох уулзалт, сайн туршлагын эх бэлтгэх уулзалт семинарыг тус тус зохион байгуулсан. Энэ үеэр ИТХ-ийн хуулиар олгогдсон бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэхэд батлагдсан төсөв хангалттай хүрэлцдэггүй өнөөгийн нөхцөлд төлөвлөсөн ажлаа амжилттай хийж хэрэгжүүлэхэд тэтгэлэг нь чухал хөшүүрэг боллоо гэдгийг ажлын албаны ажилтнууд онцолж байв.

ҮР ДҮН 4. НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ, ХУРЛУУДЫН САЙН ТУРШЛАГА СОЛИЛЦОХ, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ ХҮРЭЭНД:

#### Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудын нэгдсэн, портал khural.mn цахим хуудас

Бүхшатны иргэдийн төлөөлөгчдийн хурлын мэдээлэл, мэдлэг, туршлагыг хуваалцах, хурлын үйл ажиллагааны ил тод байдлыг өргөжүүлэх зорилгоор www.khural.mn вэб хуудсыг 2014 онд нээсэн. 2015 он гэхэд ихэнх иргэдийн төлөөлөгчдийн хурлын хувьд цахим хуудсаар дамжуулан бие биенээсээ суралцах, дэд цахим хуудсаа шинэчлэх нь өдөр тутмын үйл ажиллагаа болсон бөгөөд үүнийг цахим хуудсанд хийсэн хандалтын тоо, байршуулсан хэвлэлийн статистик мэдээ нотолж байна.

2016 оны 6 дугаар сарын байдлаар 365 дэд цахим хуудсанд нийтдээ 25,387 мэдээ мэдээлэл нийтлэгдэж, 7,284,992 хандалт хүлээн авсан байна. Мөн олон ИТХ -ыншийдвэр, тогтоолыг цахим хуудсандаа байршуулдаг уламжлал тогтоод байгаа нь ил тод байдлыг өргөжүүлэх анхны үндсэн зорилтдоо хүрсэн гэж хэлж болно.

#### Орон нутгийн засаглалын асуудлаар хүндэсний чуулганууд

Нутгийн өөрөө удирдах байгууллагыг чадваржуулах, төвлөрлийг сааруулах талаар 2015 онд хийсэн гол бодлогын сурталчилгааны ажлын нэг бол Нутгийн удирдлага: Тулгарч буй сорилт, шийдэл сэдвээр зохиогдсон Үндэсний чуулган юм.

Ерөнхийлөгчийн Тамгын газар, УИХ-ын Тамгын Газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, нийслэлийн ИТХ-ын Тамгын газар, МНУХ-той хамтран зохион байгуулсан тус чуулганд аймаг, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, иргэдийн төлөөлөгчдийн хурлын Нарийн бичгийн дарга, нутгийн удирдлагын асуудлаар ажилладаг төрийн бус байгууллага болон эрдэм шинжилгээ, сургалтын байгууллагын төлөөлөл бүхий 200 гаруй төлөөлөгчид оролцсон.

Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дэд дарга, ЗГХЭГ-ын дарга, Ховд аймгийн Засаг дарга болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Суурин төлөөлөгч нар чуулганыг нээж үг хэлсэн. Тэд хэлсэн үгэндээ орон нутгийн засаг захиргааны өмнө тулгарч буй гол сорилтыг олон талаас нь онцлон тэмдэглэсэн юм. Үндэсний мэргэжилтнүүд 5 үндсэн баримт бичиг болон холбогдох илтгэлийг тавьж хэлэлцүүлсэн. Үүнд:

- Нутгийн удирдлагын тогтолцоо: тэнцвэр, хяналт;
- Орон нутгийн чиг үүргийн хуваарь;
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж;

- Орон нутгийн өмчийн харилцаа;
- Нутгийн удирдлагын эрхзүйн орчин.

Үндэсний Чуулганы үеэр өргөн хүрээтэй бодлогын олон асуудлыг хөндөж хэлэлцүүлсэн. Төвлөрлийг сааруулах талаар ахиц, дэвшил гарахгүй байгаа, засаг захиргааны үйл ажиллагааны үр ашгийг улам нэмэгдүүлэхийн тулд нутаг дэвсгэрийн шинэчлэл хийх шаардлагатайг, чиг үүрэг, өмчийн эрх, татвар тогтоох эрх мэдлийн хуваарилалт, засаг захиргааны доод түвшин рүү эрх мэдэл шилжүүлэх хуулийн заалт байгаа ч хэрэгжихгүй байгаа тухай, чиг үүрэг, эрх мэдэл, мандат болон хариуцлагын талаар хуулийн нэр томъёог нэгдсэн болгох шаардлага байгаа нь хуулийн заалтуудын ойлгомжгүй байдлаас харж болохыг чуулганд оролцогчид дурьдаж байсан. Судлаачдаас тавьсан асуудлыг баяжуулсан олон тохиолдлыг аймаг, орон нутгийн оролцогчид дурьдаж байлаа. Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн тухай саналыг Чуулганы үеэр мөн хэлэлцсэн.

Хамтын хүч - Нутгийн хөгжил” чуулганыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Монголын баг, сумдын холбоотой хамтран иргэдийн бүлэг, баг, хороо, тосгоны хамтын ажиллагааны сайн туршлагаудыг түгээн дэлгэрүүлэх, тэдний сайн дурын мөнгөн хуримтлалын сангийн үйл ажиллагааг дэмжин өргөжүүлэх, эрх зүйн хувьд баталгаажуулах арга зүйгээр хангах зорилгоор 2016 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулав.

Чуулганд УИХ, Засгийн газрын гишүүд, нутгийн удирдлагын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөлөл, энэ салбарын эрдэмтэн судлаачид “Нутгийн удирдлага, хөгжлийн эрх зүйн орчинг сайжруулах тухай”, “Хамтын хүчний давуу талыг бэхжүүлэх гарц, боломжууд”, “Сайн туршлагауд” гэсэн гурван үндсэн хэсэгт илтгэл, хэлэлцүүлэг өрнүүлэв.

Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх, сонгуульд нэр дэвшүүлэхэд эмэгтэйчүүдийн шударга төлөөллийг хангахад улс төрийн намуудын сайн дурын алхам, хүсэл зоригийг нэмэгдүүлэх зорилготой “Нутгийн удирдлагад эмэгтэйчүүдийн манлайлал” чуулганыг УИХ-ын эмэгтэй гишүүд, Канадын Гадаад хэргийн яамны санхүүжилттэй Олон улсын Бүгд найрамдахчуудын хүрээлэнгийн хэрэгжүүлж буй “Сонгуульд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төсөлтэй хамтран 2016 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр зохион байгуулав.

Чуулганд нийт 530 гаруй улс төрч эмэгтэйчүүд оролцсоноос УИХ-ын гишүүн 9, ИТХ-ын төлөөлөгч 397, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл 48, олон улсын байгууллагын төлөөлөл 27 байв.

Чуулганд УИХ-ын гишүүн, ИТХ-ын төлөөлөгч, төрийн бус болон олон улсын байгууллагын төлөөлөл эмэгтэйчүүд “Улс төрийн дээд түвшинд шийдвэр гаргахад эмэгтэйчүүдийн оролцоо”, “Орон нутгийн түвшинд шийдвэр гаргахад эмэгтэйчүүдийн оролцоо”, “Монголын нийгэмд эмэгтэйчүүдийн манлайлал”, “Эмэгтэйчүүдийг улс төрийн карьерт бэлдэх нь” салбар хуралдааны хүрээнд илтгэл тавьж хэлэлцүүлэв.

Шийдвэр гаргах бүх шатны төлөөлөл болсон эмэгтэйчүүд цуглан, улс төрийн намын ялгаваргүйгээр харилцан туршлага солилцож, бие биенээ дэмжин ажиллахаа илэрхийлсэн нь тэдний урам зоригийг сэргээж урамшуулсан чухал арга хэмжээ болсныг чуулганд оролцогсод онцолж байв.

#### Иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүсийн чуулган

Бүсийн чуулган нь хөрш зэргэлдээ аймгуудын иргэдийн төлөөлөгчдийн хурлууд цуглан тулгарч буй нийтлэг бэрхшээл болон боломжийн тухай ярилцах, туршлагаа хуваалцах,

бие биенээсээс уралцах, нийтлэг сонирхсон асуудлаар зөвшилцөлд хүрэх механизм болж байдаг. Нутгийн өөрөө удирдах байгууллагыг төлөөлөх, ашиг сонирхлыг нь хамгаалах албан ёсны биедаасан толгой байгууллага байхгүй нөхцөлд бүсийн чуулган нь хэвтэй хамтын ажиллагаа, сургалтын үүргийг гүйцэтгэж, УИХ -ын гишүүдтэй харилцах гүүр болж байна.

Хангай, Төв, Зүүн болон Баруун гэсэн 4 бүсийн чуулганыг зохион байгуулсан. Бүсийн чуулганд УИХ-ын гишүүд оролцсон. ЗЗНДНТУТХ -ийг шинэчлэх гэж байгаатай холбогдон 3 бүсийн чуулганы хэлэлцэх гол асуудлаар ЗЗНДНТУТХ болон орон нутгийн сонгуулийн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн талаар зонхилон хэлэлцсэн.

Бүсийн чуулгануудын нэг чухал сургамж бол чуулганы бүтэц зохион байгуулалтыг сайжруулах, өмнөх чуулганы үеэр ярилцсан асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэх, хэлэлцэх асуудлыг тусгайлан сэдэвчлэх, зохион байгуулагч иргэдийн төлөөлөгчдийн хурлаас тавьж буй илтгэл, тайланг сайжруулах явдал болно.

#### Засаг захиргаа нутаг, дэвсгэр түүний удирдлагын тухай хууль (ЗЗНДНТУТХ) -ийн шинэчилсэн найруулга

УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо, Орон нутгийн засаглалын Дэд хорооны удирдлаган дор ЗЗНДНТУТХ-д оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулах хуульчдын багийг төслөөс гэрээлэн ажиллуулсан.

Орон нутгийн засаг захиргаан дахь улстөржилт, мөн шүүхээр шийдвэрлэх шатанд хуулийн зарим заалт, ялангуяа Засаг даргыг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх тухай заалтууд хоёрдмол утгаар тайлбарлагдаж байгааг засч сайжруулах үүрэгтэйгээр энэхүү хуулийн баг ажилласан. Энэ зорилгоор захиргааны хэргийн шүүх дээрбайгаа бүх хэргийн материалыг цуглуулан шинжилсэн.

Төслөөс зохион байгуулсан бүсийн сургалтанд хуульчдын баг оролцож, ИТХ-ын төлөөлөгчдийн саналыг цуглуулсан. ЗЗНДНТУТХ -д оруулах нэмэлт, өөрчлөлтийн хуулийн төслийг эцэслэн боловсруулж захирах, захирагдах зарчим, бүх шатны засаг захиргааны чиг үүргийн хуваарь зэрэг нэмэлт өөрчлөлтийг тусгаж өгсөн. Хуулийн төслийг УИХ-ын гишүүдээс өргөн барихаар төлөвлөж байна.

#### **С. ‘ЦАХИМ ПАРЛАМЕНТ’ ТӨСӨЛ**

2014 онд Улсын Их Хурлын Тамгын газар, Солонгосын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /КОИКА/ -тай хамтран БНСУ -ын Засгийн газрын 3.5 сая ам.долларын буцалтгүй тусламжаар “Цахимпарламент” төслийг амжилттай хэрэгжүүлсэн.

Энэ төслийн хүрээнд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхим болон Байнгын хороодын хуралдааны танхимуудад техник технологийн орчин үеийн ололтыг тусгасан программ хангамж, дуу, дүрсний систем бүхий хуралдааны иж бүрэн цахим системийг шинээр суурилуулсан. Тухайлбал, чуулганы нэгдсэн хуралдаан болон Байнгын хороодын хуралдаанд ашиглах Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуульд бүрэн нийцсэн программ хангамж, техникийн өндөр үзүүлэлт бүхий тоон системийн нийт 16 ширхэг камер, чадлын өсгөгч бүхий 18 ширхэг чанга яригч, дэлхийн олон орны парламентад ашиглагддаг 230 ширхэг микрофонт гар, 5 танхимын дуу, дүрсний удирдлагын систем, хуралдааны бие даасан сүлжээ, нөөцлөх төхөөрөмжүүд болон дагалдах техник хэрэгслүүд суурилагдаад байна.

Үүний үр дүнд нэгдсэн хуралдаанд төдийгүй Байнгын хороодын хуралдаанд цахим системийг ашиглах боломж бүрдлээ. Мөн хуралдааны бүх танхимуудын дуу, дүрсний сигналыг өндөр чанартайгаар хүлээн авч бичлэг хийх боломжтой парламентын сэтгүүлчдийн өрөөг шинэчлэн тохижуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглон, хууль тогтоох үйл ажиллагааны мэдээ мэдээллийг иргэд сонгогчид, олон нийтэд шуурхай түгээх боломжийг бүрдүүлсэн. Хуралдааны танхимуудын дуу дүрсийг нэг цэгээс хүлээн авч тэдгээрээс сонгон бичлэг хийхэд шаардлагатай техник хэрэгслүүдийг олон улсын жишигт нийцүүлэн суурилуулсан.

\* \* \*



**УИХ -ЫН ТАМГЫН ГАЗРЫН АХМАДЫН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА (2012.VI. – 2016.VI.)**

Тойм мэдээллийг Ахмадын хорооны дарга  
Ш. Ринчингийн бэлтгэсэнээр оруулав.

**1. Тамгын газрын ахмадын байгууллагын үүсэл**

1990 оны 12 дугаар сарын 03 -ны өдөр Улсын Бага Хурлын Зохион байгуулалтын хэлтсийн дарга Л. Хангай Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн газарт ажиллаж байсан зарим ахмад ажилтнуудыг хүлээн авч уулзсан байна. Энэ уулзалтад төр нийгмийн нэрт зүтгэлтэн С.Удвал, Ц.Готов, АИХ -ын Тэргүүлэгчдийн ахмад ажилтан Г.Адъяа, А.Содномбалжир, Б.Бэгзсүрэн, Ч.Бавуу, Г.Мандах нар оролцож, ахмад настны талаар анхаарах асуудлаар санал солилцож, УБХ -ын Тамгын газрын дэргэд Ахмадын зөвлөл байгуулах нь зүйтэй гэж үзэж, даргаар нь УБХ-ын Тамгын газрын Зохион байгуулалтын хэлтсийн орлогч, боловсон хүчний эрхлэгч Ч.Бавууг ажиллуулахаар сонгожээ.

1992 онд УБХ -ын үйл ажиллагаа дуусгавар болсноор тэнд харьяалагдаж байсан ахмад настнууд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, УИХ -ын Тамгын газарт хуваагдан харьяалагдах болсон. Ийнхүү УИХ -ын Тамгын газрын дэргэдэх Ахмадын байгууллага анх АИХ -ын Тэргүүлэгчдийн газарт ажиллаж байсан ахмад настан Ц.Готов, С.Батаа, А.Содномбалжир, Д.Чадраа, Т.Цэрэндорж, Ц.Тэрбиш, С.Гомбодоо, Б.Бэгзсүрэн, Ё.Доржпагма нарын 10 гаруй ахмадтайгаар байгуулагдаж, Ахмадын зөвлөлийн даргаар УИХ -ын ахмад ажилтан Чогсомын Бавуу 2005 он хүртэл ажилласан юм. Эдүгэ Ахмадын хорооны дарга (орон тооны бус) -аар төр, захиргааны ахмад ажилтан Ш.Ринчин 12 дахь жилдээ ажиллаж байна.

**2. Ахмадын байгууллагын бүтэц, бүрэлдэхүүн**

УИХ -ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын “Журам тогтоох тухай” 2005 оны 39 тоот захирамжид өндөр насны тэтгэврээ хууль тогтоомжийн дагуу тогтоолгосон /УИХ -ын гишүүн болон Тамгын газар, нам, эвслийн бүлгийн ажлын албанд ажиллаж байсан/ ажилтнуудыг бичгээр гаргасан хүсэлтийнх нь дагуу Тамгын газрын ахмад настны бүрэлдэхүүнд авч, Тамгын газрын ахмад настанд тооцож байхаар заасан. Одоо УИХ -ын Тамгын газрын Ахмадын хороонд 65 ахмад настан /эрэгтэй 38, эмэгтэй 27/ харьяалагдаж байна. Насны хувьд 70 хүртэл настан 50 хувь, 70 - 80 насны ахмад 38 хувийг эзэлж байна.

Эдгээр ахмад настны 37 хувь нь УБХ, УИХ -ын гишүүн, АИХ -ын депутат, төрийн сайдаар ажиллаж байсан хүмүүс юм. Тухайлбал: Монгол Улсын Баатар, Сансрын нисэгч Ж.Гүррагчаа, Хөдөлмөрийн баатар, Соёлын гавьяат зүтгэлтэн Г.Очирбат, Хөдөлмөрийн баатар, алдарт оёдолчин Ц.Амгалан, Ардын багш Ч.Авдай, Гавьяат агрономич Ц.Өөлд, Малын гавьяат эмч Ч.Дашдэмбэрэл, Худалдааны гавьяат ажилтан А.Шагдарсүрэн, Гавьяат тээвэрчин Р.Сандалхан, Гавьяат багш Ш.Бадам, Д.Ламжав, Гавьяат эдийн засагч Ч.Улаан, Ж.Гомбожав, Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан Д.Мөнхөө, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн Н.Тогтох, Соёлын гавьяат зүтгэлтэн Л.Одончимэд, УБХ -ын гишүүн асан П.Бямбацэрэн, Р.Хатанбаатар, УБХ, УИХ -ын гишүүн асан С.Чулуунбаатар, Ц.Товуусүрэн, УИХ -ын гишүүн асан Н.Гэрэлсүрэн, Ё.Адилбиш, Г.Цэдэндагва нарын зэрэг үе үеийн парламентын гишүүн, нийгмийн зүтгэлтэн ахмадууд харьяалагдаж байна.

**3. Ахмад настнаар бүртгэх журам**

“Журам тогтоох тухай” Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн

даргын 2005 оны 39 дүгээр захирамжид зааснаар өндөр насны тэтгэврээ хууль тогтоомжийн дагуу тогтоолгосон ажилтнуудыг дор дурдсан тохиолдолд өөрсдийнх нь бичгээр гаргасан хүсэлтийн дагуу ахмад настны бүртгэлд авч, Тамгын газрын ахмад настанд тооцож байхаар заажээ.Үүнд:

- УИХ -ын гишүүнээр ажиллаж байгаад бүрэн эрхийн хугацаа нь дуусмагц дараагийн ажил албанд томилогдолгүй өндөр насны тэтгэврээ тогтоолгосон гишүүд,
- Тамгын газарт ажиллаж байгаад өндөр насны тэтгэврээ тогтоолгосон ахмадууд,
- УИХ дахь нам, эвслийн бүлгийн ажлын албанд ажиллаж байгаад өндөр насны тэтгэврээ тогтоолгосон ажилтнууд.
- Дээрх 3 тохиолдолд ажиллаж байх үедээ групп тогтоолгоод, группийн хугацаа дуусмагц үргэлжлүүлж өндөр насны тэтгэврээ тогтоолгосон ажилтнууд.

4. Тамгын газар, Ахмадын хорооноос ахмад настны дунд зохион байгуулж буй ажлын хэлбэр

Улсын Их Хурал, Тамгын газар ахмад настан, ахмадын байгууллагаа байнга дэмжиж бүх талын туслалцаа дэмжлэг үзүүлж ирсэн. Монголын Ахмадын Холбоо Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлж, ахмад буурлууддаа байнга анхаарал халамж тавьж, нэмэгдэл тэтгэврээ тогтоох, мөнгөн тусламж, тэтгэмж олгож ахуй амьдралыг нь тэтгэх, чөлөөт цагийг нь ая тухтай өнгөрүүлэх, эмчилгээ сувилгаа, амралт аялалд хамруулах зэрэг олон талын ажиллагааг тогтмолжуулж, ахмадын сангийн үйл ажиллагааг идэвхжүүлж байгааг нь үнэлж 2013 онд УИХ -ын Тамгын газарт “Ахмадад ээлтэй байгууллага” хүндэт өргөмжлөл гардуулсан юм.

Монголын ахмадын холбооны Ерөнхийлөгч УИХ -ын гишүүн асан Ц.Сүхбаатар уг хүндэт өргөмжлөл гардуулах үеэр ... “Тамгын газрын ахмадын хороо нь бусад төрийн байгууллагад үлгэр дуурайл болохуйцаар ажилладгийг онцлон тэмдэглэж, яамд, төрийн байгууллагын дэргэдэх ахмадын хороодын төлөөллийг Тамгын газрын Ахмадын хорооны ажлын туршлагатай танилцуулах ажлыг хоёр тал хамтран зохион байгуулахыг санал болгосон. 2014 оны 3 дугаар сард болсон Монголын Ахмадын Холбооны төв, орон нутгийн удирдах ажилтны зөвлөгөөний хөтөлбөрийн дагуу УИХ -ын Тамгын газрын Ахмадын хороо “Зохион байгуулж буй ажлын зарим арга хэлбэр” сэдвээр мэдээлэл хийсэн.

Ахмадын хороо юуны өмнө УИХ, Засгийн газар болон ахмадын төв байгууллагаас ахмад настны асуудлаар гаргаж буй хууль, тогтоол, зөвлөмж шийдвэрийг ахмадуудад хүргэж сурталчлах, улмаар хэрэгжүүлэх ажлыг ахмадуудынхаа санал санаачилга, оролцоонд тулгуурлан зохион байгуулж байна. Энэ зорилгоор төр, засгаас ахмад настны асуудлаар гарч буй бодлого, шийдвэр болон ахмад настны аж байдлыг дээшлүүлэх, эрүүл мэндийг нь хамгаалахад туслах, түүнчлэн ахмадын хорооноос зохион байгуулсан ажлын тухай мэдээллийг багтаасан “Ахмадуудад зориулсан гарын авлага” эмхэтгэлийг жил бүр 1 - 2 дугаарыг бэлтгэн хүргэж байна.

УИХ -ын даргын 2007 оны захирамжаар баталсан “Ахмадын сан” -гийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэж, уг дүрмийн төслийг холбогдох хэлтэс, ажилтнуудтай хамтран боловсруулж УИХ -ын даргын 2013 оны 105 тоот захирамжаар УИХ -ын “Ахмадын сан”-гийн дүрмийг шинэчлэн батлуулсан. Ингэснээр ахмад настанд байгууллагаас үзүүлэх тусламж, дэмжлэгийн хүрээг үлэмж өргөтгөсөн.



УИХ, Тамгын газрын удирдлагууд билгийн тооллын хаврын тэргүүн сар- Цагаан сарын шинийн нэгэн болон Монголын ахмадын өдрийг тохиолдуулан нийт ахмад настнуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүлж, тэдний санал хүсэлтийг сонсож байна. Түүнчлэн Тамгын газар Ахмадын хороо Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойг тохиолдуулан улсын болон хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтноос бусад ахмадуудаа, мөн Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ахмад настан эмэгтэйчүүдээ хүлээн авч, хүндэтгэл үзүүлэх ажил хэвшлээ.

Ахмад настнуудынхаа 60, 70, 80 насны ойг тохиолдуулан баяр хүргэж, дурсгалын зүйл гардуулдаг уламжлал тогтож, 2012 - 2015 онд насны ой нь тохиосон 27 ахмад настанд хүндэтгэл үзүүлсэн байна. Ахмадын хороо ахмад настнууд хөдөлмөр, бүтээлээ төр, нийгэмдээ хэрхэн үнэлүүлж ирсэн байдалд судалгаа хийсэн үндсэн дээр тэднийг төрийн дээд алдар цол, одон медалиар шагнуулахаар тодорхойлох ажлыг 2006 оноос эхлэн санаачлан ажиллаж байна. 2012 -2015 онд Ахмадын хорооны боловсруулсан санал, тодорхойлолтын дагуу төрийн дээд шагналаар тодорхойлсон ахмадуудаас Гавьяат цолоор 1, “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон” -гоор 9, “Алтан гадас одон” -гоор 3 ахмад настан шагнуулсан байна.

Ахмад настан С.Батаа /одоо 87 настай/ 50 гаруй жилийн өмнө Баянхонгор аймагт ажиллаж байхдаа “Бүгийн цав” хэмээх газар үлэг гүрвэлийн томоохон орд байж болохыг үзэж, ШУА -д мэдээлснээр эрдэмтдийн баг шуурхай ажиллаж, энэ орд нь палентологийн салбарт онцгой ач холбогдол бүхий шинэ орд байгааг тодорхойлжээ.

Ахмадын хороо уг асуудлаар холбогдох баримт материалыг бүрдүүлж 2014 онд ССАЖЯ -нд хүргүүлснээр тус яамнаас ахмад настан С.Батааг “Соёлын тэргүүний ажилтан” цол, тэмдгээр шагнаж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчилсан. Соёлынхоо өвийг хадгалж хамгаалахад үлгэр дуурайл болсон энэ асуудлаар УИХ -ын Тамгын газар төрийн одонгоор шагнуулахаар тодорхойлж “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон” -гоор шагнуулсан юм.

Монголын ахмадын өдрийг тохиолдуулан зохион байгуулдаг идэвхтэй амралт - аялал нь ахмад настны хүсэн хүлээдэг арга хэмжээний нэг болсон. 2012 онд Дорноговь аймаг “Д.Равжаа хутагтын музей”, “Хамрын хийд”-ийн чиглэлд; 2013 онд Буриад Улсын Улаан-Үд хот, Иволгин дацан /Итгэлт хамбын цогцолбор/ -тай танилцах аялал; 2014 онд “Чингис хааны хөшөөт цогцолбор”, XIII зуун үндэсний парк”-тай танилцаж, “Ар жанчивлан” рашаан сувилалд амрах аялал - амралт; 2015 онд УБТЗ -ын “Баянбуурал” амралтад амрах ажиллагааг зохиож, давхардсан тоогоор 120 гаруй ахмад настан оролцсон. “Ар жанчивлан” рашаан сувилалд амрах үеэр сувиллын ажиллагсад, амрагчдын дунд УБХ, УИХ -ын үйл ажиллагааг сурталчлах уулзалт үдэшлэг зохион байгуулж, тусгай бэлтгэсэн асуудлаар асуулт- хариултын тэмцээн явуулж, шалгарсан хүмүүст дурсгалын зүйл гардуулсан юм.

Энэ хугацаанд Ахмадын хороо “Ахмадын өдрийг тохиолдуулан зохион байгуулах ажлын тухай”, “УБХ, УИХ -ын гишүүн асан ахмад настан болон Тамгын газрын ахмад ажилтнууд, тэдгээрийн гэр бүлийн эмнэлгийн үйлчилгээний тухай”, “Ахмад настанд хүндэтгэл үзүүлэх журам”, “Ахмад мэргэжилтний баг ажиллуулах тухай”, “Зарим ахмад настанд тусламж үзүүлэх тухай”, “Парламентын тэмдэглэлт ой угтаж зохиох ажлын тухай” зэрэг асуудлаар санал боловсруулан Тамгын газрын удирдлагад танилцуулж тухай бүр зөвлөмж дэмжлэг авч ажилласан байна.

Улсын Их Хурал, Тамгын газрын удирдлага ахмад настнууддаа онцгой анхаарал тавьж байдгийн нэг жишээ бол парламентын түүхэн хөгжилтэй холбоотой асуудалд Ахмадын

хороо, ахмад ажилтнуудынхаа санал, оролцоог авч байдаг явдал юм. Тухайлбал, Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны тэмдэглэлт ой болон ардчилсан Үндсэн хуулийн ойг тэмдэглэх ажлын комиссын бүрэлдэхүүнд Ахмадын хорооны даргыг оруулж, тодорхой ажил хариуцуулдаг юм.



**Улсын Их Хурал, УИХ -ын Тамгын газрын удирдагууд тус байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудын хамт**

2015 онд тэмдэглэсэн Парламентын 25 жилийн ойг угтсан ажиллагаанд ахмадууд идэвхитэй оролцсон. Ахмад настан Ц.Товуусүрэн “Улсын Бага Хурал 1990 - 1992” номын зохиогчоор, Л.Одончимэд “Найргийн хуртай Монгол парламент” номын редактораар, Ч.Сэндэнпүрэв “Монгол Улсын парламент III, IV боть” бэлтгэх ажлыг тус тус гүйцэтгэв.

Уг ойн үеэр зохион байгуулсан “Төрийн түшээдийн уран бүтээл /ном/ -ийн үзэсгэлэн” -д 18 ахмад настан өөрсдийн бүтээлээр оролцож, УИХ -ын номын сангийн фондыг 50 гаруй номоор баяжуулж, “Парламент 25 жил” гэрэл зургийн үзэсгэлэнд 12 ахмад настан 40 гаруй гэрэл зургаа архивын фондод оруулсан байна. Мөн “Найргийн хуртай Монгол парламент” номд төрийн түшээ 51 хүний 100 -гаад бүтээл нийтлэгдсэний дотор манай ахмад настан 9 хүний 20 гаруй бүтээл багтсан юм.

Ахмад настан удаан хугацаагаар өвчилж, өндөр өртөг бүхий оношилгоо эмчилгээ, мэс засал хийлгэх, эм тариа худалдан авах үед нь нэг удаагийн буцалтгүй тусламж олгох, галлагаатай орон сууцанд амьдардаг ахмад настанд түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт үзүүлэх ... зэргээр УИХ -ын Тамгын газраас тус хорооны үйл ажиллагааг бодитойгоор дэмжиж ирсэн юм.



Өнгөрсөн 4 жил (2012-2016) -ийн хугацаанд, нэг удаагийн буцалтгүй тусламж, түлээ нүүрсний хөнгөлөлт, бэлэг дурсгалын зүйл гардуулах, эмчилгээний зардал олгох, нэмэгдэл тэтгэмжийг олгоход УИХ -ын Тамгын газраас нийт 72,6 сая төг. зарцуулжээ.

\* \* \*



**ПАРЛАМЕНТЧДЫН ШАДАР ТУСЛАХУУДЫН ХОЛБОО (ТББ)**

Парламентчдын шадар туслахуудын холбоо нь 2008 онд байгуулагдсан. Тус холбоо нь Хүндэт ерөнхийлөгч, тэргүүн, Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл, нарийн бичгийн даргаас бүрддэг. Холбоо нь хуулийн дагуу байгуулагдсан, гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага бөгөөд Улсын Их Хурлын гишүүдийн зөвлөх, туслах, бие-төлөөлөгчдөөс бүрдсэн 200 гаруй гишүүнтэй. Тус холбооны эрхэм зорилго нь гишүүдийнхээ нийтлэг эрх ашгийг хамгаалж, мэдлэг чадварыг дээшлүүлэхэд дэмжпэг үзүүлж, тэдгээрийн хамтын ажиллагааг бэхжүүлэхэд оршино.

2008 - 2012 онд Парламентын шадар туслахуудын холбооны Хүндэт Ерөнхийлөгчөөр Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Шаравдорж ажиллаж байсан бол 2012 - 2016 онд Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар ажиллаж байна. Холбооны тэргүүнээр:

- 2012 - 2013 онд Гантөмөрийн Мөнх-Очир (Улсын Их Хурлын гишүүн О.Содбилэгийн туслах)
- 2013 - 2014 онд Батдэлгэрийн Цогт (Улсын Их Хурлын гишүүн Р.Бурмаагийн туслах)
- 2014 - 2015 онд Жаргалсайханы Жамбалдагва (Улсын Их Хурлын гишүүн Д.Хаянхярваагийн туслах, өөр ажилд шилжсэн) нар ажиллаж ирсэн.
- 2015 оны 04 дүгээр сараас Батсуурийн Гантуяа (Улсын Их Хурлын гишүүн Н.Батбаярын туслах) сонгогдон ажиллаж байна.

Холбоо нь гадаад, дотоодын байгууллагуудтай хамтран ажиллаж сургалт, эрдэм шинжилгээ, урлаг соёл, спортын олон талт үйл ажиллагаа явуулах, гишүүдээ ажил, мэргэжлийн холбогдолтой мэдээ, мэдээллээр хангах, чөлөөт цагийг нь үр бүтээлтэй өнгөрүүлэх ... зэрэг бусад олон чиглэлээр ажилладаг.

\* \* \*

**УИХ -ын Тамгын газрын [орон тооны бус] Спортын зөвлөлийн үйл ажиллагаанаас ...****УИХ -ын Тамгын газрын Биеийн тамир, спортын зөвлөл**

Улсын Их Хурлын Тамгын газрын Биеийн тамир, спортын зөвлөлийг 2010 онд байгуулж, зөвлөлийн анхны даргаар Судалгаа, шинжилгээний төвийн референт Н.Түвшинтөгс ажиллаж байв. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2013 онд шинэчилж, зөвлөлийн даргаар Гадаад харилцааны хэлтсийн дарга Ц.Нарантунгалаг ажиллаж байна. Тус зөвлөл нь 8 гишүүнтэй.

Биеийн тамир, спортын зөвлөл нь Тамгын газар, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны ажилтнууд, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, туслах, бие төлөөлөгч - туслахуудыг хамруулан жил бүр биеийн тамир, спортын нийтийг хамарсан арга хэмжээ / явган аялал, цасны баяр, сагсан бөмбөгийн тэмцээн, ажлын байрны дасгал, ажилтнуудын бие бялдрын хөгжил чийрэгжилтын түвшин тогтоох сорил зэрэг/ зохион байгуулах төлөвлөгөө боловсруулж Ерөнхий нарийн бичгийн даргаар батлуулан улирал бүр зохион байгуулж, ажилтнуудыг татан оролцуулж бүрэн хамруулах арга хэмжээ авч байна. Мөн бусад байгууллагаас зохион байгуулдаг уламжлалт тэмцээн, уралдаанд оролцох, бэлтгэл сургуулилт хийлгэх ажлыг хариуцан зохион байгуулж амжилттай оролцож ирсэн билээ. Түүнчлэн ажилтнуудын амралт, чөлөөт цагийг зөв зохистой, идэвхтэй өнгөрүүлэхэд анхаарч сургууль болон байгууллагуудтай спорт заалны гэрээ байгуулан ажиллаж 7 хоногийн 1 өдөрт спортын зарим төрлөөр хичээллэн бэлтгэл сургуулилт хийдэг болов.

Улсын Их Хурлын Тамгын газраас Улсын Их Хурлын гишүүд, тэдний зөвлөх, туслах, бие

төлөөлөгч-туслах, Тамгын газар, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, бие бялдрыг чийрэгжүүлэх, хөгжүүлэх, нийтийн биеийн тамир болон спортын төрлүүдээр хичээллүүлэх зорилгоор “Бялдаржуулах танхим”-ыг байгуулж, 2008 оны 3 дугаар сарын 7-ноос үйл ажиллагааг нь эхлүүлсэн.

Бялдаржуулах танхим нь нийт 11 төрлийн 25 ширхэг техник, тоног төхөөрөмжтэй, нэг ээлжинд 20 - 25 хүн хүлээн авч үйлчлэх боломжтойн зэрэгцээ хувцас солих өрөө, шүршүүр, ширээ, сандал зэргээр тохижуулж, бэлтгэл сургуулилт хийх таатай орчин бүрдүүлэн ажиллаж байна.

Мөн 2015 оны нэгдүгээр улиралд сүүлийн үеийн 16 төрлийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр шинэчлэн тохижуулсан. Тус танхимаар өдөрт дунджаар 10 - 23 үйлчлүүлэгч хоёр ээлжээр үйлчлүүлэн хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлж, бие бялдраа хөгжүүлж, бэлтгэл сургуулилт болон дасгал хөдөлгөөнд хамрагдаж байна. Мөн 2013 оноос хойш ажилтнуудын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг жил бүр авч үнэлэлт, дүгнэлт өгч байна.

#### Спортын уламжлалт тэмцээний зарим амжилтууд:

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын баг тамирчид спортын дээрх уралдаан, тэмцээнд байнга идэвхтэй оролцож, амжилт гаргаж ирсэн уламжлалтай.

- Монгол Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудын дунд шилжин явах цомын төлөөх спортын 5 төрлийн тэмцээнийг анх 2010 онд Авлигатай тэмцэх газраас анх санаачилсан. Жил ирэх тусам өргөжин одоо спортын 7 төрлөөр уламжлал болгон зохион зохион байгуулж байгаа уг тэмцээнд Улсын Их Хурлын Тамгын газрын баг тамирчид сагсан бөмбөг, волейбол, хөлбөмбөг, шатрын төрөлд тогтмол 1-3 дугаар байр, ширээний теннис, биллиард, дартсын төрөлд II-Ү байрт шалгарч, 2014 онд шилжин явах цом хүртсэн.
- “Засгийн газрын цом”-ын тэмцээн:  
Эрүүл мэндийн яам байгуулагдсаны 80 жилийн ойг угтсан “Засгийн газрын цом - 2010” сагсан бөмбөгийн тэмцээний эрэгтэй, эмэгтэй төрөлд М байр эзэлж, байгууллагын нэгдсэн дүнгээр I байрт шалгаран Өргөмжлөл хүртсэн.
- Сангийн яам байгуулагдсаны болон санхүү, эдийн засгийн алба үүсч хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд зохиогдсон “Засгийн газрын цом - 2011” сагсан бөмбөгийн тэмцээний эрэгтэй төрөлд III байрт шалгарсан.
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны нэрэмжит “Засгийн газрын цом - 2012” сагсан бөмбөгийн тэмцээний эрэгтэй төрөлд III байр эзэлсэн.
- Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны нэрэмжит “Засгийн газрын цом - 2013” спортын 4 төрлийн тэмцээнд сагсан бөмбөг: эмэгтэй II, эрэгтэй IV, волейбол: эрэгтэй II, эмэгтэй I, шатар: эрэгтэй I, эмэгтэй IV, ширээний теннис: эрэгтэй IV, эмэгтэй II байр тус тус эзэлж, байгууллагын нэгдсэн дүнгээр “Шилжин явах цом”, өргөмжлөл хүртсэн
- Батлан хамгаалах яамны нэрэмжит Засгийн газрын цом - 2014 спортын 4 төрлийн тэмцээнд сагсан бөмбөг: эрэгтэй I, волейбол: эрэгтэй II, эмэгтэй I, шатар: эрэгтэй I, эмэгтэй V, ширээний теннис: эрэгтэй V, эмэгтэй I байр эзэлж, байгууллагын нэгдсэн дүнгээр “Шилжин явах цом”, өргөмжлөл хүртсэн.
- Хуулийн төв байгууллагуудын спортын 5 төрлийн тэмцээн 2014 онд сагсан бөмбөг: эрэгтэй II, эмэгтэй I, волейбол: холимог төрөлд III, шатрын багийн төрөлд I, ширээний

теннис: эрэгтэй IV, эмэгтэй II, багийн төрөлд II байр, биллиард: эрэгтэй III, эмэгтэй IV, багийн төрөлд III байр тус тус эзэлж, байгууллагын дүнгээр “Шилжин явах цом”, өргөмжлөлөөр шагнагдсан.

- Төрийн ордонд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын дунд жил бүр уламжлал болж зохиогддог сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээний эмэгтэй төрөлд 2008 оноос хойш таван удаа I байрт шалгарсан бол 2014 онд волейболын төрөлд тэргүүлж “Шилжин явах цом” хүртсэн. Харин эрэгтэй баг 2013 онд түрүүлж, бусад хугацаанд II-III байр эзэлж ирсэн.
- Төрийн тусгай хамгаалалтын газрын нэрэмжит хөлбөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн 2008, 2009 онд тэргүүлж шилжин явах цом хүртсэн бол 2010 онд III, 2014 онд I байрт шалгарсан.
- Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ойн хүрээнд 2014 онд гадаад улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамд, олон улсын байгууллагуудын дунд зохиогдсон хөлбөмбөгийн нөхөрсөг тэмцээнд түрүүлж, шилжин явах цом, өргөмжлөл хүртсэн.
- Монголын дартсын холбооны 20 жилийн ой, Монгол Улс, Их Британи Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын төрийн байгууллагууд, Монгол Улсад суугаа гадаадын дипломат төлөөлөгчийн газруудын хооронд 2014 онд зохиогдсон “Зэв” дартсын шилжин явах цомын тэмцээнд 1 дүгээр байр эзэлж, шилжин явах цомоор шагнагдсан.
- Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдсан 25 жилийн ойн хүрээнд зориулан “Улсын Их Хурлын цом - 2015” тэмцээнийг урлаг, спортын наадамд болгож Улсын Их Хурлын Тамгын газар энэ оны эхний хагаст амжилттай зохион байгуулав.
- Энэ тэмцээний багийн төрөлд шатар, хөлбөмбөгөөр II, дартсаар V, ширээний теннис: эмэгтэй II, эрэгтэй V, биллиард: эрэгтэй, эмэгтэй II, сагсан бөмбөг: эрэгтэй V, эмэгтэй I, волейболын холимог төрөлд V байрт тус тус шалгарч, байгууллагын дүнгээр II байр эзэлсэн. Харин урлагийн тоглолтын дуу, бүжгийн төрөлд тустус II байр эзэлж, байгууллагын нэгдсэн дүнгээр II байрт шалгарсан ... гэх мэт.
- 2013 оны 9 дүгээр сард Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнууд Монгол Улсын гавьяат тамирчин, уулчин Г.Өсөхбаяраар ахлуулан Төрхурах - Богдхан уулын оргил “Цэцээ гүн” маршрутаар явган аялал амжилттай зохион байгуулсан.
- 2014 оны 6 дугаар сард Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнууд Үндэсний аудитын газартай хамтран Төрхурах - Богдхан уулын оргил “Цэцээ гүн” маршрутаар явган аялал хийсэн ... г. м.

\* \* \*



**ХАВСРАЛТУУД (НЭМЭЛТ ЗАРИМ МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ)**





**[2012 - 2016 ОНЫ УЛСЫН ИХ ХУРЛЫН НЭГЭН БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦААНД БАТЛАГДАН ГАРСАН]  
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НЭРИЙН ЖАГСААЛТ**

(2012. VII. - 2016.VII.)

**Нэг. БИЕ ДААСАН ХУУЛЬ****2012**

1. Засгийн газрын бүтцийн тухай хууль (2012.08.16)
2. Засгийн газрын бүрэлдэхүүний тухай (2012.08.16)
3. Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай (2012.09.04)
4. Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай (2012.09.14)
5. Монгол Улсын 2013 оны төсвийн тухай (2012.11.09)
6. Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай (2012.11.09)
